ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

2019

VII

Улаанбаатар хот
2021 он

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ЭМХЭТГЭЛ

(2019 он)

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Улаанбаатар хот
2020

ДАА 340
ННА 67
С-701

Судалгааны баг:

Удирдсан:

Х.Эрдэм-Ундрах	Захирал
Ж.Амарсанаа	Зөвлөх, Академич

Судалгааны багийн гишүүд:

Б.Алтангэрэл
Ж.Алтансүх
Ж.Ариунцэцэг
Л.Банзрагч
С.Батбаяр
Ч.Бат-Уянга
Ж.Бариаширсүрэн
У.Буянтогтох
Л.Галбаатар
Б.Гончигсумлаа
Б.Доржпагма
Н.Мичидмаа
Д.Мөнхжаргал
Д.Нямбаяр
Ц.Одгэрэл
Э.Өлзийлхам
Б.Сүнжидмаа
М.Төрбаяр
А.Түвшинтулга
Б.Ундрах
Э.Уянга
Г.Халиунаа
Г.Цагаанбаяр
М.Цэдэвсүрэн
Б.Энх-Амгалан
У.Эрдэнэзаяа

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.jh.gov.mn

© Хууль зүйн үндэсний хүрээлэн

Хянасан: Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн ухааны доктор /Ph.D/ П.Амаржаргал
Эмхэтгэсэн: Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа
Эрдэм шинжилгээний ажилтан Х.Ариунсүрэн
Хэвлэлийн эх бэлтгэсэн: З.Эрдэнэтөгс
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.
Хэвлэсэн хугацаа: 2020 оны 5 дугаар сар

ISBN-978-99978-788-0-9

ГАРЧИГ

НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 59 ДҮГЭЭР ТОГТООЛД ЗААСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА

1. Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн хийсэн үнэлгээ
2. Онц байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль боловсруулах шаардлагатай эсэх талаарх тандан судалгаа
3. Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын Пактын 19 дүгээр зүйлтэй үндэсний хүчин төгөлдөр хууль тогтоомж нийцэж байгаа эсэх болон тэдгээр хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ
4. Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах шаардлагатай эсэх талаарх тандан судалгаа
5. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ
6. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ
7. Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээ
8. Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилсан тандан судлах судалгаа

ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

1. Кодификацийг амжилттай хэрэгжүүлж буй гадаад орнуудын туршлага
2. Хүний сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцох аргачлал болон гадаад улсын туршлага

ГУРАВ. БУСАД СУДАЛГАА

1. Монгол Улсын Үндсэн хууль дахь Ерөнхийлөгчийн институтийн зарим нэр томьёо

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АИХ	Ардын Их Хурал
АН	Ардчилсан нам
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНМАУ	Бүгд Найрамдах Монгол Ард Улс
БНУ	Бүгд Найрамдах Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГХтХ	Гамшгаас хамгаалах тухай хууль
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ЕХ	Европын холбоо
ЗГ	Засгийн газар
ЗЕХ	Захиргааны ерөнхий хууль
ЗСтХ	Зар сурталчилгааны тухай хууль
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ЗХШХШтХ	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ИБУТЭТОУП	Иргэний болон Улс төрийн тухай Олон Улсын Пакт
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
КБНУ	Колумбын Бүгд Найрамдах Улс
МАН	Монгол ардын нам
МУГХУСАЗЗ	Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл
МУЕСтХ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
МУИХтХ	Монгол Улсын Их Хурлын тухай хууль
МУИХСтХ	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль
МУИХтХ	Монгол Улсын Их Хурлын тухай хууль
МУҮХ	Монгол Улсын Үндсэн хууль
МҮХЭҮК	Монгол Улсын Хүний эрхийн үндсэний комисс
НАНБХАСЗАШЗУСтХ	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
ННХГ	Нийслэлийн нийгмийн халамжийн газар
ОБтХ	Онц байдлын тухай хууль
ОУ	Олон Улс
ОУЭЗ	Олон улсын эрх зүй
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨАБНУ	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс
САХ	Сонгуулийн ажиглах хороо
САХХ	Сонгуулийн ажиглагч хязгаарлагдмал хороо
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СтХ	Сонгуулийн тухай хууль
СТБтХ	Сонгуулийн төв байгууллагын тухай хууль
ТАтХ	Төрийн албаны тухай хууль
ТАудтХ	Төрийн аудитын тухай хууль

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ulis.gov.mn

ТББ	Төрийн бус байгууллага
УБХ	Улсын Бага Хурал
УДШ	Улсын дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
ҮХЦ	Үндсэн хуулийн цэц
ҮЦАК	Үнэт цаас ба арилжааны комисс
ХБХЭтК	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц
ХБХЭтХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай хууль
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХЗС	Хууль зүйн сайд
ХЗҮХ	Хууль зүйн үндэсний хүрээлэн
ХЗЯ	Хууль зүйн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХОМ	Хөрөнгө орлогын мэдүүлэг
ХТтХ	Хууль тогтоомжийн тухай хууль
ХТЭТ	Хүйсийн тэгш эрхийн төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХЗХ	Харилцаа холбооны зохицуулах хороо
ХХтХ	Харилцаа холбооны тухай хууль
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ӨМНӨХ ҮГ

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс судалгааны үр дүнгээ эрдэм шинжилгээ, судалгааны эргэлтэд оруулах, нийтийн хүртээл болгох зорилгоор 2009 оноос эхлэн гүйцэтгэсэн судалгааны бүтээлээ тогтмол эмхэтгэн хэвлүүлсээр өдгөө 7 дахь цувралаа уншигч Танд толилуулахад бэлэн боллоо.

Энэ удаагийн цувралд 2019 онд гүйцэтгэсэн 11 судалгааны тайлан нийтлэгдэж байна. Эдгээрээс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолд заасан аргачлалын дагуу хийсэн суалгаа найм, харьцуулсан судалгаа хоёр, хууль зүйн нэр томьёоны хүрээнд хийсэн нэг судалгааны тайланг тус тус эмхэтгэн нийтэллээ.

Тус цувралын онцлогоос дурдвал, сүүлийн жилүүдэд хууль зүйн нэр томьёог судлах, цэгцлэх, жигдрүүлэх талаар эрдэмтэн, судлаачид нэлээдгүй ажлыг хийж, судалгааны цөөнгүй бүтээл хэвлэгдэн гарчээ. Хууль зүйн үндэсний хүрээлэн ч мөн энэхүү үйлст хувь нэмэр оруулах үүднээс 2019 оноос хууль зүйн нэр томьёотой холбоотой судалгааг хийж эхэлсэн юм. Тус ажлыг цаашид жил бүр тасралтгүй хийхээр зорьж байгаа бөгөөд бидний зүгээс энэ удаа Монгол Улсын Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн институттэй холбогдох нэр томьёоны талаар хийсэн судалгааны үр дүнгээ энэхүү дугаарт нийтлүүлж байна.

Түүнчлэн энэ удаагийн цувралаас эхлэн “Судалгааны тайлангийн эмхэтгэл”-ийг тухайн судалгааг гүйцэтгэсэн он, оноор нь эмхэтгэн гаргахаар төлөвлөн ажиллаж байна.

Хууль зүйн шинжлэх ухааныг шимтэн судалдаг эрдэмтэн, судлаач, уншигч Таны оюунд энэхүү бүтээл зохих хувь нэмрээ оруулна гэдэгт бид гүнээ итгэж байна.

Номын цагаан буян дэлгэрэх болтугай.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ Х.ЭРДЭМ-УНДРАХ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 59 ДҮГЭЭР ТОГТООЛД ЗААСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

НЭГ. ЗАСГИЙН ГАЗРЫН 2016 ОНЫ 59 ДҮГЭЭР ТОГТООЛД ЗААСАН АРГАЧЛАЛЫН ДАГУУ ГҮЙЦЭТГЭСЭН СУДАЛГАА

ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХЭСЭГЧЛЭН ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ[1]

УДИРТГАЛ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.3-т “Хууль заавал хэрэгждэг, хүн бүрт эрх тэгш, алагчлалгүй, шударга үйлчилдэг, итгэл хүлээсэн хүний эрхийн мэдрэмжтэй, шударга ёсны засаглалыг бэхжүүлэх зарчмыг баримтлана” гэж, 5.4.1-д “Хуулийн байгууллагуудын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, иргэдэд чирэгдэлгүй, ялгаваргүй, тэгш, шударгаар үйлчлэх эрх зүйн орчинг цогцоор нь бүрдүүлнэ” гэж тус тус заасан байна.

ХЗДХЯ-наас ирүүлсэн 1-4/554 тоот албан бичигт үндэслэн Хууль зүй, дотоод хэргийн сайдаас өгсөн чиглэлийн дагуу шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбараас шалтгаалан 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгааг тогтоох үүднээс энэхүү хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийв.

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх энэхүү үнэлгээний зорилго нь тус хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, зөвлөмж боловсруулахад оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хэсэгчлэн үнэлгээ хийх ажлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэсэн. Төлөвлөх үе шатанд дараахь ажлыг хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж[2] улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оноос эхлэн дагаж мөрдөх болсон билээ.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөөд нэг жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд Эрүүгийн хуулийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, хэрэглэхэд хүндрэлтэй, эрх зүйн хийдэлтэй зохицуулалт нэлээдгүй

[1] Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал, О.Төрболд нар хамтран гүйцэтгэв.

[2] Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, УБ., 2013 он.

байгааг салбарын эрдэмтэн, судлаач, шүүгч, прокурор, өмгөөлөгчид судлан үзэж өөр өөрийн байр суурийг илэрхийлсээр байна.[3]

Энэхүү маргаан бүхий зохицуулалтын нэг нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар буюу 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэж заасан нь практикт хэд хэдэн асуудлыг бий болгож байна.

Дээрх тайлбартай холбоотойгоор Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд бага хэмжээний хохирлоос[4] дээш хэмжээний хохирол учруулсан байхыг шаардахгүй байгаа юм. Уг асуудалд салбарын эрдэмтэн, судлаач, өмгөөлөгч, прокурор, шүүгчид өөр өөр байр суурийг илэрхийлж байна. Тухайлбал, зарим судлаачид[5] хуулийн дээрх зохицуулалт нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг буюу үндсэн бүрэлдэхүүндээ бага хэмжээнээс дээш хохирол шаардаж байгаа хэрнээ хүндрүүлэх бүрэлдэхүүндээ хохирол шаардахгүй байгаа нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулж, хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрхийг зөрчиж байна хэмээн үзэж байна.

Үүнтэй холбоотойгоор практикт маргаан дагуулаад байгаа Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг болон Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2. 3 дахь хэсэгт заасан зохицуулалтад үнэлгээ хийх зайлшгүй шаардлага үүссэн гэж үзлээ.

Иймд энэхүү үнэлгээгээр дээр дурдсан зохицуулалтын хэрэгжилтийг үнэлэх болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн онцлог нь хорих ялыг биечлэн эдлүүлэх явдлыг багасгах, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэхэд анхаарч, зорчих эрхийг хязгаарлах ял, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэж үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ хэрэглэх, гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд насанд хүрсэн хүнээс ялгамжтай байдлаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нөхцөлийг бүрдүүлж, ялын агуулга хэлбэрийг шинэчлэн тодорхойлж, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх институтийг тусгасан явдал юм.[6] Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн зохицуулалт нь дээрх онцлог шинжийг хангасан эсэх болоод уг зохицуулалтын эерэг, сөрөг талыг судалж, хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийхээр судалгааны хүрээг тогтоосон.

[3] Тухайлбал, судлаач Г.Ганбаатар "Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ" нийтлэл, судлаач Д.Нямбатын Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан "Хулгайлах" гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrenve theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ гэх мэт.

[4] Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.3 дахь заалт "бага хэмжээний хохирол" гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээ

[5] Энэ талаар судлаач Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, нар "Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг" нийтлэлдээ, судлаач Г.Ганбаатар "Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ" нийтлэлдээ, судлаач Б.Ганболд "Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай)" нийтлэлдээ тус тус дурдаж өгсөн байна.

[6] Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, УБ., 2017 он, 4 дэх тал.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

“Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу Эрүүгийн хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараахь хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

1. Зорилгод хүрсэн түвшин;
2. Практикт нийцэж байгаа байдал;

1.3.1. “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Эрүүгийн хуулийн 1.1 дүгээр зүйлд энэ хуулийн зорилгыг “Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино” хэмээн тодорхойлжээ.

Үүнээс үзвэл, Эрүүгийн хуулийн үндсэн зорилгын нэг нь хүний эрх, эрх чөлөөтэй холбогдсон харилцааг зохицуулах явдал болох нь харагдаж байна. Иймд энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилгыг хангахтай холбогдуулан тусгасан зүйл, заалтын нэг болох Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар болон 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалтыг сонгож “Зорилгод хүрсэн түвшин” шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. *Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд*

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг	2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч; 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж; 2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж; 2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар нь Эрүүгийн хуулийн тулгамдаж буй асуудлуудын нэгд зүй ёсоор тооцогдож байна. Учир нь энэхүү тайлбарт “Энэ

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jli.gov.mn

зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэж заасан нь судлаачдын дунд ихээхэн маргаан дагуулсаар байна. Учир нь бага хэмжээний хохирол учруулж, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд ялын хувьд сонгох санкцгүйгээр 2-8 жилийн хорих, 5-12 жилийн хорих ял оногдуулахаар хуульчилсан нь энэ гэмт хэргийн улмаас бусдад бага хэмжээний хохирол учруулсан хүний хувьд эрх зүйн байдал нь дордож, хүлээлгэж буй эрүүгийн хариуцлага нь үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирохгүй байна гэж зарим судлаачид[7] үзэж байна.

Иймд судалгааны энэ хэсэгт "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар буюу маргаан бүхий тус хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. *"Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1	17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг	2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч; 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж; 2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж; 2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш;
- Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш;
- Тохиолдол судлах.

Судалгааны явцад Эрүүгийн хуулиас сонгон авсан зохицуулалтыг өмнөх хууль тогтоомж дахь заалттай харьцуулан авч үзэх хэлбэрийг ашиглана.

[7] Тухайлбал, судлаач Г.Ганбаатар, Б.Ганболд, Ж.Эрдэнэбулган гэх мэт. Эдгээр судлаачдын нийтлэл, бүтээлүүдийг энэхүү судалгаанд ашигласан болно.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jus.gov.mn

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр Эрүүгийн хуулийн сонгон авсан хэсэгт тохируулан дараахь таамаглал дэвшүүлж, асуулт боловсруулаа:

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар зорилгодоо хүрсэн эсэх?

Практикт нийцэж буй байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүллийг унших, судлах, харьцуулалт хийх, прокурор, шүүгчидтэй уулзаж ярилцлага, анкетын судалгааны аргаар санал авах зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос дараахь хоёр аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно:

1. Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах;
2. Холбогдох субъектээс судалгаа авах.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Эрүүгийн хууль, холбогдох ном сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайланг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

Холбогдох субъектээс судалгаа авах хүрээнд: Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэхийн тулд прокурор, шүүгчидтэй уулзаж, ярилцлага болон анкетын аргаар судалгаа авсан. Мөн холбогдох байгууллагаас үйл ажиллагааны тайлан, судалгаа, бусад мэдээллийг гаргуулан авч үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, прокурор, шүүгчдээс анкетын судалгаа авч, ярилцлагын аргад тулгуурлаж энэхүү судалгааг гүйцэтгэв.

Баримт бичгийн судалгаа: Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно. Үүнд:

Хууль, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол.

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал, ХЗЯ, 2010 он;
- УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт

ХУУЛЬСАЙН ЗӨВШӨӨРӨЛ ХЭРЭЭЛЭН www.mn.gov.mn

оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2017 он;
- Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2013 он;
- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга, ХЗДХЯ, 2016 он;
- "Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь" судалгааны үндсэн тайлан, ХЗҮХ, 2016 он;
- "Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь" хавсралт тайлан, ХЗҮХ, 2016 он;
- Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.

Ном, сурах бичиг, гарын авлага

- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2016, МУГХУСАЗЗ, 2017 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2017, МУГХУСАЗЗ, 2018 он
- Монгол Улсын 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа, МУИС-ХЗС, 2016 он;
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2010 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/, 2011 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол – I боть, 2009 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ - II боть, 2014 он;
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), 2007 он;
- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он;
- Эрүүгийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2007 он.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, "Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг" нийтлэл, 2017 он;
- Б.Ганболд, Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл, №2 2018 он;
- Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2018 он;
- Д.Нямбат, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан "Хулгайлах" гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrenve theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ;
- Б.Өнөрмаа, Г.Оюунболд, "Эрүүгийн хуулийн хэрэгжилт" нийтлэл, 2017 он.

Цахим эх сурвалж

- Shuukh.mn, Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан;
- Prokuror.mn, Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын албан ёсны цахим хуудас;
- Judcouncil.mn, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн албан ёсны цахим хуудас.

Холбогдох субъектээс авсан судалгаа

Эрүүгийн хуулийн хэрэгжилтийн талаар прокурор, шүүгчдээс ярилцлагын болон анкетын аргаар судалгаа авсан.

Ярилцлагын арга: Эрүүгийн хуулийн холбогдох зүйл, заалтын хэрэгжилтийн бодит байдал, хууль хэрэглээнд тулгамдаж буй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг тодруулахаар прокурор, шүүгчдийн төлөөлөлтэй ярилцлага хийсэн.

Хуулийн Үндэсний Хүрээлэн www.nlis.gov.mn

Прокурор, шүүгчдээс бүрдсэн нийт 236-н хүнээс анкетын аргаар судалгаа авсан.

Судалгааны анхдагч мэдээллийг ярилцлагын болон анкетын судалгааны аргаар практикт ажиллаж буй прокурор, шүүгчдээс авсан тул илүү бодитой, үр дүнтэй байдлыг хангаж чадна гэж үзсэн болно.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар буюу маргаан бүхий 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан заалтад сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн.

3.1. "Зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад Эрүүгийн хуулийн зорилтыг зорилго хэмээн өөрчилсөн бөгөөд гэмт халдлагаас хамгаалахаас гадна гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгыг давхар агуулахаар заасан.[8]

Эрүүгийн хуулийн зорилгыг "Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх" хэмээн 1.1 дүгээр зүйлд заасан байна. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилгыг хангахад чиглэн үйлчлэх учиртай.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар зорилгодоо хүрсэн эсэх?

Үнэлгээ:

Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө гэдэгт Монгол Улсын Үндсэн хуулийн хоёрдугаар бүлэгт Монгол Улсын иргэнд баталгаатай эдлүүлэхээр заасан үндсэн эрх, эрх чөлөө хамаарна.[9]

Үндсэн хуульд заасан хүний эрхийг хамгаалах нэгэн баталгаа нь Эрүүгийн хууль бөгөөд Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлыг шийдвэрлэдэг. Энэ ч уттгаараа Эрүүгийн хууль нь бусад хууль тогтоомжоос илүү хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж байдаг хатуу хууль юм.

Тиймээс ч Эрүүгийн хууль нь хүний амьдрах эрх, аюулгүй байдал, амин эрх ашиг, үнэт зүйлсийн үндсэн бөгөөд онцгой хамгаалалт учир Эрүүгийн хуулийн шинэчлэлийн бодлого, зохицуулалт нь орчин цагийн эрх зүйн хөгжлийн түгээмэл хандлага, нийгмийн бодит амьдрал ахуйд нийцсэн, зөв оновчтой, гэмт хэргийн гаралтыг ихэсгэхгүй харин бууруулах буюу тодорхой түвшинд тогтоон барихад чиглэгдсэн, энэрэнгүй, эрх зүйн хийдэлгүй байх зэрэг "олон талт" шалгуур, шаардлагыг хангасан байх ёстой.[10]

2002 оны Эрүүгийн хуулийг баталснаас хойш цаг үеийн нөхцөл байдал, нийгмийн шаардлагаас шалтгаалан уг хуульд 13 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж улмаар Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах шаардлагатай гэж салбарын олон эрдэмтэн, судлаачид үзсэнээр 2015 онд Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулсан.

Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулах болсон нь Монгол Улсын Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг материаллаг хуулиар хамгаалахдаа гэмт хэрэг, зөрчлийн шинжийг ойлгомжтой, хэрэглэхэд хялбар байдлаар, өнөөгийн нийгмийн

[8] Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, УБ., 2017 он, 5 дахь тал.

[9] Мөн тэнд.

[10] Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг нийтлэл, 2017 он.

хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчилж, томьёолохоос гадна шинээр хамгаалах шаардлагатай харилцаа, хүний эрх, эрх чөлөө, хүний халдашгүй байдлыг хамгаалах хууль эрх зүйн баталгаатай орчныг бүрдүүлэхэд[11] чиглэсэн.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага бий болж[12] улмаар Улсын Их Хурал Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгыг 2015 онд баталж, 2017 оноос эхлэн дагаж мөрдөх болсон.Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээс хойш практикт маргаан дагуулаад буй асуудлын нэг нь 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийн тайлбар хэсэг юм. Уг тайлбарт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заажээ.

Энэхүү тайлбарыг судлан үзвэл Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулахдаа анх Гэмт хэргийн тухай хуулийн төсөл нэртэйгээр боловсруулж, уг төсөлд өөрчлөлт орж явсаар Эрүүгийн хуулийн төсөл боловсруулагдсан бөгөөд уг төсөлд хорих ялын доод хэмжээг 7 хоног, хулгайлах гэмт хэргийн хохирлын хэмжээг хуульчилж өгөөгүй зэрэг одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулиас нэлээд ялгаатай зохицуулалтууд байсан. Тухайлбал 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр Эрүүгийн хуулинд хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүнийг “Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан...” гэж хуульчилж өгсөн. Улмаар хууль тогтоогч 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Дээрх өөрчлөлтийн талаар судлаач Г.Ганбаатар: “Хожуу боловч энэхүү өөрчлөлтөөр Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зохицуулалтын ноцтой сөрөг үр дагаврыг анхаарч, саармагжуулахад чиглэсэн нэг алхам нь энэхүү зүйлд хийсэн хууль тогтоогчийн тайлбар юм. Гэвч тухайн тайлбарт “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэсэн бичвэрийг нэмж хуульчилсан нь “нуухыг нь авах гэсэн нүдийг нь сохолсон”, “Нэг алхам урагшилж, хоёр алхам хойшилсон” утга агуулгын бодит илрэл болсон буюу ялимгүй алдсан иргэдийн ирээдүйг шоронд булшлах бодлого дүр эсгэн хэвээр үлдсэн байна.[13]” хэмээн тодорхойлсон байна.

Ийнхүү шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн юм. Шинэ хууль хэрэгжиж эхэлсэн өдрөөс 2018 оны 6 дугаар сарын 1-ний өдрийн хооронд улсын хэмжээнд хулгайлах төрлийн нийт 35397 гомдол, мэдээлэл хүлээн авч, 8390 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. Энэхүү тоо баримтаас харвал 2002 оны Эрүүгийн хууль үйлчилж байх үед хулгайлах гэмт хэргийн гаралт жил ирэх бүр өсч байсан ба 2015 оны Эрүүгийн хуулийн хэрэгжих цаг хугацаанд мөн л өссөөр байгааг харуулж байна.[14]

Улсын хэмжээнд 2017 оны 7 дугаар сарын 1-нээс 2018 оны 6 дугаар сарын 30-ны хооронд нийт 1650 хүн хулгайлах гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас 137 буюу 8.3 хувь нь эмэгтэй, 1513 буюу 91.7 хувь нь эрэгтэй, 199 буюу 12.1 хувь нь хүүхэд байна.[15]

Практикт өсвөр насны (14-17) 4-н хүүхэд дэлгүүрээс 110.000-н төгрөгийн талх, боорцог, чихэр гэх мэт хүнсний зүйл хулгайлсан үйлдэлдээ Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцогдон хорих

[11] Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, УБ., 2013 он.

[12] Мөн тэнд.

[13] Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018 он, №2, 79-80 дахь тал.

[14] Д.Нямбат, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrenve theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ

[15] Мөн тэнд.

ялаар шийтгүүлсэн[16] энэхүү асуудлаас үүдэн УИХ-ын гишүүн О.Батнасан "Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл"-ийг санаачлан боловсруулж, Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн зарим хэсэгт 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан юм.

Гэсэн хэдий ч дээрх өөрчлөлтөөр зөвхөн өсвөр насны хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэх зарим зохицуулалтад өөрчлөлт оруулснаас бусдаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн маргаан бүхий зохицуулалтуудад өнөөдрийг хүртэл нэмэлт өөрчлөлт оруулаагүй хүчин төгөлдөр үйлчилсээр байна.

Маргаан бүхий Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбарыг судлаачид өөр өөрийн үзэл бодлоор тайлбарлаж байна. Тухайлбал, судлаач Г.Ганбаатар "Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ" нийтлэлдээ "...Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн аутентик тайлбар нь "Зорилго чиглэл, утга агуулга"-ын хувьд гагцхүү Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт шууд хамааралтайгаар хуульчлагдсан, тухайн хамаарах хэсгийн хэм хэмжээний хамт хүчин чадалтай байх хэдий боловч тухайн тайлбар дахь "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэсэн бичвэрийг "тайлбар" гэж үзэх боломжгүй харин эсрэгээр тайлбарт хамаарахгүй өөр зохицуулалтыг тусгасан нь хуулийн тухайн зүйлийн хэсгүүд хооронд зөрчилдөөн үүсгэж, улмаар иргэдийг хуучин Эрүүгийн хуулиас илүүтэй шоронжуулахад чиглэсэн үзэл санааг агуулсан нь илэрхий байна" хэмээн үзжээ.

Эрх зүйн хэм хэмжээний албан ёсны тайлбар нь кейсийн тайлбар болон хэм хэмжээний тайлбар гэсэн хоёр төрөлтэй байна. Эрх зүйн хэм хэмжээний буюу норматив тайлбар нь аутентик тайлбар ба хууль зүйн тайлбарт /Улсын Дээд шүүхийн абстракт тайлбар/ хуваагдана. Тэрээр Аутентик тайлбарыг тодорхойлохдоо эрх зүйн хэм, хэмжээг батлан гаргасан байгууллагаас тайлбарласан тайлбар. Эрх зүйн хэм хэмжээний утга санааг шууд тайлбарлахад чиглэгдэх хийгээд тэдгээрийг хэрэглэж байгаа бүхэнд заавал биелүүлэх шинжийг агуулдаг.[17]

Дээрхээс үзвэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" хэмээн заасан байх бөгөөд дээрх зүйлийн тайлбар хэсэгт "Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэж зааж өгсөн нь ямар нэгэн салаа утгагүйгээр хохирлын хэмжээнээс үл хамааран 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн бол 2 жилээс 12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэхээр заасан байна.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг хэрэгжүүлж эхэлснээс хойш Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 2018 онд нийт 17734 хүн, 4 хуулийн этгээдэд холбогдох 14207 эрүүгийн хэрэг хүлээн авч 12551 хэрэг шийдвэрлэсэн бөгөөд анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг өмнөх оноос 42.0 хувиар өссөн байна.[18]

Харин 2002 оны Эрүүгийн хууль хэрэгжиж байх үед хулгайлах гэмт хэргийг шүүхээс шийдвэрлэж байсан тоон мэдээг харвал 2011 онд 1282, 2012 онд 1281, 2013 онд 1283, 2014 онд 1336, 2015 онд 1418[19], 2016 онд 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд зааснаар 995 хэрэг, 2015 оны Эрүүгийн хуулийн 17.1

[16] УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

[17] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), УБ., 2007 он, 648 дахь тал.

[18] Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан. Дэлгэрэнгүйг http://www.judcouncil.mn/main/8465--2018-.html үзнэ үү.

[19] Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном - 2016, УБ., 2017 он, 152 дахь тал.

дүгээр зүйлд зааснаар буюу 421 хэрэг нийт 1416 хэрэг шийдвэрлэсэн байна.[20]

Хүснэгт 3. *Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэсэн хулгайлах гэмт хэргийн тоон мэдээ /2018 он/*[21]

Эрүүгийн хууль /2015 он/ 17.1 дүгээр зүйл					
Хянан шийдвэрлэсэн		Нийт	17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг	17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг	17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг
	Хэрэг	1553	778	775	20
	Холбогдогч	2049	958	1061	30

Дээрх графикаас үзвэл, 2018 онд Эрүүгийн хэргийн анхан шатны шүүх 12551 хэрэг хянан шийдвэрлэснээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан 1553 хэрэг хянан шийдвэрлэгдсэн нь нийт анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн 12.4 хувийг эзэлж байна.

Харин давж заалдах шатны шүүх 2018 онд эрүүгийн 2166 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 9.9 хувиар өссөн. Хяналтын шатны шүүх 2018 онд эрүүгийн 851 хэрэг хянан шийдвэрлэсэн нь өмнөх оноос 92.6 хувиар тус тус өссөн байна.[22]

Өнгөрсөн онтой харьцуулбал, шүүхээр хянан шийдвэрлэсэн эрүүгийн хэрэг 42 хувиар, ял шийтгүүлэгчдийн тоо мөн 37.1 хувиар тус тус өссөн. Энэ нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж гэмт хэрэг тус бүрт ял оногдуулж, шийдвэрлэдэг болсонтой холбоотой бөгөөд 2018 онд эдгээр хууль бүтэн жилийн хугацаанд хэрэгжиж эхэлсэн анхны жил болсонтой холбоотойгоор хянан шийдвэрлэсэн хэрэг, ял шийтгүүлсэн хүний тоо өсөлттэй гарахад нөлөөлсөн байна.[23]

Өөрөөр хэлбэл, шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль хэрэгжиж эхэлснээр гэмт хэргийн гаралт, ял шийтгүүлж буй хүний тоо өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс хулгайлах гэмт хэргийн тухайд дэлгэрүүлэн судлан үзэхэд анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэсэн нийт хэргээс хулгайлах гэмт хэрэг 137 хэргээр буюу 9.7 хувиар өссөн бөгөөд ял шийтгүүлэгчдийн байдлаар нь авч үзвэл хулгайлах гэмт хэрэгт ял шийтгүүлэгчдийн тоо 18.6 хувиар өсжээ.[24]

Ийнхүү хулгайлах гэмт хэргийн гаралт, ял шийтгүүлж буй хүний тоо өсөж буй нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбартай хамаарал бүхий байж болох юм.

Учир нь шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүн нь бусдын “хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар...” авсан үйлдэл байх бөгөөд энэхүү үйлдлийн улмаас бага хэмжээнээс[25] дээш буюу 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан бол энэ гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг агуулахаар хуульчилжээ.

Гэтэл энэ зүйлийн тайлбар хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн

[20] Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном - 2017, УБ., 2018 он, 82 дахь тал.

[21] Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн тоон мэдээ.

[22] Монгол Улсын шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.
Дэлгэрэнгүйг http://www.judcouncil.mn/main/8465--2018-.html үзнэ үү.

[23] Мөн тэнд.

[24] Мөн тэнд.

[25] Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 4.3-т “бага хэмжээний хохирол гэж гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс доош хэмжээг”, мөн хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “...нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. Өөрөөр хэлбэл, бага хэмжээний хохирол нь 300.000 төгрөг бөгөөд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон эрүүгийн хариуцлага хүлээлгэх нэг үндэслэл нь 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан байхыг шаардаж байгаа юм.

улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасан байна. Дээрх тайлбараас үүдэн хулгайлах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бага хэмжээний хохирол учруулж үйлдсэн тохиолдолд ч эрүүгийн хариуцлага хүлээхээр болж байгаа юм.

Харин 2002 оны Эрүүгийн хуульд хулгайлах гэмт хэргийн улмаас бусдад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс бага хохирол учруулсан тохиолдолд эрүүгийн хариуцлага шууд хүлээлгэх үндэслэл бүхий зохицуулалт байхгүй байсан юм. Хулгайлах гэмт хэргийн тухайд 2002 болон 2015 оны Эрүүгийн хуулийн зохицуулалтыг харьцуулан үзвэл:

Хүснэгт 4. *2002 болон 2015 оны Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан “Хулгайлах” гэмт хэргийн зохицуулалт, түүний харьцуулалт*

№	2002 оны Эрүүгийн хууль	2015 оны Эрүүгийн хууль
1	145 **дугаар зүйл.Бусдын эд хөрөнгийг хулгайлах** 145.1.Бусдын эд хөрөнгийг хулгайлсны улмаас бага бус хэмжээний хохирол учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас хоёр зуун тавин цаг хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ. 145.2.Энэ гэмт хэргийг давтан бүлэглэж буюу урьдчилан үгсэж тохиролцсон бүлэг, машин механизм, тусгайлан бэлтгэсэн багаж хэрэгсэл хэрэглэж буюу орон байр, агуулах саванд нэвтэрч үйлдсэн, энэ хэргийн улмаас үлэмж хэмжээний хохирол учирсан, олон тооны мал хулгайлсан бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 145.3.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хохирогчийг амьдралын эх үүсвэрээс нь салгасан буюу их хэмжээний хохирол учирсан, түүнчлэн гамшигийг далимдуулж үйлдсэн бол эд хөрөнгийг хурааж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуун тавин нэгээс таван зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл таваас дээш арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 145.4.Энэ хэргийг булаах, дээрэмдэх, уулгалан довтлох гэмт хэрэгт шийтгүүлсэн этгээд, түүнчлэн онц аюултай гэмт хэрэгтэн, гэмт бүлэглэл үйлдсэн, энэ хэргийн улмаас онц их хэмжээний хохирол учирсан бол эд хөрөнгийг хурааж, арваас дээш арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйл. Хулгайлах 1.Бусдын эд хөрөнгийг хүч хэрэглэхгүйгээр, нууцаар, хууль бусаар авсан бол хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 2.Энэ гэмт хэргийг: 2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч; 2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж; 2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж; 2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 3.Энэ гэмт хэргийг: 3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон; 3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.

1. 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар хөдөлмөрийн харилцаанд хэрэглэдэг “хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ” гэдэг ойлголтыг Эрүүгийн хуульд тусгасан байсныг халж гэмт хэргийн ангилалт, учирсан хохирлын хэмжээг бодитой тогтоох, торгуулийн ял хэмжээг тогтвортой байлгах үүднээс Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар “нэгж” гэсэн хэмжигдэхүүнийг

шинээр оруулж ирсэн. Учир нь 2002 оны Эрүүгийн хуулиар хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ өөрчлөгдөхөд[26] эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байсан зарим хэргүүд гэмт хэргийн шинжгүй болж, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх тохиолдол цөөнгүй байсан.

2. 2015 оны Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах эрүүгийн хариуцлагын төрөл нь дан ганц хорих ял байгаа бол 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлийн 145.1, 145.2, 145.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах ял нь сонгох санкцтай, 145.4 дэх хэсэгт заасан онц хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй гэмт хэрэгт сонгох санкцгүйгээр хорих ял оногдуулахаар хуульчилсан байжээ.

3. 2002 оны Эрүүгийн хуулийн 145 дугаар зүйлд заасан “Бусдын эд хөрөнгийг хулгайлах” гэмт хэрэг нь үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүндээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэхүйц буюу түүнээс дээш хэмжээний хохирол учруулсан тохиолдолд хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон ял оногдуулдаг байсан бол 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд 300.000 төгрөгөөс дээш хэмжээний хохирол учруулсан, харин хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр дээрх гэмт хэргийг үйлдсэн тохиолдол хохирол шаардахгүй байдлаар хуульчилснаараа өмнөх хуулиас нэлээд ялгаатай зохицуулалт болсон байна.

Түүнчлэн, шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбараас хамааран Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан хүнд оногдуулах хорих ял нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд “...тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна” гэж заасан шударга ёсны зарчимтай нийцэхгүй байгаа нь харагдаж байна. Үүнийг жишээгээр авч үзвэл:

Тохиолдол 1.

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 110 дугаар тогтоолтой иргэн Л.Б-д холбогдох эрүүгийн хэргийн талаар:[27]

Шүүгдэгч Л.Б нь 2018 оны 06 дугаар сарын 08-ны шөнө 23 цаг 30 минутын орчим Замын-Үүд сум 2 дугаар багт оршин суух иргэн Д.Э-н байнга амьдрах орон байранд нэвтэрч 1 ширхэг цайны халуун сав, 7.5 литр сарлагийн сүү, 5 кг үхрийн мах зэргийг хулгайлж 51.250 төгрөгийн бага хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт холбогдсон бөгөөд шүүхээс Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 6.7 дугаар зүйлийн 1.3-т заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар шүүгдэгч Л.Б-д 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ял оногдуулсан байна.

Тохиолдол 2.

Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь сум дундын шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 21-ний өдрийн 09 дүгээр тогтоолтой иргэн Ш.С-д холбогдох эрүүгийн хэргийн талаар:[28]

Шүүгдэгч Ш.С нь 2018 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Өмнөговь аймгийн Цогтцэций сумын төвд үйл ажиллагаа явуулдаг Цэцгэн бууз цайны газраас иргэн М.Л-ийн гар цүнхийг хулгайлж бусдад 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт холбогджээ.

Шүүхээс Ш.С-г хулгайлах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 7.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Ш.С-д хорих ял оногдуулахгүйгээр 1 /нэг/ жил 6 /зургаа/-н сарын хугацаагаар тэнссэн байна.

Дээрх 2 тохиолдолд шүүхээс ялгамжтай байдлаар ял оногдуулсан байх бөгөөд эхний тохиолдолд Л.Б нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан “Хулгайлах” гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэй буюу хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч үйлдэн, 51.250 төгрөгийн хохирол учруулж улмаар 1 жил

[26] Манай улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 2000 оноос хойш нийт 13 удаа өөрчлөгдсөн.

[27] Дэлгэрэнгүйг http://new.shuukh.mn/eruuanhan/25274/view үзнэ үү.

[28] Дэлгэрэнгүйг http://new.shuukh.mn/eruuanhan/28027/view үзнэ үү.

хорих ялаар шийтгүүлсэн бол хоёр дахь тохиолдолд цайны газраас Ш.С нь иргэн М.Л-ийн гар цүнхийг хулгайлж, 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан гэх хэрэгт шүүхээс хорих ял оногдуулахгүйгээр нэг жил зургаан сарын хугацаагаар тэнссэн байна.

Өөрөөр хэлбэл, учруулсан хохирлын хэмжээний хувьд хорих ял шийтгүүлсэн Л.Б нь 51.250 төгрөг буюу бага хэмжээний хохирол, хорих ял оногдуулахгүйгээр тэнсэгдсэн Ш.С нь 1.660.000 төгрөгийн хохирлыг бусдад учруулсан байна.

Товчхондоо хохирлын хэмжээ их байх тусмаа тухайн хүнд оногдуулах ялын хэмжээ нэмэгдэх нь зүйн хэрэг. Гэтэл бусдад 51.250 төгрөгийн хохирол учруулсныхаа төлөө 1 жил чөлөөгөө хасуулан эрүүгийн хариуцлагын хамгийн хүнд төрөл болох хорих ялаар шийтгүүлж байгаа нь Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан "Шударга ёсны зарчим"-д нийцэж буй эсэх нь эргэлзээтэй юм. Түүнчлэн, дээрх хоёр тохиолдол нь гэмт хэргийн ангиллын хувьд ч эрс ялгаатай байна.

Гэмт хэрэг бүрт нийгэмд аюултай байдлын шинж чанар, хэр хэмжээ оногдуулж болох ялын хүнд, хөнгөн зэрэг шалгууруудыг харгалзан нийт гэмт хэргүүдийг тодорхой төрөлд хуваахыг ангилалт гэнэ.[29]

Гэмт хэргийн ангилал нь гэмт хэргийг нийгмийн хор аюул, шинж чанараар нь ангилахын зэрэгцээ хууль зүйн үр дагаврыг ангиллаас нь хамааран ялгамжтайгаар тогтоох, эрүүгийн хариуцлагыг оновчтой тодорхойлоход ач холбогдолтой төдийгүй хууль зүйн техникийн хувьд ерөнхий ангид заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тэнсэх, хорих ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэхэд чухал ач холбогдолтой тул гэмт хэргийг хөнгөн, хүнд гэсэн хоёр ангилалтай байхаар тусгасан.[30]

Дээрх тохиолдолд 51.250 төгрөгийн хохирол бусдад учруулсан хүний үйлдсэн хулгайлах гэмт хэрэг нь гэмт хэргийн ангиллын хувьд хүнд гэмт хэрэгт хамаарна. Харин 1.660.000 төгрөгийн хохирол учруулсан хүний үйлдсэн хулгайлах гэмт хэрэг нь хөнгөн гэмт хэрэгт хамаарч байна.

Нөгөөтээгүүр хууль тогтоогч Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хулгайлах гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хуульчлан өгсөн. Тухайлбал, дээрх 2 тохиолдолд Л.Б нь хүн байнга амьдрах зориулалттай орон байранд нэвтэрч эд зүйл хулгайлсан учир хүндрүүлэн авч үзэж буй нь зүйн хэрэг болович хохирлын хэмжээ нь 51.250 төгрөг байгаа нь хулгайлах гэмт хэргийнхээ үндсэн бүрэлдэхүүнийг хангаагүй (17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй) байхад хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр хулгайлах гэмт хэрэг үйлдсэн учраас бага хэмжээний хохирол учруулсан ч хүндрүүлэн зүйлчилж байгаа нь өрөөсгөл юм.

Учир нь эрүүгийн эрх зүйд гэмт хэргийн бүрэлдэхүүнийг үндсэн, хүндрүүлэх, онц хүндрүүлэх зэргээр тайлбарлан хэрэглэж ирсэн байдаг ба үндсэн бүрэлдэхүүний шинжгүй нөхцөлд дараахь хүндрүүлэх болон онц хүндрүүлэх бүрэлдэхүүний шинж бий болохгүй гэсэн үзэл хэвшин тогтсон ойлголт.[31]

Гэтэл шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлд заасан "Хулгайлах" гэмт хэргийн тайлбар нь дээрх ойлголттой зөрчилдөж байна.

Хуулийн энэхүү зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хамгаалахад чиглэж буй хэдий ч Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн хүнд ялгамжтай байдлаар хандаж, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, учруулсан хохирлыг үл

[29] С.Жанцан, Монгол Улсын эрүүгийн эрх зүйн онол I боть, УБ., 2009 он, 206 дахь тал.

[30] ХЗДХЯ-аас гаргасан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга.

[31] Б.Ганболд, Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018 он, №2, 61 дэх тал.

харгалзаж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх зохицуулалтад нийцсэн эсэх нь эргэлзээ төрүүлэхүйц байна.

Мөн шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн зорилго нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн бөгөөд энэ хууль хэрэгжиж эхэлснээс хойш хулгайлах төрлийн гэмт хэргийн гаралт, гэмт хэрэгт холбогдож ял шийтгүүлж буй хүний тоо ч мөн өссөн үзүүлэлттэй[32] байна. Иймд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар зорилгодоо бүрэн хүрээгүй хэмээн үзэж байна.

3.2. "Практикт нийцэж байгаа байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйл. Хулгайлах
2.Энэ гэмт хэргийг:
2.1.хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрч;
2.2.түүх, соёл, шинжлэх ухаан, техник, технологийн хөгжилд чухал ач холбогдолтойд тооцож тусгайлан хамгаалсан эд зүйлсийг хулгайлж;
2.3.ноцтой хохирол учруулж, их хэмжээний эд хөрөнгийг хулгайлж;
2.4.учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3.Энэ гэмт хэргийг:
3.1.байнга үйлдэж амьдралын эх үүсвэр болгосон;
3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
Тайлбар: -Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлдлийн улмаас бага хэмжээний хохирол учруулсан бол гэмт хэрэг үйлдсэнд тооцохгүй. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй.

Үнэлгээ:

Эрүүгийн хууль нь хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулж, улс үндэстний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг сахин хангах чиг үүрэг бүхий суурь хууль болохын хувьд эрх зүйн шинэтгэл, олон нийтийн анхаарлын төвд байнга байдаг.

Эрүүгийн хууль тогтвортой удаан хугацаанд мөрдөгдөж байх явдал чухал болов уг хуулийн хэрэгжилт, үр нөлөө, нийгмийн эрэлт шаардлагад нийцэж байгаа эсэхэд тогтмол хяналт шинжилгээ хийж, хэрэв нийцэхгүй зүйл байвал түүнийг шинэчлэх, өөрчлөх арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлж байх нь зүйтэй.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөөд жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн алдаа, зөрчил, эрх зүйн хийдэл бүхий зохицуулалтуудыг практикт ажиллаж буй шүүгч, прокурор, өмгөөлөгч, салбарын эрдэмтэн, судлаач судалж, засаж сайжруулбал зохих асуудлын талаар[33] өөр өөрийн байр суурийг илэрхийлсээр байгаа билээ.

Маргаан бүхий энэхүү асуудлын талаар практикт ажиллаж буй прокурор, шүүгчдийн саналыг авснаар судалгааны үр дүн илүү бодитой гарна гэж үзсэний үндсэн дээр 78 прокурор, 158 шүүгч, нийт 236 хүнээс анкетын аргаар судалгаа авч үр дүнг боловсруулсан болно.

[32] Тоон мэдээг үнэлгээний тайлангийн 12 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү.

[33] Тухайлбал, Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйл, 6.7 дугаар зүйл, 7.1 дүгээр зүйл, мөн хуулийн 13.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг гэх мэт.

Анкетын судалгааны үр дүнгээр:[34]

График 1. *Судалгаанд хамрагдсан байдал*



Нийт 236 оролцогч анкетын судалгаанд хамрагдсанаас шүүгч 158 буюу 67 хувийг, прокурор 78 буюу 33 хувийг тус тус эзэлж байна.

Анкетын судалгаагаар тавигдсан Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг байх шаардлагатай юу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын **72.5 хувь** нь шаардлагатай хэмээн хариулсан байна.

Мөн Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хохирлын хэмжээг тусгаж өгөх шаардлагатай юу? гэсэн асуултад шаардлагатай гэж **83.9 хувь** нь хариулсан байна.

Дээрх 2 асуултын үр дүнгээс харвал Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгийг бүхэлд нь хүчингүй болгох нь буруу. Харин тодорхой хэсэг буюу "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэснийг тайлбар хэсгээс хасах нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрч болох юм.

Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүн тэр дундаа хулгайлах гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд оногдуулах ялын хэмжээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохирч байна уу? гэсэн асуултад тохирч байна гэж **8.5 хувь** нь, тохирохгүй байна гэж **51.7 хувь** нь, ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг оногдуулах боломжтой гэж **39.8 хувь** нь хариулсан байна. Энэхүү асуултын хариултыг бататгах зорилгоор Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт ялын төрлийг нэмж хуульчлах шаардлагатай юу? гэсэн асуултад шаардлагатай гэж 72 хувь, шаардлагагүй гэж 28 хувь нь хариулсан байна.

Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсны улмаас дээрх гэмт хэрэгт гэм буруутайд тооцогдож хорих ял эдэлж буй хүмүүсийн хорих ялын хэмжээ тухайн гэмт хэргийнхээ нийгмийн аюулын шинж чанарт тохирохгүй байна гэж судалгаанд оролцогчдын олонхи нь үзэж байна. Тиймээс энэхүү гэмт хэрэгт оногдуулж буй ялын төрлийг нэмэгдүүлэх шаардлагатай хэмээн хариулсан гэж үзэж болох юм.

Түүнчлэн, практикт дээрх төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй" гэж заасныг үндэслэн шийдвэрлэж буй тохиолдол цөөнгүй байна. Үүнийг жишээгээр авч үзвэл:

[34] Дэлгэрэнгүйг хавсралт 1, 2, 3-аас үзнэ үү.

Тохиолдол 3.

Увс аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 35 дугаар шийтгэх тогтоол[35], Увс аймгийн эрүү, иргэний хэргийн давж заалдах шатны 2018 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн 14 дүгээр магадлал[36], Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүхийн 299 дүгээр тогтоолтой Т.О, Б.Х нарт холбогдох эрүүгийн хэргийн талаар:[37]

Т.О, Б.Х нар нь 2017 оны 12 дугаар сарын 8-ны шөнө Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар багийн нутаг дэвсгэрээс тоёота аллион загварын саарал өнгийн 06-83 УВХ улсын дугаартай автомашин ашиглаж хохирогч Ц.А-гийн эзэмшлийн ногооны талбайн 20 метр урттай төмөр тор хулгайлж нийт 90.000 төгрөгийн хохирол учруулсан бөгөөд гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлсөн бөгөөд анхан шатны шүүхээс Б.Х, Т.О нарт тус бүрт нь нэг жилийн хорих ял оногдуулсан.

Давж заалдах шатны шүүхээс энэхүү хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцаасан.

Харин давж заалдах шатны шүүх уг хэргийг хянан хэлэлцээд "шүүгдэгч Т.О, Б.Х нарын ногооны талбайн 20 метр урттай төмөр тор хулгайлж учирсан 90.000 төгрөгийн хохирлыг нь Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодитой хохирол учирсан гэж дүгнэхээргүй байх тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан үйлдлийг гэмт хэрэгт тооцох үндэслэлгүй гэсэн прокурорын дүгнэлтийг хүлээн авахаар тогтов" гэжээ. Ийнхүү хяналтын шатны шүүхээс ЭХХШтХ-ийн 34.19 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, цагаатгасан байна.

Дээрх тохиолдолд анхан шатны шүүхээс машин механизм нь ашиглаж хулгайлах гэмт хэрэг үйлдэж бусдад 90.000 төгрөгийн хохирол учруулсан Т.О, Б.Х нарын үйлдэлд нэг жилийн хорих ял оногдуулсан бөгөөд 90.000 төгрөгийн хохирол учруулж, хохирлоо нөхөн төлсөн ч эрх чөлөөгөө нэг жилийн хугацаагаар хязгаарлуулж байгаа нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд эрүүгийн хариуцлага тохирсон эсэх нь эргэлзээтэй.

Хорих ял гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь тогтоогдвол шүүх Эрүүгийн хуульд заасан хугацаанд эрх чөлөөг нь хязгаарлаж, олон нийтээс тусгаарлаж, тусгай дэглэм бүхий хорих анги, гянданд албадан байлгадаг төрийн албадлагын **хатуу цээрлэл** агуулсан арга хэмжээ[38] гэтэл 90.000 төгрөгийн хохирол бусдад учруулж, хорих ял эдэлнэ гэдэг нь хохирол болон нийгмийн аюулын хэр хэмжээндээ тохирох эсэх нь эргэлзээтэй байна.

Энэ байдлыг хяналтын шатны шүүхээс харгалзан үзэж Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "...Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан боловч тухайн этгээдийн хувийн байдал, үйлдэл, эс үйлдэхүйн нийгмийн аюулын хэр хэмжээ нь энэ хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодит хохирол, хор уршиг учруулаагүй үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцохгүй" гэж заасныг журамлан Т.О, Б.Х нарт холбогдох эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон, цагаатгаж шийдвэрлэсэн байна.

Тэгвэл, Т.О, Б.Х нарын үйлдсэн хулгайлах гэмт хэргийг адил төсөөтэй хэргүүдийг практикт Эрүүгийн хуулийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг журамлан хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байгаа эсэхийг судлах зорилгоор анкетын судалгаагаар Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохируулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой юу? гэсэн асуулт тавихад:

"Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой" гэж судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын **37.3 хувь** нь хариулсан бол *"Боломжгүй. Учир нь хууль тогтоогч 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт энэхүү гэмт хэрэгт хохирол шаардахгүй байхаар*

[35] Дэлгэрэнгүйг http://new.shuukh.mn/eruuanhan/18434/view үзнэ үү.

[36] Дэлгэрэнгүйг http://new.shuukh.mn/eruudavah/5384/view үзнэ үү.

[37] Дэлгэрэнгүйг http://new.shuukh.mn/eruuhyanalt/962/view үзнэ үү.

[38] УДШ, Ханнс Зайделийн сан, "Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар", 2010 он, 162-163 дахь тал.

тодорхой байдлаар тусгасан" гэж **62.7 хувь** нь хариулсан байна.

Мөн Та Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэсэн тохиолдол байгаа юу? гэсэн асуултад судалгаанд хамрагдсан нийт оролцогчдын **13.1 хувь** нь тийм гэж, **86.9 хувь** нь үгүй гэж тус тус хариулсан байна.

Гэсэн хэдий ч дээрх асуултад хариулсан шүүгч, прокуроруудын хариулт нэлээд ялгамжтай байсан бөгөөд тухайлбал, прокуроруудын 32.1 хувь, шүүгчдийн 3.8 хувь нь дээрх асуултад тийм гэж хариулсан байна.

Дээрхээс дүгнэвэл, практикт прокурорын хяналтын шатанд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэж буй тохиолдолд шүүхээс илүү байна.

Анкетын судалгааны үр дүнг нягтлах зорилгоор Монгол Улсын шүүхийн шийдвэрийн shuukh.mn цахим сангаас 2019 оны 3 дугаар сарын 4-ний өдрийн байдлаар Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад зааснаар эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс хянан шийдвэрлэгдэж, тус санд байршуулсан нийт 724[39] хэргээс санамсаргүй түүврийн аргаар 200 хэрэг сонгон судалж, түүнээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж шүүхээс шийдвэрлэгдсэн хэргийг түүвэрлэн судалсан болно.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан 200 хэргээс 30 хүнд холбогдох 27 хэрэг[40] нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтад заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдол байв.

Энэхүү 30 хүнд холбогдох 27 эрүүгийн хэрэгт шүүхээс оногдуулсан ялыг судлан үзэхэд 1 хүнд хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ, үлдсэн хүмүүст хорих ял оногдуулсан байна. Хорих ял шийтгүүлсэн 29 хүнд хамгийн багадаа 1 жилийн хорих ял, ихдээ 2 жил 1 сарын хорих ял оногдуулсан байна. Үүнийг дунджилж үзвэл ойролцоогоор 1 жил 3 сарын хорих ял оногдуулсан байна.

Дээрх 27 хэргийн хохирлын хэмжээг харвал, хамгийн бага нь 20.000 төгрөгийн, хамгийн их нь 300.000 төгрөгийн хохирол бусдад учруулсан байх бөгөөд хохирлын хэмжээ нь дундажаар 178.993 төгрөг байна.

Гэмт хэрэг үйлдсэн хүний насны байдлын хувьд дээрх 30 хүнээс 9 хүний насны байдлыг шүүхийн шийдвэрт тусгалгүй орхигдуулсан байна. Үлдсэн 21 хүнээс хамгийн бага нь 18 настай, хамгийн өндөр нь 51 настай хүн байх бөгөөд гэмт хэрэг үйлдсэн хүний дундаж нас 34 байна.

Хулгайлах үйлдэл нь мөн чанартаа нэг үйлдэл бөгөөд үүнийг том, жижиг гэж хоёр хуваах нь шударга ёсны зарчимд харшилдаг. Шударга ёсны зарчмын хүрээнд авч үзвэл Эрүүгийн хуулийн 17 дугаар зүйлийн хүндрүүлэх шинж болох «орон байранд нэвтэрсэн" хулгайлах үйлдэлд хохирол шаардахгүй атлаа, «нэвтрээгүй" үйлдэлд 300.000 төгрөгнөөс дээш хохирол шаардаж байгаа нь учир дутагдалтай юм.[41]

Практикт маргаан үүсгэсэд буй асуудлыг ерөнхийлөн авч үзвэл Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарт "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар

[39] shuukh.mn (Сүүлд үзсэн огноо 2019.3.4.)

[40] Дэлгэрэнгүйг хавсралт 4-өөс үзнэ үү.

[41] Б.Өнөрмаа, Г.Оюунболд, "Эрүүгийн хуулийн хэрэгжилт" нийтлэл, 2017 он. Дэлгэрэнгүйг http://www.prokuror.mn/a/1946 үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2019.2.21)

хамаарахгүй” гэсэн бичвэрийг хуульчилсан явдал юм.

Тайлбарын энэхүү хэсгийг судлаач Г.Ганбаатар “Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ” нийтлэлдээ “Монгол Улсын Үндсэн хуулийн “хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг эрхэмлэн дээдэлж, эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх” эрхэм зорилго, мөн тус хуулиар хамгаалсан үнэт зүйлс, шударга ёс Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын “хүнтэй ... хүнлэг бусаар харьцах буюу шийтгэхийг хориглосон” 7 дугаар зүйлийг зөрчсөн гэж үзэх үндэслэлийг бүрдүүлсэн[42] хэмээн дүгнэсэн байна.

Нөгөөтээгүүр, энэхүү тайлбарыг утгачилан ойлговол Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсгийн “энэ гэмт хэргийг...” гэдэг нь Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний шинж бүрэн хангагдсан тухайн гэмт хэргийг л ойлгодог. Тийм ч учраас гэмт хэргийн үндсэн бүрэлдэхүүний дараа харин хүндрүүлэх бүрэлдэхүүний өмнө нь “ энэ гэмт хэргийг...” гэж Эрүүгийн хуулийн тухайн зүйлийн 2, 3 дахь (хэдэн хэсэгтэй ч байж болно) хэсэг болгон тусгайлан хуульчлан заадаг ба тус хэсгийн заалт болгож тус гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг нарийвчилсан, дэс дараалсан байдлаар зохицуулдаг.[43]

Дээрхээс дүгнэвэл, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгийн “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасныг практикт хэрэгжүүлэхэд сөрөг нөлөө үүсгэж, хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр бусдад бага хэмжээний хохирол учруулж хулгайлах гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 2-12 жилийн хорих ял оногдуулахаар хуульчилсан нь хорих ял эдлэх хүний тоог нэмэгдүүлэхээр байна гэж үзэж байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. ДҮГНЭЛТ

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдсөнөөс хойш жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хугацаанд эрх зүйн хийдэлтэй зохицуулалт болон маргаан дагуулж буй заалтуудыг хэрхэн засаж, сайжруулах талаар олон талын сургалт, хэлэлцүүлэг[44], судалгаанууд хийгдсээр байгаа билээ. Энэ хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар буюу 17.1 дүгээр зүйлийн 2,3 дахь хэсгийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, дараахь дүгнэлтэд хүрч байна. Үүнд:

1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбарт “...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй” гэж заасныг практикт хэрэгжүүлэхэд сөрөг нөлөөлөл үзүүлж байгаа нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Хамгийн түгээмэл байдлаар Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт заасан *“... хүн байнга амьдрах, үйл ажиллагаа явуулах зориулалттай орон байр, тусгайлан хамгаалсан байр, агуулахад нэвтэрсэн”, мөн зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан “учрах саадыг арилгах зорилгоор зэвсэг, тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл хэрэглэж, машин механизм ашиглаж үйлдсэн”* хэргүүдэд хохирлын хэмжээ нь 300.000 төгрөг хүрээгүй хэргүүд байсан боловч шүүхээс эдгээр хэрэгт хуульд заасан үндэслэл журмын дагуу хорих ял оногдуулан шийдвэрлэж байна.

[42] Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018 он, №2, 80 дахь тал.

[43] Мөн тэнд.

[44] Тухайлбал, УИХ-ын ХЗБХ, ХЗДХЯ-тай хамтран “Эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх хэлэлцүүлэг”, “Шүүхийн шийдвэр түүний хэрэглээ ач холбогдол” сэдэвт хэлэлцүүлэг, “Эрүүгийн хуулийн шинэтгэлийн үйл явц” сэдэвт хэлэлцүүлэг, “Хүний эрх, эрх чөлөөний хууль зүйн баталгаа - онол практикийн асуудал” олон улсын эрдэм шинжилгээний хурал гэх мэт.

Өөрөөр хэлбэл, хулгайлах гэмт хэргийг Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдэж бусдад 1-300.000 төгрөгийн хохирол учруулсан үйлдэлдээ гэмт хэрэг үйлдсэн хүн 2-12 жилийн хорих ял шийтгүүлэхээр хуульчилжээ.

Энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүний эрх зүйн байдлыг дордуулахын зэрэгцээ Эрүүгийн хуулийн 1.3 дугаар зүйлд заасан "Шударга ёсны зарчим"-тай зөрчилдөж байна хэмээн дүгнэж болох юм.

2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт дан ганц хорих ял оногдуулахаар хуульчилсан нь тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, учруулсан хохирол зэрэг олон шалтгаан нөхцөлийг шүүх тал бүрээс нь бүрэн бодитой хянан шийдвэрлэж, гэмт хэрэг үйлдсэн хүнд тохирох ял шийтгэлийг оногдуулахад хязгаарлагдмал байдлыг бий болгож байна хэмээн үзэж болох юм.

Энэхүү судалгааны явцад шүүгч, прокуроруудаас анкетын аргаар судалгаа авахад энэ гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг гэмт хэрэг үйлдсэн хүнд оногдуулах боломжтой гэж нийт оролцогчдын 39.8 хувь нь хариулсан нь энэ гэмт хэрэгт оногдуулах ялын төрлийг нэмж хуульчлах боломжийг судлан үзэх шаардлагатай болохыг илэрхийлж байна.

4.2. ЗӨВЛӨМЖ

Судалгааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг гаргаж байна. Үүний тулд:

1. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсгээс "...Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт энэ тайлбар хамаарахгүй" гэсэн хэсгийг хасах;

2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ялын төрлийг нэмэх. Тухайлбал, арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ялыг нэмэх.45

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ТӨЛӨЛ
www.nlt.gov.mn

[45] Практикт түгээмэл үйлдэгддэг гэмт хэргийн нэг болох Эрүүгийн хуулийн 17.3 дугаар зүйлд заасан "Залилах" гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнтэйгээр үйлдсэн тохиолдолд энэ хуулийн 17.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "...арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заасныг харгалзан үзэж дээрх саналыг гаргасан болно.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 1992, №1;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2002, №5;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2016, №7;
- Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол.

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Монгол Улсын Эрүүгийн хуулийг шинэтгэх төслийн санал, ХЗЯ, 2010 он;
- УИХ-ын гишүүн О.Батнасангийн санаачилсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2017 он;
- Эрүүгийн хуулийн төслийн үзэл баримтлал, ХЗЯ, 2013 он;
- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх танилцуулга, ХЗДХЯ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” судалгааны үндсэн тайлан, ХЗҮХ, 2016 он;
- “Эрх зүйн шинэтгэлийн бодлогын баримт бичиг боловсруулахад дэмжлэг үзүүлэх нь” хавсралт тайлан, ХЗҮХ, 2016 он;
- Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан.

Ном, сурах бичиг, гарын авлага

- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2016, МУГХУСАЗЗ, 2017 он;
- Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном -2017, МУГХУСАЗЗ, 2018 он
- Монгол Улсын 2002 ба 2015 оны Эрүүгийн хуулийн харьцуулсан судалгаа, МУИС-ХЗС, 2016 он;
- Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар, 2010 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүй /Ерөнхий ба тусгай анги/, 2011 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол – I боть, 2009 он;
- С.Жанцан, Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол /Ялын тухай сургаал/ - II боть, 2014 он;
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Анхны хэвлэл), 2007 он;
- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, 2017 он;
- Эрүүгийн эрх зүй гарын авлага, ХЗДХЯ, 2007 он.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Г.Ганбаатар, Ж.Эрдэнэбулган, “Эрүүгийн хуулийн шинэчлэлийн тухай цөөн үг” нийтлэл, 2017 он;
- Б.Ганболд, Хулгайлах гэмт хэрэг (Хуулийн амин сүнсний хулгай), Шүүх эрх мэдэл сэтгүүл, №2 2018 он;
- Г.Ганбаатар, Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйл дэх тайлбарт хийсэн дүн шинжилгээ, Шүүх эрх мэдэл сэтгүүл №2, 2018 он;
- Д.Нямбат, Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан “Хулгайлах” гэмт хэрэгт оногдуулах ял шийтгэлийн үр нөлөөнд татгалзуулах онол (deterrenve theory)-ын үүднээс хийсэн дүн шинжилгээ;
- Б.Өнөрмаа, Г.Оюунболд, “Эрүүгийн хуулийн хэрэгжилт” нийтлэл, 2017 он.

Цахим эх сурвалж

- Shuukh.mn, Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан;

Хуулийн хэрэгжилтийн судлал www.hi.gov.mn

- Prokuror.mn, Монгол Улсын Ерөнхий Прокурорын Газрын албан ёсны цахим хуудас;
- Judcouncil.mn, Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн албан ёсны цахим хуудас.

Хавсралт 1.

Анкетын судалгааны нийт үр дүн

Судалгаанд оролцогч	Судалгаанд оролцогчдын тоо	Хувь
Шүүгч	158	67
Прокурор	78	33
Нийт	236	100

Асуулт 1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг байх шаардлагатай юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	171	72.5
2	Шаардлагагүй.	65	27.5
Нийт		236	100

Асуулт 2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хохирлын хэмжээг тусгаж өгөх шаардлагатай юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	198	83.9
2	Шаардлагагүй.	29	16.1
Нийт		236	100

Асуулт 3. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүн тэр дундаа гэмт хэргийн улмаас бага хэмжээний хохирол бусдад учруулсан тохиолдолд оногдуулах ялын хэмжээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохирч байгаа эсэх?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	20	8.5
2	Үгүй	122	51.7
3	Ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг оногдуулах боломжтой.	94	39.8
Нийт		236	100

Асуулт 4. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт ялын төрлийг нэмэх шаардлагатай юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	170	72
2	Шаардлагагүй.	66	28
Нийт		236	100

Асуулт 5. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохируулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой юу?

Хуулийн Үндэсний Хүрээлэн www.ilo.gov.mn

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Боломжтой. Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой.	88	37.3
2	Боломжгүй. Учир нь хууль тогтоогч 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт энэхүү гэмт хэрэгт хохирол шаардахгүй байхаар тодорхой байдлаар тусгасан.	148	62.7
Нийт		236	100

Асуулт 6. Та Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэсэн тохиолдол байгаа эсэх.

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	31	13.1
2	Үгүй	205	86.9
Нийт		236	100

Асуулт 7. Дээрхээс гадна Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийг практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй нөхцөл байдал байвал дурдана уу.

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	113	47.9
2	Хариулаагүй	123	52.1
Нийт		236	100

Асуулт 8. Танд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлтэй холбоотой засаж сайжруулах ямар санал байна вэ?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	116	49.1
2	Хариулаагүй	120	50.9
Нийт		236	100

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mjs.gov.mn

Хавсралт 2.

Шүүгчдээс авсан анкетын судалгааны үр дүн

№	Албан тушаал	Саналын тоо	Хувь
1	Хяналтын шатны шүүгч	0	0
2	Давж заалдах шатны шүүгч	44	27.8
3	Анхан шатны шүүгч	114	72.2
Нийт		158	100

Асуулт 1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг байх шаардлагатай юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	105	66.5
2	Шаардлагагүй.	53	33.5
Нийт		158	100

Асуулт 2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хохирлын хэмжээг тусгаж өгөх шаардлагатай юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	129	81.6
2	Шаардлагагүй.	29	18.4
Нийт		158	100

Асуулт 3. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүн тэр дундаа гэмт хэргийн улмаас бага хэмжээний хохирол бусдад учруулсан тохиолдолд оногдуулах ялын хэмжээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохирч байгаа эсэх?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	16	10.1
2	Үгүй	77	48.7
3	Ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг оногдуулах боломжтой.	65	41.2
Нийт		158	100

Асуулт 4. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт ялын төрлийг нэмэх шаардлагатай юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	115	72.8
2	Шаардлагагүй.	43	27.2
Нийт		158	100

Асуулт 5. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохируулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Боломжтой. Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой.	46	29.1

хуулийн үзэгдлийн хүрээлэн www.nli.gov.mn

2	Боломжгүй. Учир нь хууль тогтоогч 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт энэхүү гэмт хэрэгт хохирол шаардахгүй байхаар тодорхой байдлаар тусгасан.	112	70.9
Нийт		158	100

Асуулт 6. Та Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэсэн тохиолдол байгаа эсэх.

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	6	3.8%
2	Үгүй	152	96.2%
Нийт		158	100%

Асуулт 7. Дээрхээс гадна Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийг практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй нөхцөл байдал байвал дурдана уу.

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	69	43.7%
2	Хариулаагүй	89	56.3%
Нийт		158	100%

Асуулт 8. Танд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлтэй холбоотой засаж сайжруулах ямар санал байна уу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	66	41.8%
2	Хариулаагүй	92	58.2%
Нийт		158	100%

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУДАЛДАН
www.nlt.gov.mn

Хавсралт 3.

Прокуроруудаас авсан анкетын судалгааны үр дүн

№	Албан тушаал	Саналын тоо	Хувь
1	Туслах прокурор	1	1.3
2	Ахлах прокурор	15	19.2
3	Хяналтын прокурор	62	79.5
Нийт		78	100

Асуулт 1. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэг байх шаардлагатай юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	66	84.6
2	Шаардлагагүй.	12	15.4
Нийт		78	100

Асуулт 2. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт хохирлын хэмжээг тусгаж өгөх шаардлагатай юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	69	88.5
2	Шаардлагагүй.	9	11.5
Нийт		78	100

Асуулт 3. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдсэн хүн тэр дундаа гэмт хэргийн улмаас бага хэмжээний хохирол бусдад учруулсан тохиолдолд оногдуулах ялын хэмжээ гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохирч байгаа эсэх?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	4	5.1
2	Үгүй	45	57.7
3	Ялын төрлийг нэмж, сонголттой болгосноор тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан тохирох ялыг оногдуулах боломжтой.	29	37.2
Нийт		78	100

Асуулт 4. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт ялын төрлийг нэмэх шаардлагатай юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Шаардлагатай.	55	70.5
2	Шаардлагагүй.	23	29.5
Нийт		78	100

Асуулт 5. Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бусдад бага хэмжээний хохирол учруулсан тохиолдолд тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанарт тохируулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар тухайн үйлдлийг гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой юу?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Боломжтой. Тухайн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанараас хамааруулан гэмт хэрэгт тооцохгүй байх боломжтой.	36	46.1

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

2	Боломжгүй. Учир нь хууль тогтоогч 17.1 дүгээр зүйлийн тайлбар хэсэгт энэхүү гэмт хэрэгт хохирол шаардахгүй байхаар тодорхой байдлаар тусгасан.	42	53.8
Нийт		78	100

Асуулт 6. Та Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж бага хэмжээний хохирол бусдад учруулсан хэрэгт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн гэмт хэрэгт тооцохгүй байдлаар хэрэг шийдвэрлэсэн тохиолдол байгаа эсэх.

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Тийм	25	32.1
2	Үгүй	53	67.9
Нийт		78	100

Асуулт 7. Дээрхээс гадна Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлийг практикт хэрэгжүүлэхэд тулгамдаж буй нөхцөл байдал байвал дурдана уу.

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	44	56.4
2	Хариулаагүй	34	43.6
Нийт		78	100

Асуулт 8. Танд Эрүүгийн хуулийн 17.1 дүгээр зүйлтэй холбоотой засаж сайжруулах ямар санал байна вэ?

№	Хариулсан байдал	Саналын тоо	Хувь
1	Хариулсан	50	64.1
2	Хариулаагүй	28	35.9
Нийт		78	100

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУУЛЬЧИЙН ХЭЛТЭС
www.mn.gov.mn

Хавсралт 4.

Санамсаргүй түүврийн аргаар сонгон судалсан хэргүүд

Д/Д	Шүүхийн шийдвэрийн нэр	Шүүгдэгч, нас	Хохирлын хэмжээ	Хэргийг шийдвэрлэсэн байдал
1	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн №107 дугаар тогтоол	Н.Б, 43 настай	151,000	2 жил хорих ял
2	Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн №0231 дугаар тогтоол	М.Б, С.Н нас нь тодорхойгүй	272,100	М.Б- 2 жил хорих ял С.Н- 1 жил хорих ял
3	Дундговь аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн №64 дүгээр тогтоол	Л.Э, 31 настай	120,000	1 жил хорих ял
4	Сэлэнгэ аймаг Мандал сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн №00120 дугаар тогтоол	А.А, 41 настай	160,000	1 жил 1 хоног хорих ял
5	Сэлэнгэ аймаг Мандал сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн №00149 дүгээр тогтоол	Б.Э, 34 настай Б.М, 31 настай	114,500	Тус тус 1 жилийн хорих ял
6	Сэлэнгэ аймаг Сайхан сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн №02 дугаар тогтоол	Б.О 33 настай	20,000	2 жил хорих ял
7	Хэнтий аймаг Бор-Өндөр сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн №58 дугаар тогтоол	Х.Д, өсвөр нас	220,000	1 жил хүмүүжлийн чанартай албадлагын арга хэмжээ
8	Говьсүмбэр аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн №2019/ШЦТ/03 дугаар тогтоол	Ц.Г, 35 настай	170,000	2 жил хорих ял
9	Дархан-Уул аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн №401 дүгээр тогтоол	О.Г, 22 настай	240,000	2 жил хорих ял
10	Өвөрхангай аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн №194 дүгээр тогтоол	Л.Н, Нас тодорхойгүй	280,000	1 жил хорих ял
11	Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн №203 дугаар тогтоол	Б.Гантулга, 47 настай	100,000	1 жил 2 сар хорих ял
12	Сэлэнгэ аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн №235 дугаар тогтоол	А.Мөнхбат, 30 настай	50,000	1 жил хорих ял
13	Увс аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 16-ны өдрийн №05 дугаар тогтоол	Э.Б, 18 настай	256,000	1 жил хорих ял
14	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн №00344 дүгээр тогтоол	Н.Л, Д.Б нас нь тодорхойгүй	182,000	1 жил хорих ял
15	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн №873 дугаар тогтоол	Ц.Х, 43 настай	291,500	2 жил хорих ял

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭС ХҮРЭЭЛЭН www.ali.gov.mn

16	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн №887 дугаар тогтоол	Т.Т, 25 настай	300,000	2 жил хорих ял
17	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн №79 дүгээр тогтоол	Н.З, 34 настай	Өнгөлгөөний дрилл 2 ширхэг	2 жил хорих ял
18	Хан-Уул дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн №11 дүгээр тогтоол	Б.М, 51 настай	100,000	2 жил 1 сар хорих ял
19	Сонгинохайрхан дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн №23 дугаар тогтоол	С.Б, 41 настай	150,000	1 жил 1 сар хорих ял
20	Дорнод аймаг дахь сум дундын Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн №16 дугаар тогтоол	Б.Э, 26 настай	240,000	1 жил хорих ял
21	Хөвсгөл аймаг дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №00286 дугаар тогтоол	Х.М,	152,000	1 жил 1 сар хорих ял
22	Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь сум дундын шүүхийн 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №110 дугаар тогтоол	Л.Б,	51,250	1 жил хорих ял
23	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн №389 дүгээр тогтоол	З.Б, 27 настай	160,000	1 жил хорих ял
24	Дорнод аймаг дахь сум дунлын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн №2018/ШЦТ/324 дүгээр тогтоол	Д.М,	140,000	1 жил хорих ял
25	Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн 2018 оны 11 дугаар сарын 21-ний өдрийн №00333 дугаар тогтоол	С.Б	275,500	1 жил хорих ял
26	Өвөрхангай аймаг Хархорин сум дахь сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн №2018/ШЦТ/84 дүгээр тогтоол	Д.Т, 25 настай	177,300	1 жил хорих ял
27	Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн №806 дугаар тогтоол	Д.А, 46 настай	280,680	1 жил 5 сар хорих ял

ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГААНЫ ТАЙЛАН[46]

Удиртгал

Монгол Улсын Үндсэн хуулийн /цаашид "Үндсэн хууль" гэх/[47] Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө" гэж заасан. Мөн хуулийн "Хүний эрх, эрх чөлөө" хэмээх Хоёрдугаар бүлэгт тус үндсэн эрхүүдийг хуульчлан баталгаажуулсан байдаг. Ингэхдээ хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр хариуцахаар үүрэг хүлээсэн.

1992 оны Үндсэн хуульд ийнхүү хуульчилсны дараагаар 1995 онд "Онц байдлын тухай" хуулийг /цаашид "ОБтХ" гэх/[48] баталж, өнөөдрийг хүртэл дагаж мөрдөж

[46] Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний Б.Ариунжаргал, Ц.Оюунчимэг, С.Цэрэндолгор нар хамтран гүйцэтгэв.

[47] Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1

[48] Төрийн мэдээлэл эмхэтгэл (1996), №2

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДСЭН ХУРЭЭЛЭН www.ulsgov.mn

байгаа билээ. Тус хуулиар онц байдал зарлах үндэслэл, журам, онц байдлын үед хэрэгжүүлэх онцгой арга хэмжээ, онц байдлыг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрхийг тогтоож, онц байдал зарласантай холбогдсон бусад харилцааг зохицуулсан.

Түүнчлэн ОБтХ-ийн 18 дугаар зүйлд онц байдлын үед үл хөндөгдөх иргэний эрх, эрх чөлөөг зааж өгсөн бөгөөд онц байдал зарласан үед гадаад харилцааны асуудал эрхэлсэн Монгол Улсын сайд онц байдлын үед Монгол Улс Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт /цаашид "ИБУТЭТОУП" гэх/49-аар хүлээсэн үүргээс татгалзахад хүргэсэн хүний эрх, эрх чөлөөг хязгаарлахтай холбогдсон ямар онцгой арга хэмжээг, ямар үндэслэлээр авч хэрэгжүүлэхээр тогтоож байгаа болон түүнийгээ хэдийд цуцлах тухайгаа Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдээлэх тухай ОБтХ-ийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хуульчилжээ.

Монгол Улс Нэгдсэн Үндэстний Байгууллага /цаашид "НҮБ" гэх/-д гишүүнээр элссэнээсээ хойш ИБУТЭТОУП, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон Улсын Пакт50 зэрэг хүний эрхийн талаарх НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудаас баталсан Олон Улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, үүрэг хүлээсээр иржээ.

Энэ хүрээнд ИБУТЭТОУП-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын зургаа дахь удаагийн ээлжит тайланд Хүний эрхийн хорооноос өгсөн дүгнэлттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжүүдийг 2018-2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө"-ний 15 дахь хэсэгт заасан "Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Онц байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар анхаарч үзэх" гэсэн зөвлөмжийн хүрээнд хийгдэх ажлыг "Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу онц байдлын талаарх зохицуулалтын талаар нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль боловсруулах шаардлагатай эсэх талаар тандан судалгаа хийх" гэж тодорхойлсон байна.

Иймд дээрх хэрэгцээ шаардлагад үндэслэн ОБтХ-д тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэхийг тодруулахыг зорилоо.

Судалгааны аргачлал:

Тус судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу дараах үе шатаар хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Зохицуулалтын хувилбаруудыг харьцуулж дүгнэлт хийх;
6. Тухайн зохицуулалтын талаарх Олон Улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
7. Зөвлөмж боловсруулах.

Дээрх дараалын дагуу нэгдүгээрт "онц байдал"-тай холбогдох ойлголт, харилцааг судалж, ОБтХ-д үүсэж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Үүний тулд Монгол Улсын болон бусад орны хууль тогтоомж, Олон Улсын байгууллагаас гаргасан баримт бичиг, Олон Улсын гэрээ, холбогдох ном сурах бичиг, өмнө хийгдсэн социологийн судалгаа, судалгааны тайлан, илтгэл, өгүүллийг уншиж судлах, харьцуулалт хийх болон бусад статистик мэдээллийг ашигласан бөгөөд асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны

[49] Монгол Улсын Олон Улсын гэрээ, Иргэний болон улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт, НҮБ, 1966, https://www.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257 хаягаас үзнэ үү.

[50] Монгол Улсын Олон Улсын гэрээ, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай Олон Улсын Пакт, НҮБ, 1966, https://www.legalinfo.mn/law/details/1284?lawid=1284 хаягаас үзнэ үү.

ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг болон тухайн асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тус тус тодорхойлов.

Асуудлыг тодорхойлсны дараагаар асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгоо томьёолж, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Тухайн үе шатанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч үр нөлөөг судлав.

Эцэст нь тухайн хувилбаруудаас сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулаа.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

ОБтХ батлагдан, хэрэгжиж эхлээд 24 жил болж байна. Энэ хугацаанд тус хуульд нийт 4 удаа нэмэлт, өөрчлөлт орсон. Харин хууль хэрэгжих хугацаанд буюу Монгол Улс түүхэндээ ганцхан удаа 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 194 дүгээр зарлигийн[51] дагуу "Нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт бүлэг хүмүүсийн хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн эмх замбараагүй байдал үүсч, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад халдан амь насанд нь заналхийлж, эд хөрөнгө устгах, галдан шатаах үйл ажиллагаа даамжирч нийтийн эмх замбараагүй байдал бий болсон тул энэхүү онцгой нөхцөл, үр дагаврыг арилгах , хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор..." онц байдал тогтоосон байдаг.

Онц байдал зарласнаар нийгэм, эдийн засаг, хүний эрх зэрэг нийгмийн олон талт харилцаанд тодорхой хэмжээнд нөлөө үзүүлдэг. Тухайлбал, Онц байдал зарлах болсон шалтгаан, нөхцөлөөс хамаарч эдийн засагт онц байдал зарласан болон зарласны дараа авч хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулах төсөв нь улс орны эдийн засагт шууд байдлаар нөлөө үзүүлэх боломжтой.

Монгол Улсад 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр онц байдал зарлах болсон шалтгаан, нөхцөлтэй холбоотойгоор төрөөс МАХН-ын байрыг шинээр барих, үймээнээр гэмтсэн цагдаагийн алба хаагчдад нөхөн олговор олгох зэрэг асуудалд улсаас төсөв, санхүүжилт олгосон. Тухайлбал, УИХ-аас 2009 оны 7 дугаар сарын 09-ний өдөр "Хохирогчид нөхөх олговор олгох тухай хууль"[52]-ийг баталж, улсын төсвөөс 17.1 тэрбум төгрөг зарцуулсан байна. Мөн Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 294 дүгээр тогтоолын дагуу нөхөх олговор олгох болсонтой холбогдуулан 2008 оны нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын үеэр албан үүргээ гүйцэтгэж байхдаа гэмтэж бэртсэн 396 цагдаагийн алба хаагчдад нийт 442.5 сая төгрөгийн нөхөх олговор олгуулах ажлыг зохион байгуулсан"[53] байна.

Мөн хуульд заасан онц байдал зарлаж болох үндэслэлд малын гоц халдварт өвчин, ган, зуд зэрэг манай улсад түгээмэл тохиолддог үзэгдлүүд хамаардаг бөгөөд хэдийгээр өнөөдрийг хүртэл дээрх асуудлуудын хүрээнд онц байдал зарлаж байгаагүй ч тухай бүрт нь төрөөс санхүүгийн дэмжлэг олгон, шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлсээр ирсэн. Тухайлбал, 2016-2017 онд зудтай, зудархуу байгаа аймаг, сумдад тусламж үзүүлэхээр Засгийн газрын зүгээс 48.2 тэрбум төгрөгийн тусламж, дэмжлэг үзүүлсэн юм.

Энэ мэтчилэн онц байдал зарлах нөхцөл байдал болон онц байдал зарласан үед уг асуудал нь зарласан хугацаа, тухайн нөхцөл байдлаас хамаарч улсын эдийн засагт тодорхой хэмжээнд өөр өөр үр нөлөө үзүүлэх боломжтой.

Онц байдал зарласнаар хүний эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлах, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулах, төрийн болон аж ахуйн нэгж,

[51] Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 7 дугаар сарын 1-ний 194 дүгээр зарлиг, "Онц байдал тогтоох тухай", https://www.legalinfo.mn/law/details/762?lawid=762 хаягаас үзнэ үү.

[52] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2009), №28

[53] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит зургаа дахь тайлан, (УБ: 2015), 5 дахь тал.

байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар хязгаарлалт тогтоох зэрэг үйл ажиллагаа шаардлагатай болдог тул энэ утгаар нийгэмд мөн тодорхой үр нөлөөг үзүүлэх боломжтой юм.

Дээрх туршлагад үндэслэн ОБтХ-тай холбоотой асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, ямар арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлэх, хуулийн зохицуулалтын ач холбогдол, эерэг, сөрөг талыг судлан, цаашид уг хуулийг засан сайжруулж ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль боловсруулах шаардлагатай эсэхийг энэхүү судалгааны хүрээнд судлан үзнэ.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор дээрх тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудлууд анхаарал татаж байна. Үүнд:

- Онц байдал зарласан үед ямар арга хэмжээг хэн, хэрхэн авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны талаарх нарийвчилсан зохицуулалт дутмаг байгаа асуудал;
- Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх болсноор ялын төрлөөс цаазаар авах ялыг халсан. Гэтэл ОБтХ-ийн 15 дугаар зүйлд заасан “Онц байдал үргэлжлэх хугацаанд цаазаар авах ял гүйцэтгэхгүй байх” зохицуулалт хүчин төгөлдөр үйлчилж байгаа нь зөв эсэх;
- Монгол Улсад түгээмэл тохиолддог малын гоц халдварт өвчин, ган, зуд болсон тохиолдлуудад онц байдал зарлахгүй хэрнээ тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын захирамж, Засгийн газрын тогтоолоор хүний эрхийг /тухайлбал, чөлөөтэй зорчих эрх/ хязгаарлаж байгаа нь хууль зүйн үндэслэлтэй эсэх.

Эдгээр асуудлыг харгалзан судалгааны цар хүрээг өргөн хүрээнд авч үзэх нь тохиромжтой байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох[54]

Онц байдал нь улс орны амьдралд нөлөөлөхүйц онцгой нөхцөл байдал бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарласан шалтгаан, нөхцөлөөс хамаарч хүний эрх, эрх чөлөөг хязгаарладаг тусгай үйл ажиллагаа тул төрөөс Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах үүргээ биелүүлэх, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор авч хэрэгжүүлж буй арга хэмжээ юм.

Иймд нэг талаас онц байдал зарласнаар хүний эрхийг тодорхой хүрээнд хязгаарлах боломжтой, нөгөө талаас ийнхүү эрхийг нь хязгаарлаж буй үйлдэл нь нийтийн сайн сайхны төлөө буюу нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилготой байдаг.

Тухайлбал, 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Онц байдал тогтоох тухай” 194 дүгээр зарлигт “... Үндэсний олон нийтийн радио телевизээс бусад телевизийн үйл ажиллагааг онцгой байдлыг цуцлах хүртэл зогсоох” зохицуулалтыг тусгаснаар иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхол хөндөгдөж байна. Тодруулбал, Үндэсний олон нийтийн радио телевизээс бусад телевизийн үйл ажиллагааг зогсоож байгаа нь бусад олон нийтийн мэдээлэл дамжуулах эрх бүхий байгууллагын /хуулийн этгээдийн/ эрх болон иргэдийн

[54] Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Харин манай тохиолдол нь “аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй тул энэхүү судалгааны 1.2 дахь хэсгийн нэршлээс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй бүлгийг хассан болно.

мэдээлэл авах эрхийг тодорхой хэмжээнд хязгаарласан буюу хөндсөн байна.

Иймд онц байдал зарласан үед улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсэгт байгаа дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх боломжтой гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Хүн ам	Онц байдал зарлах болсон шалтгаан нөхцөлөөс хамаарч тухайн онц байдал зарласан нутаг дэвсгэрт амьдарч буй хүн амын /иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн/ Үндсэн хуулиар хамгаалагдсан зарим эрх, эрх чөлөөг хязгаарлаж болно. Ийнхүү эрхээ хязгаарлуулж буй хүн амын эрх ашиг нь хөндөгдөх боломжтой.
2	Өмчийн бүх хэлбэрээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага /хуулийн этгээд/	Онц байдал зарлах болсон шалтгаан нөхцөлөөс хамаарч зарим хуулийн этгээд, байгууллагын үйл ажиллагаа түр зогсоож болно.

Ерөнхийд нь авч үзвэл онц байдал зарласан үед иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлах боломжтой юм. Үүнтэй холбоотойгоор иргэн, хуулийн этгээд, байгууллагын эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх магадлалтай.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэг, ОБтХ-ийн 4 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал бий болсон үед онц байдал зарлаж болно.

Эдгээр үндэслэлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон эсхүл Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон зэрэг тохиолдол хамаарч байна.

Онц байдал зарлах нь энгийн үзэгдэл биш бөгөөд шаардлагатай, зайлшгүй тохиолдолд л зарладаг. Тиймдээ ч Үндсэн хуульд онц байдал зарласан үед хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлахаар хуульчилсан юм.

ОБтХ-ийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөл байдал бий болсны улмаас Монгол Улс түүхэндээ ганцхан удаа онц байдал зарласан.

Онц байдал зарласнаар хүний эрх, эрх чөлөөнд төрөөс халдах боломж нээгддэг. Гэвч энэхүү халдлага нь зохих хэмжээнд байх ёстой. Олон Улсын эрх зүйд тухайлан хэзээд зөрчиж үл болох эрхийн тоонд оруулсан ч онц байдлын үед зөрчигдөхөд ойрхон байдаг хамгийн эмзэг эрхүүдэд:[55]

- Хүний амьд авах эрх;
- Хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрх;
- Хэнийг ч дур мэдэн баривчлахгүй байх;
- Баривчлагдан саатуулагдсан үед хэнтэй ч хүнлэг ёсоор харьцах, эрүүдэн шүүхээс ангид байх тухай эрхүүд орно. Учир нь төр өөрөө хүний эрх, эрх чөлөөг гол зөрчигч байдаг тул илүү ноцтой нөхцөл байдал үүсгэх боломжтой.

Иймээс онц байдлын үед дээр дурдсан заяамал эрх, эрх чөлөөг зөрчиж болохгүйг ИБУТЭТОУП-аар сануулсан байдаг.

Манай улсын хувьд 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр онц байдал зарлаж, улмаар онц байдал зарласантай холбоотойгоор авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь

[55] Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг хамгааллын эвсэл /Баримтжуулалтын тайлан/, (УБ: 2008), “BCI” хэвлэлийн компани, 8 дахь тал.

Хуулийн шинжлэх ухааны хүрээлэн www.nlis.gov.mn

өнөөдрийг хүртэл шүүмжлэл, маргаан, асуудал дагуулсаар байна. Тухайлбал,

Онц байдал зарласан тухай мэдээллийг радио, телевизээр хүлээн авах боломжгүй байсан иргэдэд Ерөнхийлөгчийн зарлигийг толилуулах, түгээх арга хэмжээг бүрэн, шуурхай аваагүйн улмаас цуглаан, жагсаалд оролцоогүй зарим иргэд хоморголон баривчлагдсан явдал нэлээд гарсныг илрүүлсэн. Мөн түүнчлэн иргэний үнэмлэхтэй ч баригдсан, хотын өөр бусад хэсгээс ч баригдсан гэх хүмүүс байсан.[56]

Баривчлагдсан иргэдийг хорихдоо хэт олноор нь хорих болон гэрэл агаарын хангамж муутай, хэт халуун эсвэл хүйтэн орчинд байх нь баривчлагдагсдын аюулгүй байдал, халдашгүй байдлыг үл хайхарсан хууль бус үйлдэл юм. Ялангуяа гэм буруутай нь нотлогдоогүй иргэдийг жинхэнэ гэмт хэрэгтнүүдтэй хорьж байгаа нь аюулгүй байдалд ноцтойгоор заналхийлсэн явдал болно гэж Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг, хамгаалын эвсэлийн баримтжуулалтын тайланд[57] дурджээ.

Монгол Улсын түүхэнд сөрөг үр дагавар үлдээсэн 2008 оны 7 сарын 1-ний өдрийн үймээн самууны үед хүний эрх ноцтой зөрчигдсөн болох нь Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, ажлын хэсгийн санал, дүгнэлт, төрийн бус байгууллагуудын гаргасан тайлан мэдээнд тусгагдсан байна.

2008 онд онц байдал зарлах үед манай улсын хувьд өмнө нь онц байдал зарлаж байсан туршлага байхгүй /гэнэтийн үймээн самууны үед ямар арга хэмжээг, хэн, хэрхэн, яаж хэрэгжүүлэх нь тодорхойгүй байснаас/, тухайн үеийн хурцадмал нөхцөл байдалд балмагдсан цагдаагийн алба хаагчдын хувьд хуульд заасан үндэслэл журмын дагуу үйл ажиллагаагаа хэрэгжүүлээгүй зэрэг шалтгааны улмаас тухайн үед хүний эрхийг ноцтой зөрчсөн гэж үзэж болох юм.

Тиймээс онц байдал зарласан үед төрөөс авч хэрэгжүүлж буй арга хэмжээг хуульд заасан үндэслэл журмын дагуу явуулах, хүний үл хөндөж болох эрх, эрх чөлөөг хамгаалан ажиллахад анхаарах, бусад хууль тогтоомжийг аль болох сахин биелүүлэхэд чиглэх ёстой. Иймд онц байдал зарласан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ, байгууллагын эрх, үүрэг, зохион байгуулалтыг хуулиар нарийвчлан зохицуулах шаардлагатай болох нь харагдаж байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

ОБтХ батлагдан хүчин төгөлдөр үйлчилж буй нь Үндсэн хуульд заасан ёсоор онцгой нөхцөл байдал бий болсон үед онц байдал зарлах тухай зохицуулалтыг нарийвчлан зохицуулсан, тус харилцааны эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болох боловч хуулиар зохицуулагдаагүй үлдсэн болон засан сайжруулах шаардлагатай зарим асуудал байсаар байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан “ИБУТЭТОУП-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын зургаа дахь удаагийн ээлжит тайланд Хүний эрхийн хорооноос өгсөн дүгнэлттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжүүдийг 2018-2021 онд хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 15 дахь хэсэгт заасан “Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг болон Онц байдлын тухай хуульд нэмэлт, өөрлөлт оруулах талаар анхаарч үзэх” гэсэн зөвлөмжийн хүрээнд хийгдэх ажлыг “Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу онц байдлын талаарх зохицуулалтын талаар нэмэлт, өөрчлөлтийн тухай хууль боловсруулах шаардлагатай эсэх талаар тандан судалгаа хийх” гэж тодорхойлсон байна.

Мөн ОБтХ-ийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг “Энэ хуулийн зорилт нь онц байдал зарлах үндэслэл, журам, онц байдлын үед хэрэгжүүлэх онцгой арга хэмжээ, онц байдлыг хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрхийг тогтоож, онц

[56] Мөн тэнд, 12 дахь тал.

[57] Мөн тэнд, 22 дахь тал.

байдал зарласантай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино” хэмээн томьёолжээ. Энэ нь нэг талаас Үндсэн хуульд заасан зохицуулалтыг ердийн хуулиар дэлгэрэнгүй зохицуулах, нөгөө талаас онц байдал зарлах, түүний тухай ойлголт, холбогдох харилцааг зохицуулах журмыг нарийвчлах зэрэг зорилготой болов уу. Гэсэн хэдий ч онц байдал болон тус харилцааны хүрээнд тодруулах, боловсронгуй болгох шаардлагатай зарим асуудал тухайлбал, онц байдлын тухай ойлголтын дэлгэрэнгүй, хуулийн зарим зохицуулалт зорилго болон бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэх зэрэг асуудал байгаа юм.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго: “Онц байдлын тухай ойлголт, хамрах хүрээ хязгаарыг нарийвчлан тодруулах, хууль тогтоомжийн уялдаа холбоо болон онц байдлын үед хүний эрхийг хангах”

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, судалгаагаар тодорхойлсон “Онц байдлын тухай ойлголт, хамрах хүрээ хязгаарыг нарийвчлан тодруулах, хууль тогтоомжийн уялдаа холбоо болон онц байдлын үед хүний эрхийг хангах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 1. *Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал*

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.	Үр дүн сөрөг
2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгоо биелүүлэхэд зохих хэмжээгээр нөлөөлөх боломжтой. Гэвч өнөөгийн тулгамдаж буй бэрхшээлийг үр дүнтэй шийдвэрлэх боломжгүй буюу асуудал цаашид хэвээр үргэлжилнэ.	Зардал ихээхэн хэмжээнд шаардагдах бөгөөд ухуулга сурталчилгааг байнга идэвхтэй явуулахыг шаардана. Асуудлыг үүсгэх гол шалтгааныг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдээр одоо байгаа зохицуулалтыг тодорхой түвшинд дэмжих, сайжруулах боломжтой болно.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Онц байдал зарласан үед хүний эрхийг хангахад хууль тогтоомжгүйгээр бүрэн шийдвэрлэх боломжгүй.	Дан ганц санхүүжилтээр сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Онц байдлын үед хүний эрхийг хамгаалах ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоог дэмжих нь чухал ач холбогдолтой. Гэвч өнөөдрийн хууль тогтоомжийн хүрээнд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага ажиглагдахгүй байна.	Иргэний нийгмийн байгууллагыг оролцуулахад зохих хэмжээний зардал гарах боловч үр ашгаа өгнө.	Зарим үр дүн гарах боловч зорилгодоо хүрч чадахгүй

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nlrcgov.mn

6	Захиргааны шийдвэр гаргах	Онц байдал зарласан үед хүний үндсэн эрх хязгаарлагддаг тул Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “гагцхүү хуулиар хязгаарлах” ёстой. Иймд тус суурь харилцааг хууль тогтоомжоор хуульчлан баталгаажуулах нь оновчтой.	Хэдийгээр зарчмын хувьд онц байдалд хамаардаг зарим асуудлыг Засгийн газрын тогтоол зэрэг захиргааны шийдвэрээр зохицуулж буй боловч зохицуулалтын түвшин харилцан адилгүй, үр өгөөжгүй болох талтай. Захиргааны шийдвэр гаргах нь асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад тухайлсан тохиолдолд нөлөөлөх боломжтой ч сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Зарим үр дүн гарах боловч зорилгодоо хүрч чадахгүй
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Онц байдлын тухай ойлголт, хүрээ хязгаар, хэрэгжүүлэх арга замыг нэмэлт, өөрчлөлт оруулсан хууль батлах замаар бий болгох нь хамгийн оновчтой, тогтвортой хувилбар байна.	Нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай асуудлын хүрээнд зардал шаардагдахгүй бөгөөд энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй арга зам юм.	Зорилгодоо хүрэх боломжтой, үр дүнтэй

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, нийгмийн хэрэгцээ шаардлага, зохицуулалтын түвшинг харгалзан тулгамдаж буй асуудлыг хуулийн зохицуулалт хийх, тодруулбал, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Ингэхдээ “Онц байдлын тухай ойлголт, хамрах хүрээ хязгаарыг нарийвчлан тодруулах, хууль тогтоомжийн уялдаа холбоо болон онц байдлын үед хүний эрхийг хангах” зорилгын хүрээнд дараах боломжит зохицуулалтын 2 хувилбарыг дэвшүүллээ.

Хувилбар 1. Онц байдлын тухай ойлголт, төрөл, хамрах хүрээ хязгаарыг нарийвчлан тодруулах

Монгол Улсын хувьд Үндсэн хууль болон ОБтХ-даа онц байдлын тухай харьцангуй дэлгэрэнгүй тодорхойлсон нь сайшаалтай боловч онц байдал, түүний хүрээ хязгаар гэдэгт чухам юуг ойлгох, онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх талаар онолын болон практик түвшний тодорхойлолт, нарийвчилсан зохицуулалт бий болгох шаардлагатай байна.

Дээрх асуудлыг тодорхой болгосноор ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулахад анхаарах зүйлсийг тодотгох боломжтой болох юм. Иймд хувилбарын үр нөлөөг зорилгод хүрэх байдал болон зардал, үр өгөөжийн харьцаа, үр нөлөөг харьцуулан авч үзье.

1. Зорилгод хүрэх байдал

1.1. Онц байдлын тухай ерөнхий ойлголт

Онц байдалтай холбоотой олон асуудлыг тодруулахын тулд юун түрүүнд онц байдлын талаарх ерөнхий ойлголт, эрх зүйн үндэслэл, шалтгааныг авч үзэх шаардлагатай. Энэ хэсэгт дэлхий нийтийн онолын чиг хандлагыг эх газрын эрх зүйн бүлийн улсуудын жишээн дээр тайлбарлах ба Монгол Улсын зохицуулалтыг

Хуулийн үзэгдлийн судлалын www.ikh.edu.mn

харьцуулан авч үзэх замаар бэлтгэлээ.

Онц байдал гэдэг нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад ердийн үед зөвшөөрөгдөхөөргүй үйлдэл хийх бүрэн эрхийг олгож буй үйл ажиллагаа буюу байгалийн гамшиг, иргэний дайн, зэвсэгт мөргөлдөөн зэргийн үед зарлаж болох ажиллагаа юм. Онц байдлыг зарлах нь ард иргэдэд өдөр тутмын хэвийн байдлаа өөрчлөх болон Засгийн газрын агентлагуудад онц байдлын шийдвэрийг хэрэгжүүлэх нөхцөл байдлыг үүсгэнэ.[58]

Онц байдлын тухай ойлголт нь эртний Ромын эрх зүйн Юститиум (лат. Justitium)[59] гэх ойлголттой дүйх бөгөөд МЭӨ 465 онд Эквы омгийнхон дайрахаар айсуй гэсэн цуурхлаас болж хотод үймээн дэгдсэн тул анхны Юститиумыг зарлаж байжээ.

Олон Улсын эрх зүйн дагуу онц байдлын үед тухайлбал, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэлгүйгээр хүнийг цагдан хорих буюу эрх, эрх чөлөөг хязгаарлаж болно. Өөрөөр хэлбэл, ИБУТЭТОУП-д заасан аливаа эрхийг хязгаарлаж болох ба гагцхүү тус пактын 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрхүүдээс ухарч үл болно. Тодруулбал, “ухарч үл болох эрх” (англ. Non-derogable rights) гэдэгт амьд явах эрх, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс ангид байх эрх чөлөө зэрэг хамаарна.

Зарим улсууд онц байдлын үеэр Үндсэн хууль болон ОБтХ-даа нэмэлт, өөрчлөлт оруулах, нөгөө зарим нь Үндсэн хуулийн хүрээнд баталгаажуулсан эрх, зохицуулалтыг ямар ч үед, хүссэн хэлбэрээр өөрчлөх зэргээр Олон Улсын Пактыг зөрчдөг.[60] Үндсэн хууль нь Засгийн газар болон хувь этгээд хоорондын гэрээ байдаг тул ИБУТЭТОУП-д нэгдэн орсон улсууд заавал дагаж мөрдөх учиртай. Өөрөөр хэлбэл, онц байдалд хамаарах асуудлын хүрээг дураараа томьёолох боломжгүй юм. Пактад нэгдэн орсон гэдэг утгаар тус пактыг хувь этгээдээс илүү Засгийн газар биелүүлэх үүрэг хүлээх бөгөөд онц байдал зарласан тохиолдолд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдээлнэ.

Дээрх пактын зохицуулалтыг пактын гишүүн улсууд үндэсний хууль тогтоомжоор зохицуулах ёстой ба Монгол Улсын хувьд ОБтХ-ийн 7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт хуульчилжээ.

Онц байдал нь аливаа улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл болдог бөгөөд зарлах журам, эрх зүйн үндэслэлийг улсууд пактад нийцүүлэн янз бүрээр зохицуулж байна.

Дэлхий даяар, ялангуяа Англи-Америкийн эрх зүйд өргөн хэрэглэгддэг АНУ-ын хууль зүйн нэр томьёоны “Блэкийн хууль зүйн толь”-д “Үндэсний онц байдал” (англ. National emergency) гэж “Үндэсний хэмжээний хямралт байдал; Холбоо болон үндэсний хэмжээнд хойшлуулшгүй бөгөөд онц арга хэмжээ авахыг шаардсан нөхцөл байдал” -ыг ойлгохоор тайлбарласан[61] байна.

АНУ-ын Пеннсилвани мужийн Дүүргийн шүүхийн 1943 оны Дөрөвдүгээр сарын 13-ны Brown v. Bernstein, D.C.Pa., 49 F.Supp. 728 хэргийн шүүхийн шийдвэрт (прецедент) “Конгресс хууль батлахдаа “үндэсний онц байдал” болон “дайны байдал”-ын хоорондын ялгааг бараг тодорхойлоогүй байна”[62] гэжээ.

Блэкийн хууль зүйн толь төдийгүй 1943 оны шүүхийн шийдвэрт тусгагдсан байдлаас үзвэл, “Онц байдал” хэмээх ойлголт нь Англи-Америкийн эрх зүйд нэлээд

[58] Anna Khakee, Securing Democracy? A Comparative Analysis of Emergency Powers in Europe, Policy Paper No.30 (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.6.

[59] William Smith, William Wayte and G.E.Marindin, A Dictionary of Greek and Roman Antiquities, Volume 1. (London: John Murray, 1890), p.1052.

[60] “Declaratoria dello stato di emergenza e Consiglio supremo di difesa” *Nuovi studi politici* (gennaio-giugno 2005, n. 1/2): p. 107.

[61] Henry Campbell Black, *Black’s law dictionary*, 9th edition (St.Paul, Minn: West publishing Co, 2009), p.1122.

[62] Мөн тэнд.

эртнээс хэрэглэгдэж ирсэн гэж үзэж болохоор байна. Түүнчлэн эртний Ромын эрх зүйд МЭӨ 465 оноос хэрэглэсэн ойлголт гэж үзвэл эх газрын эрх зүйн бүлийн орнуудын хувьд мөн олон жилийн түүхтэй үйл ажиллагаа гэхээр байна.

Харин Монгол Улсын хувьд энэхүү ойлголт хэзээнээс нэвтэрсэн талаар түүх сөхвөл, 1940 оны БНМАУ-ын Үндсэн хуульд "онц байдал" гэсэн агуулга бүхий заалт байхгүй боловч хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 11 дэх хэсэгт "Бага хурлын чөлөө цагт хэрэв Бүгд Найрамдах Монгол Ард Улсад дайнаар довтлох буюу эсвэл харилцан туслалцаж дайран довтлогчдоос хамгаалалцахаар Олон Улсын хооронд тогтоосон гэрээний үүргийг гүйцэтгэх учир тохиолдвол Бага Хурал нь дайн бүхий байдлыг зарлах"[63] хэмээн Бага Хурлын Тэргүүлэгчдийн эрхлэх асуудлыг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, 1940 оны Үндсэн хуульд дайны байдал зарлах эрх зүйн зохицуулалт байсан боловч онц байдлын талаар тусгаагүй.

1960 оны БНМАУ-ын Үндсэн хуульд мөн "онц байдал" гэсэн ойлголт байхгүй бөгөөд гагцхүү хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн "р" дэх хэсэгт "БНМАУ-д халдан довтлоход буюу түүнчлэн харийн довтолгооноос харилцан бие биеэ хамгаалах талаар Олон Улсын гэрээгээр авсан үүргээ биелүүлэх хэрэгцээ тохиолдвол Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт дайны байдал зарлана"[64] хэмээн Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн бүрэн эрхийг заасан байна.

1992 оны Үндсэн хуульд анх удаа "онц байдал" гэсэн ойлголтыг дурдаж, хуулийн Арван есдүгээр зүйлийн 2, Хорин тавдугаар зүйлийн 1-ийн 18, мөн зүйлийн 2, Хорин долдугаар зүйлийн 5, Гучин гуравдугаар зүйлийн 1-ийн 12 дахь хэсэгт тус тус уг ойлголтыг хуульчилжээ.

Ингэхдээ Улсын Их Хурлаас 1995 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ОБтХ-ийг баталж, хуулийн 3 дугаар зүйлд "Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг онц байдал гэнэ" хэмээн тодорхойлжээ.

"Онц байдал"-ын тухай тайлбарласан монгол хэл дээр буй хууль зүйн тодорхойлолт нь хуулийн дээрх тодорхойлолт бөгөөд академич С.Нарангэрэлийн "Эрх зүйн эх толь бичиг"-т "тухайн улс орны амьдралд нөлөөлөхүйц онцгой нөхцөл байдал бий болсныг эрх зүйн үүднээс тодорхойлсон нэр томьёо"[65] хэмээжээ.

1.2. Онц байдлын төрөл

Онц байдлын төрөлд юу хамаарах талаар нэгдсэн тодорхойлолт, жагсаалт байхгүй бөгөөд улсууд үндэсний хууль тогтоомжоороо хүрээг нь томьёолж байна.

Байгалийн гамшиг болон тахал нь эмх замбараагүй байдал буюу төрийн эрхэд халдсан үйлдлээс ялгаатай хариу үйлдлийг шаардаж, ялгаатай үр дүнг бий болгодог. Мөн террорист халдлага нь эдийн засгийн хямрал буюу гадаадын зэвсэгт довтолгооноос ялгаатай. Энэ мэтчилэн нийгэмд гарч болох онц байдал хоорондын ялгаа нь Үндсэн хууль боловсруулагч болон энэ чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтдийн хувьд ихээхэн бэрхшээлтэй асуудал болдог байна.[66] Онц байдалд хамаарах асуудлын хүрээг тодорхойлж чадахгүй байх нь мөн онц байдлыг хуулиар зохицуулахтай холбогдсон харилцаанд эргэлзээ үүсэх үндэс болно. Дэлхий дахинд улсууд Үндсэн хуульдаа онц байдлын төрлийг зохицуулж буй хэлбэрээр нь дараах

[63] 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, Ханнс-Зайделийн сан (УБ: "Хөх судар принтинг" ХХК, 2007), 32 дахь тал.

[64] Мөн тэнд. 106 дахь тал.

[65] С.Нарангэрэл, *Эрх зүйн эх толь бичиг* (УБ: Адмон, 2007), 352-353 дахь тал.

[66] Anna Khakee, Securing Democracy? *A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30 (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.10.

байдлаар 3 ангилж болно:[67]

- Өргөн утгаар нь зохицуулж буй (Герман, Грек, Унгар, Польш, Португаль, Испани)
- Явцуу утгаар нь зохицуулж буй (Австри, Бельги, Кипр, Чех, Дани, Финланд, Люксембург, Норвеги, Швейцарь)
- Дундаж хүрээнд зохицуулж буй (Болгарь, Эстони, Франц, Ирланд, Итали, Латви, Литва, Мальт, Нидерланд, Румын, Словак, Словени, Швед)

Дээрхээс үзвэл онц байдал гэдэгт бүхий л төрлийн ноцтой аюул, байгалийн гамшиг, дайны байдал зэргийг хамааруулах эсэхийг улсууд Үндсэн хуульдаа ялгамжтай байдлаар зохицуулж байна.[68] Гэвч энэхүү ялгамжтай байдал гэдгийн зааг ялгаа нь нэг талаас дайны байдлыг онц байдалд хамааруулах эсэх, нөгөө талаас бусад онц байдлын төрлүүдийг хамааруулах эсэх гэсэн асуудалд оршино.

Саяхныг хүртэл захиргаадалтын дэглэмд байсан буюу Эстони, Польш, Испани зэрэг улсууд Үндсэн хуульдаа онц байдлыг илүү нарийвчилсан байдлаар зохицуулсан байна. Тодруулбал, үүнийг "гурван шатлалт тогтолцоо" (англ. Three-level system) гэх бөгөөд дайны байдал, онц байдал, байгалийн гамшиг зэргийг нийлүүлэн "онцгой арга хэмжээ" буюу "онц байдал" хэмээн томьёолжээ. Гэтэл Унгарын Үндсэн хуульд зааг ялгааг нь нарийн тодорхойлоогүй ч онц байдлын таван өөр түвшинг хуульчилжээ. Тэдгээр нь дайны байдал, үндэсний хямралт байдал, онц байдал, урьдчилан сэргийлэх батлан хамгаалах байдлыг зарлах эсхүл үргэлжлүүлэх зэрэг болно.

Ирээдүйд үүсэж болзошгүй онц байдлын хэлбэр, төрлийг урьдчилан нарийн тодорхойлох боломжгүй тул улсууд ихэвчлэн Үндсэн хуульдаа "Үндсэн хуулийн дэг журамд заналхийлсэн", "нийтийн дэг журамд ноцтой заналхийлсэн", "тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлсэн" зэрэг томьёоллоор онц байдлыг тусгажээ.[69]

Монгол Улсын хувьд онц байдал болон дайны байдлыг тусад нь авч үзсэн байх бөгөөд онц байдлыг дотор нь хоёр хуваасан байна:[70] (1) "улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон"; (2) "Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон" гэжээ. Үүнийг дээр дурдсан гурван шатлалт тогтолцоотой дүйцүүлбэл, (1) байгалийн гамшгийн нөхцөл байдал; (2) онц байдал хэмээн тодорхойлж болох юм. Өөрөөр хэлбэл, манай улс онц байдлыг өргөн утгаар нь Үндсэн хуульдаа зохицуулжээ.

1.3. Онц байдал зарлах, хугацааг сунгах, цуцлах бүрэн эрх ба эрх бүхий этгээд

Онолын хувьд онц байдал зарлах, хугацааг сунгах, цуцлах бүрэн эрхийг "онц байдлын бүрэн эрх" (англ. Emergency powers) гэх ба дайн, эмх замбараагүй байдал, террорист халдлага, улсад ноцтой аюул учруулах бусад байдал, байгалийн гамшиг, онц ноцтой үйлдвэрийн осол, тахал буюу их хэмжээний хүн амд аюул учруулахуйц онцгой нөхцөл байдлыг зогсоох зорилгоор Засгийн газар болон Ерөнхийлөгчид олгож буй онцгой эрхийг хэлдэг.[71] Гэвч дурдсан нөхцөл байдал үүссэнээс үл хамааран Үндсэн хуулийн арга хэрэгслээр зохицуулах боломжгүй, гагцхүү онц буюу

[67] Мөн тэнд, p.11.

[68] Мөн тэнд.

[69] Мөн тэнд, p.12.

[70] Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэг.

[71] Anna Khakee, *Securing Democracy? A Comparative Analysis of Emergency Powers in Europe,* Policy Paper No.30 (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.6.

гоц нөхцөл байдалд энэхүү бүрэн эрхийг хэрэгжүүлэхийг зөвшөөрдөг. Онц байдлын хувьд дараах хоёр асуудал хамгийн тодорхойгүй, маргаантай байдаг нь (1) хууль тогтоох, шүүх, гүйцэтгэх эрх мэдлийн тэнцвэрийг хадгалах; (2) эрх зүйт төр болон хүний эрхийг хамгаалах[72] гэсэн асуудлууд болно.

Онц байдал зарлах, хугацааг сунгах, цуцлах бүрэн эрхтэй субъектийг улсууд Үндсэн хуулиараа ялгаатай тодорхойлсон байна.

Онолын хувьд парламент нь онц байдлын үеийн дүрэм журмыг мөрдүүлэх шийдвэр гаргахад түлхүү оролцох бөгөөд онц байдал зарлах эрх Засгийн газар болон Ерөнхийлөгчид хадгалагддаг.[73]

Онц байдлын тухай асуудлыг нэн даруй шийдвэрлэх ёстой бөгөөд Парламентаас яаралтай арга хэмжээ авах боломжгүй нөхцөл байдалд авах нэмэлт арга хэмжээ гэж байх ёстой. Энэ тохиолдолд ихэвчлэн Засгийн газар эсхүл Ерөнхийлөгч онц байдлыг зарлана. Эх газрын эрх зүйн бүлийн орнуудын хувьд парламент арга хэмжээ авах боломжгүй нөхцөлд сонголт бүхий өөр шийдлийг хуульдаа зохицуулсан байна. Тухайлбал, ХБНГУ-д Хамтарсан хороо (улсыг батлан хамгаалах шаардлагатай байдалд байгаа үед Бундестаг болон Бундесратыг орлох эрх бүхий мини-парламент) нь онц байдал зарлах тухай шийдвэр гаргадаг бол Польшийн Үндсэн хуулиар парламентыг энэ асуудлын хүрээнд орлох бүрэн эрхийг Байнгын хороонд олгосон байна. Унгарын хувьд нэлээд өөр загвараар буюу Парламентын дарга, Үндсэн хуулийн шүүхийн дарга болон Ерөнхий сайд нар нь хамтран Ерөнхийлөгчийг парламентад онц байдал, үндэсний хямралт байдал, дайны байдал зарлах талаар танилцуулах эсэхийг шийддэг. Эцсийн шийдвэрийг парламентын гуравны хоёрын олонхоор шийдвэрлэнэ.

Түүнчлэн онц байдал зарлахад парламентын оролцоо сул буюу Ерөнхийлөгч дангаараа шийддэг улсууд ч байна. Тухайлбал, Францад Ерөнхий сайд, Зөвлөл болон Үндсэн хуулийн зөвлөлийн Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Ерөнхийлөгч дангаараа онц байдал зарлах бөгөөд үүнийг онц байдлын бүрэн эрх гэнэ. Словак Улсад мөн Засгийн газрын санал болгосноор Ерөнхийлөгч дангаараа онц байдал зарлах бүрэн эрхтэй боловч шийдвэртээ хамтын хариуцлага хүлээнэ.

Монгол Улсын хувьд Үндсэн хууль болон ОБтХ-д онц байдал зарлах, хугацааг сунгах, цуцлах бүрэн эрх бүхий этгээдийг тодорхой заасан. Ингэхдээ дараах боломжит хувилбараар зохицуулсан байна:[74] (1) УИХ-ын ээлжит болон ээлжит бус чуулган чуулж байх үед онц байдал зарлах бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар эсхүл УИХ-ын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүйн санаачилгаар УИХ хэлэлцэж шийдвэрлэх; (2) УИХ-ын чуулганы чөлөө цагт хойшлуулшгүй үндэслэлээр онц байдал зарлах бол Ерөнхийлөгч онц байдал зарлах тухай зарлиг гаргасныг УИХ долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгох гэсэн хоёр хувилбар байна. Ингэхдээ (1) дэх тохиолдолд зааснаар онц байдал зарлахын өмнө холбогдох этгээдүүдэд 12 цагийн дотор үйлдлээ таслан зогсоох талаар урьдчилан сануулах ба заасан хугацаанд таслан зогсоогоогүй бол онц байдал зарлана. Харин (2) дахь тохиолдолд буюу хойшлуулшгүй тохиолдолд урьдчилан сануулах арга хэмжээ авалгүйгээр онц байдал зарлана.

Тодруулбал, Монгол Улсын хувьд онц байдал зарлах бүрэн эрхтэй субъект нь УИХ болон Ерөнхийлөгч байх бөгөөд Засгийн газар онц байдал зарлах талаар санаачлах юм.

Дээр дурдсанчлан онц байдал зарлах тухай асуудлыг улсууд Үндсэн хуульдаа тусгасан байх боловч хугацааг сунгах, цуцлах тухай асуудлыг төдийлөн заагаагүй байна.[75] Эндээс үүдэн онц байдал зарлах хугацаа болон түүнийг сунгах асуудал

[72] Мөн тэнд.

[73] Мөн тэнд, p.12.

[74] ОБтХ-ийн 5 дугаар зүйлийг үзнэ үү.

[75] Мөн тэнд, p.13.

нь Үндсэн хуулийн хүрээнд ямар байх шаардлагатай вэ? гэсэн асуулт урган гарах юм. Гэвч онолын болон практик туршлагаас үзвэл захиргаадалтын дэглэмтэй байсан улсууд эдгээр асуудлыг илүү нарийвчлан зохицуулдаг байна. Тухайлбал, Грекийн Үндсэн хуульд онц байдлын хугацаа нь 15 хоног, парламентын олонхийн шийдвэрээр сунгах хугацаа нь 15 хоног байх бол Испанийн Үндсэн хуульд онц байдлын хугацаа 30 хоног ба Конгресс хугацаа сунгах асуудлыг шийдвэрлэж дахин 30 хүртэл хоногоор сунгана.

Харин Монгол Улсын хувьд Үндсэн хууль болон ОБтХ-д онц байдал зарлах хугацаа болон түүнийг сунгах асуудлыг тодорхой зохицуулаагүй байх бөгөөд гагцхүү эдгээр шийдвэр нь гарсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болохоор зааснаас[76] үзвэл хугацааны хязгаарлалт байхгүй байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

“Онц байдлын тухай ойлголт, төрөл, хамрах хүрээ хязгаарыг нарийвчлан тодруулах” хувилбарын хүрээнд төр, хуулийн этгээд, иргэнд зардал үүсэхгүй бөгөөд гарах зардал байхгүйтэй харьцуулахад үр дүн сайтай хувилбар юм. Учир нь онц байдлын тухай томьёолол, хүрээ хязгаарыг тодорхойлох, онц байдал зарлах бүрэн эрх бүхий этгээдийн эрх хэмжээг тодотгох, онц байдал зарлах, түүний хугацааг сунгах, цуцлах тухай асуудал, хугацааны хязгаарлалтыг нарийвчлан зохицуулснаар хууль хэрэглээний асуудал боловсронгуй болох, эргэлзээ, маргаантай асуудал тодорхой болох зэрэг олон талын ач холбогдолтой.

Хувилбар 2. Хууль хоорондын уялдаа холбоог хангах

Энэхүү хувилбарын хүрээнд ОБтХ дахь зохицуулалтаас бусад хууль, тодруулбал, Эрүүгийн хууль[77] болон “Гамшгаас хамгаалах тухай хууль” /цаашид “ГХтХ” гэх/[78]-тай тус тус холбогдох уялдааг хангах тодорхой зохицуулалтыг сонгон авч судаллаа.

2.1. ОБтХ болон Эрүүгийн хууль хоорондын уялдаа холбоо

Зорилгод хүрэх байдал

ОБтХ батлагдсанаас хойш 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр “Онц байдал тогтоох тухай” зарлиг гаргасан нь Монгол Улсын түүхэнд анх удаа “Онц байдал” зарласан үйл явдал болсон юм.

15 дугаар зүйл.Онц байдал үргэлжлэх хугацаанд цаазаар авах ял гүйцэтгэхгүй байх

Онц байдал үргэлжлэх хугацаанд үйлдсэн гэмт хэрэгтээ цаазаар авах ял шийтгэгдсэн хүний ялыг онц байдал үргэлжлэх хугацаанд болон онц байдал дуусгавар болсон, онц байдлыг цуцалснаас хойшхи 30 хоногт гүйцэтгэж болохгүй.

Уг зарлигт “... 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нийслэлийн Сүхбаатар дүүргийн нутаг дэвсгэрт бүлэг хүмүүсийн хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас нийтийн эмх замбараагүй байдал үүсч, хууль сахиулах байгууллагын ажилтнуудад халдан амь насанд нь заналхийлж, эд хөрөнгө устгах, галдан шатаах үйл ажиллагаа даамжирч нийтийн эмх замбараагүй байдал бий болсон тул энэхүү онцгой нөхцөл, үр дагаврыг арилгах , хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 12-т заасан бүрэн эрхийнхээ дагуу, Онц байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсгүүдийг баримтлан нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт 2008 оны 7 дугаар сарын 01-ний 24.00 цагаас эхлэн 4 хоногийн хугацаанд онц байдал зарласугай” гэжээ.

[76] ОБтХ-ийн 7 дугаар зүйлийг үзнэ үү.

[77] Эрүүгийн хууль 2002 он, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2002), №5;
Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №7

[78] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №7

Хуулийн үндэсний сан www.ali.gov.mn

Шигтгээ 1.

2008 оны 6 дугаар сарын 30-ны өдөр болсон УИХ-ын тав дахь удаагийн сонгуулийн үр дүнгээр МАХН 41, АН 29, бусад нам дөрвөн суудал авсан гэх сонгуулийн санал хураалтын үр дүн гарахад АН, БНН, Иргэний хөдөлгөөн МАХН сонгуулийн үр дүнг будилантуулсан гэж үзэж байгаагаа илэрхийлсэн байдаг. Харин 7 дугаар сарын 1-ны өдөр Б.Жаргалсайхан, Ж.Батзандан, О.Магнай нар хэвлэлийн бага хурал зарлаж, Б.Жаргалсайхан ганцаараа хэвлэлийн бага хурал хийсэн. Улмаар АН-ын дарга Ц.Элбэгдорж, БНН-ын дарга Б.Жаргалсайхан, Иргэний хөдөлгөөний намын Ж.Батзандан, О.Магнай нар ард түмнийг шударга бус сонгуулийн үр дүнг эсэргүүцэхийг уриалж, иргэд Сүхбаатарын талбайд үзэл бодлоо илэрхийлэхээр цуглаж эхэлсэн.

Ийнхүү цугларсан иргэд МАХН-ын байрны гадаа очиж үг хэлж, уулзах шаардлага тавьсан ч МАХН-ыг төлөөлөн хэн ч гарч ирж иргэдтэй уулзалт зохион байгуулалгүй, намын байрыг цагдаа нарын хамгаалалтад авсан юм. Дотогш нэвтрэх гэсэн иргэдэд саад болсон цагдаа, иргэдийн хооронд маргаан үүсэж, улмаар тайван байдлаар эхэлсэн жагсаал эцэстээ хүчирхийлэл, үймээн самуун болон хувирч МАХН-ын төв байрыг шатааж үймээн улам даамжирсан.

Улмаар Ерөнхийлөгч 00:00 цагт онц байдал тогтоох тухай зарлиг гаргаснаар цагдаагийн албан хаагчид уг жагсаал, цуглаан, нийтийн эмх замбараагүй байдлыг зогсоохын тулд 7 дугаар сарын 1-нээс 2-нд шилжих шөнө жагсагчид руу байлдааны зэвсэгээр гал нээж, дөрвөн хүн буудуулж, нэг хүн түймэрт өртөж нас барсан эмгэнэлт үйл явдал болсон юм.

Онц байдал зарласантай холбоотой асуудлаар УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны 2009 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 01 дүгээр тогтоолоор Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний комиссын 2008 оны илтгэлийн “2008 оны 7 дугаар сарын 01-ний өдөр Нийслэл Улаанбаатар хотод үүссэн олон нийтийн эмх замбараагүй байдал ба хүний эрх” хэмээх нэгдүгээр бүлгийг хэлэлцэхтэй холбогдуулж дурдсан нөхцөл байдлын улмаас хууль тогтоомжийг зөрчиж хүний эрхэнд халдан, хязгаарласан гэх 4 бүлэг асуудлыг хянан шалгаж, нээлттэй сонсгол зохион байгуулах, холбогдох байгууллага, албан тушаалтан, иргэдээс тайлбар, мэдээлэл авах, дүгнэлтийг Дэд хорооны хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж дүгнэлт гаргасан байдаг.

Энэхүү ажлын хэсэг эрх нь зөрчигдсөн гэж үзэж буй иргэн, байгууллага, албан тушаалтнаас өргөдөл, гомдол, мэдээлэл авах үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нээлттэй зарлан 2009 оны 7 дугаар сарын 01-нээс 8 дугаар сарын 25-ны өдрүүдэд ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн асан Х.Тэмүүжингийн нэр дээр болон Хууль зүйн байнгын хорооны ажлын албанд хүлээн авчээ.

Энэ хугацаанд иргэдээс гомдол, мэдээлэл 47, өмгөөлөгчийн тайлбар 4, хүний эрхийн байгууллагын тайлан 2, сэтгүүлчдээс 4 мэдээлэл ирүүлсэн байна.[79]

Өргөдөл, мэдээллийг агуулгаар нь ангилж үзвэл, галт зэвсгийн улмаас амь насаа алдсан, эрүүл мэндээрээ хохирсон гэх гомдол 6, баривчилгаа болон хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын үед зодуулсан, дарамтлуулсан, эрүү шүүлтэд орсон, үүний улмаас хилс ял шийтгүүлсэн гэх гомдол 18, прокурор, шүүхийн байгууллага хэт нэг талыг барьсан, хэргийн шийдвэрлэлтэд урьдчилсан дүгнэлттэй, холбогдох хуулиуд болон шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн, дээрээс өгсөн чиглэлийн дагуу ажилласан, хэргүүдийг шийдвэрлэх үйл явц нь шударга шүүхээр шүүлгэх иргэний эрхийг ноцтой зөрчсөн гэх гомдол 13, хохирол барагдуулах болон бусад асуудлаар

[79] Т.Занданмядаг “Долоон сарын нэгний дүгнэлтттэй танилцана уу?” (2010.06.28), https://news.mn/r/524042/ (Сүүлд үзсэн: 2019.04.19).

12 гомдол, мэдээлэл ирсэн байжээ.

Ажлын хэсгээс "...Онц байдал тогтоосноос хойш иргэдийг хомроглон, нийтээр баривчилж, иргэдийн халдашгүй чөлөөтэй байх эрхийг зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна. 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр нийслэл Улаанбаатар хотод үүссэн нийтийг хамарсан эмх замбараагүй байдлын улмаас нийт 700 гаруй хүн баривчлагдсанаас 60 орчим хувь нь суллагдсан байна. Цагдаагийн байгууллагаас явуулсан баривчлах ажиллагаа холбогдох хууль, журмыг зөрчиж хүний эрхэнд халдсан гэдгийг Хүний эрхийн Үндэсний Комисс албан ёсоор дүгнэсэн бөгөөд энэ байдал нь төрийн бус байгууллагуудаас ажлын хэсэгт ирүүлсэн тухайн үйл явдлын баримтжуулалтын тайлан, мөн иргэдийн гомдол, мэдээллээс тодорхой харагдаж байна"[80] гэжээ.

Мөн ажлын хэсгээс "... 7 дугаар сарын 1-ний үймээн самуунтай холбоотой хэргийг шийдвэрлэсэн үйл явц, шүүхийн шийдвэрийн байдлаас харахад шүүгчдийн хараат бус байдал алдагдаж, иргэний шударга шүүхээр шүүлгэх эрх хангагдсангүй гэж дүгнэхээр байна. Энэ нь шүүхийн өмнөх шатанд буюу баривчлах ажиллагаа, эрүүгийн хэргийг байцаан шалгах ажиллагаанд иргэний үндсэн эрхийн зөрчил хавтгайрсан явдалд шүүгч анхаарал тавьж харгалзан үзэлгүй хатуу, чанга ял оноох нийтлэг зарчим баримтлан ажилласнаас харагдаж байна ..."[81] хэмээн үзжээ.

Энэ тухай Нээлттэй сонсголд Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн асан Ж.Дашдорж Комиссын бодит судалгаанд үндэслэсэн албан ёсны дүгнэлтийг сонсгохдоо: "... Шударга шүүхээр шүүлгэх эрх зөрчигдсөн гэсэн шүүмжлэл хүний эрхийг хамгаалах байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд, иргэдээс их хэмжээгээр гарсан. Энэ асуудал ямар байгааг бид баримтад тулгуурлаж статистик судалгаа хийж, дүгнэж үзсэн. Бид сүүлийн 2 жилийн дунджаар авч үзвэл жилдээ найман мянга гаруй хүн шүүхээр ял шийтгүүлсэн. Тэдний 49-50.6 хувьд нь хорих ял оноодог. Улсын дундаж болон энэ хэрэгт ял шийтгүүлсэн байдлыг харьцуулж үзсэн. Дээрх хэргийг шийдвэрлэсэн 244 хүнд холбогдох 45 шийтгэх тогтоол байна. Нийт ял шийтгүүлсэн 244 хүний 86.6 хувьд нь хорих ял, 8.9 хувьд нь баривчлах ял, 0.8 хувьд нь торгох ял, 8 хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Энэ үзүүлэлт нь хорих болон баривчлах ялын эзлэх хувь нь 96 хувьд хүрч байгаа юм. Өөрөөр хэлбэл энэ тоо улсын дундаж статистикаас бараг 2 дахин өндөр буюу нийт шийтгүүлсэн хүний 96 хувьд нь хорих ял оноосон явдал нь Шүүхээс 7 дугаар сарын 1-ний хэрэгт холбогдсон хүмүүст нилээн хатуу ял оноох зарчим баримталсан гэж дүгнэхээс аргагүйд хүрч байна"[82] гэсэн байна.

2008 оны 7 сарын 1-ний дээрх үйл явдалтай холбоотойгоор шүүхээс хэд хэдэн албан тушаалтан ОБтХ-ийн 21 дүгээр зүйлд "Цагдаагийн ба цэргийн алба хаагч, төрийн албан хаагчийн хүлээх хариуцлага"-ыг тусгасан. Ийнхүү хуульчлахдаа "... Онц байдлын үед хүч, галт зэвсэг, тусгай хэрэгсэл хэрэглэхдээ хууль зөрчсөн, бүрэн эрхээ хэтрүүлсэн, түүнчлэн албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан иргэний эрх, эрх чөлөөний баталгааг зөрчсөн цагдаагийн ба цэргийн алба хаагч, төрийн албан хаагч нь хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээнэ" гэж заасны дагуу Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тодорхой гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцон ял оногдуулсан байдаг.

Тухайлбал, Цагдаагийн ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгч асан, хошууч генерал Ч.Амарболд, Эргүүл хамгаалалтын газрын дарга асан, цагдаагийн хурандаа Ш.Батсүх нарт 6 жил 6 сарын хорих ял, Нийслэлийн Цагдаагийн газрын дарга асан, цагдаагийн хурандаа О.Зоригтод 5 жил 6 сарын хорих ял, Хэв журмын хэлтсийн дарга асан, цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаатарт хоёр жилийн хорих ял тус тус оноосон. Дээрх гэмт хэргүүд нь Өршөөлийн хуульд хамрагдаж Ч.Амарболд, Ш.Батсүх нарыг 3 жил 6 сарын хорих ял, О.Зоригтод 2 жил 6 сарын хорих ялыг

[80] Мөн тэнд.

[81] Мөн тэнд.

[82] Мөн тэнд.

тус тус эдлүүлэхээр шийдвэрлэж, тус газрын Хэв журмын хэлтсийн дарга асан, цагдаагийн дэд хурандаа Г.Ганбаатар ялыг эдлүүлэхгүй байхаар тус тус тогтсон юм.[83]

2008 оны 7 сарын 1-ний өдрийн үймээн самууны үеэр үйлдэгдсэн гэмт хэргийг мөрдөн шалгах ажлын хэсгийг Улсын мөрдөн байцаах газарт байгуулж, нийт 30 гаруй мөрдөн байцаагч, 250 гаруй хүнд холбогдох эрүүгийн хэргийг шалгаад ихэнхийг нь прокурорт шилжүүлсэн байна. прокурорын байгууллага харьяаллын дагуу хавтаст хэргүүдийг Хан-Уул, Чингэлтэй, Баянзүрх, Сүхбаатар дүүргийн шүүхэд шилжүүлэн шийдвэрлэж эхлээд байна. Үймээнд оролцсон 200 гаруй хүний хэрэг анхан шатны шүүхээр оржээ.[84]

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг хулгайлах", 146 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг булаах", 147 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг дээрэмдэх" 153 дугаар зүйлд заасан "Бусдын эд хөрөнгийг санаатайгаар устгах гэмтээх", 155 дугаар зүйлд заасан "Гэмт хэрэг үйлдэж, олсон эд хөрөнгийг олж авах, борлуулах", 181 дүгээр зүйлд заасан "Танхайрах", 177 дугаар зүйлд заасан "Зандалчлах", 179 дүгээр зүйлд заасан "Нийтийн эмх замбараагүй байдал бий болгох", 230 дугаар зүйл "Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийн эсэргүүцэх" гэмт хэрэг үйлдсэн хэмээн ял сонсгосон байна.

Түүнчлэн, онц байдал зарлахаас өмнө болон зарласан үед нийгмийн хэв журам зохицуулж ажилласан цагдаагийн албан хаагчдаас 471 хүн гэмтэл авсан, үүний 100 гаруй нь хүндэвтэр гэмтэл авсан гэсэн шүүх эмнэлгийн дүгнэлт гарсан.

Энэхүү үйл явдалтай холбоотой асуудлыг 2002 оны Эрүүгийн хуулиар шийдвэрлэсэн. Харин 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан гэмт хэрэг үйлдсэн бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөлд байдалд тооцохоор хуульчилсан байна. Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хэд хэдэн гэмт хэргийг хүндрүүлэх бүрэлдэхүүнд онц байдал зарласан үед тухайн гэмт хэргийг үйлдсэн бол хүндрүүлэн зүйлчилж, ял оногдуулахаар хуульчилжээ.

Хүснэгт 2. *Эрүүгийн хууль дахь онц байдлын талаарх зохицуулалт*

№	Эрүүгийн хуулийн зүйл	Заалт
1	**6.6 дугаар зүйл.** Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал	1.7. онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан үйлдсэн;
2	**28.1 дүгээр зүйл.** Тушаал биелүүлэхгүй байх	2.2.дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
3	**28.5 дугаар зүйл.** Цэргийн албанаас оргон зайлах	2.Энэ гэмт хэргийг: 2.1.дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед;
4	**28.6 дугаар зүйл.** Биедээ гэмтэл учруулах, өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх	2.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
5	**28.7 дугаар зүйл.** Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших	3.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
6	**28.8 дугаар зүйл.** Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх	2.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

[83] Ө.Батхүү "Долдугаар сарын 1-нээс хойш..." (2015.07.01) http://www.olloo.mn/n/17420.html хаягаас үзнэ үү.

[84] Дам эшлэв. Г.Оюунболд "Онц байдал, түүний эргэн тойронд" Хууль дээдлэх ёс сэтгүүл №4 (2008): 65 дахь тал.

7	**28.12 дугаар зүйл.** Байлдааны жижүүр хийх журам зөрчих	2.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
8	**28.14 дүгээр зүйл.** Харуулын албаны журам зөрчих	2.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Түүнчлэн, ОБтХ-ийн 15 дугаар зүйлд "Онц байдал үргэлжлэх хугацаанд цаазаар авах ял гүйцэтгэхгүй байх" тухай зохицуулалт өнөөдрийг хүртэл төгөлдөр хэвээр байгаа нь хууль тогтоомжуудын хоорондын уялдаа холбоог алдагдуулж байна.

Монгол Улс ИБУТЭТОУП-ын цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нэгдэн орсонтой холбогдуулан цаазаар авах ялын төрлийг хасаж, энэ онцгой ялын оронд бүх насаар хорих ялыг ялын төрөлд нэмсэн. 2015 оныг хүртэл Монгол Улс цаазаар авах ялыг практикт халсан улсад хамаарч байсан бол 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Эрүүгийн хууль хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлснээр цаазаар авах ялыг бүрмөсөн халсан дэлхийн 103 дахь улс болж, Олон Улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж буйн илрэл юм.[85]

Мөн 2002 оны Эрүүгийн хуулийг дагаж мөрдөж байх үед буюу 2010 онд Монгол Улсын Ерөнхийлөгч асан Ц.Элбэгдорж "Цаазаар авах ялыг хориглох тухай" мэдэгдэл хийж, ИБУТЭТОУП-ын Пактын цаазаар авах ялыг халахад чиглэсэн Нэмэлт II Протоколд 2012 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр Монгол Улс нэгдэн орсон зэрэг үйлдэл, үйл ажиллагаанаас улбаалан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх өдрийг хүртэл Монгол Улсын шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэгт цаазаар авах ялыг огт оногдуулаагүй байна.

Зөвхөн Эрүүгийн хуулиар гэмт хэрэг үйлдсэн хүнд шүүхээс цаазаар авах ял оногдуулдаг. Гэтэл Эрүүгийн хуульд цаазаар авах ялыг халсан байхад ОБтХ-ийн 15 дугаар зүйлд заасан "Онц байдал үргэлжлэх хугацаанд цаазаар авах ял гүйцэтгэхгүй байх" зохицуулалт хэвээр байгаа нь хуулийн уялдаа холбоог алдагдуулж байна. Иймд ОБтХ-ийн дээрх зохицуулалтыг хүчингүй болгох нь зүйтэй.

2.2. ОБтХ болон ГХтХ хоорондын уялдаа холбоо

4 дүгээр зүйл.Онц байдал зарлах үндэслэл
Монгол Улсын Үндсэн хуульд заасан ёсоор дор дурдсан онцгой нөхцөл бий болсон үед онц байдал зарлаж болно:
1/ улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон;

ОБтХ-ийн 4 дүгээр зүйлд "Монгол Улсын Үндсэн хуульд заасан ёсоор дор дурдсан онцгой нөхцөл бий болсон үед онц байдал зарлаж болно" гэж заасан бөгөөд мөн хуулийн 4.1 дэх хэсэгт "... Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул /газар хөдлөлт, хүчтэй салхи, ган, зуд, үер, түймэр, цацраг идэвхт болон химийн бодисын хордуулалт, хүн, малын гоц халдварт өвчин зэрэг/ тохиолдсон" бол онц байдал зарлаж болохоор хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, малын гоц халдварт өвчнийг "онц байдал"-д хамааруулахаар хуульчилжээ.

2017 онд ГХтХ-ийг шинэчлэн батлсантай холбогдуулан 2017 оны 2 дугаар сарын 2-ны өдөр ОБтХ-ийн дээрх заалтад "гамшиг, аюулт үзэгдэл, осол" гэж өөрчлөлт оруулсан.

ГХтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх хэсэгт "гамшиг" гэж аюулт үзэгдэл, ослын

[85] *Сургагч багш нарт зориулсан гарын авлага*, Хууль зүй, дотоод хэргийн яам, (УБ: ХЗДХЯ, 2017), 43 дахь тал.

улмаас олон хүний амь нас, эрүүл мэнд хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, түүх, соёлын дурсгалт зүйл, хүрээлэн байгаа орчинд улс болон орон нутгийн эдийн засаг, нийгмийн дотоод нөөц, боломжоос давсан хохирол учрахыг; 4 дүгээр зүйлийн 4.1.2 дахь хэсэгт ...“аюулт үзэгдэл” гэж хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, аянга, газар хөдлөлт, гал түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин гарах, хортон шавж, мэрэгч тархах зэргийг”; 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт ...“осол” гэж үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс тоног төхөөрөмж, барилга байгууламж ноцтой эвдрэх, нурах, тэсэврийн хэрэгсэл осолдох, сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах, дэлбэрэлт болох зэргийг” тус тус хамааруулан ойлгохоор хуульчилсан юм.

Монгол Улс нүүдлийн соёл иргэншилтэй, мал аж ахуйтай орон бөгөөд нийт 3.253.233 хүн амтай.[86] 2018 оны байдлаар нийт 66.460.180 малтай ба үүнээс адуу 3.940.092, үхэр 4.380.879, тэмээ 459.702, хонь 30.554.804, ямаа 27.124.703 тоо толгой тус тус бүртгэгдсэн байна.[87]

Мал аж ахуйд суурилсан орон болохын хувьд Монгол Улсын хэмжээнд мал сүргийн эдийн засагт үзүүлэх нөлөө их бөгөөд малын гаралтай гоц халдварт өвчин түгээмэл гардаг, тийм өвчин гарсан тохиолдолд учрах хор хохирлын хэмжээ өндөр байдаг. Тухайлбал, 2017 онд мал, амьтны гоц халдварт өвчнөөс шүлхий, хонины цэцэг, бог малын мялзан өвчин тус тус бүртгэгдсэн бөгөөд 2017 онд бог малын мялзан өвчний нийт 11 тохиолдол бүртгэгдсэн, хонины цэцэг өвчин нийт 9 аймгийн 37 суманд бүртгэгдсэн бол шүлхий өвчин 2017 оны 01 сарын 28-ны өдөр Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан суманд бүртгэгдсэнээс хойш Сүхбаатар, Дорнод, Хэнтий, Дорноговь, Төв, Дундговь, Сэлэнгэ аймгийн нийт 41 сум, нийслэлийн нэг дүүрэгт шүлхий өвчин оношлогдож нийт 830-аад өрхийн 9452 толгой мал, амьтныг зориудын устгалд хамруулсан байна.

Малын гоц халдварт өвчин дан ганц манай улсад төдийгүй Африк, Ази, Төв Америк, Өмнөд болон Зүүн Европын зарим улсад түгээмэл тархалттай, нэн хурцадмал эрсдэл болоод байна. Тухайлбал, Дэлхийн амьтны эрүүл мэндийн байгууллагаас гаргасан судалгаанд дурдсанаар мал, амьтны халдварт өвчнөөс болж жилд дунджаар 100 сая орчим мал, амьтан устгалд орж, 2.2 сая хүн нас бардаг байна.[88]

Иймд малын гоц халдварт өвчин нь хүн, мал, улс орны эдийн засагт нөлөөлөхүйц аюул, эрсдэлтэй өвчин юм.

2018 онд Засгийн газраас “Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт”-ыг баталсан[89] бөгөөд ийнхүү батлахдаа тухайн өвчний хор хөнөөл, аюулын зэргээс нь хамааруулан ангилан авч үзсэн.

Хүснэгт 3. *Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчний жагсаалт*

№	**Хавсралт 1.** Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний Олон Улсын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчин, хүний амь нас хохирох эрсдэл үүсгэдэг зооноз өвчний жагсаалт	**Хавсралт 2.** Мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний дотоодын худалдаанд хориг саад үүсгэдэг гоц халдварт, халдварт өвчний жагсаалт	**Хавсралт 3.** Бусад халдварт өвчний жагсаалт
1	Бог малын мялзан	Дуут хавдар	Колибактериоз
2	Шүлхий	Дотрын халдварт хордлого	Сохор догол

[86] Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас, https://www.nso.mn/ (Сүүлд үзсэн: 2019.04.19)

[87] Мөн тэнд.

[88] Б.Ану, “Мал амьтны гоц халдварт өвчний эрсдэл буурчээ” (2018.07.19), https://ikon.mn/n/1cb7 хаягаас үзнэ үү.

[89] Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 225 дугаар тогтоол.

3	Боом	Цусан халдвар	Гүүний иж балнад
4	Хонь, ямааны цэцэг	Иж балнад	Сахуу
5	Гахайн сонгомол мялзан	Ботулизм	Шөвөг яр
6	Өндөр хоруу чанартай шувууны томуу	Гахайн үржил, амьсгалын хам шинж	Хулгана яр
7	Бруцеллёз	Үхрийн ринотрахейт	Адууны хачгийн халуун
8	Ямааны годрон	Үхрийн диарей	Шувууны гамбора
9	Үхрийн мялзан	Үхрийн лейкоз	Марекийн өвчин
10	Үхрийн цээж	Иж сүрьеэ	Нохой, муурны парвовирусын халдвар
11	Галзуу	Адууны вирусын артрит	Адууны пневмони
12	Ям	Баруун нилийн халдвар	Некробактериоз
13	Хорт салст халуурал	Адууны халдварт цус багадах	Дэлэнгийн өмрөө
14	Шувууны тахал	Нийлүүлгийн өвчин	Хачигт риккетсиоз
15	Хөх хэлтэх	Тэмээний амруу	Гахайн миксоплазмоз
16	Сүрьеэ	Маеди висна	Гахайн сальмонеллёз
17	Листериоз	Сул хоруу чанартай шувууны томуу	Шувууны миксоплазмоз
18		Аденоматоз	Шувууны пуллюроз
19		Зогсоо	Шувууны сүрьеэ
20		Лептоспироз	Шувууны ларинготрахейт
21		Энтеробактериоз	Зөгийн үжил
22		Туляреми	Туулайн вируст цусан халдвар
23		Ку чичрэг	Туулайн миксоматоз
24		Кампилобактериоз	
25		Гахайн ёлом	
26		Хачигт энцефалит	
27		Хонины энзоот зулбах	

Манай улс бэлчээрийн мал аж ахуйтай учраас цаг агаарын нөхцөлөөс ихээхэн хамааралтай байдаг. 1918 оноос хойших 100 жилийн хугацаанд том малын зүй бус хорогдлыг авч үзвэл, 16 удаа томоохон зуд тохиолдож, тохиолдол тутамд 2 саяас дээш толгой мал хорогдож, үлэмж хохирол учруулсан байна. Тухайлбал, 2000-2001 оны зуд нь 1950 оноос хойш тохиолдсон хамгийн том зуд байсан. 1950 онд 4 сая толгой мал хорогдож байсан бол 2000 онд 3.5 сая толгой мал, 2001 онд 4.8 сая толгой мал хорогдсон.[90]

Хамгийн их хэмжээгээр том малын зүй бус хорогдол гарсан жил нь 2010 он бөгөөд 10.3 сая толгой мал зүй бусаар хорогдсон юм. Тухайн онд оны эхний ямааны 25.4 хувь нь, хонины 22.6 хувь нь, үхрийн 22.4 хувь нь, адууны 16.6 хувь

[90] Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2017, Монгол Улсын Үндэсний статистикийн хороо, 79 дэх тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.nli.gov.mn

нь, тэмээний 6.1 хувь нь хорогдсон байна.[91]

Малын хорогдолд хүн амын аюулгүй байдалд дан ганц малын гоц халдварт өвчин бус ган, зуд, түймэр, үер гэх мэт олон шалтгаан нөхцөл нөлөөлж байдаг.

Тухайлбал, 1940-2017 он хүртэл 77 жилийн судалгаагаар[92] Өнтэй буюу хэвийн жил 42 буюу 55 хувь, ган, зудтай жил 34 буюу 45 хувь байжээ.

***Хүснэгт 4**. Монгол оронд тохиолдсон ган, зудын давтамж*[93]

№	Хулгана	Үхэр	Бар	Туулай	Луу	Могой	Морь	Хонь	Бич	Тахиа	Нохой	Гахай
1					1940	1941	1942	1943	1944	1945	1946	1947
2	1948	1949	1950	1951	1952	1953	1954	1955	1956	1957	1958	1959
3	1960	1961	1962	1963	1964	1965	9666	1967	1968	1969	1970	1971
4	1972	1973	1974	1975	1976	1977	1978	1979	1980	1981	1982	1983
5	1984	1985	1986	1987	1988	1989	1990	1991	1992	1993	1994	1995
6	1996	1997	1998	1999	2000	2001	2002	2003	2004	2005	2006	2007
7	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016	2017	2018	

***Хүснэгт 5.** Засгийн газар, төрийн болон төрийн бус байгууллага, Олон Улсын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн зүгээс үзүүлсэн тусламж, дэмжлэг*[94]

№	Он	Нөхцөл байдал	Засгийн газар	ОУ-ын байгууллагын төсөл, хөтөлбөр	Гадаад, дотоодын байгууллагын тусламж
1	2009-2010	15 аймгийн 80 сум гамшгийн, 18 аймгийн 95 сум зудтай	9.8 тэрбум	12.3 тэрбум	28.0 тэрбум
2	2011-2012	8 аймагт хаваржилт хүндрэхээс урьдчилан сэргийлэх	547.8 сая		
3	2012-2013	18 аймгийн 98 сум зудтай, 16 аймгийн 88 сум зудархуу	4.4 тэрбум		434.4 сая
4	2013-2014	18 аймгийн зам даваа хаагдсан	421.6 сая		
5	2014-2015	Зүүн аймгуудад гарсан хээрийн түймэр	1.2 тэрбум		90.0 сая
6	2015-2016	18 аймгийн 98 сум зудтай, 20 аймгийн 111 сум зудархуу	7.3 тэрбум	11.5 тэрбум	
7	2016-2017	16 аймгийн 90 сум зудтай, 14 аймгийн 59 сум зудархуу	48.2 тэрбум	4.1 тэрбум*	

Дээрхээс дүгнэвэл, ган, зуд манай улсад түгээмэл болдог үзэгдлийн нэг юм. Мөн ой хээрийн түймэр, ган, зуднаас шалтгаалан үүссэн хохирлыг арилгах, урьдчилан сэргийлэхийн тулд төрөөс шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

Энэ төрлийн аюулт үзэгдлийн улмаас манай улсад жил бүр тодорхой хэмжээний хохирол учирч байдаг бөгөөд маш их хэмжээний буюу ноцтой хохирол учирч байсан хэдий ч энэхүү шалтгаан, нөхцөлийн улмаас онц байдал зарлаж байгаагүй юм.

Үндсэн хууль болон ОБтХ-ийн 4 дүгээр зүйлд тус тус онц байдал зарлах үндэслэлийг хуульчилсныг дээр дурдсан.

Үндсэн хуулийн тайлбарт "... Хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулахуйц байгалийн гамшиг гэдэгт гал, усны аюул, хор хөнөөл учруулсан газар хөдлөлт, ган, зуд, олон хоног үргэлжилсэн салхи, шуурга зэргийг тооцно. Гэнэтийн бусад аюул гэдэгт хүн, мал, ан амьтан,

[91] Мөн тэнд, 80 дахь тал.

[92] Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан ёсны цахим хуудас, http://mofa.gov.mn/exp/blog/7/8 (Сүүлд үзсэн: 2019.04.20)

[93] Мөн тэнд.

[94] Мөн тэнд.

өргөн хүрээнд хамарсан өвчин эмгэг, тахал зэргийг хамааруулах бөгөөд эдгээр аюул нь улсын нийт нутаг буюу зарим аймаг, сумдын нутгийг хамарсан ч байж болно. Зарим аймаг, сумдын нутаг хамарсан тохиолдолд тэр нь цаашид өргөжин тэлэх магадлалтай, эсхүл тухайн бүс нутгийнханд онц аюултай тохиолдолд онц байдал зарлаж болно”[95] гэжээ.

Өөрөөр хэлбэл, ган, зуд, малын гоц халдварт өвчин зэргийг онц байдалд хамааруулан хуульчилсан бөгөөд эдгээр тохиолдол манай улсад олон гардаг боловч 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн олон нийтийг хамарсан үймээн самуунтай холбоотойгоор нэг удаа онц байдал зарласнаас бусдаар онц байдал зарлаагүй байна.

Ийнхүү онц байдлыг цөөн тохиолдолд зарлах нь нийгэм, эдийн засаг, хүн амын аюулгүй байдал, Олон Улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, улс орны тогтвортой байдал зэрэгт эерэг нөлөөтэй боловч анхаарах шаардлагатай дараах асуудал байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг заасан. Харин Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно... ” гэж зааснаас үзвэл онц байдал зарласан үед л хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлахаар ойлгогдож байна. Хуулийн дээрх заалтыг Үндсэн хуулийн тайлбарт “...улсын хэмжээнд буюу зарим хэсэгт байгалийн гамшиг, гэнэтийн аюул тохиолдсон буюу нийгмийн тогтворгүй байдал даамжирч үймээн самуун дэгдсэн зэрэг онцгой нөхцөл байдлаас болж онц байдал буюу дайны байдал зарласан тохиолдолд төр хүний эрхэнд хязгаар тогтоосон хуулийг уг нөхцөл байдлыг арилтал мөрдүүлэхээр гаргаж болно”[96] хэмээн тайлбарлажээ.

Гэтэл манай улсын хувьд малын гоц халдварт өвчин, ган, зуд зэрэг онц байдал зарлах нөхцөл байдалд хамаарах аюул, гэнэтийн аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед Засгийн газраас тогтоол, журам, Засаг дарга захирамж гаргаж, мөн ГХтХ-д зааснаар онцгой байдлын газраас шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

Энэ нь тухайн асуудлыг түргэн шуурхай шийдвэрлэхэд хамгийн дөт хурдан авч хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээ мөн боловч Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан хүний эрх, эрх чөлөөг хуулиар бус Засгийн газрын тогтоол, Засаг даргын захирамжаар хязгаарлаж байх талтай юм.

Тухайлбал, Архангай аймгийн Засаг даргын 2018 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн А/72 дугаар захирамжийн 3 дахь хэсэгт “... Булган аймгийн шүлхий өвчний голомт бүхий нутгаас ирэх хүн, мал тээврийн хэрэгслийг аймгийн нутагт орохыг хориглож, бусад тээврийн хэрэгсэлд халдваргүйжүүлэлт хийж, бүртгэл хөтөлж, ажиллахыг үүрэг болгосугай” гэжээ.

Ийнхүү захирамж гаргахдаа Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “...Засаг дарга эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцүүлэн захирамж гаргана”, ГХтХ-ийн 32 дугаар зүйлд “... аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга гамшгаас хамгаалах асуудлаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, мөн зүйлийн 32.1.1-д “... нутаг дэвсгэрийн хэмжээнд гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх” гэж тус тус заасныг үндэслэжээ.

Түүнчлэн, 2017 оны 12 дугаар сарын 8-ны өдөр УИХ-аас “Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль”[97]-ийг баталсан бөгөөд тус хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт “... Гоц халдварт өвчин гарсан үед мал, амьтны эрүүл мэндийн асуудал

[95] Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, Ханнс-Зайделийн сан (УБ: 2009),149 дэх тал.

[96] Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар (УБ: 2000), 135 дахь тал.

[97] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2018), №2

хариуцсан төрийн захиргааны байгууллагын, бусад халдварт өвчин гарсан үед аймаг, нийслэлийн мал эмнэлгийн байгууллагын саналыг үндэслэн сум, дүүргийн Засаг даргын шийдвэрээр энэ хуулийн 16.1.4-т заасан өвчингүй бүсэд байгаа мал, амьтныг нүүлгэн шилжүүлж болно" гэж, мөн хуулийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт "...Хорио цээр, хязгаарлалт тогтоох халдварт өвчний талаар мэдээлэл хүлээн авсан аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга дараахь үйл ажиллагааг нэн даруй хэрэгжүүлнэ: 15.5.1.энэ хуулийн 17.2, 18.1, 18.3-т заасны дагуу дэглэм тогтоож, халдварт өвчинтэй тэмцэх арга хэмжээг зохион байгуулах, хүн, мал, амьтан, тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, эсхүл хориглох" гэж тус тус зааснаас үзвэл Засаг даргад шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, хориглох эрх олгосон байна.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд "...Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ", мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "...онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлана" гэж тус тус заасан.

Дүгнэвэл, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэн, хэрхэн хэрэгжүүлэх талаар ердийн хуульд тодорхой тусгасан нь зөв хэдий ч гагцхүү хуулиар хязгаарладаг хүний эрх, эрх чөлөөг Засгийн газрын тогтоол, Засаг даргын захирамжаар ийнхүү хязгаарлах нь учир дутагдалтай юм.

Иймд тус асуудлыг ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тодруулах, мөн уг хуулийг ГХтХ-тай уялдуулах шаардлагатай гэж үзэж байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа

"Хууль хоорондын уялдаа холбоог хангах" хэмээх хувилбар 2-ын хүрээнд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахад зардал шаардагдахгүй бөгөөд харин хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгаж, уялдаа холбоог хангах эерэг үр дагавартай.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 1-ийн 1, 2, 3, 4 дүгээр хүснэгтээс үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Зохицуулалтын хувилбарын хүрээнд ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй. Тухайлбал, тус хуулийн 15 дугаар зүйлд заасан "Онц байдал зарласан үед цаазаар авах ял гүйцэтгэхгүй байх" талаарх зохицуулалт нь 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн ялын төрлөөс цаазаар авах ялыг халсан учир ОБтХ-д энэ талаарх зохицуулалт хэвээр байгаа нь буруу юм.

Мөн онц байдал зарласан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээ,тухайн арга хэмжээг авч хэрэгжүүлэх албан тушаалтан, байгууллагыг тодорхой зааж, эрх, үүргийн нь хуульчилснаар хүний эрх, эрх чөлөөнд зүй бусаар халдахаас сэргийлж чадна.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Энэхүү судалгааны үр дүнд гарч буй зохицуулалтын хувилбарын хувьд эдийн засагт нөлөө үзүүлэх боломжтой. Тодруулбал, онц байдал зарласан үед шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд улсын төсвөөс тодорхой төсөв зарцуулах байдлаар эдийн засагт нөлөө үзүүлнэ.

хуулийн үйлчлэлийн хүрээнд www.mli.gov.mn

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Энэхүү судалгааны үр дүнд гарч буй зохицуулалтын хувилбарын хувьд нийгэмд тодорхой үр нөлөөг үзүүлнэ. Тухайлбал, иргэдийн дунд айдас түгшүүр нэмэгдэх, хүний зарим эрхийг хязгаарлах, тодорхой хугацаагаар зарим байгууллагын үйл ажиллагааг явуулахыг зогсоох, хилийн хорио тавих гэх мэт тухайн онц байдал зарлах болсон шалтгаан, нөхцөлтэй уялдуулан төрөөс шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ нийгэмд онц байдал зарлахаас өмнөх нөхцөл байдлаас /өдөр тутмын хэвийн байдал/ өөр хэвийн бус нөхцөл байдал үүсэх юм.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн шууд болон шууд бус сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Олон Улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө” гэж заасан. Онц байдал зарлах үед хязгаарлаж болох буюу үл болох эрхүүдийн талаар Монгол Улсын нэгдэн орсон Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Олон Улсын конвенц, ИБУТЭТОУП, Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц зэрэгт тодорхой заасан бөгөөд Үндсэн хуулийн дурдсан зохицуулалт нь эдгээрт нийцэж байна.

Гагцхүү хувилбар 2-ын хүрээнд авч үзсэн ОБтХ-ийн 15 дугаар зүйл нь Эрүүгийн хууль болон Монгол Улсын нэгдсэн орсон ИБУТЭТОУП-аар цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протоколд нийцэхгүй байх тул тус зохицуулалтыг өөрчлөх нь зүйтэй.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ХАРЬЦУУЛСАН ДҮГНЭЛТ

Зардал үр өгөөжийн харьцааг зорилгод хүрэх боломжтой харьцуулан судалсны үндсэн дээр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дагавар

Хувилбар 1-ийн хувьд онц байдлын тухай томьёолол, хүрээ хязгаар, онц байдал зарлах бүрэн эрх бүхий этгээдийн эрх хэмжээ, онц байдал зарлах, түүний хугацааг сунгах, цуцлах тухай асуудал, хугацааны хязгаарлалт зэрэг асуудал илүү боловсронгуй төдийгүй эргэлзээ, маргаантай асуудал тодорхой болох зэрэг олон талын ач холбогдолтой.

Хувилбар 2-ын хувьд ОБтХ-д одоо байгаа зарим зохицуулалт дотоодын зарим хууль, тодруулбал, Эрүүгийн хууль, ГХтХ, Монгол Улсын нэгдэн орсон ИБУТЭТОУП-ын II нэмэлт протокол зэрэг эрх зүйн баримт бичигт нийцэхгүй, зөрчилдөж байгаа тул холбогдох заалтуудыг нийцүүлснээр хууль хоорондын уялдаа хангагдах, хуулийн давхардал, хийдэл, зөрчил арилах эерэг үр дагавартай.

Гарч болох сөрөг үр дагавар

Судалгаанд дэвшүүлсэн хувилбаруудын хүрээнд төр, иргэн, хуулийн этгээдэд захиргааны зардал үүсэхгүй, сөрөг үр дагавар гарахгүй байх боломжтой. Харин хувилбарын хүрээнд дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэхгүй удсанаар хууль болон Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ хооронд давхардал, зөрчилдөөн байсаар байх, уялдаа холбоо хангагдахгүйд хүрэх зэрэг сөрөг үр дагавартай тул хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар засан сайжруулах шаардлагатай байна.

Хуулийн үндэсний сан www.nli.gov.mn

ЗУРГАА.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Олон Улсын эрх зүйн зохицуулалт

Онц байдал зарласан үед хязгаарлаж болох буюу үл болох эрхүүдийн талаар зохицуулсан Олон Улсын эрх зүйн холбогдох баримт бичиг нь:

- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Олон Улсын конвенц (англ. International Convention on the Elimination of All Forms of Racial Discrimination, 1965);
- Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт (англ. International Covenant on Civil and Political Rights, 1966);
- Хүний эрхийн тухай Европын конвенц (англ. European Convention on Human Rights, 1950)[98];
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц (англ. Convention on the Elimination of All Forms of Discrimination against Women, 1979);
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц (англ. Convention against Torture and Other Cruel, Inhuman or Degrading Treatment or Punishment, 1984).

Дээрх баримт бичгүүдээс хамгийн гол хоёр баримт бичиг нь ИБУТЭТОУП болон Хүний эрхийн тухай Европын конвенц юм. Хүний эрхийн тухай Европын конвенц нь зөвхөн Европын орнуудад ч бус Африк, Карибийн тэнгисийн орнуудад нөлөө үзүүлсэн гэж үздэг.[99] Тус конвенцод онц байдал зарлах үед хязгаарлаж үл болох "үнэмлэхүй эрх"-ийг заасан бөгөөд тэдгээр нь эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс ангид байх эрх чөлөө (3 дугаар зүйл), боолчлолыг хориглох (4 дүгээр зүйл), хуулиас гадуур хэнд ч ял шийтгэл ногдуулахгүй байх зарчим (7 дугаар зүйл) болно.

ИБУТЭТОУП-ын хувьд мөн онц байдал зарласан үед "ухарч үл болох эрх"-үүдийг заасан ба тэдгээр нь амьд явах эрх (6 дугаар зүйл), эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс ангид байх эрх чөлөө (7 дугаар зүйл), боолчлолыг хориглох (8 дугаар зүйл), гэрээгээ биелүүлээгүй үндэслэлээр эрх чөлөөг нь хасахыг хориглох (11 дүгээр зүйл), хуульд заагаагүй үндэслэлээр ял шийтгэл ногдуулахыг хориглох (15 дугаар зүйл), эрх зүйн чадвартай байх эрхээ хүлээн зөвшөөрүүлэх (16 дугаар зүйл), шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө (18 дугаар зүйл) юм.

Онц байдал зарласан үед дээр дурдсан эрхүүдийг хязгаарлаж болох талаар улсууд Үндсэн хуульдаа хуульчлах замаар Олон Улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж байна.

Бусад улсын эрх зүйн зохицуулалт

Гадаад улсын туршлагыг судлах хүрээнд эх газрын эрх зүйн бүлд хамаарагддаг бөгөөд онц байдал зарлах талаар Үндсэн хууль болон бусад хуульдаа нарийвчлан зохицуулсан улсуудыг түлхүү авч үзэхийг зорилоо. Ингэхдээ хэрэв нарийвчлан зохицуулаагүй бол түүний үндэслэл шалтгааныг тодруулахыг зорьсон ба зохицуулалтын ялгааг харгалзан дараах байдлаар бүлэг болгов.

1. **Швейцарийн Холбооны Улс** /цаашид "Швейцари" гэх/ **ба Холбооны Бүгд Найрамдах Герман Улс** /цаашид "ХБНГУ" гэх/: Үндсэн хуулиас гадуурх Карт-Бланш ба Үндсэн хуулийн чанд хязгаарлалт

[98] Монгол Улс Хүний эрхийн тухай Европын Конвенцид нэгдэн ороогүй боловч Олон Улсын эрх зүйн хүрээнд судалгааны сэдэвтэй холбогддог тул энд дурдав.

[99] Elliot Bulmer, *Emergency Powers* (Stockholm: International Institute for Democracy and Electoral Assistance, 2018), p.22.

Швейцари Улс болон ХБНГУ нь онц байдал зарлах эрх зүйн зохицуулалтын талаар эрс тэс үзэл баримтлалтай байх тул хамтад нь авч үзэн ялгааг тодруулахыг зорилоо.

1.1. Швейцари

Швейцари Улс онц байдлын эрх зүйн зохицуулалтын талаар "Үндсэн хуулиас гадуурх Карт-Бланш"[100] гэх үзэл баримтлалыг баримталдаг. Тодруулбал, тус үзэл баримтлал нь онц байдал бол хүний үндсэн эрх, эрх чөлөөг хязгаарладаг ноцтой үйл ажиллагаа тул Үндсэн хууль болон бусад хуульд нарийвчлан зохицуулах нь Үндсэн хуулийн дэг журамд харшилна гэсэн утга бүхий юм.

Иймд Швейцарийн Үндсэн хуульд онц байдлыг тухайлан хуульчлаагүй. Хэдийгээр 1950-1985 оны хооронд тус улс "зайлшгүй байдлын онол" (англ. the doctrine of necessity; фр. droit de nйcessitй)-ын тухай бичмэл дүрэмтэй байсан боловч 2003 онд Засгийн газраас үүнтэй холбогдох бусад баримт бичиг болон 23 эрх зүйн актыг хуучирсан, зорилго, ач холбогдлоо алдсан гэх үндэслэлээр нэг дор хүчингүй болгосон ажээ.[101] Зайлшгүй байдлын онол гэдэг нь хүний эрхийг гагцхүү зайлшгүй тохиолдолд хязгаарлаж болох тухай ойлголтыг агуулдаг эрх зүйн үзэл санаа юм. Өөрөөр хэлбэл, онц байдлын үед хүний эрхийг хязгаарлаж, илүү ноцтой хор уршгаас сэргийлэхийн тулд хууль бус үйлдлийг зөвшөөрөх тухай утгыг агуулдаг.

Дээрх зайлшгүй байдлын онолтой холбогдох дүрэм, журмыг хүчингүй болгосны дараа Холбооны Хууль зүй, Цагдаагийн яамнаас тэдгээрийг инкорпораци буюу төрөлжүүлэн нэгтгэх замаар Үндсэн хуульд нийцсэн ердийн хууль батлах шаардлагатай эсэх талаар хяналт, шалгалт хийсэн байна. Түүнд үндэслэн Засгийн газраас "зайлшгүй байдлын тухай" хуулиуд нь "хэрэгжүүлэхэд бэрх, учир холбогдлоо алдсан, аюулгүй биш" тул дахин хуульчлах шаардлагагүй"[102] гэж дүгнэжээ.

Засгийн газрын дүгнэлтэд цаашлаад "хойшлуулшгүй арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд хуучны зохицуулалт түргэн шуурхай үйлчилж чадахгүй, бөгөөд Холбоо шийдвэр гаргах боломжгүй үед Мужид бүрэн эрхийг шилжүүлэх хялбар боломжийг олгож байна" гэжээ. Түүнчлэн зайлшгүй байдлыг Үндсэн хуульд зохицуулснаар эрх мэдлийг урвуулан ашиглах эрсдэл буурах бус харин ч өснө гэж үзсэн байна. Учир нь зайлшгүй байдал буюу онц байдлын үед хүний эрхийг хязгаарлах шаардлага гардаг төдийгүй шаардлагатай гэвэл хуулиар зөвшөөрөгдөөгүй үйлдэл хийх шаардлагатай болдог тул бичмэл зохицуулалтын үндсэн дээр эрх мэдлээ хэтрүүлэн ашиглах эрсдэл бий болох юм.

Швейцари Улс зайлшгүй байдал буюу онц байдлын тухай зохицуулалтуудаа хүчингүй болгож, хуулиар зохицуулах шаардлагагүй гэж үзэх болсон нь мөн дараах түүхэн шалтгаанаас үүдэлтэй:

Дэлхийн I дайны үед тус улсад зайлшгүй байдлын онол үйлчилж байсан бөгөөд 1914 оны 8 дугаар сард Швейцарийн парламент 1921 он хүртэл онц байдал зарлаж, үндэсний эв нэгдэл, аюулгүй байдал, төвийг сахих байр суурьиа хамгаалах үүднээс шаардлагатай арга хэмжээ авах үнэмлэхүй бүрэн эрхээ Засгийн газарт шилжүүлсэн. Гэтэл энэ үеэр Засгийн газар болон яамдаас 1400 гаруй "Үндсэн хуульд нийцээгүй, хууль бус" шийдвэр гаргасан байдаг.[103] Дэлхийн II дайны үед мөн төстэй нөхцөл байдал үүссэн ба үүнийг судлаач Франсуа Бэлланжер (Fransois Bellanger) хууль тогтоох эрх мэдэл ганхсан, зайлшгүй байдлын онолыг урвуулан

[100] Карт-Бланш (фр. Carte Blanche) - Үйлдэл хийх хязгааргүй бүрэн эрх, эрх чөлөө буюу хязгааргүй эрх хэмжээ.

[101] "*Une nouvelle réglementation du droit de nécessité ne s'impose pas*" Communiqués, Federal Department of Justice and Police, 16 June 2006, https://www.admin.ch/gov/fr/start/dokumentation/medienmitteilungen.msg-id-5670.html хаягаас үзнэ үү.

[102] Мөн тэнд.

[103] François Bellanger, *Droit de nécessité et état d'exception*, In: Thürer, Daniel ; Aubert, Jean-François; Müller, Jörg Paul (Ed.). *Droit constitutionnel suisse*. (Zürich: Schulthess, 2001), p.1269.

ашигласан үе[104] гэжээ.

Ийнхүү хоёр удаагийн Дэлхийн дайны туршлагад үндэслэн тус улс онц байдлыг хуульчлах нь Үндсэн хуульд харшилна гэж үзэх болжээ. Хэдийгээр зайлшгүй байдлын онол нь ноцтой хор уршиг учруулахуйц хямрал, нийтийг хамарсан байгалийн гамшгийн үед арга хэмжээ авахад хэрэгцээтэй боловч дээд шатны байгууллагууд, ялангуяа парламент үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломжгүй болох эрсдэлтэй. Учир нь энэ онолын дагуу парламент онц байдал зарлах, гүйцэтгэх эрх мэдэлд үнэмлэхүй эрх мэдлээ шилжүүлэх боломжгүй бол Засгийн газар өөрөө онц байдал зарлаж, шаардлагатай бүх арга хэмжээг авах бөгөөд ингэснээр Үндсэн хуулийн бус, дур зоргын шийдвэр хүртэл гаргах эрхтэй болно.[105]

Швейцари Улсын зохицуулалтын тогтолцоог дүгнэвэл, зайлшгүй байдлын онол буюу онц байдлыг хуулиар нарийвчлан зохицуулснаар хязгааргүй гүйцэтгэх эрх мэдлийг авчирдаг бөгөөд Үндсэн хуульд харшлах тул энэ талаар бичмэл зохицуулалтгүй байхыг илүүд үздэг байна.

1.2. ХБНГУ

ХБНГУ-ын хувьд Швейцариас ялгаатай нь Үндсэн хууль (герм. Grundgesetz) болон Онц байдлын тухай хууль (герм. Notstandgesetze)-даа онц байдлын талаар нарийвчлан зохицуулсан байна. Ингэхдээ онц байдал зарлах асуудал нь "батлан хамгаалах байдал" зарлах болон Spannungsfall (зэвсэгт босогчид болон зохион байгуулалттай тэмцэл өрнүүлж байгаа тохиолдолд иргэдийн өмч хөрөнгийг хамгаалах ажиллагаа) гэсэн агуулгын хүрээнд түлхүү хэрэглэгдэх бөгөөд хууль тогтоох тодорхой эрх мэдлийг гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад шилжүүлж болдог.[106]

Түүнчлэн ХБНГУ-ын Үндсэн хуульд онц байдлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээдээс цуцлах үүргээ "мартах боломжтой байх"-аас урьдчилан сэргийлэх зорилгоор онц байдлыг зарлах, хугацааг сунгах, цуцлах хугацааг аюул өнгөрмөгц "нэн даруй цуцлах" гэжээ.

Энэхүү судалгааны хүрээнд дэвшүүлсэн хувилбар 1-ийн агуулгын 1.2 дахь хэсэгт дурдсанаар ХБНГУ нь онц байдлыг "өргөн утгаар" зохицуулдаг улсад хамаарагддаг. Иймд тус улс Үндсэн хуульдаа дэлгэрэнгүй зохицуулахаас гадна ердийн хуулиар нэлээд тодорхой зохицуулсан.

ХБНГУ-д ийнхүү онц байдал зарлах талаар нарийвчлан зохицуулах нь "онц байдал болон батлан хамгаалах байдал зарлах, цуцлахад парламентын гүйцэтгэх үүрэг, ардчилсан тогтолцооны тогтвортой байдал, Үндсэн хуулийн шүүх, Бундестаг, Бундесратын хэвийн үйл ажиллагааг хангах хэтийн баталгаа болно"[107] гэж үздэг байна. Өөрөөр хэлбэл, ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалтын загвар нь онц байдлын үед улсын үндсэн ардчилсан институтыг хамгаалах, хэвийн үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг олгож буй хэрэг гэж үздэг.

Дүгнэвэл, Швейцари болон ХБНГУ-д онц байдлын талаар Үндсэн хууль болон бусад хуульдаа нарийвчлан зохицуулсан эсхүл зохицуулаагүй нь "онц байдлын үед хүний эрх, эрх чөлөө, ардчиллын суурь үнэт зүйл хязгаарлагддаг" гэх үндсэн нэг шалтгаанаас эхтэй боловч үндэслэл, тайлбар нь зарчмын хувьд ялгаатай байна. Швейцари Улсын хувьд онц байдлын үед хүний эрх, эрх чөлөөг хязгаарлаж, шаардлагатай үйлдэл хийх бүрэн эрхийг хууль тогтоох байгууллагаас гүйцэтгэх эрх мэдэлд шилжүүлснээр дур зоргын шийдвэр гаргах боломжтой болдог тул Үндсэн

[104] Мөн тэнд, p.1270.

[105] Anna Khakee, *Securing Democracy? A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30 (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.19.

[106] Онц байдлын тухай хууль (Notstandsgesetze)-ийг http://www.rechtliches.de/Gesetze_17.html хаягаас үзнэ үү.

[107] Anna Khakee, *Securing Democracy? A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30 (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.21.

хуульд харшилна гэж үзэж, улмаар энэ талаар бичмэл байдлаар зохицуулах нь түүнийгээ бататгаж буй хэрэг хэмээн Үндсэн хуульдаа зохицуулахаас татгалзсан байна. Харин ХБНГУ-ын хувьд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах боломжтой болдог учраас тэр тусмаа онц байдлын талаар нарийвчлан зохицуулах нь эрх мэдлээ урвуулан ашиглахаас сэргийлэх, хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага хуулийн дагуу үйл ажиллагаагаа явуулах, улсын ардчилсан институт оршин тогтнох баталгаа болно гэж үзэж Үндсэн хуулиараа онц байдал зарлах хүрээ хязгаарыг чанд тогтоожээ.

2. Норвегийн Вант Улс /цаашид "Норвеги" гэх/ **ба Бүгд Найрамдах Франц Улс** /цаашид "Франц" гэх/: Холимог загвар

Өмнөх хэсэгт дурдсанчлан, Швейцари болон ХБНГУ нь онц байдлын эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан хуульчилдаг ба хуульчилдаггүй гэсэн хоёр туйлт загварын гол төлөөлөл болох боловч гуравдагч загвар буюу холимог загварыг сонгож авсан улсууд ч байна.

Норвеги болон Франц Улсын зохицуулалт нь Швейцарийн загвартай төстэй гэж болно. Учир нь онц байдал нь гагцхүү ноцтой хор уршиг учруулахуйц нөхцөл байдалд хэрэглэх сүүлийн боломжит арга хэмжээ бөгөөд энэ талаар бичмэл байдлаар хуульчлах нь Үндсэн хуульд харшилна гэсэн үзэл баримтлалтай. [108] Гэвч Швейцариас ялгаатай нь эдгээр улсад онц байдлын талаарх зарим зохицуулалтыг, тодруулбал, хор уршиг бага учруулахуйц нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээний талаар нарийвчлан авч үздэг.

2.1. Норвеги

Норвегийн Үндсэн хуульд Швейцарийнхтай адилаар онц байдлын талаар бараг зохицуулаагүй боловч онц байдал болон дайны байдлын үед гаргах шийдвэр, эрх мэдлийн хуваарилалтын талаар зохицуулсан "Болзошгүй байдлын тухай хууль" (англ. Contingency Law)[109] гэж байна.

Тус хуулиар Стортинг[110] буюу парламент нь онц байдлын үед шийдвэр гаргах боломжгүй бол улсын ашиг сонирхлыг хамгаалах шаардлагатай арга хэмжээг авах эрхийг Хаанд олгосон. Гэсэн хэдий ч бодит байдал дээр Засгийн газар энэ эрхийг хэрэгжүүлдэг. Стортинг дараагийн арга хэмжээг нэн даруй авч, шийдвэрийг мэдээлснээр Хаан буюу Засгийн газрын гаргасан шийдвэр хүчингүй болно. Өөрөөр хэлбэл, эцсийн шийдвэрийг гаргах бүрэн эрх парламентад хадгалагдана. Парламент шийдвэрийг баталмагц хууль батлах үйл явцыг түргэсгэх бөгөөд хуульд онц байдлын үед хамрах нутаг дэвсгэрийн талаар зохицуулна. Онц болон дайны байдал зарласан, улсын аюулгүй байдал, бүрэн эрхэд заналхийлэл учирсан үед Эрүүгийн хуулийг мөн өөрчилж болдог.

Өөрөөр хэлбэл, Норвеги Улсад онц байдал зарлах шаардлагатай тохиолдол бүрт заавал хууль батлах замаар шийдвэрлэдэг. Гэвч онц байдал зарлахтай холбоотойгоор батлах хуулийн сул тал нь тухайн нөхцөлд хязгаарлах болон хамгаалах эрхийн талаар зохицуулдаггүй, ардчиллын суурь үнэт зүйлийг хамгаалах зорилго бүхий заалт агуулдаггүй байна.

Норвеги Улс хэдийгээр ийнхүү тухайлсан хуультай боловч "зайлшгүй байдлын онол"-ыг зөвхөн үндэсний ашиг сонирхолд аюул учирсан, ердийн хэм хэмжээгээр зохицуулах боломжгүй тохиолдолд хэрэглэх ёстой гэж үздэг. Учир нь Швейцари Улстай адил Дэлхийн II дайны үеийн туршлага бий бөгөөд ердийн нөхцөлд онц байдал зарлахаар хуульчлах нь Үндсэн хуулийг зөрчинө гэдэг ажээ.[111]

Дүгнэвэл, Норвеги нь нэг талаас онц байдал зарлах эрхийг парламентад

[108] Мөн тэнд.

[109] Хуулийг http://www.lovdata.no/all/hl-19501215-007.html хаягаас үзнэ үү.

[110] Норвеги Улсын парламентыг ингэж нэрлэдэг.

[111] Anna Khakee, *Securing Democracy? A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30 (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.22.

олгож, эрх зүйн зохицуулалтын талаар тухайлсан хуультай гэдгээрээ ХБНГУ-тай төстэй боловч нөгөө талаас гагцхүү маш ноцтой хямралт байдлын үед онц байдал зарлах үзэл баримтлалтай байдгаараа Швейцаритай төстэй, онц байдлын хоёр талт, холимог тогтолцоотой улс байна.

2.2. Франц

Франц Улсын хувьд онц байдлын эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан зохицуулах нь зүйтэй гэж үздэг ба ингэхдээ эрх мэдэл хуваарилалтын зарчмыг зохистой хэмжээгээр баримтлахыг зорьсон байна.

Франц Улсад онц байдал зарлах бүрэн эрх хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн аль алинд тодорхой хэмжээгээр хадгалагддаг боловч Үндсэн хуулийнх нь Арван зургадугаар зүйлд зааснаар уг бүрэн эрх Ерөнхийлөгчид арай илүү төвлөрдөг.112

Тус улс онц байдал зарлах бүрэн эрхийн гурван түвшин/шатлал (three-level system) бүхий тогтолцоотой. Тэдгээр нь Ерөнхийлөгчийн онц байдал зарлах бүрэн эрхээс гадна батлан хамгаалах байдал (Үндсэн хууль болон Батлан хамгаалах тухай хуульд тусгагдсан); онц байдал зэрэг болно. Өөрөөр хэлбэл, эдгээрийг бүгдийг нэгтгэн онц байдал гэж томьёолох боловч ийнхүү 3 шатлалаар ангилдаг.

Нийтийн дэг журамд ноцтой аюул заналхийлсэн буюу байгалийн гамшиг тохиолдсон үед улсын нийт болон зарим нутаг дэвсгэрт онц байдал зарлах бүрэн эрхийг Засгийн газар эдэлнэ. Батлан хамгаалах байдал болон онц байдал зарлаад 12 хоног өнгөрснөөс хойш хугацааг нь сунгахаар бол заавал парламентаар хэлэлцүүлдэг байна.

Харин онц байдлын үед хөл хорио тогтоох, чөлөөтэй зорчих эрх чөлөөг хязгаарлах зэрэг эрх хэмжээг Орон нутгийн төлөөлөгч буюу захирагчид хуулиар олгосон. Мөн Дотоод хэргийн сайд нь тодорхой төрлийн зэвсгийг хураан авах, орон байранд үзлэг, нэгжлэх хийх, нийтийн дэг журмыг сахиулах үүднээс тодорхой нутаг дэвсгэрт хөл хорио тогтоох эрхтэй.

Францын батлан хамгаалах болон онц байдал зарлах зохицуулалт нь олон талаараа төстэй бөгөөд дайны байдлаас ялгаатай нь онц байдлын үед зэвсэгт хүчинд эрх мэдэл шилжүүлдэггүй гэдгээрээ ялгаатай байна. Түүнчлэн Франц Улсад батлан хамгаалах байдал зарласан удаагүй боловч онц байдлыг 1955, 1985, 2005, 2006 онуудад тус тус зарлаж байжээ.113

Дүгнэвэл, Франц Улс нь Норвегийн адил онц байдлын талаар холимог зохицуулалттай хэдий ч онц байдлыг нарийвчлан хуульчилсан төдийгүй эрх мэдэл хуваарилалтын тэнцвэрийг сайн хадгалсан, онц байдлын үед аль байгууллага ямар эрхтэй байх талаар тодорхой тусгасан байгаагаараа давуу байна.

3. Испанийн Вант Улс /цаашид “Испани” гэх/: Холимог, нэгтгэмэл загвар

Испани Улсын зохицуулалт ХБНГУ-ын загвартай нэлээд төстэй, өргөн утгаар нь зохицуулсан боловч ерөнхийдөө дээр дурдсан улсуудын зохицуулалтын эерэг шинжийг Үндсэн хуульдаа нийцүүлэн нэгдмэл байдлаар хуульчилсан гэдгээрээ хамгийн онцлог байна.

Мөн дээрх улсуудаас ялгаатай нь фашизм, дайн, дарангуйлал XX зуунаас эхлэн Испанийн нийгэмд ноёрхсон тул дайны болон онц байдлын талаар харьцангуй туршлагатай улс юм. Тиймээс ч дотоодын туршлага болон бусад улсын зохицуулалтын эерэг, сөрөг талыг харьцуулсны үндсэн дээр онц байдлын талаар харьцангуй тодорхой, нарийвчилсан зохицуулалтыг бий болгожээ.

Испани Улс нь онц байдлыг дотор нь мөн гурав хуваадаг буюу гурван шатлалт тогтолцоотой. Тэдгээр нь түгшүүрт байдал, онц байдал, батлан хамгаалах байдал

[112] François Saint-Bonnet, *L’Etat d’exception* (Paris: Presses Universitaires de France, 2001), pp. 5-28-аас дэлгэрүүлж үзнэ үү.

[113] Thénault, Sylvie opt cit., Ministère de l’intérieur et de l’aménagement du territoire Décret n°2005-1387 du 8 novembre 2005 relatif à l’application de la loi n°55-385 du 3 avril 1955.

болно. Эдгээрийг хуульчлахдаа онц байдлын үед хязгаарлаж болох үндсэн эрх, эрх чөлөө, ардчиллын суурь үнэт зүйлийг хангах баталгаа болгож авах арга хэмжээ зэргийн талаар зохицуулахыг хичээдэг нь тус улсын эрх зүйн зохицуулалтын давуу тал ажээ.[114] Мөн онц байдлын гурван төрлийг "the Ley Orgбnica 4/1981" нэртэй органик хуулиар тус тусад нь нарийвчлан зохицуулсан.

Газар хөдлөлт, өргөн хүрээг хамарсан гал түймэр, тахал, нийтийн эмх замбараагүй байдал зэргийн үед улсын нийт буюу зарим нутаг дэвсгэрт "түгшүүрт байдал" зарлана. Харин нийтийн дэг журам, улс төрийн тогтолцоонд ноцтой аюул заналхийлсэн тохиолдолд "онц байдал", улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал, бүрэн эрх, Үндсэн хуулийн дэг журмын эсрэг заналхийлсэн зэвсэгт халдага, аюулын үед "батлан хамгаалах байдал" зарлана.

Ингэхдээ Испани Улсын хуульд дээрх гурван өөр төрлийн онц байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээ, хариуцах этгээдийн эрх хэмжээг тодорхой хуульчилсан нь онцлог байна. Тодруулбал, онц байдал, батлан хамгаалах байдал зарлах үед парламент давуу эрх хэмжээтэй бол түгшүүрт байдлын үед Засгийн газрын шийдвэрийг үндэслэн нутгийн захиргааны байгууллагууд захирамж, тушаал гаргана.

Харин онц байдлын үед нийтийн дэг журамд заналхийлэл учруулсан гэж үзэх хангалттай үндэслэл байвал тухайн этгээдийг 10-аас дээшгүй хоногоор цагдан хорих, парламентаас зөвшөөрвөл хүний зарим эрх, эрх чөлөөг хязгаарлах, шүүхийн зөвшөөрөлгүйгээр нэгжлэг, хяналт шалгалт хийх, эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлах зэргээр хүний эрх, эрх чөлөөг илүү өргөн хүрээгээр хөндөх шаардлагатай болдог. Гэвч тийнхүү хязгаарлахдаа баримтлах хүрээг мөн хуулиараа зохицуулсан. Тухайлбал, эвлэлдэн нэгдэх эрхийг хязгаарлахдаа улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, ажилтны зөвлөлийн ердийн хурал, уулзалтыг хориглож болохгүй гэжээ.

Мөн энэ судалгааны хувилбар 1-ийн хүрээнд дурдсанчлан, тус улс Үндсэн хуульдаа онц байдал зарлах хугацаа, түүнийг сунгах, цуцлах талаар дэлгэрэнгүй зохицуулсан байна. Тодруулбал, онц байдал зарлах дээд хугацаа 30 хүртэл хоног байх ба Конгресс хугацаа сунгах асуудлыг шийдвэрлэж дахин 30 хүртэл хоногоор сунгадаг. Ийнхүү хугацааг нарийвчлан тогтоох учир нь онц байдлын үед хүний эрх, эрх чөлөөг тодорхой хэмжээнд хязгаарладаг тул хэдий ноцтой тохиолдол гаравч хязгаарлалт тогтоох дээд хугацаа 60 хоногоос хэтрэх ёсгүй гэж үздэгт оршдог ажээ.

Нэмж дурдахад, Испани Улсын "The Ley Orgбnica 4/1981" нэртэй органик хууль нь 1981 онд батлагдсан боловч өдийг хүртэл нэг ч удаа хэрэглэх шаардлага гараагүй байгаагаараа Монгол Улстай төстэй.

Дүгнэвэл, Испанийн загвар нь ардчилсан институтийг хамгаалах ХБНГУ-ын зохицуулалттай төстэй боловч хэт чанд мөн хэт нуршуу бус, тэнцвэрийг хадгалсан[115] гэдгээрээ онцлог юм. Мөн онц байдлын гурван шатлалт тогтолцоог илүү тодорхой, дэлгэрэнгүй хуульчилж, байгалийн гамшиг, аюулт тахал, осол зэргийг онц байдалд бус "түгшүүрт байдал"-д хамааруулж, энэ тохиолдолд хууль гаргах замаар биш харин орон нутгийн захиргааны байгууллагууд захирамж гаргах замаар шийдвэрлэхээр зохицуулсан нь авуштай байна.

Өөрөөр хэлбэл, онц байдлын талаар дэлгэрэнгүй зохицуулалт бүхий Испани Улсын загвар нь онц байдал зарлах үед парламент болон бусад байгууллагуудын гүйцэтгэх үүрэг, хүний эрхийг хязгаарлах буюу хамгаалах гэсэн анхаарах шаардлагатай бүх асуудлыг хамарсан, нарийвчилсан зохицуулалт бүхий сайн загвар гэж үзэж болохоор байгааг дурдах нь зүйтэй.

[114] Anna Khakee, *Securing Democracy? A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30 (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.24.

[115] Мөн тэнд, p.25.

ДОЛОО. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт онц байдлын үед хязгаарлаж болох ба ухарч үл болох эрхийг заасан бөгөөд ОБтХ-д Үндсэн хуулийн тус зохицуулалтыг зүй ёсоор баталгаажуулсан нь Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээ болох ИБУТЭТОУП-д нийцсэн байна.

ОБтХ хэрэгжих хугацаанд буюу Монгол Улс түүхэндээ ганцхан удаа онц байдал зарласан нь 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн 194 дүгээр зарлиг байв. Тэрхүү үйл явдал нь Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөг хамгаалах Үндсэн хуулийн баталгааг шалгасан томоохон шалгуур болж, цөөнгүй хүний эрх, эрх чөлөө ноцтойгоор зөрчигдсөн тухай иргэний нийгмийн байгууллагуудын хүний эрхийн баримтжуулалтын тайланд дурджээ.

Энэхүү судалгааг гүйцэтгэхээр мэдээлэл цуглуулах явцад 2008 оны 7 дугаар сарын 1-нд зарласан онц байдлын үеэр тулгарсан асуудал, бэрхшээл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигт, тодруулбал, тус зарлигт асуудлыг шийдвэрлэх талаарх арга замыг тодорхой заагаагүй, хүний эрхийг хязгаарлах хүрээ, баталгааг хангах талаар оновчтой дурдаагүйд оршиж байсан буюу энэ нь хүний эрх, эрх чөлөө зөрчигдөх үндэслэл болсон гэж судлаачдын зүгээс үзлээ. Харин энэхүү судалгааны гол агуулга нь хууль тогтоомжийн зохицуулалтад холбогдох хүрээнд байсан тул 2008 оны 7 дугаар сарын 1-ний үйл явдалд бус хуулийн зохицуулалтад түлхүү ач холбогдол өгч судалгааг гүйцэтгэлээ.

Онц байдал зарлахтай холбоотой Монгол Улсын хууль тогтоомж нь харьцангуй нарийвчлан зохицуулагдсан, нэгдэн орсон Олон Улсын гэрээний үзэл баримтлалтай нийцсэн гэж үзэх бүрэн үндэслэлтэй бөгөөд бие даасан хууль батлах буюу шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах шаардлагагүй юм. Гэсэн хэдий ч цаг үе, нийгмийн шаардлагаар залруулах, тодруулах, бусад хуультай уялдуулах шаардлагатай зарим зохицуулалт байна.

Тухайлбал, ОБтх-ийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан онц байдал зарлаж болох үндэслэлд хамаарах асуудлын хүрээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээг практикт ГХтХ-аар зохицуулан хэрэгжүүлж байна. Энэ нь Олон Улсын гэрээг сахин биелүүлэх, хүний эрхийг хамгаалах, нийгэм, эдийн засгаа тогтвортой байлгах зэрэг олон талт харилцаанд эерэг нөлөөлөлтэй ч гажуудал, давхардлыг бий болгож байна.

Учир нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт онц байдал зарлаж болох үндэслэлийг хуульчлан өгсөн бөгөөд Үндсэн хууль нь төрийн тулгуур хууль болохын хувьд бусад хууль тогтоомж нь түүнтэй уялдаж байх ёстой учир ОБтХ-ийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон" бол онц байдал зарлаж болохоор хуульчилсан.

Гэтэл онц байдал зарлалгүйгээр ГХтХ-д гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан нь дээрх асуудлын хүрээнд ямар үед ГХтХ-д зааснаар арга хэмжээ авч хэрэгжүүлэх, ямар үед ОБтХ-д зааснаар онц байдал зарлаж болох тухайд эргэлзээ үүсгэж байх юм.

Иймд гамшиг, аюулт үзэгдэл, ослын шинж чанар, аюул, хэр хэмжээ, үргэлжилж буй хугацаанаас нь хамааруулан ОБтХ, ГХтХ-аар зохицуулагдах харилцааг нь ялган зааглах нь ач холбогдолтой.

Ийнхүү судалгааны үр дүнд зохицуулалтын хувилбаруудыг харьцуулан үзсэнээр одоогийн тулгарч буй асуудлыг шийдвэрлэх хамгийн оновчтой арга зам бол одоо хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд "нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах" гэж дүгнэв. Нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлахтай холбогдуулан дараах 2 хувилбарыг дэвшүүлсэн:

Хувилбар 1. Онц байдлын тухай ойлголт, хамрах хүрээ хязгаарыг нарийвчлан тодруулах;

Хувилбар 2. ОБтХ, Эрүүгийн хууль, ГХтХ зэрэг хууль хоорондын уялдаа холбоог хангах.

Дэвшүүлсэн хувилбаруудын аль нь ч зардал шаардагдахгүй бөгөөд үр дүн сайтай гэж үзэх үндэслэлтэй юм. Мөн түүнчлэн хувилбарууд нь агуулгын хувьд тусдаа асуудлыг хөндсөн боловч аль аль нь ОБтХ-ийг боловсронгуй болгох, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ач холбогдолтой.

Судалгааны хувилбар 1-ийн хүрээнд дурдсанчлан онц байдлын эрх зүйн үндэслэлийг зохицуулж буй байдлаар нь дэлхийн улсуудыг (1) өргөн утгаар нь зохицуулж буй; (2) явцуу утгаар нь зохицуулж буй; (3) дундаж байдлаар зохицуулж буй гэж гурав ангилж болох бөгөөд Монгол Улс өргөн утгаар нь зохицуулж буй улсад хамаарагдана. Түүнчлэн судалгааны эцэст оновчтой дүгнэлт, зөвлөмжид хүрэхийн тулд гадаад улсын эрх зүйн зохицуулалтыг тодорхой хэмжээнд судлах шаардлага гарсан ба судалгааны хүрээнд Монгол Улстай адил эх газрын эрх зүйн бүлд харьяалагддаг Швейцари, ХБНГУ, Норвеги, Франц, Испани гэсэн 5 улсыг сонгон авч судаллаа.

Гадаад улсын туршлагыг судлах хүрээнд сонгон авсан улсуудыг зохицуулалтын ялгаатай байдлаар нь мөн (1) Үндсэн хууль болон бусад хуульдаа онц байдал, зайлшгүй байдлын онолыг нарийвчлан зохицуулсан; (2) Үндсэн хууль болон бусад хуульдаа онц байдал, зайлшгүй байдлын онолыг бараг зохицуулаагүй буюу огт зохицуулаагүй; (3) Дундаж хэмжээгээр, холимог байдлаар зохицуулсан хэмээн 3 ангилж болох юм.

Онц байдал нь ердийн үед хэрэглэх арга хэмжээ биш бөгөөд онц байдал зарласан үед заавал хүний эрхийг хязгаарлах шаардлагатай болдог тул онц байдал зарлах асуудалд маш хянуур хандах учиртай. Энэ үүднээс онц байдал зарласан үед хүний эрх, эрх чөлөө, эрх мэдэл хуваарилах зарчим алдагддагийг мэдэрсэн туршлага дээрээ үндэслэн Швейцари, Норвеги зэрэг улсууд онц байдал болон зайлшгүй байдлын онолыг хуульчлах шаардлагагүй гэж үзжээ. Харин ХБНГУ, Франц зэрэг улсууд онц байдлын талаар нарийвчлан зохицуулах нь тухайн улсын ардчиллын суурь үнэт зүйл, хүний эрх, эрх чөлөөг хангах баталгаа болно гэж үздэг тул Үндсэн хууль болон бусад хуулиараа дэлгэрэнгүй бөгөөд чанд хязгаарлалтыг хийсэн байна. Гэвч ингэж хэт нэг талыг баримтлахдаа эдгээр улсууд аль нэг асуудлыг нь орхигдуулсан гэж үзэж болохоор юм. Сонгон авсан улсуудаас хамгийн боломжит хувилбар бүхий загварыг баримталдаг улс болох Испани Улсын хувьд дээрх хоёр загварын алинд ч туйлшралгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хангах, хязгаарлах үндэслэл болон ардчиллын суурь үнэт зүйлийг хамгаалах, эрх мэдлийн тэнцвэрт байдлыг хангахыг бүхий л талаар зорьсон зохицуулалт хийсэн байна.

Испани Улсын Монгол Улстай төстэй тал нь, тус улсын онц байдлын тухай нарийвчилсан зохицуулалт бүхий органик хууль нь 1981 онд батлагдсан боловч өнөөдрийг хүртэл хэрэглэх шаардлага үүсээгүй байна. Түүнчлэн манай улсын ОБтХ-ийн зохицуулалт Испанийн зохицуулалттай олон талаар төстэй. Тиймээс энэхүү судалгаанд судлагдсан гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтаас нутагшуулж болох дараах зохицуулалт байна:

- Испани Улс онц байдлын гурван шатлалт тогтолцоо (англ. Three-level system)-г баримталдаг бөгөөд Бүгд Найрамдах Солонгос Улс мөн энэ загварыг хэрэглэдэг. Гурван шатлалт тогтолцоо гэдэг нь онц байдлын хэлбэрийн хувьд төстэй боловч агуулгын хувьд ялгаатай ойлголтуудыг зэрэглэлээр нь ангилан тодорхойлох явдал юм. Тодруулбал, Монгол Улсын хуульд “онц болон дайны байдал”-ыг тусад нь авч үзсэн бөгөөд онц байдал дотроо байгалийн гамшиг, малын гоц халдварт өвчин, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал зэргийг бүгдийг багтаасан байхад Испани Улсын хувьд “түгшүүрт байдал”, “онц байдал”, “батлан хамгаалах байдал” хэмээн гурван төрлийг тогтоож, бүгдийг нь нэгтгэн “онц байдал зарлах” хэмээн томьёолсон

бөгөөд тус бүрт нь тохирох зохицуулалтыг хуульчилжээ. Тухайлбал, “түгшүүрт байдал”-ыг заавал хууль гаргаж зохицуулах шаардлагагүй бөгөөд энэ тохиолдолд Засгийн газар болон захиргааны байгууллагууд тогтоол, шийдвэр гаргах замаар шийдвэрлэдэг. Харин “онц байдал” зарлах үед хууль батлах буюу заавал парламентаас шийдвэрлэдэг. Хэдийгээр манай улсын хувьд практикт үүнтэй адил шийдвэрлэж байгаа боловч хуульдаа зохицуулаагүй учир ойлгомжгүй байдлыг үүсгэж байгаа тул онц байдлын хоёр төрлөө зэрэглэлээр ангилж, арга замыг тодорхой болгох нь зүйтэй байж болох юм.

- Испани Улсын хуульд онц байдлыг дээд тал нь 30 хоногийн турш зарлах бөгөөд сунгаж болох хугацаа нь мөн нэг удаа 30 хүртэл хоног байна. ХБНГУ-ын хувьд хугацааг мөн хуульчилсан ба онц байдал зарласан этгээд шийдвэрээ эргээд цуцлах талаар “мартах боломжтой” бөгөөд онц байдал нь хүний эрхийг хязгаарладаг тул тодорхой хугацааны хязгааралттай байх ёстой гэсэн үүднээс ийнхүү зохицуулдаг байна.

Иймд ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага нэгэнт бий болсон учир хуулийн төсөл боловсруулах шаардлагатай. Харин судалгааны хүрээнд дурдсан зохицуулалтуудаас бусдаар хууль харьцангуй хангалттай түвшинд хуульчлагдсан гэж болохоор тул шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах шаардлагагүй харин ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулах шаардлагатай гэж судлаачдын зүгээс үзлээ.

Хуулийн төсөл боловсруулахдаа одоогийн хуулиар зохицуулаагүй болон зохицуулалт гарцаагүй шаардаж байгаа дараах асуудлыг тусгах нь зүйтэй:

- 2015 оны Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиар ялын төрлөөс цаазаар авах ялыг хассан болон Монгол Улс ИБУТЭТОУП-аар цаазаар авах ялыг халах II нэмэлт протоколд нэгдэн орсонтой холбогдуулан ОБтХ-ийн 15 дугаар зүйлд заасан “Онц байдал үргэлжлэх хугацаанд цаазаар авах ял гүйцэтгэхгүй байх” зохицуулалтыг бүхэлд нь хүчингүй болгох;
- Онц байдал зарласан үед ямар байгууллага, ямар үйл ажиллагаа, ямар зохион байгуулалттайгаар авч хэрэгжүүлэх талаар нарийвчилсан зохицуулалтыг тусгах буюу онц байдлын төрлийг зэрэглэлээр нь нарийвчлан тодорхойлох;
- Онц байдал зарлаж болох үндэслэлд хамаарах нөхцөл байдал болох гамшиг, аюулт үзэгдэл, осол зэрэгтэй холбоотой асуудалд ГХтХ-ийг хэрэглэн зохицуулж байх тул энэхүү хоёр хуулийн давхардлыг арилгах, /Үүний тулд онц байдлыг дээр дурдсанчлан ангилалтай байдлаар авч үзэж болох юм. Хэрэв ангилалтай байдлаар авч үзвэл, ОБтХ-аар зохицуулагдаж буй харилцааг ямар үед нь гагцхүү онц байдал зарлан шаардлагатай арга хэмжээ авч шийдвэрлэх, ямар үед ГХтХ-ийг баримтлан уг асуудлыг шийдвэрлэвэл зохих талаар зохицуулалтыг бий болгох/ зэрэг болно.

Хуулийн хүрээний хүрээлэн www.law.mn

Хавсралт 1

ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨНИЙ УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	**1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх**			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь ялгаварлан гадуурхахыг хориглосон байх боломжтой.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэсэн зохицуулалт агуулаагүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол Олон Улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарлах талаар Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид хуульчилсан бөгөөд Олон Улсын эрх зүйн баримт бичигт тусгагдсан.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан Монгол Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим нутаг дэвсгэрт авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь оршин сууж буй бүх хүн, хуулийн этгээдэд хамааралтай.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан Монгол Улсын нийт нутаг дэвсгэр буюу зарим нутаг дэвсгэрт оршин сууж буй бүх хүн, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлана.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан цаазаар авах ялтай холбоотой зохицуулалтыг хүчингүй болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалахад ахиц дэвшил гарна. Мөн онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар хуульд нарийвчлан зохицуулснаар нийгэмд үүссэн эмх замбараагүй байдал даамжрах болон хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх боломжтой.

Хууль зүйн яаманд хүлээлгэн www.mj.gov.mn

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын Олон Улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	ИБУТЭТОУП-ын нэмэлт II протоколд Монгол Улс нэгдэн орсонтой холбогдуулан цаазаар авах ялыг 2015 оны Эрүүгийн хуулиас халсан учир ОБтХ-ийн 15 дугаар зүйлийг хүчингүй болгох асуудал, мөн ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулан онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар ИБУТЭТОУП-ын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын зургаа дахь удаагийн ээлжит тайланд Хүний эрхийн хорооноос өгсөн дүгнэлттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжтэй нийцэх юм.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	**Үгүй**	ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулсан тохиолдолд уг хуулийг зөрчсөн “албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр, уг хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр” одоогийн мөрдөж буй ОБтХ-д зохицуулагдсан байна. Иймд хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын дээрх заалтыг өөрчлөх шаардлагагүй гэж үзэж байна.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	**Тийм**	Үгүй	Үндсэн хууль болон Олон Улсын гэрээнд заасны дагуу онц болон дайны байдал зарласан үед хүний эрхийг хязгаарлаж болохоор заасан. Ийнхүү хүний эрхийг хязгаарлахдаа онц байдлын үед үл хөндөгдөх иргэний эрх, эрх чөлөөг мөн хуульчлан өгсөн байна. Онц байдал нь онцгой нөхцөл байдал бий болсон үед үр дагаврыг нь арилгах, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд авч хэрэгжүүлж буй хууль ёсны зорилгод нийцсэн үйл ажиллагаа юм.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед онц байдал зарласан шалтгаан, нөхцөлөөс хамааруулан хязгаарлалт тогтоох шаардлагатай.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГ www.nli.gov.mn

3. Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Эрх агуулагчдыг тодорхойлоогүй.
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулсан тохиолдолд эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлох боломжтой.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	**Тийм**	Үгүй	ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулсан тохиолдолд эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн зохицуулалт бий болгох боломжтой.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	**Тийм**	Үгүй	ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулсан тохиолдолд Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах боломжтой.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулахдаа онц байдал зарласан үед ямар байгууллага ямар үйл ажиллагаа хэрхэн хэрэгжүүлэх талаар нарийвчлан тусгаснаар үүрэг хүлээгчдийг тодорхойлно.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан улсын нийт нутаг дэвсгэр буюу түүний зарим хэсэгт байгаа хүн амд хамааралтай бөгөөд энэхүү харилцаанд жендерийн хувьд ялгавартай хандах тухай зохицуулалт агуулагдаагүй байна.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан улсын нийт нутаг дэвсгэр буюу түүний зарим хэсэгт байгаа хүн амд нас, хүйс харгалзахгүйгээр ижил тэгш хамааралтай.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭС www.nli.gov.mn

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	**Тийм**	Үгүй	ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар аж ахуй нэгжид шинээр зардал үүсэх боломжтой.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	ОБтХ-д нэмэлт, өөрчлөлт оруулж онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх боломжтой.
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар онц байдал зарласан шалтгаан, нөхцөлөөс хамаарч тодорхой бараа бүтээгдэхүүн худалдан авахад хүргэх боломжтой.

Хууль зүйн яамны хуулийн хүрээлэн www.mli.gov.mn

	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед тухайн онц байдал зарлах болсон шалтгаан, нөхцөлөөс хамаарч зарим бараа бүтээгдэхүүнийг борлуулахад хязгаарлалт тавих боломжтой. Тухайлбал, нийтийг хамарсан үймээн самууны үед архи, согтууруулах ундааны зүйл худалдахыг хориглох, малын гоц халдварт өвчин гарсан үед тухайн малын махыг зарахыг хориглох гэх мэт.
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан шалтгаан нөхцөлөөс хамаарч зарим тохиолдолд ААН-ийн үйл ажиллагааг зогсоож болно. Тухайлбал, нийтийг хамарсан үймээн самууны үед нийтийн жагсаал уриалан дуудсан мэдээ мэдээлэл дамжуулсан олон нийтийн мэдээллийг хэрэгслийн үйл ажиллагааг зогсоох, малын гоц халдварт өвчин гарсан тохиолдолд тухайн түүхий эдээр бүтээгдэхүүн нийлүүлдэг ААН-ийн үйл ажиллагааг зогсоох гэх мэт.
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нөмөлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар онц байдал зарласан үед энгийн үед авч хэрэгжүүлдэг байсан арга хэмжээнээс өөр арга хэмжээ авч хэрэгжүүлсэнтэй холбоотойгоор нэмэлт зардал гарах боломжтой бөгөөд үүний талаар мэдээлэх, тайлан гаргах шаардлагатай.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэхийн тулд иргэн, хуулийн этгээдийн өмчлөх эрхийг хөндөх боломжтой. Тухайлбал, газар хөдлөлтийн улмаас иргэдийг аюулгүй газар байрлуулахын тулд тухайн шаардлага хангасан барилгад хүмүүсийн түр оргонуулах тохиолдол.
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	**Тийм**	Үгүй	Тухайн онц байдал зарласан нутаг дэвсгэрт өмчлөх эрх олж авах, шилжүүлэх, хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болох боломжтой.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ХУУЛЬ ЗҮЙНДЭСНИЙ ХЭЛЛЭГ
www.mngov.mn

6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар тухайн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хэрэглээний үнийн түвшинд нөлөөлөх боломжтой.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	**Тийм**	Үгүй	Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломжтой.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар тухайн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх боломжтой.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар тухайн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь хувь хүн, гэр бүлийн санхүүгийн байдалд нөлөө үзүүлэх боломжтой. Тухайлбал, мах махан бүтээгдэхүүн зарж орлого олдог хүний хувьд малын гоц халдварт өвчин гарсны улмаас мах махан бүтээгдэхүүн зарахыг хориглосноор санхүүгийн байдалд нь сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.
8.Тодорхой бус нутаг, салбарууд	8.1.Тодорхой бус нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Онц байдал зарласан үед шинээр ажлын байр бий болохгүй.
	8.2.Тодорхой бус нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага болон онц байдал зарлах болсон шалтгаан нөхцөлтэй тодорхой байдлаар холбоо хамааралтай байгууллагын үйл ажилагааг зогсоовол нөлөө үзүүлэх боломжтой.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ www.mjs.gov.mn

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар онц байдал зарласан үед аливаа байгууллагын авч хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах төсвийн улсын төсвөөс гаргах шаардлага бий болно.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар шаардлагатай тохиолдолд чиг үүргийн хувьд өөр боловч тусгай байгууллага, хэлтэсүүдийн үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах боломжтой.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох боломжтой.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотойгоор эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлэх, ажилт эрхлэлтийг түр зогсоох зэрэг байдлаар нөлөө үзүүлэх боломжтой.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	**Үгүй**	Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжихгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	**Тийм**	Үгүй	Инфляци нэмэгдэх боломжтой.
11.Олон Улсын харилцаа	11.1.Монгол Улсын Олон Улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

ХУУЛЬ ЗҮЙ ЯАМНЫ ХУДАЛДАН ЗАРЛАГЫН www.mojha.gov.mn

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	**Үгүй**	Шинээр ажлын байр бий болгохгүй.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ажлын байрны цомхотгол бий болгохгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед авч хэрэгжүүлэх арга хэмжээнээс хамаарч тодорхой мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх боломжтой.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар хуулийн дагуу эрх эдэлж, үүрэг хүлээж буй байгууллагууд шинээр ажлын стандарт гаргах боломжтой.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарлах болсон шалтгаан нөхцөлтэй холбоотойгоор төрийн байгууллагуудад нэмэгдэл үүрэг өгч, үйл ажиллагаанд нь нөлөөлөх боломжтой.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулсантай холбоотойгоор төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг харилцаанд нөлөөлөх боломжтой.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулсантай холбоотойгоор нөлөөлөх боломжтой.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар онц байдал зарласан шалтгаан, нөхцөлөөс хамааран хүмүүсийн амьдралын хэв маягт нөлөөлөх боломжтой.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар онц байдал зарласан үед ажилчдын шинжилт хөдөлгөөнд нөлөөлөх боломжтой.

Хуулийн мэдээний хүрээлэн www.ilaw.mn

	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар онц байдал зарласан үед гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах боломжтой.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар онц байдал зарласан үед хуулийг албадан хэрэгжүүлэх боломжтой.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Онц байдал зарласан үед хэн, ямар арга хэмжээ, хэрхэн авч хэрэгжүүлэх талаар нарийвчлан зохицуулснаар онц байдал зарласан үед үйлдэгдсэн гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөөлөх боломжтой.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРААНГУЙ
www.hi.gov.mn

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Хууль зүйн яаманд хянагдсан
www.nli.gov.mn

Хавсралт 2

ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХОЛБОГДОХ ХУУЛИЙН ТҮҮВЭР СУДАЛГАА

(Хүснэгт 5)

д/д	Хуулийн нэр	Холбогдох зүйл, заалт
1	**Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын пакт**	**4 дүгээр зүйл** 1. Улс үндэстний амьдралд аюул занал тулгарч, энэ тухай албан ёсоор зарлаж нийтийг хамарсан онц байдал тогтоосон үед энэхүү Пактад оролцогч улс уг Пактаар хүлээсэн үүргээсээ тухайн нөхцөл байдлын хурцадмал шинжид дүйх хэмжээгээр ухарсан арга хэмжээ авч болох бөгөөд тэр нь Олон Улсын эрх зүйгээр хүлээсэн бусад үүрэгт нь харшлах ёсгүйгээс гадна зөвхөн арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг буюу нийгмийн гарлаар алагчилах явдалд хүргэхгүй байх ёстой.
2	**Монгол Улсын Үндсэн хууль**	**Арван есдүгээр зүйл** 2. Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө. **Хорин тавдугаар зүйл** 2. Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно: 1/ улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон; 2/ Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон.
3	**Байгаль орчныг хамгаалах тухай хууль**	**23 дугаар зүйл.Онц байдал тогтоосон үед байгаль орчныг хамгаалах** Үндсэн хуульд зааснаар онц байдал тогтоосон нутаг дэвсгэрт байгалийн гамшиг, гэнэтийн аюулыг сааруулах, түүний хор уршгийг арилгах, байгаль орчин, түүний баялгийг хамгаалах арга хэмжээг онц байдлын тухай болон онц байдал зарласан хуульд заасан үндэслэл, журмын дагуу авч хэрэгжүүлнэ.
4	**Газрын тосны тухай хууль**	12.2.Гэрээлэгч газрын тос, уламжлалт бус газрын тосны ашиглалт явуулах нь эдийн засгийн үр ашиггүй гэж үзсэн, эсхүл онц байдал, давагдашгүй хүчин зүйл нэг ба түүнээс дээш жил үргэлжилбэл гэрээг цуцлах хүсэлтээ төрийн захиргааны байгууллагад хүргүүлж болно. **38 дугаар зүйл. Онц байдал, давагдашгүй хүчин зүйл** 38.1.Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт, эсхүл түүний зарим хэсэгт онц байдал зарласан тохиолдолд Засгийн газар гэрээлэгчид ногдох газрын тос, уламжлалт бус газрын тос, барилга байгууламж, техник, тоног төхөөрөмжийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нөхөх олговортойгоор дайчилж болно.

Хуулийн зүйлийг хүрэлцэхгүй www.legal.mn

5	**Дайны байдлын тухай хууль**	8.2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтын дагуу тогтоох тусгай дэглэмийн хүрээнд Онц байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтаас гадна дараахь арга хэмжээг хэрэгжүүлнэ: 8.2.1.ажил хаях, зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр хурал, цуглаан, жагсаал, нийтийг хамарсан бусад арга хэмжээ зохион байгуулахыг хориглох; 8.2.2.дайны байдлын үеийн хууль тогтоомжийн заалтыг зөрчсөн хуулийн этгээдийн үйл ажиллагааг хязгаарлах, зогсоох, байгууллагыг тараах; 8.2.3.иргэний тоо бүртгэл, мэдээлэлд хатуу хяналт тогтоож, шаардлагатай үед тээврийн хэрэгсэл, иргэдийн бие, орон сууцад үзлэг хийх, зэвсэг, галт хэрэглэл, хориглосон бусад эд зүйлийг хураах, сэжигтэй этгээдийг баривчлах, саатуулах; 8.2.4.өмчийн хэлбэр харгалзахгүйгээр байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх.
6	**Дипломат албаны тухай хууль**	18.1.2. суугаа улс оронд дайны болон онц байдал тогтох, гамшиг болон аюул үүсэх, нийтийг хамарсан гоц халдварт өвчин гарах зэрэг тохиолдолд дипломат ажилтан, үйлчилгээ, техникийн ажилтан, тэдний гэр бүлийн гишүүдийг хамгаалалтад авах, уг байдлаас үүдсэн эд хөрөнгийн болон эрүүл мэндийн хохирлыг арилгах арга хэмжээ авах;
7	**Дотоодын цэргийн тухай хууль**	**17 дугаар зүйл. Дайн бүхий болон дайны байдал, онц байдлын үед ажиллах** 17.1.Дотоодын цэрэг нь дайн бүхий болон дайны байдал, онц байдлын үед ажиллах журмыг хууль тогтоомжид заасны дагуу тогтооно. 30.1.6.нийтийг хамарсан эмх замбараагүй байдал болон онц байдлын үед бусдын амь нас, эд хөрөнгө, аюулгүй байдлыг хамгаалах.
8	**Захиргааны Ерөнхий хууль**	3.1.Энэ хууль дараах харилцаанд үйлчлэхгүй: 3.1.5.онц болон дайны байдал зарласан үед зэвсэгт хүчин ашиглах, цэрэг хөдөлгөх;
9	**Зөрчлийн тухай хууль**	**5.18 дугаар зүйл. Онц байдлын тухай хууль зөрчих** 1. Онц байдал тогтоосон шийдвэр, онц байдлын үеийн онцгой арга хэмжээ, нэмэлт онцгой арга хэмжээ, онцгой арга хэмжээг тогтоох, хэрэглэх хүрээ заагийн хязгаарлалтыг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 2.Холбооны, эсхүл олшруулах, дуу авиаг чангаруулах техник хэрэгслийн ашиглалтын талаар тогтоосон журам зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 3.Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тогтоосон хяналтын журам зөрчсөн, эсхүл үйл ажиллагааг нь түр зогсоосон тогтмол хэвлэлийг хэвлэлд бэлтгэсэн, үйлдвэрлэсэн, тараасан, худалдсан, борлуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Тайлбар: Хуульд заасны дагуу нийтийн эмх замбараагүй байдлыг арилгахад саад учруулсны улмаас үйл ажиллагаа нь зогссон улс төрийн нам, эвсэл холбоо, олон нийтийн байгууллагын хөрөнгийг улсын орлого болгоно.
10	**Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль**	**13 дугаар зүйл.Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах талаархи Ерөнхийлөгчийн бүрэн эрх** 6.Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөх захирамж өгнө. Энэ тухай Ерөнхийлөгчийн зарлигийг нэн даруй ард нийтэд зарлан мэдэгдэнэ. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

Хууль зүйн мэдээлэл технологийн www.legal.gov.mn

11	**Монгол Улсын их хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай**	**6^4 дүгээр зүйл.Онц болон дайны байдал зарлах, цуцлах тухай асуудлыг хэлэлцэх** 36^4.1.Онц болон дайны байдал зарлах тухай асуудлыг Онц байдлын тухай хуулийн 5-7 дугаар зүйл, Дайны байдлын тухай хуулийн 5, 6 дугаар зүйлд заасныг тус тус баримтлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ. 36^4.2.Энэ хуулийн 36^4.1-д заасан шийдвэрийн төсөлтэй холбогдон гарах бусад хууль, Улсын Их Хурлын шийдвэрийн төслийг энэ хуульд заасан хугацааг харгалзахгүйгээр хэлэлцэнэ. 36^4.3.Онц болон дайны байдал зарлах тухай Ерөнхийлөгчийн зарлиг батлах, эсхүл хүчингүй болгох асуудлыг хэлэлцэхэд уг асуудлыг нэгдсэн хуралдаанд Ерөнхийлөгч танилцуулна. 36^4.4.Онц байдал зарлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй гишүүд санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг нэгдсэн хуралдаанд хууль санаачилсан гишүүн танилцуулж, энэ хуулийн 36^4.1-д заасан дэгийн дагуу хэлэлцэнэ.
12	**Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай**	**7^1 дүгээр зүйл. Зөвлөлийн онцгой бүрэн эрх** Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсны улмаас онц байдал зарлах тухай шийдвэр буюу Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн онц байдал үргэлжлэх хугацаанд Зөвлөл онц байдлыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах онцгой чиг үүрэг гүйцэтгэнэ. Энэ чиг үүрэгийн дагуу Зөвлөлийн хэрэгжүүлэх онцгой бүрэн эрхийг Онц байдлын тухай хуулиар тогтооно.
13	**Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хууль**	**23 дугаар зүйл. Цэцийн хуралдаанд бэлтгэх** 3.Онц болон дайны байдал зарласан, түүнчлэн цэрэг хөдөлгөх шийдвэртэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх бэлтгэл ажиллагааг 3 хоногийн дотор гүйцэтгэнэ. **36 дугаар зүйл. Цэцийн шийдвэрийг биелүүлэх** 2.Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор; хэрэв Улсын Их Хурлын чуулганы чөлөөт цагт гаргасан бөгөөд тэр нь онц болон, дайны байдал зарласнаас бусад асуудлаар гарсан бол Улсын Их Хурлын дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.
14	**Терроризмтой тэмцэх тухай хууль**	**6 дугаар зүйл. Терроризмоос сэргийлэх талаар төрийн байгууллагын хүлээх үүрэг** 6.1.3.террорист үйлдлийн улмаас онц байдал тогтоох нөхцөл байдал үүссэн тохиолдолд онц байдал тогтоох асуудлыг Монгол Улсын Үндсэн хууль, хууль тогтоомжид заасан журмын дагуу шийдвэрлүүлэх;
15	**Цагдаагийн албаны тухай хууль**	**86 дугаар зүйл. Нийгмийн баталгаа** 86.7.Цагдаагийн алба хаагчид эмнэлгийн тусламж үзүүлэх үүрэг бүхий тусгай зориулалтын эмнэлэг нь нийтийг хамарсан эмх замбараагүй байдал үүссэн, өндөржүүлсэн бэлэн байдал, онц байдал зарласан, хээрийн сургууль, дадлагын үеэр эмнэлгийн баг ажиллуулна. 86.11.Гэмт хэрэгтэй тэмцэх, дайны болон онц байдал, энхийг дэмжих ажиллагаа, гамшиг, түүний үр дагаврыг арилгах зэрэг цагдаагийн алба хаагчийн эрүүл мэнд, амь насанд өндөр эрсдэлтэй онцгой нөхцөлд алба хаасантай холбоотойгоор сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээ шаардлагатай бол 3 сар хүртэл хугацаагаар сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд үнэ төлбөргүй хамруулна. **87 дугаар зүйл. Эдийн засгийн баталгаа** 87.4.Нийтийг хамарсан эмх замбараагүй байдал, онц байдлын үед болон голомтын бүсэд үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн алба хаагчид албан томилолтын зардлыг ердийн үеийнхээс гурав дахин нэмэгдүүлж олгоно.
16	**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль**	**164 дүгээр зүйл.Нийтэд тустай ажил хийлгэх ял эдлэх хугацаа, түүнийг тооцох, ял эдэлж дуусах** 164.3.Ялтан онц байдал, гамшиг, аюулт үзэгдлийн хор уршгийг арилгах нийтийн хөдөлмөрийн дайчилгаанд дайчлагдан ажилласан цагийг нийтэд тустай ажил хийлгэх ял эдэлсэн хугацаанд тооцно.

Хууль зүйн яамны нэвтэрхий толь www.mojha.gov.mn

17	**Эрүүгийн хууль**	**6.6 дугаар зүйл.Эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдал** 1.7. онц байдал, гамшиг, аюулт үзэгдэл, нийтийн эмх замбараагүй байдлыг далимдуулан үйлдсэн; **28.1 дүгээр зүйл.Тушаал биелүүлэхгүй байх** 2.2.дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. **28.5 дугаар зүйл.Цэргийн албанаас оргон зайлах** 2.Энэ гэмт хэргийг: 2.1.дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед; **28.6 дугаар зүйл.Биедээ гэмтэл учруулах, өөр бусад аргаар цэргийн албанаас зайлсхийх** 2.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. **28.7 дугаар зүйл.Цэргийн эд хөрөнгө, байлдааны галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодисыг зарах, үрэгдүүлэх, завших** 3.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. **28.8 дугаар зүйл.Цэргийн эд хөрөнгийг санаатай устгах, гэмтээх** 2.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. **28.12 дугаар зүйл.Байлдааны жижүүр хийх журам зөрчих** 2.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. **28.14 дүгээр зүйл.Харуулын албаны журам зөрчих** 2.Энэ гэмт хэргийг дайны байдалд шилжсэн, эсхүл онц байдал зарласан үед үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
18	**Эрүүл мэндийн тухай хууль**	**6 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх** 6.1.3. онц байдлын үед хүн амын эрүүл мэнд, амь насыг хамгаалах асуудлаар эрүүл мэндийн байгууллага, иргэн, бусад байгууллагын үүргийг тодорхойлох;
19	**Онц байдлын тухай хууль**	Онц байдал зарлахтай холбоотой харилцааг бүхэлд нь энэ хуулиар зохицуулсан.
20	**Гамшгаас хамгаалах тухай хууль**	Онц байдалд зарлах үндэслэлд хамаарах гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар хуульчилсан.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1.
- Онц байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1996), №2.
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2002), №5.
- Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №25.
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №7.
- Гамшгаас хамгаалах тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №7.
- Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай Олон Улсын конвенц, 1965.
- Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт,1966.
- Эмэгтэйчүүдийг алагчлах бүх хэлбэрийг устгах тухай конвенц, 1979.
- Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенц, 1984.
- Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пактаар цаазаар авах ялыг халахад чиглэсэн нэмэлт II протокол, 1989.

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ ҮНДЭСЛЭЛ www.ali.gov.mn

- Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2008 оны 7 дугаар сарын 1-ний өдрийн “Онц байдал тогтоох тухай” 194 дүгээр зарлиг.
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”.

Хоёр. Ном зохиол, гарын авлага, судалгааны тайлан

Монгол хэлээр

- 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд. Ханнс-Зайделийн сан. УБ: “Хөх судар принтинг” ХХК, 2007.
- Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. Ханнс-Зайделийн сан. УБ: 2009.
- Нарангэрэл.С. Эрх зүйн эх толь бичиг. УБ: Адмон хэвлэл, 2007.
- Совд.Г нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ: 2000.

Гадаад хэлээр

- Bellanger, Franзois. Droit de nйcessitй et йtat d’exception, In: Thьrer, Daniel; Aubert, Jean-Franзois; Mьller, Jцrg Paul (Ed.). Droit constitutionnel suisse. Zьrich: Schulthess, 2001.
- Bulmer, Elliot. Emergency Powers. Stockholm: International Institute for Democracy and Electoral Assistance, 2018.
- Campbell Black, Henry. Black’s law dictionary, 9th edition. St.Paul, Minn: West publishing Co, 2009.
- Khakee, Anna. Securing Democracy? A Comparative Analysis of Emergency Powers in Europe. Policy Paper No.30. Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009.
- Saint-Bonnet, Franзois. L’Etat d’exception. Paris: Presses Universitaires de France, 2001.
- Smith, William. Wayte, William and Marindin, G.E. A Dictionary of Greek and Roman Antiquities. Volume 1. London: John Murray, 1890.

Гурав. Судалгааны тайлан, илтгэл өгүүлэл

Монгол хэлээр

- Онц байдалтай холбоотой хүний эрхийн зөрчлийн мониторинг хамгааллын эвсэл /Баримтжуулалтын тайлан/, (УБ: 2008), “BCI” хэвлэлийн компани
- Оюунболд.Г. Онц байдал түүний эргэн тойронд, Хууль дээдлэх ёс сэтгүүл №4 (2008): 64-70.
- Сургагч багш нарт зориулсан гарын авлага. Хууль зүй, дотоод хэргийн яам. УБ: ХЗДХЯ, 2017.
- Хөдөө аж ахуйн салбарын танилцуулга 2017. Монгол Улсын Үндэсний статистикийн хороо.

Гадаад хэлээр

- “Declaratoria dello stato di emergenza e Consiglio supremo di difesa” Nuovi studi politici (gennaio-giugno 2005, n. 1/2)

Хууль зүйн гүйцэтгэлийн хүрээлэн www.hli.gov.mn

Дөрөв. Цахим эх сурвалж

- “Une nouvelle rйglementation du droit de nйcessitй ne s’impose pas” Communiquйs, Federal Department of Justice and Police, 16 June 2006 - https://www.admin.ch/gov/fr/start/dokumentation/medienmitteilungen.msg-id-5670.html
- Ану.Б. “Мал амьтны гоц халдварт өвчний эрсдэл буурчээ” (2018.07.19) - https://ikon.mn/n/1cb7
- Батхүү.Ө. “Долдугаар сарын 1-нээс хойш...” (2015.07.01) - http://www.olloo.mn/n/17420.html
- Испани Улсын Үндсэн хууль - https://www.boe.es/legislacion/documentos/ConstitucionINGLES.pdf
- Монгол Улсын Үндэсний статистикийн хорооны албан ёсны цахим хуудас - https://www.nso.mn/
- Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем - https://www.legalinfo.mn/
- ХБНГУ-ын Эрх зүйн актын нэгдсэн сан - https://www.gesetze-im-internet.de/index.html
- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны албан ёсны цахим хуудас - http://mofa.gov.mn/exp/blog/7/8
- Швейцари Улсын Үндсэн хууль - https://www.admin.ch/opc/en/classified-compilation/19995395/201809230000/101.pdf

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ИРГЭНИЙ БОЛОН УЛС ТӨРИЙН ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ПАКТЫН 19 ДҮГЭЭР ЗҮЙЛТЭЙ ҮНДЭСНИЙ ХҮЧИН ТӨГӨЛДӨР ХУУЛЬ ТОГТООМЖ НИЙЦЭЖ БАЙГАА ЭСЭХ БОЛОН ТЭДГЭЭР ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ[116]

УДИРТГАЛ

Засгийн газраас 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-г баталсан. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний 8 дахь хэсгийн 39-д Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйл, уг зүйлийн холбогдох тайлбартай үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зохицуулсан үндэсний хүчин төгөлдөр хууль тогтоомж нийцэж байгаа эсэхэд судалгаа хийхээр төлөвлөсөн.

Уг арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвөөс Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу /цаашид “аргачлал” гэх/ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар зохицуулсан хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад үнэлгээ хийв.

Энэхүү үнэлгээний зорилго нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн тухай зохицуулсан холбогдох хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл, бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэн, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулахад оршино.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл, уг зүйлийн холбогдох тайлбартай үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг зохицуулсан үндэсний хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж нийцэж байгаа эсэхийг аргачлалын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн гурван үе шаттайгаар хийж гүйцэтгэлээ. Төлөвлөх үе шат нь дараах дараалалтай байна. Үүнд:

1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
4. Харьцуулах хэлбэрийг сонгох;
5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох;
6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох;

1.1. Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, түүний нэмэлт протокол (1966)[117]-аас гадна Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1945)[118], Хүний эрхийн тухай Европын конвенц (1950)[119], Америк дундын хүний эрхийн конвенц (1969)[120] зэрэг Олон улсын конвенцоор баталгаажуулж ирсэн.

Мөн 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн (цаашид “Үндсэн хууль” гэх) Арван зургадугаар зүйлийн 16-д “итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй

[116] Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, О.Төрболд нар хамтран гүйцэтгэв.

[117] Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, 19 дүгээр зүйл.

[118] Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 19 дүгээр зүйл.

[119] Хүний эрхийн тухай Европын конвенц, 10 дугаар зүйл.

[120] Америк дундын хүний эрхийн конвенц, 13 дугаар зүйл.

илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.”, 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;”[121] хэмээн тус тус заасан.

Үзэл бодлыг чөлөөт байдлаар бий болгох явдал нь харилцааны үйл явцад хэрэгждэг. Үүний тулд нэг талаас үзэл бодлоо илэрхийлж түгээх эрх чөлөө, нөгөө талаас илэрхийлсэн үзэл бодлыг хүлээж авах буюу мэдээлэл авах эрх чөлөө байх шаардлагатай.[122] Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16 болон 17 дугаар заалтуудад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, түүнийг хүлээж авч өөрийн үзэл бодол, итгэл үнэмшилтэй байх эрхийг хүний үндсэн эрхийн хэмжээнд баталгаажуулж байгаагийн зэрэгцээ мөн харилцааны үйл явцыг Үндсэн хуулиар хамгаалах зорилгыг тавьж байгаа юм. Уг зорилгыг хэрэгжүүлэх чухал үйл явц нь Үндсэн хуульд нийцсэн хуулиудыг Хууль тогтоогчийн зүгээс баталж мөрдүүлэх явдал юм.

ХЭҮК-оос 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрүүдэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 623-н гомдол хүлээн авч шийдвэрлэснээс 6 нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхтэй холбоотой гомдол байна.[123] Дээрх тоон үзүүлэлтийг харвал Монгол Улсад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн зөрчил харьцангуй бага мэт харагдаж байгаа хэдий ч Мэдээллийн эрх чөлөөний төлөөх Хил хязгааргүй сурвалжлагчид олон улсын байгууллагаас гаргасан Хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 2016 онд 180 орноос 60 дугаар байр, 2017 онд 69 дүгээр байр, 2018 онд 71 дүгээр байранд тус тус орж сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол доошилсоор байна.[124] Үүнээс үзвэл үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд анхаарч сайжруулах асуудал байсаар байна.

Иймд энэхүү үнэлгээгээр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн талаар зохицуулсан Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварыг үнэлэхдээ үндэсний хэмжээнд хүчин төгөлдөр үйлчилж буй 685[125] хуулиас шууд холбоотой 38 хууль /хавсралт 3-ийг үзэх/ байгаагаас Монгол Улсын Үндсэн хуулинд заасан “үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” эрхийг хуулийн зорилтоос эхлэн хангахад чиглэсэн байдлыг харгалзан үзэж сонгосон болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээг тогтоох

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэх явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг.

Итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө юм.[126] Иймд үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрхийг хангах хоёр хуулинд хэрэгжилтийн үр дагаварыг тооцох юм. Дээрх судалгааны хүрээнд Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 1, 4 дүгээр зүйл, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1,

[121] Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, 1992 он.

[122] Мориц Лоренц, “ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1-р заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плюрализмын чухал элемент хэмээн үзэх нь” Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас, эргэцүүлэл, 2000 он, №7, 106 дахь тал.

[123] Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан, 18 дахь тал. http://nhrcm.gov.mn/мэдээ/жил-хагас-жилийн-үйл-ажиллагааны-тайлан/

[124] World Press Freedom Index, accessed April 1, 2019, https://rsf.org/en/ranking/2018

[125] https://www.legalinfo.mn/ сүүлд үзсэн 2019.04.22.

[126] ХБНГУ-н Ханнс Зайделийн сан, Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он, 98 дахь тал.

14 дүгээр зүйлийн 1.1-д заасан зохицуулалтыг сонгон авч, тэдгээрийн эерэг, сөрөг талыг судалж, хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхээр судалгааны хүрээг тогтоов.

1.3. Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох

"Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал"-ын дагуу дээрх хуулийн хэрэгжилтийг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

3. Зорилгод хүрсэн түвшин;
4. Практикт нийцэж байгаа байдал;

1.3.1. "Зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д "итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;" 17-д "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;" хэмээн тус тус заасан бөгөөд Үндсэн хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх үүднээс УИХ-аас хууль тогтоомжид тусгасан зүйл, заалт олон байх боловч шууд хангахад чиглэсэн "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай", "Жагсаал цуглаан хийх журмын тухай" хуулийг батлан мөрдүүлж байна. Тухайлбал; Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино." хэмээн заажээ. Үүнээс үзвэл, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн үндсэн зорилт нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг хангаж, баталгаажуулах Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д заасан хүний эрхийг хангахад чиглэсэн болох нь харагдаж байна. Иймд, энэхүү үнэлгээний шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дээр дурдсан зорилтыг хангахтай холбогдуулан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйлд "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно." 3 дугаар зүйлийн 1-д "Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй." 4 дүгээр зүйлд "Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно." гэж заасан зохицуулалтыг сонгож "Зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлгээг хийлээ. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 1. *Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалтууд*

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	2 дугаар зүйл	Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.
2.	3 дугаар зүйл	3.1.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.
3.	4 дүгээр зүйл	Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.

1.3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл

Энэхүү шалгуур үзүүлэлт нь тухайн хууль тогтоомжийн зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа, түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлоход чиглэгддэг.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.” хэмээн заасан байна.

Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг иргэд дийлэнх тохиолдолд төрийн байгууллагын тодорхой шийдвэрийг эсэргүүцэн хэрэгжүүлдэг. Гэтэл уг шийдвэрийг эсэргүүцэн иргэд үзэл бодлоо илэрхийлэн жагсаал, цуглаан хийхдээ тухайн шийдвэрийг гаргадаг байгууллагад мэдэгдэн бүртгүүлдэг. Хэрэв жагсаал, цуглаан хийх талаар бүртгүүлээгүй тохиолдолд зөвшөөрөлгүй хэмээн албадан тараах үйл ажиллагаа явуулдаг. Энэ нь практикт ихээхэн маргаан дагуулдаг байна.

Иймд судалгааны энэ хэсэгт “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 1-д заасан зохицуулалтыг сонгож, уг зүйл, заалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа байдал, түүний эерэг болон сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд гарч буй хүндрэл, бэрхшээл байгаа эсэхийг тодорхойлохыг зорьсон болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 2. *“Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Сонгосон зүйл, заалт	Зүйл, заалтын агуулга
1.	9 дүгээр зүйлийн 9.1	Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.
2.	14 дүгээр зүйлийн 14.1	1. Дараахь тохиолдолд Засаг дарга жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэр гаргана: 1/ энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан бол; 2/ бүртгүүлсэн боловч жагсаал, цуглаан хийх газрыг дур мэдэн өөрчилж, энэ хуулийн 7 дугаар зүйлд хориглосон газарт жагсаал, цуглаан хийж байгаа буюу хийхээр завдсан бол; 3/ энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан байгууллага жагсаал, цуглааныг зохион байгуулсан бол; 4/ жагсаал, цуглааны явцад түүний анхны зорилго өөрчлөгдөж, энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулга, шинжтэй болсон, эсхүл онц болон дайны байдал зарласан буюу гамшиг болон аюул тохиолдсон үед мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад зорилгоор жагсаал, цуглаан хийж байгаа бол; 5/ жагсаал, цуглааныг зохион байгуулагч буюу түүнд оролцогчид энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3,12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ үл биелүүлснээс нийгмийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болсон буюу хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол.

1.4. Харьцуулах хэлбэрийг сонгох

Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ үнэлэх болсон шалтгаан, үнэлгээний хүрээ, шалгуур үзүүлэлт зэргийг харгалзан дор дурдсан харьцуулах хэлбэрүүдээс сонгоно. Үүнд:

- Байх ёстой болон одоо байгаа;
- Хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойших;

- Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойших;

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

Шалгуур үзүүлэлтийг томьёолохдоо сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр дараах таамаглал дэвшүүлж, асуулт боловсруулаа.

Зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 1, 4 дүгээр зүйл зорилгодоо хүрсэн эсэх? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх? Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа эсэх?

Практикт нийцэж байгаа байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 1-д заасан зохицуулалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх? Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль нь бусад хууль тогтоомжтой хэрхэн нийцэж байгаа эсэх?

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор баримт бичиг, судалгааны тайлан, илтгэл, өгүүлэл уншиж, судлах, харьцуулалт хийх зэрэг аргуудыг ашигласан бөгөөд ЗГ-ын 2016 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.7.3-т мэдээлэл цуглуулах дөрвөн аргыг тодорхойлсноос “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон үнэлгээ хийх мэдээллийг цуглуулсан болно.

Байгаа мэдээллийг цуглуулах хүрээнд: Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжоос холбогдох хууль, хэм хэмжээний актыг судлах, холбогдох ном сурах бичиг, гарын авлага, эмхэтгэл, өгүүлэл, илтгэл, эрдэм шинжилгээ, судалгааны тайланг цуглуулж, үнэлгээ хийхэд ашиглав.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх судалгааны мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаанд тулгуурлав.

Баримт бичгийн судалгаа: Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй холбогдох Монгол Улсын хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ дор дурдсан хууль тогтоомж, дүрэм, журам, эрдэмтэн, судлаачдын эрдэм шинжилгээний бүтээлүүд, илтгэл, өгүүлэл, тайланг ашигласан болно. Үүнд:

Монгол Улсын хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, 1992 он.
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №10, 1998 он.
- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №9, 1994 он.
- Олон нийтийн радио, телевизийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №8, 2005 он
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №26, 2011 он.
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №5, 2002 он.
- Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №7, 2016 он.

- Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №36, 2016 он.
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №2, 1994 он.
- Хүүхэд хамгаллын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №9, 2016 он.
- Зөрчлийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №24, 2017 он.
- Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, УИХ-ын 2003 оны 41 дүгээр тогтоол.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай, УИХ-н 2004 оны 26 дугаар тогтоол.
- "НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө" Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоол;

Олон улсын хэм хэмжээ

- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1945 он.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт түүний нэмэлт протокол, 1945 он.
- Хүний эрхийн хорооны үйл ажиллагааны түр журам, 1978 он.
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай Нью-Йоркийн гэрээ, 1953 он.

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Судалгааны тайлангийн эмхэтгэл II боть, 2010-2011он.
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан.

Ном, сурах бичиг, гарын авлага

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Мориц Лоренц, "ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1-р заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плюрализмын чухал элемент хэмээн үзэх нь" Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас эргэцүүлэл, №7, 2000 он.
- Ж.Амарсанаа, "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө", Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас эргэцүүлэл, №7, 2000 он.
- Глоб Интернейшнл ТББ, "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө", Сэтгүүлч ба хууль, №3, 2001 он.
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, "Хүний эрхийн цуврал нийтлэл", 2012 он.
- ХБНГУ-н Ханнс Зайделийн сан Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он.
- О.Мөнхсайхан, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь, Эрх зүй сэтгүүл, №2, 2017 он.
- О.Мөнхсайхан, Жагсаал цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №1, 2018 он.
- Д.Оросоо, Тайван, жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал, Хууль дээдлэх ёс, №3, 2004 он.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.jli.gov.mn

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн хүрээнд, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон Жагсаал, цуглаан хийх эрхийн тухай хуулийн хүрээнд сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийсэн.

3.1. "Зорилгод хүрсэн түвшин" шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байдал

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1 дүгээр зүйлд "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино." хэмээн заасан. Иймд уг хуулийн бүхий л зохицуулалт энэхүү үндсэн зорилтыг хангахад чиглэх учиртай.

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 1, 4 дүгээр зүйл нь зорилтод хүрсэн эсэх? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх?

2 **дугаар зүйл.Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах**
Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.
3 **дугаар зүйл.Мэдээлэлд хяналт тавихыг хориглох**
3.1.Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ. Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй.
4 **дүгээр зүйл.Төрийн байгууллагын мэдээллийн хэрэгслийг хориглох**
Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.

Үнэлгээ:

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 1 дүгээр зүйлд тусгасан зохицуулалтаас үзвэл тус хуулийн зорилт нь Үндсэн хууль болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэрэг баримт бичгүүдэд тусгагдсан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн үндсэн зорилгыг хангахад чиглэсэн болох нь харагдаж байна.

Итгэл үнэмшилтэй байж Үзэл бодлоо илэрхийлэх нь хүний сэтгэл зүй, улс төр, ёс зүйн болон бусад шинжийг илэрхийлсэн процесс юм.[127] Энэ эрх чөлөө нь хүний мөн чанар, оршин байгаатай нь холбогдон гарч ирдэг, төрөөс тогтоодоггүй түүнээс ангид оршдог, хүний төрөлх буюу оюун санааны эрх гэж ойлгож болно. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх, эрх чөлөө нь маш эмзэг, байнга хөндөгдөж байдаг бөгөөд түүнийг маш зөв, соёлтой хэрэглэх, хамгаалах учиртай.[128] Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь:

- Мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар (үг хэлэх);
- Бичгээр буюу хэвлэлээр (хэвлэн нийтлэх);
- Уран сайхны хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Эрж хайх (мэдээлэл авах);
- Хүлээн авах (мэдээлэл хүлээн авах);
- Түгээх;
- Тайван жагсаал, цуглаан хийх;
- Эвлэлдэн нэгдэх;
- Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх;

[127] Ж.Амарсанаа, "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө", Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас, эргэцүүлэл, 2000 он, №7, 103 дахь тал.

[128] Глоб Интернейшнл ТББ, "Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө", Сэтгүүлч ба хууль, 2001 он, №3, 23 дахь тал.

- Ажил хаях;
- Өлсгөлөн зарлах зэрэг багц эрх[129] эрх чөлөөний эх сурвалж, анхдагч суурь эрх юм.

Иргэн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хүрээнд төр, нийгэм, орон нутгийн асуудлыг шийдэх үйл хэрэгт дараах байдлаар оролцож болно. Тухайлбал;

- Оршин буй газрынхаа баг, хорооны иргэдийн нийтийн хурал, олон нийтийн цуглаанд оролцох;
- УИХ-ын гишүүнээр дамжуулан оролцох;
- Олон нийтийн санал асуулга явуулахад оролцох;
- Хуулийн хэлэлцүүлэг, санал шүүмжлэлд оролцох;
- Төрийн бус байгууллагаар дамжуулан оролцох;
- Сонин, хэвлэл, телевизээр үзэл бодлоо илэрхийлэх;
- Төрийн байгууллага, албан тушаалтанд захидал бичих;
- Жагсаал цуглаанд оролцох;
- Өөрсдийн саналаа өргөн барих;
- Олон нийтэд хандаж үг хэлэх[130] зэргээр бодлого боловсруулах бүх шатны үйл ажиллагаанд оролцож болно.

Гэвч үзэл бодлоо илэрхийлэх эрх нь дээр дурдсан эрхээр хязгаарлагдахгүй, учир нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийн 2-д хүн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй гэж заасан байна. Үүнээс үзвэл "хэвлэл мэдээллийн эрх чөлөө" нь үзэл бодлоо илэрхийлэх эрхийн дээр заасан аргуудаас "Сонин, хэвлэл, телевизээр үзэл бодлоо илэрхийлэх" гэсэн зөвхөн нэг л үндсэн арга болох юм.

Мэдээллийн эрх чөлөө гэдгийг мэдээлэл ил тод, нээлттэй байх, хүн бүр мэдээллийг чөлөөтэй олж хүртэх боломж, баталгаа хангагдсан байхыг ойлгодог. Хүн бүр мэдээллийн эрх чөлөөг эдлэх эрхтэй. Энэхүү эрх чөлөөг эдлэхэд тодорхой арга, хэрэгсэл хэрэгтэй. Эдгээр арга, хэрэгсэл нь хүний эрх гэсэн категориор тодорхойлогдож байдаг. Аливаа мэдээлэл нь мэдээллийн харилцаанд оролцогч субъектын тодорхой үйлдэл, үйл ажиллагаагаар дамжиж олон нийтэд хүрч, нийгмийн оюун санааны эрэлт хэрэгцээг хангаж байдаг. Энэ үйл ажиллагаа нь гурван үе шаттай байна.[131] Үүнд:

- Нэг дэх шат: Мэдээлэл хайх эрх /freedom to seek/
- Хоёр дахь шат: Мэдээлэл олж авах /freedom to recieve/
- Гурав дахь шат: Мэдээлэл тараах, түгээх /freedom to impart information/

Мэдээллийг хайх, олж авах, түгээх үе шат нь бие биетэйгээ нягт уялдаа холбоотой үйл явц бөгөөд энэхүү үйл явц, үе шатыг дамжиж мэдээлэл олон нийтэд хүрч нийтийн хүртээл болдог. Мэдээлэл хайх, олж авах, түгээх үйл явцыг хүний үндсэн эрхийн үүднээс олон улсын болон үндэсний хууль тогтоомжийн хүрээнд хүний үндсэн эрх болохыг хуульчлан тогтоожээ. Эдгээр нь мэдээллийн эрх чөлөөг эдлэх гол арга хэрэгсэл болдог.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах үүднээс УИХ-аас 1998 онд баталсан "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай" хуулийн 2 дугаар зүйлд хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг, 3 дугаар зүйлд төрөөс олон нийтийн мэдээллийн агуулагад

[129] Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.

[130] Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, "Хүний эрхийн цуврал нийтлэл", 2012 он, 54 дэх тал.

[131] Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.

хяналт /цензур/ тавихыг, 4 дүгээр зүйлд төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг тус тус хориглож хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийн төлөө хариуцлага хүлээлгэхээр заасан байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагаатай шууд холбогдох эрх зүйн актуудыг судалж үзэхэд хууль 44 /хавсралт 1-ийг үзэх/, Олон улсын гэрээ 4 , УИХ-ын тогтоол 6, Улсын дээд шүүхийн тайлбар 14 байлаа. Эдгээр актыг судлах явцад зарим алдаа дутагдалтай хийгдэх ёстой ажиллагаа хийгдээгүй үр дүн нь гараагүй байгаа нь ажиглагдаж байна. Тухайлбал, 2005 онд баталсан Олон нийтийн радио телевизийн тухай хуулиар төрийн мэдэлд байсан үндэсний хэмжээний радио, телевизийг “олон нийтийн” болгон өөрчилж, 2011 онд баталсан Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрх чөлөөний тухай хуулиар төрийн байгууллагаас олон нийтийн ашиг сонирхолд хамаарах мэдээлэл авах иргэдийн эрхийг баталгаажуулсан.

Мөн 2015 онд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар гүтгэх, доромжлох асуудлыг тус хуулиар бус, Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээр болсон гэх мэт хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хэрэгжүүлэх эерэг эрх зүйн орчин бүрдсэн хэдий ч цаашид анхаарах асуудал байсаар байна.

Монгол Улсад олон жил Эрүүгийн хуулиар гүтгэлэг, доромжлолыг гэмт хэрэгт тооцож ял шийтгэж ирсэн байдаг. 2015 оны шинэчилэн найруулсан Эрүүгийн хуулиас халсан нь үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөг хамгаалахад чухал нөлөөлсөн хэдий ч 2017 оны Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 21 дүгээр зүйлд “1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” хэмээн хуульчилж өгсөн бөгөөд ажил хэргийн нэр хүнд гэх ойлголтыг оруулж өгсөн нь зөрчлийн хүрээг өргөжүүлсэн зохицуулалт болсон.

Ингэснээр албан тушаалтнууд гүтгэх, доромжлох гэмт хэрэгтэй адилхан гүтгэх зөрчлийг өөрсдийн эсрэг эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөө шүүмжийг хааж бооход ашиглах эрсдэл хэвээр байна. Мөн Зөрчлийн хуулиар гүтгэсэн гэж их хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэх боломж нь үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөг эдлэхэд айдас төрүүлдэг. Их хэмжээний торгууль төлөх айдас нь нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлыг хэвлэх, мэдээлэхээс хэвлэлийнхэн татгалзахад хүргэнэ.[132] гэж үздэг байна.

УИХ-аас 2003 оны 41 дүгээр тогтоолоор Монгол Улсад хүний эрхийг хангах Үндэсний хөтөлбөр батлагдсан бөгөөд уг хөтөлбөрт “Нууц хамгаалах хуулиудаар тогтоосон илүүц хязгаарлалтыг арилгах зэргээр төрийн хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны ил тод байдлыг хангаж, энэ талаар иргэд, хэвлэл мэдээллийн ажилтны хүсэлт шаардлагаар мэдээлэл гаргаж өгөх үүрэг, хариуцлага иргэдээс мэдээлэл олж авах түгээх эрхийг нь нарийвчлан тодорхойлсон хууль, эрх зүйн үндсийг бүрдүүлнэ”, “Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг дэмжин төрийн болон орон нутгийн өмчид байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг зах зээлийн харилцаанд нийцүүлэн бие даасан байдлыг бэхжүүлэх зохион байгуулалт эрх зүйн арга хэмжээг авна”, “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбогдох хууль тогтоомжид судалгаа хийж, зөрчилтэй зүйл, заалтыг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах зэргээр хууль тогтоомжийг боловсронгуй болгоно”, “Мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчдийн эрх, үүргийг хуулиар баталгаажуулж, иргэд хэвлэл мэдээллийн хэрэгслийн ажилтан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхээ эдлэхдээ хүний нэр, нэр төр, алдар хүндийн халдашгүй байх эрхийг зөрчихөөс сэргийлэх, зөрчигдсөн

[132] О.Мөнхсайхан, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь, Эрх зүй сэтгүүл, 2017 он, №2, 25 дахь тал

Хуулийн үндэсний хүрээлэн www.ulii.gov.mn

эрхийг нь бүрэн сэргээх эрх зүйн механизмыг тодотгон сайжруулна” зэрэг ажлыг гүйцэтгэхээр тусгасан боловч дээрх ажлын хүрээнд хийгдэх зарим арга хэмжээнүүд төдийлөн хэрэгжээгүй байгаа нь энэ талаарх хийгдсэн судалгаа болон тайлан мэдээнүүдээс харагдаж байна.[133]

УИХ-аас 2004 оны 26 дугаар тогтоолоор Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай тогтоол гаргасан бөгөөд уг тогтоолоор “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг судлан боловсруулж шийдвэрлэнэ” гэж заасан ч хэрэгжээгүй байна.

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь өөрөө тунхгийн шинжтэй учир хуулийн зүйл заалтууд нь өөр бусад хуультай зөрчилдсөн гэж үзэж болохоор 5 хууль байна. Үүнд:

Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2-д “Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна.”, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд “Хот сонин, радио, телевизтэй байж болно” гэж тус тус заасан байгаа нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1-д “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно.” гэсэн заалттай зөрчилдөж байна. Өөрөөр хэлбэл, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд заасны дагуу төрийн байгууллагад харьяалагдах хэвлэл мэдээллийн байгууллага байх ёсгүй юм.

Мөн 2005 онд батлагдсан Олон нийтийн, радио телевизийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4-д “Олон нийтийн радио, телевиз хэвлэл, мэдээллийн бусад байгууллагын мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийг дамжуулж байгаа бол эх сурвалжийг заавал дурдана.” гэж заасан нь мэдээллийн эх сурвалжаа нууцлан хамгаалах сэтгүүлчдийн эрх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хаасан зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.

Түүнчлэн 2016 онд батлагдсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4-д “Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” хэмээн заасан бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна.

3.2. “Практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Шалгуур үзүүлэлтийн томьёолол 1. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, 14 дүгээр зүйлийн 1-д заасан зохицуулалтууд практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл тулгарч байгаа эсэх? Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль нь бусад хууль тогтоомж хэм, хэмжээний акттай хэрхэн нийцэж байгаа эсэх?

[133] Мэдээллийн эрх чөлөөний төлөөх Хил хязгааргүй сурвалжлагчид, Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний эрх зүйн орчин судалгаа, https://mongolia.mom-rsf.org/mn/translation-context/translation-law/

9 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан хийх журам

1. Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.

14 дүгээр зүйл. Жагсаал, цуглааныг албадан тараах

1. Дараах тохиолдолд Засаг дарга жагсаал, цуглааныг албадан тараах шийдвэр гаргана:

1/ энэ хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу бүртгүүлэлгүйгээр жагсаал, цуглаан зохион байгуулсан бол;

2/ бүртгүүлсэн боловч жагсаал, цуглаан хийх газрыг дур мэдэн өөрчилж, энэ хуулийн 7 дугаар зүйлд хориглосон газарт жагсаал, цуглаан хийж байгаа буюу хийхээр завдсан бол;

3/ энэ хуулийн 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан байгууллага жагсаал, цуглааныг зохион байгуулсан бол;

4/ жагсаал, цуглааны явцад түүний анхны зорилго өөрчлөгдөж, энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан агуулга, шинжтэй болсон, эсхүл онц болон дайны байдал зарласан буюу гамшиг болон аюул тохиолдсон үед мөн зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад зорилгоор жагсаал, цуглаан хийж байгаа бол;

5/ жагсаал, цуглааныг зохион байгуулагч буюу түүнд оролцогчид энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 3,12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан үүргээ үл биелүүлснээс нийгмийн хэв журам алдагдаж, эмх замбараагүй байдал бий болсон буюу хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учирсан бол.

Үнэлгээ:

Тайван жагсаал, цуглаан хийх эрх нь дараах хэм хэмжээгээр баталгаажсан байдаг. Үүнд:

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд “Хүн бүр өөрийн үзэл бодолтой байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэхүү эрхэнд үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрх чөлөө, үзэл санаа, мэдээллийг улсын хилийн заагаар үл хязгаарлан аливаа арга замаар эрж сурвалжлах, хүлээж авах, түгээн дэлгэрүүлэх эрх чөлөө багтана.”, 20 дугаар зүйлийн 1-д “Хүн бүр чөлөөтэй, тайван хуран цуглах, эвлэлдэн нэгдэх эрхтэй.” хэмээн тус тус заасан байна.

Өөрөөр хэлбэл, тус тунхаглалын 19 дүгээр зүйлд тусгасан зохицуулалт нь нэгдүгээрт хүн бүр үзэл бодлоо ямар ч хорио саадгүй баримтлах эрхтэй, хоёрдугаарт хүн бүр санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй; энэ эрхэнд төрөл бүрийн мэдээлэл болон үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар, бичгээр эсхүл хэвлэлийн буюу уран сайхны аргаар эсхүл өөрийн сонгосон бусад аргаар эрж хайх, хүлээн авах, түгээх эрх чөлөө багтах бол 20 дугаар зүйлд тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрч, энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эсхүл бусдын эрх, эрх чөлөөг хамгаалах эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй хэмээн олон улсын хэмжээнд баталгаажуулсан бол Үндэсний хэмжээнд Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д *“Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.”* хэмээн хуульчилан баталгаажуулсан байна.

Хуулийн үндэсний сүлжээ www.nli.gov.mn

Дээр дурдсанчлан[134] жагсаал цуглаан хийх эрх чөлөө нь Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний үндсэн аргын нэг юм. Учир нь улс төр, нийгэм, эдийн засгийн тодорхой асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд иргэн ганцаараа үзэл бодлоо илэрхийлбэл тийм ч үр дүнтэй биш бөгөөд хамтаараа цуглаад үзэл бодлоо илэрхийлбэл үр дүнд хүрэх магадлал нь нэмэгдэнэ. Өөрөөр хэлбэл, жагсаал, цуглаан нь хүмүүст дуу хоолойгоо хүчтэй илэрхийлэх боломж олгодог, олон нийтийн анхаарлыг илүү татдаг төдийгүй хэвлэл мэдээллийн хэрэгслийг ч татан оруулж чаддагаараа аливаа шийдвэр гаргалтад илүү нөлөөлөл үзүүлдэг гэж хэлж болно.

Цуглаан нь мөн улс төрийн намын гол үйл ажиллагааны нэг бөгөөд хүмүүсийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлэхийг зөвшөөрөхгүйгээр ардчилсан сонгууль явагдах боломжгүй. Мөн, цуглааны үеэр хүмүүс өөрсдийн итгэл үнэмшил, шашин шүтлэг үзэл бодлыг илэрхийлдэг учраас энэ эрх чөлөө нь итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй хамт хэрэгждэг.[135] Энэ ч үүднээс үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөө болон тайван, жагсаал цуглаан хийх эрх нь нэг нь нөгөөгүйгээр хэрэгжих боломжгүй хоорондоо нягт уялдаа холбоотой байдгаараа онцлог юм. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх гол арга болох тайван жагсаал, хийх эрхийг дотор нь:

1. Тайван жагсаал, цуглааныг санаачлах эрх;
2. Тайван жагсаал цуглааныг зохион байгуулах эрх;
3. Тайван жагсаал цуглаанд оролцох эрх гэж гурав ангилан авч үзэж болдог байна.[136]

Жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хангах үүднээс УИХ-аас 1994 оны 7 дугаар сарын 7-ны өдөр "Жагсаал цуглаан хийх журмын тухай" хуулийг баталсан. Уг хууль нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 16-д заасан хүний үндсэн эрх хэрэгжих чухал баримт бичгийн нэг болсон бөгөөд анх батлагдахдаа жагсаал, цуглаан зохион байгуулахдаа Засаг даргаас "зөвшөөрөл" авдаг байсан бол 2005 онд энэ хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж "зөвшөөрөл" гэдэг үгийг өөрчилж "мэдэгдэл" болгосон. Мэдэгдлийг бүртгүүлсний үндсэн дээр жагсаал, цуглаан зохион байгуулах нь үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулах, нийгмийн дэг журмыг алдагдуулах, хүн амын эрүүл мэндийг хохироох, бусдын эрх чөлөөнд халдах аюултай байдлаас сэргийлэх зорилготой хэдий ч дээрх зохицуулалт нь зайлшгүй шаардлагатай тохирсон эсэх нь эргэлзээтэй байна. Тухайлбал: Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д "Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ." хэмээн заасан бөгөөд Засаг дарга мэдэгдлийг хүлээж авсан эсэхээ ажлын 3-н өдрийн дотор бичгээр мэдэгдэх үүрэгтэйгээр зохицуулсан.

Мэдэгдэлийн тогтолцоо нь нэг талаас Засаг даргад мэдэгдсэн тэр өдрөө л жагсаал, цуглаан хийж болдог. Нөгөө талаас жагсах, цуглах эрхээ эдэлж байгаа хүмүүс рүү бусад иргэд болоод байгууллагаас халдаж, саад учруулахаас сэргийлэх. Мөн жагсаж, цуглаж буй иргэд эмх замбараагүй байдал бий болгож бусдын эд хөрөнгө, эрүүл мэндэд хохирол учруулах юм бол таслан зогсооход бэлэн байна. Ийм учраас мэдэгдэх ёстой байдаг. Үүнийг мэдэгдлийн тогтолцоо гэх бөгөөд Энэ нь өөрөө нийгмийн дэг журам, үндэсний аюулгүй байдал зэрэг ашиг сонирхлуудыг зайлшгүй хамгаалахад зориулагдсан тогтолцоо юм.[137]

[134] Энэ талаар судалгааны 5 дахь талд дурдаж өгсөн.

[135] О.Мөнхсайхан, Жагсаал цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт, Шүүх эрх мэдэл сэтгүүл, 2018 он, №1, 15 дахь тал.

[136] Д.Оросоо, Тайван, жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал, Хууль дээдлэх ёс, 2004 он, №3, 41 дахь тал.

[137] О.Мөнхсайхан, Иргэдийн жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг Засаг даргын үзэмжээр хааж, боож байна, /ярилцлага/, https://ikon.mn/n/z1y сүүлд үзсэн 2019.04.19

Гэтэл дээрх хуулийн заалт дахь мэдэгдлийг бүртгэх үүрэг бүхий субъект болох Засаг даргыг Төрийн албаны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 9-д төрийн улс төрийн албан хаагч байна гэж хуульчилсан. Иймд тодорхой нэг улс төрийн үзэл суртал зэргээс үүдэн Засаг дарга жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэхгүй байх удаашрах зэрэг нөхцөл байдал үүсэх боломжтой харагдаж байна.

Энэ талаар жишээ дурдвал, Захиргааны хэргийн анхан шатны шүүх 2017 оны 05 дугаар сарын 26-ны өдөр нэхэмжлэгч Д.Ариун-Адъяа, Я.Мөнхбат, Ц.Ууган, Д.Хатансэлэнгэ нарийн нэхэмжлэлтэй Сонгино хайрхан дүүргийн Засаг даргад холбогдох хэргийг хянан хэлэлцэж 406 дугаартай шийдвэр гаргасан бөгөөд дээрх шийдвэрийн агуулга нь Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын жагсаал, цуглааныг бүртгэхгүй байгаа эс үйлдэхүйг хууль бус хэмээн бүртгэхийг даалган шийдвэрлэсэн байна.[138]

Үүнээс гадна практикт Засаг дарга хуульд заагаагүй үндэслэлээр мэдэгдлийг бүртгэхээс татгалзах тохиолдол гардаг байна. Жишээ нь: 2006 онд "Эрүүл нийгэм" иргэний хөдөлгөөнөөс жагсаал, цуглаан хийх мэдэгдэл өгөхөд Засаг дарга "Өөр үйл ажиллагаатай давхацсан, автомашины хөдөлгөөнд саад учруулна, иргэдийг бухимдуулна" гэсэн шалтгаан хэлж, татгалзсан байна.[139]

Иймд дээрх хуулийн зохицуулалтаас үүдэн иргэний үзэл бодлыг Засаг дарга хянаж жагсаал, цуглаан хийх мэдэгдлийг бүртгэх эсхүл бүртгэхгүй байх эрх зүйн орчин бүрдсэн байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

4.1. ДҮГНЭЛТ

Үнэлгээний ажилд сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд заасан эрхийг хангахад үндэсний хууль тогтоомж хэрхэн нийцэж байгааг судлан дүгнэлт хийж, зөвлөмж боловсруулаа.

Олон улсын гэрээ болон Үндсэн хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх үүднээс УИХ-аас хууль тогтоомжид тусгасан зүйл, заалт байх боловч шууд хангахад чиглэсэн нь "Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай", "Жагсаал цуглаан хийх журмын тухай" хууль байна. Итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөөг хангах үндэсний хууль тогтоомжийн гол төлөөлөл болох дээрх хоёр хуулийн хэрэгжилтэд зорилгод хүрсэн түвшин, практикт нийцэж байгаа байдлыг тодорхойлон үзлээ.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлд заасан эрхийг хангах болон Үндсэн хуулиар заасан зорилгыг хангахад Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль болон Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн зорилт хангасан байх боловч хуулиудын зүйл заалт, бусад хуультай нийцэхгүй, хууль хэрэгжихгүй байх тохиолдол үүссээр байна. Тухайлбал: УИХ-аас 1998 онд баталсан Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 2 дугаар зүйлд "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон". Мөн 3 дугаар зүйлд "төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ" гэж заасан ба 4 дүгээр зүйлд "Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно" гэж заасан. Гэсэн хэдий ч орон нутгийн засаг, захиргаа, хот, өөрийн харьяаны мэдээллийн хэрэгсэлтэй байна. Мөн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгтэй холбоотойгоор сэтгүүлчид эх сурвалжаа

[138] http://new.shuukh.mn/zahirgaaanhan/3138/view сүүлд үзсэн 2019.04.19

[139] О.Мөнхсайхан, Иргэдийн жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг Засаг даргын үзэмжээр хааж, боож байна, /ярилцлага/, https://ikon.mn/n/z1y

нууцлах эрхгүй болсон.

Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно." хэмээн хэт өргөн хүрээнд зааснаараа улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнуудад өөрсдийгөө хамгаалах хэрэгсэл болгон ашиглах, сэтгүүлчдийг янз бүрийн хэлбэрээр шүүхэд дуудах асуудал гардаг.

Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д "Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Ингэснээр Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ." хэмээн зааснаас үзвэл мэдэгдлийн тогтолцоо бус 1994 онд анх хууль батлагдахад тусгагдсан зөвшөөрлийн тогтолцоо одоо хүртэл хэрэгжиж байгаа нь практикт нийцэхгүй байдлыг үүсгээд байна.

4.2. ЗӨВЛӨМЖ

1. Мэдээллийн эх сурвалжийг нууцлах, хамгаалах талаар тодорхой тусгасан заалт хуульд байхгүй байна. Эдгээрийг хуульчлаагүйн улмаас сэтгүүлчдэд дарамт шахалт, хавчлага учруулах явдал тохиолддог аж. Иймд мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчийн эх сурвалжаа нууцлах, сэтгүүлчийн аюулгүй байдлыг хангах талаар хуульчлах;
2. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хэвлэл мэдээллийн хэрэгсэл өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ" гэсэн заалтыг "байгууллага биш, гэм буруутай нь тогтоогдсон албан тушаалтан, субьект хүлээнэ" гэж өөрчлөх. Зохиогчийн өгсөн буюу сурвалжлагчийн нэртэй түгээж байгаа мэдээллээс бусад бүх мэдээллийн хариуцлагыг редакци хариуцах нь зүйтэй юм.
3. Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан "мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан" гэх зохицуулалт ерөнхий байгаагаас үзэл бодлоо илэрхийлсний төлөө сэтгүүлчдийг янз бүрийн хэлбэрээр шүүхэд дуудаж байгаа энэхүү гүтгэлэг, доромжлолтой холбоотой заалтыг энэ хууль болон Эрүүгийн хуулиас хасах. Иргэний хуулиар зохицуулагдсан харилцааг давхардуулан зохицуулах шаардлагагүй юм.
4. Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нь үндэсний хэмжээнд иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах гол зохицуулалт бүхий хууль болохын хувьд сайжруулах шаардлагатай буюу бусад хуультай зөрчилдсөн байна. Тухайлбал: Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, <u>хэвлэл мэдээллийн байгууллагатай</u> байна.", Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд "Хот сонин, радио, телевизтэй байж болно" гэж тус тус заасан нь Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй байх тул дээрх заалтуудыг тус хуулиудаас хасах. Мөн хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль хэт ерөнхий зохицуулалттай тунхагийн шинжтэй хэрэгжих боломжгүй нөхцөл

байдал үүсч байгаа тул цаашид нарийвчлан зохицуулах;

5. Жагсаал цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1-д “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдлийг сум, дүүргийн Засаг даргад өгч бүртгүүлнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол мэдэгдлийг аймаг, нийслэлийн Засаг даргад өгч бүртгүүлнэ.” гэж заасныг “Гудамж, талбайд жагсаал, цуглаан хийх тухай сум, дүүргийн Засаг даргад мэдэгдэнэ. Жагсаал, цуглаан хийхээр төлөвлөсөн гудамж, талбай нь хоёр буюу түүнээс дээш сум, дүүргийн хилийн цэст хамаарах газар нутгийг хамарч байгаа бол аймаг, нийслэлийн Засаг даргад мэдэгдэнэ” гэж өөрчлөн найруулах нь зүйтэй юм.

НОМ ЗҮЙ

Олон улсын хэм хэмжээ, Хууль, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль /1992/
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал /1945/
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт түүний нэмэлт протокол, /1945 он/
- Хүний эрхийн хорооны үйл ажиллагааны түр журам /1978/
- Эмэгтэйчүүдийн улс төрийн эрхийн тухай Нью-Йоркийн гэрээ /1953/
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль /1998/
- Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль /1994/
- Олон нийтийн радио, телевизийн тухай /2005/
- Мэдээллийн ил тод байдал, ба мэдээлэл авах эрхийн тухай /2011/
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай /2011/
- Эрүүгийн хууль /2002/
- Эрүүгийн хууль /2016/
- Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль /2016/
- Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль /1994/
- Хүүхэд хамгааллын тухай хууль /2016/
- Зөрчлийн тухай хууль /2017/
- Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр, УИХ-н 2003 оны 41 дүгээр тогтоол.
- Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2005 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай, УИХ-н 2004 оны 26 дугаар тогтоол.
- “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө” Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоол;

Судалгааны тайлан, эмхэтгэл

- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Судалгааны тайлангийн эмхэтгэл II боть, 2010-2011
- Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

Ном, сурах бичиг, гарын авлага

- Сургагч багш нарт зориулсан гарын авлага, ХЗДХЯ, УБ., 2017 он.
- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он.

Эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

- Мориц Лоренц, “ХБНГУ-ын Үндсэн хуулийн 5.1.1-р заалтад тодорхойлсон үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг ардчилал ба плюрализмын чухал элемент хэмээн үзэх нь” Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас эргэцүүлэл, №7, 2000 он,
- Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас эргэцүүлэл, №7, 2000 он.
- Глоб Интернейшнл ТББ, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Сэтгүүлч ба хууль, №3, 2001 он.
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, “Хүний эрхийн цуврал нийтлэл”, 2012 он.
- ХБНГУ-н Ханнс Зайделийн сан Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он.
- О.Мөнхсайхан, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь, Эрх зүй сэтгүүл, №2, 2017 он.
- О.Мөнхсайхан, Жагсаал цуглаан хийх эрх чөлөө, түүний хэрэгжилт, Шүүх эрх мэдэл сэтгүүл, №1, 2018 он.
- Д.Оросоо, Тайван, жагсаал, цуглаан хийх эрх, түүний эрх зүйн үндсийг шинэтгэх асуудал, Хууль дээдлэх ёс, №3, 2004 он.

Бусад эх сурвалж

- www.shuukh.mn, Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан
- www.legalinfo.mn, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
- https://rsf.org/en/ranking/2018, Хил хязгааргүй сурвалжлагчид олон улсын байгууллагын цахим сан,
- www.nhrcm.gov.mn, Монголын Хүний эрхийн үндэсний комисс цахим сан
- http://www.globeinter.org.mn, Глоб интернэшнл ТББ-ын цахим сан
- www.legaldata.mn, Хууль зүйн судалгааны бүтээлийн цахим сан

Хуулийн үндэсний хүрээлэн www.nlrc.gov.mn

Хавсралт 1

Хэвлэл мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой хууль

№	Хууль	Батлагдсан огноо	Холбогдох зүйл, заалт
1	Авлигын эсрэг хууль	2006-07-06	5.1.6.хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.
2	Ард нийтийн санал асуулгын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2016-02-05	16.5.Санал асуулга явуулах ажиллагаанд ажиглагч болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгч байлцаж болно.
3	Архивын тухай хууль	1998-01-02	25.3.Архивын баримтыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр архив өөрөө санаачлан сурталчилж болно.
4	Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/	2000-01-28	9.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.
5	Ашигт малтмалын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2006-07-08	17.4.Энэ хуулийн 17.3-т заасны дагуу Засгийн газраас баталсан талбайн солбицлын хүрээнд төрийн захиргааны байгууллага хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялгаж, сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.
6	Байгаль орчныг хамгаалах тухай хууль	1995-03-30	3/хэвлэл, мэдээллийн хэрэгслээр экологийн мэдлэг, байгаль орчныг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомж сурталчлах.
7	Банкны тухай /шинэчилсэн найруулга/	2010-01-18	38.1.Банк нь энэ хуулийн 37.2-т заасан шаардлагыг хангасан улирлын санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын дотор, аудитаар баталгаажуулсан жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 1 дүгээр улиралд багтаан нийтэд хэвлэлээр мэдээлж байна.
8	Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай /шинэчилсэн найруулга/	2010-06-10	3.1.14.“албан ёсны тогтмол хэвлэл” гэж энэ хуульд заасан барааны тэмдэг, газар зүйн заалтын бүртгэлийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нийтийн хүртээл болгох зорилгоор Парисын конвенцийн 12.2-т заасны дагуу оюуны өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрхлэн гаргах хэвлэл болон вэб хуудас, цахим мэдээллийг;
9	Боловсролын тухай	2002-05-03	42.2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага өөрийн харьяа хэвлэл, мэдээлэл, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хичээлийн хэрэглэгдэхүүнийг засварлах, үйлдвэрлэх, хангах зэрэг үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нэгжтэй байж болно.
10	Гаалийн тариф, гаалийн татварын тухай	2008-05-20	20.2.3.барааны төрөлжсөн биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, зах зээлд зонхилох экспортлогчдын гэрээ, түүний үнэ.
11	Гаалийн тухай /шинэчилсэн найруулга/	2008-05-20	29.1.Гаалийн хилээр нэвтрүүлэх дор дурдсан барааанд гаалийн тургэвчилсэн бүрдүүлэлтийг хийж болно: 29.1.5.сонин, тогтмол хэвлэл, мэдээллийн болон эрдэм шинжилгээ, судалгааны материал;

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛЛИЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ

12	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль / шинэчилсэн найруулга/	2010-07-08	5.1.6.“албан хэргээр оршин суугч” гэж төрийн байгууллагын урилгаар болон Монгол Улсад суугаа гадаад улсын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, Засгийн газар хоорондын эрх бүхий байгууллага, НҮБ, түүний төрөлжсөн байгууллагын суурин төлөөлөгчийн газар, түүнчлэн гадаад улсын болон олон улсын хэвлэл, мэдээллийн төлөөлөгчийн газарт ажиллахаар Монгол Улсад 90 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүнийг;
13	Газрын тосны тухай / шинэчилсэн найруулга/	2014-07-01	19.2.Төрийн захиргааны байгууллага хайгуулын талбайд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байгаа талаарх мэдээллийг өөрийн цахим хуудас болон өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр гурваас доошгүй удаа зарлана.
14	Галын аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/	2015-07-02	7.3.Хэвлэл мэдээллийн байгууллага гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөөг олон нийтэд үнэ төлбөргүй хүргэнэ.
15	Гамшгаас хамгаалах тухай / шинэчилсэн найруулга/	2017-02-02	10.5.Харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага нь өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын үед гамшиг тай холбоотой мэдээ, мэдээллийг дараалал харгалзахгүй хүлээн авч дамжуулна.
16	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	1997-12-05	**11 дүгээр зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хүлээх үүрэг**
17	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/	2016-12-22	7.2.Гэр бүлийн хүчирхийллийг сурталчилсан, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.
18	Гэрээт харуул хамгаалалтын тухай	2000-01-20	9.1.3.үйлчлүүлэгчийн зөвшөөрөлгүйгээр тэдгээрийн тухай аливаа мэдээллийг иргэн, хуулийн этгээд, хэвлэл, мэдээллийн байгууллагад өгөх;
19	Дайчилгааны тухай	1998-05-15	4.5.Улсын дайчилгаа явуулахад дараах үндсэн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ: 4.5.8.хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах;
20	Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль	2011-02-02	18.3.10.жендерийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлого, хууль тогтоомжийг аж ахуйн нэгж, байгууллага, олон нийтэд таниулах, сурталчлах үйл ажиллагааг хэвлэл мэдээлэл, олон нийтийн болон хувийн хэвшлийн байгууллагатай хамтран зохион байгуулах, жендерийн эрх тэгш байдлыг хангах ажлын үр дүнгийн тухай мэдээлэх;
21	Залуучуудийн хөгжлийг дэмжих тухай	2017-05-08	8.1.5.залуучуудын хөгжлийг дэмжсэн хөтөлбөрийг хэвлэл мэдээллийн байгууллагын нийтлэл, нэвтрүүлгийн агуулга, хөтөлбөрт тусгах;
22	Зар сурталчилгааны тухай	2002-05-30	3.1.1.”зар сурталчилгаа” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас бараа, ажил, үйлчилгээ, төсөл, үйл ажиллагаа /цаашид “бүтээгдэхүүн” гэх/-ны зах зээлийн эрэлтийг нэмэгдүүлэх, боломжит хэрэглэгчийн анхаарлыг татах зорилгоор олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад хэлбэрээр түгээсэн мэдээллийг;
23	Захиргааны ерөнхий хууль	2015-06-19	5.1.Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно: 5.1.4.үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа;

24	Зөрчлийн тухай /шинэчилсэн найруулга/	2017-05-11	**5.12 дугаар зүйл.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих** 3.Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. **5.18 дугаар зүйл.Онц байдлын тухай хууль зөрчих** 3.Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд тогтоосон хяналтын журам зөрчсөн, эсхүл үйл ажиллагааг нь түр зогсоосон тогтмол хэвлэлийг хэвлэлд бэлтгэсэн, үйлдвэрлэсэн, тараасан, худалдсан, борлуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. **6.18 дугаар зүйл.Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль зөрчих** 1.Зөвшөөрөлгүйгээр хэвлэл, ном, зохиол, зураг, кино, дүрс бичлэг бэлтгэх, тараах, борлуулах замаар олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 2.Зөвшөөрөлгүйгээр хэвлэл, ном, зохиол, зураг, кино, дүрс бичлэг бэлтгэх, тараах, борлуулах зорилгоор улсын хилээр оруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 5.Эротик хэвлэл, ном зохиол, дүрс бичлэгийг худалдах журам зөрчсөн, эсхүл хуульд заасан эротик кино, дүрс бичлэг, жүжиг, бүжиг үзүүлэхэд хориглох зүйлийг зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 6.5.Монгол Улсын стандартын шаардлага хангасан кассын машин хэвлэх төхөөрөмж, хэвлэлийн хор, тасалбарын цаас, пос терминал машин хэрэглэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. **6.21 дүгээр зүйл.Гүтгэх** 1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
25	Хог хаягдлын тухай хууль / шинэчилсэн найруулга/	2017-05-12	42.2.3.хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хог хаягдлын талаархи үндэсний уламжлал, зан заншил, тэргүүн туршлага, хууль тогтоомжийг сурталчлах;
26	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай	1993-12-20	**34 дүгээр зүйл. Хотын хэвлэл, мэдээлэл** Хот сонин, сэтгүүл, радио, телевизтэй байж болно.
27	Хөрөнгө оруулалтын тухай	2013-10-03	21.1.Дараах салбарт үйл ажиллагаа эрхлэх Монгол Улсын хуулийн этгээдийн нийт гаргасан хувьцааны 33 буюу түүнээс дээш хувийг гадаадын төрийн өмчит хуулийн этгээд эзэмших тохиолдолд зөвшөөрөл авна: 21.1.3.хэвлэл, мэдээлэл, харилцаа холбоо.
28	Хүн худалдаалахтай тэмцэх тухай	2012-01-19	10.1.Хохирогчийн өөрийн болон эцэг, эхийн нэр, оршин суугаа газрын хаяг, хувийн байдалтай нь холбоотой бусад мэдээллийг нууцлах ба эдгээр мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүй хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, түгээх, бусдад тараах, хохирогчийн нүүр царай, дуу хоолойг бусдад танигдахуйц байдлаар түгээхийг хориглоно.

29	Хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх тухай /шинэчилсэн найруулга/	2012-12-13	13.1.Хэвлэл мэдээллийн байгууллага, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж нь хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдолоос сэргийлэх талаар зохиох сургалт, сурталчилгааны ажилд оролцоно.
30	Хүүхэд хамгааллын тухай	2016-02-05	8.4.Сонин хэвлэл, телевиз, радио, цахим сүлжээ ашиглаж, хүүхдийн хувийн нууцад халдаж дуу, дуу-дүрсний, дүрсний бичвэр, гэрэл зураг тараасан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдсэн гэж мэдээлсэн, олны өмнө гутаасан ажилтан, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.
31	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль	1998-08-28	Бүхэлдээ
32	Эм, эмнэлэгийн хэрэгслийн тухай /шинэчилсэн найруулга/	2010-05-27	27.1.Жоргүй олгох эм, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг мэргэжлийн хэвлэл болон олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилж болно. 27.4.Эмийн зар сурталчилгаанд Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас гадна дараахь зүйлийг хориглоно: 27.4.1.эмийг импортлох, худалдах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;
33	Монгол Улсын батлан хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	2016-09-01	15.2.Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх асуудлын хүрээнд харьяа агентлаг, аймаг, нийслэл /дүүрэг/-ийн цэргийн штаб, батлан хамгаалах чиглэлийн улсын үйлдвэрийн газар, цэргийн сургууль, судалгаа шинжилгээ, сургалт-үйлдвэрлэл, туршилт, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, хэвлэл мэдээллийн байгууллагатай байна.
34	Монгол Улсын их хурлын тухай хууль /шинэчилсэн найруулга/	2006-01-26	20.5. Төрийн байгуулалтын байнгын хороо: 20.5 8. хэвлэл мэдээллийн хараат бус байдал;
35	Монгол хэлний тухай	2015-02-12	19.1.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага дараах үүрэг хүлээнэ: 19.1.1.монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах; 19.1.2.сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоосон байх 19.1.3.хуульд заасан бусад үүрэг.
36	Нийтийн сонсголын тухай	2015-07-08	18.4.Нээлттэй сонсголд хэвлэл, мэдээллийн төлөөллийг заавал оролцуулна.
37	Нялх балчир хүүхдийн хүнсний тухай	2017-05-12	10.1.Доор дурдсан бүтээгдэхүүнийг сурталчлах, дэмжихийг хориглоно: 10.1.2.эрүүл мэндийн болон хяналтын асуудал эрхэлсэн төрийн байгууллагаас хэвлэл мэдээллийн хэрэгслээр сэрэмжлүүлсэн бүтээгдэхүүн.
38	Ойн тухай /шинэчилсэн найруулга/	2012-05-17	41.2.4.хэвлэл мэдээллийн хэрэгслээр ойн тухай мэдлэг, ойг хамгаалах үндэсний уламжлал, зан заншил, хууль тогтоомжийг сурталчлах.
39	Олон нийтийн радио, телевизийн тухай	2005-01-27	9.4.Олон нийтийн радио, телевиз хэвлэл, мэдээллийн бусад байгууллагын мэдээ, мэдээлэл, нэвтрүүлгийг дамжуулж байгаа бол эх сурвалжийг заавал дурдана.
40	Патентийн тухай /шинэчилсэн найруулга/	2006-01-19	22.2.Төрийн нууцад хамаарах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварыг хэвлэлд нийтлэхгүй.

41	Садар самуун явдалтай тэмцэх тухай	1998-01-22	**5 дугаар зүйл.Садар самууныг сурталчлахыг хориглох** 5.1.Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно. 5.2.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, зураг, кино, дүрс бичлэг, бусад зүйлийг бэлтгэх, тараах, борлуулах, энэ зорилгоор хадгалахыг хориглоно. 5.3.Садар самууныг сурталчилсан хэвлэл, ном зохиол, кино, дүрс бичлэг, зураг болон бусад зүйлийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.
42	Соёлын өвийг хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	2014-05-15	49.2.3.олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр соёлын өвийг хамгаалах, өв уламжлал, ёс заншил, хууль тогтоомжийг сурталчлан таниулах.
43	Сонгуулийн тухай хууль	2015-12-25	5.4.Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний ажилтан, албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээх үүрэгтэй. 68.10.Энэ хуулийн 68.6, 68.7-д заасныг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. 68.11.Энэ хуулийн 68.6, 68.7-д заасныг зөрчсөн хэвлэл, мэдээллийн байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн тухайн зөвшөөрөл олгосон байгууллага зөрчил гарсан өдрөөс эхлэн зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ. 70.1.Ээлжит сонгуулийн жил эхэлснээс хойш санал хурааж дуустал аливаа этгээд сонгогчдын саналыг татах зорилгоор дараах үйлдэл, үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 70.1.6.хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим орон зай, мессеж ашиглан улс төрийн чансаа тогтоох зорилго бүхий аливаа хэлбэрийн шалгаруулалт зохион байгуулах, бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах; 70.7.Аливаа хэвлэл мэдээллийн байгууллага сонгуулийн сурталчилгааны үеэр сонгуульд оролцогч аль нэг талын талаар бүх төрлийн мэдээ, мэдээлэл гаргах, гаргахгүй байхаар амлалт авах, гэрээ байгуулахыг хориглоно.
44	Тамхины хяналтын тухай / шинэчилсэн найруулга/	2005-07-01	8.1.Дараахь хэлбэрээр тамхи сурталчлахыг хориглоно: 8.1.1.тамхи, тамхи ороодог цаас, тамхины шүүр, тамхи орооход хэрэглэгддэг төхөөрөмж, тамхины бусад дагалдах хэрэгсэл, тамхи үйлдвэрлэгчийн нэр, лого, тамхин бүтээгдэхүүн, түүний брэндийн нэр, барааны тэмдэг, тамхи үйлдвэрлэгчтэй холбоотой өнгө, өнгөний хослол, үг хэллэг, дизайн, зураг, дүрс, үнэр, дуу авиаг ашиглах, алдартай жүжигчин, тамирчин, урлаг, соёлын ажилтан зэрэг олон нийтийн дунд нэр хүнд бүхий хүнийг оролцуулах замаар тамхийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, кино, хувцасны загвар өмсөх үзүүлбэр, урлаг, спортын тоглолт, уралдаан, тэмцээн, гар утас, бусад шинэ технологи, ханын болон гудамжны самбар, зурагт хуудас, зар чимэглэл, зорчигчийн тийз ашиглах болон бусад биет байдлаар сурталчлах;

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХЭВЛЭЛ

Хавсралт 2

Хэвлэл мэдээллийн байгууллагад үүрэг болгосон, үйл ажиллагааг нь хориглосон хууль

№	Хууль	Батлагдсан огноо	Холбогдох зүйл, заалт
1	Авлигын эсрэг хууль	2006-07-06	5.1.6.хэвлэл мэдээллийн байгууллага авлигын аливаа хэлбэрийг үл тэвчих нийгмийн сэтгэл зүйн орчинг төлөвшүүлэхэд нийтлэл, нэвтрүүлгийнхээ бодлогыг чиглүүлэх, энэ талаар байнга мэдээлэл, сурталчилгаа явуулах.
2	Архидан согтуурахтай тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/	2000-01-28	9.1. Архидан согтуурахтай тэмцэх, түүний хор уршгийг олон нийтэд ойлгуулан таниулах талаар төрийн захиргааны төв болон орон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэнд, хэвлэл мэдээлэл, соёл, боловсролын байгууллага бүх төрлийн сурталчилгаа явуулах үүрэгтэй.
3	Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	2017-02-02	16.3.Гамшиг болон аюулын дохио, сэрэмжлүүлгийг харилцаа холбоо, хэвлэл мэдээллийн байгууллага өмчийн хэлбэр үл харгалзан шуурхай, үнэ төлбөргүй дамжуулах үүрэгтэй.
4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай	1997-12-05	**11 дүгээр зүйл.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи хэвлэл, мэдээллийн хэрэгслийн хүлээх үүрэг**
5	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай /шинэчилсэн найруулга/	2016-12-22	7.2.Гэр бүлийн хүчирхийллийг сурталчилсан, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, хувийн нууц, нэр төрд халдсан мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр болон бусад хэлбэрээр түгээхийг хориглоно.
6	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай /шинэчилсэн найруулга/	2015-07-08	7.6.9.иргэдэд замын хөдөлгөөнд аюулгүй оролцохыг сурталчлах, бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр санамж, зөвлөгөө үнэ төлбөргүй нийтлэх, нэвтрүүлэх, түгээхийг үүрэг болгох, хэрэгжилтэд хяналт тавих;
7	Монгол хэлний тухай хууль	2015-02-02	19.1.Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, хэвлэн нийтлэх үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага дараах үүрэг хүлээнэ: 19.1.1.монгол хэлний зөв бичих дүрэм, орчин цагийн утга зохиолын монгол хэлний хэм хэмжээг чанд баримтлах; 19.1.2.сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтны мэргэжлийн ур чадварын шалгалтад монгол хэл, бичгийн мэдлэгийн шалгуур тогтоосон байх; 19.1.3.хуульд заасан бусад үүрэг.
8	Садар самуун явдалтай тэмцэх тухай хууль	1998-01-22	5.1.Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр садар самууныг сурталчлахыг хориглоно.
9	Хүн худалдаалахтай тэмцэх тухай	2012-01-19	8.1.Хэвлэл, мэдээллийн байгууллага дор дурдсан зар сурталчилгаа, мэдээлэл тараахыг хориглоно: 8.1.1.хохирогчийн бичгээр гаргасан зөвшөөрөлгүйгээр хохирогчийн талаарх мэдээлэл; 8.1.2.гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах тухай зар сурталчилгаа; 8.1.3.хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэхэд хүргэхүйц бүх төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, холбоо, цахим сүлжээ ашигласан ил буюу далд зар сурталчилгаа.
10	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай	1998-08-28	2 дугаар зүйл Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.
11	Эм, Эмнэлэгийн хэрэгслийн тухай хууль	2010-05-27	27.4.Эмийн зар сурталчилгаанд Зар сурталчилгааны тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаас гадна дараахь зүйлийг хориглоно: 27.4.1.эмийг импортлох, худалдах зорилгоор хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах;

ХУУЛЬЗҮЙН ЯАМНЫ ХУУЛИЙН ТҮҮВЭР www.tsl.gov.mn

Хавсралт 3

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй холбогдох хууль

№	Хууль	Батлагдсан огноо	Холбогдох зүйл, заалт
1.	Авлигын эсрэг хууль	2006-07-06	**28 дугаар зүйл.Улс төрийн баталгаа** 28.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албандаа хүндэтгэлтэй хандана.
2.	Боловсролын тухай	2006-07-06	5 **дугаар зүйл.Боловсролын үндсэн зарчим** 5.1.Боловсролын үндсэн зарчим нь: 5.1.4.иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана; **44 дүгээр зүйл.Багшийн эрх, үүрэг** 44.2.Багш дараахь үүрэгтэй: 44.2.6.суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
3.	Гамшгаас хамгаалах тухай /шинэчилсэн найруулга/	2017-02-02	40 **дүгээр зүйл**. **Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт** 40.4.Тусламж үзүүлэгч тал дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 40.4.1.иргэдийг үндэс, угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах;
4.	Гүйцэтгэх ажлын тухай	1997-12-19	5 **дугаар зүйл**. **Гүйцэтгэх ажил явуулах ерөнхий нөхцөл** Хувь хүний иргэний харьяалал, яс үндэс, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, ажил, албан тушаалын байдал нь түүний хувьд хуульд заасан үндэслэл журмын дагуу гүйцэтгэх ажил явуулахад саад болохгүй. 14 **дүгээр зүйл**. **Туслагч**, **туслах ажилтан ажиллуулах** 14.1.Гүйцэтгэх байгууллага нь эрх зүйн чадамжтай энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад хүнийг өөрийн нь зөвшөөрснөөр иргэний харьяалал, үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан туслагч, туслах ажилтнаар ажиллуулж болно.
5.	Дайны байдлын тухай	1998-5-15	26 **дугаар зүйл.Хүний эрх**, **эрх чөлөөний баталгаа** 26.1.Дайны байдлын үеийн үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлахыг хориглоно.
6.	Донорын тухай /шинэчилсэн найруулга/	2018-1-19	12 **дугаар зүйл.Донорт тавигдах шаардлага** 12.1.Донор нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан цус, эс, эд, эрхтнээ өгөхдөө ашгийн төлөө бус, авлагагүй, сайн дурын байна. 12.2.Донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
7.	Жагсаал, цуглаан хийх журмын тухай	1994-7-7	Бүхэлдээ

Хуулийн мэдээлэл

8.	Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай	2011-2-2	5 **дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим**, **бодлого** 5.1.Жендэрийн эрх тэгш байдал дараахь үндсэн зарчимд тулгуурлана: 5.1.2.ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, **эмэгтэй хүн бүр нас**, **хүйс**, **ажил**, **албан тушаал**, **үзэл бодол**, **гэрлэлтийн байдал**, **боловсролын ялгаа** зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;
9.	Залуучуудын хөгжлийг дэмжих тухай	2017-05-18	4 **дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 4.1.Энэ **хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно**: 4.1.3.“залуучуудын **оролцоо**” **гэж залуучуудын улс төр**, **эдийн засаг**, **нийгмийн хөгжил**, **шийдвэр гаргах түвшинд үзэл бодлоо илэрхийлэх**, **оролцох үйл явцыг**; 5 **дугаар зүйл.Залуучуудын хөгжил**, **оролцоог дэмжихэд баримтлах зарчим** 5.1.Залуучуудын **хөгжил**, **оролцоог дэмжихэд дараахь зарчмыг баримтална**: 5.1.3.залуучуудын **үнэлэмжийг нэмэгдүүлж**, **тэдний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах**.
10.	Зар сурталчилгааны тухай	2002-5-30	7 дугаар зүйл.Хууль бус зар сурталчилгаа 7.4.Дараахь **зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно**: 7.4.5.үндэс **угсаа**, **хэл**, **арьсны өнгө**, **нийгмийн гарал**, **байдал**, **нас**, **хүйс**, **мэргэжил боловсрол**, **шашин шүтлэг**, **үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг**, **харьцуулалт**, **дүрслэл зэргийг ашигласан**;
11.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай /шинэчилсэн найруулга/	2016-2-04	4 **дүгээр зүйл**. **Шүүхийн өмнө эрх тэгш байх** 4.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, **үзэл бодол**, **боловсрол болон бусад байдал**, **хуулийн** этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана
12.	Зөвлөлдөх санал асуулгын тухай	2017-02-09	5 **дугаар зүйл**. **Зөвлөлдөх санал асуулгын зарчим** 5.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийг удирдлага болгон зөвлөлдөх санал асуулгыг дараахь зарчмыг баримтлан явуулна: 5.1.1.хууль дээдлэх; 5.1.2.иргэний бодитой, шууд оролцоог хангах; 5.1.3.иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах;
13.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	2002-1-10	4 **дүгээр зүйл.Шүүхийн өмнө эрх тэгш байх** 4.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана.
14.	Монгол Улсын ерөнхийлөгчийн тухай	1993-6-5	**15 дугаар зүйл.Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх** 4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

15.	Монгол Улсын Үндсэн хууль	1992-01-13	**Арван дөрөвдүгээр зүйл**. 1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна. **Арван зургадугаар зүйл**. Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дурааараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно; 16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно; **Арван наймдугаар зүйл**. 4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно. **Арван есдүгээр зүйл**. 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. 2.Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө. 3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.
16.	Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай	2000-12-07	3 **дугаар зүйл**. **Комисс**, **түүний үйл ажиллагааны зарчим** 3.1. Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн. 21 **дүгээр зүйл**. **Улс төрийн баталгаа** 21.2. Комиссын гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.
17.	Монголын улаан загалмай нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай /шинэчилсэн найруулга/	2016-1-07	6 **дугаар зүйл**. **Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго**, **чиг үүрэг** 6.1.Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго нь зөвсөгт мөргөлдөөн ба нийтэд учирсан гамшигт байдлын үед хүн амд эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн тусламж үзүүлэхээс гадна хүнийг зовлон зүдгүүрт өртөхөөс сэргийлэх, учирсан зовлон зүдгүүрийг хөнгөвчлөх, шударга ёсны зарчимд үндэслэн хүнийг яс үндэс, иргэний харьяалал, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, боловсролоос үл хамааран хүний аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүмүүнлэг ёсыг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, хүмүүс хоорондын ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагааг дэмжих, энх тайвныг бэхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулахад оршино.
18.	Нийтийн сонсголын тухай	2015-07-08	3 **дугаар зүйл.Үндсэн зарчим** 3.1.Нийтийн сонсголыг зохион байгуулахад ардчилсан ёс, хууль дээдлэх, талуудын оролцоог тэгш хангах, иргэний мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах, үр нөлөөтэй байх зарчмыг удирдлага болгоно

19.	Олон нийтийн радио, телевизийн тухай	2005-1-27	8 **дугаар зүйл.Олон нийтийн радио**, **телевизийн хөтөлбөрийн бодлого** 8.2.Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараахь бодлого баримтална: 8.2.1.ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүндэтгэх; 8.2.2.улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургальч үзэл бодлыг хүндэтгэж, тэдгээрийг тэгш илэрхийлэх;
20.	Онц байдлын тухай	1995-11-14	17 **дугаар зүйл.Онцгой арга хэмжээг тогтоох**, **хэрэглэх хүрээ заагийн хязгаарлалт** 1.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино.
21.	Прокурорын тухай / шинэчилсэн найруулга/	2017-06-09	61 **дүгээр зүйл.Улс төрийн баталгаа** 61.1.Прокурор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.
22.	Сонгуулийн төв байгууллагын тухай	2006-01-12	**11 дүгээр зүйл. Хорооны гишүүний бүрэн эрхийн баталгаа** 11.11.Хорооны гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ хашиж буй төрийн албан тушаалдаа хүндэтгэлтэй хандана.
23.	Сонгуулийн тухай	2015-12-25	11 **дүгээр зүйл.Монгол Улсын иргэний сонгох**, **сонгогдох эрх** 11.1.Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй. 76 **дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааны баталгаа** 76.1.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь энэ хуульд тусгайлан зааснаас гадна доор дурдсан эрх эдэлнэ: 76.1.2.үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
24.	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай	1999-7-1	5 **дугаар зүйл.Баривчлагдсан**, **цагдан хоригдсон этгээдийн эрх зүйн байдал** 5.3.Хоригдсон этгээдийн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоос үл хамааран энэ хууль нэгэн адил үйлчилнэ.
25.	Төрийн албаны тухай / шинэчилсэн найруулга/	2017-12-07	31 **дүгээр зүйл.Хориглох зүйл** 31.4.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.
26.	Төрийн бус байгууллагын тухай	1997-1-31	4 **дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо** Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 1/"төрийн бус байгууллага" гэж иргэд, төрийн байгууллага / хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг; 5 **дугаар зүйл.Төрийн бус байгууллага байгуулах**, **оролцох эрх** 1.Монгол Улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй.

27.	Улс төрийн намын тухай /шинэчилсэн найруулга/	2005-1-28	4 дүгээр зүйл.Намын тухай ойлголт 4.1.Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн. 18 дугаар зүйл.Гишүүний татвар, намд өгөх хандив 18.2.Гишүүн, дэмжигчид үзэл бодол, итгэл үнэмшлээрээ намыг дэмжин хандив өргөж болно. Хандивыг зөвхөн тухайн шатны намын байгууллагын дансаар дамжуулж авна.
28.	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай	1998-01-02	3 **дугаар зүйл.Хуулийн нэр томьёо** 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.2.“улс төрийн хэлмэгдүүлэлт” гэж хүнийг нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нам, төр, нийгэмд аюултай этгээд гэж тооцож, улс төрийн буюу төрийн эсрэг гэх гэмт хэрэгт хууль бусаар холбогдуулж, шүүх тусгай, онцгой бүрэн эрхт комиссын болон нам, төрийн бусад байгууллагын шийдвэрээр баривчлан мөрдөх, эрүүгийн ял шийтгэл эдлүүлэх, шүүхээс гадуур нутаг зааж суулгах, хууль бусаар эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хасах замаар амь нас, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирол учруулсан бөгөөд зохиомол хэрэг, гүтгэлэгт үндэслэсэн албадлагын арга хэмжээг;
29.	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай	2016-02-05	**28 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх** 28.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой аливаа бодлого, шийдвэрийг гаргах явцад тэднийг үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангана.
30.	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай /шинэчилсэн найруулга/	2011-06-17	4 **дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим**, **төрийн бодлогын чиглэл** 4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчим баримтална: 4.1.1.иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах;
31.	Хөдөлмөрийн тухай	1999-05-14	2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. 3 **дугаар зүйл.Хуулийн нэр томьёо** 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.14.”албадан хөдөлмөр” гэж хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг; 7 дугаар зүйл.Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох 7.1.Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй. 7.2.Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно. 7.4.Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашных нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй.

32.	Хүүхдийн эрхийн тухай	2016-02-05	4 **дүгээр зүйл**. **Хүүхдийн эрхийн үндсэн зарчим** 4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална: 4.1.3.хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах; 5 дугаар зүйл. Хүүхдийн **эсэн мэнд амьдрах эрх** 5.3.Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхтэй. 6 **дугаар зүйл**. **Хүүхдийн хөгжих эрх** 6.1.Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ: 6.1.5.хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах;
33.	Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай	1998-08-28	1 **дүгээр зүйл.Хуулийн зорилт** Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино. бүхэлдээ
34.	Цагдаагийн албаны тухай /шинэчилсэн найруулга/	2017-02-09	22 **дугаар зүйл**. **Цагдаагийн байгууллага**, **алба хаагчийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага** 22.1.Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй. 84 **дүгээр зүйл**. **Улс төрийн баталгаа** 84.3.Цагдаагийн алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана. 84.5.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.
35.	Цэргийн албаны тухай	2016-09-01	4 **дүгээр зүйл**. **Иргэний цэргийн үүрэг** 4.2.Монгол Улсын иргэн нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн үүрэг хүлээнэ.
36.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай / шинэчилсэн найруулга/	2017-06-09	7 **дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага** 7.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно.

37.	Эрүүгийн хууль / шинэчилсэн найруулга/	2015-12-03	1.3 **дугаар зүйл.Шударга ёсны зарчим** 2.Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй. 1.4 **дүгээр зүйл.Гэм буруугийн зарчим** 4.Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. 10.1 дүгээр зүйл.Хүнийг **алах** 2.14.үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ. 14.3 **дугаар зүйл.**Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд **халдах** 1.Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь ноцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 19.9 **дүгээр зүйл.Үндэсний эв нэгдлийг бусниулах** 1.Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон үйлдлийг зохион байгуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 19.14 **дүгээр зүйл.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх** -Үзэл бодол, улс төрийн, шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орогнох эрх олж авахын тулд Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.
38.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай / шинэчилсэн найруулга/	2017-05-18	1.12 **дугаар зүйл.Хууль**, **шүүхийн өмнө эрх тэгш байх** 1.Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМАА ХЭВЛЭВ

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХЫН ЭСРЭГ ТУСГАЙЛСАН ЗОХИЦУУЛАЛТ БҮХИЙ ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ ЭСЭХ ТАЛААРХ ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫН УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДАЛГАА[140]

УДИРТГАЛ

Хуулиа дээдлэн, хүний эрх, эрх чөлөөг хангах нь ардчилсан нийгмийн оршин тогтнох үндэс суурь юм. Хүний эрхийн гол зарчим бол хүний бие, сэтгэл, соёлын болон нийгмийн ялгаанаас үл хамааран бүх хүнд адил тэгш нөхцөл, боломж бий болгоход орших төдийгүй бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг Монгол Улс Үндсэн хуулиар тунхагласан.

Монгол Улсын Үндсэн хуулийн /цаашид "Үндсэн хууль" гэх/[141] Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна." гэж заасан. Мөн хуулийн "Хүний эрх, эрх чөлөө" хэмээх Хоёрдугаар бүлэгт тус үндсэн эрхүүдийг хуульчлан баталгаажуулсан байдаг. Ингэхдээ хүний эрх, эрх чөлөөг хангах, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг төр хариуцахаар үүрэг хүлээсэн.

Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн түвшинд хүний эрх, эрх чөлөөг хангах тухай авч үзэх бөгөөд Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 6 дахь удаагийн ээлжит тайланд Хүний эрхийн хорооноос гаргасан дүгнэлттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжүүдийг 2018-2021 онд ХЗДХЯ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Уг төлөвлөгөөний 8-д "Шууд болон шууд бус байдлаар ялгаварлан гадуурхах зэрэг төрийн болон хувийн салбарт ялгаварлан гадуурхахын эсрэг чиглэсэн дэлгэрэнгүй зохицуулалт бүхий хууль тогтоомжийг батлах" тухай заасан.

Иймд, дээрх хэрэгцээ шаардлагад үндэслэн Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэхийг тодруулахыг зорилоо.

Судалгааны аргачлал:

Тус судалгааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан аргачлалын дагуу дараах үе шатаар хийж гүйцэтгэв. Үүнд:

1. Асуудалд дүн шинжилгээ хийх;
2. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;
3. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
4. Зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судлах;
5. Тухайн зохицуулалтын талаарх Олон Улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
6. Дүгнэлт, зөвлөмж боловсруулах.

Дээрх дараалын дагуу нэгдүгээрт "ялгаварлан гадуурхах"-тай холбогдох ойлголт, харилцааг судалж, ялгаварлан гадуурхалтад үүсэж буй асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Үүний тулд Монгол Улсын болон бусад орны хууль тогтоомж, Олон Улсын байгууллагаас гаргасан баримт бичиг, Олон Улсын гэрээ,

[140] Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, Ц.Оюунчимэг, У.Эрдэнэзаяа нар хамтран гүйцэтгэв.

[141] *Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992),* №1

холбогдох ном сурах бичиг, өмнө хийгдсэн социологийн судалгаа, судалгааны тайлан, илтгэл, өгүүллийг уншиж судлах, харьцуулалт хийх болон бусад статистик мэдээллийг ашигласан бөгөөд асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг болон тухайн асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тус тус тодорхойлов.

Асуудлыг тодорхойлсны дараагаар асуудлыг шийдвэрлэх ерөнхий зорилгоо томьёолж, тухайн зорилгод хүрэх хувилбарыг тогтоосон. Тухайн үе шатанд асуудлыг шийдвэрлэх хувилбаруудыг зорилгод хүрэх байдлаар нь харьцуулан дүгнэж хамгийн оновчтой хувилбарыг сонгон авч үр нөлөөг судлав.

Эцэст нь сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулаа.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх зорилгоор үнэлгээний ажлын эхэнд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно.

Үндсэн хуулиар ялгаварлан гадуурхаж болохгүй шалтгаануудыг нэр заан тоочиж хуульчилсан байдаг. Эдгээр шалтгааныг үндэслэн хүмүүсийн эрхийн байдалд нэмүү боломж олгох буюу хязгаарлалт тогтоож болохгүй.[142] Үүгээр энэ заалт нь хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөлийг иж бүрнээр хуульчилсны хамт хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх тунхаглалаа хангах давхар баталгааг бүрдүүлсэн.

Эрх тэгш байх ойлголтын талаар Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэж заасан. Энэ заалт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт хууль ёсоор оршин сууж байгаа бүх хүнд адилхан олдсон, ашиглаж, эдлэх ёстой боломж юм. Хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна гэдэг нь хууль тогтоох, шүүх засаглалын эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аль ч хүний хувьд эрх, үүрэг, хариуцлага гэдэг гурван ойлголтыг ямар нэг ялгаваргүй тогтоох хэрэглэх үндсэн зарчим болдог. Эдгээр ойлголтын талаар товч дурдвал,

“Хүний эрх”-Хүн төрөлхөөсөө насан эцэслэтэл бусдад хохирол учруулахгүйгээр эдлэх өөрт нь заяасан эрх, эрх чөлөөтэй бөгөөд төрийн аливаа нэгдэл холбоо нь түүнийг хавчин хязгаарлаж болохгүй. Итгэл үнэмшилтэй, өмч хөрөнгөтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх нь тэдний төрөлхийн эрх чөлөө мөн.[143]

“Үүрэг”-Шударга хүнлэг ёсыг эрхэмлэн Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хуулиар ногдуулсан албан татвар төлөх, эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах үндсэн үүрэгтэй байх бол хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг байдаг.[144]

“Хариуцлага”-Хууль зөрчсөн тохиолдолд бүгд адилхан шүүхийн шийдвэрээр хуулийн хариуцлага гарцаагүй хүлээх, шударга шүүхийн хууль ёсны шийдвэрийг бүгд адилхан биелүүлэх[145] шаардлага бий юм.

Ийнхүү хүн бүр ялгаварлан гадуурхалтаас ангид эрх тэгш байх үндсэн зарчим хэрэгжих шалтгаан нөхцөл нь эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарладаг, нөгөө талаас хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын үйл ажиллагааны хүрээнд заавал удирдлага болох хууль зүйн эрх, үүрэг, хариуцлага гурав хүн бүрт адил тэгш

[142] Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх /харьцуулсан эрх зүй/ Уб., 1999 он.

[143] Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг /Францын 1789 оны “Хүний ба иргэний эрх чөлөөний тунхаглал”-аас/ 92 дахь тал

[144] Төрийн мэдээлэл эмхэтгэл. №1, 1992 он, */Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйл/*

[145] Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх /харьцуулсан эрх зүй/ Уб., 1999 он. 25 дахь тал

үйлчилж байх явдал юм. Өөрөөр хэлбэл, төрөөс хүний эрхийг хангах, хамгаалахад тохирох үүрэг, хариуцлагыг ногдуулдаг аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах нь эрх тэгш байх үндсэн зарчим бүрэн утгаараа хэрэгжих баталгаа бүрдэх учиртай.

Харин хүн бүр нийгмийн харилцаанд оролцохдоо адил тэгш байх боломж байдаггүй. Ажил мэргэжил, боловсрол, насны зөрүүтэй байдал /хүүхэд, залуу хүн, хөгшин хүн/, өмчийн хувьд, авьяас чадвар, үзэл бодол, их бага орлого, ам бүл олон, цөөн байх зэргээс шалтгаалан өөр өөр байдаг. Тухайлбал, насаараа хөдөлмөр эрхэлсэн тэтгэвэр тогтоолгож буй хүнтэй ажил хөдөлмөрийн гараагаа эхлэж буй залуу болон сургуульд орж буй хүүхдэд үндсэн эрхээ эдлэхэд чиглэсэн төрийн үйлчилгээг адил тэгш үзүүлэхийн тулд тусгайлсан зохицуулалтаар зохицуулж хуульчилах, тогтоол, шийдвэр, захирамж гарган тэдгээр хүний үндсэн эрх хангагддаг байна.

Халдашгүй байх, амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, эрүүл мэндээ хамгаалуулах, амрах, сурч боловсрох, үзэл бодлоо илэрхийлэх, бүтээл туурвих сонгох, сонгогдох, шашин шүтэх, эс шүтэх, эд хөрөнгө өмчлөх зэрэг үндсэн эрхүүдээр хүн эхийн хэвлийд бүрэлдэн бий болсон цагаас эхлэн үхэх хүртэл хангагдах талаар олон улсын гэрээ конвенц, Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор заасан байдаг. Эдгээр эрхийг эдлэхдээ хүн бүр бусдын эрхэнд халдахгүй байх зарчмыг баримтална.

Даяарчлагдаж буй өнөөгийн нийгэмд хүний эрхийг хамгаалан тунхаглаж буй төр нь халдашгүй дархан байх, улсын аюулгүй байдал, оршин тогтнох баталгааг бий болгосноор бусад улс орноос ирэх аюул, заналаас өөрийн иргэний үндсэн эрхийг хангах, хамгаалах үүргийг давхар хүлээж байдаг тул иргэн бүр төрөө дээдлэн хүндэтгэх, ёс суртахуун, төлөвшлийг бий болгон ард түмэн, газар нутаг, соёл түүхийн онцлог шинжээ хадгалан хамгаалах нь чухал юм.

Иймд НҮБ болон олон улсын жишгээс хоцрохгүйгээр өөрийн улсын онцлог шинжийг хадгалан хөгжих, хүний эрхийг дээдлэн хүндэтгэх явдал нь тулгамдсан асуудал болоод байна. Ф.Мартенс "Бүх боловсронгуй улс орон хүнийх нь хувьд үндэстэн харьяаллаас үл хамааран, бие хүнтэй салшгүй холбоотой мэдээжийн үндсэн эрхийг яс үндэс, харьяаллаас үл хамааран хүлээн зөвшөөрдөг"[146] тухай дурдсанаас үзвэл хүний үндсэн эрхийг хүлээн зөвшөөрсөн байх нь тухайн улсын хөгжил дэвшилтэй (боловсронгуй улс) салшгүй холбоотой байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей болон хүний эрхийн хороо нь олон улсын эрх зүйн салбарын хувьд хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэгэн ялгаварлалгүйгээр энх тайвны цагт ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч хангаж мөрдөх улс орны үүргийг тодорхойлсон буюу эдгээр эрхийг зөрчсөний хариуцлагыг тогтоосон зарчим, хэм хэмжээний нийлбэр юм[147] гэжээ. Ийнхүү Монгол Улс НҮБ-ын гишүүн орон болохын хувьд хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэгэн ялгаварлалгүйгээр энх тайвны цагт ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч хангаж мөрдөх, урьдчилан сэргийлэх үүрэгтэй байдаг.

Төрөөс хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэгэн ялгаварлалгүйгээр хангаж, урьдчилан сэргийлэх ажлын эрх зүйн орчныг судлан үзвэл шууд утгаар ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалттай хууль 34, УИХ-ын тогтоол 5, шударга ёс, тэгш байдлыг хангах талаар зохицуулсан 81 хууль (хавсралт 2) хүчин төгөлдөр үйлчилж байна. Үндсэн хуулиар олгогдсон хүний эрхийг аливаа ялгаваргүйгээр, тэгш хангах зорилгоор зөвхөн тухайн харилцааг зохицуулахаар тусгагдсан, эсхүл нийтлэг харилцааг зохицуулахаар тусгагджээ.

Ийнхүү судалгааны хүрээнд хууль хоорондын уялдаа холбоо, хүний эрхийг хангахад чиглэсэн хуулийн үндсэн зарчим, хүний эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлэн хуульчилсан байдлаас аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байж тэгш эрхийг

[146] Ф.Мартенс. Современное международное право цивилизованных народов. Т.1.СПб, 1882, с.327 /Ж.Амарсанаа. Хүний эрх номноос дам ишлэв./

[147] Ж.Амарсанаа. Хүний эрх /Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал/ Уб.,2000 он.

хангахтай холбоотой асуудал хэрхэн шийдвэрлэгдэж, хэрэгжих ямар арга хэмжээг хэрхэн авч хэрэгжүүлэх, ач холбогдол, эерэг, сөрөг тал, хууль боловсруулах шаардлагатай эсэхийг судлан үзнэ.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Ялгаварлан гадуурхахын эсрэг тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор дээрх тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийхэд дараах асуудал анхаарал татаж байна. Үүнд:

- Төрөөс хүний үндсэн эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтын эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар;
- Ялгаварлан гадуурхахын эсрэг арга хэмжээг хэн, хэрхэн авч хэрэгжүүлж буй байдал;
- Хууль тогтоомжид тусгагдсан ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилт;
- Үндсэн хуулийн цэцээр (Үндсэн хуулийн шүүхээр) шийдвэрлэгдсэн байдал;
- Төрөөс хүний эрхийг хамгаалан, үүрэг, хариуцлагыг ногдуулдаг аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхад эрх тэгш байх механизмын үйлчлэл, хязгаар;
- Нийгэмд ялгаварлан гадуурхалтаас үүдэлтэй айдас хүйдэс, үндсэн эрхээ эдлэх, тэгш эрхийн хэрэгжилтийг хангах нөхцөл боломж бүрдсэн эсэх.

Эдгээр асуудлыг харгалзан судалгааны цар хүрээг өргөн хүрээнд авч үзэх нь тохиромжтой байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлох

Өмнөх бүлэгт тодорхойлсон судалгаа гүйцэтгэх хүрээ, тулгамдсан асуудалтай холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна.

***Хүснэгт 1**. Эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байгаа этгээд*

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Нийгмийн бүлэг	Хүний үндсэн эрх зөрчигдөж, аливаа ялгаварлан гадуурхалтад өртөж буй байдлаас урьдчилан сэргийлж, хамгаалах нийгмийн бүлгийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх, хүчирхийлэлд өртөх явдлыг таслан зогсоох асуудал чухал байна.
2	Иргэд */18 наснаас дээш иргэний үнэмлэх авсан/*	Иргэд үзэл бодол, нас, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, хүйс, албан тушаал зэргээр ялгаварлан гадуурхалтад өртсөнөөс үүдэн гарах үр дагаварыг багасгах шаардлагатай.
3	Аж ахуйн нэгж, байгууллага	Аж ахуйн нэгжүүд хөгжлийн түвшин, хөрөнгө чинээ, тухайн аж ахуйн нэгжийн удирдлага нийгэмд эзлэх байр сууриас шалтгаалан ялгаварлан гадуурхалтад өртөх зэргээр тэгш бус байдлын нөлөө нийгэмд тодорхой байр суурийг эзэлжээ.
5	Бусад этгээд	Үндсэн эрхээ эдлэх эрхтэй хүүхэд өөр хоорондоо нэгнийгээ нийгмийн орчин нөхцөлд аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах, нийтээр хүлээн зөвшөөрдөггүй нийгмийн цөөнхийг аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Монгол Улсын Үндсэн хуулиар хүний эрхийг дээдлэн, бүх төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг тунхагласан тухай доктор, профессор Б.Чимид тайлбарлахдаа “Хүнийг дээдэлж, түүний эрх, эрх чөлөөт байдлыг хүлээн зөвшөөрч эрхэмлэсэн нь Үндсэн хуулийн язгуур үзэл баримтлалын нэг юм.”[148] Хүний эрх,

[148] Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 2017 он. 56 дахь тал.

эрх чөлөөг зөвхөн Үндсэн хуульд тодорхойлсон томьёоллоор хязгаарлан ойлгож, судалж, үнэлж, хамгаалж болохгүй. Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн түвшинд авч үзвэл зохино”[149] гэж үзсэн.

ХЭҮК-оос 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрүүдэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 623-н гомдол хүлээн авч шийдвэрлэснээс 6 нь үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэхтэй холбоотой гомдол байна.[150] Дээрх тоон үзүүлэлтийг харвал Монгол Улсад үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн зөрчил харьцангуй бага мэт харагдаж байгаа хэдий ч Мэдээллийн эрх чөлөөний төлөөх Хил хязгааргүй сурвалжлагчид олон улсын байгууллагаас гаргасан Хэвлэлийн эрх чөлөөний индексээр Монгол Улс 2016 онд 180 орноос 60 дугаар байр, 2017 онд 69 дүгээр байр, 2018 онд 71 дүгээр байранд тус тус орж сүүлийн гурван жилийн хугацаанд тогтмол доошилсоор[151] байна.

Үзэл бодлоо илэрхийлэх эрхийг “Итгэл үнэмшилтэй байж үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн арга нь үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал цуглаан хийх эрх чөлөө юм.”[152], “Итгэл үнэмшилтэй байж Үзэл бодлоо илэрхийлэх нь хүний сэтгэл зүй, улс төр, ёс зүйн болон бусад шинжийг илэрхийлсэн процесс юм.”[153] хэмээн авч үзсэн байх юм. Мөн “Үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө нь:

- Мэдээлэл, үзэл санааг улсын хил хязгаарыг үл харгалзан амаар (үг хэлэх);
- Бичгээр буюу хэвлэлээр (хэвлэн нийтлэх);
- Уран сайхны хэлбэрээр үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Түүнчлэн өөрийн сонгосон бусад аргаар үзэл бодлоо илэрхийлэх эрх;
- Эрж хайх (мэдээлэл авах);
- Хүлээн авах (мэдээлэл хүлээн авах);
- Түгээх;
- Тайван жагсаал, цуглаан хийх;
- Эвлэлдэн нэгдэх;
- Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх;
- Ажил хаях;
- Өлсгөлөн зарлах зэрэг эрх[154] эрх чөлөөний эх сурвалж, төдийгүй анхдагч суурь эрх юм.”

Аливаа мэдээлэл нь мэдээллийн харилцаанд оролцогч субъектийн тодорхой үйлдэл, үйл ажиллагаанд дамжиж олон нийтэд хүрч, нийгмийн оюун санааны эрэлт хэрэгцээг хангаж байдаг. Энэ үйл ажиллагаа нь гурван үе шаттай байна.[155] Үүнд:

- Нэг дэх шат: Мэдээлэл хайх эрх /freedom to seek/
- Хоёр дахь шат: Мэдээлэл олж авах /freedom to recieve/
- Гурав дахь шат: Мэдээлэл тараах, түгээх /freedom to impart information/”,

[149] Мөн тэнд. 194 дэх тал

[150] Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан, 18 дахь тал. http://nhrcm.gov.mn/мэдээ/жил-хагас-жилийн-үйл-ажиллагааны-тайлан/

[151] World Press Freedom Index, accessed April 1, 2019, https://rsf.org/en/ranking/2018

[152] ХБНГУ-н Ханнс Зайделийн сан, Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он, 98 дахь тал.

[153] Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас, эргэцүүлэл, 2000 он, №7, 103 дахь тал.

[154] Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.

[155] Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.

www.nli.gov.mn Хууль зүйн үндэсний хүрээлэн

Иймд төрөөс үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хангахын зэрэгцээ мэдээллийн харилцаанд оролцогч субъектийн тодорхой үйлдэл, үйл ажиллагаанд (хүүхдэд мэдлэг олгох процесс хамаардаг) анхааран нийгмийн хөгжил, улсын аюулгүй байдал, хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах нь зүйтэй байна.

Нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхагдах байдал нь бусад улс орнуудыг бодвол бага тохиолддог ч гэлээ бидний анзаарамгүй нөхцөл байдалд байнга хийгдэж байдаг. Тухайлбал, аль нэг байгууллагад анкет бөглөхдөө нийгмийн гарал гэсэн мэдээллийг заасан хүснэгтэд тэмдэглэн үлдээдэг. Энэ нь эцэг эхээ малчин, сэхээтэн, ажилчин гэж бөглөхөөс эхлэх юм. Тухайн байгууллага нь хувь хүний нууцыг хадгалах үүрэгтэй ч захиргааны зүгээс тухайн хүнд хандах хандлага, нөлөөлөх байдалд ялгаварлан гадуурхах хэлбэр болж байхыг үгүйсгэхгүй юм.

Хүний харагдах гадаад байдлаар ялгаварлан гадуурхах, хөгжлийн бэрхшээлээр нь ажиллах чадварыг үнэлэх явдал нь өнөөгийн нийгмийн ажиллах хүчний шалгуур болж байгаа нь мөн л асуудал дагуулсаар байна. 1999 онд батлагдсан Хөдөлмөрийн тухай хуульд 2003 онд орсон нэмэлт, өөрчлөлтөөр 25, түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага нь ажил, албан тушаалынхаа дөрөв, түүнээс дээш хувийн орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүнийг ажиллуулах тухай заасан. Гэтэл аж ахуйн нэгж, байгууллага хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүн ажиллуулаагүй бол ажиллуулбал зохих орон тоо тутамд төлбөр төлдөг байна. Үүнийг "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан"-д төвлөрүүлж[156] хөгжлийн бэрхшээлтэй буюу одой хүний нийгмийн хамгааллын арга хэмжээнд зориулагдаж, тэдгээрийг давтан сургах, ажлын байраар хангах, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд зээл олгох зэрэг арга хэмжээнд зарцуулагдаж байдаг. (ЗГ-ын 2019 оны 111 дүгээр тогтоол, хавсралт 2-оос үзнэ үү.)

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байрыг бий болгох чиглэлээр хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангасан ажил олгогчдод, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд санхүүгийн тусламж, урамшуулал олгох ажлыг зохион байгуулах тухай хуульчлан зааж өгсөн хэдий ч тэдний ажлын байрны орчин нөхцөлийг хангах нь хүндрэлтэй хэвээр байна. */"гадна"-шат, замын хашлага, хараагүй хүний хөтөч зам, унаа тээвэр, "дотор"-лифт, бариул, 00 өрөө, болон бусад орчинг бүрдүүлэх/*

Монгол Улсын үндэстний цөөнх иргэдийн хүний эрхийн асуудалд онцгойлон анхаарч, ялангуяа үндэстний цөөнх хүүхдийн эх хэлээрээ сурч боловсрох, харилцах, мэдээлэл авах эрх, хөдөлмөр эрхлэлтийн асуудал тулгамдсан асуудал хэвээр байгаа нь анхаарал татаж байна.

Хүний эрхийн үндэсний комисс нь НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр "Бүх нийт боловсролын төлөө!" иргэний нийгмийн үндэсний эвсэлтэй хамтран 2016 онд Баян-Өлгий аймаг дахь хэлний цөөнх хүүхдийн сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд судалгаа хийжээ.[157]

Хүснэгт 2. *Баян-Өлгий аймгийн хүн амыг угсаатны байдал*[158]

№	Аймаг, сум	Бүгд	Угсаатны бүлгээр					
			Буриад	Дөрвөд	Казах	Тува	Урианхай	Халх
1.	Алтай	4191	12	7	2792	1	1363	16
2.	Алтанцөгц	2846	15	25	2288	1	444	73

[156] Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. http://nli.gov.mn/?p=4411 Хууль зүйн үндэсний хүрээлэн, Уб., 2018 он. /сүүлд үзсэн 2019.06.11/

[157] Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. Уб., 2017 он.

[158] Мөн тэнд. /Хүний эрхийн үндэсний комисс НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр "Бүх нийт боловсролын төлөө!" иргэний нийгмийн үндэсний эвсэлийн судалгаа/

3.	Баяннуур	5100	44	1	5010			45
4.	Бугат	3711	23	199	3345	2	109	33
5.	Булган	5231	19	11	4330		773	98
6.	Буянт	2768	23	6	1402	10	1302	25
7.	Дэлүүн	7236	39		7170			27
8.	Ногооннуур	6313	13	58	6155		46	41
9.	Сагсай	5188	19	10	4998	2	111	48
10.	Толбо	4123	28	16	4067			12
11.	Улаанхус	8789	86	29	8629		12	33
12.	Цэнгэл	9329	71	6	7770	13	13	160
13.	Өлгий	34305	251	393	31955	1142	1142	502
14.	Цагааннуур	1595	9	235	1295	6	25	25
	ДҮН	**100725**	**652**	**996**	**91206**	**1393**	**5340**	**1138**

Баян-Өлгий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2014 оны 51 дүгээр тогтоолоор “Хос хэлээр сургалт явуулдаг сургуулийн сургалтын талаар баримтлах аймгийн бодлого, чиглэл”-ийг баталсан байна. Тус тогтоолыг батлах үед аймгийн статистик мэдээгээр 32 цэцэрлэгт нийт 6117 хүүхэд хүмүүжиж байснаас бүх цэцэрлэг сургалтаа казах хэлээр явуулдаг, мөн судалгаанд хамрагдсан хүүхдийн 3 хүүхэд тутмын 1 нь сургуулийн өмнөх боловсрол эзэмшээгүй, Монголоор мэндлэх энгийн үг хэллэгийг ойлгохгүйгээс нэгдүгээр ангид орохдоо хичээлээ гүйцэхгүй хоцордог, нийт 43 ерөнхий боловсролын сургуульд 22626 хүүхэд суралцаж байгаагаас 19283 нь Казах-Монгол, 278 нь Тува-Монгол хос хэлээр суралцдаг, хэлний ялгаанаас болж сургууль дээрээ 10 хүүхэд тутмын 6 нь хүчирхийлэлд өртдөг, казах хүүхдүүдээс илүү казах багш нар ялгаварлан гадуурхах нь их, хэлний цөөнх сурагчдын хувьд анги дэвших тусам сургуулийн багш, ажилтан, үе тэнгийнхний зүгээс ялгаварлан гадуурхах, зодох, шийтгэх, дээрэлхэх, үзэгдэл улам нэмэгддэг тухай онцлон тэмдэглэсэн байна[159].

Хэлний цөөнхөөс гадна бэлгийн цөөнх нь нийгмийн харилцаанд ялгаварлан гадуурхагдах нь гадаад төрх байдал, бусад байдлаар бий болсоор байна. Тухайлбал, үг хэл, үйлдлээр доромжлон хүчирхийлэх, ажлаас нь халах, ажлаасаа гарахаас өөр аргагүй байдалд хүргэх, гэрээсээ хөөгдөх, боловсрол болон мэдээлэл олж авах эрхийг үгүйсгэх, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхгүй байх, эсхүл үйлчилгээ үзүүлэхдээ элдвээр доромжлох, амь насанд нь халдах, халдахаар завдах, заналхийлэх, сүрдүүлэх зэрэг үзэгдэл байнга гардаг гэжээ[160]. Эрүүл мэндийн шалтгаанаар бэлгийн чиг баримжаагаа тодорхойлох боломжгүй, мэс засал, хагалгааны аргаар аль нэг хүйс тогтоолгож, албажуулан бүртгүүлснээр тухайн иргэн нийгмийн харилцаанд өөрийн байр суурийг тодорхойлдог.

Энэ хүртэлх хугацаанд тухайн хүний хүйсийн илэрхийлэл янз бүрийн байдлаар тодорч болох бөгөөд энэ нь хүний хөгжил (нялх балчир үеийн зан байдал, өсвөр насны хүүхдийн зан байдал, залуу насны, идэр насны хүний зан байдал гэх мэт), бэлгийн хөгжил, үйл явцтай салшгүй холбоотой үзэгдэл юм. Үүнийг өмнө нь сэтгэцийн эмгэг гэж үздэг байсныг өндөр хөгжилтэй орон эрүүл мэндийн хувьд өвчин гэдгээр хүлээн авч ялгаварлан гадуурхах байдлыг өөр өнцгөөс тайлбарлан авч үздэг болсныг харгалзан үзэх нь зүйтэй болов уу. /Хөгжлийн бэрхшээлийн нэг хэлбэр гэдэг утгаар/ Харин зориудаар нийгмийн залуу, өсвөр үе, төлөвшил, хөгжил нь гүйцээгүй учраа олоогүй байгаа хүүхэд, залуусыг уруу татах, хүчирхийлэх, дарамтлах бэлгийн чиг хандлагын аль нэгийг хүлээн зөвшөөрүүлэх байдалд хүргэх, эргэлзээ тээнэгэлзээ бий болгох зэргээр нөлөөлөхгүй байх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, насанд хүрэх

[159] Мөн тэнд. /48 дахь тал/

[160] Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн талаарх судалгаа, үр дагаварт хийсэн үнэлгээ. /2018 онд ХЗДХЯ-ны захиалга/.,

хүртэлх хүүхдийн төлөвшил хандлагад аливаа буруу үлгэр дууриалал үзүүлэх, гэмт санаа зорилгоор элдэв мэдээлэл хүргэснээр зан байдалд нь нөлөөлөх зэргээр зориудаар үйлдэх халдлагаас сэргийлэх нь тулгамдсан асуудал юм.

Нийгмийн харилцаанд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор нь, хуулийн этгээдийг хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс хамааран ялгаварлан гадуурхах хандлага их болсон. Энэ талаар ХБНГУ-ын Фридрих-Эбертийн-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар "Цахим орчин дахь үзэн ядах үг хэллэг"[161]-ийг шүүсэн судалгаа гаргажээ.Үүнийг зургаар үзүүлэв.

Зураг 1. *Цахим орчин дахь үзэн ядах үг хэллэг*

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nlis.gov.mn

[161] Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг. /контент анализын судалгаа/ ХБНГУ-ын Фридрих-Эбертийн-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. 2018 он. http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14785.pdf /сүүлд үзсэн 2019.06.11/

Чадваргүй, тэрбумтан өмгөөлөгч, өмгөөлөгч гэгдэх, ам ажил нь алд дэлэм зөрөгч, хууль бус авирлагч, яллагч (6 үг, холбоо үг)	**Боловсрол** Нийт 11 (5 үг, холбоо үг)	Чадваргүй, найдваргүй, дампуу, залилан мэхлэгч, худалч
Гомо, лесби, заавхарсан, Эрийг эмэгчлэн, Эр хүйстэй "эмэгтэйчүүд", эмэгтэй болохыг хүсэх болсон эрчүүд, эмэгтэйлэг /эрэгтэй хүнийг хэлэх тохиолдолд/ (7 үг, холбоо үг)	**Бэлгийн, хүйсийн чиг баримжаа** Нийт 13 (6 үг, холбоо үг)	Гомо, лесби, янхан, хормойн донтой, заавхай, заавхарсан
Архичин (1 үг, холбоо үг)	**Эрүүл мэндийн нөхцөл байдал** Нийт 9 (8 үг, холбоо үг)	Архичин, донтон, ДОХ-той, тахир дутуу, солиотой, ухаанд нь ухна ишиг шүгэлсэн, сэтгэл мэдрэлийн өвчтэй, шизотой
Казак банди, тэмбүү, Орк, том шившиг, нухчин дарагч, "Эрийн муу эмд", ичих ч үгүй, новш, Нэгэн алд дөрвөн ямх нуруутай (8 үг, холбоо үг)	**Ерөнхий нэр хоч өгсөн, доромжилсон** Нийт 28 (20 үг, холбоо үг)	Нохойн баас, Казак банди, тэмбүү, Орк, дүр царайлагч, уран донгодогч, шавар хаагч, өшөө аваг, улайрагч, ичих ч үгүй, булай, новш, гөлөгнүүд, тэмбүүнд тарха идуулсэн, хучин, алуур хядуур үйлдэгч, "Ямар гэгчийн хар сүнсний алуурчин бэ", "Нүүр царайг нь нийтэд цацаж жигшүүлэх хэрэгтэй", "Гуравхан сая хүнийг амийг нь хорлуулаад дуусгах даалгавар авсан амилсан шулам", "манайхан ч энэ хүүхдээр туг тахих вий дээ"
Сошиал мангас Осоржамаа (1 үг, холбоо үг)	**Бодит хүнд өгсөн доромж хоч** Нийт 2 (1 үг, холбоо үг)	"Урвагч" Доржсэдов
57	189	132

Ийнхүү гадаад төрх байдал, нийгэмд эзлэх байр суурь, ажил мэргэжил, амьдарч буй орчин нөхцөл бусад олон хэлбэрээр нийгмийн харилцаанд ил, далд хэлбэрээр ялгаварлан гадуурхах нь хүнийг өөртөө итгэлтэй амьдрах, ажиллаж хөдөлмөрлөх, сурч боловсрох, нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулах үйл явцыг хойш татаж байдаг. Монгол Улсад аж төрөх, өөрийн улсын хөгжилд хувь нэмрээ оруулж чадах хүний хөгжил, ухамсар ёс суртахуун, соёл төлөвшилд суурилсан хүний эрхийг хангах асуудал дутагдалтай байгааг дээрх судалгаа харуулжээ.

Монгол Улсад эрх зүйн зохицуулалт, тогтолцоо бүрэлдэн тогтсон *(хуулиас гадна 2003 оны УИХ-ын 41 дүгээр тогтоолоор хүний эрхийг хангах ажил хийгдэж, түүнийг ЗГ-ын тогтоолоор хэрэгжүүлж байна)* ч өнөөгийн нийгмийн харилцаан дахь тэгш эрх, ялгаварлан гадуурхагдсан тохиолдол бүрийг хангалттай зохицуулж чадахгүй байна. Хэдийгээр батлагдан гарч буй хууль, зарлиг, батламж, шийдвэр нь Үндсэн хуульд нийцээгүй бол Үндсэн хуулийн цэц хүчингүй болгож, улсын тусгаар тогтнол, аюулгүй байдал, хүний эрх, аливаа төрлийн ялгаварлан гадуурхах явдлыэсрэг шийдвэр гаргаж байдаг (хавсралт 3) боловч энэ нь хууль тогтоомжийн уялдаа холбоо хангагдах, нийгмийн харилцаа бүрэн зохицуулагдах нөхцөл бүрдэхгүй юм. УИХ болон ЗГ-ын тогтворгүй байдал, ажлын уялдаа, залгамж холбоо алдагдсантай холбоотой хүний эрхийг хангах гол ажлыг УИХ-аас зохион байгуулж буй нь хангалттай бус байна. УИХ, ЗГ-ын тогтоол, бусад журмаар зохицуулагдаж байсан харилцаа сүүлийн үед зөвхөн хуулиар зохицуулагдаж, хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар хүлээлгэх болсон нь зарим харилцаа зохицуулалтгүй орхигдох явдал үүссэн байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол анх 1946 онд НҮБ-д элсэн орох хүсэлт тавьж, түүнээс хойш жил дараалан элсэх тухай хүсэлтэд Аюулгүйн Зөвлөлийн гишүүн байсан янз бүрийн орнуудын байр суурь нааш цаашаа олонтаа өөрчлөгдөж, гадаад бодлого, дипломат бодлогын туршлага хуримтлуулаагүй, гадаад бодлого нь бие даасан бус байдалтай, хүний эрхийг хангах шалгуур давахгүй, НҮБ-ын дүрмийг биелүүлэхгүй байх магадлалтай гэх зэрэг шалтгаанаар 15 жилийн хугацаанд олон удаа түдгэлзэж байжээ.[162] ЗХУ-ын дэмжлэгтэйгээр 1961 онд хүлээн зөвшөөрүүлж элссэн бөгөөд бичиг үсэг, соёл, уламжлал, тусгаар тогтнолоо олон улс оронд хүлээн зөвшөөрүүлж, эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал, нийгмийн асуудлууд болон хүний эрхийн талаар хамтран

[162] Монгол Улс нэгдсэн үндэсний байгууллагын гишүүн болсон нь. Түүний түүхэн ач холбогдол. file:///C:/Users/Turbayar/Downloads/374-Article%20Text-1515-1-10-20150105%20(1).pdf http://www.info.mn/news/5948.htm /сүүлд үзсэн 2019.06.14/

ажиллах болжээ.

Төр нь ялгаварлан гадуурхахгүй байх үүргийг олон улсын хэм хэмжээгээр, үндэсний хууль тогтоомжоор хүлээснийг Монгол Улс хэрхэн биелүүлж буйд дүн шинжилгээ хийвэл тусгайлсан хуульгүй байгаа нь анхаарал татаж байна [163] гэжээ. Нэгдсэн, уялдаа холбоог хангасан зохицуулалт хийгдсэнээр нийгмийн хөгжлөөс гадуур орхигдож, эрх ашиг нь хөндөгдөж буй бүлгийн эрхийг хангах, хэрэгжүүлэх арга хэмжээ, байгууллагын эрх, үүрэг, зохион байгуулалтыг нарийвчлан зохицуулах нь зүйтэй байна.

Өсвөр ирээдүй үе, бусад өндөр хөгжилтэй улсын алдартай компанид тодорхой байр суурийг эзлэн ажиллаж буй Монголын эд эс бүхнээ хайрлан, хүний эрхийг дээдлэн хүндэтгэх аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүй байх, мөн амьдрах нөхцөл боломж, зөв мэдээлэл авах, хөгжих боломжийг бий болгон газар нутаг, уул ус, газрын баялаг иргэдэд хүртээмжтэй аз жаргалтай амьдарч болох бүхий л боломжийг бүрдүүлэн, өөрийн улсын үнэт зүйлийг хайрлан хамгаалж, улам бүр өнгөлөн зүлгэж нээлттэй болгон “иргэн баян бол улс баян”[164] зарчмыг баримтлан дэлхийн бусад хөгжилтэй оронтой эн зэрэгцэх, тэдний дунд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхэд анхаарах нь туйлаас чухал юм.

Үндсэн хууль заасан хууль шүүхийн өмнө эрх тэгш байх аливаа төрлөөр ялгаварлан гадуурхахын эсрэг хүний үндсэн эрхийг хангах нь төрийн үүрэг байтал ялгаварлан гадуурхагдах явдал улам бүр өргөжин тэлж буй байдал, мөн зам тээврийн осол, хорт хавдар, халдварт өвчин, бусад гэнэтийн байдлаар нас барагсдын тоо нэмэгдэж, агаарын бохирдол, ус байгалийн нөөц хомстох, газар нутаг сүйрэн доройтох, идэх хоол, өмсөх хувцас бүрийг хүний эрүүл мэндэд тустай гэж үзэх аргагүй болсон явдал нь манай улсын хүний эрхийг хангах асуудал дутагдалтай байгааг харуулж байна.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго: “Хүний эрх тэгш байдлыг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулах”.

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУДЫГ ТОГТООЖ, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, судалгаагаар тодорхойлсон “Хүний эрх тэгш байдлыг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулах” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 1. *Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эерэг болон сөрөг тал*

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхгүй татгалзах	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.	Үр дүн сөрөг

[163] Жэйм Фитцжералд “EQVAZ RIGHTS TRUST” олон улсын байгууллагын дэд захирал. https://www.youtube.com/watch?v=5HYI62ySPsk /сүүлд үзсэн 2019.06.14/

[164] Богд хаант Монгол Улсын үед гаалийн түшмэл байсан С.Данзан http://www.info.mn/news/5948.htm / сүүлд үзсэн 2019.06.14/

2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгоо биелүүлэхэд зохих хэмжээгээр нөлөөлөх боломжтой. Гэвч өнөөгийн тулгамдаж буй бэрхшээлийг үр дүнтэй шийдвэрлэх боломжгүй буюу асуудал цаашид хэвээр үргэлжилнэ.	Зардал ихээхэн хэмжээнд шаардагдах бөгөөд ухуулга сурталчилгааг байнга идэвхтэй явуулахыг шаардана. Асуудлыг үүсгэх гол шалтгааныг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдээр одоо байгаа зохицуулалтыг тодорхой түвшинд дэмжих, сайжруулах боломжтой болно.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Нэгдсэн зохицуулалтаар хүний эрх тэгш байх эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтад өртүүлэхгүй байх бүрэн боломжгүй.	Дан ганц санхүүжилтээр сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Төрийн бус байгууллагын оролцоог дэмжих нь чухал ач холбогдолтой хэдий ч тодорхой зохицуулалт дутагдалтай байх тул өнөөдрийн хууль тогтоомжийн хүрээнд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх зайлшгүй шаардлага ажиглагдахгүй байна.	Иргэний нийгмийн байгууллагыг оролцуулахад зохих хэмжээний зардал гарах боловч үр ашгаа өгнө.	Зарим үр дүн гарах боловч зорилгодоо хүрч чадахгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Эрх тэгш байх эрхийг хангах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхагдаж байгаа тохиолдол бүрийг хязгаарлах зайлшгүй шаардлага бий тул Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “гаргцхүү хуулиар хязгаарлах” ёстой. Иймд тус суурь харилцааг хууль тогтоомжоор хуульчлан баталгаажуулах нь оновчтой.	Хэдийгээр зарим асуудлыг Засгийн газрын тогтоол зэрэг захиргааны шийдвэрээр зохицуулж буй боловч зохицуулалтын түвшин харилцан адилгүй, үр өгөөжгүй болох талтай. Захиргааны шийдвэр гаргах нь асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад тухайлсан тохиолдолд нөлөөлөх боломжтой ч сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Зарим үр дүн гарах боловч зорилгодоо хүрч чадахгүй
7	Хуульь тогтоомжийн төсөл боловсруулах	Хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой болгох хувилбар байна.	Зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй арга зам юм.	Зорилгодоо хүрэх боломжтой,үр дүнтэй

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн холбогдох харилцааг өргөжүүлэх, чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд “Эрх тэгш байх эрхийг хангах тухай хууль”-ийг төсөл хэлбэрээр боловсруулах, эсхүл одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид үүрэг болгосон хориглосон зохицуулалтын санкцийн хэрэгжилтийг хангах, бусад аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхаж буй хэлбэрт ногдох зохицуулалтын аргыг судалж хуулийн төсөл

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН www.tsedev.mn

боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ингэхдээ "Хүний эрх тэгш байдлыг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулах" зорилгын хүрээнд дараах боломжит зохицуулалтын 2 хувилбарыг дэвшүүллээ.

1/ Хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулах;

2/ Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхсан тохиолдолд хуулиар хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах.

Зорилгод хүрэх байдал

Хувилбар 1. Иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах нэгдсэн тогтолцоо нь хуулийн хүрээнд үйлчлэх нь төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшлэх юм.

Хүний эрхийг хангах, хамгаалах, аливаа төрлийн ялгаварлан гадуурхалт гарах байдлыг таслан зогсооход чиглэсэн 2003 оны УИХ-ын 41 дүгээр тогтоолоор нарийвчлан зохицуулсан зохицуулалтыг улам бүр сайжруулан хууль бий болгон бүрдэл хэсгийн чадавх, хүний эрхийг сахин биелүүлэх шаардлагатай. Үүний тулд:

Улсын Их Хурал нь хүний эрхийг хангах бодлогыг тодорхойлж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох, Засгийн газраас хүний эрхийн хүрээнд явуулж байгаа үйл ажиллагааг хянан шалгах, шүүх эрх мэдлийн хүрээний бодлогыг хууль тогтоох замаар тодорхойлох, энэ бүхэнд иргэд, тэдний олон төрлийн байгууллагын санал, оролцоог өргөтгөх замаар хүний эрхийг хангахад чиглүүлэгч, шийдвэрлэгч үүрэг гүйцэтгэнэ.

Засгийн газар нь төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагын хувьд хүний эрх, эрх чөлөөний талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээ, энэхүү хөтөлбөрийн биелэлтийг зохион байгуулж хангах ажлыг Улсын Их Хурлын өмнө шууд хариуцан хууль, гэрээний биелэлт, үр дүнг Улсын Их Хуралд, улмаар олон улсын гэрээний биелэлтийг НҮБ-д тогтмол тайлагнана. Засгийн газар хүний эрхийн талаарх хууль тогтоомжийн болон олон улсын гэрээний биелэлтийг хангахын тулд төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагаас явуулж буй үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэхэд чиглэсэн ажлыг хийнэ.

Хүний эрхийн төрөлжсөн байгууллагууд:

- Шүүх эрх мэдлийн байгууллага нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг бэхжүүлж, шударга, хүртээмжтэй, эрх тэгш, бүтээлч байдлыг хангах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны хүнд суртал, чирэгдлийг арилгах, засаг захиргааны үйл ажиллагаанд тавих бүх төрлийн шүүхийн хяналтыг хүчтэй болгох замаар шүүхийг хүний эрх хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээн хангахад чиглүүлэх;
- Хүний эрхийн Үндэсний Комиссын бие даасан байдлыг бэхжүүлж, үйл ажиллагааг нь идэвхжүүлэн өргөтгөж, үр нөлөөг дээшлүүлэх,
- Нутгийн өөрөө удирдах байгууллага /аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, баг, хорооны иргэдийн Нийтийн Хурал/ нь тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн өөрсдийн төлөөллийн байгууллага, шууд оролцоотой болохын хувьд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дээр хүний эрхийг сахин хангах, хамгаалах талаар нутгийн захиргааны болон төрийн бус байгууллагуудын харилцан ажиллагааг хүн амынхаа өмнөөс уялдуулах;
- Төрийн бус байгууллагууд нь засаг төрийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, удирдах, шийдвэр гаргахад оролцох иргэний оролцоог өргөтгөн идэвхжүүлдгээрээ хүний эрхийг хангах механизмын нэн чухал хэсэг болно.

Хүний эрх, хүний хөгжил, хүрээлэн буй орчинтой холбоотой хөтөлбөрүүдийг боловсруулах, биелүүлэх, хянан зохицуулах, үнэлэн дүгнэхтэй холбогдсон судалгаа, яриа хэлэлцүүлэг хийх, шийдвэр гаргах ажиллагаанд засаг төрийн бүх шатны байгууллага нь төрийн бус байгууллагууд, орон нутгийн үүсгэл санаачлагын бүлэглэлүүдийн хоорондын үр бүтээлч түншлэлийг хөгжүүлэх;

- Хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг өргөтгөн бэхжүүлэх, тэдгээрийн эрхээ эдэлж, үүргээ биелүүлэх таатай орчин бүрдүүлэх, Хүний эрх, мөн олон улсын хамтын нийгэмлэгээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс зүйн хэм хэмжээ, зарчмуудыг хувийн хэвшил нэгэн адил сахин биелүүлэх ёстойг иш үндэс болгож, тэдгээрт хууль ёсны шаардлага тавих зэрэг үйл ажиллагааг нэг бүрчлэн нарийвчлан зохицуулах, бусад холбогдох хууль тогтоомжийн уялдаа холбоог хангах нь зүйтэй юм.

Хувилбар 2. Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхсан тохиолдолд хуулиар хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах, хууль хоорондын уялдаа холбоог хангах, тухайлсан харилцааг зохицуулахаар эсхүл нийтлэг харилцааг зохицуулсан хуулиудын зохицуулалттай нийцүүлэн тодорхойлох шаардлагатай.

Эрх тэгш байдал, шударга ёсыг хангах талаар зохицуулсан 81 хууль *(хавсралт 2)* хүчин төгөлдөр үйлчилж байна. Үүнээс дурдвал;

- Ахмад настны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10-т “Гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч нь ахмад настныг нийгмээс тусгаарлах, ялгаварлан гадуурхах, нийгмийн харилцаанд оролцоход нь саад учруулах, хязгаарлах, түүнийг хөгжих, асран сувилах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийхийг хориглоно.”;
- Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т “Иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.”;
- Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2-т “сэтгэцийн эмгэгтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохыг цээрлэх”;
- Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.12-т “төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх”;
- Хүүхдийн эрхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх”;
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т “хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих” гэх зэргээр тухайн харилцааг тусгайлан зохицуулсан.

Харин Боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т “иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана”;

- Онц байдлын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-т “Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн

гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино";

- Эрүүгийн хуулийн 14.1 дүгээр зүйлийн "Ялгаварлан гадуурхах" гэсэн 1 дэх хэсгийн "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ." гэж;
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.12 дугаар зүйлийн "Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх" гэсэн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна." гэж тус заажээ.

Ийнхүү нийтлэг байдлаар тусгасан дээрх хуулиудад ялгаварлан гадуурхагдсан тохиолдол бүрт нарийвчлан оногдуулах заалт тусгагдаагүй байх ба ерөнхий утгаараа Үндсэн хуульд зааснаас зарим хэсэг нэмэгдсэн байна. Жишээ нь: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд бэлгийн, хүйсийн чиг баримжаа /"хүйс" гэдэгт эрэгтэй, эмэгтэй, бэлгийн чиг баримжаа нь "байдал" гэсэн Үндсэн хуулийн заалтад хамаарах нь зүйтэй болов уу/, хөгжлийн бэрхшээлтэй байдал болон хуулийн этгээдийн хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх тухай дэлгэрүүлэн зохицуулжээ. Дээрх хуулиудад үүрэг болгосон "хориглоно" гэж заасан заалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын санкцийг зарим хуулиар тодорхой заагаагүй орхигдуулснаас уг хуулийн заалт хэрэгжих боломж хязгаарлагдмал байна. Иймд хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулан, хууль хоорондын уялдаа холбоог хангах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах нь тулгамдсан асуудал болсон байна.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах хувилбаруудад зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй арга зам юм. Иймд цаашид Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн зардал тооцох аргачлалын дагуу зардлыг тооцон гаргах нь үр дүнтэй юм.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгон авсан зохицуулалтын хувилбарын үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн болно.

4.1. Хүний эрхэд үзүүлэх нөлөө

Дэвшүүлсэн зохицуулалтын хувилбаруудыг ерөнхийд нь авч үзвэл хүн бүр ямар нэгэн алагчлалгүйгээр өөрийн салшгүй эрх, эрх чөлөөгөө эдлэх тэр боломжийг нь бүрдүүлэх, хүний эрхийг хангах, хамгаалах, хариуцлага тооцох механизмыг сайжруулахад тодорхой үр дүн гарч болно гэж үзэж байна.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Зохицуулалтын хувилбарууд нь дотоод болон дэлхийн зах зээлийн өрсөлдөх чадварт нөлөөлөхгүй. Харин аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргаанаас хүний тэгш эрхийг хангах чиглэлээр сургалт, семинар, хүний нөөцийг бэлтгэхэд тодорхой зардал гарах боломжтой.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин хүний эрх тэгш байх эрхийг хангах, аливаа ялгаварлахаас ангид байх зарчимд нийцсэнээр эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчинд ямар нэгэн байдлаар сөрөг нөлөө үзүүлэхгүй.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна хэмээн Үндсэн хуулиараа хүний эрхийг баталгаажуулсан нь НҮБ-ын конвенцийн зарчимд нийцэж байна.

Энэхүү үндэслэл нь бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг боловсруулах суурь болж байна. Иймд аливаа хэлбэрээр үл ялгаварлан гадуурхах ба хүний эрхийг хангах, хамгаалах үүргийг төр хүлээдэг тул эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага тулгараад байна.

ТАВ.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Монгол Улс НҮБ-д гишүүнээр элсэн Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг бүрэн хүлээн зөвшөөрч, улмаар «Иргэний болон улс төрийн эрхийн тухай», «Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай» олон улсын пакт зэрэг хүний эрхийн талаарх НҮБ болон түүний төрөлжсөн байгууллагуудын олон улсын 30 гаруй гэрээнд нэгдэн орж, хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх үйлсэд зохих амжилт олсоор ирсэн. НҮБ-ын гишүүн 190 гаруй орноос ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтыг судлан үзвэл /Хавсралт 4-өөс үзнэ үү./165 тусгайлсан хуультай 18 орон байна. Эдгээр улсуудаас Европын Холбоо, ИБУИНВУ, ХБНГУ, Австрали Улс, АНУ болон Колумба Улсын алагчилах үзлийг хууль тогтоомжид хэрхэн тусгалаа олсон талаар 8-9 нийтлэг шинжээр алагчилах үзэл гаргах явдлыг хориглосон байна. Эдгээр шинжүүдийг хуулийн зорилго болгон тусгасан байх боловч ихэнх тохиолдолд нийтлэг харилцаанд авч үзжээ.

Нэг. Европын Холбоо

Европын Холбооны гишүүн орон “Ялгаварлан гадуурхахын эсрэг хууль” тэр дундаа “Арьс өнгөөр тэгш байх зааварчилгаа”-нд арьс өнгөөр ялгаварлан гадуурхах, гадаадын иргэдээс айх үзэл, үзэн ядах гэмт хэргийн эсрэг зэрэг асуудлыг авч үздэг байна. Энэхүү хууль зүйн баримт бичиг нь олон салбарт үйлчилдэг. Тухайлбал, ажил эрхлэлт, нийгмийн хамгаалал болон нийгмийн халамж, эрүүл мэндийн

165 http://hdr.undp.org/en/countries
Монгол Улсын НҮБ–д илгээсэн тайлангууд: http://hdr.undp.org/en/countries/profiles/MNG
https://www.unicef.org/about/annualreport/files/Mongolia_2017_COAR.pdf
НҮБ тус конвенц-д нэгдсэн улс орнуудын илтгэл, тайлангууд: https://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/TBSearch.aspx?Lang=en&TreatyID=6&DocTypeID=27 /сүүлд үзсэн 2019.06.17/

үйлчилгээ, мөн нийгмийн давуу эрх, боловсролын үйлчилгээ, шашин шүтэх, ажил олгох, мэргэжил эзэмшихэд нь ялгаварлан гадуурхахгүй байх зэрэг өргөн хүрээнд зохицуулагддаг.[166]

Европын Холбоо нь олон нийтийг хамарсан, хүчирхийлэлд өдөөн турхирсан үйлдлийг гэмт хэрэгт тооцон шийтгэл ногдуулах талаар, эрүүгийн хууль тогтоомжид хуульчлахыг зөвлөмж болгосон. Энэхүү баримт бичиг нь гишүүн орнуудад үл ялгаварлах, тэгш хандах үүрэг хүлээсэн бөгөөд тус холбоо нь гэмт хэргийн улмаас хохирсон иргэдийг хамгаалалтад авах журам боловсруулсан байна.

Европын Комисс нь яг тодорхой асуудлаар санаачлага /цахим сүлжээн дэх хууль бус үзэн ядах үг хэллэгтэй тэмцэх, менежментын асуудлыг дэлгэрүүлэх г.м/ гаргаж, эрх бүхий байгууллага, иргэний нийгэмд зориулсан төслийн санхүүжилтийн санг байгуулан Эрх тэгш байдал болон Иргэний хөтөлбөр боловсруулсан байна. Энэ хөтөлбөр нь шашны болон цөөнхийн бүлэглэлд байгаа хүмүүсийг хамгаалах асуудлыг зохицуулсан байх бөгөөд тэр дундаа Европын Комиссоос томилогдсон Антисемитизм буюу Жүүдүүдийн эсрэг үзэл, мөн Муслам шашинтай иргэдийг үзэн ядахтай тэмцэхэд чиглэгджээ. Европ дахь шинэ, хуучин Антисемитизм буюу Жүүдүүдийн эсрэг үзэл, тэдний нөхцөл байдлын талаар олж мэдэх зорилгоор 2018 оны 12 дугаар сард "Жүүдүүдийн эсрэг үзлийн тухай" судалгааг Европын Холбооны Хүний эрхийн агентлаг явуулсан байдаг.

Европын Комисс нь бүх хүмүүсийн тэгш эрхийг хангах, тэр дундаа Европын Холбоон дахь Африк гаралтай иргэдийг арьс өнгөөр ялгаварлан гадуурхах асуудалд тусгайлан анхаарал хандуулдаг байна. Ийнхүү "Afrophobia" гэх нэр томьёог тусгайлан судалж, хэлэлцүүлэг зохион байгуулж ихээхэн хүчин чармайлт гаргасны үр дүнд Европын Комиссоос гаргасан төслийн баримт бичигт тусгалаа олж, улмаар 2018 оны 5 дугаар сарын 14-17-ны хооронд Европын Парламентаас зохион байгуулсан "Европын Холбоо Африк гаралтай иргэдийн 7 хоног" гэсэн чуулганаар хэлэлцэгдэн, ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх зорилготой дүгнэлтэд тусгалаа олсон байна.

Хоёр. ИБУИНВУ

ИБУИНВУ нь 2010 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр Тэгш байдлын тухай хууль баталснаар өмнө үйлчилж байсан алагчилах үзлийн эсрэг хуулиудыг нэгтгэж зохицуулах болсон байна.[167]

Энэ хуулийн "нэр томьёо" II тал, I бүлэг, 4 дүгээр зүйлийн "Хамгаалагдах шинжүүд" хэсэгт нас, хөгжлийн бэрхшээл, жендэр, гэрлэлт болон иргэний түншлэл, жирэмслэлт болон жирэмсний байдал, арьс, шашин эсхүл итгэл үнэмшил, хүйс болон бэлгийн чиг хандлага зэрэг 9 шинжийг тусгасан байдаг.

Мөн тус хуульд шууд[168], холимог алагчилах[169] болон шууд бус алагчилах[170] үзэл гэж ангилсан байдаг.

Шууд алагчилах нь хамгаалагдсан шинжүүдээс шалтгаалан үл нааштай хандсан эсхүл бусдад хэрхэн хандах байсан тийм байдлаар адил хандаагүй, гэрлэсэн болон иргэний түнш гэдгээр алагчилан хандсан, эмэгтэй хүн хөхөөр хооллох аргыг сонгосон гэсэн шалтгаан байх зэрэг, холимог алагчилах үзэл нь хамгаалагдах шинжүүдээс хоёр болон түүнээс дээш шинжээр хамтад нь үл

[166] Европын Холбооны мэдэгдэл, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн №73 чуулган 3 дугаар хороо, 2018 / уг мэдэгдэлд Турк, Бүгд Найрамдах Макадони, Монтенегро, Серби, Албани, Босни ба Херцеговина, Украйн, Молдав, Жеоржиа улсууд мөн нэгдэж буйгаа илэрхийлсэн/, Сүүлд зочилсон 2019-03-22: https://eeas.europa.eu/delegations/un-new-york/52953/eu-statement-%E2%80%93-united-nations-3rd-committee-elimination-racism-racial-discrimination_en

[167] Сүүлд зочилсон: 2019-05-07: https://www.gov.uk/guidance/equality-act-2010-guidance

[168] ИБУИНВУ "Тэгш байдлын хууль" (2010), 13 дүгээр зүйл. https://www.gov.uk/guidance/equality-act-2010-guidance /сүүлд үзсэн 2019-05-07/

[169] Мөн тэнд. 14 дүгээр зүйл.

[170] Мөн тэнд. 19 дүгээр зүйл.

нааштай хандсан эсхүл тэдгээр шинж байхгүй бусад этгээдэд хэрхэн хандах байсан тийм хандлагаар хандаагүй зэрэг тохиолдлыг, шууд бус алагчлах нь холбогдох хамгаалагдах шинжээр нь шалгуур үзүүлэлт болгож, эсхүл холбогдуулан хандсан гэж үзсэн бол, холбогдох хамгаалагдах шинжээр нь шалгуур үзүүлэлт болгон, эсхүл холбогдуулан хандсан нь алагчилах үзэл гаргасан харилцаанд хэрэгжсэн гэж үзнэ.

Хуулийн 25 дугаар зүйлд[171] "Алагчилах үзлийн тусгайлсан тохиолдлууд"-д зохицуулсан байдаг. Уг хуулийн "Үл алагчилах үзлийн дүрэм" 61 дүгээр зүйлд "(8) Хатан хааны Сайдын зарлигт тодорхойлсон үл алагчилах үзлийн дүрмийг баримтлан шийдвэр гаргах, үйл ажиллагаа явуулсан эрх бүхий ажил олгогч, итгэмжлэгдсэн этгээд болон менежер уг дүрмийн хүрээнд явагдсан бол тэрхүү харилцааг үл алагчилах үзлийн дүрмийг зөрчөөгүй гэж үзнэ." гэж хуульчилсан байдаг.

Гурав. ХБНГУ

ХБНГУ-д аливаа хэлбэрээр алагчилах үзлийг хориглосон бөгөөд Европын Холбооноос гаргасан Алагчилах үзлийн эсрэг 4 зааварчилгааг[172] өөртөө нэгтгэсэн. 2006 оны 8 дугаар сарын 14-ний өдөр "Тэгш хандах тухай ерөнхий хууль"[173]-ийг батлан гаргасан.

Тус хуулийн зорилго[174] нь дараах нийтлэг долоон шинж болох арьс өнгө, гарал үүсэл, /угсаа язгуур/, хүйс, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзэл, хөгжлийн бэрхшээл, нас болон бэлгийн чиг хандлагын улмаас хуулиар зохицуулсан харилцаанд ялгаварлан гадуурхах явдлаас хамгаалахад чиглэсэн байна. Эдгээр шинж бүрээр ялгаварлан гадуурхаж болохгүй тохиолдлуудыг заан тодорхойлсон. Үүнээс гадна хуулийн 20 дугаар зүйлд алагчилах үзэл гаргахыг зөвшөөрсөн нөхцөлийг хуульчилжээ. Үүнд:

1. аюул заналхийллээс зайлсхийх болон, гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэхэд, эсхүл харьцуулсан шинж бүхий бусад зорилгоор;

2. хувь хүний халдашгүй болон аюулгүй байдлыг хамгаалах шаардлагыг хангахаар бол;

3. тусгай тэтгэмж бүхий давуу байдал олгох болон тэгш хандахыг албадах ашиг сонирхол үгүй бол;

4. эрх ашиг нь хөндөгдсөн этгээдийн шашин болон шашин шүтэх эрх, эрх чөлөө эсхүл шашны нийгэмлэгийн өөртөө засан тохинох эрхээ эдлэх зорилгоор болон тэдгээрт зориулсан (хууль зүйн хэлбэрийг үл харгалзан) байгууламж болон хамтдаа шашин шүтэх, эсхүл тэдний хүндэтгэж буй үзэл санаа, итгэл үнэмшилтэй байхад нь зориулсан байгууллагад нэгдэх нь зөвтгөгдсөн үед шашин, хөгжлийн бэрхшээл, нас, бэлгийн чиг хандлага, эсхүл хүйсээр алагчилах нь зорилго бүхий үндэслэлтэй байвал алагчилсан гэж үзэхгүй.." гэж заасан байдаг.

Дөрөв. Австрали Улс

Австрали Улсад ялгаварлан гадуурхахын эсрэг хууль тогтоомж нь холбооны болон муж улсын түвшинд үйлчлэх бөгөөд олон нийтийн дунд ялгаварлан гадуурхах, дарамт үзүүлэхээс хамгаалахад чиглэсэн байдаг. Холбооны хууль нь муж улсын нутаг дэвсгэрийн хуулиудтай нэгэн зэрэг үйлчлэх хүчин чадалтай байдаг.

Австрали Улсад ялгаварлан гадуурхахын эсрэг Австралийн Хүний Эрхийн Комиссын тухай хууль (1986), Шударга ажлын тухай хууль (2009)-ийг гол хууль болгон авч үздэг бөгөөд Насаар алагчилахгүй байх тухай хууль (2004), Хөгжлийн

[171] "References to particular strands of discrimination" гэдгийг "Алагчилах үзлийн тусгайлсан тохиолдлууд" гэж авч үзэв.

[172] Сүүлд зочилсон: 2019-06-14, https://www.antidiskriminierungsstelle.de/EN/TheAct/theAct_node.html

[173] Тэгш хандах тухай ерөнхий хууль (2006), Сүүлд зочилсон: 2019-06-14, http://www.ilo.org/dyn/natlex/docs/ELECTRONIC/77201/93329/F695840346/DEU77201.pdf

[174] Эрх зүйн үзэл баримтлал: шинэ хандлага, Олон улсын бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Уб., 2012, 51 тал.

бэрхшээлээр алагчилахгүй байх тухай хууль (1992), Арьс өнгөөр алагчилахгүй байх тухай хууль (1975), Хүйсээр алагчилахгүй байх тухай хууль (1984) гэсэн 6 хуулийг Холбооны хэмжээнд дагаж мөрддөг байна.

Харин Австрали улсын нийслэл дэх нутаг дэвсгэрт: Алагчилах үзлийн тухай Акт 1991, Шинэ өмнөд Уэльсийн нутаг дэвсгэрт: Алагчилахын эсрэг Акт (1977), Хойд нутаг дэвсгэрт: Алагчилахын эсрэг Акт (1992), Хатан хааны нутаг дэвсгэрт: Алагчилахын эсрэг Акт (1991), Өмнөд Австралид: Тэгш боломжийн Акт (1984), Тасманид: Ялгаварлахын эсрэг Акт (1998), Викториад: Тэгш боломжийн Акт (2010), Баруун Австралид: Тэгш боломжийн Акт (1984) зэрэг нь муж улсын нутаг дэвсгэрийн тухайд үйлчилдэг байна.

Эдгээр хууль тус бүрээр алагчилах үзлийн шинжүүдийг тусгасан байх бөгөөд нийтлэг "арьс, арьсны өнгө, улс төрийн үзэл баримтлал, үндэстний удам, нийгмийн гарал, нас, эрүүл мэндийн талаарх тэмдэглэл, эрүүгийн гэмт хэрэгтний талаарх тэмдэглэл, гэрлэлтийн болон харилцааны төлөв, аль нэг эрхтний хөгжил сааталтай байх, сэтгэлгээ, оюуны эсхүл сэтгэц мэдрэлийн хөгжлийн бэрхшээл, бие махбодын хөгжлийн бэрхшээл, үндэстэн байх, бэлгийн чиг хандлага болон үйлдвэрчний эвлэлийн үйл ажиллагаа зэрэгт үндэслэн ялгавартай хандах" гэж заасан[175].

Австралийн муж, нутаг дэвсгэрийн түвшний хэмжээнд үйлчилж буй алагчилах үзлийн тухай хуулиудын хэрэгжилтийг муж, нутаг дэвсгэрийн тэгш боломж болон алагчилахгүй байхын эрэг агентлагууд хариуцдаг байна.

Тав. Америкийн Нэгдсэн Улс

АНУ анх удаа 1866 оны Иргэний хуульд[176] тодорхой эрхүүдийг хамгаалах, тэдгээр эрхийг алагчилах үзэл гаргах явдлаас хамгаалах зорилгоор буюу Өмнөдийн эрх чөлөөг олсон хүмүүсийг хамгаалахаар уг хуулийг баталсан байдаг.

Алагчилах үзлийн тухайд АНУ-ын хувьд 1964 оны Иргэний хууль, Хөдөлмөр эрхлэлтэд алагчилах үзэл гаргахын эсрэг хууль ("ADEA"), 1990 оны Хөгжлийн бэрхшээлтэй Америк иргэдийн тухай хууль ("ADA"), 1963 оны Тэгш цалин олгох тухай хууль ("EPA"), 1978 оны Жирэмсэн байдлаар нь алагчилахын эсрэг хууль ("PDA"), 2008 оны Генийн мэдээллээр алагчилахын эсрэг хууль ("GINA")[177] болон бусад мужийн батлагдсан хучин төгөлдөр хуулиар аливаа алагчилах үзэл гаргах явдлаас хамгаалдаг байна.

1964 оны Иргэний хууль болон бусад Холбооны холбогдох хуулиар хүн ам дахь зарим бүлгийн хүмүүсийг "нас, арьс, үндэстний гарал, шашны итгэл үнэмшил, жендэр, хөгжлийн бэрхшээл, жирэмслэлт, ахмад дайчин байсан" зэрэг үндэслэлээр алагчилах үзэл гарган хандахыг хориглодог байна. Мөн мужийн хуулиар жендэрийн байдал, бэлгийн чиг хандлага, улс төрийн үзэл санаа, цэрэг армид алба хаасан байдал зэргээр алагчилах үзэл гаргахын эсрэг хуульчилсан зэрэг шинжүүдийг хууль тус бүрээр зохицуулсан байна. Тухайлбал, насны шинжээр нь хөдөлмөр эрхлэхэд алагчилах үзлийг хориглох заалтад Насаар алагчилах тухай 1975 оны хууль АНУ Код 42, 6101-6107 хэсгийг[178] буюу Холбооноос санхүүгийн туслалцаа авах хөтөлбөр, үйл ажиллагаанд насанд үндэслэн алагчилах үзэл гаргахыг хориглосон жишээг дурдаж болох юм.

---

[175] Насаар алагчилахгүй байх тухай хууль (2004), Хөгжлийн бэрхшээлээр алагчилахгүй байх тухай хууль (1992), Арьс өнгөөр алагчилахгүй байх тухай хууль (1975), Хүйсээр алагчилахгүй байх тухай хууль (1984), Шударга ажлын тухай хууль (2009)-ийн хэрэгжилтийг холбооны хэмжээнд Австралийн Хүний Эрхийн Комисс хариуцдаг.

[176] Michael J. Perry, *The Constitution, the Courts and Human rights*, Wiley Eastern Limited, 1982, P.62

[177] (Title VII and Title II of the Civil Rights Act of 1964) (Age Discrimination in Employment Act) (Americans with Disabilities Act), (Equal Pay Act), (Pregnancy Discrimination Act), (Genetic Information Non-Discrimination Act) Сүүлд зочилсон: 2019-06-14, https://knowledge.leglobal.org/anti-discrimination-laws-in-usa/

[178] https://www.dol.gov/oasam/regs/statutes/age_act.htm Сүүлд зочилсон: 2019-05-08

Зургаа. Колумбын Бүгд Найрамдах Улс

КБНУ нь 1948 оны 5 дугаар сарын 2-ны өдөр хүчин төгөлдөр болсон Хүний эрх үүргийн тухай Америкийн тунхаглалыг[179] баталсан буюу нэгдэн орсон орны нэг юм.

Тус тунхаглалын 2 дугаар зүйлд "Хүн бүр хуулийн өмнө эрх тэгш мөн хүнийг арьс, хүйс, хэл, итгэл үнэмшил болон бусад зүйлээр ялгаварлахгүй энэхүү тунхагт заасан эрхийг эдлэж үүрэг хүлээнэ." гэж шинжүүдийг заасан байна. Мөн КБНУ-ын Конгрессоос 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр баталсан 1482 тоот хуулийн180 1 дүгээр зүйлд "арьс, угсаатны гарал, шашин, үндэстэн, улс төрийн эсхүл философийн үзэл санаа, хүйс, бэлгийн чиг хандлага, хөгжлийн бэрхшээл болон бусад шалтгаанаар алагчилах үзэл гаргасан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд энэ хуулийн зорилт оршино." хэмээн хуульчилжээ.

КБНУ-ын Эрүүгийн кодын II ном, I бүлэг, 2о дугаар зүйлийн "Алагчилах үйлдэл" хэмээх IX дэд бүлэгт 134 А зүйлд "... аливаа хүнийг арьс, үндэстэн, хүйс, бэлгийн чиг хандлагаар алагчилсан эсхүл арьс өнгөний үзэл гаргасан бол буруутай этгээдийг 12, 36 сарын хугацаагаар хорих, 10-15 хүртэлх сарын цалингийн доод хэмжээгээр албадан торгоно" гэсэн заалт, мөн Эрүүгийн кодын 134В дүгээр зүйлд "...алагчилах үзлийг: 1. Олон нийтийн газар, олон нийтэд зориулсан мөн олон нийтэд нээлттэй газарт, 2. Олон нийтийн хэвлэлд, 3. Төрийн албан хаагч үйлдсэн, 4. Уг үйлдэл нь хүүхэд, охид, өсвөр, дунд эргэм насныхан эсхүл насанд хүрсэн этгээдийн эсрэг чиглэсэн бол...." оногдуулах шийтгэлийг нэмэгдүүлэхээр хуульчилсан байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улс НҮБ-д гишүүнээр элссэн нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрч, улмаар «Иргэний болон улс төрийн эрхийн тухай», «Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай» олон улсын пакт зэрэг хүний эрхийн талаарх гэрээ, конвенцоор хүний үндсэн эрх, эрх чөлөөг ямар нэгэн ялгаварлалгүйгээр энх тайвны цагт ч, зэвсэгт мөргөлдөөний үед ч хангаж мөрдөх үүрэгтэй байна.

Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактын хэрэгжилтийн талаарх Монгол Улсын 6 дахь удаагийн ээлжит тайланд Хүний эрхийн хорооноос гарсан дүгнэлттэй холбоотойгоор өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах шаардлагатай эсэхийг судлан үзвэл, манай улсад ялгаварлан гадуурхалт, эрх тэгш байдал, шударга ёсны талаар хууль, тогтоомжид тусгасан хэдий ч зохицуулагдаагүй үлдсэн болон засан сайжруулах шаардлагатай зарим асуудал байх тул, тус харилцааны эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзэх үндэсгүй байна. УИХ болон ЗГ-ын тогтворгүй байдал, ажлын уялдаа, залгамж холбоо алдагдсантай холбоотой хүний эрхийг хангах ажлыг төрөөс зохион байгуулж буй нь хангалттай бус байна. УИХ, ЗГ-ын тогтоол, бусад журмаар зохицуулагдаж байсан харилцаа сүүлийн үед зөвхөн хуулиар зохицуулагдаж, хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар хүлээлгэх болсон нь зарим харилцаа зохицуулалтгүй орхигдох явдал үүссэн байна.

Иймд тусгайлан зохицуулсан, шинэлэг харилцааг зохицуулсан хууль шаардлагатай юм.

Судалгааны 3-р хэсэгт зардал, үр өгөөжийн харьцааг зорилгод хүрэх боломжтой харьцуулан судалсны үндсэн дээр дээрх хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дагавар

Хувилбар 1-ийн хувьд иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэж, төрийн үйлчилгээний чанар,

[179] Ian Brownlie, *Basic documents on Human rights*, II edition, Claredon Press Oxford, 1981, P.382

[180] *LEY 1482 DE 2011 (noviembre 30)*, Сүүлд зочилсон: 2019-05-08, http://www.secretariasenado.gov.co/senado/basedoc/ley_1482_2011.html

үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах нэгдсэн тогтолцоотой болно. Ингэснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшилнэ.

Хувилбар 2-ын хувьд иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээний жишиг зардлыг тогтоож, хүний эрхийг хангах, хамгаалах олон тооны мэргэжлийн байгууллагаас сонгож үйлчлүүлэх, эрхээ хамгаалуулах, одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагын чанар, хүртээмжийг сайжруулах боломж бүрдэнэ. Түүнчлэн улсын төсөвт үзүүлэх зардлын ачааллыг бага байлгах боломжтой.

Гарч болох сөрөг үр дагавар

Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенцийн үзэл баримтлалд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, шударга шүүхээр шүүлгэх, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхээр хангагдах нь хүн бүрийн эдлэх эрх тул үүнийг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэхдээ хууль хоорондын уялдаа холбоог хангаагүйгээс сөрөг үр дагавар үүсэх магадлалтай гэж дүгнэсэн билээ.

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр ялгаварлан гадуурхалтаас ангид эрх тэгш байх үндсэн зарчим хэрэгжих шалтгаан нөхцөл нь эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарладаг, нөгөө талаас хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын үйл ажиллагааны хүрээнд заавал удирдлага болох хууль зүйн эрх, үүрэг, хариуцлага гурав хүн бүрт адил тэгш үйлчилж байдаг.

Төрөөс хүний эрхийг хангах, хамгаалахад тохирох үүрэг, хариуцлагыг ногдуулдаг аливаа төрлийн ялгаварлан гадуурхалтаас ангид байлгах нь эрх тэгш байх үндсэн зарчим бүрэн утгаараа хэрэгжих баталгаа бүрдэх учиртай.

Хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулахад бүрдэл хэсэг тус бүрээр дараах байдлаар авч үзэх саналтай байна:

- Хууль тогтоох болон бүх шатны гүйцэтгэх байгууллага;
- Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх, прокурор, өмгөөлөх мэт хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд;
- Нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг оролцуулан иргэний нийгмийн бүх байгууллага, хөдөлгөөн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл;
- Бүх төрлийн бизнес эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа;
- Хүний эрхийг хангах, хамгаалах ажлын алба, тэдгээртэй адилтгах хэлтэс, нэгж.

Тус байгууллагууд нь хүний эрхийг хангах, хамгаалах, аливаа төрлийн ялгаварлан гадуурхалт гарах байдлыг таслан зогсооход чиглэсэн нарийвчилсан зохицуулалтыг тусгаж өгөх, бүрдэл хэсгийн чадавх, хүний эрхийг сахин биелүүлэх, үүрэг хариуцлагыг тухайлсан хуулийн зохицуулалттай нийцүүлэн тодорхойлох шаардлагатай байна.

Хүний эрхийн үндэсний комисс www.nhrc.mn

НОМ ЗҮЙ

- Ж.Амарсанаа. Хүний эрх /Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал/ Уб.,2000 он.
- Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас, эргэцүүлэл, 2000 он, №7, 103 дахь тал.
- Б.Чимид. Үндсэн хуулийн үзэл баримтлал. Уб., 2017 он. 56 дахь тал.
- Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх /харьцуулсан эрх зүй/ Уб., 1999 он.
- ХБНГУ-н Ханнс Зайделийн сан, Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, 2009 он, 98 дахь тал
- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуультай холбоотой судалгаа, 2004 он, 2 дахь тал.
- Францын 1789 оны “Хүний ба иргэний эрх чөлөөний тунхаглал”-аас
- Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 16 дахь илтгэл. Уб., 2017 он.
- Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн талаарх судалгаа, үр дагаварт хийсэн үнэлгээ. /2018 онд ХЗДХЯ-ны захиалга/.
- Эрх зүйн үзэл баримтлал: шинэ хандлага, Олон улсын бага хурлын илтгэлийн эмхэтгэл, Уб., 2012, 51 тал.
- Ф.Мартенс. Современное международное право цивилизованных народов. Т.1.СПб, 1882, с.327
- Michael J. Perry, The Constitution, the Courts and Human rights, Wiley Eastern Limited, 1982, P.62
- Ian Brownlie, Basic documents on Human rights, II edition, Claredon Press Oxford, 1981, P.382

Цахим эх сурвалж

- Зөрчлийн тухай хууль болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхахын эсрэг зохицуулалтын хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. http://nli.gov.mn/?p=4411 ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН, Уб., 2018 он. /сүүлд үзсэн 2019.06.11/
- Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комисс, 2018 оны үйл ажиллагааны тайлан, 18 дахь тал. http://nhrcm.gov.mn/мэдээ/жил-хагас-жилийн-үйл-ажиллагааны-тайлан/
- World Press Freedom Index, accessed April 1, 2019, https://rsf.org/en/ranking/2018
- Цахим сайтууд дахь үзэн ядах үг хэллэг. /контент анализын судалгаа/ ХБНГУ-ын Фридрих-Эбертийн-Сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар. 2018 он.
- http://library.fes.de/pdf-files/bueros/mongolei/14785.pdf /сүүлд үзсэн 2019.06.11/
- Монгол Улс нэгдсэн үндэстний байгууллагын гишүүн болсон нь. Түүний түүхэн ач холбогдол file:///C:/Users/Turbayar/Downloads/374-Article%20Text-

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

1515-1-10-20150105%20(1).pdf http://www.info.mn/news/5948.htm /сүүлд үзсэн 2019.06.14/

- Жэйм Фитцжералд “EQVAZ RIGHTS TRUST” олон улсын байгууллагын дэд захирал. https://www.youtube.com/watch?v=5HYI62ySPsk /сүүлд үзсэн 2019.06.14/
- Богд хаант Монгол Улсын үед гаалийн түшмэл байсан С.Данзан http://www.info.mn/news/5948.htm /сүүлд үзсэн 2019.06.14/
- http://hdr.undp.org/en/countries
- Монгол Улсын НҮБ–д илгээсэн тайлангууд: http://hdr.undp.org/en/countries/profiles/MNG
- https://www.unicef.org/about/annualreport/files/Mongolia_2017_COAR.pdf
- НҮБ тус конвенцод нэгдсэн улс орнуудын илтгэл, тайлангууд: https://tbinternet.ohchr.org/_layouts/treatybodyexternal/TBSearch.aspx?Lang=en&TreatyID=6&DocTypeID=27 /сүүлд үзсэн 2019.06.17/
- Европын Холбооны мэдэгдэл, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн №73 чуулган 3 дугаар хороо, 2018 /уг мэдэгдэлд Турк, Бүгд Найрамдах Макадони, Монтенегро, Серби, Албани, Босни ба Херцеговина, Украйн, Молдав, Жеоржиа улсууд мөн нэгдэж буйгаа илэрхийлсэн/, сүүлд үзсэн 2019-03-22:
- https://eeas.europa.eu/delegations/un-new-york/52953/eu-statement-%E2%80%93-united-nations-3rd-committee-elimination-racism-racial-discrimination_en
- https://www.gov.uk/guidance/equality-act-2010-guidance
- ИБУИНВУ “Тэгш байдлын хууль” (2010), 13 дүгээр зүйл. https://www.gov.uk/guidance/equality-act-2010-guidance
- “References to particular strands of discrimination” https://www.antidiskriminierungsstelle.de/EN/TheAct/theAct_node.html
- Тэгш хандах тухай Ерөнхий хууль (2006), http://www.ilo.org/dyn/natlex/docs /ELECTRONIC/77201/93329/F695840346/DEU77201.pdf
- https://www.legislation.gov.au/Details/C2019C00132
- https://www.ag.gov.au/RightsAndProtections/HumanRights/Pages/Australias-Anti-Discrimination-Law.aspx ,
- (Title VII and Title II of the Civil Rights Act of 1964) Сүүлд зочилсон: 2019-06-14, https://knowledge.leglobal.org/anti-discrimination-laws-in-usa/
- https://www.dol.gov/oasam/regs/statutes/age_act.htm Сүүлд зочилсон: 2019-05-08,
- LEY 1482 DE 2011 (noviembre 30), Сүүлд зочилсон: 2019-05-08, http://www.secretariasenado.gov.co/senado/basedoc/ley_

Хуулийн үндэсний сан www.legal.gov.mn

ХАВСРАЛТ 1

ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨНИЙ УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
2. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	**1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх**			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	**Тийм**	Үгүй	Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалтыг арилгахад чиглэнэ.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхах байдлыг хуулиар хориглох шаардлагыг тодотгох боломжтой.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол Олон Улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	**Тийм**	Үгүй	Хүний эрхийг зөрчөөгүй төдийгүй олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	**Тийм**	Үгүй	Ялгаварлан гадуурхалт аливаа байдлаар өртөж байсан хүмүүс мөн тэдний ар гэрийн хүмүүсийн саналыг авсан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Аливаа хүн бүрийн тэгш байдлыг хангах, бүгдэд адил боломж хангагдана.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	**Тийм**	Үгүй	Хүний эрхийг хангаж, хамгаалах механизм сайжирна.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын Олон Улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцнэ.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	**Тийм**	**Үгүй**	Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхсан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага оногдуулах саналыг дэвшүүлсэн.
5. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	**Үгүй**	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	**Үгүй**	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.

Хууль зүйн яаманд хүргэлэн www.ali.gov.mn

6. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Иргэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, үндэсний цөөнх, ТББ
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхалтад өртөж буй иргэдийн эрх тэгш байх эрхийг хангахад чиглэсэн.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	**Тийм**	Үгүй	Ялгаварлан гадуурхалтад өртөж буй иргэд нийгмийн харилцаанд адил тэгш оролцох боломжийг хангахад чиглэсэн.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх / хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	**Тийм**	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй харин тэдгээрийн тэгш байдлыг хангах.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Хүний эрхийг хамгаалагч, ТББ, хүний эрхийг хангах төрийн үүрэг хүлээсэн алба хаагчид нэмэлт үүрэг хүлээнэ.
7.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	**Тийм**	Үгүй	Жендэрийн тэгш байдлыг бүрдүүлсэн байна.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Эрх тэгш боломжоор хангагдана.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	**Холбогдох асуултууд**	**Хариулт**		**Тайлбар**
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	**Үгүй**	Энэ чиглэлээр зохицуулалт агуулаагүй.
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	**Тийм**	Үгүй	Аж ахуй нэгжид зардал үүсэх боломжтой.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Тодорхой нэмэлт зардал гарах боломжтой.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	**Тийм**	Үгүй	Шинээр ажлын байр нэмэгдэх боломжтой.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.ri.gov.mn

9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Тодорхой арга хэмжээнд шаардагдах төсвийг улсын төсвөөс гаргах шаардлага гарч болно.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөө үзүүлэх боломжтой.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон Улсын харилцаа	11.1.Монгол Улсын Олон Улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	**Тийм**	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тохирох орон тоо тодорхой хэмжээгээр нэмэгдэж болно
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхтгол бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Ажлын байрны аюулгүй байдлын стандартад тодорхой хэмжээгээр нөлөөлөх боломжтой.
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	**Тийм**	Үгүй	Ажлын ажлын байрны стандарт боловсруулах шаардлага гарч болзошгүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй

Хуулийн үндэсний хүрээлэн www.mli.gov.mn

3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нь нөлөөлөх боломжтой.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	**Тийм**	Үгүй	Албан хаагчдыг хүний эрхийн сургалтад хамруулах шаардлага гарч болох юм.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

Хууль зүйн шинжлэх ухаан www.jl.gov.mn

7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	**Холбогдох асуултууд**	**Хариулт**		**Тайлбар**
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nlt.gov.mn

6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

ХАВСРАЛТ 2

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАХЫН ЭСРЭГ ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХОЛБОГДОХ ТҮҮВЭР СУДАЛГАА

(Хүснэгт 5)

Монгол Улсын хууль тогтоомжид “ялгаварлан” үгийн тусгагдсан байдал

№	Хууль /огноо/	Холбогдох зүйл, заалт
39.	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ /1992-1-13/	Арван дөрөвдүгээр зүйл. 1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна. Арван зургадугаар зүйл. 10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дурааараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;
40.	АХМАД НАСТНЫ ТУХАЙ /2017-1-26/	5 дугаар зүйл. Ахмад настны эрхийг хангахад төрөөс баримтлах зарчим 5.1.1.нийгмийн амьдралд эрх тэгш оролцуулах; 5.1.4.үл ялгаварлах; 6.10.Гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч нь ахмад настныг нийгмээс тусгаарлах, ялгаварлан гадуурхах, нийгмийн харилцаанд оролцоход нь саад учруулах, хязгаарлах, түүнийг хөгжих, асран сувилах үйлчилгээнд хамруулахаас зайлсхийхийг хориглоно.
41.	БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТУХАЙ /2017-07-06/	5 дугаар зүйл.Биеийн тамир, спортын үндсэн зарчим 5.1.4.спортыг ялгаварлан гадуурхалт, шударга бус өрсөлдөөнөөс ангид байлгах.

Хууль зүйн тасгийн хүрээлэн www.jli.gov.mn

42.	БОЛОВСРОЛЫН ТУХАЙ /2006-07-06/	5 дугаар зүйл.Боловсролын үндсэн зарчим 5.1.Боловсролын үндсэн зарчим нь: 5.1.4.иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана; 44 дүгээр зүйл.Багшийн эрх, үүрэг 44.2.Багш дараахь үүрэгтэй: 44.2.4.суралцагчдыг ялгаварлан гадуурхахгүй байх, нэр төрийг нь хүндэтгэн хамгаалах; 44.2.6.суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
43.	ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ /2017-2-02/	40.4.Тусламж үзүүлэгч тал дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 40.4.1.иргэдийг үндэс, угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах;
44.	ГЭР БҮЛИЙН ТУХАЙ /1999-6-11/	4 дүгээр зүйл. Гэрлэлт, гэр бүлийн харилцааны зарчим 4.1.Гэрлэлт нь тэгш эрх, сайн дурын харилцаан дээр үндэслэнэ. 4.2.Иргэнийг гэрлэхэд нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхахыг хориглоно. 25 дугаар зүйл. Хүүхдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах 25.1.Хүүхэд гэр бүлийн дотор тэгш эрх эдэлнэ. 25.2.Гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн болон гэрлэгчдийн хэн нэгний нь дагавар хүүхдийг ялгаварлан гадуурхаж, эрх, ашиг сонирхлыг нь хохироохыг хориглон
45.	ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ /2016-12-22/	4 дүгээр зүйл. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааны зарчим 4.1.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд заасан зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална: 4.1.1.хохирогчийн нэр төрийг хүндэтгэх, үл буруутгах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх; 28.3.Энэ хуулийн үйлчлэлд хамаарах этгээд хүүхэдтэй хүнлэг бус, хэрцгий харьцах, ялгаварлан гадуурхах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, заналхийлэх, хүч хэрэглэх, зодож шийтгэх, тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх, үл хайхрах, хүүхдийн дэргэд архидан согтуурах, мансуурах, хүчирхийлэл үйлдэхийг хориглоно.
46.	ДОНОРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2018-1-19/	12 дугаар зүйл.Донорт тавигдах шаардлага 12.2.Донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
47.	ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ /1994-7-7/	8 дугаар зүйл. Жагсаал, цуглаан болон өлсгөлөн зохион байгуулахыг хориглох 1. Дараахь зорилгоор жагсаал, цуглаан хийхийг хориглоно: 1/ дайн сурталчлах, үндэстэн ястны хооронд хагарал гаргах буюу үндэс угсаа,хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэгээр ялгаварлан гадуурхах, аллага, хядлага, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах;
48.	ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ /2011-2-2/	Бүхэлдээ
49.	ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ /2017-5-18/	5 дугаар зүйл.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд баримтлах зарчим 5.1.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд дараахь зарчмыг баримтална: 5.1.1.үндэсний эв нэгдэл, шударга ёсыг дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх;
50.	ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-5-11/	6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих 8.Хүүхдийг хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан ялгаварлан гадуурхсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хуулийн зүйлийн агуулгаас www.legal.mn

51.	ИРГЭДЭЭС ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТАНД ГАРГАСАН ӨРГӨДӨЛ, ГОМДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /1995-4-17/	8 дугаар зүйл.Өргөдөл, гомдол гаргах зарчим 1.Өргөдөл, гомдол гаргагч өргөдөл, гомдол гаргах эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль, бусад хуулийг зөрчих, бусдын эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироох, ялгаварлан гадуурхахыг уриалж болохгүй.
52.	МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2016-1-07/	6.3.Монголын улаан загалмай нийгэмлэг нь зорилго, чиг үүрэгтээ хамаарах дараах үйл ажиллагааг эрхэлнэ: 6.3.3.гамшиг, осол, зэвсэгт мөргөлдөөн, нийтэд учирсан гамшигт байдлын үед хэнийг ч үл ялгаварлан анхны тусламж, нийгмийн сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх;
53.	ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ /2005-1-27/	8 дугаар зүйл.Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого 8.3.Олон нийтийн радио, телевизээр харгислал, ялгаварлан гадуурхал, дайн, хүчирхийлэл, садар самууныг сурталчилсан, иргэний нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндэд халдсан агуулгатай нэвтрүүлэг бэлтгэж түгээхийг хориглоно.
54.	ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ /1995-11-14/	17 дугаар зүйл.Онцгой арга хэмжээг тогтоох, хэрэглэх хүрээ заагийн хязгаарлалт 1.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино.
55.	СОЁЛЫН ТУХАЙ /1996-4-11/	19 дүгээр зүйл. Соёлын хүрээнд төрийн болон бусад байгууллага, иргэнээс явуулах үйл ажиллагаанд тавих хязгаарлалт 2. Угсаатан ястны соёлыг ялгаварлан гадуурхах, хавчин хязгаарлахыг хориглоно.
56.	СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /2013-1-3/	6 дугаар зүйл.Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаарх иргэн, хуулийн этгээдийн үүрэг 6.1.Хүн амын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, дэмжих талаар хуулийн этгээд дараах үүрэг хүлээнэ: 6.2.2.сэтгэцийн эмгэгтэй хүнийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохыг цээрлэх;
57.	ТӨР, СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ /1993-11-11/	3 дугаар зүйл.Иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө 3.Иргэдийг шашин шүтлэгийн ялгаа болон шашин шүтэх, эс шүтэх байдлаар нь ялгаварлан гадуурхах, доромжлох, хагалан бутаргах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.
58.	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-12-07/	37 дугаар зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүрэг 37.1.Төрийн жинхэнэ албан хаагч дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 37.1.12.төрийн үйлчилгээг чирэгдэлгүйгээр чанартай, хүртээмжтэй, шуурхай, соёлтой хүргэх, төрийн үйлчилгээг хүргэхдээ аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй байх 39 дүгээр зүйл.Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагаанд хориглох зүйл 39.1.12.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 4.1.5, 4.1.6-д заасан хэлбэрээр иргэнийг ялгаварлан гадуурхах;
59.	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ /1997-1-31/	5 дугаар зүйл.Төрийн бус байгууллага байгуулах, оролцох эрх 4.Төрийн бус байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө хүнийг ялгаварлан гадуурхах, эрх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно.

Хүний эрхийн Үндэсний Комисс www.nhrc.mn

60.	УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2005-1-28/	4 дүгээр зүйл.Намын тухай ойлголт 4.2.Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, олон түмнийг үймүүлэх, айлган сүрдүүлэх, аллага, хядлага үйлдэх, яс үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулах зорилгоор, түүнчлэн шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист нам байгуулахыг хориглоно. 5 дугаар зүйл.Намын үйл ажиллагааны зарчим 5.1.3.гишүүддээ намын удирдах байгууллагын төлөөлөлд орох, сонгуульд нэр дэвших, сонгогдоход үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаалаар ялгаварлахгүйгээр адил тэгш боломж олгох; 23.2.Монгол Улсын бүрэн эрхт байдал, тусгаар тогтнолыг бусниулах, үндэсний эв нэгдлийг задлан бутаргах, Үндсэн хуулийн бус аргаар төрийн эрхийг авах, хүч түрэмгийлэх, яс, үндэс, арьсны өнгөөр ялгаварлан гадуурхах, бусад орны тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын эсрэг үйл ажиллагаа, сурталчилгаа явуулсан буюу шашны, цэргийн болон цэрэгжсэн, фашист намын хэлбэрт шилжсэн бол Улсын дээд шүүх намыг тараах тухай шийдвэр гаргаж, уг намыг энэ хуулийн 23.1-д заасан хугацаанд улсын бүртгэлээс хасч, нийтэд мэдээлнэ.
61.	УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ /1998-1-2/	3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо 3.1.2.“улс төрийн хэлмэгдүүлэлт” гэж хүнийг нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нам, төр, нийгэмд аюултай этгээд гэж тооцож, улс төрийн буюу төрийн эсрэг гэх гэмт хэрэгт хууль бусаар холбогдуулж, шүүх тусгай, онцгой бүрэн эрхт комиссын болон нам, төрийн бусад байгууллагын шийдвэрээр баривчлан мөрдөх, эрүүгийн ял шийтгэл эдлүүлэх, шүүхээс гадуур нутаг зааж суулгах, хууль бусаар эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хасах замаар амь нас, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирол учруулсан бөгөөд зохиомол хэрэг, гүтгэлэгт үндэслэсэн албадлагын арга хэмжээг;
62.	ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛҮҮДИЙН ЭРХИЙН ТУХАЙ /1991-4-19/	3 дугаар зүйл.Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх 3.Үйлдвэрчний эвлэлийн гишүүн мөн эсэхтэй холбогдуулан иргэдийн эрх, эрх чөлөөг хязгаарлах буюу тэднийг ялгаварлан гадуурхахыг хориглоно.
63.	ХАДГАЛАМЖ, ЗЭЭЛИЙН ХОРШООНЫ ТУХАЙ /2011-10-27/	4 дүгээр зүйл.Хадгаламж, зээлийн хоршооны үйл ажиллагааны зарчим 4.1.Хадгаламж, зээлийн хоршоо үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална: 4.1.7.ялгаварлан гадуурхахгүй байх;

Хуулийн үйлчлэлтэй ажиллах www.mrt.gov.mn

64.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ /2016-2-05/	4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 4.1.2.“хөгжлийн бэрхшээлээр нь ялгаварлан гадуурхах” гэж хөгжлийн бэрхшээлтэй хүн улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын харилцаанд иргэний үндсэн эрх, эрх чөлөөг бусадтай адил тэгш эдлэх, нийгмийн баялгаас тэгш хүртэх, хөгжилд хувь нэмрээ оруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангагдах боломжийг үгүйсгэх, хязгаарлах үйлдэл, эс үйлдэхүй; 5 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад баримтлах зарчим 5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах, хамгаалахад дараахь зарчмыг баримтална: 5.1.1.хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн амьдралд эрх тэгш оролцоход аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг үл тэвчих; Хоёрдугаар бүлэг: Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш оролцох эрх 6 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг үл ялгаварлан гадуурхах 6.1.Хүн бүр хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байж, үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэн, нийгмийн баялгаас адил хүртэх эрхтэй. Хүнийг хөгжлийн бэрхшээл болон эрүүл мэндийн байдлаар нь ялгаварлан гадуурхахыг хориглоно. 6.2.Түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлээгүй байх, бүрдүүлэхээс татгалзах, нийгмийн үйлчилгээг бусдын адил тэгш хүртэх боломжийг хязгаарлах төрийн байгуулллага, иргэн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ. 6.3.Хөгжлийн бэрхшээлтэй хүний таатай, аюулгүй орчинд амьдрах, сурч боловсрох, шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох, улс төрийн эрхээ эдлэхэд энэ хуулийн 6.2-т заасснаас гадна иргэн, хуулийн этгээдийн дараахь үйлдэл, эс үйлдэхүйг ялгаварлан гадуурхалт гэж үзнэ: Бусад.
65.	ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ /1999-5-14/	7 дугаар зүйл.Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох 7.1.Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй. 7.2.Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно.
66.	ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ /2012-01-19/	4 дүгээр зүйл.Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зарчим 4.1.Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаанд дараах зарчмыг удирдлага болгоно: 4.1.3.ялгаварлан гадуурхахгүй байх;
67.	ХҮНИЙ ДАРХЛАЛ ХОМСДОЛЫН ВИРУСЫН ХАЛДВАР, ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛООС СЭРГИЙЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2012-12-13/	11 дүгээр зүйл.Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний эрхийг хамгаалах 11.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүний эрх, эрх чөлөөг хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой гэсэн үндэслэлээр хязгаарлахыг хориглоно. 11.2.Хүний дархлал хомсдолын вирусын халдвар авсан буюу дархлалын олдмол хомсдолтой хүнийг гутаан доромжлох, ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг хориглоно.
68.	ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ /2016-2-05/	4 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн үндсэн зарчим 4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална: 4.1.1.хүүхдийг ялгаварлан гадуурхахгүй байх;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ МЭДЭЭЛЭН www.legal.gov.mn

69.	ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2012-5-22/	6 дугаар зүйл.Иргэдийн төлөөлөгчөөр сонгогдоход хориглох зүйл 6.2.Иргэдийн төлөөлөгчийг сонгон шалгаруулахдаа үндэс угсаа, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
70.	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /2015-12-03/	14.1 дүгээр зүйл.Ялгаварлан гадуурхах 1.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, эрүүл мэндийн нөхцөл байдлаар ялгаварлан гадуурхаж эрх, эрх чөлөөг нь хязгаарласан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. 19.9 дүгээр зүйл.Үндэсний эв нэгдлийг бусниулах 1.Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон үйлдлийг зохион байгуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. 1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим 2.Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй.
71.	ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-5-18/	1.12 дугаар зүйл.Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх 1.Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 35.18 дугаар зүйл.Гэрч, хохирогчийг хамгаалах 1.Шүүх хуралдааны турш энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасны дагуу гэрч, хохирогчийг хамгаалах арга хэмжээ авахад гэрч, хохирогчийн хувийн байдал, тухайн гэмт хэргийн нөхцөл байдал, ялгаварлан гадуурхах, бэлгийн халдашгүй байдлын эсрэг, хүүхдийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдсэн эсэргийг харгалзана.
72.	ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /2011-5-5/	4 дүгээр зүйл.Эрүүл мэндийн талаар төрөөс баримтлах бодлого, үндсэн зарчим 4.1.Төрөөс хүн амын эрүүл мэндийн талаар дараах бодлогыг хэрэгжүүлнэ: 4.1.2.хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ялгаварлан гадуурхахгүйгээр тэгш, хүртээмжтэй үзүүлэх;
	УИХ-ын тогтоол	
1.	Монгол Улсад хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр /2003-10-24 Дугаар 41/	1992 оны Үндсэн хуульд Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш, эрх зүйн этгээд байх, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхахгүй байх зарчим, хүний салшгүй эрхүүдийг баталгаажуулсан юм.
2.	Үндсэн хуулийн цэцийн 1998 оны 02 тоот дүгнэлтийн тухай /1998-4-17 Дугаар 38/	3.Тухайн сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлого нь амьжиргааны доод түвшингийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлснээс их бол 4О хувиар.”; гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалтыг, Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 5 дахь хэсгийн “Иргэд... өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй гэсэн заалтыг тус тус зөрчжээ” гэж үзсэн Үндсэн хуулийн цэцийн 1998 оны О2 тоот дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.

хууль зүйн үндэсний хүрээлэн www.legalinstitute.mn

3.	Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай /2010-04-22 Дугаар 19/	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2010 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн 01 дүгээр дүгнэлтийн "Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэгт "60-аас дээш настай,…" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг… нас, …-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно", мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх…" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна" гэснийг хүлээн зөвшөөрсүгэй.
4.	Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 07 дугаар дүгнэлтийн тухай /2014-04-10 Дугаар29 /	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1."Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт "Согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн өвчтэй, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно." гэж заасны "… эсхүл хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан …" гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн " ... хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ...ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.", Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтын "... тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ..." гэснийг тус тус зөрчсөн байна." гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 07 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй.
5.	Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 03 дугаар дүгнэлтийн тухай /2014-04-10 Дугаар 29/	Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1."Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7 дахь хэсгийн "... Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна.", Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн "... Давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.", Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй.", Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.", Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын "давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;", Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх ..." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна." гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2014 оны 3 дугаар сарын 12-ны өдрийн 03 дугаар дүгнэлтийг хүлээн зөвшөөрсүгэй. 2.Энэ тогтоолыг 2014 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Хууль зүйн Үндэсний Хүрээлэн www.legal.mn

1.	ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ /НҮБ-ын хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө/ /2016-4-11 Дугаар 204/	108.44. Эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн үүрэг, хариуцлагын талаарх нийгмийн хэвшмэл ойлголтыг өөрчлөх, ялгаварлан гадуурхах уламжлалт зан үйлийг халах арга хэмжээнийхээ үр нөлөөг сайжруулахад чиглэсэн хүчин чармайлтаа нэмэгдүүлэх (Словени) 108.154. Бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг зохицуулсан, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад насны хүмүүсийн эрхийг хамгаалах тодорхой хууль батлах (Турк) 108.86. Гэр бүлийн болон жендэрт суурилсан хүчирхийлэл, эмэгтэйчүүдийг ялгаварлан гадуурхах явдлыг халах чиглэлээр илүү хүчин чармайлт гаргах, 108.20. Ялгаварлан гадуурхахтай тэмцэх цогц хууль тогтоомжийг батлах, ийнхүү батлах хууль тогтоомж, эсхүл одоо байгаа хуулиар тогтоосон тэгш байдлыг бодит амьдралд баталгаажуулах алхмыг авч хэрэгжүүлэх (Ирланд) 108.41. Аливаа шалтгаанаар ялгаварлан гадуурхахтай тэмцэх шинэ хууль тогтоомжийг батлах (Уругвай) 108.50. Арьс үндсээр ялгаварлан гадуурхахыг өдөөн хатгасан үзэн ядах үг хэлэх үйлдэлтэй болон үүнээс улбаатай хүчирхийлэлтэй тэмцэх (Хятад) 108.42. Ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийн эсрэг, түүний дотор хохирогчдын эрхийг хамгаалсан цогц хууль батлах (Бүгд Найрамдах Чех Улс) 108.53. Бэлгийн чиг баримжаа, эсхүл хүйсийн баримжаа, илэрхийлэлд үндэслэсэн ялгаварлан гадуурхалтыг оролцуулан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэртэй тэмцэх (Франц) 108.61. Өмнөх удаа зөвлөмж болгож байсанчлан ялгаварлан гадуурхалтын бүх хэлбэрийг, тэр дундаа хүний дархлал хомсдолын вирус, дархлалын олдмол хомсдолтой гэсэн үндэслэлээр ялгаварлан гадуурхахыг эрс хориглох, гарахаас урьдчилан сэргийлэх, шийтгэх, болон устгах зорилго бүхий хууль тогтоомжийг батлах, үр нөлөөтэй, шуурхай арга хэмжээ авах (Мексик) 108.32. Парисын зарчимд нийцүүлэх зорилгоор Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааг сайжруулах, ялгаварлан гадуурхалтын эсрэг үр нөлөөтэй тэмцэх эрх зүйн орчинг бэхжүүлэх (Нигери) 108.51. Гэр хорооллын дүүргүүдэд амьдарч байгаа хүмүүсийг шууд болон шууд бусаар ялгаварлан гадуурхах явдалтай тэмцэх үр нөлөөтэй арга хэмжээнүүдийг авах (Швед)
2.	НҮБ-ЫН ХҮНИЙ ЭРХИЙН ЗӨВЛӨЛӨӨС ГАРГАСАН ЗӨВЛӨМЖҮҮДИЙГ 2011-2014 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БАТЛАХ ТУХАЙ /2011-5-18 Дугаар 159/	11/Үндэсний хууль тогтоомжийг олон улсын эрх зүйн хэм хэмжээнд нийцүүлэх, олон улсын стандарт, хэм хэмжээг үр дүнтэй хэрэглэх зорилгоор шүүгчид болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулах 19/ Арьс өнгөөр алагчлах бүх хэлбэрийг устгах тухай олон улсын Конвенцид тусгагдсан хувь хүний гомдлыг хянан шийдвэрлэх механизмыг нэвтрүүлэх боломжийг судлах 31/ Эмэгтэйчүүдэд адил тэгш боломж олгоход чиглэсэн бодлого боловсруулах, тэгш хөдөлмөр эрхлэлтийг баталгаажуулах 41/ Бэлгийн чиг хандлага, хүйсийн баримжаагаар алагчлахыг хатуу хориглосон хууль тогтоомж боловсруулан, хэрэгжилтийг хангах 47/ ХДХВ/ДОХ болон аливаа бусад байдлаар алагчлах явдлыг хориглох, устгах, түүнээс урьдчилан сэргийлэх, ийм хэрэг үйлдэгчдийг шийтгэхэд чиглэсэн хууль тогтоомжийн төсөл боловсруулах, шуурхай, үр нөлөөтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх 52/ Хүний эрхийн боловсрол, мэдээллийг олон нийтэд түгээх замаар «ЛГБТ» хүмүүсийг алагчлах үзлийг арилгах, тэдний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх эрхийг хангах гэх зэрэг хүний эрхийг хангах хамгаалахад чиглэсэн ажилуудыг төлөвлөсөн байна.
3.	ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭГ ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ /2019-03-21 Дугаар 111/	Хөгжлийн бэрхшээлтэй болон одой хүнийг ажиллуулах орон тоог аж ахуйн нэгж байгууллагын нийт ажиллагчдын 25 хүн тутамд 1 гэж тооцохдоо ажиллуулаагүй тохиолдолд сар дутамд Улаанбаатар хот, Орхон, Дархан-Уул аймагт тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн хэмжээгээр, бусад аймагт тухайн байгууллагад ажиллагчдын дундаж цалингийн 60 хувиар төлбөр авч хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэхийг төсвийн шууд захирагч нарт үүрэг болгосон байна.

Хууль зүйн цахим хуулбар www.legal.gov.mn

(Хүснэгт 6)

Монгол Улсын хууль тогтоомжид “үзэл бодол” үгийн тусгагдсан байдал

№	Хууль	Холбогдох зүйл, заалт
1.	АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ /2006-07-06/	**28 дугаар зүйл.Улс төрийн баталгаа** 28.2.Авлигатай тэмцэх газрын албан хаагч үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албандаа хүндэтгэлтэй хандана.
2.	БОЛОВСРОЛЫН ТУХАЙ /2006-07-06/	**5 дугаар зүйл.Боловсролын үндсэн зарчим** 5.1.Боловсролын үндсэн зарчим нь: 5.1.4.иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана; **44 дүгээр зүйл.Багшийн эрх, үүрэг** 44.2.Багш дараахь үүрэгтэй: 44.2.6.суралцагчийн бие даасан байр суурь, үзэл бодолд хүндэтгэлтэй хандах;
3.	ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-02-02/	**40 дүгээр зүйл. Олон улсын хүмүүнлэгийн тусламжийн зохицуулалт** 40.4.Тусламж үзүүлэгч тал дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно: 40.4.1.иргэдийг үндэс, угсаа, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах;
4.	ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ /1997-12-19/	**5 дугаар зүйл. Гүйцэтгэх ажил явуулах ерөнхий нөхцөл** Хувь хүний иргэний харьяалал, яс үндэс, хүйс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, ажил, албан тушаалын байдал нь түүний хувьд хуульд заасан үндэслэл журмын дагуу гүйцэтгэх ажил явуулахад саад болохгүй. **14 дүгээр зүйл. Туслагч, туслах ажилтан ажиллуулах** 14.1.Гүйцэтгэх байгууллага нь эрх зүйн чадамжтай энэ хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас бусад хүнийг өөрийн нь зөвшөөрснөөр иргэний харьяалал, үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан туслагч, туслах ажилтнаар ажиллуулж болно.
5.	ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ /1998-5-15/	**26 дугаар зүйл.Хүний эрх, эрх чөлөөний баталгаа** 26.1.Дайны байдлын үеийн үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлахыг хориглоно.
6.	ДОНОРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2018-1-19/	**12 дугаар зүйл.Донорт тавигдах шаардлага** 12.1.Донор нь хүний эрүүл мэндийг хамгаалах, амь насыг аврахад зориулан цус, эс, эд, эрхтнээ өгөхдөө ашгийн төлөө бус, авлагагүй, сайн дурын байна. 12.2.Донорыг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахыг хориглоно.
7.	ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ /1994-7-7/	**Бүхэлдээ**
8.	ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ТУХАЙ /2011-2-2/	**5 дугаар зүйл.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндсэн зарчим, бодлого** 5.1.Жендэрийн эрх тэгш байдал дараахь үндсэн зарчимд тулгуурлана: 5.1.2.ялгаварлан гадуурхахгүй байх зарчим: эрэгтэй, эмэгтэй хүн бүр нас, хүйс, ажил, албан тушаал, үзэл бодол, гэрлэлтийн байдал, боловсролын ялгаа зэргийг үл харгалзан ялгаварлан гадуурхалт, хязгаарлалтгүйгээр хүний эрх, эрх чөлөөг эдлэх;

Хуулийн зүйлийн хүчинтэй эсэх www.mongolcourt.mn

9.	ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ /2017-05-18/	**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно: 4.1.3.“залуучуудын оролцоо” гэж залуучуудын улс төр, эдийн засаг, нийгмийн хөгжил, шийдвэр гаргах түвшинд үзэл бодлоо илэрхийлэх, оролцох үйл явцыг; **5 дугаар зүйл.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд баримтлах зарчим** 5.1.Залуучуудын хөгжил, оролцоог дэмжихэд дараахь зарчмыг баримтална: 5.1.3.залуучуудын үнэлэмжийг нэмэгдүүлж, тэдний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах.
10.	ЗАР СУРТАЛЧИЛГААНЫ ТУХАЙ /2002-5-30/	**7 дугаар зүйл.Хууль бус зар сурталчилгаа** 7.4.Дараахь зар сурталчилгааг ёс суртахуунд үл нийцсэнд тооцно: 7.4.5.үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нийгмийн гарал, байдал, нас, хүйс, мэргэжил боловсрол, шашин шүтлэг, үзэл бодлыг гутаан доромжилсон үг хэллэг, харьцуулалт, дүрслэл зэргийг ашигласан;
11.	ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2016-2-04/	**4 дүгээр зүйл. Шүүхийн өмнө эрх тэгш байх** 4.1.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана
12.	ЗӨВЛӨЛДӨХ САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ /2017-02-09/	**5 дугаар зүйл. Зөвлөлдөх санал асуулгын зарчим** 5.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийг удирдлага болгон зөвлөлдөх санал асуулгыг дараахь зарчмыг баримтлан явуулна: 5.1.1.хууль дээдлэх; 5.1.2.иргэний бодитой, шууд оролцоог хангах; 5.1.3.иргэний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах;
13.	ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /2002-1-10/	**4 дүгээр зүйл.Шүүхийн өмнө эрх тэгш байх** 4.1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх/ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана.
14.	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ /1993-6-5/	**15 дугаар зүйл.Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх** 4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ www.legal.mn

15.	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ /1992-01-13/	**Арван дөрөвдүгээр зүйл.** 1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна. 2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна. **Арван зургадугаар зүйл.** Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ: 10/нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно; 16/итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно; **Арван наймдугаар зүйл.** 4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно. **Арван есдүгээр зүйл.** 1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна. 2.Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө. 3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй.
16.	МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ТУХАЙ /2000-12-07/	**3 дугаар зүйл. Комисс, түүний үйл ажиллагааны зарчим** 3.1. Комисс нь Монгол Улсын Үндсэн хууль, хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөөний тухай заалтын хэрэгжилтэд хяналт тавьж, хүний эрхийг сахин хамгаалах, хөхүүлэн дэмжих байгууллага мөн. **21 дүгээр зүйл. Улс төрийн баталгаа** 21.2. Комиссын гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.
17.	МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2016-1-07/	**6 дугаар зүйл. Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго, чиг үүрэг** 6.1.Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго нь зэвсэгт мөргөлдөөн ба нийтэд учирсан гамшигт байдлын үед хүн амд эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн тусламж үзүүлэхээс гадна хүнийг зовлон зүдгүүрт өртөхөөс сэргийлэх, учирсан зовлон зүдгүүрийг хөнгөвчлөх, шударга ёсны зарчимд үндэслэн хүнийг яс үндэс, иргэний харьяалал, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, боловсролоос үл хамааран хүний аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүмүүнлэг ёсыг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, хүмүүс хоорондын ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагааг дэмжих, энх тайвныг бэхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулахад оршино.
18.	НИЙТИЙН СОНСГОЛЫН ТУХАЙ /2015-07-08/	**3 дугаар зүйл.Үндсэн зарчим** 3.1.Нийтийн сонсголыг зохион байгуулахад ардчилсан ёс, хууль дээдлэх, талуудын оролцоог тэгш хангах, иргэний мэдэх эрх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хангах, үр нөлөөтэй байх зарчмыг удирдлага болгоно

19.	ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ /2005-1-27/	**8 дугаар зүйл.Олон нийтийн радио, телевизийн хөтөлбөрийн бодлого** 8.2.Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараахь бодлого баримтална: 8.2.1.ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүндэтгэх; 8.2.2.улс төр, шашин, нийгэм, эдийн засгийн олон ургальч үзэл бодлыг хүндэтгэж, тэдгээрийг тэгш илэрхийлэх;
20.	ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ /1995-11-14/	**17 дугаар зүйл.Онцгой арга хэмжээг тогтоох, хэрэглэх хүрээ заагийн хязгаарлалт** 1.Энэ хуулийн 5 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн 5, 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээг хэрэгжүүлэх хүрээ зааг нь бий болсон онцгой нөхцөлийн шаардлага, Монгол Улсын олон улсын гэрээгээр хүний эрхийн талаар хүлээсэн үүрэгт нийцэж байхаас гадна хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахад хүргэхгүй байвал зохино.
21.	ПРОКУРОРЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-06-09/	**61 дүгээр зүйл.Улс төрийн баталгаа** 61.1.Прокурор үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөгөө эдлэхдээ өөрийн албан тушаалд хүндэтгэлтэй хандана.
22.	СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ /2006-01-12/	**11 дүгээр зүйл. Хорооны гишүүний бүрэн эрхийн баталгаа** 11.11.Хорооны гишүүн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө эдлэхдээ хашиж буй төрийн албан тушаалдаа хүндэтгэлтэй хандана.
23.	СОНГУУЛИЙН ТУХАЙ /2015-12-25/	**11 дүгээр зүйл.Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрх** 11.1.Сонгуульд сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр оролцох эрхтэй. **76 дугаар зүйл.Сонгуулийн сурталчилгааны үйл ажиллагааны баталгаа** 76.1.Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь энэ хуульд тусгайлан зааснаас гадна доор дурдсан эрх эдэлнэ: 76.1.2.үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх;
24.	СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ /1999-7-1/	**5 дугаар зүйл.Баривчлагдсан, цагдан хоригдсон этгээдийн эрх зүйн байдал** 5.3.Хоригдсон этгээдийн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоос үл хамааран энэ хууль нэгэн адил үйлчилнэ.
25.	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-12-07/	**31 дүгээр зүйл.Хориглох зүйл** 31.4.Төрийн тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангасан иргэний төрийн жинхэнэ албан тушаал эрхлэх эрхийг үндэс, угсаа, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, нам, олон нийтийн бусад байгууллагын харьяаллаар ялгаварлаж үл болно.
26.	ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ /1997-1-31/	**4 дүгээр зүйл.Хуулийн нэр томьёо** Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 1/"төрийн бус байгууллага" гэж иргэд, төрийн байгууллага / хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллага/-аас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг; **5 дугаар зүйл.Төрийн бус байгууллага байгуулах, оролцох эрх** 1.Монгол улсын иргэн, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээд төрийн байгууллагаас зөвшөөрөл авахгүйгээр өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс дангаараа буюу хамтран төрийн бус байгууллага байгуулах эрхтэй.

Хуулийн мэдээлэл www.mn.gov.mn

27.	УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2005-1-28/	**4 дүгээр зүйл.Намын тухай ойлголт** 4.1.Нам нь Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нийгмийн ашиг сонирхол болон хувийн үзэл бодол, улс төрийн үйл ажиллагаа явуулах зорилгын үүднээс сайн дураараа эвлэлдсэн Монгол Улсын иргэдийн нэгдэл мөн. **18 дугаар зүйл.Гишүүний татвар, намд өгөх хандив** 18.2.Гишүүн, дэмжигчид үзэл бодол, итгэл үнэмшлээрээ намыг дэмжин хандив өргөж болно. Хандивыг зөвхөн тухайн шатны намын байгууллагын дансаар дамжуулж авна.
28.	УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ /1998-01-02/	**3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо** 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.2.“улс төрийн хэлмэгдүүлэлт” гэж хүнийг нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан нам, төр, нийгэмд аюултай этгээд гэж тооцож, улс төрийн буюу төрийн эсрэг гэх гэмт хэрэгт хууль бусаар холбогдуулж, шүүх тусгай, онцгой бүрэн эрхт комиссын болон нам, төрийн бусад байгууллагын шийдвэрээр баривчлан мөрдөх, эрүүгийн ял шийтгэл эдлүүлэх, шүүхээс гадуур нутаг зааж суулгах, хууль бусаар эрх, эрх чөлөөг нь хязгаарлах, хасах замаар амь нас, эрүүл мэнд, нэр төр, сэтгэл санаа, эд хөрөнгийн хохирол учруулсан бөгөөд зохиомол хэрэг, гүтгэлэгт үндэслэсэн албадлагын арга хэмжээг;
29.	ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ЭРХИЙН ТУХАЙ /2016-02-05/	**28 дугаар зүйл. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрх** 28.5.Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй холбоотой аливаа бодлого, шийдвэрийг гаргах явцад тэднийг үзэл бодлоо илэрхийлэх боломжоор хангана.
30.	ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2011-06-17/	**4 дүгээр зүйл.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны зарчим, төрийн бодлогын чиглэл** 4.1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд дараах зарчим баримтална: 4.1.1.иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, эрүүл мэндийн байдал, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах;
31.	ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ /1999-05-14/	2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө. Хэвлэх **3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо** 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.14.”албадан хөдөлмөр” гэж хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил, үүргийг; **7 дугаар зүйл.Хөдөлмөрийн харилцаанд ялгаварлал, хязгаарлал, давуу байдал тогтоохыг хориглох** 7.1.Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй. 7.2.Хөдөлмөрийн харилцаанд үндэс, угсаа, арьсны өнгө, нас, эрэгтэй, эмэгтэй, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, боловсрол шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлах, хязгаарлах, давуу байдал тогтоохыг хориглоно. */Энэ хэсэгт 2011 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан/* 7.4.Иргэнийг ажилд авахад эрхлэх ажил, үүргийн онцлогтой холбоогүй тохиолдолд түүний хувийн амьдрал, үзэл бодолтой холбоотой, гэрлэлтийн байдал, намын харьяалал, шүтдэг шашных нь тухай болон жирэмсэн эсэх талаар асуулт тавьж болохгүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ АГУУЛАХ www.legalinfo.mn

32.	ХҮҮХДИЙН ЭРХИЙН ТУХАЙ /2016-02-05/	**4 дүгээр зүйл. Хүүхдийн эрхийн үндсэн зарчим** 4.1.Хүүхдийн эрхийг хамгаалахад дараахь зарчмыг баримтална: 4.1.3.хүүхдийн нас, төлөвшлийн байдлыг харгалзан, түүний үзэл бодолд хүндэтгэлтэй хандах; **5 дугаар зүйл. Хүүхдийн эсэн мэнд амьдрах эрх** 5.3.Хүүхэд эцэг эхтэйгээ амьдрах, тэдний анхаарал халамжид байх, эцэг эхээсээ буюу хэн нэгнээс нь тусдаа амьдрах үед тэдэнтэй байнгын харилцаатай байх, эцэг, эх нь гэрлэлтээ цуцлуулсан, тусдаа амьдрах үед хэнтэй нь амьдрах тухай үзэл бодол, саналаа илэрхийлэх эрхтэй. **6 дугаар зүйл. Хүүхдийн хөгжих эрх** 6.1.Хүүхдийн бие махбодь, оюун санаа, ой ухаан, сэтгэц, зан байдал, харилцаанд гарч байгаа ахиц өөрчлөлтийг хүүхдийн хөгжил гэж үзэх бөгөөд хүүхэд дараахь эрх эдэлнэ: 6.1.5.хүүхэд чөлөөтэй бодож сэтгэх, өөрөө эсхүл бусдаар дамжуулан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах;
33.	ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ /1998-08-28/	**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт** Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино. бүхэлдээ
34.	ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-02-09/	**22 дугаар зүйл. Цагдаагийн байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага** 22.1.Цагдаагийн байгууллага, алба хаагч нь хуулийг чанд сахиж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хүний эрх, эрх чөлөөг хамгаалах үүрэгтэй. **84 дүгээр зүйл. Улс төрийн баталгаа** 84.3.Цагдаагийн алба хаагч үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх, хэвлэн нийтлэх, шашин шүтэх, эс шүтэх эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ албандаа хүндэтгэлтэй хандана. 84.5.Цагдаагийн алба хаагч албан үүргээ гүйцэтгэх үедээ аливаа улс төрийн нам, түүний үйл ажиллагааны талаар хувийн үзэл бодлоо илэрхийлэх, албаны эрх мэдлээ улс төрийн зорилгоор ашиглахыг хориглоно.
35.	ЦЭРГИЙН АЛБАНЫ ТУХАЙ /2016-09-01/	**4 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүрэг** 4.2.Монгол Улсын иргэн нь үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол ялгаварлахгүйгээр цэргийн үүрэг хүлээнэ.
36.	ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-06-09/	**7 дугаар зүйл.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага** 7.1.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, алба хаагч нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэж, үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлахгүйгээр хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүний эрх, эрх чөлөөнд хязгаарлалт тогтоож болно.

Хуулиг зүйнд хүрэхийн www.pdf.mn

37.	ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /Шинэчилсэн найруулга/ /2015-12-03/	**1.3 дугаар зүйл.Шударга ёсны зарчим** 2.Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй. **1.4 дүгээр зүйл.Гэм буруугийн зарчим** 4.Хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй. **10.1 дүгээр зүйл.Хүнийг алах** 2.14.үзэл бодол, арьсны өнгө, үндэс, угсаа, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаагаар нь үзэн ядаж алсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар нь хорих ял шийтгэнэ. **14.3 дугаар зүйл.Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах** 1.Өөрийн, эсхүл бусдын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, тараалгахгүй байхын тулд хэвлэн нийтлэгчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсхүл төлбөр төлж зориуд нийтлүүлээгүй, эсхүл эрх, хууль ёсны ашиг сонирхолд нь нөцтой хор уршиг учруулахаар сүрдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ. */Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* **19.9 дүгээр зүйл.Үндэсний эв нэгдлийг бусниулах** 1.Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, шашны номлол, үзэл бодлоор дайсагнуулах, эвдрэлцүүлэх, салан тусгаарлахыг ухуулсан, уриалсан, ялгаварлан гадуурхсан, хүчирхийлсэн, эрхийг нь хязгаарласан, давуу байдал тогтоосон үйлдлийг зохион байгуулсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. **19.14 дүгээр зүйл.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх** -Үзэл бодол, улс төрийн, шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орогнох эрх олж авахын тулд Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.
38.	ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/ /2017-05-18/	**1.12 дугаар зүйл.Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх** 1.Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, бэлгийн, хүйсийн чиг баримжаа, хөгжлийн бэрхшээл, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхагдахгүйгээр, хуулийн этгээд бүр хөрөнгө, орлого, үйл ажиллагааны чиглэл, зохион байгуулалтын хэлбэрээс үл хамааран хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.
Улсын Их Хурлын тогтоол		
1.	УЛС ТӨРИЙН ҮЗЭЛ БОДЛООР НЬ ЯЛГАВАРЛАН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫГ АЖЛААС НЬ ХАЛАХ, ӨӨРЧЛӨХ АЛДАА ЗАВХАРЛЫГ ЗОГСООХ ТУХАЙ ТОГТООЛЫН ТӨСӨЛ БУЦААХ /2002-05-16/ Дугаар 17	2000 оны Улсын Их Хурлын сонгуулиас хойш улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан төрийн албан хаагчдыг ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхрал гарсан гэж үзэх үндэслэл байхгүй тул Улсын Их Хурлын гишүүн Л.Гүндалай, Ж.Наранцацралт нарын өргөн мэдүүлсэн “Улс төрийн үзэл бодлоор нь ялгаварлан төрийн албан хаагчдыг ажлаас нь халах, өөрчлөх алдаа завхарлыг зогсоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг төсөл санаачлагчид нь буцаасугай.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦ www.legal.mn

2.	ЦАХИМ БОДЛОГЫН ТҮР ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ /2018-05-24/ Дугаар 38	1.Төрийн алба, үйлчилгээг шуурхай, ил тод, хэмнэлттэй болгох, төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ, системийг сайжруулах, иргэний мэдээлэл авах, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө болон түүний хувийн мэдээллийн өгөгдлийн нууцыг хамгаалах, цахим мэдээллийн аюулгүй байдлыг хангах, мэдээлэл, харилцаа холбооны технологид суурилсан үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний мэдээллийн дэд бүтцийг хамгаалах чадавх бий болгох, энэ чиглэлээр мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, цахим бодлогын асуудлыг судалж, санал боловсруулах үүрэг бүхий Цахим бодлогын түр хороог дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай: /нийт 25 гишүүн/
3.	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БАТЛАХ ТУХАЙ /2010-7-15/ Дугаар 48	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3 дугаар бүлгийн 3.6.4.1 дэх хэсэгт “.Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түүгээр эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагддаг.”

(Хүснэгт 7)

Монгол Улсын хуулиудад “шударга ёс” тусгагдсан байдал

№	Хууль /огноо/	Холбогдох зүйл, заалт
1.	**МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ /1992/**	**Монголын ард түмэн бид**: **...**шударга ёс**... эрхэмлэн дээдэлж**... **эх орондоо хүмүүнлэг**, **иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно**. **Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна**. **Нэгдүгээр зүйл**. 2. Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн. **Арван хоёрдугаар зүйл.** 2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ. **Арван наймдугаар зүйл**. 4. Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргавал Монгол Улсад орогнох эрх олгож болно.
2.	**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ /2006/**	3 **дугаар зүйл**. **Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим** 3.1.Улсын Их Хурлын үйл ажиллагааны үндсэн зарчим бол Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ёсоор ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.
3.	**МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ /2012/**	4 **дүгээр зүйл.Шүүхийн эрхэм зорилго** 4.1.3.хууль дээдлэх, шударга ёс**,** ардчилсан ёсыг бэхжүүлэх; 8 **дугаар зүйл.Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй**, **ил тод байх** 8.4.Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ ил тод байдал, шударга ёс**,** олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулах бөгөөд иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг хуулиар тогтооно.
4.	**МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2004/**	4 **дүгээр зүйл**. **Яамны үйл ажиллагааны зарчим** 4.1.Яамны үйл ажиллагааны үндсэн зарчим нь ардчилсан ёс, шударга ёс**,** эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх явдал мөн.

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЙН ХҮРЭЭЛЭН ШИНЖИЛГЭЭ

5	**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ /2017/**	7 **дугаар зүйл.Төрийн албаны зарчим** 7.1.Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараахь зарчмыг баримтална:
6.	**ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2012/**	3 **дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт** 3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно: 3.1.1.шүүгч гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, хууль ёс, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг сахиулан хамгаалахаар тангараг өргөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг; 4 **дүгээр зүйл.Шүүгчид тавих болзол**, **шаардлага** 4.1.Шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна: 4.1.5.мэргэжлийн ёс зүйгээ ухамсарласан, шударга ёсыг эрхэмлэдэг, хүний эрхийг дээдлэх, бусдын нөлөөнд автахгүй, бие даасан шийдвэр гаргах чадвартай; 16 **дугаар зүйл.Шүүгчийн тангараг**, **түүнийг өргөх журам** 16.1.Шүүгч томилогдсон өдрөөсөө хойш 30 хоногийн дотор хамт олон болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийн өмнө "Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан тангараглая. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч хуульд заасан хариуцлага хүлээнэ." гэж Төрийн сүлдэнд тангараг өргөнө. 31 **дүгээр зүйл.Шүүгчид хүлээлгэх хариуцлага** 31.1.Шүүгч зөвхөн хуульд захирагдах, шударга ёсны зарчим болон шүүгчийн ёс зүйг санаатай буюу болгоомжгүйгээр зөрчсөн бол холбогдох сахилгын болон хуульд заасны дагуу хариуцлага хүлээнэ.
7.	**ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2012/**	6 **дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах зарчим** 6.2.Хуульч нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалж, шударга ёсыг хангана. 7 **дугаар зүйл.Хуульчийн мэргэжлийн шалгалт** 7.2.Хуульчийн шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд тэгш эрх, шударга ёсыг хангах, ил тод байх, хууль дээдлэх, олон нийтийн итгэлийг даах, хараат бус байх зарчмыг баримтална. 23 **дугаар зүйл.Хуульчийн тангараг** 23.1.Хуульч хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авснаас хойш 30 хоногийн дотор "Хуульч би Монгол Улсын Үндсэн хуулийг даган мөрдөж, хуульчийн үүрэг, мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрмийг чанд сахиж, шударга ёсыг хамгаалагчийн хувьд иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг бүрэн, тууштай хамгаалахаа батлан тангаргалъя. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ" гэж Хуульчдын холбоонд тангараг өргөнө. 56 **дугаар зүйл.Хуульчдын эрх**, **хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах асуудал эрхэлсэн хороо** 56.3.Хуульчдын эрхийг хамгаалах хороо нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих замаар хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хангах чиг үүрэгтэй байна.
8.	**НОТАРИАТЫН ТУХАЙ /2011/**	3 **дугаар зүйл.Нотариатын зарчим** 3.1.4.шударга ёсыг сахих;
9.	**ГАЗРЫН ТУХАЙ /2002/**	4 **дүгээр зүйл.Төрөөс газрын талаар баримтлах зарчим** 4.1.3.газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёс, тэгш байдлыг хангах;
10.	**ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ /1997/**	4 **дүгээр зүйл**. **Гүйцэтгэх ажлын зарчим** Гүйцэтгэх ажилд үндэсний болон нийгэм, төр, иргэний аюулгүй байдлыг хангах, хууль дээдлэх, шударга ёс, тэгш байдал, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, шуурхай, тасралтгүй байх, нууц хамгаалах зарчмыг удирдлага болгоно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ www.ulsiin.gov.mn

11.	**ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ /2017/**	5 **дугаар зүйл.Залуучуудын хөгжил**, **оролцоог дэмжихэд баримтлах зарчим** 5.1.1.үндэсний эв нэгдэл, шударга ёсыг дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх;
12.	**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ /2017/**	1.1 **дүгээр зүйл.Хуулийн зорилго** 1.Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино. 1.3 **дугаар зүйл.Шударга ёсны зарчим** 1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байна. 2.Энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна. 3.1 **дүгээр зүйл.Шийтгэл оногдуулах үндэслэл** 1.Шийтгэлийн зорилго нь хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх, шударга ёсыг тогтооход оршино.
13.	**ЭРҮҮГИЙН ХУУЛЬ /2015/**	1.3 **дугаар зүйл.Шударга ёсны зарчим** 1.Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байна. */Энэ хэсгийг 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөн найруулсан/* 2.Гэмт хэрэгт тооцох, ял оногдуулахад хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй байдлаар ялгаварлан гадуурхахгүй. 3.Гэмт хэрэг үйлдсэн хүнд өөрт нь эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Эрүүгийн хариуцлагыг бусад хүнд халдаан хэрэглэж болохгүй. */Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* 4.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдсэн хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь хуулийн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. */Энэ хэсэгт 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан/* 5.Нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна. 9.7 **дугаар зүйл.Хуулийн этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлага гарцаагүй байх** 3.Хуулийн этгээдэд энэ зүйлийн 1.3-т зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх нь эрүүгийн хариуцлагын зорилгыг хангах боломжгүй, шударга ёсны зарчимд нийцэхгүй бол шүүгч гэмт хэрэг үйлдэгдэх үед тухайн гэмт хэрэгт холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байсан хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. 19.14 **дүгээр зүйл.Монгол Улсын хилийг хууль бусаар нэвтрэх** 1.Монгол Улсад орох, гарах хил нэвтрэх эрхийн баримт бичиггүйгээр, эсхүл хуурамч баримт бичгээр, эсхүл зохих зөвшөөрөлгүйгээр Монгол Улсын хилийг нэвтэрсэн бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Тайлбар: -Үзэл бодол, улс төрийн, шударга ёсны бусад үйл ажиллагааны улмаас хавчигдан мөшгигдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсад орогнох эрх олж авахын тулд Монгол Улсын хил нэвтэрсэн бол энэ гэмт хэргийг үйлдсэнд тооцохгүй.

Хууль зүйн яаманд хүргэлдэн www.mojha.gov.mn

14.	**ИРГЭНИЙ ХУУЛЬ /2002/**	193 **дугаар зүйл**. **Үүргийн гүйцэтгэлийг тодорхойлох** 193.1.Үүрэг гүйцэтгэх арга, хэлбэр, журмыг гэрээний аль нэг тал буюу гуравдагч этгээд тодорхойлсон нь нөгөө талд буюу талуудад эргэлзээ төрүүлэхээр бол шударга ёсны зарчимд нийцүүлэн харилцан хүсэл зоригоо илэрхийлэх замаар шийдвэрлэнэ. 193.2.Үүрэг гүйцэтгэх арга, хэлбэр, журмыг тодорхойлсон нь шударга ёсны зарчимд нийцээгүй, эсхүл үүргийн гүйцэтгэлийг тодорхойлохыг хэт удаашруулж байна гэж аль нэг тал нь үзвэл арбитрын хэлэлцээртэй бол арбитрын журмаар, бусад тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлэхээр хандах эрхтэй. 202 **дугаар зүйл**. **Стандарт нөхцөл хүчин төгөлдөр бус байх** 202.1.Стандарт нөхцөлийг гэрээнд тусгасан ч тэр нь харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш, уг нөхцөлийг хүлээн зөвшөөрөгч нөгөө талдаа хохиролтой бол уг нөхцөл хүчин төгөлдөр бус байна. Энэ тохиолдолд стандарт нөхцөлийг гэрээнд тусгах болсон нөхцөл байдал, талуудын ашиг сонирхол болон бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ. 488 **дугаар зүйл**. **Дундын өмчийг ашиглах, удирдах** 488.2.Олонхийн шийдвэр буюу хэлцлээр өөрөөр тогтоогүй бол дундаа хэсгээр өмчлөгч бүр шударга ёсны дагуу бусад өмчлөгчдийн ашиг сонирхолд нийцүүлэн ашиглалт болон удирдлагын талаар шаардлага гаргах эрхтэй.
15.	**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУХАЙ /1993/**	15 **дугаар зүйл.Ерөнхийлөгчийн бусад бүрэн эрх** 4.Үзэл бодол, улс төрийн хийгээд шударга ёсны бусад үйл ажиллагааныхаа улмаас хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэн, харьяалалгүй хүн үндэслэл бүхий хүсэлт гаргасан тохиолдолд Монгол Улсад орогнох эрх олгох асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.
16.	**МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ /2006/**	8 **дугаар зүйл**. **Удирдлагын үндсэн зарчим** 8.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага нь нутгийн өөрөө удирдах ёсыг төрийн удирдлагатай хослуулах үндсэн дээр нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие даан зохион байгуулж үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчим баримтална.
17.	**ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /1993/**	9 **дүгээр зүйл**. **Хот, тосгоны удирдлагын үндсэн зарчим** Хот, тосгоны удирдлага нь үйл ажиллагаандаа ардчилсан ёс, шударга ёс, хууль дээдлэх болон оршин суугчдын ашиг сонирхлыг чөлөөлөх үндсэн зарчим баримтална.
18.	**ГААЛИЙН ТУХАЙ /2008/**	273 **дугаар зүйл**. **Гаалийн улсын байцаагч** 273.4.Гаалийн улсын байцаагч нь “Гаалийн улсын байцаагч би, Монгол Улсын тусгаар тогтнол, эдийн засгийн аюулгүй байдлыг хангахын төлөө үнэнчээр зүтгэж, гаалийн хяналт, бүрдүүлэлт хийхдээ хууль, шударга ёсыг дээдлэн, гаалийн улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хэний ч нөлөөнд үл автахаа батлан тангараглая. Өргөсөн тангарагаас няцвал төрийн хуулийн хариуцлага хүлээнэ” гэсэн тангаргийг гаалийн улсын байцаагчийн эрх авахад өргөнө.
19.	**ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2010/**	41 **дүгээр зүйл.Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч**, **түүний бүрэн эрх**, **баталгаа** 41.4.Улсын байцаагч нь “Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч би, Монгол Улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлыг хангахын төлөө үнэнчээр зүтгэж, гадаадын иргэн болон түүний баримт бичигт хяналт, шалгалт хийхдээ хүний эрх, хууль, шударга ёсыг дээдлэн, улсын байцаагчийн ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, хэний ч нөлөөнд үл автахаа батлан тангараглая. Өргөсөн тангаргаас няцвал төрийн хуулийн цээрлэл хүлээнэ” гэсэн тангараг өргөнө.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jni.gov.mn

20.	**СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /2015/**	5 **дугаар зүйл.Сонгуулийн үйл ажиллагааг зохион байгуулахад баримтлах зарчим** 5.1.3.шударга ёсыг сахих; 126 **дугаар зүйл.Нам**, **эвслээс нэр дэвшүүлэх** 126.5.Нам, эвсэл нэр дэвшүүлэхдээ нэр дэвшүүлэх нийтлэг журмаас гадна дор дурдсан журмыг баримтална: 126.5.1.нэр дэвшүүлэхдээ тухайн хүний Улсын Их Хурлын гишүүн байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, эх орон, ард түмний тусын тулд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэх төгс эрмэлзэл, шударга ёс, хууль дээдлэх ёс, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадварыг харгалзан үзэх; 140 **дүгээр зүйл.Нам дангаар нэр дэвшүүлэх** 140.2.1.тухайн хүний Ерөнхийлөгч байх мэдлэг, боловсрол, туршлага, ур чадвар, эх орон, ард түмний тусын тулд оюун ухаан, хүч хөдөлмөрөө зориулж, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг хамгаалан бэхжүүлэх төгс эрмэлзэл, шударга ёс, хууль дээдлэх ёс, Ерөнхийлөгчийн ёс зүйн хэм хэмжээг сахин биелүүлэх чадварыг харгалзан үзэх;
21.	**УЛС ТӨРИЙН НАМЫН ТУХАЙ /2005/**	5 **дугаар зүйл.Намын үйл ажиллагааны зарчим** 5.1.1.ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнолыг хангах, нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлэх;
22.	**ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ /2003/**	3 **дугаар зүйл.Төрийн аудитын үндсэн зарчим** 3.1.Төрийн аудит нь хууль дээдлэх, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх, төрийн аудитын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандартад нийцсэн байна. 7 **дугаар зүйл.Үндэсний аудитын газар** 7.5.Монгол Улсын Ерөнхий аудитор төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд шударга ёсыг сахиулах үүднээс ёс зүйн дүрэм баталж мөрдүүлнэ.
23.	**ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2012/**	3 **дугаар зүйл.Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх** 3.4.Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанаас өмнө хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бусаар шийдвэрлэхээ батлан тангараглана.
24.	**МОНГОЛЫН УЛААН ЗАГАЛМАЙ НИЙГЭМЛЭГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /2016/**	6 **дугаар зүйл**. **Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго**, **чиг үүрэг** 6.1.Монголын улаан загалмай нийгэмлэгийн зорилго нь зэвсэгт мөргөлдөөн ба нийтэд учирсан гамшигт байдлын үед хүн амд эрүүл мэнд, нийгэм, сэтгэл зүйн тусламж үзүүлэхээс гадна хүнийг зовлон зүдгүүрт өртөхөөс сэргийлэх, учирсан зовлон зүдгүүрийг хөнгөвчлөх, шударга ёсны зарчимд үндэслэн хүнийг яс үндэс, иргэний харьяалал, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, шашин шүтлэг, улс төрийн үзэл бодол, боловсролоос үл хамааран хүний аюулгүй байдал, амь нас, эрүүл мэндийг хамгаалах, хүмүүнлэг ёсыг хангахад дэмжлэг туслалцаа үзүүлэх, хүмүүс хоорондын ойлголцол, нөхөрлөл, хамтын ажиллагааг дэмжих, энх тайвныг бэхжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулахад оршино.
25.	**ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ /2005/**	8 **дугаар зүйл.Олон нийтийн радио**, **телевизийн хөтөлбөрийн бодлого** 8.2.Олон нийтийн радио, телевиз хөтөлбөрөө бэлтгэж түгээхдээ дараахь бодлого баримтална: 8.2.1.ардчилал, шударга ёс, хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хүндэтгэх;
26.	**ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ /1994/**	2 **дугаар зүйл**. **Төрийн бэлгэ тэмдэг** 2. Төрийн сүлд, туг, далбаа, дуулал нь Монголын ард түмний түүхэн уламжлал, хүсэл тэмүүлэл, эв нэгдэл, шударга ёс, цог хийморийг илэрхийлнэ.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.mjs.gov.mn

ХАВСРАЛТ 3

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭР

(Хүснэгт 8)

1.	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль, Ашигт малтмалын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2007-6-13/ Дугаар 07	“Улсын Их Хурлаас 2001 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсгийн “Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Ашигт малтмалын тухай хуулийн 43.1-д заасан хувиас илүү хэмжээгээр гадаадын иргэдийг авч ажиллуулсан тохиолдолд мөн хуулийн 43.2-т заасан хэмжээний төлбөрийг сар тутам төлнө”, мөн 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын иргэдийг ажлын байраар хангах үүрэг хүлээх бөгөөд тухайн хуулийн этгээдэд ажиллагсдын 10-аас дээшгүй хувь нь гадаадын иргэн байж болно”, 43.2 дахь хэсгийн “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь гадаадын иргэдийг энэ хуулийн 43.1-д зааснаас илүү хэмжээгээр авч ажиллуулсан тохиолдолд ажлын байр тутамд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төлбөрийг сар бүр төлнө” гэсэн заалтууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “…шударга ёс, …тэгш байдал,…ийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцлөөр хангуулах, ...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.
2.	Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар бүлгийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт, Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104, 105, 146 дугаар тогтоол Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай Маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /1996-5-29/ Дугаар 4	Монгол Улсын Засгийн газрын 1995 оны 104, 105 дугаар тогтоолууд гарч 1995 оны 1 дүгээр сарын 1-нээс өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэврийг нэмэгдүүлэхдээ 1997 онд хүрсэн байвал зохих хэмжээг тогтоов. Монгол Улсын Засгийн газрын 104 дүгээр тогтоолд зааснаар 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгогчид 1997 онд сард 7200-14400 төгрөгийн тэтгэвэртэй болох юм. Энэ нь 1995 оноос хойш тэтгэвэр тогтоолгогчдоос даруй 2-4 дахин бага байхаар тогтоогджээ. Энэхүү утгаар нь үзэхэд Улсын Их Хурлын 1994 оны 60, 61 дүгээр тогтоол, Засгийн газрын 1995 оны 104, 105 дугаар тогтоолууд нь тэтгэврийн насны иргэдийг 1995 оноос өмнөх ба хойшхи гэх мэт хугацаагаар ялгаварлан өөр өөр хэмжээтэй тэтгэвэр тогтоож, иргэд хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх тухай Монгол Улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн байна.
3.	Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2015-6-10/ Дугаар 10	Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12 дахь хэсгийн “Банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч, түүний холбогдох этгээд өөр банкны саналын эрхтэй нөлөө бүхий хувьцаа эзэмшигч байхыг хориглоно.” гэж заасан нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” Арван зургадугаар зүйлийн 4/ дэх хэсгийн “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ...хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. ...” гэсэн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРААНГУЙ

4.	Банкны тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2010-06-30/ Дугаар 03	Иргэн Д.Ламжав мэдээлэлдээ Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3, 36.4, 36.7, 36.11, 36.12 дахь хэсгүүд нь банкны хувьцаа эзэмшигчийн болон бусад этгээдийн өмчлөх эрхийг ноцтой хязгаарлаж, тэдгээрийг ялгаварлан гадуурхаж, эрх зүйн байдлыг үндэслэлгүйгээр дордуулан, улмаар тэгш эрхийн зарчмыг зөрчиж байгаа нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, ...Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалттай нийцэхгүй байна гэж үзжээ.
5.	Банкны тухай хуулийн зарим зүйл заалт Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 3, 14; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /Дүгнэлт/ /1998-1-28/ Дугаар 01	Банкны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 1, 2 дугаар заалт бүхэлдээ Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2-ын “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.Хүн бүр хууль зүйн этгээд байна”, 16 дугаар зүйлийн 14-т байгаа “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах ... эрхтэй” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байх тул хянан үзэж, хэлэлцэж өгнө үү” гэжээ.
6.	Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг болон 40.1.1, 40.1.2 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2010-11-10/ Дугаар 06	Хүүхдэд олгох тэтгэлэгийг тогтоохдоо нас харгалзсан нь үндэслэл муутайн дээр уг заалт нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалсан хууль зүйн орчин болж чадсангүй. Хүүхдийн амьжиргааны зардлыг насаар нь ялгавартай тогтоосон нь бодит байдалд нийцэхгүйн зэрэгцээ насаар нь алагчилсан хууль зүйн орчныг бий болгосон байна. Үүнээс үзвэл хуулийн энэ заалт нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “ Хүнийг ...нас...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасныг зөрчиж байна
7.	Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсгийн заалт Үндсэн Хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2010-03-24/ Дугаар 01	“Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэсэн заалтыг 1999 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдаад одоо мөрдөж байгаа Монгол Улсын Гэр бүлийн тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь хэсэг зөрчсөн байна.
8.	Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын Хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /Дүгнэлт/ /1996-03-27/ Дугаар 01	1. Жагсаал, цуглаан хийх журмын тухай Монгол Улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 3-ын 5-д буй “Жагсаал, цуглааныг зохион байгуулагч нь сэтгэцийн өвчтэй хүмүүсийг жагсаал цуглаанд оролцуулахгүй байх үүрэг хүлээнэ” гэсэн заалт нь иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 26 дугаар зүйлийн “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй. Энэ утгаар аливаа төрлийн ялгаварлан гадуурхлыг хуулиар хориглосон байх ёстой бөгөөд хуулиар бүх хүн ямар ч шинж тэмдгээр тухайлбал арьс-үндэс, арьс-өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн байдал буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахын эсрэг тэгш, үр нөлөөтэй хамгаалалтыг баталгаатай болгоно” гэсэн заалтыг; мөн пактын 2 дугаар зүйлийн 1-ийн “Энэхүү пактад оролцогч улс бүр нутаг дэвсгэртээ болон эрх мэдэлдээ байгаа бүх хүний энэхүү пактаар хүлээн зөвшөөрсөн эрхийг арьс-үндэс, арьс-өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу бусад үзэл бодол, үндэсний буюу нийгмийн гарал, эд хөрөнгийн байдал, төрсөн буюу бусад нөхцөл байдлаар ялгаварлахгүйгээр хүндэтгэн хангах үүрэгтэй” гэсэн заалтыг тус тус зөрчиж тухайлбал бусад нөхцөл гэсэнд хамаарах эрүүл мэндийн байдлаар ялгаварлан гадуурхаж байгаа учраас Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2-ын “Монгол Улс, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэсэн заалтыг зөрчиж байна.

Хууль зүйн Үндэсний Сургууль www.num.edu.mn

9.	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2007-4-18/ Дугаар 04	Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх хэсгийн “алтны үнийн өсөлтийн нэмэгдэл орлого” гэж дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хассаны дараа үлдсэн орлогыг, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 3.1.1-д заасан бүтээгдэхүүнд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо дэлхийн зах зээлийн үнийг харгалзан Монголбанкнаас зарласан 1 унци алтны үнээс 500 ам.долларыг хасч тооцно” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн “шударга ёс, ..., тэгш байдал, ...-ийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсгийн “шударга ёс, ..., тэгш байдал, ...-ийг хангах нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн” гэсэн заалт нь ижил бөгөөд харьцуулж болохуйц нөхцөлтэйгээр эрх зүйн харилцаанд оролцогчдод алагчлалгүй хандах, ялгаварлан гадуурхахгүй байх, адилхан эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг төрийн зүгээс бүрдүүлэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа явуулна гэсэн агуулгатай байдаг. Энэ ч үүднээс “Тэгш байдал нь төр харъяат субъектүүдээ хууль болон шүүхийн өмнө адилхан эрх эдэлж, үүрэг хүлээх боломжийг хангахад үйл ажиллагаагаа бүрэн чиглүүлснээр хэрэгжинэ”
10.	Засгийн газрын “журам батлах тухай” 2005 оны 208 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2006-12-20/ Дугаар 13	Уг тогтоол Биеийн тамир, спортын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4, 22 дугаар зүйлийн 22.2.1 дэх заалтуудыг засварлаж өөрчилсөн байдалтай гарсан нь “Хуульд өөрчлөлт оруулах тухай” Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалтыг Засгийн газар зөрчсөн шинж чанартай байна. Мөн олимпийн наадамд ордог, ордоггүй гэдэг хандлага байдлаар спортын салбарынхныг эрхэлсэн ажил, сонгосон спортын төрлөөр нь ялгаварлан үзэх байдал бий болгосон нь олимпод ордоггүй спортын төрлийнхний хувьд сонирхлынхоо дагуу спортын төрлөө сонгон хөдөлмөрлөх, үр шимийг нь үзэх, хөдөлмөрөө үнэлүүлэх тэдний хууль ёсны эрхийг хязгаарлаж “эрхэлсэн ажил, мэргэжлээрээ ялгаварлагдан гадуурхагдахгүй байх” тухай Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2, “Ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрлөх аятай нөхцлөөр хангагдах, хөдөлмөрөө үнэлүүлэх” тухай Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4 дэх заалтуудыг тус тус зөрчиж байна
11.	Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2005-6-17/ Дугаар 04	“Монгол Улсын төр, засаг минь иргэн биднийгээ тэтгэвэрт гарсан он, нас, хүйсээр нь ялгаварлан гадуурхаж 1995 оноос өмнө тэтгэврээ тогтоолгосон иргэдийн тэтгэврийн мөнгийг дутуу олгож 10 жилийн турш бие сэтгэлийн хүнд дарамт учруулж хохироож байна. 1995 оноос өмнө нийт 250 мянган иргэд тэтгэвэр тогтоолгож тэтгэврээ дутуу авч олон тэрбум төгрөгөөр хохирсон төдийгүй тэднээс энэ хугацаанд 170 мянга нь хорвоог орхин одсон бөгөөд одоо 80 хүрэхгүй мянга нь үлджээ. Өөрөөр хэлбэл жилд 17000, сард 1510, хоногт 47-48, цагт 2 тэтгэвэр авагч насан эцэслэж байна. Засгийн газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоёрдугаар бүлгийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг зөрчиж байгааг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээр хуулийн дагуу хэлэлцэж зохих дүгнэлт гарган шийдвэрлэж өгөхийг хүсч байна.” гэжээ.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ www.mojus.gov.mn

12.	Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2011-12-27/ Дугаар 05	Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дугаар зүйлээр нөхөх олговрын үнэлгээг тооцоолон тогтоож, тогтоосон хэмжээний нөхөх олговрыг олгохоос өмнө олборлох эрх бүхий этгээдийг "...уурхайн хаалт, нөхөн сэргээлт, байгаль орчны мониторингоос бусад үйл ажиллагааг..." тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайд явуулахыг хориглосон нь бодит байдалд олборлох эрх буюу тусгай зөвшөөрлийг цуцалснаас өөрцгүй үр дагаврыг бий болгож байх бөгөөд ингэснээрээ Засгийн газар өөрт нь хуулиар ногдуулсан үүргийг "зөрчиж гүйцэтгэсэн", Үндсэн хуулийн дээрх зүйл, заалтуудыг зөрчсөн үйл ажиллагаа болжээ. Засгийн газрын 2010 оны 299 дүгээр тогтоолын 3 дугаар зүйл нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 болон 3, Арван зургадугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 болон 2, Нэгдүгээр зүйлийн 2, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг тус тус зөрчсөн болохыг тогтоолгох шаардлагыг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргаж байна" гэжээ
13.	Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн Хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2005-3-31/ Дугаар 02	1.Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан үзэхээр зааж, уг хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заасан нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1, 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн. 2. Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.6-д Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрийг захиргааны актад тооцож уг хуулийн 8.1.2-т заасны дагуу Захиргааны хэргийн шүүх хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ нь Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтыг зөрчсөн байна.
14.	Захиргааны Хэрэг Хянан Шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн Хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2006-1-25/ Дугаар 01	"Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1.2-ын ".../Ерөнхий сайд/... " гэсэн хэсэгт Монгол Улсын Засгийн газраас гаргасан захиргааны актыг Захиргааны хэргийн шүүх магадлан хянаад, тус хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заажээ. Энэ заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн" гэсэн 38 дугаар зүйлийн 1, "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэсэн 45 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг тус тус зөрчиж байна.
15.	Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2017-11-29/ Дугаар 07	Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "... хөгжлийн бэрхшээлтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.", мөн зүйлийн 3 дахь хэсгийн "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, ... -ийн өмнө эрх тэгш байна...", 2 дахь хэсгийн "Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.", Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын "... өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс ... сайн дурааараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. ...", 16 дахь заалтын "... тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, ..." гэснийг тус тус зөрчсөн байх тул хянан хэлэлцэж дүгнэлт гаргаж өгнө үү." гэжээ.

Хуулийн этгээдийн мэдээлэл www.ikh.gov.mn

16.	Иргэн Г.Алтан, иргэн Ө.Мөнхтуяа, иргэн Д.Ламжав нараас компанийн тухай Монгол Улсын хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 58 дугаар зүйл, 67 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 83 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 98 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2002-06-26/ Дугаар 03	Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”; Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно”; Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “… хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Монгол Улсын иргэн энэхүү үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”; Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц хууль зүйн баталгааг бүрдүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна”, 2 дахь хэсгийн “Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно”, 3 дахь хэсгийн “Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож болохгүй” гэсэн заалтуудыг зөрчсөн, “ 2002 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөлдөө Компанийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчиж байгаа тухай нэхэмжлэл гаргасан билээ. Энэхүү өргөдөлд дурдсан нэхэмжлэлтэй хамтатган “Компанийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 4, 67 дугаар зүйлийн 1 дэх заалт өргөдөлд иш татсан Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван есдүгээр 3 дахь хэсгийн заалтыг зөрчиж байна”, “Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 1, 2; 87 дугаар зүйлийн 2; 93 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтууд Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална”; Аравдугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ”; Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “ ...хүн бүр хууль, шүүхийн өмнө тэгш эрхтэй байна”, 2 дахь хэсгийн “Хүнийг хөрөнгө чинээгээр ньялгаварлан гадуурхаж үл болно”; Арван зургадугаар зүйлийн 3 дахь хэсгийн “… хөдлөх, үл хөдлөх хөрөнгө өмчлөх эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Монгол Улсын иргэн энэхүү үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ”; Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг зөрчсөн байна гэжээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ АКАДЕМИ
WWW.LAW.EDU.MN

17.	Иргэний хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 154.4, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2006-4-12/ Дугаар 04	Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3-т “барьцааны зүйл нь бусдын өмчлөлийн хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэж, Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.4-т “барьцааны зүйл нь ирээдүйд бий болох хөрөнгө байж болно. Энэ тохиолдолд тухайн хөрөнгө бий болж, барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ” гэж, .Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.3-т “үүрэг гүйцэтгэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар шүүхэд, эсхүл шүүхийн бус журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана” гэсэн нь нэгдүгээрт иргэний эрх зүйн талуудын тэгш эрхийн зарчим, хоёрдугаар, “хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэсэн Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д заасан зарчим, гуравдугаарт, Үндсэн хуулийн Дөчин долдугаар зүйлийн 2-т заасан “шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно”, дөрөвдүгээрт, Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дүгээр хэсэг буюу “эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... шудрага шүүхээр шүүлгэх... эрхтэй” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна
18.	Иргэний хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3, 174 дүгээр зүйлийн 174.2, 174.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай / Тогтоол/ /2006-6-15/ Дугаар 02	Монгол Улсын Иргэний хуулийн 154 дүгээр зүйлийн 154.3 дахь заалтын “...Энэ тохиолдолд тухайн хөрөнгө барьцаалуулагчийн өмчлөлд шилжсэнээр барьцаагаар хангагдах шаардлага үүснэ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т заасан “Хөдлөх, үл хөдлөх хөрөнгө... өмчлөх...эрхтэй” гэснийг, Иргэний хуулийн 174 дүгээр зүйлийн 174.2 дахь заалтын “...Барьцаалагч нь банк, эсхүл банк бус санхүүгийн байгууллага бол энэ заалт хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна” гэснийг, 174.3 дахь заалт “Үүрэг гүйцэтгүүлэгч нь банк, банк бус санхүүгийн байгууллага бол ипотекийн зүйлийг шүүхийн журмаар худалдан борлуулахаар хуульд заасан журмын дагуу бүртгэлийн байгууллагад хүсэлтээ гаргана. Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулахад энэ хуулийн 175.5 -175.7, 176, 177 дугаар зүйл хамаарахгүй” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандөрөвдүгээр зүйлийн 1-д заасан “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, Арванзургадугаар зүйлийн 14-д заасан “...эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ...шударга шүүхээр шүүлгэх...эрхтэй”, Арвандөрөвдүгээр зүйлийн 2-т заасан “...хөрөнгө чинээгээр ялгаварлан гадуурхаж үл болно”, Дөчиндолдугаар зүйлийн 1-д заасан “...шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ”, Дөчиндолдугаар зүйлийн 2-т заасан “...шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно” гэснийг тус тус зөрчсөн байна гэжээ

Хуулийн хүрээлэн www.ecs.mn

19.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4, 32 дугаар зүйлийн 4 дэх заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай / Дүгнэлт/ /2004-04-21/ Дугаар 01	2002 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр батлагдаж, 2002 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж, үйлчилж эхэлсэн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 114 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт: "Хэргийг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байхад 3 шүүгч гурван өөр санал гаргавал шүүх хуралдаан даргалагчийн саналаар шийдвэр гаргаж, эсрэг саналтай хоёр шүүгчийн саналыг бичгээр авч шийдвэрт хавсаргана" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг зөрчиж байна, Мөн хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт: "Эрх зүйн бүрэн чадамжтай иргэн сайн дураараа гэр бүлийн гишүүн, төрөл садангаараа, эсхүл гэрээний үндсэн дээр өмгөөлөгчөөр төлөөлүүлж болно" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14 дэх хэсгүүдэд заасан заалтуудыг зөрчиж байна.333 Иймд, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: "Прокурор төрийн ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд… төрийн нэрийн өмнөөс оролцоно" гэж төрийн байгууллага, албан тушаалтанд өмгөөлөгч бус хүнээр /прокуророор/ эрх ашгаа хамгаалуулж болохоор заасан хэрнээ иргэн хүнд өмгөөлөгч бус хүнээр эрх ашгаа хамгаалуулах боломжийг олгоогүй байгаа нь бас л иргэний албан тушаалтнаас доогуур тавьж, хууль, шүүхийн өмнө ялгаварлан гадуурхаж байгаа хэрэг билээ гээд, иймд Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн заалтыг зөрчсөн Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хүчингүй болгож өгнө үү гэжээ.
20.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх /хойшид ИХШХШ гэх/ тухай хууль болон прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн заалт зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2003-04-30/ Дугаар 01	2002 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас батлан гаргасан Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны тухай Монгол Улсын хуулийн 31 дүгээр зүйл 31.1 заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2; Дөчин есдүгээр зүйлийн 1,2; Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт мөн хуулийн 170 дугаар зүйл 170.3 заалт Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12, 14, Арван есдүгээр зүйл 1, 2 дахь хэсгийн заалтуудыг тус тус зөрчсөн байна. Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл 1.2 "хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байх, хүнийг эрхэлсэн ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхахгүй байх", Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 2 "төр, ...бусад байгууллагын албан тушаалтан иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

www.ccpr.mn

21.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1.5 дахь заалт, 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2018-02-02/ Дугаар 02	1/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 67 дугаар зүйлд "67.1.5. хариуцагчийн хөрөнгө, орлого, эд хөрөнгийн эрхийн талаар холбогдох байгууллагаас тодорхойлолт, лавлагаа авах." гэсэн заалт нэмэлтээр оруулж, уг ажиллагаа хийх үүргийг шүүгчид хүлээлгэсэн байна.. Нэхэмжлэгчийн нэхэмжлэлдээ дурдсан этгээдийг "хариуцагч" гэж үздэг бөгөөд хариуцагчаар оролцох иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгууллага, төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага, олон улсын байгууллага аль нь ч байсан "хэдий хэмжээний хөрөнгө, орлоготой, эсхүл хөрөнгө орлогогүй" байхаас үл хамааран шүүх иргэний хэргийг хянан шийдвэрлэх учиртай. Гэтэл "хариуцагч" гэж үзэж буй этгээдийнхээ хөрөнгө, орлогын мэдээллийг шүүхээр гаргуулах давуу байдлыг нэхэмжлэгчид хуулиар олгож байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөрөг үр дагавар үүсгэхийг үгүйсгэхгүй бөгөөд энэ нь Үндсэн хуулийн "... хөрөнгө чинээ, ... гээр нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэж заасантай нийцэхээргүй байна. 2/ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт өөрчлөлт оруулжээ. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлд шүүхээс гарах шийдвэрийн агуулгад тавигдах, нөхцөл шаардлагыг хуулиар тогтоож өгсөн байдаг. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн тухай хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар "Иргэний шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг баталгаажуулах арга хэмжээ"-нд 17 төрлийн ажиллагааг хамруулсан байх бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн байгууллага нь дээрх ажиллагааг хуулиар тогтоосон арга, журмын дагуу хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ хуулийн 20 дугаар зүйлийн 20.3, 20.5 дахь хэсэг нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 118 дугаар зүйлийн 118.5 дахь хэсэгт орсон өөрчлөлттэй шууд холбоотой бөгөөд энэ нь Үндсэн хуулийн "Шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлэх" гэж заасныг зөрчсөн гэж үзэхээр байгааг дурдах нь зүйтэй гэжээ.
22.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "энэ нь Улсын дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай /2002-6-05/ Дугаар 01/	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй "Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн заалтын дараа "Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх", Дөчин есдүгээр зүйлийн 1-ийн "шүүгч хараат бус байх" заалтыг тус тус зөрчсөн байна" гэжээ
23.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2; 184 дүгээр зүйлийн 5; 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2002-04-03/ Дугаар 01	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 177 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт, 184 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөнийг хянан үзээд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт буй "Анхан шатны болон давж заалдах, хяналтын журмаар хэргийг хянаж шийдвэрлэхэд оролцсон шүүгч уг хэргийг өөр шатны журмаар хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй гэсэн заалтын дараа "Энэ нь Улсын Дээд шүүхийн хяналтын шүүх хуралдаанд үл хамаарна" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн "...шударга шүүхээр шүүлгэх", Дөчин есдүгээр зүйлийн 1-д заасан "шүүгч хараат бус байх" заалтыг тус тус зөрчсөн байна, харин хуулийн 177 дугаар зүйлийн 2, 184 дүгээр зүйлийн 5 дахь заалтууд, Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1, 2; Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгүүдийг зөрчөөгүй байна гэжээ.

Хүний эрхийн үндэсний комисс www.nhrc.gov.mn

24.	Компанийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2012-10-10/ Дугаар 04	Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.11, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 30 дугаар зүйлийн 30.1, 33 дугаар зүйлийн 33.7, 84 дүгээр зүйлийн 84.1, 84.10 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2, 3, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 4, 17 дахь заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн эсэх тухай
25.	Компанийн тухай хуулийн зарим заалтууд Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг дахин хянан шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2002-11-13/ Дугаар 03	Компанийн тухай хуулийн 58 дугаар зүйл нь миний үзэж байгаагаар Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2; Арван дөрөвдүгээр зүйлийн 2; Арван зургадугаар зүйлийн 3; Арван есдүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтуудыг зөрчиж байна. Компанийн тухай Монгол Улсын хуулийн 83 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Компанийн энгийн хувьцааны нэг ба түүнээс дээш хувийг эзэмшигч нь компанийн эрх бүхий албан тушаалтнаар компанид учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй"; 87 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн Компанийн энгийн хувьцааны нэгээс дээш хувь эзэмшигч болон компанийг төлөөлөх эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 87 дугаар зүйлийн 1-д заасан хариуцлага хүлээлгэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй, Хуулийн 35 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, хуулийн 83 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, хуулийн 98 дугаар зүйлийн 3 дахь хэсэг нь "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө тэгш эрхтэй байна"; "Хүнийг ... хөрөнгө чинээгээр нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэжээ.
26.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /1996-12-02/ Дугаар 09	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 10 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэгт заасан "дахин нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан нөхцөлд дээд шатны Засаг дарга доод шатны Засаг даргыг, Ерөнхий сайд аймаг, нийслэлийн Засаг даргыг тухайн шатны Хуралтай зөвшилцөн томилно" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт буй "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна" гэснийг, хуулийн 16 дугаар зүйлийн 9-т "хүн бүр шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй" гэж тогтоосныг, хуулийн 1 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт "Ардчилсан ёс ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг, хуулийн 60 дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт "Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд ... томилно" гэж заасныг, уулийн 16 дугаар зүйлийн 10-т "Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийгялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэжээ.
27.	Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 92 дугаар тогтоол, 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 153 дугаар тогтоолын холбогдох заалт Үндсэн хуулийн зарим заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2014-1-22/ Дугаар 02	Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 92 дугаар тогтоол, 2012 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн 153 дугаар тогтоолын 2 дахь хэсгийн в/ заалт Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.", Арван зургадугаар зүйлийн 5/ дахь заалтад "өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй" гэснийг зөрчсөн тухай.

28.	Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 22 дугаар тогтоолын зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2005-12-14/ Дугаар 02	“Засгийн газраас 2005 оны 2 дугаар сарын 2-ны өдөр баталсан “Итгэлцүүрийг шинэчлэн тогтоох, тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 22 дугаар тогтоолын 2 дахь хэсэгт “1998 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хугацааны тэтгэвэр тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг 120000 төгрөгөөр тогтоосугай” гэж заасан нь тэтгэврийн насны иргэдийг 1998 оноос өмнө, хойно гэж хоёр хувааж ялгавартай хандсан, Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна” гэжээ.
29.	Монгол Улсын Засгийн Газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2006-2-22/ Дугаар 02	Засгийн газар нь 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг хэрэгжүүлснээс гарах үр дагаврыг шийдвэрлээгүй юм. Энэ нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь заалт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэсэн заалтыг зөрчлөө. Иймд Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт, түүнийг гаргахтай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурсан заалтуудыг зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү” гэжээ.
30.	Монгол Улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх /хойшид ИХШХШ гэх/ тухай хууль болон прокурорын байгууллагын тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2003-06-20/ Дугаар 02	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 170 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “…энэ хуулийн 20.2; 38.9; 65.1.3; 65.1.6; 65.1.10 дахь …зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргахгүй” гэсэн заалт, мөн Прокурорын байгууллагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор төрийн байгууллагын хүсэлтээр иргэний хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд зохигчийн төлөөлөгчөөр оролцож, өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ” гэсэн заалтын “…өмгөөлөгчийн бүрэн эрх эдэлнэ” гэсэн хэсэг, мөн хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Прокурор энэ хуулийн 16.1-д заасан ажиллагаанд оролцохдоо Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 25, 34 дүгээр зүйлд заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ” гэсэн заалтын “…34 дүгээр” гэсэн хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх хэсгийн “Монгол Улсын иргэн …шударга шүүхээр шүүлгэх …шүүхийн шийдвэрийг давж заалдах …эрхтэй”, Тавин зургадугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна.
31.	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай / 2018-8-22/ Дугаар 10	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал, ... боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...”, Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад “... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ...”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж тус тус заасныг зөрчсөн байна гэжээ.

ХУУЛЬ ЗҮЙН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ www.legal.mn

32.	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 62 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай /2018-11-30/ Дугаар 03	Монгол Улсын Их Хурлын 2018 оны 6 дугаар сарын 28-ны өдөр батлан гаргасан "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 42 дугаар тойрогт нөхөн сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай" 62 дугаар тогтоол нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "... шударга ёс, ... тэгш байдал, ... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.", Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ... -р нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...", Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад ... сонгогдох эрхтэй. ...", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.", Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Үндсэн хуульд ... төрийн байгууллагын бусад шийдвэр ... бүрнээ нийцсэн байвал зохино." гэж заасныг зөрчсөн байна
33.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2015-9-30/ Дугаар 12	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэгт "Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна." гэж заасны "...бусад төрийн албан хаагч..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэснийг зөрчсөн байна гэжээ.
34.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн нам, эвслийг бүртгэхээс татгалзах үндэслэлийг заасан 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалтын "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", мөн зүйлийн 10/ дахь заалтын "...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно..." гэснийг тус тус зөрчсөн байна гэжээ.
35.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2010-1-22/ Дугаар 01	2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3.6 дахь заалтад "өмнөх сонгуулийн зардлын тайланг энэ хуулийн 42.2-т заасны дагуу Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлээгүй бол" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9/ дэх заалтын "...Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", мөн зүйлийн 10/ дахь заалтын "...Аль нэгэн нам, ...гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно..." гэснийг тус тус зөрчсөн байна гэжээ.
36.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж, эцэслэн шийдвэрлэсэн тухай /2015-11-27/ Дугаар 10	Монгол Улсын Их Хурал 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.6 дахь хэсгийн "Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч," гэснийг "Төрийн жинхэнэ албан хаагч болон төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалтан," гэж өөрчилж Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 12 дугаар дүгнэлтийн үндэслэлийн агуулгад нийцүүлсэн

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЛЫН ГИШҮҮН www.legal.mn

37.	Монгол Улсын Их Хурлын songуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2012-05-02/ Дугаар 03	Монгол Улсын Их Хурлын songуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9-д "Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан songуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын songуулийн эвсэл /цаашид "нам, эвсэл" гэх/-ийн жагсаалтаас тус тус songono." гэсэн заалт оруулснаас үүдэн уг хуульд 6.7.2, 27.5.4, 48.2, 48.7, 49.1.1, 49.1.2, 49.1.3, 49.1.7, 49.2 гэсэн зохицуулалтуудыг хийжээ. Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн songож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.", Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т "Хүнийг...эрхэлсэн ажил, ... үзэл бодол, -оор ньялгаварлан гадуурхаж үл болно...", Арван зургадугаар зүйлийн 9-д "... Төрийн байгууллагад songох, songогдох эрхтэй...", Арван зургадугаар зүйлийн 16-д "итгэл үнэмшилтэй байх, ... эрх чөлөөтэй...", Хорин нэгдүгээр зүйлийн 2-т "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын songуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд songох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар songono.", Хорин гуравдугаар зүйлийн 1-д "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална." гэсэн заалттай тус тус зөрчилдсөн байна гэжээ.
38.	Монгол Улсын Их Хурлын songуулийн тухай хуулийн зарим зүйл, заалтын холбогдох хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2012-03-28/ Дугаар 02	Монгол Улсын Их Хурлын songуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.9-д "Энэ хуулийн 27.1-д заасан нэрийн жагсаалтын эхний 48-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан songуулийн 26 тойргоос, 28-аас илүүгүй нэр дэвшигчийг энэ хуулийн 49.1.6-д заасны дагуу гаргасан улс төрийн нам буюу улс төрийн намуудын songуулийн эвсэл /цаашид "нам, эвсэл" гэх/-ийн жагсаалтаас тус тус songono." гэсэн заалт оруулснаас үүдэн уг хуульд 6.7.2, 27.5.4, 48.2, 48.7, 49.1.1, 49.1.2, 49.1.3, 49.1.7, 49.2 гэсэн зохицуулалтуудыг хийжээ. Эдгээр нь Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1-д "Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн songож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.", Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т "Хүнийг... эрхэлсэн ажил, ...үзэл бодол, -оор ньялгаварлан гадуурхаж үл болно...", Арван зургадугаар зүйлийн 9-д "...Төрийн байгууллагад songох, songогдох эрхтэй...", Арван зургадугаар зүйлийн 16-д "итгэл үнэмшилтэй байх, ...эрх чөлөөтэй...", Хорин нэгдүгээр зүйлийн 2-т "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын songуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд songох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар songono.", Хорин гуравдугаар зүйлийн 1-д "Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална." гэсэн заалттай тус тус зөрчилдсөн байна гэжээ.

www.ulsiin.gov.mn

39.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн холбогдох заалтууд Үндсэн хууль зөрчсөн эсэхийг хянан хэлэлцсэн тухай /1993-12-22/ Дугаар 04	Улсын Бага Хурлаас 1992 оны 4 дүгээр сарын 4-нд батлагдсан Монгол Улсын Их хурлын сонгуулийн хуульд сонгогчдын эрх тэгш байх, чөлөөтэйгөөр сонгох эрхийг алдагдуулан Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчив, 1994 онд сонгуулийн хууль Үндсэн хуультай харшилж байгаа эсэх, Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрх хууль ёсны эсэх талаар ард нийтийн санал асуулга явуулж өгөхийг хүссэн нь Үндсэн хуулийн Цэцийн шийдэх эрх хэмжээний асуудал биш, Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн зарим заалт, 33, 35, 36, 38 дугаар зүйлийн зарим заалтууд боловсронгуй бус байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 4-т буй Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно гэсэн заалтын хүрээнд хуульчлагдсан тул Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралтын хуулийн нэгдүгээр зүйлийн 2-ын 2 дахь заалтаар Улсын Бага Хуралд олгогдсон хууль тогтоох эрх хэмжээнд шийдвэрлэгдсэн байна гэжээ.
40.	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2011-10-21/ Дугаар 03	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна.”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал... -аар нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэснийг тус тус зөрчсөн гэжээ.
41.	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол/ /2012-02-15/ Дугаар 02	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад “гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан;” гэж заасан нь Үндсэн хуулийн Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. ...”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно. ...” гэснийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэж, хянан хэлэлцсэн байна.
42.	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн эсэх тухай маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай / Тогтоол/ /2009-5-27/ Дугаар 02	2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хурлаас баталсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “Онцгой албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн хүснэгтийн … 5 дахь заалтын “Импортоор авсан бараа”-нд хамаарах “0.20” гэснийг “0.35” гэж …өөрчилсүгэй” гэж эх орны үйлдвэрийн болон импортын литр пиво тутамд онцгой албан татварыг ялгавартайгаар ногдуулахаар хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн 2/03 дугаар дүгнэлтийн дагуу хүчингүй болсон Онцгой албан татварын тухай хуулийн заалтыг дахин сэргээсэн байх тул 2009 оны 3 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн 1 дүгээр зүйлийн “…5 дахь заалтын “Импортоор авсан бараа”-нд хамаарах “0.20” гэснийг “0.35” гэж” өөрчилсөн хэсгийг хүчингүй болгох тухай.

Хуулийн үнэн зөвлөгөө www.legal.mn

43.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг дахин хянаж эцэслэн шийдвэрлэсэн тухай /2016-11-16/ Дугаар 05	Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт "... энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.", Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ." гэснийг зөрчсөн байна гэжээ.
44.	Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2016-09-28/ Дугаар 10	Монгол Улсын Их Хурлаас 2012 оны 3 дугаар сарын 7-ны өдөр баталсан Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт "... энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт ..." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.", Тавин хоёрдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна гэжээ.
45.	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл, түүний тайлбар нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2008-4-16/ Дугаар 05	Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйл, түүний тайлбар нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1-д "…Хүнийг …үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхаж үл болно…", Арван зургадугаар зүйлийн 9-д "…Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй", Арван зургадугаар зүйлийн 10-т "…аль нэг нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно", Арван зургадугаар зүйлийн 13-т "халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. …Мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно", Арван зургадугаар зүйлийн 14-д "Монгол Улсын олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно.", Арван зургадугаар зүйлийн 18-д "Улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй" Хорин есдүгээр зүйлийн 2-т "Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална" гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэжээ.
46.	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн зарим заалт Монгол Улсын хууль зөрчсөн эсэх тухай /Дүгнэлт/ /1998-2-24/ Дугаар 02	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 1997 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуулийн 1 дүгээр зүйлд буй заалтууд Монгол УлсынҮндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг … ажил, албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж үл болно" гэсэн заалтыг; мөн хуулийн 16 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "Иргэд … өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд мөнгөний тусламж авах эрхтэй" гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэжээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭС www.legal.mn

47.	Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2007-01-10/ Дугаар 01	Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн /цаашид НӨАТ гэх/ 9 дүгээр зүйлийн 9.3-д “Жилийн 10.0 сая ба түүнээс доош төгрөгийн татвар ноогдох борлуулалтын орлоготой үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлнө. Энэ заалт импортлогчдод хамаарахгүй” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна”, Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчиж байна гэжээ.
48.	Онцгой албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль, Үндсэн хуулийн хавсралт хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /2005-04-13/ Дугаар 03	Дэлхийн худалдааны байгууллагын Тариф, худалдааны ерөнхий хэлэлцээрийн удиртгал хэсгийн “Тариф болон худалдааны бусад саад тотгорыг багасгах, түүнчилэн олон улсын худалдаан дахь ялгаварлан гадуурхах явдлыг арилгахад чиглэсэн адил тэгш нөхцөл бүхий харилцан ашигтай тохиролцоонд хүрэх” гэсэн заалт болон 1 дүгээр зүйлийн “Үндэсний нэн тааламжтай нөхцөл”, 3 дугаар зүйлийн “Дотоодын татвар ногдуулалт болон зохицуулалтын үндэсний нөхцөл”-ийг зөрчсөн байна
49.	Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуультай холбогдсон маргааныг хянан хэлэлцсэн тухай /Дүгнэлт / /1996-10-30/ Дугаар 08	Өршөөл үзүүлэхдээ ингэж “60-аас дээш насны эрэгтэйчүүд” гэсэн хязгаар тогтоож байгаа явдал нь Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд заагдсан “Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн “хүнийг ... нас хүйсээр нь ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн заалт, 16 дугаар зүйлийн 11-д заагдсан “Улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй”, “гэр бүл, эх нялхас хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэсэн заалтуудыг Монгол Улсын Их Хурлын 1996 оны 8 дугаар сарын 28-ны өдрийн тогтоол зөрчиж байна гэжээ.
50.	Сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2018 оны 49 дүгээр тогтоол, 2019 оны 22, 23 дугаар тогтоол Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2019-5-27/ Дугаар 02	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.3 дахь заалт нь “өөр ажилд шилжих”, “хүндэтгэн үзэх бусад шалтгаан” гэсэн хоёр нөхцөлийг шаардаж байна. Гэтэл Д.Гантулга гишүүн нь өөр ажилд шилжих болсон талаар хүсэлтдээ дурдаагүй, дараа нь томилогдоогүй. Мөн түүний чөлөөлөгдөхийг хүссэн өргөдөлд “хүндэтгэн үзэх шалтгаан”-ы талаар огт дурдаагүйгээс гадна нотлох баримт хавсаргаагүй тул хүндэтгэн үзэх ямар нэг шалтгаан бүрдээгүй байна. ... Тэгэхээр хүндэтгэн үзэх шалтгаан байхгүй байхад түүнийг чөлөөлсөн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “... хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн гэжээ.

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛЛЭГ ХЭЛЭЛЦЭЭ www.ubs.mn

51.	Сонгуулийн тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.5 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2016-09-21/ Дугаар 09	Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Сонгуулийн тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.5 дахь хэсэгт "Нэр дэвшигчдийн нэрийн жагсаалтаас хасагдсаны улмаас дахин сонгууль явагдсан бол хасагдсан нэр дэвшигч хүн зургаан жилийн хугацаанд сонгуульд нэр дэвших болон төрийн албанд томилогдох, сонгогдох эрхээ алдах ба урьд явагдсан сонгуулийн сурталчилгааны болон зохион байгуулалтын бүх зардлыг нөхөн төлөх үүрэгтэй" гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ", Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... эрхэлсэн ажил, албан тушаал ...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно ..." гэснийг тус тус зөрчсөн.
52.	Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийн зохицуулалтаар Цэцийн 2010 оны 01 дүгээр тогтоолоор хүчингүй болсон холбогдох хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг эцэслэн хянан шийдвэрлэсэн тухай / 2019-1-16/ Дугаар 01	Сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсэгт "Хуульд заасан хугацаанд сонгуулийн зардлын тайлангаа ирүүлээгүй бол тухайн нам, эвсэл, нэр дэвшигчийг дараагийн сонгуульд бүртгэхгүй." гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх заалтад "... Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. ...", мөн зүйлийн 10 дахь заалтад "... Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. ...", мөн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэсэн хэм хэмжээг тус тус зөрчсөн гэж үзсэн байна.
53.	Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн зарим заалт Үндсэн хууль зөрчсөн тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /1994-01-12/ Дугаар 02	"Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол Улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ" гэсэн нь Үндсэн хуулийн 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалт, 2 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг тус тус зөрчиж байна гэжээ.
54.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь заалт үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай / Дүгнэлт/ /2006-9-20/ Дугаар 09	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дугаар заалтад тусгасан хязгаарлалт нь хуулийн этгээд болох аж ахуйн нэгж болон аж ахуйн нэгж байгуулан үйл ажиллагаа явуулах Монгол Улсын иргэн хуулийн хүрээнд, хуулиар хориглоогүй үйл ажиллагаа эрхлэн шударгаар чөлөөтэй өрсөлдөн, хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх эрхийг хязгаарлан хориглож буйгаараа Үндсэн хуулийн заалтуудыг зөрчиж байна
55.	Улсын Их Хурлын дэргэдэх сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 9 дүгээр тогтоол Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэх талаархи маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /Дүгнэлт/ /1996-06-20/ Дугаар 05	Улсын Их Хурлын дэргэдэх Сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 09 тоот тогтоолоор Д.Нармандах, Х.Баянмөнх нарыг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчийн нэрсийн жагсаалтаас хасах шийдвэр гаргасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9 болон 10-т байгаа Монгол Улсын иргэн ... сонгогдох эрхтэй ... нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй. Аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд нь хувь хүнийгялгаварлан гадуурхахыг хориглоно ... гэсэн заалтуудыг зөрчсөн гэж үзэж байна

Хуулийн нэгдсэн сан www.legal.mn

56.	Улсын Их Хурлын дэргэдэх сонгуулийн ерөнхий хорооны 1996 оны 9 дүгээр тогтоол үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /Тогтоол / /1996-09-11/ Дугаар 04	Улсын Их Хурлын дэргэдэх Songуулийн ерөнхий хорооны 1996 оны 6 дугаар сарын 6-ны 09 тоот тогтоолоор Д.Нармандах, Х.Баянмөнх нарыг Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвшигчдийн нэрсийн жагсаалтаас хасах шийдвэр гаргасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 9, 10-т байгаа "Монгол Улсын иргэн songогдох эрхтэй. ... нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам байгуулах, сайн дураар эвлэлдэн нэгдэх эрхтэй. Аль нэгэн намд эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний хувьд нь хувь хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглоно" гэсэн заалтуудыг зөрчсөн гэж үзэж байна
57.	Улсын Их Хурлын songуулийн тухай хуулийн зарим заалт үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /Дүгнэлт/ /2007-11-16/ Дугаар 11	Улсын Их Хурлын Songуулийн тухай хуулийн холбогдох заалтууд нь Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2; 3 дугаар зүйлийн 1; 14 дүгээр зүйлийн 1; 16 дугаар зүйлийн 10; 19 дүгээр зүйлийн 1, 2, 3; 21 дүгээр зүйлийн 2; 23 дугаар зүйлийн 1; 70 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг тус тус зөрчсөн байна" гэжээ
58.	Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2005-9-30/ Дугаар 07	Улсын Их Хурлын гишүүдийн дунд эрх зүйн ялгаварлал бий болгож тодорхой зарим гишүүд, тухайлбал 8-аас дээш суудал бүхий намын Улсын Их Хуралд songогдсон гишүүний "бүлгийн харъяаллаас татгалзан гарч өөр бүлэгт нэгдэн орж болох", бие даан нэр дэвшиж songогдсон гишүүний "аль нэг нам, эвслийн бүлэгт нэгдэж болох" зэрэг эрхээ эдлэх боломжгүйд хүрч Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "…тэгш байдал .. нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", Арван зургадугаар зүйлийн 10 дахь заалтын "Аль нэг нам ...-ын гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно" гэснийг зөрчиж байна
59.	Үндсэн хуулийн цэцийн 2012 оны 02 дугаар тогтоолоор хүчингүй болсон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэх маргааныг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тухай /2017-12-20/ Дугаар 02	Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.1 дэх заалтад "гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай нь баривчилж, улмаар бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх тухай саналыг Улсын ерөнхий прокурор Улсын Их Хуралд оруулсан бол гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ." гэж заасан нь Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн байна гэжээ.
60.	Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцсэн тухай /дүгнэлт/ /2000-3-15/ Дугаар 03	Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт" нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн", жаран наймдугаар зүйлийн 1-д заасан "Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно", далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна

Хуулийн Ерөнхий Зөвлөлийн www.ulsgov.mn

61.	Үндсэн хуульд оруулсан нэмэлт,өөрчлөлт нь Үндсэн хууль зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /тогтоол / /2000-11-29/ Дугаар 02	Монгол Улсын Их Хурлаас 1999 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт” нь Монгол Улсын Үндсэн хуулийн нэгдүгээр зүйлийн 2-т заасан “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, жаран наймдугаар зүйлийн 1-д заасан “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн Цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно”, далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.
62.	Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг Зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /2014-12-12/ Дугаар 02	Улсын Их Хурлаас 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын “нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин” гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй” гэсэн хэсэг нэмсэн. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараахь утгаар ойлгоно” гэжээ 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад “эрүүл мэндийн нуущад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг” гэж заасан. Хуулийн дурдсан хэсэг, заалтаас харахад хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн хүний мэдээллийг хувь хүний нуущын төрлөөс хассан байна. Ингэснээр Хувь хүний нуущын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “...хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна”, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 13/ дахь заалтын “...Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, ... -ыг хуулиар хамгаална”, мөн зүйлийн 17/ дахь заалтын “... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, ...-г хангах зорилгоор задруулж үл болох ... хувь хүний нуущыг хуулиар тогтоон хамгаална”, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэснийг тус тус зөрчсөн байна

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЛЫН ГАЗАР www.ikh.gov.mn

63.	Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2014-9-10/ Дугаар 05	Улсын Их Хурлаас 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдөр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтын "нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчин" гэдэгт хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчин хамаарахгүй" /цаашид "ХДХВ/ДОХ" гэх/ гэсэн хэсэг нэмсэн. Тус хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Захидал харилцаа, эрүүл мэнд, хөрөнгө, гэр бүлийн нууц гэдгийг энэ хуульд дараах утгаар ойлгоно:" гэсэд 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2 дахь заалтад "эрүүл мэндийн нууцад тухайн хувь хүний бие эрхтний гажиг, нийтэд аюултай онцлог зарим халдварт өвчнөөс бусад өвчнөөр өвчилсөн тухай мэдээллийг;" гэж заасан. Хуулийн дурдсан хэсэг, заалтаас харахад хүний дархлал хомсдолын вирусын халдвар, дархлалын олдмол хомсдол өвчнөөр өвчилсөн хүний мэдээллийг хувь хүний нууцын төрлөөс хассан байна. Ингэснээр Хувь хүний нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.", мөн зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг ... ялгаварлан гадуурхаж үл болно.", Арван зургадугаар зүйлийн 13 дахь заалтын "... Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, ... -ыг хуулиар хамгаална;", мөн зүйлийн 17 дахь заалтын "... Хүний эрх, нэр төр, алдар хүнд, ...-г хангах зорилгоор задруулж үл болох ... хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална;", Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц ... хууль зүйн ... баталгааг бүрдүүлэх, ... үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэснийг тус тус зөрчсөн байна.
64.	Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.3, 17.4 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн 18.1.2 дахь заалт үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2010-11-24/ Дугаар 08	Хуульч сонгон шалгаруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн "Хуульч нь хууль зүйн үргэлжилсэн сургалтад хамрагдаж, 3 жил тутам сургалтын тодорхой багц цаг хангаж байх үүрэг хүлээнэ." гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг, 17.3 дахь хэсгийн "Шүүх, прокурорын байгууллагад ажиллагсдын сургалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ." гэсэн нь Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн заалтыг, 17.4 дэх хэсгийн "Хуульчийн сургалтад хамрагдах журмыг Зөвлөл тогтооно." гэсэн нь Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг, 18 дугаар зүйлийн 18.1.2-т "хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр энэ хуулийн 17.2-т заасан сургалтад хамрагдаагүй, авбал зохих багц цагийг хангаагүй;" гэсэн нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 3, 4, 7 дахь заалт болон Тавин нэгдүгээр зүйлийн 3, 4 дэх хэсгийн заалтыг зөрчсөн байна гэжээ.
65.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2 дахь хэсгийн заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2014-3-12/ Дугаар 03	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7 дахь хэсэгт "... Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр эцсийн байна." гэж хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "... Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.", мөн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" гэсэд мөн зүйлийн 2 дахь заалтад "давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх", Тавьдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ." гэсэн заалтуудтай зөрчилдөж байна. Иймд Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.7 дахь заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэжээ.

66.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /2015-2-11/ Дугаар 02	Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэргэжлээрээ ажиллах гэсэн ойлголтыг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад заасан хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа гэх ойлголтоор явцууруулан хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан зарим иргэний шүүгчээр томилогдон ажиллах эрхийг хязгаарлаж байгаа нь Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ... эрхтэй. ...” гэснийг зөрчсөн гэж үзэх үндэслэл болж байна. Ингэснээрээ Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан “... шударга ёс, ... тэгш байдал ... нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэснийг зөрчсөн гэжээ.
67.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2013-12-11/ Дугаар 05	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “Өмгөөлөгч багшлах, эрдэм шинжилгээний болон өмгөөллийн хуулийн этгээд, Хуульчдын холбоонд хамаарахаас бусад ажил, албан тушаалыг хавсран эрхлэхийг хориглоно.” гэсэн заалт Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Хүнийг... эрхэлсэн ажил...-аар нь ялгаварлан гадуурхаж үл болно”, Арван зургадугаар зүйлийн 4/ дэх заалтын “ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах... хувийн аж ахуй эрхлэх эрхтэй ...” гэснийг зөрчсөн гэжээ.
68.	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн зарим зүйл заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2014-10-22/ Дугаар 06	Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, мөн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.6, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 1, 2, Арван зургадугаар зүйлийн 4/, Арван есдүгээр зүйлийн 1, Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн холбогдох зүйл заалтыг тус тус зөрчсөн гэж үзжээ.
69.	Цөмийн энергийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /дүгнэлт/ /2009-11-13/ Дугаар 05	Цөмийн энергийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 болон 5.3 дахь хэсгийн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 1, 2, 3, Аравдугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн заалт, Арван зургадугаар зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн тухай.
70.	Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2017-10-4/ Дугаар 05	Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Арван зургадугаар зүйлийн 4, 5 дахь заалт, Дөчин есдүгээр зүйлийн 3, 4, Тавин нэгдүгээр зүйлийн 4, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай
71.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2, 111.5 заалтууд Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2006-12-14/ Дугаар 12	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуулийн 111 дүгээр зүйлийн 111.2-ын “Жирэмсэн болон насанд хүрээгүй эмэгтэй ялтныг тусад нь байрлуулна”; 111.5-ын “Ял эдэлж байх хугацаандаа амаржсан ялтныг 0-1 насны хүүхэдтэй нь хамт байлгаж болно” гэсэн заалт Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14-ийн “…гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно” гэснийг зөрчсөн эсэх тухай.

www.nli.gov.mn

72.	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2014-01-15/ Дугаар 01	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1 дэх хэсгийн "Давж заалдах шатны шүүх ял оногдуулсан, эсхүл цагаатгагдсан этгээдийн гэм буруутай эсэх асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл энэ хуулийн 304 дүгээр зүйлд заасан журмын дагуу шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогчийн өмгөөлөгч гомдол гаргах, улсын яллагч, эсхүл дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэй." гэж заасны "... шүүгдэгч, цагаатгагдсан этгээд, хохирогчийн өмгөөлөгч гомдол гаргах ... эрхтэй." гэсэн заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14/ дэх заалтын "Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, ... өөрийгөө өмгөөлөх, ... шүүхийн шийдвэрийг давж заалдах ... эрхтэй." гэснийг зөрчсөн тухай.
73.	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсгийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2017-4-12/ Дугаар 03	Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 349 дүгээр зүйлийн 349.1 дэх хэсэгт "Хяналтын шатны журмаар хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ба уг этгээд энэ тухай хүсэлтээ бичгээр гаргасан бол заавал оролцоно." гэж заасны "... шүүх хуралдаанд прокурор, өмгөөлөгч оролцох эрхтэй ..." гэсэн хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "... хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна."; Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалтад "... өөрийгөө өмгөөлөх, ... шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, ... эрхтэй. ..." гэснийг тус тус зөрчсөн эсэх тухай
74.	Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг эцэслэн шийдвэрлэсэн тухай /тогтоол/ /2006-07-05/ Дугаар 03	.Улсын Их Хурлаас 2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хууль, Захиргааны хариуцлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай Монгол Улсын хуулийн 1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна" гэсэн заалтыг зөрчсөн гэжээ.
75.	Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2012-5-09/ Дугаар 03	Монгол Улсын Эрүүгийн хуулийн 294 дүгээр зүйлийн 294.1-д "Захирагч эрх мэдэл албан тушаалынхаа байдлыг урвуулсан, хэтрүүлсэн, албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс үлэмж хэмжээний хохирол учирсан бол ... ял шийтгэнэ.", мөн 294.2-т "Энэ хэргийн улмаас их буюу онц их хэмжээний хохирол, хүнд хор уршиг учирсан бол ... ял шийтгэнэ." гэж заасан байдаг. Эрүүгийн хуулийн уг 294.1, 294.2 дахь заалтад захирагч албаны бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс хохирол, хүнд хор уршиг учирсан бол гэмт хэрэгт тооцохоор заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Хүнийг ...нийгмийн байдал ... эрхэлсэн ажил, албан тушаал ...боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно." гэж заасныг зөрчсөн гэжээ.
76.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2019-03-13/ Дугаар 01	Монгол Улсын Их Хурлаас 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 39.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.4, 40.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.4 дэх заалтын холбогдох хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 14 дэх заалт, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг зөрчсөн эсэх тухай

Хуулийн хэрэгслийн төв www.ilbx.mn

77.	Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, мөн зүйлийн 17.6 дахь хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай /2009-4-15/ Дугаар 03	Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3 дахь хэсэгт "Эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг анагаах ухааны боловсрол олгох тусгай зөвшөөрөл бүхий сургууль төгссөн дараахь эмнэлгийн мэргэжилтэнд олгоно" хэмээгээд тус хуулийн 17.3.1-д "өрх, сум, тосгон, сум дундын эмнэлэгт эхний жилд, аймаг, хот, дүүргийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, нүүр ам судлал, уламжлалт анагаах ухааны чиглэлээрх хувийн хэвшлийн эмнэлэгт хоёр дахь жилдээ тус тус дадлагажигчаар ажилласан, мэргэжлийн шалгалт өгч тэнцсэн их эмч" гэсэн заалт болон мөн зүйлийн 17.6 дахь хэсэгт "Дадлагжигчаар ажиллуулахад эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл шаардлагагүй" гэсэн заалтууд нь Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, …хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн;" Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Хүнийг …эрхэлсэн ажил, албан тушаал, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно"; Арван зургадугаар зүйлийн 4 дэх хэсгийн "ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, …хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;" 6 дахь хэсгийн "…эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй;" 18 дахь хэсгийн "…оршин суух газраа сонгох, гадаадад явах…;" гэсэн баталгаатай эдлэх эрх, эрх чөлөөг зөрчсөн гэжээ.

ХАВСРАЛТ 4

1/ Австрали улс

2004 оны Насаар ялгаварлахын эсрэг хууль

1991 оны Ялгаварлангийн эсрэг хууль

1977 оны Ялгаварлангийн эсрэг хууль

1986 оны Австралийн Хүний эрхийн комиссын хууль

1992 оны Хөгжлийн бэрхшээлтэйгээр ялгаварлахын эсрэг хууль

2001 оны Арьсны өнгө шашин шүтлэгийг хүлцэх тухай хууль

1975 оны Арьс өнгөөр ялгаварлахын эсрэг хууль

2/ Болива улс

2010 оны Арьсны өнгөөр болон бүх төрлийн ялгаварлангийн эсрэг хууль

3/ Канад улс

1982 оны Канадын хүний эрх, эрх чөлөөний дүрэм

1986 оны Канадын Хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлын тухай хууль

1977 оны Канадын Хүний эрхйн хууль

2002 оны Онтарчууд болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн тухай хууль

1976 оны Хүний эрх, эрх чөлөөний дүрэм

1971 оны Канадын олон төрлийн соёлын хэв маягийн тухай хууль

4/Колумба улс

2011 оны Колумбын ялгаварлангийн эсрэг хууль

5/ Европын холбоо

Европын Хамтын Нийгэмлэгийн Зөвлөлийн 1976 оны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрны сургалт, тушаал дэвших болон ажиллах нөхцлийг хангахад эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш хандах тухай олон улсын зарчмыг хэрэгжүүлэх Зааварчилгаа /Directive 76/207/EEC/

Европын Холбооны 2000 оны Ялгаварлахын эсрэг Зааварчилгаа /Directive 2000/43/EC on Anti-discrimination/

Хуулийн үйлчлэлийн хугацаа www.ilgov.mn

Европын Холбооны 2004 оны Ажил үйлчилгээ авахад эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш хандах тухай зарчмыг хэрэгжүүлэх тухай Зааварчилгаа / Directive 2004/113/EC/

Европын Холбооны зөвлөлийн 2006 оны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байранд эрэгтэй эмэгтэй хүмүүст тэгш хандах болон тэгш боломж олгох тухай зарчмыг хэрэгжүүлэх Зааварчилгаа /Equal Treatment Directive 2006/54/EC/

Европын Холбооны Хүний үндсэн эрхийн тухай конвецийн 21 дүгээр зүйл / хүнийг хөгжлийн бэрхшээл, нас, бэлгийн чиг хандлагаар зэрэг бүх төрлөөр ялгаварлахыг хориглосон/

6/ France

1598 оны Нантесын хууль/Edict of Nantes/

7/ ХБНГУ

2006 оны Тэгш хандах тухай хууль

8/ Хонг-Конг

Хөгжлийн бэрхшээлийн тухай Тогтоол -1995

Гэр бүлийн байдлаар ялгаварлахын эсрэг Тогтоол - 1997

Хүнй эрхийн Хонг-Конгийн хууль - 1991

Арьс өнгөөр ялгаварлахын эсрэг Тогтоол - 2008

Хүйсээр ялгаварлахын эсрэг хууль - 1996

9/ Энэтхэг улс

1949 оны Энэтхэгийн Үндсэн хуулийн 14, 15, 16, 17 дугаар зүйл

1850 оны Ангит нийгэм дэх хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай заалтыг халах тухай хууль

1956 оны эмэгтэй хүний “хязгаарлагдмал өмчлөгч” гэсэн байдлыг халах тухай хууль

1989 оны Ангит нийгэм болон овог тогтоох /харгис явдлаас сэргийлэх тухай/ хууль

10/ Олон улсад

1925 оны Тэгш хандах / гэмтлийн нөхөн төлбөр/ тухай конвенц

1960 оны Боловсрол дахь ялгаварлахын эсрэг конвенц

1962 оны Тэгш байдал Нийгмийн халамжийн тухай конвенц

1975 оны Гадаад ажиллагсдын ажлын дарамттай нөхцлийн тухай болон тэдэнд тэгш хандах, тэгш боломж олгох тухай конвенц

1979 оны Эмэгтэйчүүдийн эсрэг бүх төрлийн ялгаварлан гадуурхалтыг устгах тухай конвенц

1965 оны Бүх төрлийн арьсны өнгөөр ялгаварлахыг устгах тухай конвенц

2006 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийн тухай конвенц

1958 оны Хөдөлмөр эрхлэлт, ажлын байран дахь ялгаварлахын эсрэг конвенц

1951 оны Ижил цалин хөлс олгох тухай конвенц

2000 оны Хүний эрхийн тухай Европын конвецийн 12 дугаар нэмэлт протокол

2013 оны Бүр төрлийн арьс, арьсны өнгөөр ялгаварлахын эсрэг хүлцэхүйн тухай Америк улсуудын конвенц

2013 оны Бүр төрлөөр ялгаварлахын эсрэг хүлцэхүйн тухай Америк улсуудын конвенц

11/ Израйл улс

1988 оны Хөдөлмөр эрхлэлт / тэгш боломжийн/ тухай хууль

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.rli.gov.mn

2000 оны Бараа, үйлчилгээ авах, олон нийтийн үзвэрийн газарт ялгаварлахын эсрэг хууль

12/ Нидерланд улс

1881 оны Дани улсын Эрүүгийн хуулийн 137 /в-ж/зүйлийн 1/4/ дэх зүйл

13/ Шинэ Зиланд улс

1990 оны Хүний эрхийн хууль 19 дүгээр зүйл

1993 оны Хүний эрхийн хууль

14/ Польш улс

1264 оны Калисзийн хууль

1573 оны Варшавын хууль

15/ ОХУ

1917 оны Оросын ард түмний эрхийн тунхаг

16/ Өмнөд Африк

1996 оны Өмнөд Африкийн Үндсэн хуулийн 9 дүгээр зүйл

1998 оны Хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлын тухай хууль

2000 оны тэгш байдлыг дэлгэрүүлэх, Шударга бус ялгаварлалтаас сэргийлэх тухай хууль

17/ИБУИНВУ

1995 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль

2005 оын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тухай хууль

1970 оны Тэгш цалин хөлс авах тухай хууль

2006 Тэгш байдлын тухай хууль

2010 оны Тэгш байдлын тухай хууль

1965 оны Арьсны хамаарлын тухай хууль

1968 оны Арьсны хамраарлын тухай хууль

1976 оны Арьсны хамаарлын тухай хуульд 2000 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан

1918 оны Хүмүүсийн төлөөлөгчийн /бизнест тэгш зөвшөөрөл олгох/ хууль

1975 оны Хүйсээр ялгаварлах хуульд 2002 оны Хүйсээр /сонгуульд нэр дэвшигчийг/ ялгаварлах тухай хуулиар нэмэлт, өөрчлөлт оруулсан

2003 оны Ажилтны тэгш байдлын хангах (бэлгийн чиг хандлага) журам

2003 оны Ажилд ороход тэгш хандах (шашин, итгэл үнэмшил) журам

2006 оны Ажилд ороход тэгш хандах (нас) журам

18/ АНУ

1975 оны Насаар ялгаварлахын эсрэг хууль

1967 оны Хөдөлмөр эрхлэлтэд насаар ялгаварлахын эсрэг хууль

1945 оны Ялгаварлахын эсрэг Аласкагийн хууль

1990 оны Хөгжлийн бэрхшээлтэй Америк иргэдийн хууль

1959 оны Калифорни мужийн Шударга хөдөлмөр эрхлэлт, орон байрны шударга байдлын тухай хууль

1866 оны Иргэний эрхийн хууль

1871 оны Иргэний эрхийн хууль

1957 оны Иргэний эрхийн хууль

1964 оны Иргэний эрхийн хууль

1968 оны Иргэний эрхийн хууль

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХЭРЭЭЛЭН www.mn.gov.mn

1991 оны Иргэний эрхийн хууль

1974 оны Ажилд авахад үл алагчилах тухай хууль

1963 оны Тэгш цалин хөлс олгох тухай хууль

1969 оны Ерөнхийлөгчийн 11478 дугаар зарлиг

2000 оны Ерөнхийлөгчийн 13166 дугаар зарлиг "Англи хэлээр үл яригч этгээдэд үзүүлэх үйлчилгээг сайжруулах хууль"

1941 оны Шударга Хөдөлмөр эрхлэлтийн хууль

1993 оны Гэр бүл, эрүүл мэндийн шалтгаанаар амралт авах хууль

1868 оны Үндсэн хуулийн 14 дүгээр нэмэлт, өөрчлөлт

2008 оны Генийн мэдээллийн ялгаварлалын эсрэг хууль

2012 оны Орон гэргүйчүүдийн хүний эрхийн хууль

1912 оны Lloyd–La Follette хууль

2009 оны Lilly Ledbetter шударга цалин хөлс олгох хууль

2018 оны Масачутессийн Жендэрт суурилсан ялгаварлалын эсрэг санаачлага

2010 оны Нью Жерси Үг хэлээр доромжлохын эсрэг хүний эрхийн хууль

2002 оны Мэдэгдэл болон Холбооны ажилтныг алагчилахын эсрэг болон Хариу хууль

1965 оны Санал өгөх эрхийн хууль

1978 оны Жирэмсэн байдлаар нь алагчилахын эсрэг хууль

1973 оны Сэргээн засах үйлчилгээний тухай хууль

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

“МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ[181]

УДИРТГАЛ

Сонгуулийн тухай хууль[182] /цаашид “СтХ” гэх/ нь 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдөр батлагдсанаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, Улсын Их Хурлын сонгууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуультай холбоотой харилцааг нэгдсэн нэг хуулиар зохицуулах болсон. Уг хуульд 2016 онд 4, 2017 онд 2, нийт 6 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль нь тус тусын зохион байгуулалтын онцлог шинж чанартай үйл ажиллагаа байтал эдгээр харилцааг нэг хуулиар зохицуулснаар хүндрэл үүсэх, улмаар СтХ-ийн зарим зүйл, заалтыг сонгуулийн харилцаанд оролцогчид өөр өөрийнхөөрөө тайлбарлах, оролцогч талуудын хооронд маргаан үүсэх, сонгогчдод ойлгомжгүй байдал бий болох зэрэг нөхцөл байдал үүсгэж байгаа талаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл /цаашид “төсөл” гэх/-ийн үзэл баримтлалд дурджээ.

Иймд эдгээр үндэслэлийг харгалзан үзэж Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг тус тусад нь боловсруулсан байна.

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ыг баримтлан МУЕСтХ-ийн төслийг боловсронгуй болгоход оршино.

Түүнчлэн, судалгаагаар төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүйн орчинг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэхийг зорилоо.

Төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг аргачлалд заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх зэрэг болно.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаатай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгов. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Хүлээн зөвшөөрөгдөх байдал;
4. Ойлгомжтой байдал;
5. Харилцан уялдаа.

[181] Энэхүү үнэлгээг УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангийн захиалгаар 2019 онд ХЗҮХ-ийн ЭНБД, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа, С.Цэрэндолгор нар хамтран гүйцэтгэв.

[182] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №4

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзэв. Үүнд:

1. Төсөл нь "Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн онцлог бүхий харилцааг зохицуулсан бие даасан хуулийг боловсруулах, сонгууль зохион байгуулахтай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж, боловсронгуй болгох" гэсэн зорилгодоо хүрсэн эсэх;
2. Төсөлд тусгагдсан асуудал болох нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт Үндэсний аудитын газрын дүгнэлт гаргах хугацаатай хамааралтай зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;
3. Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ дахь сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/-ны улмаас эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлоо зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд нь шүүхэд хандан нэхэмжлэл гаргах эрхтэй тухай заалтыг төсөлд хассан нь иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндөх эсэх;
4. Төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субьектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;
5. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тус тусад нь шалгана.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Энэхүү хэсэгт уг төслийн үр нөлөөг нь үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

2.1. "Зорилгод хүрэх байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд

"Улсын Их Хурлын сонгууль, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль нь тус тусдаа зохион байгуулалтын онцлог шинж чанартай үйл ажиллагаа бөгөөд ялангуяа сонгуулийн зохион байгуулалтын бүхий л үйл ажиллагаа нь тухайн сонгуулийн онцлогт тохирсон хуулийн зохицуулалттай байх шаардлагатай байдаг тул Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах шаардлагыг харгалзан сонгуулийн тогтолцоо, үндсэн зарчим, журмыг улам бүр тодорхой болгох, хуулийн тогтвортой байдлыг хангах, сонгууль тус бүрийн онцлогт тохирсон тусгайлсан бие даасан хууль боловсруулах, Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах, түүнчлэн, сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж боловсронгуй болгох шаардлага байна"[183] гэж төслийн үзэл баримтлалд дурджээ.

Дээрхээс үзвэл төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн онцлог бүхий харилцааг зохицуулсан бие даасан хуулийг боловсруулах, сонгууль зохион байгуулахтай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж, боловсронгуй болгоход оршиж байна. Энэхүү зорилгод хүрэхийн тулд хуулийн төслөөр дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах;
- Ерөнхийлөгчийн сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний

[183] Монгол Улсын Ерөнхийлөгчийн Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, 1-2 дахь тал.

сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах;

- Сонгуулийн хороодын бүрэн эрх, ажлын зохион байгуулалттай холбогдсон харилцааг бусад сонгуулийн хуультай нийцүүлэн боловсронгуй болгох гэжээ.

Иймд хуулийн төслийн дээрх зорилтуудтай холбогдсон зүйл, заалтыг сонгон авч "зорилгод хүрэх байдал"-ын үр нөлөөг тооцох болно. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. *Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах	а/ Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг; б/ Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.14, 39 дүгээр зүйлийн 39.2, 40 дүгээр зүйлийн 40.4.18 дахь хэсэг
2	Ерөнхийлөгчийн сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах	а/ Төслийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг; б/ Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг
3	Сонгуулийн хороодын бүрэн эрх, ажлын зохион байгуулалттай холбогдсон харилцааг бусад сонгуулийн хуультай нийцүүлэн боловсронгуй болгох	Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 15 дугаар зүйлийн 15.1, 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг

2.2. "Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд

"Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд төсөлд тусгагдсан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөртэй холбогдуулан Үндэсний аудитын газраас дүгнэлт гаргах хугацаатай хамааралтай зохицуулалтыг сонгон үр нөлөөг нь тооцох болно.

Хүснэгт 2. *Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1	Нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт Үндэсний аудитын газраас дүгнэлт гаргах хугацаа	30.1.Нэр дэвшигч нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд үзэл баримтлалаа тодорхойлсон сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна. 30.5.Нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө Төрийн аудитын дээд байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ. 30.6.Төрийн аудитын дээд байгууллага нь нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө гаргана. 30.7.Нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулж, 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ. 30.8.Төрийн аудитын дээд байгууллага нь нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг түүнд хийсэн дүгнэлтийн хамт санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

2.3. "Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд

"Ойлгомжтой байдал" шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг төслийн зүйл, заалтыг бүхэлд нь шалгаж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл 11 бүлэг, 81 зүйлтэй/

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

2.4. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд, одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ дахь сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/-ны улмаас эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд нь шүүхэд хандан нэхэмжлэл гаргах эрхтэй тухай заалтыг төсөлд хассан нь иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндөх эсэхэд дүгнэлт хийх зорилгоор доорх зохицуулалтыг сонгож авав. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 3. *Хүлээн зөвшөөрөгдөх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Хүлээн зөвшөөрөгдөх байдал/Сонгосон зүйл, заалт	Агуулга
1	Төслийн 79 дүгээр зүйлийн 79.1, 79.2, 79.4, 79.5, 79.6 дахь хэсэг	79.1.Энэ хуульд заасан зөрчлийг Зөрчил шалгах шийдвэрлэх тухай хуульд заасан харъяалал, журмын дагуу хянан шийдвэрлэнэ. 79.2.Сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд тухайн гомдол, маргааны онцлог байдлыг харгалзан тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ. 79.4.Сонгуулийн хороод нь шатлан захирагдах зарчмаар ажиллах бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргана. 79.5.Хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргана. 79.6.Сонгуулийн хороодын шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор өргөдөл, гомдол гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн гомдлыг хүлээн авахгүй.

2.5. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтыг бүхэлд нь шалгаж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл 11 бүлэг, 81 зүйлтэй/

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 4. *Шалгах хэрэгслийг сонгосон байдал*

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	а/ Төслийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг; б/ Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.14, 39 дүгээр зүйлийн 39.2, 40 дүгээр зүйлийн 40.4.18 дахь хэсэг в/ Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг; г/ Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 15 дугаар зүйлийн 15.1, 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	а/ Төслийн 30 дугаар зүйлийн 30.5, 30.6, 30.7, 30.8 дахь хэсэг	Практикт тухайн төрлийн харилцаа, чиг үүргийг хэрэгжүүлж буй этгээдээс ярилцлага авах, гарч болох хүндрэлийг судлах.

3	Ойлгомжтой байдал	Төслийг бүхэлд нь тооцно.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4	Хүлээн зөвшөөрөгдөх байдал	Төслийн 79 дүгээр зүйлийн 79.1, 79.2, 79.4, 79.5, 79.6 дахь хэсэг	Хүлээн зөвшөөрөгдөх байдлын судалгаа хийх асуудлын хүрээнд, холбогдох байгууллагуудаас бичгээр санал авах, мэдээлэлд дүн шинжилгээ хийх.
5	Харилцан уялдаа	Төслийг бүхэлд нь тооцно	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

3.1.1. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн "Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах" эхний зорилтын хувьд дараах зохицуулалтыг сонгон авч үзэв.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг; 3 дугаар зүйлийн 3.1.14, 39 дүгээр зүйлийн 39.2, 40 дүгээр зүйлийн 40.4.18 дахь хэсэг
а/ 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт
1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
б/ 3.1.14.»Сонгуулийн сурталчилгааны цахим хуудас» гэж цахим орчин дахь олон нийтийн сүлжээ бүхий цахим хуудсаас бусад цахим хуудсыг.
39 дүгээр зүйл.Сонгуулийн сурталчилгааанд цахим хуудас ашиглах
39.2.Сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар сурталчилгаа явуулах тохиолдолд тухайн цахим хуудсаар зөвхөн сурталчилгааны цахим хуудсын хаяг, нам, хамтарсан намын нэр, далбаа, таних тэмдэг, нэр дэвшигчийн нэр, сонгуулийн уриа зэргийг сурталчилж болно.
40 дүгээр зүйл.Хууль бус сурталчилгааг хориглох
40.4.18.сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах.

а/ Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт "Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино" гэж хуулийн зорилтыг тодорхойлжээ. Төслийн үзэл баримтлалд "сонгуулийн тогтолцоо, үндсэн зарчим, журмыг улам бүр тодорхой болгох, хуулийн тогтвортой байдлыг хангах, сонгууль тус бүрийн онцлогт тохирсон тусгайлсан бие даасан хууль боловсруулах, Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах, түүнчлэн, сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж боловсронгуй болгох" гэсэн хэдий ч зорилтыг ийнхүү "сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах" хүрээгээр хязгаарласан нь оновчтой эсэхэд дүгнэлт хийх шаардлагатай байна.

Хууль тогтоомжийн тухай хууль[184] /цаашид "ХТтХ" гэх/-ийн 29 дүгээр зүйлийн 29.1.11-д "хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана" гэж заасан.

Харин төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгаагүй, гагцхүү "сонгууль зохион

[184] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №25

байгуулж явуулахтой холбогдсон харилцааг зохицуулах”-аар заасан нь төслийн үзэл баримтлал болох онцлог зохицуулалт бүхий харилцааг тусгайлсан хуулиар зохицуулахтай зөрчилдөхөөр байна.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ-ийн 1 дүгээр 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурал /цаашид “Улсын Их Хурал” гэх/, Монгол Улсын Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч” гэх/, түүнчлэн, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал /цаашид “орон нутгийн хурал” гэх/-ын сонгууль, үндсэн зарчим, журмыг тодорхойлж, эдгээр сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж; 2012 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль[185] /цаашид “МУЕСтХ” гэх/-ийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорхойлж, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тус тус заажээ.

Өөрөөр хэлбэл, СтХ болон өмнөх МУЕСтХ-ийн зорилтоор тухайн харилцааны эрх зүйн үндсийг оновчтой тодорхойлсон бол төсөлд хуулийн зорилтыг учир дутагдалтай томьёолсон гэж үзэх үндэслэлтэй.

Түүнчлэн, Монгол Улсын хувьд өнөөдрийн байдлаар сонгуулийн үйл ажиллагаанд СтХ, Сонгуулийн төв байгууллагын тухай хууль[186] /цаашид “СТБтХ” гэх/, Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хууль[187] /цаашид “САСтХ” гэх/ болон Сонгуулийн ерөнхий хороо /цаашид “СЕХ” гэх/-ноос батлагдсан сонгуулийн холбогдох дүрэм, журмуудыг тус тус хэрэглэж байна.

Төслийн үзэл баримтлалд дурдсанчлан “Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль нь тус бүрдээ онцлог зохицуулалттай харилцаа болохын хувьд тус бүрд нь тухайлсан хуулиар зохицуулах нь зүйтэй боловч ингэхдээ хуулийн төслүүдэд тусгагдсан давхардал, хийдлийг маш сайн анхаарах шаардлагатай.

б/ Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ болон 2012 оны МУЕСтХ-д тусгагдсан хэд хэдэн зохицуулалтыг төсөлд шинэчлэн найруулжээ. Тухайлбал, (1) СтХ-д “Сонгуулийн штаб” гэх томьёоллоор орсон зохицуулалтыг төслийн 28 дугаар зүйлд “Сонгууль эрхэлсэн байгууллага” гэх нэршлээр оруулж, тус байгууллагыг удирдах этгээдэд тухайн шатны намын дарга, эсхүл түүний итгэмжлэл олгосон албан тушаалтныг хамруулахаар заасан (СтХ-д Ерөнхийлөгчийн сонгуулийн хувьд сонгуулийн штабыг намын дарга бус гагцхүү нэр дэвшигч, түүний итгэмжлэл олгосон менежер, шадар туслагч нар удирдах зохицуулалттай); (2) Төслийн 33 дугаар зүйлд сонгуулийн сурталчилгааны хүрээнд тараах хэвлэмэл материалын тухай зохицуулахдаа өмнөх болон одоогийн хуульд байгаа нэр дэвшигчийн намтар, хийсэн ажлын тайланг хассан; (3) Санал хураалтын дүнг гаргах 4 үзүүлэлт СтХ-д байдгийг төсөлд мөн 4 байхаар зохицуулсан ч агуулгын хувьд “тухайн хэсэгт бүртгүүлсэн нийт сонгогчдын тоо” гэсэн хэсгийг хассан; (4) Сонгуулийн сурталчилгаанд ашиглах тээврийн хэрэгслийн тоог шинээр тогтоосон; (5) Сонгуулийн сурталчилгааны цахим хуудсын тухай тодорхойлолтыг хуульчилсан зэрэг болно. Энд тухайлан цахим хуудастай холбоотой зохицуулалтыг сонгон авав.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх хэсэгт ““Сонгуулийн сурталчилгааны цахим хуудас” гэж цахим орчин дахь олон нийтийн сүлжээ бүхий цахим хуудсаас бусад цахим хуудсыг” ойлгохоор заасан. Өмнөх МУЕСтХ болон одоогийн СтХ-д цахим хуудасны тухай ойлголтод ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй бөгөөд бүхий л төрлийн цахим хуудсыг ойлгох боломжтой байсан тул энэ зохицуулалт нь шинэ юм.

Дээрх зохицуулалттай холбогдуулан төслийн 39 дүгээр зүйлийн 39.2 болон

[185] Энэ хуулийг 2015 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон.

[186] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2006), №5

[187] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2011), №48

40 дүгээр зүйлийн 40.4.18 дахь хэсэгт заасныг үзэх шаардлагатай. Төслийн "Сонгуулийн сурталчилгаанд цахим хуудас ашиглах" тухай 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт "Сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар сурталчилгаа явуулах тохиолдолд тухайн цахим хуудсаар зөвхөн сурталчилгааны цахим хуудсын хаяг, нам, хамтарсан намын нэр, далбаа, таних тэмдэг, нэр дэвшигчийн нэр, сонгуулийн уриа зэргийг сурталчилж болно" гэснээс үзэхэд сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсыг тодорхой тохиолдолд ашиглаж болохоор байна. Гэтэл мөн төслийн 40 дүгээр зүйлийн 40.4-т "Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь сонгуулийн сурталчилгааны явцад дараах үйлдэл гаргах, үйл ажиллагаа явуулахыг хориглоно" гээд 40.4.18-д "сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах" гэж бусад хуудсаар аливаа хэлбэрээр сурталчилгаа явуулахыг хоригложээ. Өөрөөр хэлбэл, сурталчилгааны цахим хуудсыг тодорхойлсон тодорхойлолт болон түүнтэй хамааралтай заалтууд нь хоорондоо зөрчилдөхөөр байна.

Түүнчлэн, сонгуулийн сурталчилгааны цахим хуудаст олон нийтийн сүлжээ бүхий цахим хуудсыг хамруулалгүй хуульчилсан нь үндэслэлтэй эсэхэд товч дүгнэлт хийе.

2016 оны 8 сард Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэнгээс хийсэн "Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа"-нд "Мэдээлэл авдаг гол эх сурвалж"[188] гэсэн асуултад телевиз, интернет, нийгмийн сүлжээ гэсэн гурван гол эх сурвалж зонхилж байх бөгөөд "Улс төрийн талаарх мэдээлэл авахдаа нийгмийн аль сүлжээг та ашигладаг вэ?"[189] гэсэн асуултад дийлэнх олонх буюу 43% нь Facebook гэж, 23% нь мэдээллийн цахим сайтууд гэжээ. Үүнээс үзвэл, сонгогчид мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээнээс илүү авдаг байх хандлага ажиглагдаж байна.

Нам, эвсэл, нэр дэвшигч нь сурталчилгааг хуулиар хориглоогүй арга, хэлбэрээр явуулах бөгөөд хуулиар хориглоогүй гэдэг бол чөлөөт байдлын зарчмыг баримтална гэсэн үг юм.[190] Энд мөн "Чөлөөт байдлын зарчмын хязгаар" гэсэн ойлголт байдаг ба хязгааргүй чөлөөт байдал хаа ч үгүй. Тэр нь ямагт бусдын эрх чөлөөгөөр хязгаарлагддаг. Сурталчилгааг хуульд заасан хориг хязгаарлалтыг сахиж ёс зүйтэй явуулах нь нам, эвсэл, нэр дэвшигчдийн өөрийгөө сонгогчдод зөвөөр ойлгуулж, тэдний талархлыг хүлээж дэмжлэгийг олох нэгэн их нөхцөл мөн. Иймд сурталчилгаанд голлон анхаарах зүйл бол хуулийг зөрчихөөс болгоомжлох явдал[191] болно. Хэдийгээр төсөлд олон нийтийн сүлжээг сонгуулийн сурталчилгааны цахим хуудаст хамааруулахгүйгээр зохицуулсан ч дээр дурдсанаар тэдгээр заалт нь хоорондоо зөрчилтэй байна.

Дүгнэвээс, нэг талаас олон нийтийн сүлжээ буюу Facebook, Twitter зэрэг хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй байх нь мэдээллийн эмх замбараагүй, тогтворгүй урсгалаас сэргийлэх боловч нөгөө талаас сонгогчдын мэдээлэл авах хэлбэр нэлээд хумигдаж мэдэх тул энэхүү зохицуулалтыг анхааран үзэх, зөрчилдөж буй хэсгийг залруулах шаардлагатай.

3.1.2. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн "Ерөнхийлөгчийн сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах" хоёр дахь зорилтын хувьд дараах зохицуулалтыг сонгон авав.

[188] Нийгмийн Бодлого Хөгжил Судалгааны Хүрээлэн, Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа (УБ, 2016), Center for Insights in Survey Research, 74 дэх тал, https://www.iri.org/sites/default/files/wysiwyg/iri_mongolia_poll_-_august_2016_-_public_deck_mon.pdf (Сүүлд үзсэн: 2019.01.03.)

[189] Мөн тэнд, 76 дахь тал.

[190] Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), "Адмон" хэвлэл, 149 дэх тал.

[191] Мөн тэнд.

а/ Төслийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг; б/ Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг

а/ 6 дугаар зүйл.Сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

6.2.Сонгууль нь бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгогч бүр оролцох эрхтэй.

6.3.Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө өгнө.

6.4.Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.

6.5.Сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах боломжоор хангагдсан байна.

6.6.Сонгуулийн үйл ажиллагаанд оролцож буй аливаа этгээд нь хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд эхэлж, дуусах зарчмыг баримтална.

б/ *23 дугаар зүйл. Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх нийтлэг журам*

23.1.Дараах этгээд Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй:

23.1.1.Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн нам дангаараа;

23.1.2.Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намууд хамтран.

а/ Төслийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг

Төслийн 6 дугаар зүйлд “Сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчим”-ыг хуульчилсан бөгөөд өмнөх хууль болон одоогийн хуулиас ялгаатай нь тус зүйлд сонгуулийн үндсэн зарчим болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон зарчмыг хамтад нь тусгасан байна. Ингэхдээ зарим шаардлагатай зарчмыг орхигдуулсан талаар авч үзье.

Сонгуулийн хууль, эрх зүйн бусад хэм хэмжээг тогтоох, сахин биелүүлэх, хэрэглэхдээ нийтээр нэг мөр баримталдаг үндсэн эхлэл, сонгуулийн улс төр-эрх зүйн бодлогын тогтвортой үндсүүдийг сонгуулийн эрх зүйн зарчим[192] гэдэг. Сонгуулийн эрх зүйн зарчим бол ардчиллын жам ёсыг бодитой тусгасан, заавал биелүүлэх, харилцан уялдаа холбоотой хэрэгжих арга хэрэглүүрийн нийлбэр цогц[193] юм.

1990-ээд оноос хойш ардчилсан хувьсгалын үр дүнд сонгуульд санал өгөх нь албадлага биш иргэний сайн дурын, хувийн үзэл бодлын асуудал болсон нь том ололт юм. Ийнхүү чөлөөт сонгууль жинхэнэ утгаараа монголын нийгмийн практикт бий болов.[194] Хуучин тус тусдаа байсан хэдэн хуулийг халж, тэр үеийн гурван шатны (Улс, аймаг, сум /хот, район/-ын) Хурлыг “Ардын депутатуудын хурал” гэсэн нэрэнд “багцалж” “БНМАУ-ын Ардын депутатуудын хурлын сонгуулийн хууль” гэсэн төрөлжсөн нэг хууль гаргаж бүх шатны сонгуулийг зохицуулах болжээ. Тус хуулиар бэхжүүлсэн сонгуулийн тогтолцооны зарчим, журам өмнөхөөс үзэл баримтлалын эрс ялгаатай бөгөөд сонгогчид нийтийн, шууд, тэгш эрхийн зарчмаар, саналаа нууцаар гаргаж оролцох журам нэрийн хувьд давтагдсан боловч зарчмын шинэ агуулгатай болсон талаар Б.Чимид агсан тэмдэглэжээ.[195]

Сонгуулийн эрх зүйд сонгуулийн зарчмыг чиглэлээр нь 3 хуваадаг[196] бөгөөд (а) сонгуулийг зохион байгуулж явуулах зарчим, (б) сонгуульд иргэдийн оролцооны зарчим, (в) иргэд, байгууллагын нийтээр баримтлах түгээмэл зарчим болно. Эдгээрийг төсөлд нэг зүйл болгон оруулахдаа зарим зарчмыг орхигдуулсан байна.

Тухайлбал, төслийн 6 дугаар зүйлийн 6.2 – 6.5 дахь хэсгийг үзвэл иргэдийн оролцооны буюу сонгуулийн үндсэн зарчимд “бүх нийтийн”; “шууд сонгох”; “саналаа чөлөөтэй илэрхийлэх”; “саналаа нууцаар гаргах” зарчмуудыг хуульчилсан.

[192] Мөн тэнд, 47 дахь тал.

[193] Мөн тэнд, 48 дахь тал.

[194] Д.Өлзийсайхан, Удирдлагын сэхээтэн (УБ, 2008), Бит Пресс, 6 дахь тал.

[195] Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), “Адмон” хэвлэл, 32 дахь тал.

[196] Мөн тэнд, 48 дахь тал.

Хэдийгээр тус зарчмууд нь өмнөх МУЕСтХ болон одоогийн СтХ-д тусгагдсантай адил боловч эдгээр хуульд бүгдэд нь "тэгш эрхийн зарчим"-ыг зохицуулаагүй нь Үндсэн хуулийн зохицуулалттай холбоотой.

Сонгуулийн тэгш эрхийн зарчмыг шинэ Үндсэн хуульд нэр зааж оруулаагүй ч аль ч улсад энэ зарчмыг сонгуулийн үндсэн зарчимд оруулж хэрэгжүүлэх арга механизмыг нь боловсронгуй болгосоор байна. Энэ зарчмын мөн чанар нь нэг сонгогч нэг удаагийн сонгуульд нэг л удаа саналаа өгөх, сонгогчид адил саналын эрхтэй байх явдлаар илэрхийлэгдэнэ.[197]

Мөн, дээр дурдсанчлан, БНМАУ-ын Ардын депутатуудын хурлын сонгуулийн хуульд "тэгш эрхийн зарчим" тусгагдсан байсан. Иймд хуулийн төсөлд "тэгш эрхийн зарчим"-ыг тусгах нь зүйтэй талаар дараах үндэслэл бий:

Монгол Улсын Үндсэн хууль[198]-ийн Аравдугаар зүйлийн 3-т "Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ"; мөн зүйлийн 2-т "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ" гэж тус тус заасан.

Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглал[199]-ын 21 дүгээр зүйлийн 3-т "Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно" гэж заасан буюу сонгогчийн тэгш эрхийн зарчмыг тунхагласан.

Мөн Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт[200]-ын 25 дугаар зүйлийн (b)-д "сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох" хэмээн тэгш эрхийн зарчмыг заажээ.

Иймд төсөлд одоо тусгагдсан зарчмууд дээр нэмээд "тэгш эрхийн үндсэн дээр оролцох" зарчмыг хуульчлах нь Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээнд нийцэх төдийгүй иргэний сонгох эрхийг бүрэн эхээр нь баталгаажуулах, сонгуулийн үндсэн зарчмын бүрдэл бүрэн хангагдах алхам болно.

Түүнчлэн, төслийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт "Сонгуулийн үйл ажиллагаанд оролцож буй аливаа этгээд нь хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд эхэлж, дуусах зарчмыг баримтална" гэж сонгуулийг зохион байгуулах зарчмыг тусгажээ. Ингэхдээ өмнөх МУЕСтХ болон СтХ дахь "маргааныг шуурхай, үндэслэлтэй, хуулийн хүрээнд шийдвэрлэх"; "сонгогчийн эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх"; "энгийн ойлгомжтой байх" зэрэг зарчмуудыг хуульчлаагүй орхигдуулсан байна. Өөрөөр хэлбэл, төсөлд нийтээр баримтлах түгээмэл зарчим болох хууль дээдлэх болон шударга ёсны зарчмыг хуульчилсан нь сайшаалтай хэдий ч сонгууль зохион байгуулахтай холбогдсон зарчмуудыг орхигдуулжээ.

Өдгөө сонгуулийн эрх зүйн зарчмуудыг өргөсгөн авч үзэх хандлага бий болсон бөгөөд зарчмууд зөвхөн иргэдийн сонгуульд оролцох үзэл хандлагыг төдийгүй ард түмэн засгийн эрхээ хэрэгжүүлэхэд засаг төрөөс үр нөлөөтэй, шийдвэрлэгч чанартай оролцуулах нөхцөлийг хангах үүрэг, ардчилсан ёсны арга хэрэглүүрийг

[197] Монгол Улсын Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь, Олон Улсын бага хурал (УБ, 2002), 31-32 дахь тал.

[198] Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1

[199] Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ, 1946, https://www.legalinfo.mn/law/details/1271

[200] Иргэний Болон Улс Төрийн Эрхийн Тухай Олон Улсын Пакт, НҮБ, 1966, https://www.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257

багтаах[201] тул дээрх орхигдуулсан зарчмыг хуульчлах нь зүйтэй.

б/ Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг

Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт "Дараах этгээд Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх эрхтэй" гэвд 23.1.1 дэх заалтад "Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн нам дангаараа"; 23.1.2 дахь заалтад "Улсын Их Хуралд суудал бүхий улс төрийн намууд хамтран" гэж тус тус заажээ. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчид УИХ-д суудал бүхий намууд дангаараа буюу хамтран нэр дэвшүүлэх эрхтэй. Энэ хэсэгт (а) УИХ-д суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжиж болох зохицуулалттай байсныг хассан тухай; (б) Бие даан нэр дэвших асуудлыг цаашид /Үндсэн хуульд нийцүүлэн/ бий болгох боломжтой эсэх тухай хоёр асуудлыг хөндөж үзэв.

Өмнөх МУЕСтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 7.1-д заасаас бусад улс төрийн нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид нэр дэвшигчийг дэмжиж болно" гэж; одоо хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ-ийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт "Улсын Их Хуралд суудалгүй нам Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг дэмжиж болно" гэж тус тус заасан. Төсөлд харин энэ зохицуулалтыг хассан байна.

УИХ-д суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжих тухай зохицуулалтыг хуульчилсан нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших асуудалд бусад улс төрийн намуудын оролцооны асуудал хумигдаж, гагцхүү хэдхэн намын нэр дэвшигчийн хооронд өрсөлдөөн болдог тул тэдгээр бусад намын эрх тэгш оролцоог хангах зорилготой гэж үзэж болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлд Ерөнхийлөгчийн сонгуулийн эрх зүйн үндсийг тогтоосон бөгөөд мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Улсын Их Хуралд суудал бүхий нам дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчид тус бүр нэг хүний нэр дэвшүүлнэ" гэж заасан тул төслийн дээрх хэсэг нь Үндсэн хуулийн зохицуулалтыг баталгаажуулсан. Гэсэн хэдий болов мөн Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 9 дэх хэсэгт "шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй" болохыг хуульчилсан тул УИХ-д суудалгүй нам нэр дэвшигчийг дэмжиж оролцох нь Үндсэн хуулийн зохицуулалтаас зөрсөн хэрэг болохгүй.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 29 нам[202] байх болов УИХ-д суудалтай 3 нам байна. Мөн практик туршлагаас үзвэл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд дээд тал нь 4 намаас[203] нэр дэвшиж байжээ.

> УИХ-д суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжиж оролцох зохицуулалтыг төсөлд оруулаагүй хэдий ч хориглоогүй. Дэмжиж оролцож болно гэсэн үг.
>
> *СЕХ-ны хуульчтай хийсэн ярилцлагаас... 2018.12.21.*

Дээрх ярилцлагад өгүүлсэнчлэн, хэдийгээр хуулиар хориглоогүй бүхэн зөвшөөрөгдөх зарчимтай ч хуульчлаагүй байгаа энэ тохиолдолд эргэлзээтэй байдлыг бий болгож байх юм.

Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар "Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн" болохын хувьд тангараг өргөснөөр улс төрийн намын харьяаллаас татгалздаг. Гэвч УИХ-д суудал бүхий намуудаас нэр дэвшүүлэх нь Ерөнхийлөгч улс төрөөс

[201] Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), "Адмон" хэвлэл, 47 дахь тал.

[202] Улс төрийн намын бүртгэл – Улсын дээд шүүхийн албан ёсны цахим хуудас, http://www.supremecourt.mn/nam (Сүүлд үзсэн: 2019.01.10.)

[203] 1997 оны сонгуульд 2 нам хамтарч, бусад 2 нь тусдаа буюу нийт 4 намаас 3 нэр дэвшигч; 2005 оны сонгуульд 4 намаас 4 нэр дэвшигч нэр дэвшиж байсан байна.

хараат бус байх үзэл санаатай зарим талаар зөрчилдөхөөр[204] байна.

Дэлхийн улс орнуудын харьцуулсан туршлагаас үзэхэд ард түмнээс, эсхүл парламентаас (хуралдайгаас) сонгох гэсэн хоёр хувилбар байдаг. Ерөнхийлөгчийг бүх ард түмнээс сонгодог улсуудад хоёр шаттай сонгууль нийтлэг загвар байдаг бөгөөд үнэмлэхүй олонхийн санал авсан байхыг шаарддаг. Эхний шатанд "хэн ч" нэрээ дэвшүүлж болох ба өрсөлдөгч нараас хэн нь ч олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигч дараагийн шатны сонгуульд өрсөлддөг.[205]

Өнөөдрийн байдлаар дэлхий дахинд Ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгодог 87 улс[206] /Монгол Улсыг хамааруулаад/ байна. Тэдгээрээс тухайлан эх газрын эрх зүйн бүлд харьяалагддаг Бүгд Найрамдах Австри Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Турк Улсуудын Сонгуулийн тухай хуулийг тус тус үзвэл бүгдэд нь Ерөнхийлөгчид бие даан нэр дэвших эрх нээлттэй байна. Гагцхүү бие даан нэр дэвшсэн тохиолдолд тодорхой тооны гарын үсгийг цуглуулах /Бүгд Найрамдах Турк Улсын хувьд сонгогчдоос 100,000 гарын үсэг цуглуулахыг шаарддаг/ зэрэг шаардлагыг тавьдаг.

Түүнчлэн, Монгол Улсын хувьд бие даан нэр дэвшихийг хуулиар зөвшөөрдөггүй нь сонгогдох эрхийн тухай Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага /цаашид "ЕАБХАБ" гэх/-ын өмнө хүлээсэн үүрэг амлалтууд болон олон улсын бусад хэм хэмжээтэй нийцэхгүй, сонгогчдын сонголтыг хязгаарлаж байгаа тухай ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газрын сонгууль ажиглах хорооны тайланд[207] дурджээ.

Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пактын 25 дугаар зүйлийн тухай НҮБ-ын Хүний эрхийн хорооноос гаргасан 25 дугаар Ерөнхий тайлбарын 15 дахь хэсэгт "Сонгогдох эрх эдлэх боломжгүй хүмүүсээс бусад хүмүүс нь боловсрол, оршин суугаа газар, гарал үүсэл, эсвэл улс төрийн харьяаллын шалтгаан гэх мэт үндэслэлээр ялгаварлан гадуурхагдах ёсгүй"[208] хэмээн заасан байдаг.

Иймд иргэний сонгогдох эрхийг хангах, Олон Улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс цаашид Ерөнхийлөгчийн сонгуульд бие даан нэр дэвших эрхийг хуульчлах асуудлыг Үндсэн хуулийн хүрээнд хэлэлцэх, одоогийн тохиолдолд УИХ-д суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжиж оролцож болох зохицуулалтыг төслийн хүрээнд хуульчлах талаарх асуудлыг анхааран үзэх шаардлагатай.

3.1.3. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн "Сонгуулийн хороодын бүрэн эрх, ажлын зохион байгуулалттай холбогдсон харилцааг бусад сонгуулийн хуультай нийцүүлэн боловсронгуй болгох" гурав дахь зорилтын хүрээнд дараах зохицуулалтыг сонгон авлаа.

[204] Ч.Энхбаатар нар, Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ, хамтын судалгааны тайлан (УБ, 2015), "Мөнхийн үсэг" ХХК, 37 дахь тал.

[205] Мөн тэнд, 38 дахь тал.

[206] Дэлхийн улс орнуудын сонгуулийн тогтолцооны жагсаалтаас төрийн тэргүүн буюу Ерөнхийлөгчөө ард түмнээс шууд сонгодог тогтолцоотой улс орнуудыг нэг бүрчлэн үзэж, тооцсон болно. - https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/ (Сүүлд үзсэн: 2019.01.04.)

[207] Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль - Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлан, ЕАБХАБ, АИХЭГ (Варшав, 2017), OSCE, 15 дахь тал.

[208] Мөн тэндээс дам эшлэв.

Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 15 дугаар зүйлийн 15.1, 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг

14 дүгээр зүйл.Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны бүрэн эрх

14.1.Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ.

15 дугаар зүйл.Сум, дүүргийн сонгуулийн хорооны бүрэн эрх

15.1.Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо нь сум, дүүргийн сонгуулийн хороог санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, гурваас таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлнэ.

16 дугаар зүйл. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах төв болон салбар комиссын бүрэн эрх

16.1.Сонгуулийн ерөнхий хороо, гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн гадаад улсад байгаа иргэдийн санал авах ажлыг зохион байгуулах, нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих үүрэг бүхий төв комиссыг гадаадад санал авах өдрөөс 60-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

17 дугаар зүйл.Хэсгийн хорооны чиг үүрэг

17.1.Сум, дүүргийн сонгуулийн хороо хэсгийн хороог санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дарга, зургаагаас найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтэд мэдээлнэ.

Төслийн 14, 15, 16, 17 дугаар зүйл тус бүрийн 1 дэх хэсэгт Сонгуулийн ерөнхий хороо болон холбогдох хороод сонгуулийн хороодыг “таваас долоо”, “гурваас тав”, “зургаагаас найм”-н гишүүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулж, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд нийтэд мэдээлэхээр зохицуулжээ.

МУЕСтХ-ийн төслийн зорилгын хүрээнд дэвшүүлсэн “Сонгуулийн хороодын бүрэн эрх, ажлын зохион байгуулалттай холбогдсон харилцааг бусад сонгуулийн хуультай нийцүүлэн боловсронгуй болгох” гэх зорилтын хувьд сонгуулийн хороодын бүрэн эрхийг тус тусад нь зохицуулсан нь сайшаалтай. Гэвч энд дараах асуудал байгааг анхаарах нь зүйтэй.

СТБтХ-ийн 7 дугаар зүйлд СЕХ-ны бүрэн эрхийг зааж, мөн зүйлийн 7.1.3 дахь заалтад “сонгуулийн бүх шатны хороодын үйл ажиллагааг нэгтгэн зохион байгуулах” гэжээ.

Сонгуульд бэлтгэж, явуулах ажлыг сонгогчид өөрсдөө мэдэж зохион байгуулах боломжийг аль болохоор хангах нь ардчилсан ёсны шаардлага юм. “Засгийн бүх эрх ард түмний мэдэлд” гэдэг зарчмын уг чанар энд бас оршино.[209]

Энэ утгаараа орон нутгийн хороод бол уг чанар, нийгмийн үндэс, бүрэлдэхүүн, үүрэг зорилгоороо тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн (сонгогчдын) байгууллага, шууд ардчиллын хэлбэр мөн бөгөөд энэ нь онолын баримтлал болохыг, мөн тийм байтал СтХ-д сонгуулийн хороодыг дээрээс нь, төвөөс томилж байгуулах зарчим тогтоосон нь эргэлзээтэйг, хэдий тийм боловч “хууль бол хууль” учир гүйцэтгэхээс аргагүйболох тухай Б.Чимид агсан тэмдэглэсэн[210] байна.

Тиймээс сонгууль зохион байгуулахад онцгой чиг үүрэг бүхий сонгуулийн хороод нь сонгогчдын, ямар нэг бүлгийн өмнөөс биш нийтийн ашиг сонирхлын үүднээс, өөрөөр хэлбэл, “цэвэр иргэний байр суурь”-ийг баримтлан ажиллах зарчмын тусгал[211] юм.

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ-д сонгуулийн хороодын бүрэлдэхүүнийг дарга, нарийн бичиг, гишүүд, “нийт таваас есөн хүний бүрэлдэхүүнтэй”[212] байхаар хуульчилсан бол төсөлд сонгуулийн хороодын

[209] Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), “Адмон” хэвлэл, 103 дахь тал.

[210] Мөн тэнд.

[211] Мөн тэнд, 104 дэх тал.

[212] СтХ-ийн 31 дүгээр зүйлийн 31.4, 33 дугаар зүйлийн 33.4 дэх хэсэг.

гишүүдийн тоог “таваас долоо”, “зургаагаас найм” байхаар тус тус зохицуулсан буюу тоог тодорхой тогтоогоогүй нь оновчтой эсэхэд товч дүгнэлт хийе. Хэдийгээр СтХ-ийн тоог тодорхой тогтоогоогүй зохицуулалтыг төсөлд мөн оруулсан боловч энд өмнөх хуулиуд болон эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлалыг харгалзан үзэх нь зүйтэй.

Өмнөх МУЕСтХ-ийн 15, 16, 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үзвэл аймгийн сонгуулийн хороог “долоо”, бусад хороодыг “таван” гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар тодорхой зохицуулсан байна. Түүнчлэн, СТБтХ-д зааснаар СЕХ-ны бүрэлдэхүүн дарга, нарийн бичигтэйгээ нийлээд нийт 9 хүний бүрэлдэхүүнтэй[213] байдаг. Үүнтэй холбогдуулан өмнөх УИХ-ын болон орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулиудыг үзвэл мөн тоог тодорхой зохицуулж байжээ.

Сонгуулийн хороод нь хамтын удирдлагатай бөгөөд эрх хэмжээнийхээ асуудлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон хуралдаанаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэдэг тул бүрэлдэхүүний тоог ийнхүү тодорхой байдлаар, сондгой тоогоор тогтоох нь зүйн хэрэг юм. Гэтэл төслийн зохицуулалтад “таваас долоо” гэснээр бүрэлдэхүүний тоо “зургаа” ч байж болохоор ойлгогдож байна.

Иймд төслийн үзэл баримтлалын хүрээнд дэвшүүлсэн гурав дахь зорилтын хүрээнд сонгуулийн хороодын бүрэлдэхүүний тоог анхааран үзэх, тодруулбал, тав эсхүл долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар тодорхой зохицуулах шаардлагатай.

3.2. Практикт хэрэгжих боломж

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг нь тооцох хэсгийг тогтоохдоо сонгон авсан зохицуулалтад хамаарах байгууллагын үйл ажиллагаа, эрх зүйн орчин, судлаачдын судалгаа, мэдээлэлд дүн шинжилгээ хийх, холбогдох мэргэжилтэнтэй ярилцлага хийх замаар үнэлгээ хийв.

Тус шалгуур үзүүлэлтээр сонгон авсан зохицуулалтын хүрээнд (1) Хуулийн төслийг хэрэгжүүлэх субьект байгаа эсэх; (2) Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх гэсэн хоёр асуултад хариулт өгөхийг эрмэлзлээ.

30 дугаар зүйл.Сонгуулийн мөрийн хөтөлбөр

30.1.Нэр дэвшигч нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд үзэл баримтлалаа тодорхойлсон сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байна.

30.4. Нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль, бусад хуульд нийцсэн байдал болон хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрийн талаарх тооцоо, судалгааг төрийн аудитын байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан байна.

30.5.Нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө Төрийн аудитын дээд байгууллагад дүгнэлт гаргуулахаар хүргүүлнэ.

30.6.Төрийн аудитын дээд байгууллага нь нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр энэ хуульд заасан шаардлагад нийцэж буй эсэх талаарх дүгнэлтийг санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө гаргана.

30.7.Нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулж, 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.

30.8.Төрийн аудитын дээд байгууллага нь нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг түүнд хийсэн дүгнэлтийн хамт санал авах өдрөөс 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

1. Хэрэгжүүлэх субьект байгаа эсэх:

Төслийн 30 дугаар зүйлд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд

[213] СТБтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг.

үзэл баримтлалаа тодорхойлсон сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байх бөгөөд тэрхүү мөрийн хөтөлбөртөө төрийн аудитын дээд байгууллагаар дүгнэлт гаргуулна.

Төрийн аудитын дээд байгууллага гэдэг нь Төрийн аудитын тухай хууль[214] / цаашид "ТАудтХ" гэх/-ийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "... Төрийн аудитын дээд байгууллага нь Үндэсний аудитын газар ... байна" гэж заасны дагуу Үндэсний аудитын газар бөгөөд төслийн 30 дугаар зүйлд заасан дүгнэлтийг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газар[215] гаргадаг.

Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах байгууллага нь ийнхүү тодорхой боловч субьекттэй холбоотой зарим асуудал байгааг дурдах нь зүйтэй: Төслийн дээрх зохицуулалтад зааснаар нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн эсэхийг Үндэсний аудитын газар шалгадаг. Гэвч ТАудтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1.18-д "Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрт дэвшүүлсэн зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн эсэхэд болон сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэрт дүгнэлт гаргах" гэж Үндэсний аудитын газрын бүрэн эрхийг заажээ.

Үүнээс үзвэл, Үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх дүгнэлт гаргах эрх төрийн аудитын дээд байгууллагад олгогдоогүй, Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянадаг байгууллага нь Үндсэн хуулийн цэц байтал Үндэсний аудитын газар энэ талаар дүгнэлт гаргаж байгаа нь чиг үүргийн хувьд эргэлзээтэй[216] болох тухай тус байгууллагын холбогдох мэргэжилтэн хэлж байлаа. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн[217] 1 дүгээр зүйлд Үндсэн хуулийн цэцийн эрх зүйн байдлыг "Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн" гэж тодорхойлсон. Хэдийгээр нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах нь Цэцийн харьяалан шийдвэрлэх асуудалд шууд хамааралгүй боловч Үндсэн хуульд нийцсэн эсэх "дүгнэлт"-ийг гагцхүү Үндсэн хуулийн цэц гаргадаг билээ.

> Нэгэнт Үндэсний аудитын газар мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргаж байгаа бол Үндсэн хуулиас бусад хууль, үзэл баримтлалд нийцсэн эсэхийг шалгадаг байх нь зүйтэй. Учир нь бид Үндсэн хуульд нийцсэн эсэх талаарх дүгнэлтийг гаргах нь Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээний асуудлыг гүйцэтгэсэн мэт эргэлзээтэй байдал үүсгэхийг үгүйсгэхгүй.
>
> *Үндэсний аудитын газрын аудитортай хийсэн ярилцлагаас... 2019.01.09.*

Түүнчлэн, аудитын байгууллагын чиг үүргийг нэгэнт дурдсаных, төслийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсэгт "Төрийн аудитын дээд байгууллага зардлын тайланг хүлээн авсан өдрөөс хойш 90 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлэх ба нэг сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн иргэн, таван сая ба түүнээс дээш төгрөгийн хандив өгсөн хуулийн этгээдийг нийтэд зарлана" гэж заасан зохицуулалтад мөн товч дүгнэлт хийх шаардлагатай. Нэр дэвшигчдийн зардлын тайланд хийсэн хувийн аудитын байгууллагын дүгнэлтийг Үндэсний аудитын газар хянаж, нийтэд мэдээлэх зохицуулалттай.

Гэтэл СТБтХ-ийн 7 дугаар зүйлийн 7.4.8-д "Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам, нэр дэвшигчийн авсан хандивын хэмжээ, зарцуулалтад хяналт тавих"; мөн зүйлийн 7.4.9-д "Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшүүлсэн нам болон сонгуульд хамтарч нэр дэвшүүлсэн намуудыг төлөөлөх байгууллагын сонгуулийн зардлын сангийн тайланг хянан хэлэлцэх, дүнг нийтэд мэдээлэх" гэж

[214] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2003), №2

[215] УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын ерөнхий бүтэц, эрхлэх асуудлын хүрээ", https://www.audit.mn/?page_id=1455 (Сүүлд үзсэн: 2019.01.09.)

[216] Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын аудитор н.Отгонбаяртай хийсэн ярилцлага. (2019.01.09.)

[217] Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №3

тус тус заасан ба эдгээр бүрэн эрх СЕХ-нд хадгалагддаг.

Захиргааны ерөнхий хууль[218] /цаашид "ЗЕХ" гэх/-ийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт "Хуульд зааснаас бусад тохиолдолд захиргааны байгууллага хуулиар тусгайлан заасан бүрэн эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно" гэж заасан. Үндсэн хуулийн суурь зарчмын дагуу иргэн хуулиар хориглоогүйг хийж болох, харин захиргаа нь хуульд заасныг хийх үүрэг хүлээх бөгөөд захиргааны байгууллага хуульд заасан чиг үүрэг, бүрэн эрхээ хэрэгжүүлснийхээ төлөө хариуцлагаа өөрөө хүлээнэ.[219] Тухайлбал, Засаг дарга хуульд заасан бүрэн эрхээ шилжүүлэхээр бол юуны өмнө Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон тухайн харилцааг нарийвчилсан хуулийн зохицуулалтыг баримтлах хэрэгтэй болно гэсэн үг. Чиг үүргийг нь хуулиар тогтоосон захиргааны байгууллага өөрийн чиг үүргийг бусдад шилжүүлэх эрхгүй.[220]

Өөрөөр хэлбэл, төслийн 54 дүгээр зүйлийн 54.1 дэх хэсгээр СЕХ хуулиар тогтоосон санхүүгийн зардлын тайланд хяналт тавих өөрийн бүрэн эрхийг Үндэсний аудитын газарт давхардуулан олгосон нь Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн суурь зарчмын үүднээс зөрчилтэй байдал үүсгэхээр байна.

Мөн төслийн 42 дугаар зүйлийн 42.2-т сонгуулийн зардал нь "хандив"; "намын өөрийн хөрөнгө"; "нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө»-өөс бүрддэг болох тухай заажээ. Өөрөөр хэлбэл, сонгуулийн зардлын нэг хэсэг болох хандивыг төсвөөс бус иргэн, хуулийн этгээдийн өгсөн мөнгөн болон мөнгөн бус хандиваар бүрдүүлдэг. Харин ТАудтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт "Энэ хуулийг төрийн аудитын байгууллагаас улс, орон нутгийн төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, төсвөөс санхүүгийн дэмжлэг авсан төсөл, хөтөлбөрийн санхүүгийн тайлан, үйл ажиллагааны гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргахад дагаж мөрдөнө" гэж төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны хүрээг тогтоосон байна. Тодруулбал, төрийн аудитын дээд байгууллага нь гагцхүү улсын төсөв болон түүнтэй холбогдох төсөл, тайлан, хөтөлбөр, үйл ажиллагааны гүйцэтгэлд аудит хийдэг байгууллага юм. Тийм байтал төсвийн хөрөнгөтэй хамааралгүй асуудалд хяналт тавих нь Үндэсний аудитын газрын хуулиар олгогдсон чиг үүргээс гадуурх асуудал болон үлдэж байна.

Иймд дээр дурдсан асуудлыг анхаарах, төсөлд хамаарах байгууллагуудын уялдаа холбоо, чиг үүргийг салбарын бусад хуульд нийцүүлэн сайтар судлан үзэх шаардлагатай.

2. Хуулийн төслийн зохицуулалт хэрэгжих боломжтой эсэх:

Энэ хэсэгт сонгож авсан зохицуулалтын хүрээнд тус зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг шалгах шаардлагатай юм.

Төслийн 30 дугаар зүйлийн 30.5 - 30.8 дахь хэсэг хүртэлх зохицуулалтыг үзвэл, нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах; тухайн мөрийн хөтөлбөр нь хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд зөрчлийг арилган дахин дүгнэлт гаргах; дүгнэлтээ СЕХ-нд хүргүүлэх зэрэг ажиллагаанд төрийн аудитын байгууллагад нийт 10 хоног олгогдсон байна. Гэтэл дурдсан бүх шаардлагатай үйл ажиллагааг гагцхүү 10 хоногийн дотор гүйцэтгэх зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхэд асуудлын гол нь оршиж байна.

Энэ зохицуулалттай холбогдуулан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслийг үзвэл, мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргахад харьцангуй их хугацааг тогтоосон байх атал Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, шаардлагатай тохиолдолд дахин дүгнэлт гаргах, хүргүүлэхэд нийт ердөө

[218] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №28

[219] Монгол Улсын Захиргааны ерөнхий хуулийн тайлбар, Ханнс-Зайделийн сан (УБ, 2017), МУИС пресс, 87 дахь тал.

[220] Мөн тэнд.

10 хоногийн хугацааг хуульчилсан нь үндэслэлгүй бөгөөд хэрэгжүүлэх субьектийн хувьд ачааллын тэнцвэргүй байдал үүсгэж мэдэхээр байна.

Үндэсний аудитын газраас одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ-ийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санал хүргүүлж байсан ба УИХ болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох нам, эвсэл, нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө СЕХ-нд бүртгүүлэх хугацаанаас 14-өөс доошгүй хоногийн өмнө төрийн аудитын байгууллагад ирүүлсэн байх тухай заалтыг оруулах саналыг тусгажээ. Учир нь аудитын олон улсын стандартаар аудит хийхэд тодорхой хугацаа шаардаг бөгөөд сонгуульд оролцох нам, эвслүүд сонгуулийн мөрийн хөтөлбөрөө СЕХ-нд бүртгүүлэх хугацааны өмнөх өдөр ирүүлж байгаа нь төрийн аудитын байгууллагаас аудит хийх нөхцөлийг бүрдүүлэхгүй байгаа тухай[221] мөн саналын үндэслэлдээ тодотгосон байна.

СтХ-д явуулж байсан санал энэ төсөл дээр мөн адил. Олон улсын стандартын дагуу аудит хийхэд дор хаяж 2 сарын хугацаа шаардагддаг бөгөөд мөрийн хөтөлбөрт 14 – 30 хоногийн дотор дүгнэлт гаргах боломжтой. Гэвч нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийг СЕХ-нд бүртгүүлэх хугацаанаас доод тал нь 14-өөс доошгүй хоногийн өмнө ирүүлэх тухай зохицуулсан тохиолдолд энэ хугацаанд аудитын байгууллагаас дүгнэлт гаргах бүрэн боломжтой. Мөн энэ тохиолдолд зөрчлийг арилгасны үндсэн дээр 3 хоногийн дотор буцаан хүргүүлэх зэрэг зохицуулалт шаардлагагүй болно. Харин төсөлд заасан нийт 10 хоногийн хугацаанд мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах боломжгүй, энэ нь практикаас зөрсөн зохицуулалт байна.

Үндэсний аудитын газрын аудиторгай хийсэн ярилцлагаас... 2019.01.09.

Иймд дээр дурдсан үндэслэлийг харгалзан төрийн аудитын байгууллагаас дүгнэлт гаргах хугацааг дахин авч үзэх шаардлагатай. Төсөлд зохицуулагдсан одоогийн зохицуулалт буюу дүгнэлт гаргахад 5 хоног, дахин дүгнэлт гаргах, хүргүүлэхэд мөн 5 хоног, нийт 10 хоног байх нь нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр зүй ёсоор хянагдахгүй байх нөхцөл байдлыг бий болгож, хэрэгжүүлэх субьектэд хэт ачаалал нэмсэн зохицуулалт болохоор байна.

3.3. Ойлгомжтой байдал

Хуулийн төслийн зохицуулалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг дараах байдлаар шалгаж үзэв.

Хүснэгт 5. *Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхийг шалгасан байдал*

Д/д	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	“Нэн даруй” гэсэн нэр томьёо бичигдсэн төслийн зохицуулалтууд: 6.10, 16.7.4, 17.2.3, 18.11, 18.14, 18.15, 40.17, 57.8, 67.4.1, 69.1.2, 69.5.2, 69.16, 69.17, 70.3, 72.1, 73.2	Төсөлд “нэн даруй” хэрэгжүүлэхээр заасан 16 заалт байх бөгөөд тэдгээрийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолуудыг үзвэл хууль, түүний зохицуулалтаас хамаарч “нэн даруй” гэдгийг ойлгох хугацаа өөр байна. Тухайлбал, Иргэний хуульд заасан “нэн даруй” гэдгийг тухайн тохиолдолд мэдэгдэх боломжтой ердийн хугацаанд[222] ойлгохоор байгаа бол Прокурорын /хуучин/ тухай хуульд заасан “нэн даруй” гэдгийг 24 цагийн дотор[223] гэж ойлгохоор байна.	Явуулах үйл ажиллагааны төрлөөс хамаарч “нэн даруй” гэсэн ойлголт нь өөр өөр байх тул хугацааг нарийвчлан зааж зохицуулах.

[221] Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөлд өгөх санал, Үндэсний аудитын газар, хүснэгтийн 1 дэх мөр.

[222] Улсын Дээд Шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.06.22.) “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178 (Сүүлд үзсэн: 2018.12.26.)

[223]

2.	Төслийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.”	Хориглосон заалтыг сонгуулийн үйл ажиллагааны зарчимд оруулсан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Ойлголтыг нэг мөр болгох.
3.	Төслийн 6 дугаар зүйлийн 6.8-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хугацаа тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална.”	“Иргэний хуульд заасан зарчмыг баримтална” гэсэн байгаагаас үзвэл Иргэний хуульд хугацаа нь зарчим байх тухай заагаагүй байна.	Ойлголтыг нэг мөр болгох.
4.	Төслийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.”	Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчимд сонгогч саналаа нууцаар гаргах эрхийг хамааруулсан байна. Энэ нь сонгох, сонгогдох эрх тусдаа байх бөгөөд сонгууль зохион байгуулах, сонгуулийн төв хорооны ил тод байдалтай хамааралгүй юм.	Сонгууль зохион байгуулах ил тод байдлыг хангах тухай ойлголтыг нэг мөр болгох.
5.	Төслийн 6 дугаар зүйлийн 6.12-т “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/, ажиглалт хийх, сонгогчдод сонгуулийн мэдлэг олгох, эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах эрхтэй.”	Улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллагын эрхийг үйл ажиллагааны зарчимд хуульчлан тусгасан нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.	Ойлголтыг нэг мөр болгох.
6.	Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.15-д “энэ хуулийн 48.2-т заасан мөнгөн урамшууллын зардал;”	Төслийн 48 дугаар зүйлийн 48.2-т “Иргэн, хуулийн этгээд нь нам эсхүл нэр дэвшигчид жилд нэг удаа хандив өгч болно” гэж заасан бөгөөд мөнгөн урамшуулалд хандив орохгүй.	Хуулийн төсөлд өөрчлөлт оруулах.

www.nli.gov.mn

7.	Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1-д “Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ.”	Төслийн дээрх заалтууд нь практикт хэрэгжихэд ойлгомжгүй байдлыг бий болгох боломжтой байна. Тухайлбал, төслийн уг заалтаас үзвэл аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн даргаас гадна таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болохоор заасан нь сонгуулийн хороог зургаа /тэгш тоотой/-н гишүүнтэйгээр байгуулж болохоор харагдаж байна. Харин 2012 оны МУЕтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.1-д “Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 50-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, аймагт долоо, нийслэлд таван гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ.” гэж зааж байсан нь аливаа шийдвэр гаргах тохиолдолд санал тэнцэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс сондгой тоогоор гишүүдийг бүрдүүлж байсан байх юм. Төсөлд энэхүү өмнө хэрэгжүүлж байсан хуулийн эрсдэлийг тооцсон ач холбогдолтой зохицуулалтын агуулгыг тусгаж тав эсхүл долоон гишүүнтэй байхаар зохицуулах нь зүйтэй юм.	Иймд тус зохицуулалтыг маргаан дагуулахгүй байлгах үүднээс “таваас долоон гишүүнтэй” гэснийг “тав эсхүл долоо” гэж өөрчлөн найруулах.
8.	Төслийн 18 дугаар зүйлийн 18.10-т “Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сонгуулийн хорооны үйл ажиллагаа болон хуралдаанд оролцох боломжгүй болсон бол энэ тухайгаа бичгээр болон бусад хэлбэрээр урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.”	Урьдчилан мэдэгдэх хугацаа тодорхойгүй байна.	Урьдчилан мэдэгдэх хугацааг тодорхой болгох.
9.	Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэлд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, сонгогчдийн нэрсийн жагсаалт болон сонгогч шилжих, түүнтэй холбоотой гомдол шийдвэрлэх зэрэг ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.”	Бүлэг болоод зүйлийн гарчигт “Сонгогчдын нэрийн жагсаалт” гэж бичигдсэн байхад зүйлийн доторх хэсэгт “сонгогчдын нэрийн жагсаалт”, “сонгогчдын нэрсийн жагсаалт” гэсэн хоёр янзаар бичигдсэн байна.	Тус нэр томьёог нэг мөр болгох.

www.ali.gov.mn

10.	Төслийн 20 дугаар зүйлийн 20.10-т “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нягтлан шалгасан гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг салбар комисст цахим хэлбэрээр буцаан илгээх бөгөөд уг жагсаалтыг салбар комисс гадаад улсад санал авах өдрөөс таваас доошгүй хоногийн өмнө өөрийн байранд ил тавих, цахим хуудаст байршуулах зэргээр сонгогчдод чөлөөтэй танилцах бололцоо олгоно.”	Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нягтлан шалгасан гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг салбар комисст цахим хэлбэрээр хэд хоногийн дотор буцаан илгээхийг тодорхой заагаагүй байгаа нь уг үйл ажиллагаанаас аливаа маргаан үүссэн тохиолдолд аль байгууллагын буруутай үйл ажиллагаанаас үүссэн нь тогтоогдохоргүй байна.	Гадаад улсад байгаа сонгогчдын нэрийн жагсаалтыг салбар комисст цахим хэлбэрээр буцаан илгээх хугацааг тодорхой болгох.
11.	Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн, сонгогчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаарх гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арван дөрвөөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.”	Аливаа шалтгааны улмаас санал авах өдрөөс 14 хоногийн өмнө гомдол гаргаж чадаагүй сонгогчийн тухайд сонгох эрх нь зөрчигдөхөөр харагдаж байна. Тухайлбал, хуулийн төслийн 21.1-д заасан үндэслэлээр гомдол гаргах иргэн санал авах өдрөөс 10 хоногийн өмнө энэ тухай мэдсэн тохиолдолд гомдол гаргах эрхгүй болох бөгөөд цаашилбал сонгох эрхээ эдлэх боломжгүй болж байна.[224]	Гомдол гаргах хугацаа боломжит хугацаа мөн эсэхийг дахин нягтлах.
12.	Төслийн 30 дугаар зүйлийн 30.7-д “Нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь энэ хуульд заасан шаардлага хангаагүй тохиолдолд зөрчлийг арилгасны үндсэн дээр дахин дүгнэлт гаргуулж, 40-өөс доошгүй хоногийн өмнө Сонгуулийн ерөнхий хороонд ирүүлнэ.”	Төслийн 30 дугаар зүйлийн 30.5-30.8 дахь хэсэгт харилцан уялдаа бүхий зохицуулалтыг тусгасан байхад төслийн 30.7 дахь хэсэгт “... санал авах өдрөөс ...” гэснийг орхигдуулсан байна.	Үүнийг нэмж тусгах.
13.	Төслийн 40 дүгээр зүйлийн 40.3-т “Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно.”	Төслийн 40 дүгээр зүйлд “Хууль бус сурталчилгааг хориглох” тухай зохицуулалтуудыг тусгасан харин төслийн 40.3-т “Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно” гэж заасан бөгөөд хориглосон заалтын хэсэгт “болно” гэсэн зохицуулалтыг тусгасан нь төслийн бусад заалтуудын уялдаа холбоо, утга найруулгыг алдагдуулж ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Энэхүү зохицуулалтыг зохих хэсэгт нь тусгах.

[224] Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 11 дэх талд “Сонгогчийн нэрийн жагсаалтыг сумын засаг захиргааны байранд хадгалах тохиолдлууд гарсан бөгөөд энэ нь сумын төвөөс алслагдмал суудаг орон нутгийн сонгогчдод мэдээллээ шалгахад нь хүндрэлтэй байлаа.” гэж дурджээ. https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн: 2019.01.02).

14.	“Итгэмжлэгдсэн ажилтан”-тай холбогдох төслийн зохицуулалтууд: 19.10, 19.11, 19.12; 20.7; 21.2, 21.4; 22.5, 22.6; 59.2; 61.1.5, 61.4; 69.10	Төслийн 19 дүгээр зүйлийн 19.10 дахь хэсэгт “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжилсэн ажилтан /цаашид “итгэмжлэгдсэн ажилтан” гэх/ нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хүргүүлсэн өдрөөс эхлэн сонгогчдын нэрийн жагсаалтыг хариуцан хэсгийн хорооны дэргэд ажиллана” хэмээн Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжилсэн ажилтныг төслийн бусад хэсэгт “итгэмжлэгдсэн ажилтан” гэх томьёоллоор оруулахаар хуульчилсан атал цаашид энэхүү товчилсон хувилбараар бичигдээгүй, олон янзаар буюу “улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан”; “иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан”; “иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан” гэх зэргээр ялгаатай томьёолсон нь ойлгомжгүй байдал үүсгэж байна.	Тус нэр томьёог нэг мөр болгож, хоёрдмол утгагүй байхаар томьёолох.
15.	Төслийн 63 дугаар зүйлийн 63.17-д “Энэ хуулийн 63.2-т заасныг зөрчсөн иргэн, холбогдох бусад этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл 14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулна.”	Төслийн уг заалтад “... 14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулна” гэж заасан нь Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1.1-д “баривчлах шийтгэл” гэж зааснаас өөрөөр ойлгогдохоор байна. Өөрөөр хэлбэл, төсөлд “захиргааны шийтгэл” гэж заасан нь захиргаанаас баривчлах шийтгэл оногдуулах мэтээр ойлгогдож байна.	Иймд төслийн уг заалтад “баривчлах захиргааны шийтгэл” гэж заасныг “баривчлах шийтгэл” гэж өөрчлөн найруулах.
16.	Төслийн 66 дугаар зүйлийн 66.2-т “Ажиглагч дараах эрх эдэлнэ: 66.2.2.санал авах, үйл ажиллагааг ажиглах”	Төсөл дэх ажиглагчийн эдлэх эрхийг заасан зохицуулалт болох 66 дугаар зүйлийн 66.2 дахь хэсгийн 66.2.2-т “санал авах, үйл ажиллагааг ажиглах” хэмээн хоорондоо таслал тавьснаар ажиглагч нь үйл ажиллагааг ажиглахаас гадна санал авах эрхтэй мэтээр ойлгогдож байна.	Хоёрдмол ойлголтыг залруулах үүднээс холбоо үгийн дундах таслалыг арилгах.

Түүнчлэн, энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

Хүснэгт 6. *Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх*

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	**Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал**

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУРААНГУЙ ТАЙЛАН www.mojus.mn

29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	– Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “арван найм, дөчин таван нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг ойлгохоор тусгажээ. Энэхүү ойлголт нь хоёр өөр субъектийн талаар тодорхойлж байгаа тул тусад нь зохицуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, сонгох эрх бүхий иргэний тухайд санал авах өдөр буюу түүнээс өмнө хуульд заасан насанд хүрсэн байх зохицуулалт нь хүнийг сонгох эрхээ эдлэх боломжоор хангасан хуулийн төслийн зорилгод нийцсэн зохицуулалт болсон бол нэр дэвшиж буй иргэний тухайд “дөчин таван нас хүрсэн” байх тухай зохицуулалт нь сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг ойлгохоор заажээ. Үүнээс үзвэл, сонгуулийн санал авах өдөр 45 нас хүрсэн байхад хангалттай, түүнээс өмнө 44 настай байж болно гэж ойлгогдохоор байна. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар “дөчин таван нас хүрсэн” иргэн Ерөнхийлөгчид сонгогдох эрхтэй болдог. Мөн төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т “”нэр дэвшигч” гэж дөчин таван нас хүрсэн...” гэж, 5 дугаар зүйлийн 5.4-т “Дөчин таван нас хүрсэн ... иргэн Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдох эрхтэй” гэж тус тус заасан. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгчийн сонгуульд оролцогч иргэний сонгогдох эрх тухайн насанд хүрснээр бий болох учиртай. Энэ утгаараа тус заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалт болон төслийн заалтад нийцэж байгаа эсэх нь учир дутагдалтай байна. – Төслийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07:00 цагаас 20:00[225] цаг хүртэл хугацаанд санал авах байранд авна.” гэж харин төслийн 58 дугаар зүйлийн 58.1-д “Гадаад улсад байгаа сонгогчдын саналыг Сонгуулийн ерөнхий хорооноос тогтоосон санал авах өдөр, тухайн улсын орон нутгийн цагаар 07.00 цагаас 22.00 цаг хүртэл хугацаанд салбар комиссын тогтоосон санал авах байранд авна.” гэж тус тус заасан нь сонгогчдын сонгох эрхээ эдлэх боломжид ялгавартай хандаж байгаа мэт ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заасан тэгш байдлын зарчмыг алдагдуулсан гэж үзэж болохоор байна. Иймд энэхүү ялгавартайгаар тогтоож өгсөн хугацааг ижил тогтоож өгөх нь зүйтэй юм.

[225] СЕХ-оос ирүүлсэн урьд онуудад явуулж байсан Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцийн мэдээллээс үзэхэд 2013 оны тухайд ирцийн мэдээг 11.00, 15.00, 19.00, 22.00 цагаас дөрвөн удаа гаргаж байсан бөгөөд 19.00 цагийн байдлаар ирц улсын хэмжээнд 1,073,118 иргэн санал өгсөн буюу 57.73 хувьтай байсан бол үүнээс 4 цагийн дараа буюу 22.00 цагийн байдлаар 1.234.999 иргэн санал өгсөн буюу 66.46 хувьтай болсон байна. Үүнээс харахад 19.00-22.00 цаг хүртэл 161.881 иргэн буюу 8.73 хувиар санал өгсөн иргэний тоо нэмэгдсэн байна. Харин 2017 оны тухайд ирцийн мэдээг 12.00, 17.00, 22.00 цагаас гурван удаа гаргаж байсан бөгөөд 17.00 цагийн байдлаар ирц улсын хэмжээнд 762.703 иргэн санал өгсөн буюу 38.44 хувьтай байсан бол үүнээс 6 цагийн дараа буюу 22.00 цагийн байдлаар 1.199.084 иргэн санал өгсөн буюу 60.41 хувьтай болсон байна. Үүнээс харахад 17.00-22.00 цаг хүртэл 436.381 иргэн буюу 21.97 хувиар санал өгсөн иргэний тоо нэмэгдсэн байна. Сонгуулийн ирцийн талаар цаг тутмын мэдээлэл байхгүй учраас 20.00 цаг хүртэл ирц ямар байдаг, 20.00-22.00 цагийн хооронд ирц ямар байдаг талаар бодитой тооцон гаргахад хүндрэлтэй байна. Гэсэн хэдий ч дээрх хоёр сонгуулийн 17.00-22.00 цаг, 19.00-22.00 цагийн хоорондох 4-6 цагийн ирцийн мэдээг дундажлан хувааж үзвэл 2013 онд 19.00-22.00 цагийн хооронд цагт дунджаар 40.470 иргэн буюу 2.1 хувиар, 2017 онд 17.00-22.00 цагийн хооронд цагт дунджаар 72.730 иргэн буюу 3.66 хувиар ирц өссөн дүнтэй байжээ. Энэ нь мэдээж хэлбэлзэлтэй дүн юм. Хуулийн төсөлд санал авах цагийг 2 цагийн өмнө дуусгахаар зохицуулсан нь сонгуулийн ирц хүрэхгүй байх эрсдэлийг үүсгэж болзошгүй юм.

29.1.2.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх	МУЕСтХ-ийн төсөлд сонгуулийн анхан шатны санал хураалтын үед сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулж өгсөн байна. Харин сонгуулийн хоёр дахь санал хураалт болох тохиолдолд сонгуулийн сурталчилгааг хэрхэн явуулах талаар зохицуулалтыг тусгаагүй байна.[226]
29.1.3.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх	Төсөлд зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл тусгасан нь судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.53үйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдөж болзошгүй хэд хэдэн тохиолдол илэрсэн бөгөөд энэ талаар харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй бичигдсэн болно.
29.1.6.Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

[226] Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 14 дэх талд "СТХ-иар зөвхөн сонгуулийн анхан шатны санал хураалтын үед сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулж өгсөн байна. Харин сонгуулийн хоёр дахь санал хураалтын үеэрх сонгуулийн сурталчилгааны тухайд хуулийн хийдэл байгаа нь ажиглагдав." гэж дурджээ. https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн: 2019.01.02).

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

29.1.9.Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.10.Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулаагүй байна.
29.1.11.Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх талаар харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй бичигдсэн болно.
30.1.2.Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

Хууль зүйн яамны хуулийн хүрээлэн www.hi.gov.mn

30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	– Төслийн 6 дугаар зүйлийн 6.7-д “Сонгуулийн хугацааг хугацааг санал авах өдөртэй уялдуулан жил, сар, хоног, цаг, минутаар тоолно.” гэж заасны “хугацааг” гэж давхардаж бичигдсэн тул хасах; – Төслийн 6.10-т Сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэрийг гаргасан этгээд нь нэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар нийтэд албан ёсоор мэдээлнэ гэж заасны мөрдөх “өөр гаргасан” гэж давхардаж бичигдсэн тул хасах. – Төслийн 4 дүгээр зүйлийн 4.5.1 болон төслийн 74 дүгээр зүйлийн 74.5-д “...бүрт...” гэснийг “... бүрд ...” гэж; – Төслийн 6 дугаар зүйлийн 6.13-т “... 6.12-д ...” гэснийг “... 6.12-т ...” гэж; – Төслийн 6 дугаар зүйлийн 6.14-т “... 6.4-д ...” гэснийг “... 6.4-т ...” гэж; – Төслийн 8 дугаар зүйлийн 8.7-д “... шийдвэр гарсаны дараа ...” гэж заасны “гарсаны” гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт зааснаар “гарсны” гэж; – Төслийн 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.2.1 болон 9.8 дахь хэсэгт “... програм хангамж ...” гэж заасны “програм” гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт зааснаар “... программ ...” гэж; – Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2-т “... 11.1-т ...” гэснийг “... 11.1-д ...” гэж; – Төслийн 18 дугаар зүйлийн 18.1-д “... бүрэлдэхүүний олонхийн саналаар ...” гэж заасны “олонхийн” гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт зааснаар “олонхын” гэж; – Төслийн 28 дугаар зүйлийн 28.1-д “... сонгуулийн мөрийн хөтөлбөрөө сурталчилах ...” гэж заасны “сурталчилах” гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт зааснаар “сурталчлах” гэж; – Төслийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.21, 19.23 болон төслийн 21 дүгээр зүйлийн 21.6, 21.7, 21.8-д “...сонгогчдийн...” гэж заасныг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт зааснаар “сонгогчдын” гэж; – Төслийн19 дүгээр зүйлийн 19.3-т “...сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн...” гэж заасны “Иргэдийн” гэснийг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэж заасантай нийцүүлж “иргэдийн” гэж; – Төслийн 22 дугаар зүйлийн 22.8-д “... 22.5-т ...” гэснийг “... 22.5-д ...” гэж; – Төслийн 23 дугаар зүйлийн 23.3.3-т “эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй байх” гэж заасны “хүлээлгээгүй” гэснийг “хүлээгээгүй” гэж; – Төслийн 25 дугаар зүйлийн 25.2.4-т “... 23.3-д ...” гэснийг “... 23.3-т ...” гэж; – Төслийн 31 дүгээр зүйлийн 31.6 болон 31.7-д “... 31.4-д ...” гэснийг “... 31.4-т ...” гэж; – Төслийн 37 дугаар зүйлийн 37.3-т “... 37.1-т ...” гэснийг “...37.1-д ...” гэж; – Төслийн 38 дугаар зүйлийн 38.11-д “... 38.10-д ...” гэснийг “... 38.10-т ...” гэж; – Төслийн 38 дугаар зүйлийн 38.22-т “... цуцлана.” гэснийг “... цуцална” гэж; – Төслийн 39 дүгээр зүйлийн 39.5 болон 39.6-д “... 39.4-д ...” гэснийг “... 39.4-т ...” гэж; – Төслийн 40 дүгээр зүйлийн 40.12-т “... 40.11-т ...” гэснийг “... 40.11-д ...” гэж; – Төслийн 40 дүгээр зүйлийн 40.14-т “...хяналт тавиж ...” гэж заасны “тавиж” гэснийг “тавьж” гэж; – Төслийн 40 дүгээр зүйлийн 40.14-т “... 40.9-т ...” гэснийг “... 40.9-д ...” гэж; – Төслийн 53 дугаар зүйлийн 53.6-д “... 53.3-д ...” гэснийг “... 53.3-т ...” гэж; – Төслийн 54 дүгээр зүйлийн 54.3-т “... 30.4-д ...” гэснийг “... 30.4-т ...” гэж; – Төслийн 54 дүгээр зүйлийн 54.4-т “... 54.1-т ...” гэснийг “... 54.1-д ...” гэж; – Төслийн 59 дүгээр зүйлийн 59.3 болон 59.4-т “... 59.1.1-т ...” гэснийг “... 59.1.1-д ...” гэж; – Төслийн 59 дүгээр зүйлийн 59.14-т “... 59.9-т ...” гэснийг “... 59.9-д...” гэж; – Төслийн 59 дүгээр зүйлийн 59.15-д “... 59.4-д ...” гэснийг “... 59.4-т ...” гэж; – Төслийн 61 дүгээр зүйлийн 61.14-т “... 61.12-д ...” гэснийг “... 61.12-т ...” гэж; – Төслийн 69 дүгээр зүйлийн 69.1 болон 69.1.1-д “... доор дурдсан ажиллагааг гүйцэтгэнэ:” гэж заасны “доор” гэснийг “ дор” гэж; – Төслийн 71 дүгээр зүйлийн 71.6-д “... 71.2-д ...” гэснийг “... 71.2-т ...” гэж; – Төслийн 77 дугаар зүйлийн 77.1-д “... 4.2.3-д ...” гэснийг “... 4.2.3-т ...” гэж; – Төслийн 79 дүгээр зүйлийн 79.1-д “ ... харъяалал ...” гэснийг “... харьяалал ...” гэж тус тус өөрчлөх.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ www.mojha.gov.mn

30.1.4.Хуч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5.Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.4. Хүлээн зөвшөөрөгдөх байдал

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоохдоо хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектээс анкетын судалгаа авах нь үр дүн багатай гэж үзсэний үндсэн дээр бусад арга хэрэгслүүд болох төсөлд санал авах, эрдэмтэн, судлаачдын бүтээл, илтгэлийн эмхэтгэл, цахим хуудас дахь мэдээлэл, шүүхийн практик зэргийг судлах замаар шалгасан.

Энэ хэсэгт одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ дахь сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/-ны улмаас эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд нь шүүхэд хандан нэхэмжлэл гаргах эрхтэй тухай заалтыг төсөлд хассан нь иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндөх эсэхэд дүгнэлт хийх зорилгоор доорх зохицуулалтыг сонгож авав.

79 дүгээр зүйл.Сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн тухай гомдол, маргааныг шийдвэрлэх харьяалал
79.1.Энэ хуульд заасан зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан харъяалал, журмын дагуу хянан шийдвэрлэнэ.
79.2.Сонгуулийн гомдол, маргааныг хянан шийдвэрлэж байгаа эрх бүхий этгээд тухайн гомдол, маргааны онцлог байдлыг харгалзан тухайн сонгуулийн жилд багтаан шийдвэрлэнэ.
79.4.Сонгуулийн хороод нь шатлан захирагдах зарчмаар ажиллах бөгөөд сум, дүүргийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны шийдвэрт холбогдуулан Сонгуулийн ерөнхий хороонд тус тус гомдол гаргана.
79.5.Хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэрт холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргана.
79.6.Сонгуулийн хороодын шийдвэр гарснаас хойш 7 хоногийн дотор өргөдөл, гомдол гаргах бөгөөд хугацаа хэтэрсэн гомдлыг хүлээн авахгүй.

Төслийн 79 дүгээр зүйлд хууль зөрчсөн тухай гомдол, маргааныг хянан шийдвэрлэх харьяаллыг заасан бөгөөд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ-с ялгаатай нь шүүхэд маргаан хянан шийдвэрлэх зохицуулалтыг хассан байна. СтХ-ийн Арван тавдугаар бүлэгт “Маргаан шийдвэрлэх” гэзд өргөдөл, нэхэмжлэл гаргах, зөрчил шийдвэрлэх ажиллагаа зэргийг тус тусад нь нарийвчлан зохицуулсан.

СтХ-ийн 111 дүгээр зүйлийн 111.5 дахь хэсэгт “Улсын Их Хурлын сонгуулийн талаар Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсэн болон Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэнэ” гэж; мөн хуулийн 115 дугаар зүйлийн 115.2 дахь хэсэгт “Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн сонгуультай холбогдуулан сонгуулийн төв байгууллагад холбогдох энэ хуулийн 111.5-д зааснаас бусад эрх зүйн маргааныг захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар, Улсын дээд шүүх давж заалдах журмаар хянан шийдвэрлэнэ” гэж тус тус заасан.

Гэтэл төслийн 79 дүгээр зүйлийн 79.4 болон 79.5 дахь хэсгийг үзвэл сонгуулийн хороодын шийдвэр, үйл ажиллагаанд тухайн байгууллагын дээд шатны байгууллагад гомдол гаргах, харин СЕХ-ны шийдвэрт холбогдуулан гагцхүү Үндсэн хуулийн цэцэд гомдол гаргахаар заасан нь иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндөж байна.

Үндсэн хуулийн цэцээс 2005 онд “Сонгуулийн ерөнхий хороо хуульд зааснаар ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийг улсын хэмжээнд зохион байгуулах үндсэн чиг үүрэгтэй байгууллага бөгөөд Үндсэн хуульд заасан иргэдийн сонгох, сонгогдох эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргадаг байна. Дэлхийн ардчилсан улсуудын Үндсэн хуулийн заалтаас үзэхэд энэ төрлийн маргааныг Үндсэн хуулийн шүүхтэй улсад Үндсэн хуулийн шүүх, Үндсэн хуулийн шүүхгүй улсад Дээд шүүх нь хянан шийдвэрлэдэг жишиг тогтсон байна. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2-т Сонгуулийн төв байгууллагын шийдвэр Үндсэн хууль зөрчсөн бол Үндсэн хуулийн цэц хянан шийдвэрлэхээр заажээ. Гэтэл Сонгуулийн ерөнхий хорооны шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэж байхаар Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хуульчилсан нь Үндсэн хуулиар Үндсэн хуулийн цэцэд тусгайлан олгосон эрх хэмжээнд халдсан байна”[227] гэсэн агуулга бүхий дүгнэлт гаргаж, УИХ хүлээн авснаар сонгуулийн эрх зүйн маргаан Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гарсан.

Мөн 2005 онд шинэчлэн найруулсан УИХ-ын сонгуулийн тухай хуульд СЕХ-нд холбогдох Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн талаарх маргааныг ерөнхий харьяаллаар иргэний шүүх шийдвэрлэж байхаар хуульчилсныг Үндсэн хууль зөрчөөгүй гэж Цэц дүгнэсэн байдаг[228]. СЕХ нь захиргааны байгууллага тул нэг талаас захиргааны байгууллага, нөгөө талаас иргэн, хуулийн этгээд буюу харьцангуй тэгш бус субьектүүдийн хооронд харилцаа үүсэх бөгөөд тийнхүү үүссэн маргааны харьяалал аль шүүхэд байх нь оновчтой талаар дүгнэлт хийх шаардлага урган гарна. Иргэний хэргийн шүүхэд талууд нэхэмжлэлийн үндэслэл болсон нотлох баримтаа өөрсдөө бүрдүүлж өгдөг байхад захиргааны хэргийн шүүх нь дагнасан шүүх болохын хувьд “шүүх нотлох зарчим”[229]-ын хүрээнд нотлох баримт цуглуулах үүргийг гүйцэтгэдэг.

Захиргааны үйл ажиллагааны материаллаг болон процессын хуулийг 2015, 2016 онуудад тус тус баталснаар иргэн, хуулийн этгээдээс захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар, түүнчлэн, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд, хуульд заасан бол захиргааны байгууллага тус тус Захиргааны хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх боломжтой болсон. Эдгээр шинэ хуулийн гол үзэл баримтлалын хүрээнд маргааны онцлогт тохирсон хянан шийдвэрлэх ажиллагааг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх анхан шатны журмаар шийдвэрлэх болж, үүнийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль[230] /цаашид “ЗХШХШтХ” гэх/-ийн 112 дугаар зүйлийн 112.1.3 дахь заалтад “Тусгай журмаар шийдвэрлэх маргаан” нэртэйгээр журамласан билээ.

Учир нь сонгуулийн хууль тогтоомж нь нийтийн эрх зүйн эх сурвалж мөн бөгөөд Үндсэн хуулийн шинжтэй зөрчил, маргаан үүссэн бол Үндсэн хуулийн шүүх буюу цэц шийдэх ёстой. Хэрвээ ердийн хуулийн буюу сонгуулийн хуулийн маргаан үүссэн бол захиргааны хэргийн шүүх шийдвэрлэх[231] ёстой.

Шүүхийн шийдвэрийн цахим сангаас СтХ болон ЗХШХШтХ-ийн холбогдох зохицуулалт хэрэгжиж эхэлснээс хойш өнөөдрийг хүртэлх 3 жилийн хугацаанд

[227] МҮҮХЦ-ийн 2005 оны 2 дугаар дүгнэлт “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай”, https://www.legalinfo.mn/law/details/997?lawid=997

[228] Э.Лхагвасүрэн “Хариуцлагын механизмыг сонгуулийн хуулинд нарийн тусгах хэрэгтэй” (2014.12.22), http://vip76.mn/content/28836 (Сүүлд үзсэн: 2019.01.11.)

[229] ЗХШХШтХ-ийн 7 дугаар зүйлд “Шүүх нотлох зарчим”-ыг хуульчилсан.

[230] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №9

[231] Д.Ганзориг “Үндсэн хуулийн зөрчил үү, энгийн хуулийнх уу гэдгээс хамаарч маргааныг шийдэх учиртай” (2014.12.26), http://vip76.mn/content/28970 (Сүүлд үзсэн: 2019.01.11.)

шийдвэрлэсэн Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг шүүж үзвэл Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 95 шийдвэр[232]; Улсын дээд шүүхийн 59[233] шийдвэр байна. Захиргааны хэргийн шүүх нь сонгуулийн эрх зүйн маргааныг харьяалан шийдвэрлэх нь Сонгуулийн тухай хуулийн үзэл баримтлал, иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд нийцэх тухай дээрх үндэслэлүүдийг баталгаажуулах үүднээс шүүхийн шийдвэрийн цахим сангаас ач холбогдол бүхий 2 шийдвэрийг сонгон авч, дүгнэлт хийлээ.

Тохиолдол 1.

Нэхэмжлэгч: Н.Э

Хариуцагч: Сонгуулийн ерөнхий хороо

Нэхэмжлэлийн шаардлага: Сонгуулийн ерөнхий хорооны 2017 оны .. дугаар сарын ... өдрийн "Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай" ... дугаар тогтоолыг хүчингүйд тооцуулах, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуульд М намаас нэрийг нь дэвшүүлсэн Н.Э-г Монгол Улсын Ерөнхийлөгчид нэр дэвшигчээр бүртгэхийг хариуцагчид даалгуулах

СЕХ нь 2017 оны ... дугаар сарын ... өдөр "Нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзах тухай" тогтоолыг гаргасан бөгөөд Сонгуулийн тухай хуулийн 143 дугаар зүйлийн 143.1.2-т "нэр дэвшигчид тавигдах шаардлагыг хангаагүй", 143.1.4-т "нэр дэвшигчийг бүртгүүлэхэд шаардагдах энэ хуульд заасан баримт бичиг дутуу..." гэсэн үндэслэлээр нэхэмжлэгчийг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзаж, маргаан бүхий актыг үндэслэлтэй байна гэж Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх үзсэн. Харин нэхэмжлэгч Н.Э нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч хяналтын шатны гомдол гаргасан.

Улсын дээд шүүх дүгнэхдээ: "Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2-т "Ерөнхийлөгчөөр дөчин таван нас хүрсэн, сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан, Монгол Улсын уугуул иргэнийг дөрвөн жилийн хугацаагаар сонгоно" гэж, Сонгуулийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.7-д нэр дэвшигч нь "сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан", 139 дүгээр зүйлийн 139.3.4-т "ял шийтгүүлж байгаагүй, эсхүл ял шийтгүүлж байсан бол ялгүй болсон буюу ялгүйд тооцогдсон байх" гэсэн шаардлагыг заасан байх бөгөөд хариуцагч Цагдаагийн ерөнхий газар болон Хил хамгаалах ерөнхий газрын тодорхойлолтыг үндэслэн хуульд заасан эдгээр шаардлагыг хангаагүй гэж үзэн нэхэмжлэгчийг нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан шийдвэр гаргасныг буруутгах боломжгүй байна. Учир нь, давж заалдах шатны шүүхийн дүгнэсэнчлэн эрх бүхий этгээдийн гаргасан "ялтай" гэсэн тодорхойлолтын үнэн зөв эсэхийг шалгах, цаашлаад иргэний ял шийтгэлийн талаар тодорхойлох бүрэн эрх хариуцагчид хуулиар олгогдоогүй болно. ... Сонгуулийн тухай хуулийн 142 дугаар зүйлийн 142.1.10 дахь хэсэгт "сүүлийн таваас доошгүй жил эх орондоо байнга оршин суусан"-ыг иргэний бүртгэлийн байгууллага биш, харин "хилийн алба" тодорхойлохоор заасан ... Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд нэхэмжлэгчийг нэр дэвшигчээр бүртгүүлэхээр ирүүлсэн баримт бичигт Сонгуулийн тухай хуулийн 142 дугаар зүйлийн 142.10-т заасан хилийн албаны тодорхойлолтыг бус харин нэхэмжлэгчийн гадаад паспротын хуулбар болох 32 хуудас баримт ирүүлсэн, энэ талаар нэхэмжлэгч маргаагүй тул хариуцагчаас мөн хуулийн 143 дугаар зүйлийн 143.1.4-т заасныг үндэслэн нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан нь хууль зөрчөөгүй, иймээс нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзэх үндэслэлгүй, энэ талаарх давж заалдах шатны шүүхийн дүгнэлт зөв байна" гэж үзэж Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж шийдвэрлэсэн.

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2017.06.28, Дугаар 266

[232] Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэрлэсэн сонгуулийн маргаан - Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, http://new.shuukh.mn/zahirgaadavah (Сүүлд үзсэн: 2019.01.14.)

[233] Улсын дээд шүүхийн шийдвэрлэсэн сонгуулийн маргаан – Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, http://new.shuukh.mn/zahirgaahyanalt (Сүүлд үзсэн: 2019.01.14.)

Тохиолдол 2.

Нэхэмжлэгч: А.Т

Хариуцагч: Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга

Нэхэмжлэлийн шаардлага: Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны Хууль, эрх зүйн хэлтсийн даргын 2016 оны ... дугаар сарын ... өдрийн ... дугаар албан бичгийг хүчингүй болгуулж, Улсын Их Хурлын ... дугаар тойрогт М намаас нэр дэвшигч А.Т-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Я.С-ээс Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хороонд 2016 оны ... дугаар сарын ... өдөр гаргасан гомдлыг Сонгуулийн ерөнхий хорооны хуралдаанаар хэлэлцэхийг хариуцагчид даалгуулах

Нэхэмжлэгч А.Т нь 2016 онд УИХ-ын ... дугаар тойрогт М намаас нэр дэвшихтэй холбоотой гомдлыг шийдвэрлүүлэхээр СЕХ-нд хандсан боловч гомдлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэлгүйгээр, "гомдолтой танилцаад хэлтсээрээ хариу өгье" гэжээ Хууль, эрх зүйн хэлтсийн даргаар шийдвэрлүүлсэн бөгөөд Хууль, эрх зүйн хэлтсийн дарга нь "хангаж шийдвэрлэх үндэслэлгүй" гэсэн албан бичгээр гомдлын хариуг өгчээ. Нэхэмжлэгч тус албан бичгийг эс зөвшөөрч, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргахад шүүхээс нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгосон тул Улсын дээд шүүхэд хяналтын шатны журмаар хандсан.

Улсын дээд шүүх дүгнэхдээ: "Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д Хорооны дарга "Хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх", 9.2-т "Хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах" гэснийг "дарга Хорооны бүрэн эрхийн асуудлыг дангаар шийдвэрлэх, Хорооны бүрэн эрхэд хамаарах асуудлыг хуралдаанаар хэлэлцэх эсэхийг шийдвэрлэх" гэсэн утгаар тайлбарлах боломжгүй юм. ... Маргаан бүхий актаар нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гомдолд эрх хэмжээгүй этгээд болох Хууль, эрх зүйн хэлтсийн дарга "гомдлыг хянан шийдвэрлэх үндэслэлгүй" хэмээн татгалзсан хариу өгсөн нь хууль бус, түүнчлэн, эрх бүхий этгээд болох Сонгуулийн ерөнхий хороо гомдлыг хуралдаанаараа хэлэлцээгүй нь хууль зөрчсөн эс үйлдэхүй байх тул нэхэмжлэлийн дээрх шаардлагын талаар гаргасан нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн гомдлыг хангах үндэслэлтэй" гэж үзэж Давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2017.04.24, Дугаар 145

http://new.shuukh.mn/zahirgaahyanalt/876/view

Дээрх хоёр тохиолдлыг үзвэл эхний тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуульд М намаас нэр дэвшигч Н.Э-г нэр дэвшигчээр бүртгэхээс татгалзсан СЕХ-ны шийдвэр буюу захиргааны акт нь эрх зүйн үндэслэлтэй бөгөөд нэхэмжлэгчийн эрх, ашиг сонирхлыг зөрчөөгүй гэдгийг Захиргааны хэргийн шүүх шийдвэрээрээ баталгаажуулж, захиргааны итгэлийг хамгаалсан байна. Хоёр дахь тохиолдолд СЕХ хуралдаанаараа хэлэлцэх ёстой эрх хэмжээний асуудлыг хэлэлцэлгүйгээр Хууль, эрх зүйн хэлтсийн даргаараа албан бичгээр хариу өгүүлсэн нь хууль зөрчсөн эс үйлдэхүй бөгөөд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн болохыг тогтоосноор захиргааны үйл ажиллагаа хууль ёсны байх зарчмыг хэрэгжилтийг хангажээ.

СЕХ-ны сонгуулийн тухай хуультай холбогдуулан гаргасан захирамжилсан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх нь Үндсэн хуулийг зөрчихгүй бөгөөд харин Үндсэн хууль болон захиргааны эрх зүйн суурь үзэл баримтлалд нийцэх; иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах; СЕХ-ны үйл ажиллагааг баталгаажуулж, захиргааны итгэлийг хамгаалах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Иймд СЕХ-ны сонгуультай холбогдуулан гаргасан шийдвэр нь Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил үү, эсхүл захиргааны эрх зүйн зөрчил үү гэдгийг харгалзан үзэж маргааны харьяаллыг тогтоох нь зүйтэй тул төслөөс шүүхийн хяналтыг хассан зохицуулалтыг эргэн харж, хуульчлах шаардлагатай байна.

3.5. Харилцан уялдаа

Төслийн харилцан уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн, хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Хүснэгт 7. *Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал*

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зорилтод сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байх тул хуулийн төслийн 5 дугаар зүйл, 8 дугаар зүйл нийцэхгүй байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх	
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	– Төслийн 31 дүгээр зүйлийн 31.7-д "Энэ хуулийн 31.1, 31.4-д заасныг зөрчсөн нь радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг Харилцаа холбооны зохицуулах хороо зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно", төслийн 40 дүгээр зүйлийн 40.14-т "Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 40.9-т хяналт тавиж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно" гэж тус тус заасан. Гэтэл Харилцаа холбооны тухай хууль[234] /цаашид "ХХтХ" гэх/-д "зогсоох" гэсэн үгийг гагцхүү хэрэглэгч, үйлчлэгчид хамааруулан ойлгохоор хуульчилсан. Харин ХХЗХ-ны үйл ажиллагаанд "түдгэлзүүлэх", "хүчингүй болгох" гэсэн үгийг хамааруулан ойлгохоор тусгажээ. – Төслийн 38 дугаар зүйлийн 38.22-т телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулсан бөгөөд ХХтХ-д "гэрээ цуцлах" гэсэн ойлголт байхаас тусгай зөвшөөрлийг цуцлах тухай нэр томьёо байхгүй, дээр дурдсанчлан "хүчингүй болгох" гэсэн нэршлээр илэрхийлдэг. Иймд "цуцална" гэснийг "хүчингүй болгоно" гэж өөрчлөн найруулах шаардлагатай.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	– Хуулийн төслийн зүйл, заалт бусад хуультай нийцэж байгаа эсэх: – Төслийн 5 дугаар зүйлийн 5.9, 12 дугаар зүйлийн 12.20, 18 дугаар зүйлийн 18.24, 78 дугаар зүйлийн 78.4-т "...төрийн албанд нэг жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах үндэслэл болно." гэж заасан нь 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хууль[235] /цаашид "ТАтХ" гэх/-ийн 48 дугаар зүйлийн 48.1.4-т "...төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах" гэж заасантай зөрчилдөхөөр байна. – Төслийн 6 дугаар зүйлийн 6.3-т "Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө өгнө.", төслийн 63 дугаар зүйлийн 63.5-д "Сонгогч саналын хуудаст саналаа тэмдэглэх үед тухайн сонгогчийн дэргэд өөр хүн байхыг хориглоно." гэж тус тус заасан нь ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож саналаа өгөх тухай ойлгогдож байхад төслийн 63 дугаар зүйлийн 63.12-т "Бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болно." мөн төслийн 63 дугаар зүйлийн 63.13-т "Энэ хуулийн 63.12-т заасан итгэмжилсэн иргэн нь хоёроос дээш сонгогчид туслалцаа үзүүлэхийг хориглоно. Сонгуулийн байгууллагын ажилтан, нэр дэвшигч, ажиглагч, улс төрийн албан тушаалтан нь итгэмжилсэн иргэн байж болохгүй." гэж заасан нь ямар нэг төлөөлөлгүйгээр санал өгөх тухай зохицуулалттай нийцэхгүй байгаа мэт ойлгогдож байна.

[234] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43
[235] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2018), №01

	– Төслийн 6 дугаар зүйлийн 6.7-д сонгуулийн хугацааг санал авах өдөртэй уялдуулан жил, сар, хоног, цаг, минутаар тоолохоор зохицуулсан боловч төслийн 6 дугаар зүйлийн 6.8-д "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хугацаа тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална" гэж заасан нь 6.7-д заасан хугацаа тоолох зохицуулалтыг тусгагдаагүй мэтээр ойлгоход хүргэж байна. Нэгэнт төслийн 6.7-д нарийвчилсан байдлаар хэрхэн хугацаа тоолохыг тусгаж өгсөн байхад 6.8-д энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэж заасан нь төслийн 6.7 дахь заалтыг үгүйсгэсэн хуулийн зөрчлийг бий болгож байна. – Төслийн 19 дүгээр зүйлийн 19.6.6-д заасан заалт нь цагдаагийн байгууллагын хувьд сонгуулийн санал авах өдөр /төслийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу "Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн зургадугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна"/ зөрчлийн улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн улмаас цагдан хоригдсон сонгогчдын мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллагад хүргүүлэхээр, харин төслийн 19 дүгээр зүйлийн 19.6-д заасан зохицуулалт нь ээлжит сонгуулийн жилийн тавдугаар сарын 15-ны өдрөөс өмнө буюу сар гаруйн өмнө тухайн мэдээллийг хүргүүлэхээр заасан нь зөрчил үүсгэж байна. – Төслийн 22 дугаар зүйлийн 22.1-д "Сонгогчийн шилжилтийг санал авах өдрөөс арван дөрөв хоногийн өмнө, шилжин ирсэн сонгогчийн бүртгэлийг санал авах өдрөөс арав хоногийн өмнө тус тус зогсооно." гэж, төслийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн, сонгогчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаарх гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арван дөрвөөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана." гэж тус тус зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн 22 дугаар зүйлийн 22.1-д шилжин ирсэн сонгогчийн бүртгэлийг санал авах өдрөөс 10 хоногийн өмнө зогсоохоор заасан гэтэл хуулийн төслийн 21 дүгээр зүйлийн 21.1-д шилжилт хөдөлгөөнтэй холбоотой гомдлыг санал авахаас 14 хонгийн өмнө гаргасан байхаар заасан нь хуулийн төслийн зүйл, заалтууд харилцан уялдаагүй байгааг харуулж байна. – Төслийн 38 дугаар зүйлийн 38.21-д "Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх талаар энэ хуулийн 38.17-д заасан журам зөрчсөн радио, телевизэд эхний удаа сануулах арга хэмжээ авах бөгөөд дахин зөрчил гаргавал санал авах өдөр хүртэл сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхийг цуцлах тухай шийдвэр гаргана." гэж заасан. Гэтэл төслийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "Сонгуулийн сурталчилгааг нэр дэвшигчид үнэмлэх олгосон өдрөөс эхлүүлж, санал авах өдрөөс 24 цагийн өмнө буюу санал авах өдрийн өмнөх өдрийн 00.00 цагаас өмнө зогсооно." гэж нийт нэр дэвшигчдийн сурталчилгаа явуулах хугацааг эрх тэгш олгосон зохицуулалтыг тусгасан байхад сурталчилгааны үед радио, телевизийн буруутай үйл ажиллагаанаас болж эсхүл магадгүй бусад нэр дэвшигчийн үйлдлээс болж тухайн радио, телевизийн сурталчилгаа нэвтрүүлэх эрхийг цуцалсан тохиолдолд сурталчилгаа хийлгэхээр харилцан тохиролцсон бусад нэр дэвшигчийн эрх зөрчигдөхөд хүрч байна. – Төслийн 39 дүгээр зүйлийн 39.2-т сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар сурталчилгаа явуулж болох талаар тусгасан бол төслийн 40 дүгээр зүйлийн 40.4.18-д сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглох тухай заасан нь зөрчилтэй ойлголтуудыг бий болгож байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭС www.01.law.mn

	– Төслийн 40 дүгээр зүйлийн 40.1.4-т “бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах”-ыг хориглох тухай, төслийн 40 дүгээр зүйлийн 40.13-т “Энэ хуулийн 40.1-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван нэгээс арван зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох”-оор заасан бөгөөд энэхүү заалтад заасан бусдыг гүтгэх доромжлох, хуурамч мэдээлэл тараах нь Зөрчлийн тухай[236] хуулийн 6.21 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан. “Гүтгэх” зөрчлийн шинжийг мөн агуулж байна. Энэ тохиолдолд хэрэв төсөлд зааснаар хариуцлага оногдуулбал /нэгжийг мөнгөн дүнд шилжүүлж үзвэл[237]/ иргэнийг 320.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3.520.000-5.120.000 төгрөгөөр, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг 1.920.000-2.560.000 төгрөгөөр тус тус торгохоор байна. Харин Зөрчлийн тухай хуульд зааснаар дээрх зөрчлийг үйлдсэн хүнийг 2.000.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 20.000.000 төгрөгөөр торгохоор хуульчилсан байна. Иймд төслийн 40.1-д заасан бусад заалтуудаас мөн Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой заалтуудыг хуулийн давхардал үүсгэхгүй байлгах үүднээс Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээр зохицуулах шаардлагатай. – Төслийн нийт 53 зүйл, заалтад /5.8, 6.14, 11.10, 12.17-12.19, 12.21, 18.23, 19.24, 20.11, 21.9, 22.8, 28.9, 29.5, 31.5, 31.6, 32.5, 33.13, 34.9, 35.3, 36.6, 37.3, 38.22, 39.9, 40.12, 40.13, 42.6, 44.4, 45.8, 46.4, 48.8-48.10, 49.5, 49.6, 53.6, 54.4, 57.12, 58.9, 59.14, 59.15, 61.14, 61.15, 62.5, 63.16, 63.17, 64.13, 65.5, 66.4, 68.3, 69.18, 71.6, 72.3/ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарч торгууль оногдуулахаар заасан байна. Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарч торгууль ногдуулахаар төсөлд тусгасан нь хэд хэдэн асуудлыг бий болгож болохоор байна. Тухайлбал, Хууль тогтоогч төсөлд тусгасан торгох шийтгэлийн хэмжээг өөрчлөөгүй байхад Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэр өөрчлөгдвөл уг хуульд заасан торгуулийн хэмжээ өөрчлөгдөхөд нөлөөлж байна.[238] Түүнчлэн, Монгол Улсад дагаж мөрдөгдөж буй хуулиуд хоорондоо давхардал, хийдэл, зөрчилгүй хүн бүрд тодорхой ойлгомжтой нэгдмэл нэг ойлголтоор ойлгогдох ёстой. Тиймээс ч 2017 оноос эхлэн дагаж мөрдөгдөх болсон Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуульд торгох ял, шийтгэлийг хуульчилж өгсөн бөгөөд ийнхүү хуульчлахдаа “нэгж” гэх ойлголтыг бий болгож, нэг нэгж нь 1000 төгрөгтэй тэнцүү байхаар тусгасан. Өөрөөр хэлбэл, торгох ял, шийтгэлийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр /Засгийн газрын тогтоолоор/ өөрчлөгдөж буй явдлыг зогсоох эрх зүйн үндэслэлийг бий болгосон юм.

[236] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24

[237] "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2018 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320.000 /гурван зуун хорин мянга/-н төгрөгөөр тооцов.

238

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭС www.ccpa.mn

Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төслийн заалттай давхардсан эсэх: – Төслийн 5 дугаар зүйлийн 5.6 болон 5.7 дахь хэсэг нь төслийн 6 дугаар зүйлийн 6.4 болон 6.5 дахь хэсэгтэй хэлбэр болон агуулгын хувьд давхардсан ба үүнтэй холбоотойгоор тус зүйлүүдэд хамаарах санкцууд; – Төслийн 40 дүгээр зүйлд "Хууль бус сурталчилгааг хориглох" хэсэгт хориглосон үйл ажиллагааг жагсаахдаа мөн зүйлийн 40.1.7, 40.1.9-г хэлбэр, агуулгын хувьд; – Төслийн 61 дүгээр зүйлийн 61.14 болон 61.15 дахь хэсгийн санкцууд; – Төслийн 69 дүгээр зүйлийн 69.16 болон 72 дугаар зүйлийн 72.1, мөн төслийн 69 дүгээр зүйлийн 69.17 болон 73 дугаар зүйлийн 73.1 дэх хэсгүүд нь хоорондоо хэлбэр, агуулгын хувьд тус тус давхардсан байна. Хуулийн төслийн зүйл, заалт нь бусад хуулийн заалттай давхардсан эсэх: МУЕСтХ-ийн төсөлд УИХ-ын сонгуулийн тухай хууль, Орон нутгийн хурлын сонгуулийн тухай хуультай хэлбэр болон агуулгын хувьд давхардсан заалт олон байна.[239]
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Төслийн 40 дүгээр зүйлийн 40.16-д "... Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага санал хураалтын дүн гарах хүртэлх хугацаанд үйл ажиллагааг зогсоох тухай дүгнэлтийг зөвшөөрөл олгосон байгууллагад нь хүргүүлэх арга хэмжээг авч болно." гэж, харин төслийн 40 дүгээр зүйлийн 40.18-д "Шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь хэвлэл мэдээллийн байгууллагад эхний удаа сануулах арга хэмжээ авч болно." гэж зааснаас үзвэл хариуцлага хүлээлгэх эрх бүхий этгээд нь хоёр өөр байгууллага байхаар харагдаж байна. Үүнээс үүдэн төслийн 40 дүгээр зүйлийн 40.17-д "... шударга өрсөлдөөний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн хэвлэл мэдээллийн байгууллагын үйл ажиллагааг нэн даруй зогсоох арга хэмжээ авна." гэж заахдаа ямар субъект үйл ажиллагааг зогсоох талаар тодорхой дурдаагүй нь ойлгомжгүй байдлыг үүсгээд байна.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Төслийн 53, 54 дүгээр зүйлд сонгуулийн зардлын тайлан болон түүнд хийх хяналт ба нээлттэй, ил тод байдлын талаар тусгажээ. Гэхдээ зардлын тайлангаа гаргаж өгөх хугацааны хувьд санал авах ажиллагаа явагдсан өдрөөс хойш 45 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад гаргаж өгнө, төрийн аудитын байгууллага тайланг хүлээн авснаас хойш 90 хоногийн дотор хянаж, дүнг нийтэд мэдээлнэ гэж зааснаас үзвэл сонгуулийн сурталчилгааны үеэр сурталчилгаатай холбоотой зардлын мэдээллийг шалгах, нийтэд ил тод байлгах, сонгогчид санал өгөхөөс өмнө нэр дэвшигчдийн болон улс төрийн намуудын санхүүгийн талаар мэдээлэл авах[240] боломж хязгаарлагдсан харагдаж байна. Иймд сонгуулийн сурталчилгаа дуусахаас өмнө сонгуулийн сурталчилгааны орлого, зарлагын төсөөллийг ил болгож, цахим хэлбэрээр олон нийтэд мэдээлэх тухай зохицуулалт тусгаж өгөх шаардлагатай.[241]

[239] СЕХ-оос хийсэн хуулийн төслүүдийн харьцуулалтаас дэлгэрүүлэн үзнэ үү.

[240] Авлигын эсрэг конвенцийн 7 (3) зүйлд "оролцогч улс орон бүр сонгуульт төрийн байгууллагад нэр дэвшүүлэх, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгохын тулд хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээ авах талаар анхаарч үзэх"-ыг санал болгодог. Улс төрийн намын зохицуулалтын тухай 194 дүгээр зүйлд "сонгогчид нь улс төрийн намуудыг хариуцлагатай байлгахын улс төрийн намуудад өгсөн санхүүгийн дэмжлэгийн талаар холбогдох мэдээлэлтэй байх ёстой" гэжээ.

[241] Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 19 дэх талд "... сонгуулиас өмнө намуудын орлого, зардлын тайланг ил болгох тухай ямар нэг заалт байсангүйгээс гадна намуудаас аль нь ч сурталчилгааны зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг сайн дураар тайлагнасангүй. Тиймээс сонгуулийн сурталчилгааны үеэрх сурталчилгааны зардлыг шалгаж, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн журмыг зөрчсөн эсэхийг илрүүлж, зохих арга хэмжээг шуурхай авах боломжгүй байлаа. Түүнчлэн, сонгогчид санал өгөхөөсөө өмнө нэр дэвшигчдийн болон улс төрийн намуудын санхүүгийн байдлын талаар баталгаатай мэдээлэл авах боломжгүй байсан нь хариуцлагатай сонголт хийх болон нэр дэвшигчдэд хариуцлага тооцох боломжийг сонгогчдод олгосонгүй." гэж дурджээ.
https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн: 2019.01.02).
Мөн энэ талаар 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгээс хамтран зохион байгуулсан "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг"-т оролцсон оролцогчдоос сурталчилгааны зардлын тайланг ил болгох, тухай бүрд нь мэдээлж байх талаар санал гаргаж байсан байна.

Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Төслийн 19 дүгээр зүйлийн 19.19-т “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, давхардлыг шалгах, сонгогч шилжих журмыг энэ хуулийн 19 дүгээр зүйлд нийцүүлэн батлан мөрдүүлнэ” гэж, мөн зүйлийн 19.23-т “Сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн тагнуулын байгууллага батална” гэж тус тус заасан. Эдгээр зохицуулалтуудаас үзвэл сонгогчдын нэрийн жагсаалт танилцуулах журмыг батлах эрхийг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тагнуулын байгууллагад давхардуулан олгосон мэт ойлгогдож байна.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Төсөлд татвар, төлбөр хураамж шинээр тогтоосон зүйлгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Төслийн 38 дугаар зүйлийн 38.22-т “38.11-д заасныг зөрчсөн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо цуцлана” гэж заасан. Мөн зүйлийн 38.11-д “... шаардлага хангаагүй телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно” гэжээ. ААҮАТЗтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.16-д “Мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр” олгох тусгай зөвшөөрлийг мөн хэсгийн 15.16.3-д “контентийн үйлчилгээ эрхлэх” гэж хуульчилсан. Үүнээс үзвэл төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг ААҮАТЗтХ-д тусгасан гэж үзэж болох боловч нэр томьёоны хувьд ялгаатай байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл, заалт байхгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Төслийн 33 дугаар зүйлийн 33.9-д “Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхийлөгч сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тарааж болно. Үүнийг сонгуулийн сурталчилгааны материалын хэмжээнд тооцохгүй.” гэж заасан нь Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшсэн тохиолдолд түүнд давуу эрх бий болгосон зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, нэр дэвшсэн Улсын Их Хурлын гишүүн хийсэн ажлын тайлангаа ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тарааж байгаа нь бусад нэр дэвшигчдээс давуу эрх эдлэн, өөрийн ажлыг тайлагнах замаар сонгуулийн сурталчилгаа хийж буй үйл ажиллагаа гэж ойлгогдох боломжтой юм.
Авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУУЛЬЧИЙН
www.mojoy.mn

Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	– Төслийн 78 дугаар зүйлийн 78.3-т “Сонгуулийн үйл ажиллагааны явцад Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэснийг үзвэл чухам ямар хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй харагдаж байна. Учир нь эдийн болон эдийн бус хохирол учруулсантай холбогдох асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон шийдвэрлэдэг. Иймд “Иргэний хууль болон бусад хууль” гэж өөрчлөн найруулах буюу тодруулах шаардлагатай. – Төслийн Долдугаар бүлэг болох Сонгуулийн зардал хэсэгт тусгагдсан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтууд нь гаргасан зөрчилтэй харьцуулахад харьцангуй бага байгаа ажиглагдаж байна. Тухайлбал, төслийн 42 дугаар зүйлийн 42.6-д “Энэ хуулийн 42.3, 42.5-д заасныг зөрчсөн нам, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс хорин зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан торгуулийн хэмжээг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр[242] тооцон үзвэл 6.720.000-8.320.000 /зургаан сая долоон зуун хорин мянгаас найман сая гурван зуун хорин мянга/-н төгрөг байхаар байна. Энэхүү зохицуулалтыг сонгуулийн нийт зардлын мөнгөн хөрөнгөд харьцуулж үзвэл хэд дахин бага торгууль ногдуулахаар харагдаж байна. Мөн төслийн 44 дүгээр зүйлийн 44.4-т “Энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасныг зөрчсөн нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс хорин зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.” гэж заасан нь дээр дурдсан төслийн 42 дугаар зүйлд тусгасан санкцийн адил нийт дүнд харьцуулж үзвэл торгуулийн хэмжээ бага байхаар ойлгогдож байна.[243]

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 1993 онд баталсан МУЕСтХ-иар 1993-2009 оны хооронд 5 удаа, 2013 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 2012 онд батлагдсан МУЕСтХ-иар, 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг 2015 онд батлагдсан СтХ-иар тус тус зохион байгуулан явуулж байжээ.

МУЕСтХ-ийн төслөөр ерөнхийдөө ардчилсан сонгууль явуулах үндэслэлийг гаргаж тавьсан хэдий ч дийлэнх зохицуулалт нь одоо мөрдөгдөж буй СтХ болон өмнө мөрдөгдөж байсан МУЕСтХ-иудыг хуулбарлан бичсэн зохицуулалтууд байна.

Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль нь тус бүрдээ онцлог зохицуулалттай харилцаа болохын хувьд тус бүрд нь тухайлсан хуулиар зохицуулах нь зүйтэй боловч хуулийн төсөлд нийтлэг ажиглагдаж буй засаж сайжруулах шаардлагатай зохицуулалт цөөнгүй байна. Эдгээрийг сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

[242] "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2018 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320.000 /гурван зуун хорин мянга/-н төгрөгөөр тооцов.

[243] Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 20 дахь талд “Ерөнхийдөө сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоотой зөрчлүүдэд оногдуулдаг арга хэмжээнүүд нь үр дүн муутай, тохиромжгүй байгаагийн зэрэгцээ сонгууль явуулах олон улсын сайн туршлагад зөвлөсний дагуу нэр дэвшигчдэд ижил тэгш өрсөлдөх боломж, нөхцөлийг хангаж өгөхгүй байна.” гэж дурджээ. https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн: 2019.01.02).

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үзэл баримтлалыг үзвэл гурван зорилт дэвшүүлсэн байх бөгөөд дэвшүүлсэн зорилт бүрийн хүрээнд хамаарах тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлсэн. Тодруулбал, (1) "Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах" зорилтын хүрээнд хуулийн зорилт болон сонгуулийн сурталчилгааны цахим хуудастай холбогдох зохицуулалтыг; (2) "Ерөнхийлөгчийн сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах" зорилтын хүрээнд сонгуулийн үйл ажиллагааны зарчим, сонгуульд нэр дэвших этгээдтэй холбоотой зохицуулалтыг; (3) "Сонгуулийн хороодын бүрэн эрх, ажлын зохион байгуулалттай холбогдсон харилцааг бусад сонгуулийн хуультай нийцүүлэн боловсронгуй болгох" зорилтын хүрээнд сонгуулийн хороодын бүрэлдэхүүнтэй холбоотой зохицуулалтыг тус тус сонгон авч үнэллээ.

- Төсөлд хэлбэрийн хувьд шинэлэг зохицуулалт цөөнгүй боловч агуулгын хувьд шинэ зохицуулалт ховор байсан тул "хуулийн зорилт" болон "сонгуулийн сурталчилгааны цахим хуудас"-ын тодорхойлолтыг шинээр томьёолсонтой холбоотой зохицуулалтыг сонгон авсан. Гэвч тийнхүү шинээр томьёолохдоо бусад зүйл, заалтуудын уялдааг нягтлан шалгаагүйн улмаас хуулийн зохицуулалт хоорондын зөрчилтэй байдлыг бий болгож байв. Мөн хуулийн зорилтыг томьёолохдоо зохицуулах харилцааг дутуу томьёолсныг өргөжүүлэх шаардлага тулгарч байна.
- Хууль зүйн шинжлэх ухааны гол ойлголтуудын нэг нь эрх зүйн зарчим байдаг. Төсөлд сонгуулийн эрх зүйн зарчмыг хуульчлахдаа бүх нийтээр баримтлах түгээмэл зарчмыг хуульчилсан нь сайшаалтай. Гэсэн хэдий ч шаардлагатай зарчим, тодруулбал, "тэгш эрхийн зарчим" болон сонгууль зохион байгуулж явуулах зарчмуудын ихэнхийг нь орхигдуулжээ.
- Үндсэн хуулийн Гучдугаар зүйлд зааснаар УИХ-д суудалтай намууд дангаараа буюу хамтран Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшүүлэх эрхтэй. Мөн СтХ-д зааснаар УИХ-д суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжиж оролцож болно. Төсөлд дэмжиж оролцох зохицуулалтыг хассан боловч хориглоогүй байгаа нь практикт эргэлзээтэй байдлыг үүсгэхээр байна. Түүнчлэн, бие даан нэр дэвших асуудлыг цаашид Үндсэн хуулийн хүрээнд хэлэлцэх шаардлагатай юм.
- Сонгуулийн хороод нь хамтын удирдлагатай бөгөөд эрх хэмжээнийхээ асуудлыг гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон хуралдаанаар хэлэлцэж, олонхийн саналаар шийдвэрлэдэг тул бүрэлдэхүүний тоог тодорхой байдлаар, сондгой тоогоор тогтоох нь зүйн хэрэг юм. Гэтэл төслийн зохицуулалтад "таваас долоо" гэснээр бүрэлдэхүүний тоо "зургаа" ч байж болохоор ойлгогдож байна.

"Практикт хэрэгжих боломж" шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч нь Үндсэн хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд үзэл баримтлалаа тодорхойлсон сонгуулийн мөрийн хөтөлбөртэй байх бөгөөд тэрхүү мөрийн хөтөлбөртөө төрийн аудитын дээд байгууллагаар дүгнэлт гаргуулдаг. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах төрийн аудитын дээд байгууллагад олгогдсон хугацаа нь практикт хэрэгжиж боломжтой эсэх талаар авч үзэв.

Нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрт дүгнэлт гаргах, хуульд нийцээгүй тохиолдолд алдааг засуулан дахин дүгнэлт гаргах, СЕХ-нд хүргүүлэх зэрэг ажиллагаанд нийтдээ 10 хоногийг Үндэсний аудитын газарт төслөөр олгосон байна.

Гэтэл олон улсын стандартын дагуу аудит хийхэд тодорхой хугацаа шаардагддаг тул нэр дэвшигч нь мөрийн хөтөлбөрөө СЕХ-нд бүртгүүлэхээс доод тал нь 14-өөс доошгүй хоногийн өмнө ирүүлсэн тохиолдолд аудит хийх боломжтойг харгалзан үзэх зайлшгүй шаардлагатай байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэлэхэд төслийн зарим зүйл, заалт шаардлагад нийцээгүй болох нь тогтоогдож байна. Үүнд:

- Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж ойлгомжгүй байдал үүсгэж буй, төслийн зохих хэсэгт тусгаагүй зүйл, заалт хэд хэд байна. Тухайлбал, төслийн 6 дугаар зүйлийн 6.4-т хоргилсон заалт тусгасан байтал төслийн зарчмын хэсэгт оруулсан, төслийн 40 дүгээр зүйлд хориглох заалтууд тусгасан хэдий ч 40.3-т “болно” гэсэн зохицуулалтыг оруулсан, төсөлд “Итгэмжлэгдсэн ажилтан” гэх нэр томьёог хоёрдмол утгаар ойлгогдохоор, процесс үйл ажиллагаа нь өөр өөр байх тохиолдлуудад “нэн даруй” гэсэн ойлголтыг нэгдмэл байдлаар тусгасан байна.
- Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой уялдаагүй заалт хэд хэд байна. Тухайлбал, төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “арван найм, дөчин таван нас хүрсэн” гэсэн нэр томьёог тодорхойлон тусгасан хэдий ч нэр дэвшигчийн тухайд энэхүү тодорхойлолт нь МҮҮХ болон хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт тусгасан зохицуулалттай зөрчилдөхөөр байна. Мөн төслийн 57 дугаар зүйлийн 57.1-д сонгогчийн саналыг Улаанбаатарын цагаар санал авах өдрийн 07.00-20.00 цагийн хооронд авахаар, төслийн 58 дугаар зүйлийн 58.1 дэх хэсэгт гадаад улсад байгаа сонгогчийн саналыг санал авах өдөр тухайн улсын орон нутгийн цагаар 07.00-22.00 цагийн хооронд авахаар тусгасан нь МҮҮХ-д заасан тэгш байдлын зарчмыг алдагдуулж, иргэдэд ялгавартай хандсан зохицуулалт болсон гэж үзэж болохоор байна.
- Хэл зүйн найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцээгүй зүйл, заалт нэлээд байна. Үүнийг үнэлгээний тайлангийн хүснэгт 6-д дэлгэрэнгүй тусгалаа.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй СтХ дахь сонгуулийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагаа /үйлдэл, эс үйлдэхүй/-ны улмаас эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн гэж үзсэн аливаа этгээд нь шүүхэд хандан нэхэмжлэл гаргах эрхтэй тухай заалтыг төсөлд хассан нь иргэн, хуулийн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хөндөх эсэхэд дүгнэлт хийх зорилгоор шүүхийн хяналтыг хассантай холбоотой зохицуулалтыг сонгон авч үзэв.

СЕХ-ны сонгуулийн тухай хуультай холбогдуулан гаргасан захирамжилсан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэх нь Үндсэн хуулийг зөрчихгүй бөгөөд харин Үндсэн хууль болон захиргааны эрх зүйн суурь үзэл баримтлалд нийцэх; иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах; СЕХ-ны үйл ажиллагааг баталгаажуулж, захиргааны итгэлийг хамгаалах зэрэг олон талын ач холбогдолтой юм. Иймд шүүхийн хяналтыг төслөөс хассан нь үндэслэлгүй зохицуулалт болжээ.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай 14 төрлийн асуулгаас 4 төрлийн асуулга шаардлага хангасан, уялдаа холбоотой болсон бөгөөд төсөлд шинээр албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зүйлгүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, авилга хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна.

Шалгуур үзүүлэлтэд заасан 10 асуулгын хүрээнд хуулийн төслийн зарим зүйл, заалт харилцан уялдаа холбоотой байх шаардлага хангаагүй гэж үзлээ. Үүнд:

- Төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцээгүй гэж дүгнэхээр байна. Энэ талаар үнэлгээний тайлангийн 1 дүгээр бүлэгт дэлгэрэнгүй бичигдсэн.
- Нэр томьёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томьёотой нийцэхгүй байх тохиолдол байна. Тухайлбал, ХХтХ-д тусгагдсан “түдгэлзүүлэх” гэснийг “зогсоох” гэж, “хүчингүй болгох” гэснийг “цуцлах” гэж төсөлд өөрөөр томьёолсон байна.
- Төсөлд тусгагдсан зүйл, заалт нь тухайн хуулийн төсөлд болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа байдлын хүрээнд хэд хэдэн зөрчилтэй заалтууд илэрсэн. Тухайлбал, ТАтХ-д “3 жилийн хугацаагаар төрийн албанд эргэж орохгүйгээр халах” тухай зохицуулалт байхад төсөлд “1 жилийн хугацаагаар төрийн албанд эргэж орохгүйгээр халах” тухай өөрөөр зохицуулсан, төслийн 6 дугаар зүйлд songогч ямар нэгэн төлөөлөлгүйгээр саналаа өөрөө өгөхөөр зохицуулсан нь “бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй songогч өөрийн итгэмжилсэн songуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болно” гэж заасантай зөрчилдөхөөр, мөн төсөлд торгуулийн арга хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон нэмэгдүүлж авахаар тусгасан нь Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуультай нийцэхгүй байна.
- Songуулийн сурталчилгааны зардалтай холбоотой тайлан, мэдээг хурдан шуурхай, санал авах өдрөөс өмнө гарган олон нийтэд мэдээлэх талаар зохицуулалт тусгаагүй орхигдуулсан гэж үзэж байна.
- Төсөлд songуулийн зардалтай холбоотой тусгасан зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага буюу торгуулийн хэмжээ хэтэрхий бага байна гэж дүгнэлээ.

4.2. Зөвлөмж

Монгол Улсын Ерөнхийлөгчийн songуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт хуулийн зорилтыг тодорхойлохдоо дутуу томьёолсныг өргөжүүлэн зохицуулах;
- Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.14, 39 дүгээр зүйлийн 39.2, 40 дүгээр зүйлийн 40.4.18 дахь заалтад заасан “songуулийн сурталчилгааны цахим хуудас”-ын тодорхойлолтыг дахин авч үзэх, зүйл, заалт хоорондын зөрчлийг арилгах;
- Төслийн 3 дугаар зүйлийн хүрээнд “арван найм, дөчин таван нас хүрсэн” гэх ойлголтыг тусад нь, субъектийг тодорхой заан зохицуулах;
- Төслийн 6 дугаар зүйлд “тэгш эрхийн үндсэн дээр оролцох” зарчмыг хуульчлах нь Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээнд нийцэх төдийгүй иргэний songох эрхийг бүрэн эхээр нь баталгаажуулах, songуулийн үндсэн зарчмын бүрдэл бүрэн хангагдах алхам болох тул тус зарчмыг хуульчлах;

Хууль зүйн яам www.mnl.gov.mn

- Иргэний сонгогдох эрхийг хангах, Олон Улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх үүднээс цаашид Ерөнхийлөгчийн сонгуульд бие даан нэр дэвших эрхийг хуульчлах асуудлыг Үндсэн хуулийн хүрээнд хэлэлцэх, одоогийн тохиолдолд УИХ-д суудалгүй намууд нэр дэвшигчийг дэмжиж оролцож болох зохицуулалтыг төслийн 23 дугаар зүйлийн хүрээнд хуульчлах талаарх асуудлыг анхаарах;
- Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 15 дугаар зүйлийн 15.1, 16 дугаар зүйлийн 16.1, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсгийн хүрээнд тус тус сонгуулийн хороодын бүрэлдэхүүний тоог анхааран үзэж, тодорхой тогтоох;
- Төсөлд зохицуулагдсан одоогийн зохицуулалт буюу дүгнэлт гаргахад 5 хоног, дахин дүгнэлт гаргах, хүргүүлэхэд мөн 5 хоног, нийт 10 хоног байх нь нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр зүй ёсоор хянагдахгүй байх нөхцөл байдлыг бий болгож, хэрэгжүүлэх субъектэд хэт ачаалал нэмсэн зохицуулалт болохоор байх тул СЕХ-нд мөрийн хөтөлбөрийг бүртгүүлэхээс 14-өөс доошгүй хоногийн өмнө Үндэсний аудитын газар мөрийн хөтөлбөрийг хүргүүлэхээр зохицуулах;
- СЕХ-ны сонгуультай холбогдуулан гаргасан шийдвэр нь Үндсэн хуулийн эрх зүйн зөрчил үү, эсхүл захиргааны эрх зүйн зөрчил үү гэдгийг харгалзан үзэж маргааны харьяаллыг тогтоох нь зүйтэй тул төслөөс шүүхийн хяналтыг хассан зохицуулалтыг эргэн харж, хуульчлах;
- Хуулийн төсөлд байгаа хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж, ойлгомжгүй байдал үүсгэж буй зүйл заалтыг нэг мөр болгон цэгцлэх;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн зохих шаардлагад нийцүүлэх;
- Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомж, төсөлд тусгагдсан зүйл, заалтуудыг нийцүүлэх, харилцан уялдааг сайжруулах;
- Санал авах өдрийн санал авч эхлэх болон дуусах хугацааг дахин хянан авч үзэх;
- Сонгуулийн зардалтай холбоотой төсөлд тусгагдсан зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг дахин авч үзэн нэмэгдүүлэх талаас нь анхаарах;
- Сонгуулийн сурталчилгаа дуусгавар болохоос өмнө сонгуулийн сурталчилгааны орлого, зарлагын төсөөллийг ил болгож, цахим хэлбэрээр олон нийтэд мэдээлэх талаар нэмж тусгах;
- Олон нийтэд өгч буй мэдээллийн үнэн зөв, ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд СЕХ-оос санал авах өдөр сонгуулийн ирцийн тухай мэдээллийг 1-2 цагийн хооронд тогтмол мэдээлэлж байх тухай зохицуулалт нэмж тусгах;
- Санал өгөх сонгогчийн тухайд зарим онцгой шалтгааны улмаас зайлшгүй төлөөлөгчтэй оролцох иргэдийн эрх ашгийг хөндөхгүйн тулд “бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогчоос бусад сонгогчийн хувьд ямар нэг төлөөлөлгүйгээр саналаа өгөх” гэж тодруулах;
- Торгох ял, шийтгэлийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр /Засгийн газрын тогтоолоор/ өөрчлөгдөж буй явдлыг зогсоох эрх зүйн үндэслэлийг бий болгосонтой торгуулийн арга хэмжээг нийцүүлэх шаардлагатай.

Хуулийн үндэсний мэдээлэл www.mli.gov.mn

НОМ ЗҮЙ

Нэг. Хууль тогтоомж

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946
- Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт, 1966
- Авилгалын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, 2003
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №6
- Харилцаа холбооны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43
- Зар сурталчилгааны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2002), №23
- Төрийн аудитын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2003), №2
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2006), №5
- Захиргааны ерөнхий хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №28
- Сонгуулийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №4
- Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №9
- Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24
- Төрийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2018), №1

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр тогтоолын хавсралт “Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын ерөнхий бүтэц, эрхлэх асуудлын хүрээ”

ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ШИЙДВЭР

- МҮҮХЦ-ийн 2005 оны 2 дугаар дүгнэлт “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зарим заалт үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай”

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

- Улсын Дээд Шүүхийн 2003 оны 02 дугаар тогтоол “Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”
- Улсын Дээд Шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2017.04.24, Дугаар 145
- Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, 2017.06.28, Дугаар 266

Хоёр. Ном, гарын авлага, судалгааны тайлан /Үсгийн дараалаар/

- Одгэрэл.П. Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 3 дахь хэвлэлт. УБ., 2016 он.
- Захиргааны ерөнхий хуулийн тайлбар. Ханнс-Зайделийн сан. УБ., 2017 он.
- Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ. Хамтын судалгааны тайлан. УБ., 2015 он.
- Монгол Улсын анхны ардчилсан сонгууль. МУЕТГ, СЕХ. УБ., 2015 он.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль - Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлан. ЕАБХАБ, АИХЭГ. Варшав., 2017 он.

Хуулийн нэгдсэн хурээлэл www.legal.gov.mn

- Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. Олон Улсын бага хурлын эмхэтгэл. Сонгуулийн ерөнхий хороо. УБ., 2002 он.
- Совд.Г нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000 он.
- Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа. Нийгмийн Бодлого Хөгжил Судалгааны Хүрээлэн. УБ., 2016.
- Төрийн ил тод байдал: нийгмийн баялаг хуваарилалт. Форумын эмхэтгэл. Нээлттэй нийгэм форум. УБ., 2006 он.
- Чимид.Б. Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу? УБ., 2011 он.
- Чимид.Б. Сонгуульд суралцахуй. УБ., 2008 он.
- Чимид.Б. Үндсэн хуулийн үзэл баримтлал, хоёр дахь хэвлэл. УБ., 2017 он.

Гурав. Илтгэл, өгүүлэл, ярицлага, мэдээлэл, лавлагаа /Үсгийн дараалаар/

- Ганзориг.Д. “Үндсэн хуулийн зөрчил үү, энгийн хуулийнх уу гэдгээс хамаарч маргааныг шийдэх учиртай” (2014.12.26), http://vip76.mn/content/28970
- Лхагвасүрэн.Э. “Хариуцлагын механизмыг сонгуулийн хуулинд нарийн тусгах хэрэгтэй” (2014.12.22), http://vip76.mn/content/28836
- Чимид.Б. “Сонгуулийн зарчмуудыг зөв хэрэгжүүлэхүй” (2002) СЕХ, Олон Улсын бага хурлын эмхэтгэл: 56-62.
- Ядамсүрэн.Ж. “Монгол Улсын сонгуулийн тогтолцоо, зарчмыг Үндсэн хуулиар баталгаажуулсан нь ардчиллын нэг ололт мөн” (2002) СЕХ, Олон Улсын бага хурлын эмхэтгэл: 11-24.

Дөрөв. Цахим эх сурвалж

- Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбооны албан ёсны цахим хуудас, http://www.aweb.org/eng/main.do
- Азийн сонгуулийн байгууллагуудын холбооны албан ёсны цахим хуудас, http://asianelectionauthorities.org/index.html
- Сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны цахим хуудас, http://gec.gov.mn/
- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, http://www.legalinfo.mn/
- АНУ-ын Тагнуулын төв байгууллагын албан ёсны цахим хуудас дахь дэлхийн улс орнуудын мэдээллийн сан,
  https://www.cia.gov/library/publications/the-world-factbook/
- Бүгд Найрамдах Австри Улсын хууль тогтоомжийн мэдээллийн албан ёсны цахим сан, https://www.ris.bka.gv.at/default.aspx
- Бүгд Найрамдах Турк Улсын хууль тогтоомжийн мэдээллийн англи хэл дээрх сан, http://www.lawsturkey.com/laws
- ОХУ-ын хууль тогтоомжийн мэдээллийн цахим сан, http://legalacts.ru/
- Бүгд Найрамдах Солонгос Улсын хууль тогтоомжийн мэдээллийн англи хэл дээрх сан, http://www.moleg.go.kr/english/korLawEng
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны цахим хуудас,
  http://www.nli.gov.mn/
- Монгол Улсын шүүхийн шийдвэрийн цахим сан, http://shuukh.mn/
- Монгол Улсын сонгуулийн тухай хуулийн төслийн цахим хэлэлцүүлэг,
  http://vip76.mn/forum/40

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

“МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ[244]

УДИРТГАЛ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.22-т “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ” гэж, Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж тус тус заажээ.

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газраас баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг /цаашид “төсөл” гэх / боловсронгуй болгоход оршино.

Түүнчлэн судалгаагаар төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар Улсын Их Хурлын сонгууль явуулах эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх, практикт хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэхийг зорилоо.

Энэхүү хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоох;
3. Шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОХ

Төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн:

1. Төсөл нь “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн онцлог бүхий харилцааг зохицуулсан бие даасан хуулийг боловсруулах, сонгууль зохион байгуулахтай холбогдсон харилцааг боловсронгуй болгох” гэсэн зорилгодоо хүрсэн эсэх;
2. Төсөлд тусгагдсан, санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;
3. Төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;

[244] Энэхүү үнэлгээг УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангийн захиалгаар 2019 онд ХЗҮХ-ийн ЭНБД, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал, Ж.Ббулгансүрэн нар хамтран гүйцэтгэв.

Хуулийн үнэлэлтийн тайлан www.nli.gov.mn

4. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг тус тусад нь судална.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Энэхүү хэсэгт уг төслийн үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан. Өөрөөр хэлбэл, тухайн төслийн үр нөлөөг үнэлэхдээ цаг хугацаа, зардал хэмнэх үүднээс голлох ач холбогдол бүхий заалтыг сонгож, тухайн сонгосон зүйл, заалтын үр нөлөөг судаллаа.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулиар өмнө нь тус тусдаа бие даасан хуулиар зохицуулагдаж байсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах журмыг хамтад нь нэг хуулиар зохицуулсан.

Ийнхүү сонгуулийг зохион байгуулж явуулах явцад Сонгуулийн тухай хуулийг нэг мөр, зөв ойлгож хэрэглэх болон хууль хэрэглээний хувьд олон төрлийн хүндрэл, бэрхшээл үүсч байсныг сонгууль зохион байгуулж явуулсан бүх шатны сонгуулийн байгууллага, сонгууль зохион байгуулалтын үйл ажиллагаанд хуулиар үүрэг хүлээн оролцдог төрийн байгууллагууд, сонгогчид, нэр дэвшигчид, сонгуульд оролцсон нам эвслүүдээс удаа дараа илэрхийлж байсан. Иймд Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулах шаардлагыг харгалзан сонгуулийн тогтолцоо, үндсэн зарчим, журмыг улам бүр тодорхой болгох, хуулийн тогтвортой байдлыг хангах, сонгууль тус бүрийн онцлогт тохирсон тусгайлсан бие даасан хууль боловсруулах, Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах, түүнчлэн сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн орчныг сайжруулах зэргээр сонгуулийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж боловсронгуй болгох шаардлагатай[245] гэж үзсэн байна.

Энэхүү төслийг Сонгуулийн тухай хуулийн ерөнхий зарчмыг баримтлан Улсын Их Хурал /цаашид “УИХ” гэх/-ын сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан бие даасан УИХ-ын сонгуулийн тухай хуулийн төслийг боловсруулсан[246] байна.

Дээрхээс дүгнэвэл, УИХ-ын сонгуулийн онцлогт нийцүүлэн энэхүү төслийг боловсруулсан болохыг харж болох бөгөөд уг төслийн зарим зохицуулалт уялдаа холбоогүй, ойлгомжгүй, дутуу орхигдуулсан, давхардал, хийдэл, зөрчилтэй байгаа нь практикт хэрэгжүүлэхэд хүндрэл үүсгэж болох эрсдэлтэй байгааг өөрчлөн найруулах, бусад хуулиудтай уялдуулж, нийцүүлэх нь зүйтэй.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль /Цаашид “МУИХСтХ” гэх/-ийн төслийн үзэл баримтлалаас үзвэл төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн онцлог бүхий харилцааг зохицуулсан бие даасан хуулийг боловсруулах, сонгууль зохион байгуулахтай холбогдсон харилцааг боловсронгуй болгоход оршиж байна. Энэ зорилгод хүрэхийн тулд хуулийн төслөөр дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

- Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах;
- Улсын Их Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон

[245] Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал.

[246] Мөн тэнд.

тусгах;

- Сонгуулийг зохион байгуулж явуулах зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах. Иймд хуулийн төслийн дээрх зорилтуудтай холбогдох зүйл, заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцох болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. *Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1	Сонгууль зохион байгуулж явуулах эрх зүйн орчныг сайжруулах.	Төслийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 12.1, 13.3, 22.7, 26.3.1 дэх заалт.
2	Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах.	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 45 дугаар зүйлийн 45.2, 46 дугаар зүйлийн 46.4.18 дахь хэсэг.
3	УИХ-ын сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах.	Төслийн 6 дугаар зүйлийн 6.2-6.6 дахь хэсэг.

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд 1/ Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан талаарх зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг тогтоох зэрэг зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцох болно. Сонгосон зүйл, заалтыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 2. *Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1.	Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх.	69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэг “Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.” 69 дүгээр зүйлийн 69.5 дахь хэсэг “Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна.”

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл нь 12 бүлэг, 90 зүйлтэй./

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно. /Хуулийн төсөл нь 12 бүлэг, 90 зүйлтэй./

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mli.gov.mn

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

Хүснэгт 3. *Шалгах хэрэгслийг сонгосон байдал*

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Төслийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 12.1, 13.3, 22.7, 26.3.1 дэх заалт; Төслийн 6 дугаар зүйлийн 6.2-6.6 дахь хэсэг; Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 45 дугаар зүйлийн 45.2, 46 дугаар зүйлийн 46.4.18 дахь хэсэг.	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2.	Практикт хэрэгжих боломж	Төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэг.	Практикт төслийн энэхүү заалтууд хэрэгжих боломжтой эсэхийг судлах. Хэрхэн хэрэгжүүлэх
3.	Ойлгомжтой байдал	Төслийг бүхэлд нь тооцно.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4.	Харилцан уялдаа	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.1. Зорилгод хүрэх байдал

3.1.1. Төслөөр тавьсан зорилгын хүрээнд дэвшүүлсэн “Сонгуулийг зохион байгуулж явуулах зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах” эхний зорилтын хувьд дараах зохицуулалтыг сонгон авч судалсан болно:

/Төслийн 9 дүгээр зүйлийн 9.9 дэх хэсэг, 12.1, 13.3, 22.7, 26.3.1 дэх заалт/

9.9.Нөхөн сонгууль явуулах тухай шийдвэрийг Улсын Их Хурал тухайн нөхцөл байдал үүссэнээс хойш 60 хоногийн дотор гаргана.

12.1.Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тойргийг аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байршил зэргийг харгалзан байгуулж, тойрогт ногдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтооно. Тойрогт хамаарах засаг захиргааны нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл буюу зэргэлдээ байна.

13.3.Хэсэг нь суманд 2000-аас дээшгүй, аймгийн төвд 3000-аас дээшгүй, нийслэлийн дүүрэгт 4000-аас дээшгүй сонгогчтой байх бөгөөд нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна.

22.7.Энэ хуулийн 22.5-д зааснаас бусад сонгогчийн шилжилтийг аймаг болон нийслэл дотор хийхийг хориглоно.

26.3.1.тухайн сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх;

Энэхүү төслөөр Сонгуулийн тухай хууль /Цаашид “СтХ” гэх/-д заасан ойлгомжгүй, эрх зүйн хийдэл, зөрчилтэй хэд хэдэн заалтыг өөрчлөн найруулж, засаж сайжруулсан байна. Тухайлбал,

2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн явцад Сонгуулийн тухай хуулийн 22.5-д *“Улсын Их Хурлын сонгуулийн тойргийг ... санал авах өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурал байгуулж, тойргийн нутаг дэвсгэр, дугаар, төв, мандатын тоог тогтооно”* гэж заасны дагуу сонгуулийн тойргийг байгуулсан.

Хуулийн нэгдсэний хэлэлцэлэн
www.ali.gov.mn

Ийнхүү Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулах явцад сонгогчид хоёр, гурван тойргийн дунд хуваагдсан 10 сум болон хил залгаа оршдоггүй хэд хэдэн тойрог байсан байна. Тухайлбал, Ховд аймагт хамгийн жижиг тойрог 11304 сонгогчтой. Улаанбаатар хотын хамгийн том тойрог болох Чингэлтэй дүүргийн 63 дугаар тойрог 41836 сонгогчтой. Мөн Увс аймгийн 33 дугаар тойрог нь зэргэлдээ биш гурван хэсэгт хуваагджээ. Улаанбаатар хотын гадна орших Багануур дүүрэг дөрвөн хэсэгт хуваагдаж, хэсэг тус бүр нь Багануурдтай хил залгаа бус Сүхбаатар дүүргийн өөр өөр тойрогт хуваарилагдаж[247] байжээ.

Энэхүү алдааг засахын тулд СтХ-д заасан дээрх зохицуулалтыг төслийн 12.1-д боловсронгуй болгон *"Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө ... нутаг дэвсгэр, төвийг тогтооно. Тойрогт хамаарах засаг захиргааны нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд* ***нэгдмэл буюу зэргэлдээ*** *байна"* гэж, мөн төслийн 12.2-т "Аймаг, нийслэлийн дүүргийн хүн амын тоо нь тойрог байгуулах улсын дунджаас цөөн байвал зэргэлдээ аймаг, нийслэлийн дүүрэгтэй нэг тойрог болгон нэгтгэж болно" гэж тус тус өөрчлөн найруулсан нь 2016 оны Улсын Их Хурлын сонгуулийн явцад сонгуулийн тойрог байгуулахад тулгамдаж байсан асуудлыг шийдвэрлэх боломжийг бий болгосон хэмээн үзэж болох юм.

Мөн төслийн 13.3-т "...нэг хэсэгт байх сонгогчийн тоо 200-аас доошгүй байна" гэж нэг хэсэгт байх сонгогчийн доод хязгаарыг тогтоож өгсөн нь СтХ-ийн 23.2-т заасан заалтыг боловсронгуй болгосон заалт болсон гэж үзэж байна.

Түүнчлэн, 2016 оны УИХ-ын сонгуульд нийт 1.912.901 сонгогч бүртгэгдсэн бөгөөд саналаа өгөхөөр бүртгүүлсэн сонгуулийн хэсгийн хороодоос өөр газар байршиж байгаа сонгуулийн байгууллагын ажилтнууд, цэргийн албан хаагчид зэрэг хүмүүс хууль эрх зүйн хязгаарлалт болон бодит нөхцөл байдлын улмаас саналаа өгч чадахгүйд хүрч болзошгүй байна[248] гэж 2016 оны УИХ-ын сонгуулийн урьдчилсан тайланд дурдсан байх бөгөөд энэхүү асуудлыг шийдвэрлэхийн тулд төслийн 22.7-д "Энэ хуулийн 22.5-д зааснаас бусад сонгогчийн шилжилтийг аймаг болон нийслэл дотор хийхийг хориглоно" гэж заасан бөгөөд 22.5-д "Сонгуулийн байгууллагын ажилтан, иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан, мэдээллийн технологийн багийн гишүүн, даамал, санал авах байр болон сонгуулийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангахаар ажиллаж буй цагдаагийн албан хаагчийн сонгогчийн шилжилтийг хийх, бүртгэхдээ тухайн байгууллагынх нь албан бичгийг үндэслэн шийдвэрлэж болно" гэсэн зохицуулалтыг шинэчлэн найруулж тусгасан байна.

Мөн СтХ-ийн 124.3.1-д "санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байх шаардлагыг хангаагүй" тохиолдолд нам, эвслийг бүртгэхээс татгалзахаар хуульчилсан байна. Харин төслийн 26.3.1-д "тухайн сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн" нам, эвслийг бүртгэхээр тусгасан байна.

Ийнхүү төсөлд сонгуулийн жилийн нэгдүгээр сарын нэгний өдрөөс өмнө гэж тусгасан нь СтХ-д заасан "...санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө" гэж хоногоор заан өгснөөс илүү хүн бүрд ойлгомжтой хугацааны хувьд хөтөлбөргүй байх боломжийг бүрдүүлж байна. Өөрөөр хэлбэл, УИХ-аас сонгуулийн санал авах өдрийг ээлжит сонгуулийн жил бүр өөр өөр өдөр тогтоох боломжтой бөгөөд санал авах өдрийг хэдний өдөр гэж тогтоосноос хамаарч санал авах өдрөөс 180 хоногийн өмнөх өдөр өөрчлөгдөх боломжтой бол "сонгуулийн жилийн нэгдүгээр сарын 1-ний өдөр" гэсэн нь өөрчлөгдөх боломжгүй юм.

СтХ-ийн 18.1-д "Улсын Их Хурлын гишүүний нөхөн сонгуулийн энэ хуульд нийцүүлэн Улсын Их Хурал товлон зарлана" гэж заасныг төслийн 9.9-д боловсронгуй болгож "Нөхөн сонгууль явуулах тухай шийдвэрийг Улсын Их Хурал тухайн нөхцөл

[247] ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар, Сонгууль ажиглах хороо, Монгол Улс. УИХ-ын сонгууль 2016.6.26, Урьдчилсан тайлан 2016 оны 5 сарын 20-оос 6 сарын 14-ний өдөр.

[248] Мөн тэнд.

байдал үүссэнээс хойш 60 хоногийн дотор гаргана” гэж зохицуулахаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл, СтХ-д нөхөн сонгууль явуулах хугацааг зааж өгөөгүй байсныг төсөлд 60 хоногийн дотор гаргахаар тусгасан байна. Гэсэн хэдий ч төсөлд энэхүү заалтад “...60 хоногийн дотор гаргана” гэснийг “...60 хоногийн дотор товлон зарлана” гэж заасан нь илүү оновчтой хэмээн үзэж байна.

Энэ мэтчилэн төсөлд практикт хэрэгжүүлэхэд эерэг нөлөөлөл үзүүлэх заалтууд олон байх боловч хэд хэдэн учир дутагдал, эрх зүйн хийдэл, зөрчилтэй заалтууд байна. Үүнийг дор дэлгэрүүлэн авч үзэх болно.

3.1.2. Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах зорилтын хувьд дараах зохицуулалтыг сонгон авч судалсан болно:

/Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 45 дугаар зүйлийн 45.2, 46 дугаар зүйлийн 46.4.18 дахь хэсэг/

3.1.11.”Сонгуулийн сурталчилгааны цахим хуудас” гэж цахим орчин дахь олон нийтийн сүлжээ бүхий цахим хуудсаас бусад цахим хуудсыг.

45.2. Сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар сурталчилгаа явуулах тохиолдолд тухайн цахим хуудсаар зөвхөн сурталчилгааны цахим хуудсын хаяг, нам, хамтарсан намын нэр, далбаа, таних тэмдэг, нэр дэвшигчийн нэр, сонгуулийн уриа зэргийг сурталчилж болно.

46 дугаар зүйл.Хууль бус сурталчилгааг хориглох

46.4.18.сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах.

Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11 дэх заалтад Сонгуулийн сурталчилгааны цахим хуудас гэж цахим орчин дахь олон нийтийн сүлжээ бүхий цахим хуудсаас бусад цахим хуудсыг ойлгохоор заасан. Өмнөх МУИХСтХ болон одоогийн СтХ-д цахим хуудасны тухай ойлголтод ямар нэг хязгаарлалт тогтоогоогүй бөгөөд бүхий л төрлийн цахим хуудсыг ойлгох боломжтой байсан.

Дээрх зохицуулалттай уялдуулан төслийн 45.2, 46.4.18 дахь заалтад заасныг судлан үзвэл төслийн 45 дугаар зүйлийн 45.2-т “Сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар сурталчилгаа явуулах тохиолдолд тухайн цахим хуудсаар зөвхөн сурталчилгааны цахим хуудсын хаяг, нам, хамтарсан намын нэр, далбаа, таних тэмдэг, нэр дэвшигчийн нэр, сонгуулийн уриа зэргийг сурталчилж болно” гэж зааснаас үзвэл сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсыг тодорхой тохиолдолд ашиглаж болохоор байна.

Гэтэл төслийн 46 дугаар зүйлийн 46.4.18-д “сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулах” гэж заасан нь бусад хуудсаар аливаа хэлбэрээр сурталчилгаа явуулахыг хоригложээ. Өөрөөр хэлбэл, сурталчилгааны цахим хуудсыг тодорхойлсон тодорхойлолт болон түүнтэй хамааралтай заалтууд нь өөр хоорондоо зөрчилдсөн байж болзошгүй байна.

Түүнчлэн сонгуулийн сурталчилгааны цахим хуудаст олон нийтийн сүлжээ бүхий цахим хуудсыг хамруулахгүй байхаар хуульчилсан нь үндэслэлтэй эсэхийг судлан үзвэл:

2016 оны 8 сард Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэнгээс хийсэн “Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа”-нд “Мэдээлэл авдаг гол эх сурвалж”[249] гэсэн асуултад телевиз, интернет, нийгмийн сүлжээ гэсэн гурван гол эх сурвалж зонхилж байх бөгөөд “Улс төрийн талаарх мэдээлэл авахдаа нийгмийн аль сүлжээг та ашигладаг вэ?”[250] гэх асуултад дийлэнх олонх буюу 43% нь Facebook гэж, 23% нь мэдээллийн цахим хуудас гэжээ. Үүнээс үзвэл, сонгогчид

[249] Нийгмийн бодлого хөгжил судалгааны хүрээлэн, Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа (УБ, 2016), Center for Insights in Survey Research, 74 дэх тал. https://www.iri.org/sites/default/files/wysiwyg/iri_mongolia_poll_-_august_2016_-_public_deck_mon.pdf (Сүүлд үзсэн: 2019.01.03).

[250] Мөн тэнд, 76 дахь тал.

мэдээ, мэдээллийг олон нийтийн сүлжээнээс илүү авдаг хандлага ажиглагдаж байна.

Нам, эвсэл, нэр дэвшигч нь сурталчилгааг хуулиар хориглоогүй арга, хэлбэрээр явуулах бөгөөд хуулиар хориглоогүй гэдэг нь чөлөөт байдлын зарчмыг баримтална гэсэн үг юм.[251] Энд мөн "Чөлөөт байдлын зарчмын хязгаар" гэсэн ойлголт байдаг ба хязгааргүй чөлөөт байдал хаа ч үгүй. Тэр нь ямагт бусдын эрх чөлөөгөөр хязгаарлагддаг. Сурталчилгааг хуульд заасан хориг хязгаарлалтыг сахиж, ёс зүйтэй явуулах нь нам, эвсэл, нэр дэвшигчдийн өөрийгөө сонгогчдод зөвөөр ойлгуулж, тэдний талархлыг хүлээж, дэмжлэг авах боломж юм. Иймд сурталчилгаанд голлон анхаарах зүйл бол хуулийг зөрчихөөс болгоомжлох явдал[252] болно. Хэдийгээр төсөлд олон нийтийн сүлжээг сонгуулийн сурталчилгааны цахим хуудсанд хамааруулахгүй байхаар зохицуулсан ч төслийн заалтууд нь хоорондоо зөрчилтэй байна.

Дээрхээс дүгнэвэл, нэг талаас олон нийтийн сүлжээ буюу Facebook, Twitter зэрэг хуудсыг сонгуулийн сурталчилгаанд ашиглахгүй байх нь мэдээллийн эмх замбараагүй, тогтворгүй урсгалаас сэргийлэх боловч нөгөө талаас сонгогчдын мэдээлэл авах хэлбэр нэлээд хязгаарлагдах тул энэхүү зохицуулалтыг сайтар судлан үзэж, зөрчилдөж буй зүйл заалтуудыг нэг мөр болгох өөрчлөх нь зүйтэй.

3.1.3. УИХ-ын сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах зорилтын хүрээнд дараах заалтуудыг сонгон авлаа:

/Төслийн 6 дугаар зүйлийн 6.2-6.6 дахь хэсэг/

6 дугаар зүйл.Сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчим

6.2.Сонгууль нь бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгогч бүр оролцох эрхтэй.

6.3.Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө өгнө.

6.4.Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.

6.5.Сонгогч хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах боломжоор хангагдсан байна.

6.6.Сонгуулийн үйл ажиллагаанд оролцож буй аливаа этгээд нь хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд эхэлж, дуусах зарчмыг баримтална.

Төслийн 6 дугаар зүйлд "Сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчим"-ыг хуульчилсан бөгөөд өмнөх хууль болон одоогийн хуулиас ялгаатай нь тус зүйлд сонгуулийн үндсэн зарчим болон сонгууль зохион байгуулахтай холбогдсон зарчмыг хамтад нь тусгасан байна. Ингэхдээ зарим шаардлагатай зарчмыг орхигдуулсан байна.

Сонгуулийн хууль, эрх зүйн бусад хэм хэмжээг тогтоох, сахин биелүүлэх, хэрэглэхдээ нийтээр нэг мөр баримталдаг үндсэн эхлэл, сонгуулийн улс төр-эрх зүйн бодлогын тогтвортой үндсүүдийг сонгуулийн эрх зүйн зарчим[253] гэдэг. Сонгуулийн эрх зүйн зарчим бол ардчиллын жам ёсыг бодитой тусгасан, заавал биелүүлэх, харилцан уялдаа холбоотой хэрэгжих арга хэрэглүүрийн нийлбэр цогц[254] юм.

1990-ээд оноос хойш ардчилсан хувьсгалын үр дүнд сонгуульд санал өгөх нь албадлага биш иргэний сайн дурын, хувийн үзэл бодлын асуудал болсон нь том ололт юм. Ийнхүү чөлөөт сонгууль жинхэнэ утгаараа Монголын нийгмийн практикт бий болов.[255] Хуучин тус тусдаа байсан хэдэн хуулийг халж, тэр үеийн

[251] Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), "Адмон" хэвлэл, 149 дэх тал.

[252] Мөн тэнд.

[253] Мөн тэнд, 47 дахь тал.

[254] Мөн тэнд, 48 дахь тал.

[255] Д.Өлзийсайхан, Удирдлагын сэхээтэн (УБ, 2008), Бит Пресс, 6 дахь тал.

гурван шатны (Улс, аймаг, сум /хот, район/-ын) Хурлыг “Ардын депутатуудын хурал” гэсэн нэрэнд “багцалж” “БНМАУ-ын Ардын депутатуудын хурлын сонгуулийн хууль” гэсэн төрөлжсөн нэг хууль гаргаж[256] бүх шатны сонгуулийг зохицуулах болжээ. Тус хуулиар бэхжүүлсэн сонгуулийн тогтолцооны зарчим, журам өмнөхөөс үзэл баримтлалын эрс ялгаатай бөгөөд сонгогчид нийтийн, шууд, тэгш эрхийн зарчмаар, саналаа нууцаар гаргаж оролцох журам нэрийн хувьд давтагдсан боловч зарчмын шинэ агуулгатай болсон талаар Б.Чимид агсан цохон тэмдэглэжээ.

Сонгуулийн эрх зүйд сонгуулийн зарчмыг чиглэлээр нь 3 хуваадаг[257] бөгөөд (а) сонгуулийг зохион байгуулж явуулах зарчим, (б) сонгуульд иргэдийн оролцооны зарчим, (в) иргэд, байгууллагын нийтээр баримтлах түгээмэл зарчим болно. Эдгээрийг төсөлд нэг зүйл болгон оруулахдаа зарим зарчмыг орхигдуулсан байна.

Тухайлбал, төслийн 6 дугаар зүйлийн 6.2 – 6.5 дахь хэсгийг үзвэл иргэдийн оролцооны буюу сонгуулийн үндсэн зарчимд бүх нийтийн, шууд сонгох, саналаа чөлөөтэй илэрхийлэх, саналаа нууцаар гаргах зарчмуудыг хуульчилсан. Хэдийгээр, тус зарчмууд нь өмнөх МУИХСтХ болон одоогийн СтХ-д тусгагдсантай адил боловч эдгээр хуульд бүгдэд нь “тэгш эрхийн зарчим”-ыг зохицуулаагүй нь Үндсэн хуулийн зохицуулалттай холбоотой.

Сонгуулийн тэгш эрхийн зарчмыг шинэ Үндсэн хуульд нэр зааж оруулаагүй ч аль ч улсад энэ зарчмыг сонгуулийн үндсэн зарчимд оруулж хэрэгжүүлэх арга механизмыг нь боловсронгуй болгосоор байна. Энэ зарчмын мөн чанар нь нэг сонгогч нэг удаагийн сонгуульд нэг л удаа саналаа өгөх, сонгогчид адил саналын эрхтэй байх явдлаар илэрхийлэгдэнэ.[258]

Дээр дурдсанчлан, БНМАУ-ын Ардын депутатуудын хурлын сонгуулийн хуульд “тэгш эрхийн зарчим” тусгагдсан байсан. Иймд одоогийн хуульд “тэгш эрхийн зарчим”-ыг хуульчлах нь зүйтэй талаар дараах үндэслэл байдаг:

Монгол Улсын Үндсэн хууль[259]-ийн Аравдугаар зүйлийн 3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ” гэж, мөн зүйлийн 2-т “Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ” гэж тус тус заасан.

Монгол Улсын нэгдэн орсон Хүний эрхийн түгээмэл тунхаглал[260]-ын 21 дүгээр зүйлийн 3-т “Ард түмний хүсэл зориг бол засгийн эрх мэдлийн үндэс байх ёстой. Энэ хүсэл зориг нь сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хураах буюу саналаа чөлөөтэй гаргах явдлыг хангахуйц өөр адил чанартай хэлбэрийг ашиглах замаар явуулж байвал зохих тогтмол, хуурамч бус сонгуулиар илрэлээ олно” гэж заасан буюу сонгогчийн тэгш эрхийн зарчмыг тунхагласан.

Мөн Монгол Улсын нэгдэн орсон Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт[261]-ын 25 дугаар зүйлийн (b)-д “сонгуулийн бүх нийтийн тэгш эрхийн үндсэн дээр саналыг нууцаар хурааж, сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан, жинхэнэ ёсоор тогтмол явагддаг сонгуульд сонгох буюу сонгогдох” хэмээн тэгш эрхийн зарчмыг тусгажээ.

Иймд төсөлд одоо тусгагдсан зарчмууд дээр нэмж “тэгш эрхийн үндсэн дээр оролцох” зарчмыг хуульчлах нь Монгол Улсын нэгдэн орсон Олон Улсын гэрээнд нийцэх төдийгүй иргэний сонгох эрхийг бүрэн эхээр нь баталгаажуулах, сонгуулийн

256 Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), “Адмон” хэвлэл, 32 дахь тал.

257 Мөн тэнд, 48 дахь тал.

258 Монгол Улсын Сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь, Олон Улсын бага хурал, (УБ, 2002), 31-32 дахь тал.

259 Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1.

260 Хүний эрхийн түгээмэл тунхаглал, НҮБ, 1946, https://www.legalinfo.mn/law/details/1271

261 Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, НҮБ, 1966, https://www.legalinfo.mn/law/details/1257?lawid=1257

үндсэн зарчмын бүрдэл бүрэн хангагдах алхам болно.

Түүнчлэн, төслийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэгт "Сонгуулийн үйл ажиллагаанд оролцож буй аливаа этгээд нь хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд эхэлж, дуусах зарчмыг баримтална" гэж сонгуулийг зохион байгуулах зарчмыг тусгажээ. Ингэхдээ өмнөх МУИХСтХ болон СтХ дахь "маргааныг шуурхай, үндэслэлтэй, хуулийн хүрээнд шийдвэрлэх", "сонгогчийн эрх, сонгуулийн хууль тогтоомж зөрчсөн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх", "энгийн ойлгомжтой байх" зэрэг зарчмуудыг хуульчлаагүй орхигдуулсан байна.

Өөрөөр хэлбэл, төсөлд нийтээр баримтлах түгээмэл зарчим болох хууль дээдлэх болон шударга ёсны зарчмыг хуульчилсан нь сайшаалтай хэдий ч сонгууль зохион байгуулахтай холбогдсон зарчмуудыг орхигдуулжээ.

Өдгөө сонгуулийн эрх зүйн зарчмуудыг өргөтгөн авч үзэх хандлага бий болсон бөгөөд зарчмууд зөвхөн иргэдийн сонгуульд оролцох үзэл хандлагыг төдийгүй ард түмэн засгийн эрхээ хэрэгжүүлэхэд засаг төрөөс үр нөлөөтэй, шийдвэрлэгч чанартай оролцуулах нөхцөлийг хангах үүрэг, ардчилсан ёсны арга хэрэглүүрийг багтаах[262] тул дээрх орхигдуулсан зарчмуудыг хуульчлах нь зүйтэй.

3.2. Практикт хэрэгжих боломж

Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд төслийн 69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэг "Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна", 69.5 дахь хэсэг "Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна" гэсэн зүйл, заалтыг тус тус сонгон авч үнэлэлт өгөхийг зорилоо. Тус шалгуур үзүүлэлтээр сонгон авсан зохицуулалтын хүрээнд:

1. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;
2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх гэсэн хоёр асуултад хариулт өгөхийг эрмэлзлээ.

/Төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэг/

69 дүгээр зүйлийн 69.4 дэх хэсэг "Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна."

69 дүгээр зүйлийн 69.5 дахь хэсэг "Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна."

1. Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх:

Төслийн 69 дүгээр зүйлийн 69.4-т "Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна" гэж, 69.5-д "Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна" гэж тус тус заасан байна. Уг заалтаас харахад санал авах байранд тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангах зохицуулалтыг хийх субъект нь тодорхойгүй байна.

[262] Б.Чимид, Сонгуульд суралцахуй (УБ, 2008), "Адмон" хэвлэл, 47 дахь тал.

Бүх нийтийн сонгууль, санал асуулга зохион байгуулах нь аливаа улсын хувьд их хэмжээний төсөв хөрөнгө шаардсан, сайн зохион байгуулж хэрэгжүүлбэл зохих үндэсний хэмжээний томоохон арга хэмжээ юм. Санал өгөх байр хэдийг бэлтгэх, хэдэн хүн ажиллуулах, ямар материал шаардлагатай зэргийг нарийвчлан тооцож гаргах нь зардлаа бууруулах боломжийг бүрдүүлдэг. Мөн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг нарийвчлан тогтоож, зохион байгуулалтын өндөр түвшинд сайтар анхаарч бүх нийтийг хамруулан сонгуулийг зохион байгуулах нь зүйтэй.

Манай улсын хувьд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хуулиараа хүлээн зөвшөөрсөн байдаг.

Сүүлд явагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн явцад олон улсын сонгуулийн ажиглах хорооноос гаргасан урьдчилсан дүгнэлтэд "...СЕХ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг санал өгөх эрхээ эдлэх боломжоор хангахын тулд нэлээдгүй хүчин чармайлт гаргасан бөгөөд 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар нэр дэвшигч мөрийн хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй холбоотой асуудлуудыг тусгажээ. Сонгуулийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх нөхцөлийг хөнгөвчлөх хүчин чармайлтуудыг гаргаж байсан хэдий ч санал авах олон байр хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс ороход хүндрэлтэй хэвээр байв[263] хэмээн дурджээ.

Хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа тэдэнд хүртээмжтэй болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг заажээ.[264] Гэвч зарим төрлийн сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгтэй сонгогчдын санал өгөх эрхийг эрх зүйн чадамжгүй гэх өргөн хүрээтэй ойлголтод хамаатуулан хязгаарлаж байгаа нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зарчим, үзэл санаанд нийцэхгүй байна. АН болон МАН-аас нэр дэвшигчид хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, амьдралын чанарын талаар тусгажээ. СЕХ нь Иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан сонгогчдын боловсролд чиглэсэн сонгуулийн материалуудыг гаргаж, мөн сонгогчдод зориулсан видео бичлэгтээ дохионы хэлийг нэмж оруулсан. Олон нийтийн радио телевиз сонгуулийн сурталчилгааны мэдээг дохионы хэлээр хүргэж байснаас гадна зарим нэр дэвшигчид сурталчилгааны мэдээлэлдээ дохионы хэл ашиглажээ. [265]

СтХ-иар хөгжлийн бэрхшээлтэй сонгогч нь өөрийн сонгосон хүнээр туслуулан саналын хуудсыг тэмдэглүүлж болно. Түүнчлэн санал авах байруудыг харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгаж, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг заасан байдаг. Олон улсын ажиглагчдын хорооны очиж ажигласан санал авах байруудад энэ заалтуудыг дагаж мөрдсөн байсан. Хэдийгээр СтХ-иар санал авах байрууд нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх ёстой гэж заасан боловч ихэнх нь хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс орох боломжгүй байшин барилга дотор байрлаж байв.[266]

[263] Олон улсын сонгуулийг ажиглах хороо Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26-ны өдөр. Дэлгэрэнгүйг https://www.osce.org/mn/odihr/327166?download=true үзнэ үү. (Сүүлд үзсэн: 2019.1.14).

[264] 2009 оноос хойш Монгол Улс нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид (ХБХЭтК) нэгдэн орсон. Үндсэн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үл ялгаварлан гадуурхахыг зөвхөн ерөнхий зарчмаар хангаж, харин баталгаатай арга хэмжээгээр зааварчлаагүй байдаг. 2016 оны ХБХЭтХ болон бусад холбогдох хуулийн заалтуудаар улс төрийн оролцоонд хамаарах зохих хамгаалалт, нөхцөлөөр ханган өгсөн.

[265] Мөн тэнд.

[266] Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаас тооцоолж байгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж санал өгснөөс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөхийг хүсжээ. ХБХЭтК-ийн 29 дугаар зүйлд улс орнуудад "хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд ялгаварлан гадуурхалгүйгээр бусадтай адил тэгш нөхцөлд

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагуудын тооцоолсноор хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж саналаа өгөхийн оронд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөхийг илүүд үздэг ажээ. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөөврийн хайрцгаар саналаа өгөх боломжийг олгож буй нь иргэний болон сонгуулийн эрхийг нь хангаж байгаа ч, зарим тохиолдолд үүнийгээ санал авах байрыг тэдэнд орох боломжтой болгож чадаагүй шалтгаанаа тайлбарлахад ашиглаж байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуулийн үйл явцад бусад иргэдтэй адил оролцох нөхцөлийг бүрдүүлсэнгүй[267] гэж ЕАБХАБ/АИХЭГ-ын Сонгуулийн ажиглах хязгаарлагдмал хорооноос урьдчилан гаргасан дүгнэлтэд дурджээ.

Түүнчлэн, төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэгт заасан дээрх заалтуудыг практикт хэрэгжүүлэх субъект нь тодорхойгүй байна.

2. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх.

Монгол Улс нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай НҮБ-ын конвенцид 2009 оноос нэгдэн орсон. Мөн Үндсэн хуулиндаа “ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн ерөнхий зарчмыг тусгасан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухайд тусгайлан заалт байдаггүй. 2016 оны 2 дугаар сард батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн байгууллагуудад сонгуулийн сурталчилгаагаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох, мөн тэдний нэр дэвших эрхийг дэмжих зэрэг үүргийг оруулан заажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 30.1-д “Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна” гэж заасан байдаг. Харин энэхүү төслийн 14.18-д “Сонгуулийн хороог аюулгүй байдал хангасан ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна” гэж заасан нь тэргэнцэртэй сонгогчийг орох боломжийг яаж, ямар субъект хариуцах талаарх зохицуулалтыг орхигдуулж ойлгомжгүй байдлыг үүсгэжэд байна. Иймд төслийн 69.4, 69.5-д заасан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэх, тэргэнцэртэй сонгогчийг орох боломжийг хангах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах субъектыг тодорхой болгох нь зүйтэй юм.

Хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа тэдэнд хүртээмжтэй болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг заажээ.[268]

СтХ-д ч мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх эрхээ эдлэх боломжийг хөнгөвчлөн, санал авах байр нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх, харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгах, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг заажээ. СЕХ нь эдгээр шаардлагыг ханган биелүүлсэн боловч хөдөө орон нутгийн дэд бүтцийн нь санал авах байруудад орох боломж нөхцөлийг хязгаарлах магадлалтай байна. Мөн хөгжлийн бэрхшээлтэй сонгогчид нь оршин суугаа хаягаараа зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх хүсэлт гаргах боломжтой.[269]

үр ашигтай, бүрэн оролцох орчин нөхцөлийг идэвхтэйгээр сурталчилж, нийтийн үйл хэрэгт тэдний оролцоог урамшуулах”- ыг зөвлөсөн байдаг.

[267] Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6 сарын 26 болон 7 сарын 7-ны өдрүүд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Тайлан, 25 дахь тал. (Сүүлд үзсэн: 2019.1.14). Дэлгэрэнгүйг https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/366136?download=true үзнэ үү.

[268] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №9.

[269] ЕАБХАБ-ын АИХЭГ-ын САХХ, Монгол Улсын Ерөнхийлөгч сонгууль 2017 оны 6 сарын 26-ны өдөр,

Хэдийгээр харааны бэрхшээлтэй иргэдийн саналаа өгөх байдлыг хөнгөвчилсөн сайшаалтай арга хэмжээ хийгдсэн байсан ч ЕАБХАБ/АИХЭГ-ын сонгуулийн ажиглах хорооны ажиглалт хийсэн санал авах байруудын 35 хувь нь л хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдыг орох боломжоор хангасан[270] байжээ.

Дээрхээс дүгнэвэл, төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэгт заасан заалтууд нь практикт бүрэн хэрэгждэггүй зохицуулалт болохыг дээр дурдсан сонгуулийн судалгааны тайлангуудаас харж болох юм. Иймээс энэхүү зохицуулалтуудыг практикт бүрэн хэрэгжүүлэхийн тулд цаашид анхаарвал зохих хэд хэдэн асуудал байгааг судлан үзэж төсөлд тусгах нь зүйтэй болов уу. Тухайлбал, энэхүү заалтыг хэрэгжүүлэх субъектыг тодорхой болгох, түүнчлэн сонгуулийн санал авах байрыг тэргэнцэртэй иргэдийг орох боломжтой байдлыг харгалзан сонгох, эсхүл санал авах өдрөөс өмнө шаардлагатай арга хэмжээ авахыг холбогдох субъектэд даалгах нь зүйтэй.

2020 оны УИХ-ын сонгуульд тэргэнцэртэй иргэдийн сонгох эрхийн хангах үүднээс өмнөх хуулиудад ч бэлэгдлийн төдий байдлаар хуульчлагдаж ирсэн энэхүү зохицуулалтыг практикт хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай юм.

3.3. Ойлгомжтой байдал

Хуулийн төслийн зохицуулалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдүүдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхэд дараах байдлаар дүн шинжилгээ хийсэн болно.

Хүснэгт 4. *Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ*

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1	“Нэн даруй” гэсэн нэр томьёо бичигдсэн төслийн зохицуулалтууд: 6.10, 18.2.3, 19.11, 19.14, 46.14, 68.8, 76.4, 78.1.2, 78.5.2, 78.16, 78.17, 80.1 дэх хэсэг.	Хуулийн төсөлд “нэн даруй” хэрэгжүүлэхээр заасан 12 заалт байх бөгөөд тэдгээрийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолуудыг үзвэл хууль, түүний зохицуулалтаас хамаарч “нэн даруй” гэдгийг ойлгох хугацаа өөр байна. Тухайлбал, Иргэний хуульд заасан “нэн даруй” гэдгийг тухайн тохиолдолд мэдэгдэх боломжтой ердийн хугацаанд[271] ойлгохоор байгаа бол Прокурорын /хуучин/ тухай хуульд заасан “нэн даруй” гэдгийг 24 цагийн дотор[272] гэж ойлгохоор байна.	Явуулах үйл ажиллагааны төрлөөс хамаарч “нэн даруй” гэдгийг өөр өөрөөр ойлгон, хэрэглэж байх тул хуульд аутентик тайлбар хийх замаар тайлбарлах.
2	Төслийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.”	Хориглосон заалтыг сонгуулийн үйл ажиллагааны зарчимд оруулсан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Ойлголтыг нэг мөр болгох.

Урьдчилсан тайлан 2017 оны 5 сарын 23-ны өдөр

[270] Мөн тэнд.

[271] Улсын дээд шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.6.22.) “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178 (Сүүлд үзсэн: 2018.12.26).

272

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРААНГУЙ www.ikh.gov.mn

3	Төслийн 6 дугаар зүйлийн 6.8-д “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хугацаа тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална.”	Иргэний хуульд хугацаа тоолох тухай зарчим тусгагдаагүй байхад Иргэний хуульд заасан зарчмыг баримтална гэсэн нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Ойлголтыг нэг мөр болгох.
4	Төслийн 6 дугаар зүйлийн 6.9-д “Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.”	Төслийн энэхүү зохицуулалт нь сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчимд сонгогч саналаа нууцаар гаргах эрхийг хамааруулсан байна. Өөрөөр хэлбэл, сонгох, сонгогдох эрх тусдаа байх бөгөөд сонгууль зохион байгуулах, сонгуулийн төв хорооны ил тод байдалтай хамааралгүй юм.	Сонгууль зохион байгуулах ил тод байдлыг хангах гэж ойлголтыг нэг мөр болгох.
5	Төслийн 6 дугаар зүйлийн 6.12-т “Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/, ажиглалт хийх, сонгогчдод сонгуулийн мэдлэг олгох, эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах эрхтэй.”	Улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллагын эрхийг үйл ажиллагааны зарчимд хуульчлан тусгасан нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.	Ойлголтыг нэг мөр болгох.
6	Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.14 дэх заалт.	Төслийн 10.1.14-т “энэ хуулийн 48.2-т заасан мөнгөн урамшуулал” гэж заасан бөгөөд төслийн 48.2-т“ Сонгуулийн зардал нь дараах хөрөнгөөс бүрдэнэ: 48.2.1. хандив; 48.2.2. намын өөрийн хөрөнгө; 48.2.3. нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө” гэж заасан байхад уг төслийн 10.1.4-т “энэ хуулийн 48.2-т заасан мөнгөн урамшууллын зардал” хэмээн тусгаснаас төслийн 48.2 дахь заалт нь мөнгөн урамшууллын зардал мэтээр ойлгогдож байгаа энэхүү заалт ойлгомжгүй болохыг харуулж байна.	Иймд энэхүү заалтад өөрчлөлт оруулах.

ХУУЛЬ ЗҮЙН ИНДЭКСИЙН ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

7	Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг.	Төслийн дээрх заалтууд нь практикт хэрэгжихэд ойлгомжгүй байдлыг бий болгохоор байна. Тухайлбал, төслийн 16.1-д “ Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ” гэсэн заалтаас үзвэл аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн даргаас гадна таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болохоор заасан учир сонгуулийн хороог зургаан /тэгш тоотой/ гишүүнтэйгээр байгуулж болохоор харагдаж байна. 2005 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Тойргийн хороо нь суманд, шаардлагатай бол нийслэлийн дүүрэгт салбар хороог санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тойргийн хэмжээнд нийтэд мэдээлнэ” гэж, 2011 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө тойргийн хороог дарга, нарийн бичгийн дарга, сондгой тооны 7-13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ” гэж тус тус заасан байсан нь аливаа шийдвэр гаргах тохиолдолд санал тэнцэх эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс сонгуулийн хороог сондгой тооны гишүүнтэйгээр байгуулж байсан байна. Тиймээс төсөлд заасан дээрх зохицуулалтад өмнө дагаж мөрдөж байсан хуулиудын нэг адил асуудал үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхийн тулд нэг мөр, ойлгомжтой байлгах үүднээс өөрчлөлт оруулах нь зүйтэй юм.	Практикт сонгуулийн хороог байгуулахдаа тав эсхүл долоо гишүүнтэйгээр буюу сондгой тооны гишүүнтэйгээр байгуулдаг байх тул төслийн дээрх зохицуулалтыг маргаан дагуулахгүй байлгах үүднээс “таваас долоон гишүүнтэй” гэснийг “тав эсхүл долоо” гэж, “гурваас таван гишүүнтэй” гэснийг “гурав эсхүл тав” гэж, “зургаагаас найман гишүүнтэй” гэснийг “зургаа эсхүл найм” гэж өөрчлөн найруулах шаардлагатай.
8	Төслийн 19 дүгээр зүйлийн 19.10-т “Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сонгуулийн хорооны үйл ажиллагаа болон хуралдаанд оролцох боломжгүй болсон бол энэ тухайгаа бичгээр болон бусад хэлбэрээр урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.”	Урьдчилан мэдэгдэх хугацаа тодорхойгүй байна.	Урьдчилан мэдэгдэх хугацааг тодорхой болгох.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭС www.parliament.mn

9	Төслийн 20 дугаар зүйлийн 20.1-д ”Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэлд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, сонгогчдийн нэрсийн жагсаалт болон сонгогч шилжих, түүнтэй холбоотой гомдол шийдвэрлэх зэрэг ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.”	Бүлэг болоод зүйлийн гарчигт “Сонгогчдын нэрийн жагсаалт” гэж бичигдсэн атал зүйлийн доторх хэсэгт “сонгогчдын нэрийн жагсаалт”, “сонгогчдын нэрсийн жагсаалт” гэсэн хоёр янзаар бичигдсэн байна.	Тус нэр томьёог нэг мөр болгох.
10	21 дүгээр зүйлийн 21.1-д “Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн, сонгогчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаарх гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арван дөрвөөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.”	Төслийн энэхүү зохицуулалтаас үзвэл аливаа шалтгааны улмаас санал авах өдрөөс 14 хоногийн өмнө гомдол гаргаж чадаагүй сонгогчийн тухайд сонгох эрх нь зөрчигдөхөөр харагдаж байна. Тухайлбал, төслийн 21.1-д заасан үндэслэлээр гомдол гаргах иргэн санал авах өдрөөс 10 хоногийн өмнө энэ тухай мэдсэн тохиолдолд гомдол гаргах эрхгүй болох бөгөөд цаашилбал сонгох эрхээ эдлэх боломжгүй болж байна.[18]	Гомдол гаргах хугацаа боломжит хугацаа мөн эсэхийг дахин нягтлах.
11	Төслийн 46 дугаар зүйлийн 46.14-т “Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 46.9-т хяналт тавиж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно” гэж тус тус заасан байна. Төслийн 46 дугаар зүйлийн 46.15-д “Шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн 37.1, 45, 46.1.8, 46.6-д хяналт тавьж ажиллана.”	Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт “Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор ... тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ” гэж заасан. Харин төслийн холбогдох заалтуудаас үзвэл, Харилцаа холбооны зохицуулах хороо нь хуулийн зохицуулалтад хяналт тавихаар ойлгогдож байна.	“... 46.9 дэх хэсэгт заасан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах” гэж буюу “...37.1, 45, 46.1.8, 46.6 дахь хэсгийн заалтуудын хэрэгжилтэд тус тус хяналт тавьж ажиллах” гэж өөрчлөх.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН www.nlegovmn

12	Төслийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг “	Төслийн 46 дугаар зүйлд “Хууль бус сурталчилгааг хориглох” тухай зохицуулалтуудыг тусгасан боловч төслийн 46.3-т “Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно” гэж заасан нь хориглосон заалтын хэсэгт “зөвшөөрсөн” зохицуулалтыг тусгасан нь төслийн бусад заалтуудын уялдаа холбоо, утга найруулгыг алдагдагдуулж ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Энэхүү зохицуулалтыг зохих хэсэгт нь тусгах.
13	Төслийн 73 дугаар зүйлийн 73.17 дахь хэсэг.	Төслийн уг заалтад “...14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулна” гэж заасан нь Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1.1-д “баривчлах шийтгэл” гэж зааснаас өөрөөр ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, төсөлд “баривчлах захиргааны шийтгэл” гэж заасан нь захиргаанаас баривчлах шийтгэл оногдуулах мэтээр ойлгогдож байна.	Иймд төслийн уг заалтад “баривчлах захиргааны шийтгэл” гэж заасныг “баривчлах шийтгэл” гэж өөрчлөн найруулах.
	Төслийн 75 дугаар зүйлийн 75.2-т “Ажиглагч дараах эрх эдэлнэ: 75.2.2.санал авах, үйл ажиллагааг ажиглах”	Төсөл дэх ажиглагчийн эдлэх эрхийг заасан зохицуулалт болох 75 дугаар зүйлийн 75.2 дахь хэсгийн 75.2.2-т “санал авах, үйл ажиллагааг ажиглах” хэмээн хооронд таслал тавьснаар ажиглагч нь үйл ажиллагааг ажиглахаас гадна санал авах эрхтэй гэж ойлгогдохоор байна.	Хоёрдмол ойлголтыг залруулах үүднээс холбоо үгийн дундах таслалыг арилгах.
14	Итгэмжилсэн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан гэх нэр томьёо орсон төслийн зохицуулалтууд: Төслийн 20.10, 21.8, 22.2, 22.4, 70.7, 72.9, 10.2.3, 20.11, 20.12, 21.2, 21.4, 22.4, 22.6, 70.2, 72.1.5, 72.4, 78.10 дахь хэсэг.	Төслийн дурдсан заалтуудад итгэмжилсэн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан гэж нэг хүнд хамаарах ойлголтыг хоёр өөр байдлаар нэрлэн, төсөлд тусгасан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.[274]	Нэр томьёог нэг мөр болгож, хоёрдмол утгагүй байхаар томьёолох.

***Хүснэгт 5**. Итгэмжилсэн ажилтан, итгэмжлэгдсэн ажилтан гэж хоёр өөр байдлаар бичигдсэн төслийн зүйл заалт*

№	Итгэмжилсэн ажилтан	Итгэмжлэгдсэн ажилтан
1	20.10 дахь хэсэг	20.10 дахь хэсэг
2	21.8 дахь хэсэг /иргэний бүртгэлийн/	10.2.3 дахь заалт
3	22.2 дахь хэсэг / улсын бүртгэлийн/	20.11 дэх хэсэг
4	22.4 дэх хэсэг /улсын бүртгэлийн/	20.12 дахь хэсэг
5	70.7 дахь хэсэг /иргэний бүртгэлийн байгууллагын/	21.2 дахь хэсэг /иргэний бүртгэлийн байгууллагын/
6	72.9 дэх хэсэг /иргэний бүртгэлийн/	21.4 дэх хэсэг /иргэний бүртгэлийн байгууллагын/
7		22.4 дэх хэсэг /улсын бүртгэлийн/
8		22.6 дахь хэсэг /улсын бүртгэлийн/
9		70.2 дахь хэсэг /иргэний бүртгэлийн/
10		72.1.5 дахь заалт /улсын бүртгэлийн/
11		72.4 дэх хэсэг /улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын/
12		78.10 дахь хэсэг /иргэний бүртгэлийн/

[274] Дэлгэрэнгүйг хүснэгт 5-аас үзнэ үү.

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн[275] 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

Хүснэгт 6. *Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх.*

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан **Хуулийн төслийн бүтэц, хэлбэр**	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.хуулийн төслийн гарчиг; 28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.зүйлийн доторх хэсэг; 28.1.4.хэсгийн доторх заалт; 28.1.5.заалтын доторх дэд заалт; 28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.	Төслийн 42 дугаар зүйлийн 42.5-д “Энэ хуулийн 42.3 дахь заалтад шүүх, прокурор, тагнуул, цагдаа, онцгой байдлын болон эмнэлгийн байгууллага хамаарахгүй” гэж заасны **“**42.3 дахь заалтад**”** гэснийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.13-т заасны дагуу **“**42.3 дахь хэсэгт**”** гэж өөрчлөх.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан **Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага**	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, *бусад хууль,* үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.7-д “арван найм, хорин таван нас хүрсэн” гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдрөөс тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг ойлгохоор тусгажээ. Энэхүү ойлголт нь хоёр өөр субъектын /нэр дэвшигч, сонгогч/ талаар тодорхойлж байгаа тул тусад нь зохицуулах шаардлагатай. Өөрөөр хэлбэл, сонгох эрх бүхий иргэний тухайд санал авах өдөр буюу түүнээс өмнө хуульд заасан насанд хүрсэн байх зохицуулалт нь хүнийг сонгох эрхээ эдлэх боломжоор хангасан хуулийн төслийн зорилгод нийцсэн зохицуулалт болсон бол нэр дэвшиж буй иргэний тухайд “хорин таван нас хүрсэн” байх тухай зохицуулалт нь сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байхыг ойлгохоор заажээ. Төслийн дээрх 3.1.7-д зааснаас үзвэл “Сонгуулийн санал авах өдөр 25 нас хүрсэн Монгол Улсын иргэн УИХ-ын сонгуульд нэр дэвших эрхтэй бөгөөд нэр дэвшигчээр бүртгүүлэх үедээ 24 настай байж болно гэж ойлгогдож байна. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “хорин таван нас хүрсэн” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, УИХ-ын сонгуульд оролцогч иргэний сонгогдох эрх тухайн насанд хүрснээр бий болох учиртай. Энэ ч утгаараа тус заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн заалтад нийцэж байгаа эсэх нь учир дутагдалтай байна. Иймд “арван найм, хорин таван нас хүрсэн” гэсэн ойлголтыг тусад нь субъектыг тодорхой заан зохицуулах шаардлагатай.
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.

[275] Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, 2015, №25.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭН www.tsedb.gov.mn

29.1.4.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5 Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Төслийн зүйл, заалт нь хоорондоо зөрчилдсөн хэд хэдэн тохиолдол илэрсэн бөгөөд энэ талаар харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй бичигдсэн болно.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8.Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.9.Шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээ зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.10. Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.11. Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.	
30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх талаар харилцан уялдаа хэсэгт дэлгэрэнгүй бичигдсэн болно.
30.1.2.Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Төслийн 6 дугаар зүйлийн 6.10-т "...нийтээр дагаж мөрдөхөөр гаргасан шийдвэрийг гаргасан этгээд нь..." гэснийг "...нийтээр дагаж мөрдөх шийдвэр гаргасан этгээд нь" гэж, Төслийн 4.4, 19.1, 28.4-т "...олонхийн..." гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "олонхын" гэж, Төслийн 9.10-т "Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургаадугаар сарын ..." гэж заасны "зургаадугаар" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "зургадугаар" гэж, Төслийн 9.6-д "... тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсаны дараа..." гэж заасны "гарсаны" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "гарсны" гэж, Төслийн 10.1.3-т "сэлбэг хэрэгсэл,, програм хангамж...", 10.2.1-д "...техник хэрэгсэл, сэлбэг, програм хангамж...", 10.7-д "...техник хэрэгсэл, програм хангамж..." гэж тус тус заасны "програм" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "программ" гэж, Төслийн 33.1-д "сурталчилах" гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "сурталчлах" гэж, Төслийн 20.1, 20.21, 20.22, 20.23, 21.6, 21.7, 21.8, 75.2.10, 85.4-т "сонгогчдийн" гэдгийг "сонгогчдын" гэж, Төслийн 24.1.3-т, 24.8-д "...бүрт..." гэж заасны "бүрт" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "бүрд" гэж, Төслийн 27.4.3-т "эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй байх" гэдгийг "хүлээлгээгүй" гэдгийг "хүлээгээгүй" гэж, Төслийн 41.1, 41.2-т "тэмдэгийг" гэж бичсэнийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "тэмдгийг" гэж, Төслийн 43.3-т "Ухуулгын байрыг доор дурдсан зорилгоор ажиллуулна" гэсний "доор" гэдгийг "дор" гэж, Төслийн 44.22-т "...цуцлана" гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "цуцална" гэж, Төслийн 46.14-т "...хяналт тавиж" гэсний "тавиж" гэдгийг Монгол хэлний журамласан толь бичигт "тавьж" гэж, Төслийн 88.1-д "... хууль заасан харъяалал" гэж заасны "харъяалал" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "харьяалал" гэж тус тус бичсэн байх тул дээр дурдсан үгнүүдийг засаж бичих. Төслийн 3.1.7-д "Монгол Улсын Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн" гэсний "хорин" гэдгийг "Хорин" гэж бичих. Төслийн 9.10, 20.22-т "...сонгуулийн ерөнхий хороо" гэж заасан байна. "Сонгуулийн ерөнхий хороо" гэдэг нь оноосон нэр учир том үсгээр эхэлж бичнэ. "Сонгуулийн ерөнхий хороо" болгож засах. Төслийн 20.3-т "...сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн..." гэж заасны *"Иргэдийн"* гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" гэж заасан байх тул *"иргэдийн"* болгож засах. Төслийн 39.4-т "...сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн..." гэж заасны *"хурлын"* гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" гэж заасан байх тул *"Хурлын"* болгож засах. Төслийн 6.13-т ***"...6.12-д..."*** гэснийг ***"...6.12-т"*** гэж; Төслийн 6.14-т, 6.15-д *"...6.4-д..."* гэснийг *"...6.4-т"* гэж; Төслийн 8.3-т *"...8.1-т..."* гэснийг *"...8.1-д"* гэж; Төслийн 13.2-т *"...13.1-т..."* гэснийг *"...13.1-д"* гэж; Төслийн 19.23-т *"...18.14-д..."* гэснийг *"...18.14-т"* гэж; Төслийн 22.7-д *"...22.5-т..."* гэснийг *"...22.5-д"* гэж; Төслийн 22.8-д *"...22.1-22.7-т...22.7-т"* гэснийг *"...22.1-22.7-д, 22.7-д"* гэж; Төслийн 26.4-т *"...26.3-д..."* гэснийг *"...26.3-т"* гэж;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛЛЭГ www.ecourt.mn

	Төслийн 39.14-т *"...39.11-т..."* гэснийг *"...39.11-д"* гэж, Төслийн 43.4-т *"...43.1-т..."* гэснийг *"...43.1-д"* гэж, Төслийн 44.11-д *"...44.10-д..."* гэснийг *"...44.10-т"* гэж, Төслийн 45.5-д *"...45.4-д..."* гэснийг *"...45.4-т"* гэж, Төслийн 45.6-д *"...45.4-д..."* гэснийг *"...45.4-т"* гэж, Төслийн 53.9-д *"...53.4-д..."* гэснийг *"...53.4-т"* гэж, Төслийн 58.5-д *"...58.3-д..."* гэснийг *"...58.3-т"* гэж, Төслийн 63.6-д *"...63.3-д..."* гэснийг *"...63.3-т"* гэж, Төслийн 64.5-д *"...64.4-д..."* гэснийг *"...64.4-т"* гэж, Төслийн 65.4-т *"...65.1-т..."* гэснийг *"...65.1-д"* гэж, Төслийн 70.3-т *"...70.1.1-т..."* гэснийг *"...70.1.1-д"* гэж, Төслийн 70.4-т *"...70.1.1-т..."* гэснийг *"...70.1.1-д"* гэж, Төслийн 70.17-д *"...70.4-д..."* гэснийг *"...70.4-т"* гэж, Төслийн 72.14-т *"...72.12-д..."* гэснийг *"...72.12-т"* гэж, Төслийн 79.6-д *"...79.2-д..."* гэснийг *"...79.2-т"* гэж, Төслийн 82.2, 82.3-т *"...58.3-д..."* гэснийг *"...58.3-т"* гэж, Төслийн 36.9-д "50-аас доошгүй" гэснийг "50-иас доошгүй" гэж тус тус өөрчлөн бичих. Төслийн 10.5-д " 10.2, 10.3, 10.4 дэх хэсэгт " гэснийг "10.2-10.4-т" гэж өөрчлөх. Төслийн 6.7-д "Сонгуулийн хугацааг хугацааг санал авах өдөртэй..." гэж заасан зохицуулалтад давхардан бичигдсэн "хугацааг" гэдэг үгийг хасах. Төслийн 6.10-т "Сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан нийтээр дагаж **мөрдөхөөр гаргасан шийдвэрийг гаргасан** этгээд нь нэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар нийтэд албан ёсоор мэдээлнэ" гэж заасны мөрдөхөөр **"гаргасан"** гэж давхардаж бичигдсэнийг хасах. Төслийн 10.3.1-д "... санал авах үеийн хамгаалалт, хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн зардал" гэж заасан зохицуулалтад давхардан бичигдсэн "хамгаалалт" гэдэг үгийг хасах. Төслийн 73.2-т "тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх, эсхүл өөр хүний баримт бичиг, эсхүл хуурамч баримт бичиг ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох" гэж заасны зохицуулалтад давхардан бичигдсэн "эсхүл" гэдэг үгийг хасах.
30.1.4. Хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.4. Харилцан уялдаа

Төслийн харилцан уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

Хүснэгт 7. *Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал.*

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зорилтод сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байх тул хуулийн төслийн 5 дугаар зүйл, 9 дүгээр зүйл нийцэхгүй байна.

ХУУЛЬЗҮЙН УХААЛГЫН ХҮРЭЭЛЭН www.parliament.mn

Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Хуулийн төслийн үзэл баримтлалд “сонгууль тус бүрийн онцлогт тохирсон тусгайлсан бие даасан хууль боловсруулах, Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах, түүнчлэн сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг бүхэлд нь эргэн харж боловсронгуй болгох шаардлагатай байна гэж үзэн хуулийн төслийг одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа СтХ-ийн ерөнхий зарчмыг баримтлан Монгол Улсын Их Хурлын сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан бие даасан хуультай болох үүднээс боловсруулсан гэж” тусгасны дагуу энэхүү төслийн нэр нь хуулийн төсөл хийгээд төслийн үзэл баримтлалын агуулгатай нийцэж байна.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	Төслийн 37 дугаар зүйлийн 37.7-д “Энэ хуулийн 37.1, 37.4-д заасныг зөрчсөн нь радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг Харилцаа холбооны зохицуулах хороо зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно.” гэж, 46 дугаар зүйлийн 46.14-т “Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 46.9-д хяналт тавьж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно” гэж тус тус заасан байна. Гэтэл Харилцаа холбооны тухай хууль[20] /цаашид “ХХтХ” гэх/-д “зогсоох” гэсэн үгийг гагцхүү хэрэглэгч, үйлчлэгчид хамааруулан ойлгохоор хуульчилсан. Харин ХХЗХ-ны үйл ажиллагаанд “түдгэлзүүлэх”, “хүчингүй болгох” гэсэн үгийг хамааруулан ойлгохоор тусгажээ.
	Төслийн 44 дүгээр зүйлийн 44.22-т телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг цуцлах тухай зохицуулсан бөгөөд ХХтХ-д “гэрээ цуцлах” гэсэн ойлголт байхаас тусгай зөвшөөрлийг цуцлах тухай нэр томьёо байхгүй, дээр дурдсанчлан “хүчингүй болгох” гэсэн нэршлээр илэрхийлдэг. Иймд “цуцална” гэснийг “хүчингүй болгоно” гэж өөрчлөн найруулах шаардлагатай.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	МУИХтХ-тай зөрчилдөж буй талаар Төслийн 9 дүгээр зүйлийн 6-д “Энэ хуульд заасны дагуу сонгуулийг хойшлуулсан эсхүл зогсоосон бол тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсны дараа Улсын Их Хурал ажлын арван өдөрт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана” гэсэн заалт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн /цаашид МУИХтХ гэх/ 30 дугаар зүйлийн 30.5-т “...Энэ хуулийн 30.2-т заасан онцгой нөхцөл арилсны дараа Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана” хэмээн заасан заалттай зөрчилдөхөөр байна. МУИХтХ болон төслийн дээрх зохицуулалтууд нь нэг утга санааг илэрхийлж байгаа боловч МУИХтХ-ийн 30 дугаар зүйлийн 30.5-т онцгой нөхцөл арилсны дараа Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлахаар” харин төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “... тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсны дараа Улсын Их хурал ажлын 10 өдөрт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлахаар” тусгажээ. Ийнхүү МУИХтХ-д сонгуулийг ажлын 7 хоногт багтаан товлон зарлахаар тусгасан байхад энэхүү төсөлд ажлын 10 өдөрт багтаан сонгуулийг товлон зарлахаар тусгасан дээрх хуулийн заалттай зөрчилдөхөөр байна. Иймд төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д заасан энэхүү заалтыг МУИХтХ-тай нийцүүлж, өөрчлөн найруулах нь зүйтэй.

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭС ХҮЧИН ЗҮЙЛ

	Зөрчлийн тухай хуультай зөрчилдөж буй талаар Төслийн 46.1.4-т “бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах”-ыг хориглохоор заасан бөгөөд 46.13-т “Энэ хуулийн 46.1-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван нэгээс арван зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох”-оор заасан бөгөөд энэхүү заалтад заасан бусдыг гүтгэх доромжлох, хуурамч мэдээлэл тараах нь Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан заасан “Гүтгэх” зөрчлийн шинжийг мөн агуулж байна. Энэ тохиолдолд хэрэв төсөлд зааснаар хариуцлага оногдуулбал иргэнийг 320.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3.520.000-5.120.000 төгрөгөөс, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг 1.920.000-2.560.000 төгрөгөөр тус тус торгохоор байна. Харин Зөрчлийн тухай хуульд зааснаар дээр зөрчлийг үйлдсэн хүнийг 2.000.000 төргөрөөр, хуулийн этгээдийн 20.000.000 төгрөгөөр торгохоор хуульчилсан байна. Иймд төслийн 46.1-д заасан бусад заалтуудаас мөн Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой заалтуудыг хуулийн давхардал үүсгэхгүй байлгах үүднээс Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээр зохицуулах нь зүйтэй.
	Төрийн албаны тухай хуультай зөрчилдөж байгаа талаар Төслийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.15 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.21 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.24 дэх хэсэг, 87 дугаар зүйлийн 87.4 дэх хэсэгт заасан зохицуулалтууд нь 2019 оны 1 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.4-т “...төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах” гэж заасантай зөрчилдөхөөр байна. Учир нь төслийн дээрх заалтуудад “төрийн албанд нэг жил, ... хоёр жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах”-аар тусгасан нь Төрийн албаны тухай хуулийн заалттай зөрчилдөж байна хэмээн үзэх үндэслэлтэй байна.
	Төслийн 20.6-д “... улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ээлжит сонгуулийн жилийн тавдугаар сарын 15-ны өдрөөс өмнө хүргүүлнэ” гэж заасан бөгөөд 20.6.6-д “цагдаагийн байгууллага санал авах өдөр зөрчлийн улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн улмаас цагдан хоригдсон сонгогчдын мэдээллийг” гэж тус тус заасан нь хоорондоо зөрчилтэй байна. Төслийн 20.8-д “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.6.4, 20.6.5, ***20.6.6-д*** заасны дагуу ирүүлсэн иргэдийн мэдээллийг үндэслэн тухайн цэргийн анги, нэгтгэл хамаарч байгаа сонгуулийн хэсэгт саналаа өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн сонгогчийг нэмж бүртгэн байнга оршин суугаа газрынх нь хаягийн дагуу бүртгэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах” тухай тусгасан. Төслийн 21.3-т “Энэ хуулийн 21.2-т зааснаас бусад үндэслэлээр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж, 21.5-т “Санал авах өдрийг хүртэлх долоо хоногийн хугацаанд энэ хуулийн 21.2-т заасан ажиллагааг хийхийг хориглоно” гэж тус тус заасан нь 20.8-д заасан зохицуулалт нь зөрчилдөхөөр байна. Төслийн 70.1-д “Дараах сонгогчийн саналыг түүний хүсэлт, эмнэлгийн магадлагаа эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах өдрийн өмнөх өдөр 09:00-20:00 цагийн хооронд авна:

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХЭРЭГЛЭЭНД www.zalgamj.mn

	70.1.3-т “Зөрчлийн улмаас баривчлагдсан, эсхүл саатуулагдсан; 70.1.4-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон” гэж тус тус заасны дагуу 20.6.6-д заасан этгээдээс санал авах боломжтой мэтээр ойлгогдож байна. Гэтэл 20.6.6-д заасан заалт нь санал авах өдөр зөрчлийн улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн улмаас цагдан хоригдсон сонгогчдын мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх тухай зохицуулалт байх бөгөөд 70.1.3, 70.1.4-т зааснаар сонгууль өгөх боломжтой мэт харагдаж байгаа боловч дээрх зохицуулалтад үндэслэн санал авахдаа санал авах өдрийн өмнөх өдрийн 09:00-20:00 цагийн хооронд авч байх тул 20.6.6-д заасан зохицуулалтад хамаарах этгээд санал өгөх боломжгүй болох нь тодорхой харагдаж байгаа хэдий ч хуулийн дээрх зохицуулалтууд хэт ойлгомжгүй, алдаатай болохыг харуулж байна. Иймд төслийн 20.6.6-д заасан зохицуулалтыг 20.6-д заасан зохицуулалтаас тусад нь зааглан тусгах, мөн 20.8-д “20.6.4, 20.6.5-д заасан” гэж өөрчлөлт оруулах шаардлагатай.
	Төслийн 6 дугаар зүйлийн 6.7-д сонгуулийн хугацааг санал авах өдөртэй уялдуулан жил, сар, хоног, цаг, минутаар тоолохоор зохицуулсан байтал 6.8-д төслийн “Энэ хууль өөрөөр заагаагүй бол хугацаа тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална” гэж заасан нь 6.7-д заасан хугацаа тоолох зохицуулалтыг тусгагдаагүй мэтээр ойлгогдоход хүргэж байна. Төслийн 6.8-д энэ хуульд өөрөөр заагаагүй бол гэж заасан нь 6.7-д заасан заалтыг үгүйсгэж хуулийн зөрчлийг бий болгож байна.
	Төслийн 45 дугаар зүйлийн 45.2-т сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар сурталчилгаа явуулж болох талаар тусгасан бол төслийн 46.4.18-д сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон байна. Иймд эдгээр заалт өөр хоорондоо нийцэхгүй байна.
	Төслийн 5 дугаар зүйлд Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийн тухай заасан байтал 5.2-т эрх хязгаарласан, 5.4, 5.5-д хориглосон зохицуулалт, 5.7, 5.8-д хуулийн санкцийг заасан зүйлийн нэртэй нийцэхгүй байна.
	Төслийн 36 дугаар зүйлийн 36.7-д “төрийн аудитын дээд байгууллага ... бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр энэ хуульд нийцэж буй эсэх талаар дүгнэлтийг санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө гаргана” гэж зааснаас үзвэл бие даан нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөрийн талаарх дүгнэлтийг төрийн аудитын дээд байгууллагаас гаргахаар ойлгогдож байна. Харин төслийн 30 дугаар зүйлд нэр дэвшигчийг бүртгэх асуудлыг зохицуулсан бөгөөд 30.3-т “бие даан нэрээ дэвшүүлэгч нь бие даан нэр дэвшүүлэх ажиллагааны талаарх хуульд заасан хугацаа дуусан өдрөөс хойш гурав хоногт багтаан дараах баримт бичгийг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ” гэж заасан бөгөөд 30.3.9-д “Энэ хуульд заасны дагуу төрийн аудитын байгууллагаар хянуулсан бие даасан нэрээ дэвшүүлэгчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлт” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, төслийн 36.7, 36.9 дэх хэсэгт “төрийн аудитын дээд байгууллага” гэж, харин 30.3.9 дэх заалтад “төрийн аудитын байгууллага” гэж нэр томьёоны хувьд ялгамжтай байдлаар зохицуулсан нь хэд хэдэн асуудлыг бий болгож байна.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУУЛЬЧДЫН ЭМХЭТГЭЛ www.lawyers.mn

	Учир нь Төрийн аудитын тухай хуулийн 6.1-д “Төрийн аудитын байгууллагын тогтолцоо нь төрийн аудитын дээд байгууллага, түүний харьяа төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагаас бүрдэнэ...” гэж зааснаас үзвэл төрийн аудитын байгууллага нь төрийн аудитын дээд байгууллага болон түүний харьяа төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагаас бүрдэхээр ойлгогдож байна. Харин тус хуулийн 7.2-т зааснаар “Үндэсний аудитын газар нь Монгол Улсын аудитын дээд байгууллага...” юм. Хэрэв төслийн 30.3.9-д заасан уг зохицуулалтыг төрийн аудитын дээд байгууллага бус, түүний харьяа төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллага хэмээн өөр утгаар тайлбарлан ойлговол бие даан нэрээ дэвшүүлэгчийн хувьд нам, эвслээс нэр дэвшиж буй нэр дэвшигчээс ялгамжтай буюу мөрийн хөтөлбөрөө 2 өөр аудитаар хянуулж, Сонгуулийн ерөнхий хороонд аудитын дүгнэлт нь хоёр удаа хүргэгдэнэ гэсэн утгыг илэрхийлэхээр байна. Өөрөөр хэлбэл, төслийн 30.6.9-д заасан заалтад “төрийн аудитын байгууллага” хэмээн хуулийн нэр томьёог хэрэглэснээр төслийн 36.7, 36.9 дэх хэсэгт заасан зохицуулалтыг хэрэглэхэд ойлгомжгүй байдлыг бий болгохоор байна
	Төсөлд нийт 55 зүйл, заалтад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарч торгууль оногдуулахаар заасан байна. /5.7, 6.14, 13.10, 14.18, 14.19, 14.20, 14.22, 19.23, 20.24, 21.9, 22.8, 34.8, 35.4, 37.5, 37.6, 38.5, 39.14, 40.10, 41.3, 42.6, 43.4, 44.22, 45.5, 45.9, 46.12, 46.13, 47.2, 48.6, 50.4, 51.13, 52.4, 53.9, 56.9, 56.10, 56.11, 57.5, 57.6, 63.6, 64.5, 65.4, 69.12, 70.16, 70.17, 72.14, 72.15, 73.16, 73.17, 74.13, 75.4, 76.6, 77.3, 78.18, 79.6, 80.4, 85.5 дахь хэсэг/ Өөрөөр хэлбэл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарч торгууль ногдуулахаар төсөлд тусгасан нь хэд хэдэн асуудлыг бий болгож болохоор байна. Тухайлбал, Хууль тогтоогч төсөлд тусгасан торгох шийтгэлийн хэмжээг өөрчлөөгүй байхад Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэр өөрчлөгдвөл уг хуульд заасан торгуулийн хэмжээ өөрчлөгдөхөд нөлөөлж байна. Манай улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 2000 оноос хойш нийт 12 удаа өөрчлөгдсөн бөгөөд анх тогтоосноос хойш 10.8 дахин нэмэгджээ. Түүнчлэн, хуулийн үүрэгжүүлсэн, хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг (санкци) хуулийн төслийн 11 дүгээр бүлэгт заасан хэдий ч дээрх зүйл заалт бүхэнд давхардуулан зохицуулжээ. 2017 оноос эхлэн дагаж мөрдөгдөх болсон Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиудад торгох ял, шийтгэлийг хуульчилж өгсөн байх бөгөөд ийнхүү хуульчлахдаа “нэгж” хэмээх ойлголтыг бий болгож, Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр (Засгийн газрын тогтоолоор) өөрчлөгдөж буй явдлыг зогсоох эрх зүйн үндэслэлийг бий болгосон юм. Иймд төслийн энэхүү зохицуулалтуудыг бусад хууль тогтоомжид хүлээлгэж буй хариуцлагын нэгэн адил, мөн хуулийн төслийн 11 дүгээр бүлэгт заасныг өөрчлөн сайжруулж зохих хариуцлагыг хүлээлгэх нь зүйтэй байна.
	МУИХСтХ-ийн төсөл нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөлтэй хэлбэр болон агуулгын хувьд давхардсан заалт олон байна. Дэлгэрэнгүйг СЕХ-оос хийсэн хуулийн төслүүдийн харьцуулалтаас үзнэ үү.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.legal.gov.mn

Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Төслийн 4.1 дэх хэсэгт заасан “саналаа нууцаар гаргах” эрхийг 5.6 дахь хэсэгт агуулгын давхардуулан зохицуулсан байна.
	Төслийн 5 дугаар зүйлийн 5.5, 5.6-д мөн төслийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсэгтэй хэлбэр болон агуулгын хувьд давхцсан ба үүнтэй холбоотойгоор тус зүйлүүдэд хамаарах санкцийн зохицуулалт мөн давхардсан. Тодруулбал, дурдсан зүйлүүд нь сонгогчийн шууд сонгох эрх болон саналаа нууцаар гаргах эрхийн тухай зохицуулалт бөгөөд тус эрхээ эдлэхэд санаатайгаар саад учруулсан бол 5 дугаар зүйлийн 5.7-д заасны дагуу иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдийг ялгаатай хэмжээний төгрөгөөр торгохоор, 6 дугаар зүйлийн 6.14 дэх хэсэгт заасны дагуу аливаа этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тус тус заажээ. Иймд нэг үйлдэлд ялгаатай шийтгэл оногдуулахаар зохицуулсан байгааг залруулах, давхардлыг арилгах шаардлагатай.
	Төслийн “Хууль бус сурталчилгааг хориглох” хэмээх 46 дугаар зүйлд хориглосон үйл ажиллагааг жагсаахдаа мөн зүйлийн 46.1.7, 46.1.9 дэх заалтыг давхардуулан хуульчилсан байна.
	Төслийн 72 дугаар зүйлийн 72.14, 72.15-д заасан санкцууд хоорондоо давхардсан байна. Учир нь 72 дугаар зүйлийн 72.14-т “Энэ хуулийн 72.12-д заасныг зөрчсөн ... тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”; 72.15-т “Энэ хуулийн 72 дугаар зүйлд заасныг зөрчсөн этгээдийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж тус тус заасан. Үүнээс үзвэл, 72 дугаар зүйлийг зөрчсөн тохиолдолд бүхэлд нь санкци тогтоосон атлаа 72.12-т хамааруулан дахин тусдаа санкци бий болгосон байна. Иймд энэ давхардлыг засах шаардлагатай.
	Төслийн 78 дугаар зүйлийн 78.16, 78.17 дахь хэсэг болон 80 дугаар зүйлийн 80.1 дэх хэсгүүд нь хоорондоо хэлбэр, агуулгын хувьд давхардсан байгааг засах шаардлагатай.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Төслийн 20 дугаар зүйлийн 20.19-т “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, давхардлыг шалгах, сонгогч шилжих журмыг энэ хуулийн 20 дугаар зүйлд нийцүүлэн батлан мөрдүүлнэ” гэж, мөн зүйлийн 20.23-т “Сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн тагнуулын байгууллага батална” гэж тус тус заасан. Эдгээр зохицуулалтуудаас үзвэл сонгогчдын нэрийн жагсаалт танилцуулах журмыг батлах эрхийг Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон тагнуулын байгууллагад давхардуулан олгосон мэт ойлгогдож байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төслийн дээр дурдсан асуудлыг хэрэгжүүлэх этгээдийг тодорхойгүй байдлаар тусгажээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.parliament.mn

Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно" гэж заасан. Өөрөөр хэлбэл, сонгуулийн эрх бүхий иргэд сонгуульд оролцож санал өгөх эрхтэй. Харин төсөлд "эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон", "хорих ял эдэлж байгаа" иргэн сонгуульд санал өгөх боломжгүй байдлаар тусгасан. Гэтэл энэхүү төсөлд гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэн Улсын Их Хурлын сонгуульд санал өгөх асуудлыг тусгалгүй орхигдуулсан байна. 2002 оны 03 сарын 28-29-ний өдөр зохион байгуулагдсан "Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь" сэдэвт олон улсын бага хуралд Б.Чимид агсан хэлсэн үгэндээ"... гадаад байгаа манай иргэдийг боломжийн хэрээр оролцуулж болохгүй юу, ялангуяа Улсын Их Хурлын сонгуульд. Олон оронд элчин сайд, консул байгаагийн хэрэг юу юм. Төр, иргэн хоёроо холбохгүй юм бол тэнд дипломат ажил хийж сууна гэж сэтгэл цатгалан байх үндэс байна уу? Ийм хувилбарыг би хуульд тусган боловсруулсан, надад төсөл нь байгаа. Тэнд яаж сонгуулийн хэсэг байгуулах вэ? хэн хариуцах вэ? яаж нэр дэвшүүлэх вэ? гэж. Хэрэв гадаад орон эсэргүүцэхгүй бол элчин сайд, консул байгаа орнуудад Монголын иргэдийг сонгуульд оролцуулах боломж бий"[21] гэж үзжээ. Гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэд Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд санал өгдөг. Тэгсэн хэрнээ Улсын Их Хурлын сонгуульд санал өгөх боломжгүй байгаа нь учир дутагдалтай. 2016 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн ажигласан ЕАБХАБ-ын Ардчилсан институт, хүний эрхийн газар урьдчилсан тайландаа "... нийт 1.912.901 сонгогч 2016 оны сонгууль оролцохоор бүртгэгдсэн. Гадаад улсад суугаа Монгол Улсын 150.000 орчим иргэн ...сонгуульд санал өгөх боломжгүй болж байна[22] гэж үзжээ. Дээрхээс дүгнэвэл, гадаад улсад суугаа сонгуулийн эрх бүхий Монгол Улсын иргэд Улсын Их Хуралд төлөөлөлгүй болж байна гэсэн үг. Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд заасан "сонгох эрх" нь зөрчигдөж байна гэж үзэх үндэслэлтэй.
Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Төслийн 20 дугаар зүйлийн 20.19-т "Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, *танилцуулах,* давхардлыг шалгах, сонгогч шилжих журмыг энэ хуулийн 20 дугаар зүйлд нийцүүлэн батлан мөрдүүлнэ" гэж; мөн зүйлийн 20.23-т "Сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн тагнуулын байгууллага батална" гэж чиг үүргийг давхардуулан хуульчилсан байна.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамж шинээр тогтоосон зүйлгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Төслийн 44 дүгээр зүйлийн 44.22-т "...44.11-д заасныг зөрчсөн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо цуцална" гэж заасан. Мөн зүйлийн 44.11-д "... шаардлага хангаагүй телевиз, радиогоор сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэхийг хориглоно" гэжээ. ААҮАТЗтХ-ийн 15 дугаар зүйлийн 15.16-д "Мэдээлэл, харилцаа холбооны чиглэлээр" олгох тусгай зөвшөөрлийг мөн хэсгийн 15.16.3-т "контентийн үйлчилгээ эрхлэх" гэж хуульчилсан. Үүнээс үзвэл, төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг ААҮАТЗтХ-д тусгасан гэж үзэж болох боловч нэр томьёоны хувьд ялгаатай байна.

хуульзүйнмэдээлэл www.legal.mn

Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Хуулийн төслөөр хүйсийн ялгавартай байдал бий болгосон зүйл, заалт байхгүй.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1-д "Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тарааж болно. Үүнийг сонгуулийн сурталчилгааны материалын хэмжээнд тооцохгүй" гэж заасан нь Улсын Их Хурлын гишүүн сонгуульд нэр дэвшсэн тохиолдолд давуу эрх бий болгосон зохицуулалт юм. Өөрөөр хэлбэл, нэр дэвшсэн УИХ-ын гишүүн хийсэн ажлын тайлангаа ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тарааж байгаа нь бусад нэр дэвшигчдээс давуу эрх эдлэн, өөрийн ажлыг тайлагнах замаар сонгуулийн сурталчилгаа хийж буй үйл ажиллагаа гэж ойлгогдож байна. Иймд төслийн энэхүү зохицуулалтыг шударга бус өрсөлдөөний бий болгоход чиглэгдсэн заалт гэж үзэх үндэслэлтэй байна.
Авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Төслийн 87 дугаар зүйлийн 87.3 дахь хэсэгт "Сонгуулийн үйл ажиллагааны явцад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ гэснийг үзвэл чухам ямар хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй харагдаж байна. Учир нь эдийн болон эдийн бус хохирол учруулсантай холбогдох асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийг удирдлага болгон шийдвэрлэдэг. Иймд "Иргэний хууль болон бусад хууль" гэж өөрчлөн найруулах. Мөн үүрэгжүүлсэн хориглосон зохицуулалтад хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль бусад хуулиар тодорхой тусгах нь зүйтэй юм.
	Төслийн Наймдугаар бүлэг болох Сонгуулийн зардал хэсэгт тусгагдсан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтууд нь гаргасан зөрчилтэй харьцуулахад харьцангуй бага байгаа ажиглагдаж байна. Тухайлбал, төслийн 48 дугаар зүйлийн 48.6-д "Энэ хуулийн 48.3, 48.5-д заасныг зөрчсөн нам, нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс хорин зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан бөгөөд торгуулийн хэмжээг одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр[279] тооцон үзвэл 6.720.000-8.320.000 /зургаан сая долоон зуун хорин мянгаас найман сая гурван зуун хорин мянга/-н төгрөг байхаар байна. Энэхүү зохицуулалтыг сонгуулийн нийт зардлын мөнгөн хөрөнгөд харьцуулж үзвэл хэд дахин бага торгууль оногдуулахаар харагдаж байна. Мөн төслийн 50 дугаар зүйлийн 50.4-т "Энэ хуулийн 42 дугаар зүйлд заасныг зөрчсөн нэр дэвшигчийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хорин нэгээс хорин зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заасан нь дээр дурдсан төслийн 48 дугаар зүйлийн зохицуулалттай ижил байдлаар ойлгогдож байна.[280]

[279] "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2018 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320.000 /гурван зуун хорин мянга/-н төгрөгөөр тооцов.

[280] Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 20 дахь талд "Ерөнхийдөө сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоотой зөрчлүүдэд оногдуулдаг арга хэмжээнүүд нь үр дүн муутай, тохиромжгүй байгаагийн зэрэгцээ сонгууль явуулах олон улсын сайн туршлагад зөвлөсний дагуу нэр дэвшигчдэд ижил тэгш өрсөлдөх боломж, нөхцөлийг хангаж өгөхгүй байна" гэж дурдаж байжээ. https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн огноо: 2019.01.02).

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

2015 онд батлагдсан Сонгуулийн тухай хуулиар Монгол Улсын Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэлийн, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах журмыг хамтад нь нэг хуулиар зохицуулсан билээ. Ийнхүү батлагдсан Сонгуулийн тухай хуулиар 2016 оны ээлжит Улсын Их Хурлын болон Аймаг, нийслэлийн, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг, 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг тус тус зохион байгуулж явуулсан билээ.

2016 оны Улсын Их Хурлын ээлжит сонгуулийг зохион байгуулах явцад Сонгуулийн тухай хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх хийгээд хуулийн алдаа, эрх зүйн хийдэл, давхардал, зөрчил зэргээс үүдэн зохион байгуулалтын явцад ихээхэн хүндрэл бэрхшээл учирч байсныг сонгууль зохион байгуулж явуулсан бүх шатны сонгуулийн байгууллага, ажиглагч, сонгуульд өрсөлдсөн намын төлөөллүүд илэрхийлсэн байна. Ийнхүү дээрх хэрэгцээ, шаардлагад үндэслэн УИХ-ын сонгуулийн харилцааны онцлогийг тусгаж, эрх зүйн орчныг сайжруулах үүднээс энэхүү хуулийн төслийг боловсруулсан хэмээн үзэх үндэслэлтэй.

Хуулийн төслийн олон заалт нь дээр дурдсанчлан Сонгуулийн тухай хуулийн зөрчил, эрх зүйн хийдэл, ойлгомжгүй байдал бий болгож байсан зохицуулалтуудыг боловсронгуй болгож, хүн бүрд ойлгомжтой байдлаар тусган, практикт хэрэгжих боломжийг бүрдүүлсэн байна.

Гэсэн хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн, УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуулийн хуулийн төслийн зүйл, заалтууд өөр хоорондоо давхардсан заалт ихтэй. Мөн МУИХСтХ-ийн төслийн тухайд бусад хууль тогтоомжид заасан хуулийн зүйл, заалт болон төслийн зүйл, заалтууд нь өөр хоорондоо давхардсан, зөрчилтэй заалтууд цөөнгүй байна. Энэхүү судалгаагаар МУИХСтХ-ийн төслийн үр нөлөөг үнэлж, шалгуур үзүүлэлт тус бүрээр дараах дүгнэлтэд хүрч байна.

1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үзэл баримтлалыг үзвэл гурван зорилт дэвшүүлсэн байх бөгөөд дэвшүүлсэн зорилт бүрийн хүрээнд хамаарах тодорхой зохицуулалтыг сонгон авч үр нөлөөг үнэлсэн. Тодруулбал,

Нэгд, Сонгууль зохион байгуулж явуулах эрх зүйн орчныг сайжруулах;

Хоёрт, “Тухайн харилцааны эрх зүйн зохицуулалтыг нарийвчлан шинэ хуулиар зохицуулах шаардлагатай тул анхдагч хуулийн төслийг боловсруулах;

Гуравт, “УИХ-ын сонгуулийн үндсэн зарчим, журам, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангахтай холбогдсон харилцааг тодорхой болгон тусгах” зорилтын хүрээнд холбогдох зохицуулалтыг сонгон авч үнэлсэн болно.

- Төсөлд СтХ-д заасан зохицуулалтуудыг өөрчлөн найруулж, боловсронгуй болгосон, мөн шинээр зохицуулалт тусгасан зэрэг эерэг нөлөөлөл бүхий зүйлүүд ажиглагдаж байсан ч төслийн зүйл, заалтуудын хоорондын уялдаа холбоо, давхардал, зөрчил хийгээд бусад хуулийн зүйл, заалттай зөрчилдсөн заалтууд олон байсан.
- Төсөлд хэлбэрийн хувьд шинэлэг зохицуулалт цөөнгүй боловч агуулгын хувьд шинэ зохицуулалт ховор байсан тул “хуулийн зорилт” болон “сонгуулийн сурталчилгааны цахим хуудас”-ны тодорхойлолтыг шинээр томьёолсонтой холбоотой зохицуулалтыг сонгон авсан. Гэвч тийнхүү шинээр томьёолохдоо бусад зүйл, заалтуудын уялдааг нягтлан шалгаагүйн улмаас хуулийн зохицуулалт хоорондын зөрчилтэй байдлыг бий болгож байв. Мөн хуулийн зорилтыг томьёолохдоо зохицуулах харилцааг дутуу томьёолсныг өргөжүүлэх шаардлага тулгарч байна.

- Хууль зүйн шинжлэх ухааны гол ойлголтын нэг нь эрх зүйн зарчим байдаг. Иймд зарчим нь хоосон тунхаг төдий биш бөгөөд аливаа хуулийн зарчим бодитой байх учиртай. Төсөлд сонгуулийн эрх зүйн зарчмыг хуульчлахдаа бүх нийтээр баримтлах түгээмэл зарчмыг хуульчилсан нь сайшаалтай. Гэсэн хэдий ч зарим шаардлагатай зарчим, тодруулбал, "тэгш эрхийн зарчим" болон сонгууль зохион байгуулж явуулах зарчмуудын ихэнхийг нь орхигдуулсан байна.

2. Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн заалтуудаас практикт хэрэгжихэд хүндрэлтэй заалтуудыг сонгон авч судалсан болно. Дээр дурдсан заалт нь СтХ-д ч мөн хуульчлагдсан байдаг бөгөөд 2016 оны Улсын Их Хурлын сонгууль, 2017 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн зохион байгуулалт, үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, олон улсын байгууллагуудаас бүрдсэн сонгуулийн ажиглах хороодоос гаргасан тайлан мэдээнд үндэслэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн тэр дундаа тэргэнцэртэй иргэдийн Үндсэн хуулиар баталгаажсан сонгох эрхийг хэрхэн хангах талаар судлан үзсэн болно. Төслийн дээрх зохицуулалт нь хуулиар тэргэнцэртэй иргэний сонгох эрхийг баталгаажуулсан, хангахад чиглэгдсэн мэт харагдаж байвч практикт хэрэгжихэд хэд хэдэн асуудлыг үүсгэдэг байна.

Иймд энэхүү зохицуулалтыг практикт хэрхэн хэрэгжүүлбэл зохих талаар судалж, хэрэгжүүлэх субъектыг тодорхой болгон, Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний "сонгох" эрхийг баталгаатай эдлүүлэх боломжийг ханган ажиллах нь зүйтэй.

3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн зохицуулалтууд өөр хоорондоо зөрчилтэй, давхардсан зохицуулалтууд нэлээд олон байгаа нь хуулийн төслийг практикт нэг мөр ойлгож, зөв хэрэглэж, хэрэгжүүлэхэд хүндрэл учруулах боломжтой тул дээр дурдсан зөрчлүүдийг арилгах нь зүйтэй. Тухайлбал,

Төслийн ойлгомжтой байдлыг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэлэхэд төслийн зарим зүйл, заалт шаардлагад нийцээгүй болох нь тогтоогдож байна. Үүнд:

- Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж ойлгомжгүй байдал үүсгэж буй, төслийн зохих хэсэгт тусгаагүй зүйл, заалт хэд хэд байна. Тухайлбал, төслийн 6 дугаар зүйлийн 6.4-т хориглосон заалт тусгасан байтал төслийн зарчмын хэсэгт оруулсан, төслийн 46 дугаар зүйлд хориглох заалтууд тусгасан хэдий ч 46.3-т "болно" гэсэн зохицуулалтыг оруулсан, төслийн 20.6 дахь хэсэгт "... ээлжит сонгуулийн жилийн тавдугаар сарын 15-ны өдрөөс өмнө хүргүүлнэ" гэж заасан хэрнээ 20.6.6-д "санал авах өдөр зөрчлийн улмаас ... сонгогчдын мэдээллийг" гэсэн зохицуулалтыг оруулсан, мөн төсөлд "итгэмжилсэн ажилтан", "итгэмжлэгдсэн ажилтан" гэх хоёр өөр нэр томьёогоор нэг хүнийг илэрхийлсэн, мөн явуулах процесс нь өөр байх тохиолдлуудад "нэн даруй" гэсэн ойлголтыг нэгдмэл байдлаар тусгасан байна.
- Төслийн зарим зүйл, заалт нь хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой уялдаагүй, зөрчилдөж байна. Тухайлбал, төслийн 16.1, 17.1, 18.1-д заасан зохицуулалтаас үзвэл сонгуулийн хорооны гишүүдийг тэгш тоогоор бүрдүүлж болохоор ойлгогдож байх тул энэхүү асуудлыг нэг мөр болгох нь зүйтэй.

4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай 14 төрлийн асуулгаас 4 төрлийн асуулга шаардлага хангасан, уялдаа холбоотой болсон бөгөөд төсөлд шинээр албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зүйлгүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, авилга хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна.

Шалгуур үзүүлэлтэд заасан 10 асуулгын хүрээнд хуулийн төслийн зарим зүйл, заалт харилцан уялдаа холбоотой байх шаардлага хангаагүй гэж үзлээ. Үүнд:

- Нэр томьёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томьёотой нийцэхгүй тохиолдол байна. Тухайлбал, ХХтХ-д тусгагдсан “түдгэлзүүлэх” гэснийг “зогсоох” гэж, “хүчингүй болгох” гэснийг “цуцлах” гэж төсөлд өөрөөр томьёолсон байна.
- Төсөлд тусгагдсан зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа байдлын хүрээнд хэд хэдэн зөрчилтэй заалтууд илэрсэн. Тухайлбал, төслийн 5.8, 6.15, 14.21, 19.24, 87.4 дэх хэсэг нь Төрийн албаны тухай хуулийн “... төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах” тухай зохицуулалттай зөрчилдөхөөр байна. Мөн төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “... ажлын арван өдөрт” гэсэн зохицуулалт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д заасан зохицуулалттай зөрчилдөхөөр байна. Иймд бусад хууль тогтоомжтой зөрчилдөж буй зүйл, заалтуудыг тухайн хууль тогтоомжид нь нийцүүлэн өөрчлөн найруулах нь зүйтэй. Мөн төсөлд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамааруулан торгууль оногдуулахаар заасан нь Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуультай нийцэхгүй байна.
- Хуулийн төслийн зүйл, заалтууд нь өөр хоорондоо болон бусад хууль, хуулийн төсөлтэй давхардсан зохицуулалтууд нэлээд байна.[276]
- Хуулийн төсөлд гадаад улсад байгаа сонгуулийн эрх бүхий иргэд УИХ-ын сонгуульд санал өгөх асуудлыг орхигдуулсан гэж үзэж байна.

4.2. Зөвлөмж

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт хуулийн зорилтыг тодорхойлохдоо дутуу томьёолсныг өргөжүүлэн зохицуулах;
- Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.11, 45 дугаар зүйлийн 45.2, 46 дугаар зүйлийн 46.4.18 дахь заалтад заасан “сонгуулийн сурталчилгааны цахим хуудас”-ын тодорхойлолтыг дахин авч үзэх, зүйл, заалт хоорондын зөрчлийг арилгах;
- Төслийн 16.1, 17.1-д зааснаар аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн хороог байгуулахдаа дарга, нарийн бичгийн даргаас гадна “таваас долоо”, “гурваас таван” гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар, төслийн 18.1-д хэсгийн хороог дарга, зургаагаас найман гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар зохицуулсан нь сонгуулийн хорооны бүрэлдэхүүнийг тэгш тооны гишүүнтэйгээр бүрдүүлж болохоор ойлгогдож байх тул төслийн 16.1, 17.1, 18.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг нэг мөр болгох үүднээс 16.1-д “таваас долоон гишүүнтэй” гэснийг “тав эсхүл долоо” гэж, 17.1-д “гурваас таван гишүүнтэй” гэснийг “гурав эсхүл тав” гэж, 18.1-д “зургаагаас найм гишүүнтэй” гэснийг “зургаа эсхүл найм” гэж өөрчлөн найруулах нь зүйтэй;
- Төслийн 69 дүгээр зүйлийн 69.4, 69.5 дахь хэсэгт заасан зохицуулалтыг хэрэгжүүлэхэд анхаарч, хэрэгжүүлэх субъектыг тодорхой болгох;

[276] СЕХ-оос хийсэн хуулийн төслүүдийн харьцуулалтаас дэлгэрүүлэн үзнэ үү.

- УИХ-ын сонгууль бие даан нэр дэвшиж буй нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, аудитын дүгнэлтийн талаар зохицуулсан төслийн 30.6.9, 36.7, 36.9 дэх хэсэгт заасан зохицуулалтыг нэг мөр болгох;
- Бусад хууль тогтоомжтой зөрчилдсөн төслийн зүйл заалтуудыг холбогдох хууль тогтоомжтой уялдуулах. Тухайлбал, Төрийн албаны тухай хуульд зааснаар "төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах" зохицуулалттай төслийн 5.8, 6.15, 14.21, 19.24, 87.4 дэх хэсэгт заасан зохицуулалтыг уялдуулах. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.5-д заасан зохицуулалттай төслийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь хэсэгт заасан зохицуулалтыг уялдуулах;
- Хуулийн төсөлд байгаа хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдөж ойлгомжгүй байдал үүсгэж буй зүйл заалтыг нэг мөр болгон цэгцлэх;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн зохих шаардлагад нийцүүлэх;
- Хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомжтой төсөлд тусгагдсан зүйл, заалтуудыг нийцүүлэх, харилцан уялдааг сайжруулах;
- Итгэмжилсэн төлөөлөгч, итгэмжлэгдсэн төлөөлөгч гэх хоёр өөр нэр томьёогоор нэг субъектыг илэрхийлж байгаа өөрчилж, ойлголтыг нэг мөр болгох;
- Төсөлд сонгуулийн санал авах хугацааг "07:00-20:00" болгон өөрчилснийг дахин хянаж, СтХ-д зааснаар "07:00-22:00" болгох;
- Сонгуулийн зардалтай холбоотой төсөлд тусгагдсан зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг нэмэгдүүлэх талаас нь анхаарах;
- Сонгуулийн тухай хууль зөрчсөн этгээдэд хүлээлгэх зөрчил, эрүүгийн хариуцлагыг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд тусгайлан хуульчлах;
- Торгох ял, шийтгэлийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ бус Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуультай уялдуулан "нэгж"-ээр торгох тухай зохицуулах шаардлагатай.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж,

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, 1946
- Иргэний болон Улс төрийн эрхийн тухай Олон Улсын Пакт, 1966
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц, 2008
- Авилгалын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, 2003
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №6
- Харилцаа холбооны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43
- Төрийн аудитын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2003), №2
- Сонгуулийн төв байгууллагын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2006), №5
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2006), №8
- Сонгуулийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №4
- Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24

Хууль зүйн Үндэсний хүрээлэн www.jli.gov.mn

- Төрийн албаны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2018), №1
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №7
- Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль (2016), №9
- Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2017 оны 1 дүгээр дүгнэлт "Сонгуулийн тухай хуулийн зарим заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай"
- Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн 2016 оны 5 дугаар дүгнэлт " Сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, 120 дугаар зүйлийн 120.3 дахь хэсэг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай"
- УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2017 оны 1 дүгээр тогтоолын хавсралт "Төрийн аудитын байгууллагын зохион байгуулалтын ерөнхий бүтэц, эрхлэх асуудлын хүрээ"
- Улсын дээд шүүхийн 2003 оны 02 дугаар тогтоол "Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай"
- Улсын дээд шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол "Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай"

Хоёр. Ном, гарын авлага, судалгааны тайлан

- Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг: Дүн шинжилгээ /Хамтын судалгааны тайлан/, УБ., 2015 он.
- Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь. Олон Улсын бага хурлын эмхэтгэл, Сонгуулийн ерөнхий хороо, УБ., 2002 он.
- Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, УБ., 2000 он.
- Сонгуулийн дараах олон нийтийн санал бодлын тандалт судалгаа. Нийгмийн Бодлого Хөгжил Судалгааны Хүрээлэн. УБ., 2016.
- Төрийн ил тод байдал: нийгмийн баялаг хуваарилалт, Форумын эмхэтгэл, Нээлттэй нийгэм форум, УБ., 2006 он.
- Б.Чимид, Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу? УБ., 2011 он.
- Б.Чимид, Сонгуульд суралцахуй, УБ., 2008 он.
- Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал /хоёр дахь хэвлэл/, УБ., 2017 он.

Гурав. Илтгэл, өгүүлэл, ярицлага, мэдээлэл, лавлагаа /Үсгийн дараалаар/

- Д.Ганзориг, "Үндсэн хуулийн зөрчил үү, энгийн хуулийнх уу гэдгээс хамаарч маргааныг шийдэх учиртай" (2014.12.26), http://vip76.mn/content/28970
- Э.Лхагвасүрэн, "Хариуцлагын механизмыг сонгуулийн хуулинд нарийн тусгах хэрэгтэй" (2014.12.22), http://vip76.mn/content/28836
- Б.Чимид, "Сонгуулийн зарчмуудыг зөв хэрэгжүүлэхүй" (2002) СЕХ, Олон Улсын бага хурлын эмхэтгэл
- Ж.Ядамсүрэн, "Монгол Улсын сонгуулийн тогтолцоо, зарчмыг Үндсэн хуулиар баталгаажуулсан нь ардчиллын нэг ололт мөн" (2002) СЕХ, Олон Улсын бага хурлын эмхэтгэл

Дөрөв. Цахим эх сурвалж

- Дэлхийн сонгуулийн байгууллагуудын холбооны албан ёсны цахим хуудас http://www.aweb.org/eng/main.do
- Азийн сонгуулийн байгууллагуудын холбооны албан ёсны цахим хуудас http://asianelectionauthorities.org/index.html
- Сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны цахим хуудас http://gec.gov.mn/

Хуулийн Үндэсний Хүрээлэн www.ikh.gov.mn

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем http://www.legalinfo.mn/
- Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны цахим хуудас http://www.nli.gov.mn/
- Монгол Улсын сонгуулийн тухай хуулийн төслийн цахим хэлэлцүүлэг http://vip76.mn/forum/40
- Олон улсын сонгуулийг ажиглах хороо Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль 2017 оны 6-р сарын 26-ны өдөр https://www.osce.org/mn/odihr/327166?download=true
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6 сарын 26 болон 7 сарын 7-ны өдрүүд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Тайлан https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/366136?download=true

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

“АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ” ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ[277]

УДИРТГАЛ

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.1.22-д “Хууль зүйн судалгааны чанарыг шинэ түвшинд гаргаж, хууль тогтоомжийн боловсруулалт, хэрэгжилтийг судалгаанд суурилан хөгжүүлэх боломжийг бүрдүүлнэ” гэж, мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-т “Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийг санаачлах, боловсруулах ажиллагааны үндэслэл, чанарыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог хангах, хууль тогтоомжийн төсөлд тавих шаардлагыг тодорхойлох, хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг үнэлэх замаар хууль дээдлэх ёсыг бэхжүүлнэ” гэж тус тус заасан.

Энэхүү үнэлгээний зорилго нь Засгийн газраас баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг /цаашид “төсөл” гэх/ боловсронгуй болгоход оршино.

Түүнчлэн судалгаагаар төслийн үр нөлөөг үнэлж, уг төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах замаар Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн эрх зүйн орчныг сайжруулах боломжийг тодорхойлох, мөн хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад хууль санаачлагчид дэмжлэг үзүүлэхийг зорилоо.

Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-д заасны дагуу дараах үе шаттайгаар гүйцэтгэлээ. Үүнд:

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслийн үр нөлөө тооцох хэсгээ тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

НЭГ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Төслийн үр нөлөөний үнэлгээг тооцохдоо зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон:

5. Зорилгод хүрэх байдал;
6. Практикт хэрэгжих боломж;
7. Ойлгомжтой байдал;
8. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн:

1. Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад чиглэсэн278 байх гэсэн үндсэн зорилгод хүрсэн эсэх.
2. Уг төсөлд тусгагдсан, санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан

[277] Энэхүү үнэлгээг УИХ-ын гишүүн Л.Энх-Амгалангийн захиалгаар 2019 онд ХЗҮХ-ийн ЭНБД, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, Д.Цэцэгдарь нар хамтран гүйцэтгэв.

[278] Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд туссан зорилгыг аргачлалын дагуу шалгав.

зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх;

3. Төсөлд тусгагдсан зохицуулалтуудыг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектүүдийн хувьд ойлгомжтой, логик дараалалтайгаар боловсруулагдсан эсэх;
4. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан эсэхийг тус тусад нь шалгана.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООХ

Энэхүү хэсэгт уг төслийн үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд холбогдох зүйл, заалтыг сонгоно. Энэхүү зүйл, заалтыг сонгохдоо хууль зүйн хувьд шууд үр дагавар үүсгэж байгаа голлох ач холбогдол бүхий заалтуудыг сонгож авсан.

2.1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

Төслийн үндсэн зорилго нь Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад чиглэсэн279 байна. Энэ зорилгод хүрэхийн тулд дэвшүүлсэн зорилтуудыг нэгтгэн дараах байдлаар тогтоосон.

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох,
- Тусгайлсан хууль боловсруулах,
- Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах,
- Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах.

Иймд хуулийн төслийн дээрх зорилтуудтай холбогдсон зүйл, заалтыг сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцох болно. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 1. *Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох,	6 дугаар зүйл, 3.1.5, 6.13, 9.11, 14.5, 16.2.10, 16.2.13, 17.3.13, 18.2.4, 19.12, 19.16, 20.19, 20.20, 20.23, 21 дүгээр зүйлийн нэр, 22.3.5, 22.4.5, 23.6.6, 26 дугаар зүйл, 31.1, 33.6, 43.17, 44.8, 67.2, 67.5, 69.13, 70.4, 73.6, 73.7, 75.3, 77.9, 77.15, 77.18, 84.2, 84.5, 85.2, 87.1, 87.5, 87.6, 11 дүгээр бүлгийн нэр
2.	Тусгайлсан хууль боловсруулах,	1 дүгээр зүйл
3.	Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах,	4.1, 5 дугаар зүйл,
4.	Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах.	Гуравдугаар бүлэг

2.2. “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Практикт хэрэгжих байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд, санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх, талаарх зохицуулалтыг сонгон “Практикт хэрэгжих байдал”-ын үр нөлөөг нь тооцох болно.

[279] Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалд туссан зорилгыг аргачлалын дагуу шалгаж үзлээ.

Хуулийн үндэсний хөтөлбөр www.nlt.gov.mn

Хүснэгт 2. *Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зүйл, заалт*

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
2.	Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэх	68.5.Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна, 68.4.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.

2.3. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг төслийн зүйл, заалт хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг шалгаж тогтооно. /Хуулийн төсөл нь 12 бүлэг, 89 зүйлтэй/

2.4. “Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд уг хуулийн төслийн уялдаа холбоо хангагдсан эсэхийг шалгаж тогтооно. /Хуулийн төсөл нь 12 бүлэг, 89 зүйлтэй/

ГУРАВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮР НӨЛӨӨГ ТООЦОХ

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 3. *Шалгах хэрэгслийг сонгосон байдал*

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
5.	Зорилгод хүрэх байдал	6 дугаар зүйл, 3.1.5, 6.13, 9.11, 14.5, 16.2.10, 16.2.13, 17.3.13, 18.2.4, 19.12, 19.16, 20.19, 20.20, 20.23, 21 дүгээр зүйлийн нэр, 22.3.5, 22.4.5, 23.6.6, 26 дугаар зүйлийн нэр, 31.1, 33.6, 43.17, 44.8, 67.2, 67.5, 69.13, 70.4, 73.6, 73.7, 75.3, 77.9, 77.15, 77.18, 84.2, 84.5, 85.2, 87.1, 87.5, 87.6, 11 дүгээр бүлгийн нэр	Зорилгод дүн шинжилгээ хийх
		1 дүгээр зүйл	
		4.1, 5 дугаар зүйл,	
		Гуравдугаар бүлэг	
6.	Практикт хэрэгжих боломж	68.4, 68.5 дахь хэсэг	Практикт тухайн төрлийн харилцаа, чиг үүргийг хэрэгжих боломж, гарч болох хүндрэлийг судлах.
7.	Ойлгомжтой байдал	Төслийг бүхэлд нь тооцно.	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.

Хууль зүйн яаманд хүрэлцэн www.mli.gov.mn

8.	Харилцан уялдаа	Төслийг бүхэлд нь тооцно.	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараах байдлаар үнэллээ.

3.4. Зорилгод хүрэх байдал

"Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад чиглэсэн" зорилгод хүрэхийн тулд дэвшүүлсэн зорилтуудад дараах байдлаар дүн шинжилгээ хийж үзлээ:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох, /6 дугаар зүйл, 3.1.5, 6.13, 9.11, 14.5, 16.2.10, 16.2.13, 17.3.13, 18.2.4, 19.12, 19.16, 20.19, 20.20, 20.23, 21 дүгээр зүйлийн нэр, 22.3.5, 22.4.5, 23.6.6, 26 дугаар зүйл, 31.1, 33.6, 43.17, 44.8, 67.2, 67.5, 69.13, 70.4, 73.6, 73.7, 75.3, 77.9, 77.15, 77.18, 84.2, 84.5, 85.2, 87.1, 87.5, 87.6, 11 дүгээр бүлгийн нэр/

Төслийн 6 дугаар зүйлд сонгуулийн үйл ажиллагаанд баримтлах зарчмыг хуульчилжээ. Нийтлэг зарчим болох сонгох, сонгогдох эрхийг хангах, хөндлөнгийн нөлөөгүйгээр хүсэл зоригоо илэрхийлж, саналаа нууцаар гаргах, хууль дээдлэх, ил тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд эхэлж, дуусах зэргийг тусгасан.

Харин төслийн 6.4 дэх хэсэгт хориглосон зохицуулалт, 6.7, 6.8 дахь хэсэгт сонгуулийн хугацаа, 6.9 дэх хэсэгт сонгогчийн саналаа нууцаар гаргах эрх сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчимд хамаарахгүй тухай, 6.10, 6.11 дэх хэсэгт үүрэгжүүлсэн зохицуулалт, 6.12 дахь хэсэгт ТББ эрхийн талаар, 6.13 дахь хэсэгт сонгуулийн төв байгууллагын журам батлах тухай, 6.14 дэх хэсэгт хориглосон зохицуулалтад ногдуулах торгуулийн хэмжээг заасан байгааг зарчимд хамааруулан үзсэн нь зарчмыг тодорхой болгосон гэж үзэх үндэсгүй байна.

Төслийн 3.1.5, 6.13, 9.11, 14.5, 16.2.10, 16.2.13, 17.3.13, 18.2.4, 19.12, 19.16, 20.19, 20.20, 20.23, 21 дүгээр зүйлийн нэр, 22.3.5, 22.4.5, 23.6.6, 26 дугаар зүйл, 31.1, 33.6, 43.17, 44.8, 67.2, 67.5, 69.13, 70.4, 73.6, 73.7, 75.3, 77.9, 77.15, 77.18, 84.2, 84.5, 85.2, 87.1, 87.5, 87.6, 11 дүгээр бүлгийн нэрэнд журамтай холбоотой зохицуулалт тусгагдсан.

Ийнхүү тусгахдаа, *"...тухай хуулийн 141-143 дугаар зүйлд заасан журмын дагуу...",* "Энэ хуулийн 6.12-д заасан үйл ажиллагааг зохицуулах журмыг ...батална", "...хоногийн ням гарагт улс даяар нэгдсэн журмаар явагдана.", "сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журмыг... батална.", "...зохих журмын дагуу", "Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан журмын дагуу", "санал авах өдрөөс 26-аас доошгүй хоногийн өмнө ирүүлж, энэ хуульд заасан журмын дагуу бүртгүүлж болно", "Радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх, хяналт тавих журмыг ...баталж, мөрдүүлнэ", "Саналын хуудас нь санал авах өдөр хүртэл, санал авч эхэлснээс хойш санал тоолж дуусах хүртэл, санал авах ажиллагаа дуусанаас хойш холбогдох журмын дагуу", "Нөхөн сонгуулийг энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулна.", "Энэ хуульд заасан зөрчлийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан харьяалал, журмын дагуу хянан шийдвэрлэнэ", "Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 112 дугаар зүйлд заасны дагуу тусгай журмаар шийдвэрлэх", "21 дүгээр зүйлийн нэр Сонгогчдын нэрийн жагсаалттай холбогдсон гомдлыг шийдвэрлэх журам", "26 дугаар зүйлийн нэр нь Нэр дэвшүүлэх нийтлэг журам", "нэвтрүүлэх талаар энэ хуулийн 43.17-д заасан журам зөрчсөн", бүлгийн нэр нь "Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, гомдол маргаан

хянан шийдвэрлэх харьяалал, журам” зэргээр зохицуулсан байгаа нь ямар журмыг тодорхой болгож байгаа нь ойлгомжгүй байна.

Зорилгод хүрэх эхний зорилт тодорхойгүй, ойлгомжгүй байх тул зорилгод хүрсэн гэж үзэх үндэсгүй байна.

Тусгайлсан хууль боловсруулах, /хуулийн төслийн 1 дүгээр зүйл/

Хуулийн төслийн үзэл баримтлалд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан, бүхэлд нь боловсронгуй болгох, Сонгуулийн тухай хуулиас тусгайлсан хуулийн төсөл боловсруулах талаар тусгасан. Иймд хуулийн төслийн 1 дүгээр зүйлд дүн шинжилгээ хийж үзлээ.

Сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах талаар 1996, 2007, 2012, 2015 оны хуулиудын зорилтод заасан байна. Мөн энэхүү Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл, бусад тусгайлсан хуулийн төсөл болох УИХ-ын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд зорилтод ижил зохицуулжээ.

Сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбоотой харилцааг тусгайлсан хуулиар зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, сонгуулийг зохион байгуулж явуулах ажлыг Сонгуулийн төв байгууллага буюу сонгуулийн төв хороо хариуцах бөгөөд энэ тухай 2006 онд батлагдсан Сонгуулийн төв байгууллагын тухай хуулиар зохицуулдаг. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд заасан Хуулийн зорилтод “сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах” талаар тусгасан байгаа нь хууль хоорондын давхардлыг үүсгэж байна.

Аливаа хуулийн зорилтод тухайн хуулиар зохицуулагдах харилцааны хамгийн товч хэлбэрийг тусгасан байдаг бөгөөд энэхүү хуулийн төслийн зорилтоос үзвэл сонгуулийг зохион байгуулж явуулах тухай зохицуулж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар заагдсан сонгох, сонгогдох эрх хэрхэн хангагдах, үндсэн зарчмыг хэрхэн тодорхой болгож байгаа нь ойлгомжгүй байна.

Манай улсын болон олон улсын эрдэмтэн судлаачид[280] 2002 онд “Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь” олон улсын бага хурлаар “Сонгуулийн хууль тогтоомжийг улс эх орныхоо язгуур эрх ашиг, нийтийн эрх ашгийг хангах, урт удаан хугацаанд үйлчлэх тогтвортой сайн хуультай болох үүднээс боловсруулах нь зүйтэй юм. Сонгуулийн хууль ард түмэнд хамгийн ойлгомжтой, энгийн бөгөөд тэдний эрхийг дээд зэргээр хангасан байх” тухай хэлэлцэж байсан.

Мөн сонгуулийн хууль, сонгуулийн тогтолцооны үүсэл хөгжил, төлөвшил болон бүхий л асуудлыг нухацтай авч үзсэн байх бөгөөд энэ үед сонгуулийн тогтолцоог сонгох, түүний эрх зүйн үндсийг бүрдүүлэх, сонгууль явуулах ажилтныг бэлтгэх, сонгогчдын улс төрийн боловсролыг дээшлүүлэх нь тулгамдсан асуудал байжээ.

1992 оноос 2019 он буюу 27 жилийн дараа тусгайлсан хуулийн төслүүдийг хэлэлцэх хэлэлцүүлгийн[281] явцад мөн л эдгээр тулгамдсан асуудал хэвээр байгааг оролцогсод онцолж байсан. Мөн тусгайлсан хуулийн төслүүдийг давхардуулсан байгаа тухай дурдаж байна.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сонгуулийн тухай хуулиар УИХ, Ерөнхийлөгч, Орон нутаг гэсэн үгээр ялгаатай агуулгын хувьд давхардсан зохицуулалт олон байдаг. Хуулийн төслийн үзэл баримтлалд одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Сонгуулийн тухай хуулийн ерөнхий зарчмыг баримтлан орон нутгийн Хурлын сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан бие даасан хуулийн төслийг боловсруулах талаар тусгасан хэдий ч Сонгуулийн тухай хууль, Аймаг,

[280] “Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь” олон улсын бага хурлын эмхэтгэл. Эмхэтгэсэн, Ж.Ядамсүрэн. Уб., 2002 он.

[281] Төрийн байгуулалтын байнгын хорооны хэлэлцүүлэг. Уб., 2018 он.

нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл нь цөөхөн зохицуулалтаар ялгаатай болжээ. Өөрөөр хэлбэл, хуулийн ихэнх зохицуулалтыг хуулбарлах байдлаар боловсруулсан төдийгүй тусгайлсан 3 хуулийн төсөл хоорондын давхардлыг үүсгэх бөгөөд ялгаатай зохицуулалтыг олж харахад төвөгтэй байдлыг үүсгэж байна.

Иймд Сонгуулийн тухай хуулийг өөрчлөн тусгайлсан хуулиудыг гаргахаар зорьж байх тул эдгээр хуулийн төслөөр /УИХ, Ерөнхийлөгч, АНСДИТХ/ тусгайлсан онцлог зохицуулалтыг тусгах буюу нэгэнт хууль боловсруулж байгаатай холбогдуулан Сонгуулийн тухай хуульд /ерөнхий хууль/ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль буюу үйл ажиллагаа, зохион байгуулалтыг зохицуулсан байгаа Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг нэмж зохицуулан харин санхүүжилтийн асуудлыг тусдаа хуулиар зохицуулан сонгуультай холбоотой 5 тусгайлсан хуулийг боловсруулан давхардсан зүйлгүй ойлгомжтой энгийн байдлаар сонгох, сонгогдох эрхийг ханган, урт удаан хугацаанд тогтвортой үйлчлэх, сайн хуулийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах, /4.1, 5 дугаар зүйл/

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд “Монгол Улсын иргэн ...шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг 18 наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгазан хуулиар тогтооно.”[282] гэж заажээ. Ийнхүү МУҮХ батлагдсанаас хойш сонгогчид сонголтоо хийх бүрэн эрхээр хангагдсан төдийгүй бүх шатны сонгуульд оролцох эрхтэй болсон.

Хуулийн төслийн 4.1 дэх хэсэгт “Орон нутгийн Хурлын сонгууль нь Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, тухайн нутгийн өөрөө удирдах байгууллагыг өөрсдийн төлөөллөөр бүрдүүлэх үндсэн арга мөн.” гэж сонгох эрхийг хангах үндсэн зарчмыг тунхаглажээ. Харин 5 дугаар зүйлд Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг 8 хэсэгт хуваан зохицуулжээ. Сонгуулийн эрх бүхий иргэн үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлагдахгүйгээр сонгох эрхтэй.

Орон нутгийн Хурлын төлөөлөгчөөр сонгогдох эрхийг хорин таван нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, суманд санал авах өдрөөс өмнө 180-аас доошгүй хоногийн хугацаанд тасралтгүй, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, хуулиар заасан бусад шаардлагыг хангасан иргэн байх тухай заасан. Харин хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 4 заалтад хориглосон, эрхгүй байх тухай, хариуцлагын заалтыг тусгасан байгаа нь зүйлийн нэртэй нийцэхгүй байна. Иймд сонгох, сонгогдох эрхийг хангах зохицуулалт туссан хэдий ч зорилтод хүрсэн гэж үзэхгүй байна.

Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулах. /Гуравдугаар бүлэг, 14-19 дүгээр зүйл/

Хуулийн төслийн 14.2-т Сонгуулийн ерөнхий хороо нь орон нутгийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах тухай зохицуулсан бол Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.3-т Сонгуулийн ерөнхий хороо нь аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг зохион байгуулж явуулах, түүний бэлтгэл ажлыг хангахад мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах тухай заасан байна. Мөн энэ хуулийн төслийн зорилтоос эхлэн ихэнх зохицуулалт зохион байгуулалтыг хангасан байх тул сайжруулахад нэлээд анхаарсан зэрэг нь хэлэлцүүлэгт дурдсан байгаагаас харж болох юм. Иймд дээрх зорилтыг хангасан гэж үзэх үндэслэлтэй юм.

[282] Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл 1992 оны №1.

3.5. Практикт хэрэгжих боломж

Судалгааны багийн зүгээс “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн үр нөлөөг тооцох хэсгийг тогтоохдоо цахим хуудас дахь мэдээлэл, судлаачдын судалгаа, мэдээллийг судлах замаар шалгасан.

Шалгуур үзүүлэлтийн хүрээнд Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан эсэхийг хуулийн төслийн 68.4, 68.5-т заасныг сонгон авч үнэлэлт өгөхийг зорилоо. Ингэхдээ дараах асуултад хариулахыг эрмэлзлээ.

3. Хуулийн төслийг хэрэгжүүлэх субъект байгаа эсэх;
4. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэхэд боломж бололцоо байгаа эсэх.

68.4.Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна.
68.5.Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна

3. Хэрэгжүүлэх субъект байгаа эсэх:

Төслийн 68.4-т “Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна”, 68.5-т “Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна” гэж заасан байна.

СЕХ нь иргэдийг санал өгөх эрхээ эдлэх боломжоор хангахын тулд нэлээдгүй хүчин чармайлт гаргасан байдаг бөгөөд хамгийн сүүлийн 2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас авч үзвэл сонгуулийн байгууллага хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх нөхцөлийг хөнгөвчлөх хүчин чармайлтуудыг гаргаж байсан хэдий ч санал авах олон байр хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс ороход хүндрэлтэй хэвээр байжээ.[283]

Хууль эрх зүйн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа тэдэнд хүртээмжтэй болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх зэрэг үүргийг заажээ[284]. Гэвч зарим төрлийн сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгтэй сонгогчдын санал өгөх эрхийг эрх зүйн чадамжгүй гэх өргөн хүрээтэй ойлголтод хамаатуулан хязгаарлаж байгаа нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн зарчим, үзэл санаанд нийцэхгүй байна. АН болон МАН-аас нэр дэвшигчид хөтөлбөртөө хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, амьдралын чанарын талаар тусгажээ. СЕХ нь Иргэний нийгмийн байгууллагууд (ИНБ)-тай хамтран харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулан сонгогчдын боловсролд чиглэсэн сонгуулийн материалуудыг гаргаж, мөн сонгогчдод зориулсан видео бичлэгтээ дохионы хэлийг нэмж оруулсан. Олон нийтийн радио телевиз сонгуулийн сурталчилгааны мэдээг дохионы хэлээр хүргэж байснаас гадна зарим нэр дэвшигчид сурталчилгааны мэдээлэлдээ дохионы хэл ашиглажээ.[285]

[283] Олон улсын сонгуулийг ажиглах хороо Монгол Улс – Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26 https://www.osce.org/mn/odihr/327166?download=true сүүлд үзсэн 2019.1.10.

[284] Мөн тэнд. /2009 оноос хойш Монгол Улс нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид (ХБХЭтК) нэгдэн орсон. Үндсэн хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг үл ялгаварлан гадуурхахыг зөвхөн ерөнхий зарчмаар хангаж, харин баталгаатай арга хэмжээгээр зааварчлаагүй байдаг. 2016 оны Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар болон бусад холбогдох хуулийн заалтуудаар улс төрийн оролцоонд хамаарах зохих хамгаалалт, нөхцөлөөр ханган өгсөн./

[285] Мөн тэнд.

СтХ-иар хөгжлийн бэрхшээлтэй сонгогч нь өөрийн сонгосон хүнээр туслуулан саналын хуудсыг тэмдэглүүлж болно. Түүнчлэн санал авах байруудыг харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгаж, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг заасан байдаг. Олон улсын ажиглагчдын хорооны очиж ажигласан санал авах байруудад энэ заалтуудыг дагаж мөрдсөн байсан. Хэдийгээр СтХ-иар санал авах байрууд нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх ёстой гэж заасан боловч ихэнх нь хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүс орох боломжгүй байшин барилга дотор байрлаж байв.[286] Иймд, бүх нийтийн сонгууль, санал асуулга зохион байгуулах нь аливаа улсын хувьд их хэмжээний төсөв хөрөнгө шаардсан, сайн зохион байгуулж хэрэгжүүлбэл зохих үндэсний хэмжээний том арга зам. Санал өгөх байр хэдийг хаана бэлтгэх, хэдэн хүн ажиллуулах, ямар материал шаардлагатай зэргийг нарийвчлан тооцож гаргах нь зардлаа бууруулах боломж олгоно. Мөн ажилтнуудын ажил үүргийн хуваарийг нарийвчлан тогтоож, нарийн зохион байгуулж чадвал үйл ажиллагааны чанарт нөлөө үзүүлэхгүйгээр сонгуулийн ажлыг зохистой болгож болох юм.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах байгууллагуудын тооцоолсноор хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдын 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж саналаа өгөхийн оронд зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөхийг илүүд үздэг ажээ. Хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зөөврийн хайрцгаар саналаа өгөх боломжийг олгож буй нь иргэний болон сонгуулийн эрхийг нь хангаж байгаа ч, зарим тохиолдолд үүнийгээ санал авах байрыг тэдэнд орох боломжтой болгож чадаагүй шалтгаанаа тайлбарлахад ашиглаж байсан нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг сонгуулийн үйл явцад бусад иргэдтэй адил оролцох нөхцөлийг бүрдүүлсэнгүй.[287] Үүнээс үзэхэд төслийн дээрх заалтуудыг практикт хэрэгжүүлэх субъект нь тодорхойгүйгээс хэрэгжих боломж нь хязгаарлагдмал байсан гэж үзэж байна.

4. Хуулийн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж байгаа эсэх.

Монгол Улс нь Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах тухай НҮБ-ын конвенцид 2009 оноос нэгдэн орсон. Үндсэн хуулиндаа “ялгаварлан гадуурхаж үл болно” гэсэн ерөнхий зарчмыг тусгасан хэдий ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухайд тусгайлан заалт байдаггүй. 2016 оны 2-р сард батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулиар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг ханган, улс төрийн байгууллагуудад сонгуулийн сурталчилгаагаа хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй болгох, мөн тэдний нэр дэвших эрхийг дэмжих зэрэг үүргийг оруулан заажээ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай[288] хуулийн 30.1-т Бүх шатны сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй хүн саналаа бие даан, чөлөөтэй, нууцаар өгөх нөхцөлийг бүрдүүлсэн байна гэж, төслийн 14.18-д “Сонгуулийн хороог аюулгүй байдал хангасан ажиллах байр, тээвэр, холбооны болон бусад шаардлагатай хэрэгслээр хангах асуудлыг тухайн шатны засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга хариуцна” гэж, 68.2-т “Тухайн хэсгийн харъяалагдах сум, дүүргийн Засаг дарга Сонгуулийн ерөнхий хорооноос баталсан зааврын дагуу санал авахад шаардлагатай дараах зүйлийг санал авах өдрөөс таваас доошгүй

[286] Мөн тэнд. /Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн байгууллагаас барагцаалж байгаагаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 90 хүртэлх хувь нь санал авах байранд очиж санал өгснөөс зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар саналаа өгөхийг хүсжээ. ХБХЭтК-ийн 29-р зүйлд улс орнуудад “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төрийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд ялгаварлан гадуурхалгүйгээр бусадтай адил тэгш нөхцөлд үр ашигтай, бүрэн оролцох орчин нөхцөлийг идэвхтэйгээр сурталчилж, нийтийн үйл хэрэгт тэдний оролцоог урамшуулах”- ыг зөвлөсөн байдаг./

[287] Монгол Улс Хуудас: 25 Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26 болон 7-р сарын 7-ны өдрүүд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Тайлан. https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/366136?download=true сүүлд үзсэн 2019.1.10.

[288] Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2016 он, №9

хоногийн өмнө бэлэн болгох үүрэгтэй. 1/ санал авах байр, 2/ сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг, 3/ зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал өгөх сонгогч саналаа нууцаар өгөхөд шаардагдах бүхээг, 4/ суурин болон зөөврийн битүүмжилсэн саналын хайрцаг, 5/ сонгогчийн бүртгэлийн мэдээллийг ажиглагчид үзүүлэх дэлгэц, 6/ хууль тогтоомжид заасан бусад зүйл" гэж заасан нь тэргэнцэртэй сонгогчийг орох боломжийг ямар субъект хариуцан хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг орхигдуулсан байна.

Хэдийгээр СтХ-аар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн улс төрд оролцох эрхийг хүлээн зөвшөөрч, улс төрийн намуудад сурталчилгааны материалаа хүртээмжтэй болгох, мөн хөгжлийн бэрхшээлтэй нэр дэвшигчдэд дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал өгөх эрхээ эдлэх боломжийг хөнгөвчлөн, санал авах байр нь тэргэнцэртэй сонгогчдод орох нөхцөл боломжоор хангагдсан байх, харааны бэрхшээлтэй сонгогч уншиж болохуйц санал өгөх зааварчилгаа байлгах, санал өгөхөд тохиромжтой бүхээг зэргээр тоноглогдсон байхыг зааж өгсөн хэдий ч ЕАБХАБ/АИХЭГ-ын САХ-ны ажиглалт хийсэн санал авах байруудын 35 хувь нь л хөгжлийн бэрхшээлтэй сонгогчдод орох боломжоор хангагдсан[289] байна.

Иймд, СЕХ, Засаг даргын Тамгын газарт санал авах байрыг бэлтгэх тухай даалгасан зохицуулалтыг нарийвчлан хөгжлийн бэрхшээлтэй иргэд санал өгөх боломжтой байдлаар бэлтгэх зохицуулалтыг нэмж тусгах, хуулийн төслийн 68.4, 68.5-т заасан сонгогчийн эрхийг хангах төсөв болон үйл ажиллагааг зохион байгуулах субъектийг тодорхой болгох нь зүйтэй юм.

3.3. Ойлгомжтой байдал

Хуулийн төслийн зохицуулалт нь хэрэгжүүлэх, хэрэглэх этгээдэд ойлгомжтой байдлаар томьёологдсон эсэхийг шалгаж тогтоосон болно.

Хүснэгт 4. *Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ*

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	"нэн даруй" гэсэн нэр томьёо бичигдсэн төслийн зохицуулалтууд /6.10, 18.2.3, 19.11,19.14, 45.17, 68.8, 75.4.1, 77.1.2, 77.5.2, 77.16, 77.17,79.1, 80.4/	Хуулийн төсөлд "нэн даруй" хэрэгжүүлэхээр заасан 16 заалт байх бөгөөд тэдгээрийг хэрхэн ойлгох нь тодорхойгүй байна. Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоолуудыг үзвэл хууль, түүний зохицуулалтаас хамаарч "нэн даруй" гэдгийг ойлгох хугацаа өөр байна. Тухайлбал, Иргэний хуульд заасан "нэн даруй" гэдгийг тухайн тохиолдолд мэдэгдэх боломжтой ердийн хугацаанд[25] ойлгохоор байгаа бол Прокурорын /хуучин/ тухай хуульд заасан "нэн даруй" гэдгийг 24 цагийн дотор[26] гэж ойлгохоор байна.	Явуулах үйл ажиллагааны төрлөөс хамаарч "нэн даруй" гэдэг нь өөр өөр байх тул хугацааг нарийвчлан зохицуулах

[289] ЕАБХАБ-ын АИХЭГ-ын Сонгууль Ажиглах Хязгаарлагдмал Хороо Хуудас 13, Монгол Улс, Ерөнхийлөгч сонгууль, 2017 оны 6-р сарын 26-ны өдөр, Урьдчилсан тайлан (2017 оны 5-р сарын 23-ны өдөр)

290 Улсын Дээд Шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.06.22.) "Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай", https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178 (сүүлд үзсэн: 2018.12.26.)

2.	“итгэмжлэгдсэн ажилтан”- тай холбогдох зохицуулалтууд	Төслийн 20.10-т “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжилсэн ажилтан /цаашид “итгэмжлэгдсэн ажилтан” гэх/ нь сонгогчдын нэрийн жагсаалтыг хүргүүлсэн өдрөөс эхлэн сонгогчдын нэрийн жагсаалтыг хариуцан хэсгийн хорооны дэргэд ажиллана” хэмээн Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын итгэмжлэгдсэн ажилтныг төслийн бусад хэсэгт “итгэмжлэгдсэн ажилтан” гэх томьёоллоор оруулахаар хуульчилсан ч цаашид энэхүү товчилсон хувилбараар ороогүй, бүтнээрээ орсон, “улсын бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан”, “иргэний бүртгэлийн байгууллагын итгэмжлэгдсэн ажилтан”, “иргэний бүртгэлийн итгэмжлэгдсэн ажилтан” гэх зэргээр ялгаатай томьёолсон нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.	Тус асуудлыг нэг мөр болгож хоёрдмол утгагүй томьёолох
3.	6 дугаар зүйлийн 6.3-т Сонгогч сонгуульд шууд сонгох эрхийнхээ үндсэн дээр ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож, саналаа өөрөө өгнө.	Ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож саналаа өгөх тухай заасан нь хөгжлийн бэрхшээлтэй буюу бичих, хөдөлгөөний бэрхшээлтэй этгээд саналаа хэрхэн өгөх нь ойлгомжгүй байна.	Ойлголтыг нэг мөр болгох
4.	6 дугаар зүйлийн 6.4-т Сонгогч сонгуульд оролцох эсэхээ бие даан шийдвэрлэх, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд хэн боловч албадан нөлөөлж, саад учруулахыг хориглоно.	Хориглосон заалтыг сонгуулийн үйл ажиллагааны зарчимд оруулсан нь ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Ойлголтыг нэг мөр болгох
5.	6 дугаар зүйлийн 6.8-д Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хугацаа тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална.	“Иргэний хуульд заасан зарчмыг баримтална” гэсэн байгаагаас үзвэл Иргэний хуульд хугацаа нь зарчим байх тухай заагаагүй байна.	Ойлголтыг нэг мөр болгох
6.	6 дугаар зүйлийн 6.9-д Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчим нь сонгогч саналаа нууцаар гаргахад хамаарахгүй.	Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчимд сонгогч саналаа нууцаар гаргах эрхийг хамааруулсан байна.Энэ нь сонгох, сонгогдох эрх тусдаа байх бөгөөд сонгууль зохион байгуулах, сонгуулийн төв хорооны ил тод байдалтай хамаагүй юм.	Сонгууль зохион байгуулах ил тод байдлыг хангах гэж ойлголтыг нэг мөр болгох.

Хуулийн үйлчлэлийн хүрээлэн www.nli.gov.mn

7.	6 дугаар зүйлийн 6.12-т Төрийн хэргийг удирдахад иргэдийг оролцуулах зорилт бүхий дүрэмтэй, улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллага нь сонгуулийн байгууллага, сонгуульд оролцогч бусад байгууллага, албан тушаалтан сонгуулийн хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгаад хяналт шинжилгээ /мониторинг/, ажиглалт хийх, сонгогчдод сонгуулийн мэдлэг олгох, эрхээ эдлэхэд нь аргачилсан туслалцаа үзүүлэх зэргээр сонгуулийг хуулийн дагуу, шударгаар явуулахад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах эрхтэй.	Улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй төрийн бус байгууллагын эрхийг үйл ажиллагааны зарчимд хуульчлан тусгасан нь ойлгомжгүй байдлыг үүсгэж байна.	Ойлголтыг нэг мөр болгох
8.	9 дүгээр зүйлийн 9.16-д Энэ хуулийн 9.7, 9.8, 9.9, 9.10, 9.12-д заасныг зөрчсөн төрийн албан хаагчийг төрийн албанаас хална.	9.10, 9.12 дахь заалтад иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид нөхөн сонгууль буюу ээлжит бус сонгуулийг товлон зарлах тухай заасан байтал төрийн албан хаагчийг төрийн албанаас халах тухай заалтад хамааруулжээ. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид нь төрийн албан хаагч биш тул ойлголтыг нэг мөр болгох.	Ойлголтыг нэг мөр болгох

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХЭРЭГЛЭЭНД
www.legal.gov.mn

9.	Төслийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг 17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг	Төслийн дээрх заалтууд нь практикт хэрэгжихэд ойлгомжгүй байдлыг бий болгох боломжтой байна. Тухайлбал, төслийн 16.1-д “ Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 70-аас доошгүй хоногийн өмнө аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн дарга, таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, нийтэд мэдээлнэ” гэсэн заалтаас үзвэл аймаг, нийслэлийн сонгуулийн хороог дарга, нарийн бичгийн даргаас гадна таваас долоон гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болохоор заасан учир сонгуулийн хороог зургаан гишүүнтэйгээр байгуулж болохоор харагдаж байна. 2005 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д “Тойргийн хороо нь суманд, шаардлагатай бол нийслэлийн дүүрэгт салбар хороог санал авах өдрөөс 30-аас доошгүй хоногийн өмнө дарга, нарийн бичгийн дарга, 5, эсхүл 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, тойргийн хэмжээнд нийтэд мэдээлнэ” гэж, 2011 оны Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Сонгуулийн ерөнхий хороо санал авах өдрөөс 55-аас доошгүй хоногийн өмнө тойргийн хороог дарга, нарийн бичгийн дарга, сондгой тооны 7-13 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, улсын хэмжээнд нийтэд мэдээлнэ” гэж тус тус заасан байдаг.	Практикт сонгуулийн хороог байгуулахдаа тав эсхүл долоо гишүүнтэйгээр буюу сондгой тооны гишүүнтэйгээр байгуулдаг байх тул төслийн дээрх зохицуулалтыг маргаан дагуулахгүй байлгах үүднээс “таваас долоон гишүүнтэй” гэснийг “тав эсхүл долоо” гэж, “гурваас таван гишүүнтэй” гэснийг “гурав эсхүл тав” гэж, “зургаагаас найман гишүүнтэй” гэснийг “зургаа эсхүл найм” гэж өөрчлөн найруулах.
10.	20 дугаар зүйлийн 20.10-т Сонгуулийн хорооны дарга, нарийн бичгийн дарга, гишүүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас сонгуулийн хорооны үйл ажиллагаа болон хуралдаанд оролцох боломжгүй болсон бол энэ тухайгаа бичгээр болон бусад хэлбэрээр урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.	Урьдчилан мэдэгдэх хугацаа тодорхойгүй байна.	Урьдчилан мэдэгдэх хугацааг тодорхой болгох.

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

11.	20 дугаар зүйлийн 20.1-т Сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн мэдээллийн улсын сан дахь сонгогчийн бүртгэлд үндэслэн үйлдэх бөгөөд түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, сонгогчдийн нэрсийн жагсаалт болон сонгогч шилжих, түүнтэй холбоотой гомдол шийдвэрлэх зэрэг ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага улсын хэмжээнд зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.	Бүлэг болоод зүйлийн гарчигт “Сонгогчдын нэрийн жагсаалт” гэж бичигдсэн атал зүйлийн доторх хэсэгт “сонгогчдын нэрийн жагсаалт”, “сонгогчдын нэрсийн жагсаалт” гэсэн хоёр янзаар бичигдсэн байна.	Тус нэр томьёог нэг мөр болгох.
12.	21 дүгээр зүйлийн 21.1-т Сонгогч өөрийн болон өөрийн гэр бүлийн аль нэг гишүүний нэр сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй буюу буруу бүртгэгдсэн, сонгогчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой асуудлаарх гомдлоо улсын бүртгэлийн холбогдох байгууллагад санал авах өдрөөс арван дөрвөөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргана.	Аливаа шалтгааны улмаас санал авах өдрөөс 14 хоногийн өмнө гомдол гаргаж чадаагүй сонгогчийн тухайд сонгох эрх нь зөрчигдөх юм.	Нэрийн жагсаалтад гомдол гаргахад хугацааг заах шаардлагагүй гэж үзэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

13.	45 дугаар зүйлийн 45.14-д Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн *40.9-т хяналт тавьж ажиллах* бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно. 40.15.Шударга өрсөлдөөний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь энэ хуулийн *31.1, 39, 40.1.8, 40.6-д хяналт тавьж* ажиллана.	Хууль тогтоомжийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт "Хуулийн давхардал, зөрчил гарахаас сэргийлэх, ойлгож хэрэглэхэд хялбар болгох зорилгоор ... тухайн хуульд нэгэнт туссан асуудлыг дахин дурдах бол эшлэл хэрэглэнэ" гэж заасан. Харин төслийн холбогдох заалтуудаас үзвэл, Харилцаа холбооны зохицуулах хороо нь хуулийн зохицуулалтад хяналт тавихаар ойлгогдож байна.	"...40.9 дэх хэсэгт заасан үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах" гэж буюу "... 31.1, 39, 40.1.8, 40.6 дахь хэсгийн заалтуудын хэрэгжилтэд тус тус хяналт тавьж ажиллах" гэж өөрчлөх.
14.	Төслийн 45 дугаар зүйлийн 45.3 дахь хэсэг.	Төслийн 45 дугаар зүйлд "Хууль бус сурталчилгааг хориглох" тухай зохицуулсан байх бөгөөд хориглох тухай зохицуулалтуудыг тусгасан хэрнээ төслийн 45.3-т "Төрийн улс төрийн албан хаагч сонгуулийн сурталчилгаанд оролцож болно" гэж заасан нь хориглосон заалтуудын дунд "болно" гэсэн зохицуулалтыг тусгасан төслийн бусад заалтуудын уялдаа холбоо, утга найруулгыг алдагдагдуулж ойлгомжгүй байдлыг бий болгож байна.	Ойлголтыг нэг мөр болгох
15.	74 дүгээр зүйлийн 74.2-т Ажиглагч дараах эрх эдэлнэ: 74.2.2.санал авах, үйл ажиллагааг ажиглах	Төсөл дэх ажиглагчийн эдлэх эрхийг заасан зохицуулалт болох 74 дүгээр зүйлийн 74.2 дахь хэсгийн 74.2.2-т "санал авах, үйл ажиллагааг ажиглах" хэмээн хооронд таслал тавьснаар ажиглагч нь үйл ажиллагааг ажиглахаас гадна санал авах эрхтэй гэж ойлгогдохоор байна.	Хоёрдмол ойлголтыг залруулах үүднээс холбоо үгийн дундах таслалыг арилгах
16.	Төслийн 72 дугаар зүйлийн 72.17 дахь хэсэг	Төслийн 72.17-д "...14 хоногийн хугацаагаар баривчлах захиргааны шийтгэл ногдуулна" гэж заасан байх бөгөөд Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлийн 1.1-д "баривчлах шийтгэл" гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, төсөлд захиргааны шийтгэл гэж заасан нь захиргаанаас баривчлах шийтгэл оногдуулах мэтээр ойлгогдож байна.	Иймд төслийн 73.17-д "баривчлах захиргааны шийтгэл" гэж заасныг "баривчлах шийтгэл" гэж өөрчлөн найруулах;

Түүнчлэн энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн[290] 28, 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

Хүснэгт 5. *Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх.*

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал

[290] Төрийн мэдээлэл эмхэтгэл 2015 он, №25

28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.хуулийн төслийн гарчиг; 28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.зүйлийн доторх хэсэг; 28.1.4.хэсгийн доторх заалт; 28.1.5.заалтын доторх дэд заалт; 28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.	41.5.Энэ хуулийн 41.3 дахь заалтад шүүх, прокурор, тагнуул, цагдаа, онцгой байдлын болон эмнэлгийн байгууллага хамаарахгүй гэж заасны “41.3 дахь заалтад” гэснийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.13 заасны дагуу “41.3 дахь хэсэгт” гэж өөрчлөх.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29 дүгээр зүйлийн 29.1.1-т Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
29 дүгээр зүйлийн 29.1.2-т Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй
29 дүгээр зүйлийн 29.1.3-т Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29 дүгээр зүйлийн 29.1.4-т Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХҮРЭЭЛЭН
www.mjs.gov.mn

29 дүгээр зүйлийн 29.1.5-д Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	- Төслийн 20.6-д “... улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ээлжит сонгуулийн жилийн наймдугаар сарын 15-ны өдрөөс өмнө хүргүүлнэ” гэж заасан бөгөөд 20.6.6-д “цагдаагийн байгууллага санал авах өдөр зөрчлийн улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн улмаас цагдан хоригдсон сонгогчдын мэдээллийг” гэж тус тус заасан нь хоорондоо зөрчилдсөн байна. Учир нь төслийн 20.6.6-д заасан заалт нь цагдаагийн байгууллагын хувьд сонгуулийн санал авах өдөр /Төслийн 9.2-т заасны дагуу “Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн аравдугаар сарын эхний хагасын аль нэг ажлын өдөр байна”/ - Төслийн 20.8-д “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 20.6.4, 20.6.5, ***20.6.6-д*** заасны дагуу ирүүлсэн иргэдийн мэдээллийг үндэслэн тухайн цэргийн анги, нэгтгэл хамаарч байгаа сонгуулийн хэсэгт саналаа өгөх сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн сонгогчийг нэмж бүртгэн байнга оршин суугаа газрынх нь хаягийн дагуу бүртгэгдсэн сонгогчдын нэрийн жагсаалтаас хасах” тухай тусгасан байна. - Төслийн 21.3-т “Энэ хуулийн 21.2-т зааснаас бусад үндэслэлээр сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг хориглоно” гэж, 21.5-т “Санал авах өдрийг хүртэлх долоо хоногийн хугацаанд энэ хуулийн 21.2-т заасан ажиллагааг хийхийг хориглоно” гэж тус тус заасантай заалттай 20.8-д заасан зохицуулалт нь нийцэхгүй байна. - Төслийн 69.1-т “Дараах сонгогчийн саналыг түүний хүсэлт, эмнэлгийн магадлагаа эсхүл холбогдох байгууллагын тодорхойлолтыг үндэслэн зөөврийн битүүмжилсэн саналын хайрцгаар санал авах өдрийн өмнөх өдөр 09:00-20:00 цагийн хооронд авна: 69.1.3-т “Зөрчлийн улмаас баривчлагдсан, эсхүл саатуулагдсан; 69.1.4-т “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу баривчлагдсан, цагдан хоригдсон” гэж заасан нь 20.6.6-т заасан этгээдээс санал авах боломжтой мэтээр ойлгогдож байна. Гэтэл 20.6.6-т заасан заалт нь санал авах өдөр зөрчлийн улмаас баривчлагдсан, саатуулагдсан, гэмт хэргийн улмаас цагдан хоригдсон сонгогчдын мэдээллийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх тухай зохицуулалт байгаа нь хоорондоо зөрчилдсөн байна. - Төслийн 6 дугаар зүйлийн 6.7-т сонгуулийн хугацааг санал авах өдөртэй уялдуулан жил, сар, хоног, цаг, минутаар тоолохоор зохицуулсан байтал төслийн 6.8-т “Энэ хууль өөрөөр заагаагүй бол хугацаа тоолоход Иргэний хуульд заасан зарчмыг баримтална” гэж заасан нь 6.7-д заасан хугацаа тоолох зохицуулалтыг тусгагдаагүй мэтээр ойлгоход хүргэж байгаа төдийгүй 6.7-т заалтыг үгүйсгэсэн хуулийн зөрчлийг бий болгож байна.
29 дүгээр зүйлийн 29.1.6-д Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ САЙТ www.mgov.mn

29 дүгээр зүйлийн 29.1.7-д Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Төслийн 35.5. Монгол Улсын Үндсэн хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна. Төслийн 58.1-т Нам нь Улс төрийн намын тухай хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна. Төслийн 59.2-т Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна. Төслийн 69.1.2-т Дайчилгааны тухай хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна. Төслийн 86.2-т Эрүүгийн хуулийг эшлэсэн байх боловч аль заалтаас эшлэл хийж байгаа нь тодорхойгүй байна.
29 дүгээр зүйлийн 29.1.8-д Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29 дүгээр зүйлийн 29.1.10-т Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулаагүй байна.
29 дүгээр зүйлийн 29.1.11-т Хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.	
30 дугаар зүйлийн 30.1.1-т Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30 дугаар зүйлийн 30.1.2-т Нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

хуулийн үйлчлэгчийн хүрээлэн www.mli.gov.mn

30 дугаар зүйлийн 30.1.3-т Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	- Төслийн 4.4, 19.1, 27.3-т "...**олонхийн**..." гэж заасны "олонхийн" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт **"олонхын"** гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 6.7-д "Сонгуулийн хугацааг хугацааг санал авах өдөртэй уялдуулан жил, сар, хоног, цаг, минутаар тоолно" гэж заасны хугацааг гэж давхардаж бичигдсэн тул хасах. - Төслийн 6.10-т Сонгууль зохион байгуулах, түүний бэлтгэл ажилтай холбогдуулан нийтээр дагаж **мөрдөхөөр гаргасан шийдвэрийг гаргасан этгээд** нь нэн даруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсаар нийтэд албан ёсоор мэдээлнэ гэж заасны мөрдөх "өөр гаргасан" гэж давхардаж бичигдсэн тул хасах. - Төслийн 9.6-т Энэ хуульд заасны дагуу сонгуулийг хойшлуулсан эсхүл зогсоосон бол тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсаны дараа Улсын Их Хурал ажлын арван өдөрт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана гэж заасны "гарсаны" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "гарсны" гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 9.11-т "Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургаадугаар сарын ..." гэж заасны **"зургаадугаар"** гэдгийг МУҮХ-д "зургадугаар" гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 9.11-т Нөхөн сонгуулийн санал авах өдөр нь жил бүрийн зургаадугаар сарын гуравдах долоо хоногийн ням гарагт улс даяар нэгдсэн журмаар явагдана гэж заасны "гуравдах" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "гуравдахь" гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 10.2.1-т, 10.7-д "...програм..." гэж заасны "програм" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "программ" гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 12.2-т "...аймгийн төвийн баг болон аймгийн сум тус бүр нь..." гэж зааснаас "... аймгийн ..." гэдгийг хасах. - Төслийн 87.1, 16.2.15-т "харъяалах" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "харьяалах" гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 16.2.3-т, 17.3.3-т "...эцэг эхийн..." гэж заасны эцэг эхийн гэдгийг эцэг, /эх/-ийн гэж нэг мөр болгон өөрчлөх. - Төслийн 20.21-т, 20.22-т, 20.23-т, 21.6-д, 21.7-д, 21.8-д, 74.2.10-д "...Сонгогчдийн..." гэж заасны "Сонгогчдийн" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "Сонгогчдын" гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 23.1.3-т, 23.7-д "...бүрт..." гэж заасны "бүрт" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "бүрд" гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 26.3.3-т "эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй байх" гэдгийг "хүлээлгээгүй" гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "хүлээгээгүй" гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 32.1-д "сурталчилах" гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "сурталчлах" гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 40.1-т Сонгуулийн сурталчилгаа явуулах эрх бүхий этгээд нь намын далбаа, уриа, таних тэмдэгийг сурталчилгааны явцад ашиглах эрхтэй гэж заасны "тэмдэгийг" гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт "тэмдгийг" гэж бичсэнээр өөрчлөх.

ХУУЛЬ ЗҮЙН ТӨСЛИЙН ХУРААНГУЙ
www.pl.gov.mn

	- Төслийн 42.3-т “Ухуулгын байрыг доор дурдсан зорилгоор ажиллуулна” гэснийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “доор” гэдгийг “дор” гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 43.22-т Энэ хуулийн 43.2, 43.5-43.8, 43.12-43.16-д заасныг зөрчсөн хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван нэгээс арван зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, 43.11-д заасныг зөрчсөн телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо цуцлана гэж заасны “цуцлана” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “цуцална” гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 45.14-т Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 45.9-т хяналт тавиж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно гэж заасны “тавиж” гэдгийг Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь бичигт “тавьж” гэж бичсэнээр өөрчлөх. - Төслийн 3.1.7-д “Монгол Улсын Үндсэн хуулийн хорин нэгдүгээр зүйлийн” гэсний “хорин” гэдгийг “Хорин” гэж бичих. Төслийн 9.13-т, 20.22-т “...сонгуулийн ерөнхий хороо” гэж заасан байна. “Сонгуулийн ерөнхий хороо” гэдэг нь оноосон нэр учир том үсгээр эхэлж бичнэ. “Сонгуулийн ерөнхий хороо” болгож засах. - Төслийн 3.1.3, 9.10, 38.4-т “...сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн...”, “сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид” гэж өөр өөр бичсэн байгааг *“Иргэдийн”* гэдгийг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “иргэдийн Төлөөлөгчдийн Хурал” гэж заасан байх тул *“иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгч”* гэж хуулийн төсөлд жижиг, том үсгээр ижил бичих. - Монгол хэлний зөв бичих дүрмийн дагуу дараах тийн ялгалын нөхцөлийн зөв болгож өөрчлөх. Үүнд: Төслийн 43.4-т заасан “...23.13-д...” гэснийг “...23.13-т...” гэж; Төслийн 6.13-т заасан “..6.12-д...” гэснийг “...6.12-т...” гэж; Төслийн 6.14-т заасан “...6.4-д...” гэснийг “...6.4-т...” гэж; Төслийн 9.15-т заасан “...9.12-д...” гэснийг “...9.12-т...” гэж; Төслийн 9.16-д заасан “...9.12-д...” гэснийг “...9.12-т...” гэж; Төслийн 13.6-д заасан “...13.1-д...” гэснийг “...13.1-т...” гэж; Төслийн 14.7-д заасан “...16.1-д...” гэснийг “...16.1-т...” гэж; Төслийн 14.20-д заасан “...14.13.-д...” гэснийг “...14.13-т...” гэж; Төслийн 17.4-т заасан “...17.3.13-д...” гэснийг “...17.3.13-т...” гэж; Төслийн 14.20-д заасан “...14.13-д...” гэснийг “...14.13-т...” гэж; Төслийн 14.23-т заасан “...14.16-д...” гэснийг “...14.16-т...” гэж; Төслийн 16.3-т заасан “...16.2.12-д...” гэснийг “...16.2.12-т...” гэж; Төслийн 17.4-т заасан “...17.3.13-д, 17.3.10-д...” гэснийг “...17.13.13-т, 17.3.10-т...” гэж; Төслийн 21.2-т заасан “...21.1-д...” гэснийг “...21.1-т...” гэж; Төслийн 25.4-т заасан “...25.4-д...” гэснийг “...24.4-т...” гэж; Төслийн 28.5-д заасан “...28.3-д...” гэснийг “...28.13-т...” гэж;

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.pro.law.mn

	Төслийн 30.1.7-д заасан “...45.1-д...” гэснийг “...45.1-т...” гэж; Төслийн 31.2-т заасан “...31.1-д...” гэснийг “...31.1-т...” гэж; Төслийн 36.16-д заасан “...36.4-д...” гэснийг “...36.4-т...” гэж; Төслийн 36.7-д заасан “...36.4-д...” гэснийг “...36.4-т...” гэж; Төслийн 43.11-т заасан “...43.10-д...” гэснийг “...43.10-т...” гэж; Төслийн 44.5-т заасан “...44.4-д...” гэснийг “...44.4-т...” гэж; Төслийн 45.13-т заасан “...45.1-д...” гэснийг “...45.1-т...” гэж; Төслийн 45.14-т заасан “...45.-т...” гэснийг “...45.9-д...” гэж; Төслийн 48.3-т заасан “...48.1-д...” гэснийг “...48.1-т...” гэж; Төслийн 52.9-д заасан “...52.1-д...” гэснийг “...52.1-т...” гэж; Төслийн 57.4-т заасан “...57.1-д...” гэснийг “...57.1-т...” гэж; Төслийн 63.4-т заасан “...63.1-д, 63.3-д...” гэснийг “...63.1-т,63.3-т...” гэж; Төслийн 69.17-т заасан “...69.4-д...” гэснийг “...69.4-т...” гэж; Төслийн 71.3-т заасан “...71.1-д...” гэснийг “...71.1-т...” гэж; Төслийн 71.13-т заасан “...71.11-д...” гэснийг “...71.11-т...” гэж; Төслийн 77.5-т заасан “...77.1.1-д...” гэснийг “...77.1.1-т...” гэж; Төслийн 78.6.-т заасан “...78.2-д...” гэснийг “...78.2-т...” гэж; Төслийн 81.2-т заасан “...57.3-д...” гэснийг “...57.3-т...” гэж; Төслийн 81.3-т заасан “...57.3-д...” гэснийг “..57.3-т...” гэж тус тус өөрчлөх. - Төслийн 35.9-д “50-аас доошгүй” гэснийг “50-иас доошгүй” гэж өөрчлөн бичих. - Төслийн 10.3.1-д “... санал авах үеийн хамгаалалт, хамгаалалт, шатахуун, техник хэрэгслийн зардал” гэж заасан зохицуулалтад давхардан бичигдсэн “хамгаалалт” гэдэг үгийг хасах. - Төслийн 5 дугаар зүйлийн “...сонгох сонгогдох...” гэдгийн дунд таслал авах, - Төслийн 72.2.2-т “тухайн санал авах байранд саналаа өгөх эрхгүй гэдгээ мэдсээр байж санал өгөх, эсхүл өөр хүний баримт бичиг, эсхүл хуурамч баримт бичиг ашиглах зэргээр санал өгөх, санал өгөхийг оролдох” гэж заасан зохицуулалтад давхардан бичигдсэн “эсхүл” гэдэг үгийг хасах.
30 дугаар зүйлийн 30.1.4-т Хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30 дугаар зүйлийн 30.1.5-д Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.5. Харилцан уялдаа

Төслийн харилцан уялдаа холбоог шалгах шалгуур үзүүлэлтийн хүрээнд давхардал, хийдэл, зөрчлийг судлан, дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулах юм. Түүнчлэн хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалд заасан дараах асуудлыг тодорхойлох байдлаар төслийн харилцан уялдаатай байдлыг үнэллээ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭЛ www.mlsu.mn

***Хүснэгт 6**. Харилцан уялдаатай эсэхийг үнэлсэн байдал.*

Аргачлалд заасан асуулт	Хуулийн төслийг үнэлсэн байдал
Хуулийн төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Хуулийн төслийн зорилтод сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан байх тул хуулийн төслийн 5 дугаар зүйл, 8 дугаар зүйл нийцэхгүй байна.
Хуулийн төслийн нэр тухайн харилцаанд хамаарах хууль мөн эсэх,	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томьёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томьёотой нийцэж байгаа эсэх	- Төслийн 36 дугаар зүйлийн 36.7 дахь хэсэгт “Энэ хуулийн 36.1, 36.4-д заасныг зөрчсөн нь радио, телевизийн байгууллагын үйл ажиллагааг Харилцаа холбооны зохицуулах хороо зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно”; 40 дүгээр зүйлийн 45.1.4-т “Харилцаа холбооны зохицуулах хороо нь энэ хуулийн 45.9-т хяналт тавиж ажиллах бөгөөд зөрчсөн тохиолдолд радио, телевизийн үйл ажиллагааг зөрчил гарсан өдрөөс эхлэн гурван сар хүртэл хугацаагаар зогсооно” гэж тус тус заасан. Гэтэл Харилцаа холбооны тухай хууль[27] /цаашид “ХХтХ” гэх/-д “зогсоох” гэсэн үгийг гагцхүү хэрэглэгч, үйлчлэгчид хамааруулан ойлгохоор хуульчилсан. Харин Харилцаа холбооны зохицуулах хороонд “түдгэлзүүлэх”, “хүчингүй болгох” гэсэн үгийг хамааруулан ойлгодог. Иймд төсөлд заасан “зогсооно” гэснийг “түдгэлзүүлнэ” гэж өөрчлөн найруулах; - Төслийн 43 дугаар зүйлийн 43.21, 43.22-т телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо цуцлахаар заасан. Гэтэл ХХтХ болон Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд /цаашид “ААҮАТЗтХ” гэх/-д тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох түтгэлзүүлэх тухай зааснаас цуцлах тухай заагаагүй байх тул ойлголтыг нэг мөр болгох зүйтэй юм. - Төслийн 10.1.14-д энэ хуулийн 47.2-т заасан мөнгөн урамшууллын зардал Хуулийн төслийн 47 дугаар зүйлийн 47.2-т “Сонгуулийн зардал нь дараах хөрөнгөөс бүрдэнэ: • 47.2.1.хандив; • 47.2.2.намын өөрийн хөрөнгө; • 47.2.3.нэр дэвшигчийн өөрийн хөрөнгө” гэж заасан нь мөнгөн урамшуулалд хандив орохгүй байх тул нэр томьёоны хувьд нийцэхгүй байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	- Хуулийн төслийн 55 дугаар зүйлийн 55.1-т Мөнгөн хандив нь ...хуулийн этгээдийн хувьд арван таван сая төгрөг хүртэл байна, 55.2-т хуулийн этгээд нь нам, эвсэлд эсхүл нэр дэвшигчид жилд нэг удаа хандив өгч болно” гэж заасан бол 55.7-т “Хуулийн этгээд бэлэн мөнгөөр хандив өгөх, хуулийн этгээдээс бэлэн мөнгөөр хандив авахыг хориглоно” гэсэн зүйлийн заалттай нийцэхгүй байна. - Хуулийн төслийн 44.2-т сонгуулийн сурталчилгааны цахим хуудсаас бусад цахим хуудсаар сурталчилгаа явуулж болох талаар тусгасан бол төслийн 45.4.18-д сонгуулийн сурталчилгааны цахим хуудаснаас бусад хэлбэрээр цахим орчинд сонгуулийн сурталчилгаа явуулахыг хориглосон байна. Иймд эдгээр заалт өөр хоорондоо нийцэхгүй байна. - Төсөлд нийт 58 зүйл, заалтад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хамаарч торгууль оногдуулахаар заасан байна. /5.7, 6.14, 9.15, 13.10, 14.19, 14.20, 14.21, 14.23, 16.3, 17.4, 19.23, 20.24, 21.9, 28.5, 33.8, 34.4, 36.5, 36.6, 37.5, 38.14, 39.10, 40.3, 41.6, 42.4, 44.5, 44.9, 45.12, 45.13, 47.6, 49.4, 50.13, 51.4, 52.9, 55.9, 55.10, 55.11, 56.5, 56.6, 62.6, 63.4, 64.4, 68.12, 69.16 69.17, 71.13, 71.14, 72.16, 73.13, 74.4, 75.6, 76.3, 77.18, 78.6, 79.4, 81.6, 82.4, 84.6, 85.4/

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.hi.gov.mn

	- Хуулийн үүрэгжүүлсэн, хориглосон зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг (санкци) хуулийн төслийн 11 дүгээр бүлэгт заасан хэдий ч дээрх зүйл заалт бүхэнд давхардуулан зохицуулжээ. 2017 оноос эхлэн дагаж мөрдөгдөх болсон Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиудад торгох ял, шийтгэлийг хуульчилж өгсөн байх бөгөөд ийнхүү хуульчлахдаа “нэгж” хэмээх ойлголтыг бий болгож, Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр (Засгийн газрын тогтоолоор) өөрчлөгдөж буй явдлыг зогсоох эрх зүйн үндэслэлийг бий болгосон юм. Иймд төслийн энэхүү зохицуулалтуудыг бусад хууль тогтоомжид хүлээлгэж буй хариуцлагын нэгэн адил, мөн хуулийн төслийн 11 дүгээр бүлэгт заасныг өөрчлөн сайжруулж зохих хариуцлагыг хүлээлгэх нь зүйтэй байна. - Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д “Энэ хуульд заасны дагуу сонгуулийг хойшлуулсан эсхүл зогсоосон бол тухайн нөхцөл арилсан тухай шийдвэр гарсны дараа Улсын Их Хурал ажлын арван өдөрт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана” гэсэн заалт нь Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн /цаашид МУИХтХ гэх/ 30 дугаар зүйлийн 30.5-т “...Энэ хуулийн 30.2-т заасан онцгой нөхцөл арилсны дараа Улсын Их Хурал ажлын 7 хоногт багтаан ээлжит сонгуулийг товлон зарлана” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд төслийн 9 дүгээр зүйлийн 9.6-д заасан энэхүү заалтыг МУИХтХ-тай нийцүүлж, өөрчлөн найруулах нь зүйтэй. - Төслийн 45.1.4-т “бусдыг гүтгэн доромжлох, хуурамч мэдээлэл тараах”-ыг хориглохоор заасан бөгөөд 45.13-т “Энэ хуулийн 45.1-д заасныг зөрчсөн иргэнийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг арван нэгээс арван зургаа дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгох”-оор заасан бөгөөд энэхүү заалтад заасан бусдыг гүтгэх доромжлох, хуурамч мэдээлэл тараах нь Зөрчлийн тухай хуулийн 6.21 дүгээр зүйлд “Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж заасан “Гүтгэх” зөрчлийн шинжийг мөн агуулж байна. Энэ тохиолдолд хэрэв төсөлд зааснаар хариуцлага оногдуулбал иргэнийг 320.000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 3.520.000-5.120.000 төгрөгөөс, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтныг 1.920.000-2.560.000 төгрөгөөр тус тус торгохоор байна. Харин Зөрчлийн тухай хуульд зааснаар дээр зөрчлийг үйлдсэн хүнийг 2.000.000 төгрөгөөр, хуулийн этгээдийн 20.000.000 төгрөгөөр торгохоор хуульчилсан байна. Иймд төслийн 45.1-д заасан бусад заалтуудаас мөн Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх боломжтой заалтуудыг хуулийн давхардал үүсгэхгүй байлгах үүднээс Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэхээр зохицуулах нь зүйтэй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХЭЛТЭН www.legal.mn

	- Төслийн 5.8, 6.15, 14.21, 19.24, 87.4-т заасан заалтууд нь 2019 оны 1 сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөгдөж буй Төрийн албаны тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1.4-т "...төрийн албанд гурван жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах" гэж заасантай нийцэхгүй байна. Учир нь төслийн дээрх заалтуудад "төрийн албанд нэг жил, ... хоёр жилийн хугацаанд эргэж орох эрхгүйгээр халах"-аар тусгасан. - Хуулийн төслийн 5 дугаар зүйлд Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийн тухай заасан байтал 5.2-т эрхийг хязгаарласан, 5.4, 5.5-т хориглосон зохицуулалт, 5.7, 5.8-т хуулийн санкцийг заасан зүйлийн нэртэй нийцэхгүй байна. - Хуулийн төслийн 19.14-т "...саад учруулахыг хориглоно. Хуралдааны хэвийн үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг хуралдаанаас нэн даруй гаргана." гэж тусдаа зохицуулж болох заалтыг нэг дор оруулсан байна.
Хуулийн төслийн зүйл, заалт нь тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	- Хуулийн төслийн 4.1 дэх хэсэгт заасан "саналаа нууцаар гаргах" эрхийг 5.6 дахь хэсэгтэй агуулгын хувьд давхардуулан зохицуулсан байна. - Төслийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг нь мөн төслийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.5 дахь хэсэгтэй хэлбэр болон агуулгын хувьд давхцсан ба үүнтэй холбоотойгоор тус зүйлүүдэд хамаарах санкцийн зохицуулалт мөн давхардсан. Тодруулбал, дурдсан зүйлүүд нь сонгогчийн шууд сонгох эрх болон саналаа нууцаар гаргах эрхийн тухай зохицуулалт бөгөөд тус эрхээ эдлэхэд санаатайгаар саад учруулсан бол 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт заасны дагуу иргэн, албан тушаалтан, хуулийн этгээдийг ялгаатай хэмжээний төгрөгөөр торгохоор, 6 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт заасны дагуу аливаа этгээдийг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор тус тус заажээ. Иймд нэг үйлдэлд ялгаатай шийтгэл оногдуулахаар зохицуулсан байх тул давхардлыг арилгах. - Төслийн "Хууль бус сурталчилгааг хориглох" хэмээх 45 дугаар зүйлд хориглосон үйл ажиллагааг жагсаахдаа мөн зүйлийн 45.1.7, 45.1.9-г давхардуулан хуульчилсан. - Төслийн 71 дүгээр зүйлийн 71.13 болон 71.14 дахь хэсгийн санкцууд хоорондоо давхардсан байна. Учир нь 71 дүгээр зүйлийн 71.13-т "Энэ хуулийн 71.11-д заасныг зөрчсөн ... тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно"; 71.14-т "Энэ хуулийн 71 дүгээр зүйлд заасныг зөрчсөн этгээдийг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг зургаагаас найм дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж тус тус заасан. Үүнээс үзвэл 71 дүгээр зүйлийг зөрчсөн тохиолдолд бүхэлд нь санкци тогтоосон байтал 71.11 дахь хэсэгт хамааруулан дахин тусдаа санкци бий болгон давхардуулсан байна. - Төслийн 77 дугаар зүйлийн 77.16 дахь хэсэг болон 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэг, мөн төслийн 77 дугаар зүйлийн 77.17 дахь хэсгүүд нь хоорондоо хэлбэр, агуулгын хувьд яг адил байдлаар давхардсан байгааг засах. - Хуулийн төслийн зүйл, заалт нь Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн төсөл, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийн зүйл, заалттай давхардсан буюу нэр томьёог хууль бүрт ижил агуулгатай зохицуулсан байх тул давхардлыг арилгах.
Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд байх шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН www.ulsyn.mn

Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Төслийн 20 дугаар зүйлийн 20.19-т “Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, *танилцуулах,* давхардлыг шалгах, сонгогч шилжих журмыг энэ хуулийн 20 дугаар зүйлд нийцүүлэн батлан мөрдүүлнэ” гэж; мөн зүйлийн 20.23-т “Сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах журмыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын саналыг үндэслэн тагнуулын байгууллага батална” гэж чиг үүргийг давхардуулан хуульчилсан байна.
Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр хураамж тогтоосон эсэх	Төсөлд татвар, төлбөр хураамж шинээр тогтоосон зүйлгүй байна.
Тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгаж байгаа эсэх	Төслийн 43 дугаар зүйлд “...телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэгчийн тусгай зөвшөөрлийг Харилцаа холбооны зохицуулах хороо цуцлана” гэж заасан. ААҮАТЗтХ-д энэ тухай тусгасан боловч нэр томьёоны хувьд зөрчилтэй байна. /“цуцлах” гэж заасан байгааг “хүчингүй болгох, түтгэлзүүлэх” гэж/
Хуулийн төслийн зүйл, заалт нь жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	Судалгаагаар жендэрийн эрх тэгш байдлыг хангасан байна.
Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Төслийн 38 дугаар зүйлийн 38.9-д “Орон нутгийн Хурлын төлөөлөгч сонгуульд нэр дэвшихээр бол хийсэн ажлын тайлангаа ээлжит сонгуулийн жилийн хоёрдугаар сарын нэгний өдрөөс өмнө тарааж болно. Үүнийг сонгуулийн сурталчилгааны материалын хэмжээнд тооцохгүй.” гэж заасан нь сонгуульд нэр дэвшсэн тохиолдолд түүнд давуу эрх эдлэн, өөрийн ажлыг тайлагнах замаар сонгуулийн сурталчилгаа хийж буй үйл ажиллагаа нь Шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэгдсэн байна.
Авилга, хүнд суртлыг бий болгоход чиглэгдсэн заалт тусгагдсан эсэх	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хуулийн төсөлд тусгасан хориглосон зохицуулалтыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх	Төслийн 86 дугаар зүйлийн 86.3-т “Сонгуулийн үйл ажиллагааны явцад аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль тогтоомж зөрчсөний улмаас бусдад эд хөрөнгийн болон бусад хохирол учирсан бол гэм буруутай этгээдэд холбогдох бусад хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэснийг үзвэл чухам ямар хуулийн дагуу хариуцлага хүлээлгэх нь тодорхойгүй байна. Учир нь эдийн болон эдийн бус хохирол учруулсантай холбогдох асуудлыг Иргэний хуулийг удирдлага болгон шийдвэрлэдэг. Иймд “Иргэний хууль болон бусад хууль” гэж өөрчлөн найруулах. Мөн үүрэгжүүлсэн, хориглосон зохицуулалтад хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хууль, бусад хуулиар тодорхой тусгах нь зүйтэй юм.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

4.1. Үнэлэлт, дүгнэлт

1992 оны Монгол Улсын Үндсэн хууль батлагдсанаас хойш 27 жилийн хугацаанд сонгуулийн багагүй туршлагыг хуримтлуулж, холбогдох хуулиудыг өөрчлөх, шинэчлэх ажил хийгдэж байсан нь хамгийн сүүлд 2015 онд Сонгуулийн тухай хууль батлагдсанаар хэрэгжиж байна. Тус хуулийг УИХ-ын, Ерөнхийлөгчийн болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тусгайлсан хуулийн төслүүдийг боловсруулжээ.

Хуулийн төслүүдэд нийтлэг ажиглагдаж буй зарим сайжруулах шаардлагатай зохицуулалт цөөнгүй байна. Эдгээрийг аргачлалын дагуу сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр дүгнэвэл:

ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛЛЭГ ҮЙЛЧЛЭЛ www.ulsiin.gov.mn

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Хуулийн төслийн үзэл баримтлалд туссан үндсэн зорилгыг Монгол Улсын улс төр, эдийн засаг, нийгмийн амьдралын хөгжлийн хурдац, үүнээс үүдэн гарсан нөхцөл байдал, хууль тогтоомжийн чанарыг сайжруулахад чиглэсэн байхаар тодорхойлон, зорилгод хүрэхийн тулд дэвшүүлсэн зорилтуудыг дараах байдлаар тогтоосон.

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох,
2. Тусгайлсан хууль боловсруулах,
3. Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах,
4. Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн зорилтуудыг дэвшүүлжээ.

Эдгээр зорилтуудтай холбогдсон зүйл, заалтыг хуулийн төслөөс сонгон авч “зорилгод хүрэх байдал”-ын үр нөлөөг тооцож үзвэл, 1/ сонгуулийн үндсэн зарчим, журмыг улам тодорхой болгох зорилтын хүрээнд хуулийн төсөлд ил, тод байдлыг хангах, шударга ёсыг сахих, сонгуулийн үйл ажиллагаа товлосон хугацаанд эхэлж, дуусах зэргийг товч тусгасан байх боловч зарчмын талаар тусгасан зохицуулалтад хориглосон зохицуулалт, сонгуулийн хугацаа, саналаа нуцаар гаргах эрх, үүрэгжүүлсэн зохицуулалт, ТББ эрх зэрэг хамааралгүй заалтыг оруулж өгсөн байна. Сонгуулийн төв байгууллагын журмыг тодорхой болгох тухайд 39 зүйл, заалтад “журмын” тухай заасан байгаа нь ямар журмыг тодорхой /хуулиа журам гэж байна уу, батлагдах журмыг хэлж байна уу, батлагдсан хэдий ч хэрэгжиж байгаад өөрчлөлт оруулах гэж байна уу гэдэг нь ойлгомжгүй/ болгох тухай нь ойлгомжгүй байна. Зорилгод хүрэх эхний зорилт тодорхойгүй, ойлгомжгүй байх тул зорилгод хүрсэн гэж үзэх үндэсгүй байна.

2/ Дараагийн зорилтод Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийг сонгуулийн харилцааны онцлогийг тусгасан, бүхэлд нь боловсронгуй болгох, Сонгуулийн тухай хуулиас тусгайлсан хуулийн төсөл боловсруулах талаар тусгасантай холбогдуулан төслийн 1 дүгээр зүйлд дүн шинжилгээ хийж үзлээ. 1 дүгээр зүйл буюу хуулийн төслийн зорилтод сонгуулийг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулах талаар заасан. Энэхүү хуулийн төслийн зорилт агуулгын хувьд УИХ-ын сонгуулийн тухай, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслүүдтэй ижил зохицуулагдсан.

Мөн Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 1 дүгээр зүйлд заасан хуулийн зорилтод “сонгуулийн төв байгууллагын эрх зүйн байдал, зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулах талаар тусгасан байгаа нь хууль хоорондын давхардлыг үүсгэж байна.

Аливаа хуулийн зорилтод тухайн хуулиар зохицуулагдах харилцааны хамгийн товч хэлбэрийг тусгасан байдаг бөгөөд энэхүү хуулийн төслийн зорилтоос үзвэл сонгуулийг зохион байгуулж явуулах тухай зохицуулж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар заагдсан сонгох, сонгогдох эрх хэрхэн хангагдах, үндсэн зарчмыг хэрхэн тодорхой болгож байгаа нь ойлгомжгүй байна.

3/ Хуулийн төслийн 4.1, 5 дугаар зүйлд Үндсэн хуульд заасан иргэний сонгох эрхийг хангах талаар нийт 9 заалтад шууд утгаар тусгажээ. Харин 4 заалтад хориглосон, эрхгүй байх тухай, хариуцлагын заалтыг тусгасан байгаа нь зүйлийн нэртэй нийцэхгүй байгаа нь сонгох эрхийг хангах зохицуулалт туссан боловч зорилтод хүрсэн гэж үзэхгүй байна.

4/ Сонгуулийг зохион байгуулж явуулах удирдлага, зохион байгуулалтын эрх зүйн орчныг сайжруулахад Гуравдугаар бүлэг, 14-19 дүгээр зүйлд шууд утгаар туссан байх боловч хуулийн төслийн зорилтоос эхлэн ихэнх зохицуулалт зохион байгуулалтыг хангасан байх төдийгүй сайжруулахад нэлээд анхаарсан болохыг

хэлэлцүүлэгт[291] дурдаж байсан тул зорилтыг хангасан гэж үзэх үндэслэлтэй юм.

Практикт хэрэгжих байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хангасан зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой эсэхийг шалгасан. Ингэхдээ хуулийн төслийн 68.4, 68.5-т заасныг сонгон авч үзвэл "Санал авах байранд сонгогчдоос саналаа нууцаар, чөлөөтэй илэрхийлэх боломжийг хангасан, хэсэг дэх сонгогчийн тооноос хамааран хоёроос доошгүй тооны санал бэлтгэх бүхээг байх бөгөөд санал авах байр бүрд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан нэгээс доошгүй санал бэлтгэх бүхээгийг тусгайлан тоноглож бэлтгэсэн байна", "Санал авах байр нь тэргэнцэртэй сонгогч орох боломжоор хангагдсан байна" гэж заасныг ямар субъект хариуцан хэрэгжүүлэх талаарх зохицуулалтыг орхигдуулсан байна.

СЕХ, Засаг даргын Тамгын газарт санал авах байрыг бэлтгэх тухай даалгасан зохицуулалт байх боловч хөгжлийн бэрхшээлтэй иргэд санал өгөх боломжтой байдлаар бэлтгэх нарийвчилсан зохицуулалтгүй байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн ойлгомжтой байдлыг хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэх, Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалын баримталсан эсэхийг шалгасан болно.

Хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг авч үзвэл нийт 29 зүйл, заалт ойлгомжгүй байна. Тухайлбал, Хуулийн төсөлд "нэн даруй" хэрэгжүүлэхээр заасан 16 заалт, итгэмжилсэн ажилтан /цаашид "итгэмжлэгдсэн ажилтан" гэх/ гэх зэргээр ялгаатай томьёолсон, ямар нэг төлөөлөлгүйгээр оролцож саналаа өгөх тухай заасан нь хөгжлийн бэрхшээлтэй буюу бичих, хөдөлгөөний бэрхшээлтэй этгээд саналаа хэрхэн өгөх нь ойлгомжгүй, хориглосон заалтыг сонгуулийн үйл ажиллагааны зарчимд оруулсан, "Иргэний хуульд заасан зарчмыг баримтална" гэсэн байгаагаас үзвэл Иргэний хуульд хугацаа нь зарчим байх тухай заагаагүй, Сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны ил тод байдлыг хангах зарчимд сонгогч саналаа нууцаар гаргах эрхийг хамааруулсан, Улс төрийн намын дэргэд үйл ажиллагаа явуулдаггүй ТББ-ын эрхийг үйл ажиллагааны зарчимд хуульчлан тусгасан, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчид нөхөн сонгууль буюу ээлжит бус сонгуулийг товлон зарлах тухай заасан байтал төрийн албан хаагчийг төрийн албанаас халах тухай заалтад хамааруулсан гэх мэт заалтууд ойлгомжгүй байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага, мөн Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг харгалзан үнэлэхэд төслийн зарим зүйл, заалт шаардлагад нийцээгүй болох нь тогтоогдож байна. Үүнд:

Төсөлд хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо зөрчилдсөн, нэр томьёоны хувьд өөр хоорондоо нийцэхгүй байдал үүсгэж буй, үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлээгүй байна. Тухайлбал, төслийн зарчмын талаар тусгасан зүйл байтал зүйлийн заалтад хориглосон, эрх олгосон, хугацаа заасан зэрэг заалт тусгасан, төсөлд "болно" гэсэн заалтын агуулгад хориглосон зохицуулалтыг оруулсан зэрэг байна.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төслийн үр нөлөөг тооцох аргачлалын дагуу тодруулах шаардлагатай 14 төрлийн асуулгаас 4 төрлийн асуулга шаардлага хангасан байна.

[291] Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуулийн төслийн хэлэлцүүлгээс. Уб., 2018 он.

Тухайлбал, шинээр албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зүйлгүй, жендэрийн эрх тэгш байдлыг хангасан, авилга хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгаагүй байна.

Шалгуур үзүүлэлтэд заасан 10 асуулгын хүрээнд хуулийн төслийн зарим зүйл, заалт харилцан уялдаа холбоотой байх шаардлага хангаагүй гэж үзлээ. Үүнд:

- Төслийн зохицуулалт нь тухайн хуулийн зорилттой нийцээгүй, нэр томьёоны хувьд бусад хууль болон төсөлд тусгагдсан нэр томьёотой нийцэхгүй байх тохиолдол байна. Тухайлбал, ХХтХ-д тусгагдсан "түдгэлзүүлэх" гэснийг "зогсоох" гэж, "хүчингүй болгох" гэснийг "цуцлах" гэж төсөлд өөрөөр томьёолсон байна.
- Төсөлд тусгагдсан зүйл, заалт нь тухайн хуулийн төсөлд болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа байдлын хүрээнд, ТАтХ-д "3 жилийн хугацаагаар төрийн албанд эргэж орохгүйгээр халах" тухай зохицуулалт байхад төсөлд "1 жилийн хугацаагаар төрийн албанд эргэж орохгүйгээр халах" тухай өөрөөр зохицуулсан, төслийн 6 дугаар зүйлд сонгогч ямар нэгэн төлөөлөлгүйгээр саналаа өөрөө өгөхөөр зохицуулсан нь "бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогч өөрийн итгэмжилсэн сонгуулийн эрх бүхий иргэний туслалцаатайгаар санал өгч болно" гэж заасантай нийцэхгүй байна. Мөн төсөлд торгуулийн арга хэмжээг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцон нэмэгдүүлж авахаар тусгасан нь Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуультай нийцэхгүй байна.
- Хуулийн төслийн зүйл, заалтууд нь өөр хоорондоо болон бусад хууль, хуулийн төсөлтэй давхардсан зохицуулалт нэлээд байна. Хуулийн зүйл, заалт хоорондоо давхардсанаас гадна тусгаарласан хуулийн төслүүд хоорондоо давхардаж байна.
- Төсөлд сонгуулийн зардалтай холбоотой тусгасан зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага буюу торгуулийн хэмжээ хэтэрхий бага байна гэж дүгнэлээ.

4.2. Зөвлөмж

Хуулийн төслийн үр нөлөөг тооцох ажиллагааны үр дүнд гарсан дүгнэлтэд тулгуурлан дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

- Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт хуулийн зорилтыг сонгох, сонгогдох эрхэд чиглэсэн байхаар томьёолох;
- Хуулийн төсөлд байгаа хоёрдмол утга агуулсан, давхардсан, хоорондоо нийцэхгүй байгаа ойлгомжгүй байдал үүсгэж буй зүйл заалтыг нэг мөр болгох;
- Хууль тогтоомжийн тухай хуулийн зохих шаардлагад нийцүүлэх;
- Үндсэн хууль болон хүчин төгөлдөр үйлчилж буй бусад хууль тогтоомж, төсөлд тусгагдсан зүйл, заалтуудыг нийцүүлэх, харилцан уялдааг хангах;
- Санал авах өдрийн санал авч эхлэх болон дуусах хугацааг дахин хянан авч үзэх;
- Сонгуулийн зардалтай холбоотой төсөлд тусгагдсан зохицуулалтыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын арга хэмжээг нэмэгдүүлэх талаас нь анхаарах;
- Санал өгөх сонгогчийн тухайд зарим онцгой шалтгааны улмаас зайлшгүй төлөөлөгчтэй оролцох иргэдийн эрх ашгийг хөндөхгүйн тулд "бие эрхтний согог, эрүүл мэндийн байдал, боловсролын түвшингээс шалтгаалан саналаа биечлэн өгөх чадваргүй сонгогчоос бусад сонгогчийн хувьд ямар

www.nhgov.mn

нэг төлөөлөлгүйгээр саналаа өгөх” гэж тодруулах;

- Торгох ял, шийтгэлийн хувьд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт Үндэсний хорооны шийдвэрээр /Засгийн газрын тогтоолоор/ өөрчлөгдөж буй явдлыг зогсоох эрх зүйн үндэслэлийг бий болгосонтой торгуулийн арга хэмжээг нийцүүлэх.
- Сонгуулийн тухай хуулийг тусгаарлан хуулийн төсөл бэлтгэж байгааг дэмжиж байгаа боловч эдгээр хуулийн төслөөр /УИХ, Ерөнхийлөгч, АНСДИТХ/ тусгайлсан онцлог зохицуулалтыг тусгах буюу нэгэнт хууль боловсруулж байгаатай холбогдуулан Сонгуулийн тухай хуульд /ерөнхий хууль/ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль буюу үйл ажиллагаа, зохион байгуулалтыг зохицуулсан байгаа Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийг нэмж зохицуулан харин санхүүжилтийн асуудлыг тусдаа хуулиар зохицуулан сонгуультай холбоотой 5 тусгайлсан хуулийг боловсруулан давхардсан зүйлгүй ойлгомжтой энгийн байдлаар сонгох, сонгогдох эрхийг ханган, урт удаан хугацаанд тогтвортой үйлчлэх, сайн хуулийг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Ном, гарын авлага

1. Ардчилсан сонгууль: Иргэний нийгмийн хяналт Уб., 2008
2. Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтийн гарын авлага Уб., 2008
3. Монгол Улс дахь үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн төсвийн процесс: эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл Уб., 2013
4. Монгол Улсын анхны ардчилсан сонгууль 1990-2015 Уб., 2015
5. Монголын төр эрх зүй Уб., 2017
6. Сонгуулийн санхүүжилт:тулгамдсан асуудал ба шийдэл/судалгааны тайлан/.Уб., 2015
7. УИХ-ын сонгууль 2008. Уб., 2008
8. УИХ-ын сонгууль-2012 “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээнээс хийсэн мониторинг. Уб., 2013
9. Сонгуулийн менежментийн хувилбарууд:ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын институтийн гарын авлага. Уб., 2008.
10. Сонгуульд суралцахуй тогтолцоо, үйл явц, эрх зүй. Уб., 2008
11. Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний үндсэн хууль буруутай юу? Уб., 2011
12. Сонгуулийн эрх зүйн хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох ажлын хүрээнд хийсэн судалгаа/ судалгааны тайлан Уб., 2011
13. Улсын Их Хурал “Шударга сонгуулийн төлөө иргэний нийгмийн хяналт” сүлжээнээс хийсэн мониторинг Уб., 2013
14. Б.Чимид. Сонгуулийн тогтолцоонд ард түмэн, түүний Үндсэн хууль буруутай юу. Уб., 2011

Өгүүлэл, илтгэл

1. Ч.Содномцэрэн. Сонгуулийн зохион байгуулалт, тогтолцоо, түүнийг боловсронгуй болгох нь. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.

Хуулийн үнэсний хүрээлэн www.mn.gov.mn

2. Д.Болд-Эрдэнэ. Сонгуулийн хэлбэрийн үйлчлэлийн асуудалд. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.
3. Д.Баасансүрэн. Ардчилсан сонгууль:олон нийтийн санаа бодол. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.
4. Б.Нармандах. Сонгох эрхийн хэрэгжилт, анхаарах зарим асуудал. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.
5. Д.Гангабаатар. Цахим саналын систем ба иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломж. Монгол улс дахь Үндсэн хуулийн процессийн тулгамдсан асуудал: хууль тогтоох, сонгуулийн болон төсвийн процесс:эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Уб., 2013.
6. Сонгогчдын боловсролд. Хүний эрхийн цуврал нийтлэл Уб., 2012.
7. Хариуцлагатай сонголтоор бид эрхээ баталгаажуулна. Хүний эрхийн цуврал нийтлэл Уб.,2013.

Цахим эх сурвалж

1. ОлонулсынсонгуулийгажиглаххорооМонголУлс–Ерөнхийлөгчийнсонгууль, 2017 оны 6-р сарын 26 https://www.osce.org/mn/odihr/327166?download=true сүүлд үзсэн 2019.1.10
2. Монгол Улс Хуудас: 25 Ерөнхийлөгчийн сонгууль, 2017 оны 6-р сарын 26 болон 7-р сарын 7-ны өдрүүд ЕАБХАБ/АИХЭГ-ын САХХ-ны Тайлан. https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/366136?download=true сүүлд үзсэн 2019.1.10.
3. Улсын Дээд Шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.06.22.) “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178 сүүлд үзсэн: 2018.12.26.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.jli.gov.mn

ШҮГЭЛ ҮЛЭЭГЧИЙН ЭРХИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛСАН ТАНДАН СУДЛАХ СУДАЛГАА[292]

УДИРТГАЛ

Монгол Улс Нэгдсэн Үндэсний байгууллага (цаашид "НҮБ" гэх)-ын Авлигын эсрэг конвенцид 2005 онд нэгдэн орж, Улсын Их Хурал (цаашид "УИХ" гэх)-аар соёрхон батлсан. Тус конвенцын 33 дугаар зүйлд "Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ." гэж тунхагласан.[293]

Уг конвенцын дагуу Монгол Улс мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх үүргийг хүлээж байгаа юм. Нөгөө талаас мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоо бүрдүүлэх ажлыг олон улсын шинжээчид хангалтгүй гэж үнэлэн холбогдох зохицуулалтыг бий болгох талаар зөвлөмж өгсөн.[294]

Ийнхүү УИХ-аас 2016 онд "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг батлсан бөгөөд уг хөтөлбөрт "улс төр, хууль хяналтын байгууллагын хүрээнд авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлж, авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийн мэдээллийг шалгах, мэдээлэгчийг хамгаалахад иргэн хяналт тавих бололцоо бүрдсэн байх" тухай заасан.

Засгийн газраас дээрх хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г 2017 онд батлан гаргасан. Үүнд, 2018-2019 онд ХЗДХЯ-аас АТГ, ТББ-тай хамтран "Шүгэл үлээгч"-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгон хуулийн төслийг УИХ-д өргөн барьсан байх тухай тав дахь бүлэгт заажээ.[295]

"Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах" тухай хуулийн төслийг санаачлан, олон жилийн хугацаанд шийдэгдэхгүй ирсэн асуудал болон шударга ёсны төлөө эрх бүхий байгууллагад баримт нотолгоо, үндэслэл бүхий мэдээлэл өгсөн мэдээлэгчийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлага тулгарсан явдал юм. Хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэх явцад нэр томьёоны асуудал яригдаж байсан бөгөөд үүнийг "олон улсын хэмжээнд зарим нь "Шүгэлдэгч" хэмээн нэрлэдэг бол авлигын гэмт хэрэгтэй холбогдвол "Гэрч"-ийн хуваарь асуудал яригддаг. Нэлээд өргөн утгатай тал, талын асуудал хөндөж байгаа юм."[296] хэмээн тайлбарлаж байна.

Нийтийн ашиг сонирхлын төлөө зүй бус үйлдлийг мэдээлж, шүгэл үлээхийг ардчилсан нийгэмд иргэний хүлээх ёстой үүрэг гэж үздэг. Гэтэл Монгол Улсад зүй бус үйлдлийн талаар шүгэл үлээсэн иргэнийг хамгаалах механизм бүрдээгүйн улмаас үйлдэл, эс үйлдэхүйг мэдээлсний дараа гарах эрсдэлээс болгоомжлон иргэд мэдээлэл өгдөггүй, өгөхийг хүсдэггүй байдал ажиглагдаж байна.[297]

Иймд, энэхүү судалгааг "Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах" тухай ойлголтыг хуулиар тодорхойлох, "Шүгэл үлээгч" /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах, аюулгүй

---

[292] Энэхүү судалгааг АТГ-ын захиалгаар 2019 онд ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн ухааны доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан Э.Уянга, Ч.Батзориг, О.Төрболд нар хамтран гүйцэтгэв.

[293] Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай. https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269 (сүүлд үзсэн 2019.10.15)

[294] АТГ: "Шүгэл үлээгч"-ийг хуулиар хамгаалдаг болно. http://isee.mn/n/871 (сүүлд үзсэн 2019.10.15)

[295] Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр батлах тухай /УИХ-ын 2016 оны 51 дүгээр тогтоол/ https://www.legalinfo.mn/law/details/12293?lawid=12293 (сүүлд үзсэн 2019.10.18)

[296] "Шүгэл үлээгч, мэдээлэгчийн эрхийг хамгаалах» хуулийн төслийн талаар зөвлөлдөх уулзалт. http://parliament.mn/n/fxjo (сүүлд үзсэн 2019.10.15)

[297] АТГ: "Шүгэл үлээгч"-ийг хуулиар хамгаалдаг болно. http://isee.mn/n/871 (сүүлд үзсэн 2019.10.15)

байдлыг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, тэдгээрийн үйл ажиллагааг нь зохицуулах, тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд хуулийн төсөл боловсруулах шаардлагатай эсэх талаар Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэв.

Судалгааны аргачлал:

Тус судалгааг гүйцэтгэхдээ Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан аргачлалын дагуу дараах үе шатыг баримтлан гүйцэтгэв. Үүнд:

8. Асуудалд дүн шинжилгээ хийх;
9. Асуудлыг шийдвэрлэх зорилгыг томьёолох;
10. Тухайн асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож тэдгээрийн эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах;
11. Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах;
12. Тухайн зохицуулалтын талаарх олон улсын болон бусад улсын эрх зүйн зохицуулалтын харьцуулсан судалгаа хийх;
13. Дүгнэлт, санал боловсруулах;

Дээрх дараалын дагуу нэгдүгээрт, “Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах”-тай холбогдсон харилцааг судлах, тулгамдсан асуудлыг тодорхойлохыг зорьсон болно. Энэ хүрээнд Монгол Улсын хууль тогтоомжоос гадна олон улсын байгууллагаас хүний эрхийн чиглэлээр гаргасан баримт бичгүүд, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт, ярилцлага хийх, өмнө хийгдсэн социологийн судалгаа, бусад статистик мэдээллийг ашиглав. Ингэхдээ асуудлын мөн чанар, түүний цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг болон тухайн асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг тус тус тодорхойлов.

Иймд тухайн судалгааны хувилбаруудаас сонгон авсан хувилбарт үндэслэн дүгнэлт, санал боловсруулав.

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Хууль тогтоомж нь тухайн харилцааг зохицуулж чадаж байгаа эсэх болон нийгэмд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөөллийг илрүүлэх зорилгоор үнэлгээний ажлын эхэнд үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлно.

Нэр томьёо. “Шүгэл үлээгч /мэдээлэгч/” гэх нэр томьёог 1972 онд Америкийн иргэний эрхийн төлөө тэмцэгчдийн нэг Ralf Nader “нууц мэдээлэгч”, “матаач” зэрэг сөрөг нэршлээс ялгаатай гэсэн санаагаар тайлбарлаж, шүгэл үлээгч буюу “whistleblow” гэх нэр томьёог эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн байгууллагын эсрэг хүчтэй дуугарч, асуудалд нийгмийн анхаарлыг чиглүүлж байгаа хүнийг “шүгэл үлээгч” гэх утгаар хэрэглэж эхэлсэн байна.[298]

Шүгэл үлээгч-ийн талаар олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэгдсэн ойлголтод хараахан хүрээгүй байна. Ихэнх орнуудын хувьд нийтийн албан дахь шүгэл үлээгч, мэдээлэгч, холбогдох мэдээллийг internal witness-дотоод гэрч, эсхүл public interest disclosure-нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийг ил болгож буй этгээд, protected disclosure, эсхүл public interest information-нийтийн эрх ашигт хамаарах мэдээлэл зэргээр томьёолсон байна.[299]

Шүгэл үлээгчийг улс орнууд өөрсдийн хууль тогтоомжид дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд, Бүгд Найрамдах Энэтхэг улс 2011 оны Шүгэл үлээгчийн

[298] Санхүүгийн зохицуулах хороо, Банкнаас бусад санхүүгийн байгууллагын комплейнсын ажилтнуудад зориулсан гарын авлага (суурь ойлголт), (Уб, 2019), 97 дахь тал.

[299] Д.Жигваансүрэн, Д.Халиун, “Гадаадын зарим орны шүүмжлэгч (шүгэлдэгч)-ийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын талаарх лавлагаа”, УИХ-ын Тамгын газар Судалгааны эмхэтгэл XXV боть (Уб, 2017), 405 дахь тал.

эрхийг хамгаалах тухай хууль (The whistle blowers protection act)-ийг баталсан байна. Уг хуулийн 3 дугаар зүйлийн "С"-д "гомдол гаргагч" (complainant) гэж энэ хуульд заасан үндэслэлээр гомдол гаргасан аливаа хүнийг хэлнэ гэж тодорхойлсон бөгөөд "D"-д "мэдээллийг ил болгох" (disclosure) гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд,

- 1988 оны Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан гэмт хэргийг үйлдэх, эсхүл үйлдэхээр завдсан;

- Эрх мэдлээ санаатайгаар урвуулан ашиглаж Засгийн газарт хохирол учруулсан, эсхүл нийтийн албан тушаалтан болон гуравдагч этгээдэд хууль бусаар ашиг бий болгосон;

- Нийтийн албан тушаалтан гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэхийг завдсан хэмээн тодорхойлсон бол Бүгд Найрамдах Солонгос Улсын 2011 оны "Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль"-ийн 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээх" гэж нийтийн ашиг сонирхлыг хохироосон буюу хохироож болзошгүй талаар тайлагнах, өргөдөл гаргах, мэдээлэх, буруутгах, гомдол гаргах буюу энэ хуулийн 6 дугаар зүйлийн дэд хэсэгт заасан этгээдэд нийтийн ашиг сонирхлыг хохироосон асуудлаар тайлбар өгөх үйлдэл.

Гэхдээ дараах тохиолдолд нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн гэж үзэхгүй. Үүнд:

а. нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн ч шүгэл үлээгч нь тухайн мэдээлэл худлаа гэдгийг мэдэж байсан буюу мэдэх боломжтой байсан;

б. шүгэл үлээгч нь хөдөлмөрийн харилцааны хүрээнд мэдээллийн хариуд мөнгө, эд зүйл, тусгай давуу эрх шаардсан буюу бусад хууль бус зорилгоор шүгэл үлээсэн." зэргээр тодорхойлсон байна.

Харин Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын зохицуулалтын хувьд мэдээлэгч этгээд буюу шүгэл үлээгч гэдгийг явцуу хүрээнд тодорхойлохоос зайлсхийсэн бөгөөд дараах этгээд шүгэлдэгч байж болохоор байна. Үүнд,

- Төр, хувийн салбарт ажиллагч;
- Олон нийтийн төлөөлөл;
- Гэрч, хохирогч;
- Шинжээч.

Дээрхээс дүгнэж үзвэл нийтийн ашиг сонирхол, аюулгүй байдлын эсрэг үйлдлийн тухай мэдээлэл тараахыг улс төрийн нэр томьёонд "шүгэл үлээх" хэмээн нэрлэж болохоор байна.

Хамгаалагдах этгээд. Шүгэл үлээх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийн үндсэн зарчмыг Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Сайд нарын зөвлөлийн Сайн засаглалыг бэхжүүлэх тунхагт "...Төрийн болон хувийн хэвшлийн салбар дахь шүгэл үлээгчид нь авлигаас сэргийлэх, түүнтэй тэмцэхэд гол үүрэг гүйцэтгэдэг тул тэдгээрийг хамгаалах ажиллагааг хүч зузаатган нэмэгдүүлэхийн чухлыг хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд ингэснээр олон нийтийн ашиг сонирхлыг[300] хамгаалж буй хэрэг мөн.

Хамгаалах механизм. Бид шүгэл үлээгчид, тэдний гэр бүлийн гишүүдийг хөнөөлтэй нөхцөл байдал, сүрдүүлэг, сэтгэл санааны болон бие махбодын дарамт, эрх чөлөө, амь зуулгаа алдахаас үр нөлөөтэй хамгаалах эрх зүйн механизм бий болгож, хэрэгжүүлэхэд зохих арга хэмжээ авахад чиглэсэн хүчин чармайлтаа

[300] Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх хэсэгт "нийтийн ашиг сонирхол гэж нийтийн албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхээ хувийн ашиг сонирхлоосоо ангид тэгш, шударгаар хэрэгжүүлнэ гэх олон нийтийн итгэлийг" ойлгохоор тусгасан байна.

эрчимжүүлнэ. Ийм механизм нь авлигын эсрэг үр дүнтэй тэмцэх чухал бүрэлдэхүүн хэсэг мөн болохыг бид хүлээн зөвшөөрч байгаа болно..."[301], Европын зөвлөлийн Авлигын талаарх иргэний эрх зүйн тухай конвенцын 9 дүгээр зүйлд "Гишүүн улс бүр авлига хэмээн сэжиглэх баттай үндэслэлтэй, шударга ёсны үүднээс сэжиг таамгаа холбогдох эрх бүхий байгууллага, этгээдэд мэдээлсэн ажилтнуудад аливаа шударга бус хариуцлага, шийтгэл оногдуулахаас хамгаалах зүй зохистой зохицуулалтыг дотоодын хууль тогтоомжид тусгана.", Европын Зөвлөлийн Авлигатай тэмцэх Эрүүгийн хуулийн конвенцын 22 дугаар зүйлд "Оролцогч улс бүр (а) 2-14 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн талаар мэдээлсэн, эсхүл мөрдөн байцаах болон прокурорын байгууллагатай хамтран ажиллаж буй этгээд; (б) эдгээр гэмт үйлдлийн талаар мэдүүлэг өгч буй гэрчүүдийг үр нөлөөтэй, зүй зохистой хамгаалахад шаардагдах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.", НҮБ-ын Авлигын эсрэг конвенцын 33 дугаар зүйлд "Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч үзнэ."[302], гэх зэргээр тусгасан байна. Энэхүү конвенцид НҮБ-ын гишүүн 140 орон нэгдсэн ба УИХ 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр соёрхон баталсан.[303] Ийнхүү хамгаалах механизмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх үүднээс бусад улс орнууд буцаан авч чадсан хөрөнгийн хувьтай тэнцэх хэмжээний мөнгийг урамшуулал болгож шүгэл үлээгчдэд олгож байна. Тухайлбал, шүгэл үлээгчдэд АНУ-д 10-30%[304], Бүгд найрамдах Солонгос улсад хоёр тэрбум вон хүртэл (4-20%)[305], Канад улсад 5-15%[306] урамшууллыг олгож байна.

Хүний хөгжлийн индекс өндөртэй, хөгжилтэй орнуудын нэгдэл болох Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын зарим гишүүн орнуудын хувьд шүгэлдэгчийн эрхийг хамгаалах зохицуулалтын хамрах хүрээнд нийтийн албан тушаалтнаас гадна хувийн сектор багтаж байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын гишүүн орнуудын хувьд шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах асуудлыг бие даасан хууль бус Авлигын эсрэг хууль, Өрсөлдөөний хууль, Компанийн хууль, Хөдөлмөрийн хууль, Төрийн албаны тухай болон Эрүүгийн хууль болон бусад 1-ээс 2 салбар хуулиар зохицуулсан байдал түгээмэл ажиглагдаж байна. Гэвч дээрх хуулиудын хамрах хүрээ болон шүүмжлэгчийн эрхийг хамгаалах хэлбэр, түвшин нь харилцан адилгүй, шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах бие даасан хууль тогтоомжуудтай харьцуулахад тодорхой бус, хууль бус, алдаа дутагдалтай үйл ажиллагааг мэдээлэх үйл явц, механизм нь ойлгомжгүй гэж судлаачид дүгнэжээ.[307]

Монгол Улсын хувьд 2002 он болон 2016 онуудад Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийг баталж мөрдүүлсэн хэдий ч шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна. Тодруулбал, Транспэрэнси интернэшнл

[301] Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Авлигатай тэмцэх гарын авлага, (Уб, 2018), 146 дахь тал.

[302] Авлигын эсрэг нэгдсэн үндэстний байгууллагын конвенц, 33 дугаар зүйл, https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269 (Сүүлд үзсэн, 2019.10.28)

[303] Гадаад хэргийн яам, Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээний жагсаалт, http://www.mfa.gov.mn/?page_id=29040#1485132523196-a01c7d09-78b5 (Сүүлд үзсэн, 2019.10.28)

[304] Dodd-Frank Wall street Reform and Consumer Protection Act, http://www.sec.gov/spotlight/dodd-frank/whistleblower.shtml

[305] Act on the Protection of Public interest Whistleblowers

[306] Constantine (2019). Canada Makes First Securities Fraud Whistleblower Award, http://constantinecannon/2019/03/06/canada-securities-fraud-whistleblower-awards/

[307] Д.Жигваансүрэн, Д.Халиун, "Гадаадын зарим орны шүүмжлэгч (шүгэлдэгч)-ийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын талаарх лавлагаа", УИХ-ын Тамгын газар Судалгааны эмхэтгэл XXV боть (Уб, 2017), 404 дэх тал.

байгууллагаас Ази, номхойн далайн бүс нутгийн 20 гаруй мянган хүмүүсийн дунд авлигын талаар судалгаа зохион байгуулж "авлигын эсрэг иргэд тэмцэх хамгийн үр дүнтэй алхам юу вэ?" гэсэн асуултад тэдний ихэнх хувь нь "мэдээлэх", мөн "хахууль өгөхгүй байх" гэж хариулсан байна. Улмаар уг судалгаагаар яагаад "мэдээлэх" буюу шүгэл үлээх алхмыг хийгээгүй шалтгааныг тодруулахад "үр дагавраас айдаг"[308] гэж хариулсан байна.

Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах үзэл санаа. Европын Зөвлөлийн Парламентын Ассамблей 2010 онд 1729 тоот тогтоолыг баталж, шүгэл үлээгчдийг хамгаалах чиглэлээр холбогдох хууль тогтоомж бий болгохыг гишүүн улс орнууддаа уриалсан байдаг. Тус тогтоолд Европын Зөвлөлийн ихэнх гишүүн улс орнуудад цогц хууль тогтоомж байдаггүйг онцлон тэмдэглээд, АНУ, Их Британийн хэрэгжүүлж буй хууль тогтоомжийг сайшаан онцолж, мөрдвөл зохих чиглүүлэгч зарчмуудыг тодорхойлж тогтоосон байна. Үүний дараагаар 2015 онд Шүгэл үлээгчийг хамгаалах тухай 2060 тоот тогтоолыг баталсан байна. Европын Зөвлөл 2014 оны 4 дүгээр сард шүгэл үлээгчийг хамгаалах тухай CM/Rec (2014) тоот зөвлөмжийг баталж, гишүүн улс орнууддаа зориулан нарийвчилсан зөөлөн хуулийн хэрэгсэл гаргаж өгсөн байдаг.

Улс орнуудын дотоодын тусгайлсан хуулиар (АНУ-Японы Шүгэл үлээгчийг хамгаалах хууль, Их Британийн Нийтийн ашиг сонирхлыг илчлэх хууль г.м), эсхүл салбарын хуулиар (авлигын эсрэг хууль, өрсөлдөөний хууль, нягтлан бодох бүртгэлийн хууль, компанийн хууль, хөдөлмөрийн хууль) дамжуулан шүгэл үлээгчдийг хамгаалах, урамшуулах асуудлыг зохицуулж байна.[309] 2019 оны байдлаар дэлхийн 27[310] улсад шүгэл үлээгчийг хамгаалах тусгайлсан хуультай байгаа бөгөөд шүгэл үлээгчийг хамгаалж, баталж мөрдүүлэх явдал улам бүр нэмэгдэж байна.

Дээрх хүснэгтээс харвал шүгэл үлээгчийг хамгаалах чиглэлээр АНУ тэргүүлэх чиглэлтэй байна. АНУ нь 1776 онд тусгаар тогтнолоо зарласнаас 2 жилийн дараа буюу 1778 оны 7 дугаар сарын 30-ны өдөр тэнгисийн цэргийн хүчин дэх хууль бус, авлигын үйлдлийн эсрэг нийтийн ашиг сонирхлыг хамгаалж шүгэл үлээсэн, шүгэл үлээгчдийг хамгаалах зорилгоор Америкийг үндэслэгчид[311] санал нэгтэйгээр хууль[312] гаргаж байсан нь дэлхийн хамгийн анхны шүгэл үлээгчийн хууль гэж тооцогддог.[313] Мөн АНУ-д сенатаас 7 дугаар сарын 30-ны өдрийг "Үндэсний шүгэл үлээгчдэд талархах өдөр"[314] болгон зарласан байдаг бол Европ тивд Их Британи Умард Ирландын нэгдсэн вант Улсад[315] хамгийн анх буюу 1998 онд баталсан байна. Энэ хууль нь харьцангуй өргөн хүрээг хамардаг байна.[316]

Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах олон улсын сайн туршлагаас харахад дараах гол асуудлуудыг хууль тогтоомжид тусгасан байна.

[308] Transparency international (2017), People and corruption: Asia Pacific-Global corruption barometer

[309] OECD, Study on whistleblower protection frameworks, compendium of best practices and guiding principles for legislation, http://www.oecd.org/g20/topics/anti-corruption/48972967.pdf

[310] АНУ, Их Британи, Шинэ Зеланд, Босни-Херцеговин, Өмнөд Африк, Япон, Румын, Канад, Израиль, Малайз, Перу, Уганда, Замби, Этиоп, Ямайка, Өмнөд Солонгос, Вьетнам, Австрали, Бельги, Мальта, Унгар, Ирланд, Энэтхэг, Серби, Словак, Нидерланд, Намибия гэх улсуудад шүгэл үлээгчийг тусгайлсан хуулиар хамгаалдаг байна.

[311] The Founding Fathers

[312] Library of Congress (1778), Journals of the Continental Congress http://www.whistleblowers.org/wp-content/uploads

[313] National Whistleblower Center, http://www.whistleblowers.org/news/the-whistleblowers-of-1777-the-origins-of-national-whistleblower-day/

[314] http://www.whistleblowers.org/enact-a-national-whistleblower-day/

[315] Энэ талаар цаашид дэлгэрэнгүй авч үзнэ.

[316] Д.Жигваансүрэн, Д.Халиун, "Гадаадын зарим орны шүүмжлэгч (шүгэлдэгч)-ийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын талаарх лавлагаа", УИХ-ын Тамгын газар, Судалгааны эмхэтгэл, XXV боть (Уб, 2017), 404 дэх тал.

Хэнийг хамгаалах вэ?

- Нийтийн албан тушаалтан
- Гэрээт ажилтан
- Нэрээ нууцалсан этгээд

Хэнд ил болгох вэ?

- Ажил олгогч- дотоод нэгж
- Албан байгууллага- гадна
- Олон нийт
- Сэтгүүлч, парламентын гишүүд, хувийн хэвшил

Юуг ил болгох вэ?

- Хууль бус үйл ажиллагаа, авлига
- Төрийн өмчийг шамшигдуулсан хэрэг
- Зүй бус, ёс зүйгүй үйлдэл
- Нийтийн аюулгүй байдал, байгаль орчин, эрүүл мэндэд учирч буй аюул

Эрүү, иргэний хариуцлагаас чөлөөлөх

- Хуулийн хариуцлагаас чөлөөлөх
- Нүүлгэн шилжүүлэх

Ажлын байран дахь хамгаалалт[317]

Whistleblower буюу шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн тогтолцоо нь Англи Саксоны загвар, Эх газрын Европ загвар гэсэн үндсэн хоёр загвартай хэмээн үздэг. Англи Саксоны загварын хувьд нийтлэг эрх зүйд хамаарах улсууд хамаарах бөгөөд уг тогтолцоо хамгийн анх үүссэн гэх АНУ-ын хувьд энэ загварт хамаарна. Мөн АНУ-аас гадна Англи, Австрали, Канад, Шинэ Зеланд зэрэг улс багтдаг байна. Харин Эх газрын Европ загварт Герман болон Франц улсыг хамааруулан үздэг бөгөөд Япон улс ч мөн уг загварын нэгэн төлөөлөгч нь болох юм.[318]

Тухайлбал, Голланд Улсад "шүгэл үлээгч"-д зөвлөгөө өгөх төв (Adviespunt klokkenluiders) байгуулж, хамгаалах тусгай байр гаргаж байсан аж. 2013 онд хэвлэл мэдээллийн томоохон байгууллагууд хамтран "шүгэл үлээгч"-дэд мэдээлэл цацахад зориулсан тусгай хамгаалалттай цахим хуудас (Publeaks) нээсэн байна.[319]

Европын зөвлөлөөс 2014 онд гаргасан "Шүгэл үлээгчийг хамгаалах талаарх зөвлөмж"-дөө шүгэл үлээгчийг хамгаалах зохицуулалтыг дараах шалгуураар үнэлэхээр тусгаж өгсөн байна. Үүнд,

- Тодорхойлолт (шүгэл үлээгч, мэдээлэх, нийтийн ашиг сонирхол)
- Эрх зүйн зохицуулалтын хүрээ (шүгэл үлээгчийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах эрх зүйн зохицуулалтын хамрах хүрээ)
- Мэдээлэл, илчлэх суваг (мэдээлэх, нийтэд ил болгох сувгийн тодорхой байдал, дотоод суваг, дүрэм журам)
- Нууцлах (Мэдээлэгч этгээд нь нууцлагдах эрхтэй байх)
- Мэдээллийн мөрөөр авах арга хэмжээ (мэдээллийг даруй мөрдөн шалгах, мэдээлэгч этгээдэд авсан арга хэмжээний талаар мэдэгдэж байх)
- Мэдээлэгч этгээдийг хамгаалах арга хэмжээ (бүх төрлийн сөрөг үр дагавраас мэдээлэгч этгээдийг хамгаалах)
- Зөвлөгөө, ойлголт, мэдлэг өгөх, үнэлгээ хийх (зөвлөгөө өгсөн талаар нууцлах

[317] Мөн тэнд, 404 дэх тал.

[318] Л.Отгондорж, Р.Пүрэвбаатар, "Дотоод мэдээлэгчийг хамгаалах зарим санал", Орчин үеийн эрх зүйн тулгамдсан асуудлууд, (Уб, 2015), 158 дахь тал.

[319] Д.Жаргалсайхан, "Шүгэл үлээх соёл", Шүүх эрх мэдэл №4, (Уб, 2016), 146 дахь тал.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mlsc.mn

/зөвлөгөө өгсөн төлбөрөөс чөлөөлөх/ үндэсний эрх зүйн зохицуулалтын үр нөлөөг үе шаттайгаар үнэлж байх)320

Дээрхээс үзвэл шүгэл үлээхийг төрийн болон хувийн хэвшил авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх, мөн нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа асуудалтай тэмцэхэд чухал бүрэлдэхүүн болохыг нь хүлээн зөвшөөрөх хандлага улам бүр нэмэгдэж байна.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал

Шүгэл үлээгчийг хамгаалах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилгоор дээрх тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийхэд дараах эрсдэл учирч болохоор байна. Үүнд,

- Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа хууль бус үйлдлийг илчилж үг хэлсэн, үйл ажиллагаа явуулсан, төрийн байгууллага, этгээдэд хандсаныхаа төлөө бусдын халдлага, дарамт шахалтад өртөх, гадуурхагдах;
- Бусдын зүгээс илчлэгч, гэрч, хохирогч, мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийн нэр төр, алдар хүнд, эрх чөлөө, эрүүл мэнд, аюулгүй байдалд нь халдах, цахим хэлбэрээр доромжлох, сэтгэл санааны дарамт үзүүлэх,
- Илчлэгч, гэрч, хохирогч, мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийн гэр бүлийн гишүүдийг хөнөөлтэй нөхцөл байдал, сүрдүүлэг, сэтгэл санааны болон бие махбодын дарамт, эрх чөлөө, амь зуулгад халдах;
- Нийгэмд шударга бус аливаа явдалтай тэмцвэл хохирдог гэсэн ойлголт нэмэгдсэнээр төрийн байгууллагын ажилтан, олон нийтийн төлөөлөл, хувь хүмүүс хууль бус үйлдлийг хараагүй мэт өнгөрүүлж, улмаар тэр үйлдэлд нь татагдан орох;
- Гадны хууль ёсны хөрөнгө оруулалт буурах, гадны хууль бус үйл ажиллагаа нэмэгдэх, улсын хөгжил, бүтээн байгуулалт нэмэгдэхгүй байх, улсын хөрөнгийг зүй бусаар зарцуулах нь нэмэгдэж алдагдалд орох;
- Төрийн байгууллагын хүнд суртал, авлига, хээл хахууль өндөр түвшинд шилжиж, сургуулийн багш болон бусад үйлчилгээний ажилтнуудын хууль бус жижиг үйлдэл халхавч болж буй байдал;
- Төрийн байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, эрх бүхий албан тушаалтны зүгээс хууль бус мэдээллээ нууцлах, мэдээллээр хангах үүргээ биелүүлэхээс татгалзах, зайлсхийх, мэдээллийг нуун дарагдуулах;

Эдгээр асуудлыг харгалзан судалгааны цар хүрээг өргөн хүрээнд авч үзэх нь тохиромжтой байна. Өөрөөр хэлбэл, шүгэл үлээгчийг хамгаалах нэгдсэн тогтолцоог хууль тогтоомжоор бий болгох замаар дээр дурдсан бүх асуудлыг шийдвэрлэх нь зүйтэй юм.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох[321]

Дээр тодорхойлсон цар хүрээтэй холбоотойгоор дараах нийгмийн бүлэг, бусад этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байна гэж үзлээ.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Нийгмийн бүлэг	Нийтийн ашиг сонирхлын төлөө үг хэлсэн, үйл ажиллагаа явуулсан болон бүхий л хэлбэрээр тэмцсэний төлөө нийгмийн бүлгийн хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж буй бодит эрсдэл байсаар байна.

320 Л.Галбаатар, Авлигатай тэмцэх үйл ажиллагаа ба шүгэлдэгчийн хамгаалалт /олон улсын туршлага/, АТГ-аас судалгаатай холбоотой явуулсан материалаас, (Уб, 2019), 6 дахь тал.

321 Аргачлалын 3.1.2-т зааснаар “эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийг тодорхойлохоор байгаа. Харин манай тохиолдол нь “аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээд”-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөөгүй тул энэхүү судалгааны 1.2 дахь хэсгийн нэршлээс эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөхгүй бүлгийг хассан болно.

2	Иргэн */18 наснаас дээш иргэний үнэмлэх авсан/*	Иргэдийн үндсэн эрх зөрчигдсөн, зөрчигдөхөөр нөхцөл байдал үүссэн, нийтийн ашиг сонирхлын төлөө хууль бус үйлдлийн үр дагаврыг багасгах, гэмт хэргийн талаар мэдсэн, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор гэрч, илчлэгч, мэдээлэгч (шүгэл үлээгч), байсны төлөө төрөөс шаардлагатай урамшуулал, хамгаалалтыг хийх явдал төдийлөн хангалттай бус байна.
3	Аж ахуйн нэгж, байгууллага	Аж ахуйн нэгжүүд хөгжлийн түвшин, хөрөнгө чинээ, тухайн аж ахуйн нэгжийн удирдлага, нийгэмд эзлэх байр сууриас шалтгаалан гадуурхалтад өртөх, хөрөнгөө алдах, дарамт шахалтад автах, хууль бус үйл ажиллагаанд нэгдэх, татагдан орох үйлдэл гаргах. Байгууллагын дотроос шүгэл үлээсэн бол тухайн байгууллагын нэр хүндэд халдахгүй байх, гэмт үйлдлийг таслан зогсоох, илрүүлэх явдлыг хангахын зэрэгцээ шүгэл үлээсэн этгээдийг төрөөс хамгаалах, урамшуулах механизмыг хэрэгжүүлэн ажлаас халах, хавчин гадуурхах, нэр хүндэд халдах явдлыг зогсоох.
4	Бусад этгээд	Хүүхэд /3-18 нас хүртэлх/ нийгмийн орчин нөхцөлд аливаа хэлбэрээр нийтийн ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гэмт хэрэг үйлдэгдэж буйг, үйлдэхээр завдаж буйг санамсаргүй байдлаар олж мэдсэнээс үүдэн гэрч, илчлэгч, мэдээлэгч (шүгэл үлээгч) болсон тохиолдолд хүчирхийлэл, дарамтад өртөх зэрэг хууль бус явдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, урамшуулах механизмыг бүрдүүлэх.

Ерөнхийд нь авч үзвэл шүгэл үлээгч нь нас хүйс, иргэний харьяалал, ажил мэргэжил зэргээс үл хамааран хүн бүр шүгэл үлээгч байх боломжтой тул нийтлэг байдлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх магадлалтай. Гэхдээ дээрх этгээдүүдийг хэд хэдэн бүлэгт нарийвчлан авч үзэх нь судалгааны ач холбогдолтой бөгөөд дээрх хүснэгтээр дэлгэрэнгүй тайлбарлалаа.

1.3. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд ил болгосныхоо төлөө тодорхой хувь хүн, бүлэг этгээд, аж ахуйн нэгж, албан тушаалтан, засаг захиргааны зүгээс ямарваа дарамт шахалтад өртөх, эрх чөлөөгөө хязгаарлуулах, хувь хүний эрх зөрчигдөх, хүчирхийлэлд өртөх улмаар үйл ажиллагаагаа хэвийн явуулж чадахгүйд хүрэх тохиолдол дэлхий нийтийн хэмжээнд байсаар байна.

Олон улсын судалгаанаас үзэхэд хувийн хэвшлийн салбарт үйлдэгдсэн луйврын хэргийн 45 орчим хувийг салбар дотроос мэдээлсэн мэдээлэлд тулгуурлан илрүүлсэн байдаг. Зохисгүй үйлдэл, гэмт үйлдлийг дотооддоо мэдээлэх буюу шүгэл үлээх боломжийг бүрдүүлж, хөхүүлэн дэмжихийн чухлыг эндээс харж болно.[322]

Монгол Улсад гэрч, илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах тухай эрх зүйн ойлголт хангалттай бүрдээгүй, түүний дотор албан тушаалтантай холбоотой болон нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчихөөр завдсан зэрэг асуудалд мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийн эрхийг хамгаалсан, улсад учрах байсан хохирлоос урьдчилан сэргийлсэн, хамгаалсан гэх мэт статистик мэдээг хөтөлдөггүй байна. Харин албан тушаалтантай холбоотой “авлигын асуудлыг шалгахаасаа илүү авлигын мэдээллийг хэн өгч байгааг шалгах”[323] тохиолдол байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12 дахь хэсэгт “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй.” гэж заасны дагуу хүний үндсэн эрх (1/амьд явах эрхтэй,..., 2/эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй, 3/хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах,..., 4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, ..., 5/өндөр наслах, ..., 6/эрүүл мэндээ хамгаалуулах, ..., 7/сурч

[322] Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Авлигатай тэмцэх гарын авлага, (Уб, 2018), 146 дахь тал.

[323] “Авлига бол байгалийн давагдашгүй хүчин зүйл биш” Авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн дарга Г.Баасангийн илтгэл. /2017.12.8/ https://www.youtube.com/watch?v=pblzYYtBWEs (Сүүлд үзсэн. 2019.10.31)

боловсрох..., 8/соёл, ..., бүтээл туурвих, ..., 9/...төрийг удирдах хэрэгт оролцох, ...сонгох, сонгогдох, 10/...эвлэлдэн нэгдэх, 13/халдашгүй, чөлөөтэй байх..., 14/... шүүхэд гомдол гаргах, ...хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, 15/шашин шүтэх, эс шүтэх, 16/итгэл үнэмшилтэй байх,..., 18/улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох,..., зэрэг) зөрчигдсөн бол төрийн байгууллага, албан тушаалтан хянан шийдвэрлэх үүрэгтэй.

Энэ тухай Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж заасан. Гэхдээ хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй байх тухай энэ зүйлийн 3 дахь хэсэгт заажээ.

Хүн эрх, эрх чөлөөтэй байх, нийгмийн хэв журмыг сахиулах, иргэн бүрийн журамт үүргээ[324] ("Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн, Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх, хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хуулиар ногдуулсан албан татвар төлөх, эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн.") биелүүлэх нөхцөл бололцоог бүрдүүлэхдээ төр нь иргэдийг мэдээллээр хангах, иргэд төрийн үйл ажиллагааны талаар мэдээлэлтэй байх (Арван зургадугаар зүйлийн 17-д "төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй." гэж зааснаар аливаа мэдээллийг хайх, хүлээн авах эрхтэй) үндсэн эрхийг эдэлдэг байна.

Ийнхүү хүний эрх, эрх чөлөөтэй байх явдал нь мэдээлэлтэй байсны үндсэн дээр хэрэгжиж, нийтийн эрх ашгийг хөндсөн үйл ажиллагааг төрийн албан тушаалтан, иргэдээс гаргаж буй явдлыг таслан зогсоох, учирч болох хор хохирлыг багасгах үүднээс төрийн байгууллагад хандсан гомдол, мэдээллийг хянан шийдвэрлүүлэх325 эрхтэй байхаар зохицуулсан нь "... төр, иргэн хоёрын хоорондын харилцааны хэлбэр, журмыг тодорхой болгож байгаагаар онцлогтой юм."[326]

Энэ нь нэг талаас иргэд төрийн байгууллага болон түүний албан тушаалтнуудын үйл ажиллагаанд хяналт тавьж, алдаа дутагдал, зөрчил гажуудлыг арилгах, нөгөө талаас өөрсдийн зөрчигдсөн эрхийг төрөөр хамгаалуулах, эцэст нь хууль ёс, нийгмийн дэг журмыг чандлан сахиулах олон талын ач холбогдолтой иргэн төр хоёрын харилцан тэгш эрх эдэлж, үүрэг хүлээх зарчмыг хангах нэг үндсэн хэрэгсэл[327], үндсэн эрх эдэлж болох субьектүүдийн хувьд амин чухал суурь процессын эрх"[328] юм.

Иргэдийн үндсэн эрхийг хангах Үндсэн хууль нь хууль зүйн шинжлэх ухааны салаа салбар бүртэй шууд болон дам холбоотой. Хууль тогтоомжийг судлах салбар, дэд хийгээд холимог салбар хэчнээн олон ч гэсэн тэр бүхнийг хөтлөн дагуулагч гол салбар нэг байдаг.[329] Хууль зүйн салбар бүрийг зохицуулсан нийт 9572 эрх зүйн акт эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн хүрээнд үйлчилж[330] байгаагаас мэдээ,

[324] Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйл. Төрийн мэдээлэл сэтгүүл. (Уб, 1992), №1.

[325] Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2016-2018), (Уб, 2019)

[326] Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2009), 88 дахь тал.

[327] Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2000), 108 дахь тал.

[328] А.Бямбажаргал, "Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийн хэрэгжилт, шинжилгээ" Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо, (Уб, 2014), 68 дахь тал.

[329] Б.Чимид. Үндсэн хуулийн мэдлэг. (Уб, 2008), 21 дэх тал.

[330] Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. /ХЗҮХ-ийн судалгааны тайлан. 2018 он./ http://nli.gov.

мэдээлэлтэй байх эрхийг хангасан зохицуулалтыг түүвэрлэн үзвэл;

Хууль 313,

Олон улсын гэрээ 152,

Улсын Их Хурлын тогтоол 103,

Засгийн газрын тогтоол 544,

Ерөнхийлөгчийн зарлиг 29,

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр 171,

Улсын дээд шүүхийн тогтоол 78,

Сайдын тушаал 116,

Засгийн газрын агентлагийн даргын тушаал 91,

Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр 29 нийт 1626 эрх зүйн акт байна.[331]

Нийтийн ашиг сонирхлын төлөө, аливаа төрлийн хохирол учруулж болзошгүй, эсхүл учруулсан зөрчлийн талаар мэдээлэх эрх[332] түүнийг хэрхэн хамгаалах талаар 250 гаруй[333] хуулиар зохицуулсан байна. Тухайлбал, Агаарын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.10-т "иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын явуулж байгаа үйл ажиллагаа нь агаар бохирдуулж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх түвшинд хүрсэн бол холбогдох байгууллагад шаардлага тавих, гомдол мэдүүлэх, мэдэгдэх" тухай заасан.

Амьтны тухай хуулийн 38 дугаар зүйлд "Зөрчил илрүүлсэн, мэдээлэл өгсөн иргэнийг урамшуулах" талаар зохицуулсан бол 38.1-т "Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдийг илрүүлсэн, илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн буюу түүний тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн хэмжээний 15 хувиар тооцож мөнгөн шагналыг сум, дүүргийн Засаг дарга олгоно" гэж зохицуулсан.

Ийнхүү урамшуулал, мөнгөн шагналын талаар зохицуулсан хэдий ч "Зөрчлийн тухай хууль"-аар[334] 150 нэгж буюу 150,000 төгрөгөөр иргэнийг торгож, түүнийхээ 15 хувьтай тэнцэх хэмжээний урамшууллыг олгохдоо зөрчил үйлдэгдсэн хойно илрүүлсэн тохиолдолд сум, дүүргийн Засаг дарга мөнгөн шагналыг олгох тухай зохицуулсан байна. Мөн мэдээлэл хүргэсэн хүнд хор хохирол учрах бол хэрхэн хамгаалах талаар зохицуулагдсан зүйлгүй байгаа нь энэ талаарх мэдээлэгчийг дэмжсэн зохицуулалт гэж үзэхэд хангалтгүй юм. Мөн нэн ховор амьтдыг хамгаалах тухай заасан боловч (4 дүгээр зүйлийн 4.1.3." нэн ховор амьтан" гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг) 7 дугаар зүйлийн 2-т төрийн захиргааны төв байгууллагын тусгай зөвшөөрлөөр зөвхөн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх зориулалтаар агнаж, барьж болох тухай, 7 дугаар зүйлийн 5-д Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн тохиолдолд агнаж болох тухай заажээ.

Байгаль орчинд үзүүлэх хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах зэрэг ирээдүйн ашиг сонирхлын үүднээс байгаль орчныг хамгаалахад хувь нэмрээ оруулж зөрчил гаргасан иргэн, ААН-ийг илрүүлэн, энэ талаараа гомдол, мэдүүлэг гарган мэдэгдсэн ч "Шүгэл үлээгч" /мэдээлэгч/-ийг урамшуулах, дэмжих, хамгаалах,

mn/?p=4961 (сүүлд үзсэн 2019.10.25)

331 Монгол Улс дахь мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын төлөвшил, чиг хандлага. Хууль дээдлэх ёс сэтгүүл. №72, (Уб, 2019)

332 Хуулийн төслийн нэрээр санал болгосон "Шүгэл үлээгч" /мэдээлэгч/ гэдэгтэй утга ижил зохицуулалт.

333 Мэдээлэл, мэдээлэх, мэдэгдэл үгийн хайлт. https://www.legalinfo.mn/advenced-search (сүүлд үзсэн 2018.10.22)

334 Зөрчлийн тухай хуулийн **7.6 дугаар зүйлд, Амьтны тухай хууль зөрчсөн бол хүлээлгэх хариуцлагын талаар заасан,** Төрийн мэдээлэл №24, (Уб, 2017)

цаашид учруулсан хохирлын хэмжээг тооцох, нөхөн төлүүлэх, төрөөс авах арга хэмжээний талаарх зохицуулалт, уялдаа холбоо хангалтгүй байна.

Нөгөө талаас төрийн байгууллагын талаар зохицуулсан хуулийн зохицуулалтаас авч үзвэл, Авто тээврийн тухай хуулийн 192 дугаар зүйлд "Авто үйлчилгээний байгууллага нь хэрэглэгчдэд үнэн бодит мэдээлэл өгөх" тухай заасан бол 21 дүгээр зүйлд "Захиргааны хяналтыг хэрэгжүүлэхдээ авто тээврийн хэрэгслийг ашиглах, тээвэрлэлтийн үйлчилгээг хэрэглэгчийн эрх ашигт нийцүүлэхтэй холбогдсон захиргааны хяналтыг авто зам, замын байгууламж, шатахуун, тосолгооны материалын чанар нь автотээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал[335], замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлж болох зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэл"-д хэрэгжүүлэхээр заасан. Энэ тухай иргэд гомдол, мэдээлэл, гаргадаг[336] хэдий ч чанар аюулгүй байдал төдийлөн хангалттай төвшинд хүрээгүй байна. Нийтийн эрх ашгийг хангах шаардлагатай тухай нийтэд мэдээлсэн ч ямар нэгэн эерэг хандлага бий болгох томоохон ажил хийгдэлгүй өдийг хүрсэн, мөн цаашид сайжруулах ямар нэгэн алхам хийлгүй өнгөрөх тусам улам бүр дордох аюултай юм.

Эрүүл мэндийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь хэсэгт "эрүүл мэндийг хамгаалах" гэж хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, эдийн засгийн цогц арга хэмжээг ойлгох тухай заасан бол 11 дүгээр зүйлийн 11.1.5 дахь заалтад эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиглэлээр идэвх, санаачилгатай ажиллаж байгаа хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах, сурталчлах ажлыг зохион байгуулах, 44, 45 дугаар зүйлд Эрүүл мэндийг хамгаалах, дэмжих тухай зохицуулалтыг тусгажээ. Гэвч хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулах замаар хүн амын эрүүл мэндийг эсрэг аливаа үйл ажиллагаа явуулсан, эмч, эмнэлгийн ажилтан ашгийн төлөө үйл ажиллагаа явуулсан[337] бол хүлээлгэх хариуцлагын тогтолцоо тодорхойгүй байдгаас ноцтой тохиолдол үүсэхгүй л бол хариуцлагад татагдахгүй, харин Эрүүгийн хуулийн хүний эрүүл мэндтэй холбоотой ноцтой гэмт хэрэг үйлдэгдсэн нь тогтоогдсон бол хариуцлага хүлээлгэх асуудал үүсэх юм. Үүнээс наана хүлээлгэх хариуцлагын тогтолцоо төдийлөн оновчтой бус, тодорхойгүй байна.

Гаднаас дотогшоо буюу гадаад орчинд иргэн, ААН, байгууллага, албан тушаалтан нийтийн ашиг сонирхлыг хөндсөн, хохирол учруулсан, зөрчил илэрсэн тухай зохих байгууллагад гомдол, мэдээлэл гаргасан нь хор хохирлыг багасгах арга хэмжээг авахуулах ашиг тустай бол төрийн байгууллага, албан тушаалтнаас нийтийн ашиг сонирхолд нийцэхүйц, учирч буй хор хохирлыг багасгах, хор хохиролгүй болгох, чанар аюулгүй байдлыг хангах, зөрчил дутагдлаа арилгахад чиглэсэн мэдээллийг дотроос гадагшаа мэдээлэх мэдээлэгч, түүний үйлдлийг дэмжсэн, хамгаалсан зохицуулалт хангалтгүй байгааг дээрх 3 хуульд хийсэн дүгнэлтээс харж болох юм.

Дээрх хуулийн зохицуулалтад Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх эсхүл Эрүүгийн хуулиар зохих хариуцлагыг хүлээлгэх талаар зохицуулсан нь албан тушаалтан, иргэдийн үйлдэлд гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр заажээ.

Төрийн албаны тухай хуулийн 32 дугаар зүйлд заасан "Хариуцлага"-ын талаарх зохицуулалтад Төрийн албаны төв байгууллагаас буруутай албан тушаалтныг

[335] Авлигаас төрдөг "Өшиглөсөн автобус" http://www.sonin.mn/news/gemt-hereg/99728, Гурван автомашин тутмын нэг нь бүрэн бус, техникийн шаардлага хангахгүй байна. http://www.zaluu.com/read/3452163dg, http://www.arslan.mn/economy/price/598980.shtml /сүүлд үзсэн 2019.10.22/

[336] Шатахууны чанар алдагдсаар 10 жил болж байна. http://www.arslan.mn/economy/price/598980.shtml /сүүлд үзсэн 2019.10.24/

[337] Шахааны Вакцинаа хэзээ зогсоох вэ? А.Цогцэцэг сайдаа https://updown.mn/4762.html http://www.arslan.mn/economy/price/598980.shtml /сүүлд үзсэн 2020.1.24/

үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг томилох эрх бүхий этгээдэд хүргүүлснээр мэдэгдлийг заавал биелүүлж, авсан арга хэмжээний талаар 14 хоногийн дотор хариу мэдэгдэх, хэрэв зөрчсөн тохиолдолд тухайн эрх бүхий этгээдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай заасан бол төрийн улс төрийн, төрийн тусгай албан тушаалтанд хүлээлгэх хариуцлага /огцруулах, түдгэлзүүлэх, цол бууруулах, г.м/ холбогдох хуулиар зохицуулагдах тухай заасан байна.

Зөрчлийн тухай хуулиар хүлээлгэх хариуцлагыг хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйд оногдуулахад чиглэсэн. Харин Эрүүгийн хуулиар хүлээлгэх хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх тухай зохицуулсан байна.

Гэвч нийтийн ашиг сонирхлын төлөө, аливаа төрлийн хохирол учруулж болзошгүй, эсхүл учруулсан аливаа зөрчлийн талаар “Шүгэл үлээгч” /мэдээлэгч/ гомдол, мэдээлэл гаргаснаар эцэст нь тухайн мэдээлсэн иргэн, албан тушаалтан, сэтгүүлчдийг нэр төр гутаасан, гэж үзэн шүүхээр хэргийг шийдвэрлэх явдал түгээмэл байдаг[338] нь энэ төрлийн хэргүүд нуугдмал, дарагдмал байдалд шилжсэн гэж үзэх үндэстэй болжээ.

Албан тушаалтны үйлдэлтэй холбоотой нуугдмал, дарагдмал хэргийг илрүүлэх гол салбар бол Авлигатай тэмцэх газар байх бөгөөд төр, түүний төлөөллийн байгууллагын албан тушаалтны үйлдэж буй нийтийн эрх ашиг, сонирхлын эсрэг үйлдэл буюу шударга бус аргаар (Монгол хэлний тайлбар тольд “ёсон бусаар шунаж авсан эд юм”), хууль зөрчиж өөрийн болон бусдын өмч хөрөнгийг арвижуулах, албан тушаалын давуу байдлаа ашиглан хөрөнгөжих[339]-д чиглэсэн, үйлдлээс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүрэг бүхий хараат бус, бие даасан, төрийн тусгай байгууллага юм.

Тус байгууллага нь нийтийн албан тушаалтантай холбоотой асуудлыг Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хуулиар зохицуулсныг баримтлан ажиллаж байна. Төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжоор хангах зорилгоор 2018 онд нийт мэдүүлэг гаргагчдын 2017 оны ХОМ-ын хураангуйг тус газрын цахим хуудсанд нээлттэй байршуулснаар иргэд мэдээлэлтэй танилцах, хяналт тавих нөхцөл байдал сайжирч төрийн албан хаагчдын шударга байдлын түвшинд эерэг хандлага үүсэх төдийгүй олон нийтийн зүгээс цахим системд хандан албан тушаалтны хөрөнгө, орлогын өсөлт, бууралтад дүн шинжилгээ хийж, нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх нөхцөл байдал нэмэгдсэн[340] байна.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтэс нь Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль болон бусад хуулийг баримтлан ажиллах ба иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж байгаа гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл 2016 оныхтой харьцуулахад 2 дахин өссөн, мөрдөн шалгах ажиллагааны явцад 146 үйлдэл, хэрэг шинээр илрүүлсэн үзүүлэлттэй байна. Мөрдөгч нарын ажлын ачаалал ихэссэнтэй холбоотой гэмт хэргийг шуурхай илрүүлэх боломж хязгаарлагдаж гэмт хэрэгтэнд ял завшуулах боломж олгох нөхцөл байдал үүсдэг байна.[341]

Хэдийгээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлж буй гэмт хэргийн

[338] Нүүдэл Шийдэл: Шүгэл үлээгч гэж хэн бэ? http://gogo.mn/r/215308 (сүүлд үзсэн 2019.10.24)

[339] Б.Батзориг, Ц.Цэлмэг нар. Авлига, албан тушаалын гэмт хэрэг, (Уб, 2014), 54 дэх тал.

[340] Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2016-2018 он, (Уб, 2019), 81 дэх тал.

[341] Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт 2016-2018 он. (Уб, 2019) 72, 84 дэх тал,

шинжтэй гомдол, мэдээлэл өссөн[342] (мэдээ, мэдээлэлтэй байх эрхийг хангасан 1600 гаруй эрх зүйн акт бий тухай дээр дурдсан), мөрдөн шалгах ажлын ачаалал ихэссэн байгаа ч Нийтийн ашиг сонирхлын эсрэг албан тушаалтан, иргэдийн хууль бус үйлдлийг мэдээлсэн нөхцөлд төрөөс урамшуулах, хамгаалах механизм хангалтгүй үйлчилж байгаа нь албан тушаалтан, иргэдийн хууль бус үйлдэл арга нь улам бүр нарийсан ард иргэд хохирсоор байна.[343] Гэмт хэргийг зөвхөн авлига, хээл хахуулийн шинжээр нь тодорхойлохоос илүүтэй бусад төрлийн нийгэмд аюултай, хор уршигтай, нийтийн эрх ашгийг хөндсөн, зөрчсөн тохиолдол бүрийг хууль сахиулах байгууллага, шүүх шалган тогтоох зайлшгүй шаардлага бий. Өөрөөр хэлбэл, төрийн алба хааж буй төрийн улс төрийн, төрийн тусгай, төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албан тушаалтантай холбогдох шалтгаан нөхцөлийг судлан нийтийн эрх ашгийг хөндсөн, зөрчсөн, зөрчихөөр завдаж буй тохиолдол буйг нотлох гэрч (Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 9.6 дугаар зүйлд "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нөхцөл байдлыг мэдэж байгаа хүнийг гэрч гэнэ." гэж заасан), хохирогч, илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг урамшуулан, хамгаалснаар төр иргэний хоорондын харилцааны хэлбэр сайжрах, шударга ёсны зарчим алдагдахгүй байх давуу талтай.

Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хууль, Прокурорын тухай зэрэг гэмт хэргийг илрүүлэх бүхий л үйл ажиллагаатай холбоотой хийгдэж буй ажиллагаатай зэрэгцэн илчлэгч, гэрч, мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийг урамшуулан, хамгаалах тогтолцоог хуулиар зохицуулахаас гадна бусад холбогдох хуулиудтай уялдуулах, зайлшгүй шаардлага бий. (Гэрч, хохирогчийг хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай, Хөдөлмөрийн тухай г.м нийгмийн бусад салбарын хуультай уялдуулан холбох) Цагдаагийн алба, Мөрдөх алба, Авлигатай тэмцэх газар, Тагнуулын ерөнхий газар зэрэг байгууллагыг гэрч, хохирогчийг хамгаалах тусгай нэгжийг байгуулан ажиллахыг заасан боловч тус нэгж нь дэргэдээ гэрч, хохирогчийг хамгаалалтад авах хамгаалах байргүй аюулгүй газарт түр байрлуулах хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэхэд зориулагдсан төсөвгүй зэрэг хүндрэлтэй нөхцөл байдал үүсдэг байна.[344]

Илчлэгч, гэрч, хохирогч, мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийг урамшуулах, хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг 1997 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу Засгийн газраас хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, ХЗДХЯ болон холбогдох яам агентлаг төрийн бусад байгууллага, захиргааны хяналтын албад эрхэлсэн асуудлынхаа хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд идэвхтэй оролцсон иргэд, тодорхой ажил зохиож, үр дүнд хүрсэн байгууллага, аж ахуйн нэгжийг нутгийн захиргааны болон цагдаагийн байгууллагыг урамшуулан ХЗДХЯ, сум, дүүргийн Засаг дарга,

---

[342] Хуулиар заасан авлига, ашиг сонирхолын зөрчил бүхий мэдээллийг мэдээлэх эрх, үүргийн талаарх зохицуулалтыг (*Авлигын эсрэг хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Энэ хуулийн 4.1-д заасан этгээд албан үүрэг гүйцэтгэх явцдаа олж мэдсэн авлигын талаарх мэдээллийг Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдээлэх үүрэгтэй", 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ хуулийн 8.1-д заасан мэдээлэх үүргийг хэрэгжүүлэхэд төр, байгууллага, хувь хүний нууцын тухай хуулиар тогтоосон хязгаарлалт хамаарахгүй" 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Иргэн, хуулийн этгээд авлигын асуудлаар Авлигатай тэмцэх газарт өргөдөл, гомдол гаргаж, мэдээлэл өгч болно.", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Ашиг сонирхлын зөрчил бүхий нөхцөл байдлын талаар мэдэж байгаа бусад этгээд энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд мэдээлж болно.", 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Албан тушаалтан бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нөлөөлсөн аливаа дарамт, шахалт, зохимжгүй нөлөөллийн талаар өөрийн удирдах албан тушаалтан, эсхүл эрх бүхий байгууллагад, хуулийн хариуцлага хүлээхээр бол Авлигатай тэмцэх газарт нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.") тусгаж өгсөн.*

[343] "Гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоо, түүний эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь" сэдэвт хэлэлцүүлэг, (Уб, 2016)

[344] ХЗДХЯ, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан. (Уб, 2018)

цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан шагнал олгодог байна.

Харин 2019 оны 6 дугаар сарын 6-нд батлагдан, 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хэрэгжих "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2-т "Иргэний өгсөн мэдээллийн дагуу зөрчилд 200 хүртэл нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол иргэнд тухайн шийтгэлийн 20 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний, 200-аас дээш нэгжээр торгох шийтгэл оногдуулсан бол 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно." гэж заасан.

Ийнхүү Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь илчлэгч, гэрч, хохирогч, мэдээлэгч (шүгэл үлээгч)-ийг урамшуулахаар зохицуулсан нь Засгийн газрын хүрээнд хэрэгжих, буюу Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээнд цагдаагийн газраас хэрэгжүүлж болох тухай зохицуулагдсан байна. Үүнд, Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил, Тагнуулын ерөнхий газрын урьдчилан сэргийлэх ажил төдийлэн хамаарахгүй юм.

Илчлэгч, гэрч, мэдээлэгч (шүгэл үлээгч), мэдээлсний улмаас хохирсон этгээдийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн мэдээллийн нэгдсэн системтэй байх гэмт хэрэг үйлдсэн бол нийгэмд буюу нийтийн ашиг сонирхолд учирч болох аюулын хэр хэмжээнээс хамаарч /авлигын шинжтэй бол/ төрийн өндөр албан тушаалд байх, энгийн иргэн байхаас үл хамааран ард иргэд, улс орны хөгжил, дэвшил сайн сайхан байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэн зөвхөн хууль бусаар олсон хөрөнгө хураах, хорих ялыг биечлэн эдлүүлэх нь зүйтэй юм.

Ийнхүү улсын тусгаар тогтнол, бүрэн эрх, халдашгүй дархан байдал, ард иргэдийн амгалан тайван байдал, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд төрийн албаны бүх шатанд нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчихийг завдсан этгээдийг мэдээлсний улмаас хохирсон хохирогч, илчлэгч, гэрч, шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхэд чиглэсэн хуулийн зохицуулалт, хууль хоорондын уялдаа холбоог хангах шаардлагатай байна. /Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг баримтлан Улсын Их Хурал, Ерөнхийлөгч түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хэрэгжүүлэх үндсэн ажил байх тул нэгдсэн тогтолцоонд оруулан журамлах/

Уг судалгааны хүрээнд, Монгол Улсын хувьд шүгэл үлээгчийн эрх зөрчигдөхөд дараах нөхцөлүүд нөлөөлж болохоор байна гэж үзлээ. Үүнд:

- Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн талаар тогтсон тодорхойлолт байхгүй;
- Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах явдлыг төрөөс тухайлан хуульчлаагүй.

Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөлийг бууруулахын тулд эхний ээлжид дурдсан асуудлыг шийдвэрлэх нь ач холбогдолтой болно.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол Улсад Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах талаар эрх зүйн зохицуулалт дутмаг байгаа нь илчлэгч, гэрч, шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрх зөрчигдөж байгааг өмнө хэсэгт дурдсан.

Хүний эрх, эрх чөлөөг хангахад чиглэсэн, хууль дээдэлсэн, шударга ёсыг сахиулах явдал нь төр, түүний төлөөллийн байгууллагын гүйцэтгэх үүрэг юм. Ийм байтал шударга бус, ёс суртахуунгүй байдлыг даамжруулсан, гадны улсын тогтолцоонд нийцүүлсэн, нийтийн эрх ашгийг хангахад төр, түүний төлөөллийн байгууллага, албан тушаалтны эрх ашиг сонирхлыг хангахад чиглэсэн, уялдаа холбоо муутай, эрх зүйн онол, хууль зүйн шинжлэх ухааныг буруутган, үгүйсгэсэн уламжлал, зан заншил, өөрийн улсын иргэдийн зан суртахуун, оршин тогтнох суурь болох онцлогийг судлалгүйгээр хууль батлагдаж байна. Иймд, даяарчлагдаж буй өнөөгийн нийгэмд өөрийн улсын байр суурийг бататгах, иргэдийн эрхийг

дээдлэх, шударга бус явдалтай тэмцсэн хууль тогтоомжийг батлан гаргах (энэхүү "Шүгэл үлээгч" /мэдээлэгч/-тэй холбоотой хуулийг батлан гаргах), эрх зүйн орчинг сайжруулах, хууль хоорондын уялдаа холбоог хангах нь чухал юм.

Монгол Улсын Ерөнхийлөгч 2018 онд зарлиг гарган, 2018-2019 оныг "Авлигаас татгалзах, илчлэх, авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жил" болгон зарлаж, Авлига, албан тушаалын гэмт хэрэг, зөрчлийг илрүүлж илчилсэн мэдээлэгчийг урамшуулах, хамгаалах, авлига, албан тушаалын гэмт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэрчийг хамгаалах зэрэг асуудалд тусгайлан анхаарч, хууль, эрх зүйн орчинг улам боловсронгуй болгох ёстойг тэмдэглэн, "Авлигын эсрэг хууль, тогтоомжийн хэрэгжилтийн үр нөлөөг судлан сайжруулах, авлигыг илрүүлж илчилсэн иргэнийг урамшуулах, хамгаалах, авлига, албан тушаалын гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа гэрчийг хамгаалах асуудлын хүрээнд хууль, тогтоомжийн хэрэгжилт, хэрэгцээ шаардлагыг үнэлэн судалж, эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээг цаг алдалгүй авах, эрх зүйн орчинг боловсронгуй болгох асуудлын хүрээнд авлига, албан тушаалын гэмт хэргийн гэрч, мэдээлэгчийг аюулгүй байдлын болон амьдрах нөхцөл, эдийн засгийн баталгаагаар хангах асуудлыг шийдвэрлэх, шүүх ажиллагааны аюулгүй байдлыг хангах, гэрч, хохирогчийг хамгаалах асуудлын хүрээнд төрийн байгууллагуудын чиг үүрэг, тогтолцоог улам боловсронгуй болгох" арга хэмжээ авч ажиллахыг УИХ, ЗГ-т зөвлөжээ.

Ийнхүү дээрх Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ-ын тогтоол, ЗГ-ын тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Авлигын хор уршиг, хохирлыг ухамсарлах, авлигаас татгалзах, авлигыг үл зөвшөөрөх үзлийг үйл ажиллагаандаа баримталж, түгээн дэлгэрүүлж ажиллахыг төрийн болон төрийн бус байгууллага, компани, аж ахуйн нэгжүүд, ард иргэдэд авлигын гэрч, мэдээлэгчийг хамгаалах жилийн хүрээнд бүх нийтээр авлигыг үл тэвчин, тухай бүр илчилж, гэм буруутай этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэхийн төлөө нягт хамтарч, нэгнээ дэмжин ажиллахаар зорьсон байна.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна.

Зорилго: "Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулах".

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, судалгаагаар тодорхойлсон "Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулах" зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эрэг өөрчлөлтийг харьцуулан дараах дүгнэлтийг гаргалаа.

Асуудлыг зохицуулж болох хувилбаруудын эрэг болон сөрөг тал

Хувилбар		Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ.	Үр дүн сөрөг

2	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгоо биелүүлэхэд зохих хэмжээгээр нөлөөлөх боломжтой. Гэвч өнөөгийн тулгамдаж буй бэрхшээлийг үр дүн сайтай шийдвэрлэх боломжгүй буюу асуудал цаашид хэвээр үргэлжилнэ.	Зардал ихээхэн хэмжээнд шаардагдах бөгөөд ухуулга сурталчилгааг байнга идэвхтэй явуулахыг шаардана. Асуудлыг үүсгэх гол шалтгааныг арилгаж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдээр одоо байгаа зохицуулалтыг тодорхой түвшинд дэмжих, сайжруулах боломжтой болно.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалахад тодорхой санхүүжилт шаардлагатай ч хууль тогтоомж, эрх зүйн орчин сайжруулахгүйгээр бүрэн шийдвэрлэх боломжгүй.	Дан ганц санхүүжилтээр сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
5	Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх	Илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс хамгаалах ажиллагаанд төрийн бус байгууллагын оролцоог дэмжих нь чухал ач холбогдолтой ч өнөөдрийн хууль тогтоомжийн хүрээнд төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэх шаардлага ажиглагдахгүй байна.	Иргэний нийгмийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэхэд зохих хэмжээний зардал гарах боловч үр ашгаа өгнө.	Зарим үр дүн гарах боловч зорилгоо хүрч чадахгүй
6	Захиргааны шийдвэр гаргах	Илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах үйл ажиллагаа нь өргөн хүрээтэй ойлголт тул салбар бүрт зохицуулалт хийх шаардлагыг бий болгодог. Иймд тус суурь харилцааг хууль тогтоомжоор хуульчлан баталгаажуулах нь оновчтой. Зөвхөн захиргааны шийдвэрээр зохицуулах нь зохицуулалтын түвшин харилцан адилгүй, үр өгөөжгүй болох талтай.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад тухайлсан тохиолдолд нөлөөлөх боломжтой, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Зарим үр дүн гарах боловч зорилгодоо хүрч чадахгүй
7	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хүний эрхийг хангах, хамгаалах тогтолцоог сайжруулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой, тогтвортой болгох хувилбар байна.	Зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй арга зам юм.	Зорилгодоо хүрэх боломжтой, үр дүнтэй

Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс санхүүгийн интервенц хийх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж,

ХУУЛЬ ЗҮЙН ЯАМНЫ ХУРЭЭЛЭН www.mojha.gov.mn

дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй байна.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн холбогдох харилцааг өргөжүүлэх, чанар, үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд "Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах" хуулийг төсөл хэлбэрээр боловсруулахдаа одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид тусгагдсан нийтийн ашиг сонирхолыг хохироосон, хохирох бодит нөхцөл бүрдсэнээс үүдэлтэй хамгаалах, урамшуулах, шагнал олгох, зэрэгтэй холбоотой хууль хоорондын уялдаа холбоог хангах, хариуцлагыг оновчтой ногдуулан, хуулийн хэрэгжилтийг хангах нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулах саналыг хуулийн төслийн хамт боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Ингэхдээ "Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулах" зорилгын хүрээнд дараах боломжит зохицуулалтын 2 хувилбарыг дэвшүүллээ.

1/ Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах тогтолцоог сайжруулан уялдуулах;

2/ Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчихөөр завдсан тохиолдолд хуулиар хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах.

Зорилгод хүрэх байдал

Хувилбар 1. Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдүүлэх, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, урамшуулан хамгаалах нэгдсэн тогтолцоо нь хуулийн хүрээнд үйлчилснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшлэх юм. Төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдүүлэн нэгдсэн тогтолцоо хуулийн зохицуулалт, хууль хоорондын уялдаа холбоог сайжруулан, тодорхойлох шаардлагатай байна.

Мэдээлэл олж авах, дамжуулах, түгээх түүний аюулгүй байдал хангагдаж байгаа эсэхэд эргэлзээ төрөх, ард түмэнд үйлчлэх төрийн үйлчилгээ хэнд үйлчилж байгаа нь тодорхойгүй байх нь эрүүл нийгэм оршин тогтнох боломжгүй төдийгүй иргэдийн мэдээллийн эрх хангагдах боломж хязгаарлагдаж байна. Иргэдийн "Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө бол түүнгүйгээр хүн хэвийн амьдарч чадахгүй, нийгэм эрүүл саруул оршин тогтнож, үйл ажиллагаагаа явуулж чадахгүй тийм орчин юм." гэж Академич Ж.Амарсанаа хэлжээ.

Хүний итгэл үнэмшилтэй байх, түүнийгээ чөлөөтэй илэрхийлэх үндсэн эрхийг үндсэн хуульдаа тусгаж өгснөөрөө "...засаг төрийн бодлого, үйл ажиллагааг хянаж цэгнэж, дэмжих эсэхийн дэнсэн дээр шүүн тунгааж, шүүмжилж байгаа..." нь "засаг төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд оршин байгаа нуугдмал хийгээд өнгөлөн далдлагдсан хэлбэрээр илэрдэг аливаа зөрчил, гэмт хэрэг, бусармаг явдлыг чухамхүү үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үүний тул үг хэлэх, хэвлэн нийтлэх, замаар илчлэх бүх нийтийн анхааралд толилуулан, олон түмний хараа хяналтад оруулж баймааж нийгмийн өвчнийг анагааж, эрүүл саруул орчин бий болгоно."[345] гэсэн нь засаг төрийн бодлого үйл ажиллагааны ил тод байдлыг хангахын зэрэгцээ иргэдийн итгэл үнэмшилтэй, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх үндсэн дээр мэдээлэл авах эрхийг хангахын зэрэгцээ аюулгүй байдлаа ханган хэрэгжүүлэх нь эрүүл саруул нийгэм оршин тогтнох үндэс байх тухай илэрхийлсэн байна.[346]

[345] Чимид.Б, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө. "Сэтгүүлч ба хуульч" цуврал сэтгүүл №3, Уб., (2001),

[346] П.Амаржаргал, Э.Уянга, Монгол Улс дахь мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын төлөвшил, чиг хандлага. Хууль дээдлэх ёс сэтгүүл. №72, (Уб, 2019)

Үндэсний аюулгүй байдлын тухай 2001 оны хуулиар мэдээллийн аюулгүй байдлыг /Мэдээлэгч, шүгэл үлээгчийн аюулгүй байдлыг хангах ажил нэг хэсэг нь болох юм./ үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэгт оруулж үйл ажиллагааны үндсэн зарчим, үндэсний аюулгүй байдлыг хангахад аж ахуйн нэгж, байгууллага, иргэний оролцоог тодорхойлж, үндэсний аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагааг уялдуулахаар зохицуулсан. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-д Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын цогц бодлого нь харилцан уялдаатай хангагдсанаар баталгаажих тухай заасан байдаг.

Мэдээллийн аюулгүй байдлын бодлого нь оршин тогтнохуйн, эдийн засгийн, хүрээлэн байгаа орчны, хүний, дотоод аюулгүй байдалтай харилцан уялдаатай байх зарчмыг баримтлах бөгөөд нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахтай салшгүй холбоотой.

Нийтийн ашиг сонирхлын төлөө мэдээлэл өгч буй иргэнийг урамшуулах ажлыг дээр дурдсан Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх тухай хууль, бусад хууль тогтоомжид зааснаар хэрэгжүүлэх боломжтой байгаагаас гадна хэрэгжилтийг ханган ажиллах бусад холбогдох төрийн байгууллагын төсөвт суулгаж өгснийг нэмэгдүүлэх, мөн дутагдалтай байгаа харилцааг Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах хуулийг батлан гаргаснаар бусад холбогдох хуулийн зохицуулалтад нэмэлт, өөрчлөлтөөр оруулж өгөх нь зүйтэй байна.

Нийтийн ашиг сонирхлын төлөө, аливаа төрлийн хохирол учруулж болзошгүй, эсхүл учруулсан аливаа зөрчлийн талаар "Шүгэл үлээгч" /мэдээлэгч/ гомдол, мэдээлэл гаргаснаар эцэст нь тухайн мэдээлсэн иргэн, албан тушаалтан, сэтгүүлчдийг нэр төр гутаасан, гэж үзэн шүүхээр хэргийг шийдвэрлэх болсон нь Монгол Улсад олон жил Эрүүгийн хуулиар гүтгэлэг, доромжлолыг гэмт хэрэгт тооцож ял шийтгэж ирсэн байдаг. 2015 оны шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиас халсан нь үзэл бодлоо илэрхийлэх, үг хэлэх эрх чөлөөг хамгаалахад чухал нөлөөлсөн хэдий ч 2017 оны Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 21 дүгээр зүйлд "1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндийг гутаан доромжилсон худал мэдээллийг нийтэд дэлгэсэн, эсхүл мэдээллийн хэрэгсэл, нийтийн сүлжээгээр тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно." хэмээн хуульчилж өгсөн бөгөөд ажил хэргийн нэр хүнд гэх ойлголтыг оруулж өгсөн нь зөрчлийн хүрээг өргөжүүлсэн зохицуулалт[347]-тай холбоотой юм.

Ингэснээр албан тушаалтнууд гүтгэх, доромжлох гэмт хэрэгтэй адилхан гүтгэх зөрчлийг өөрсдийн эсрэг эсхүл нийтийн ашиг сонирхлын төлөө шүүмжийг хааж бооход ашиглах эрсдэл хэвээр байна. Мөн Зөрчлийн хуулиар гүтгэсэн гэж их хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл хүлээлгэх боломж нь үзэл бодлоо илэрхийлэх болон хэвлэн нийтлэх эрх чөлөөг эдлэхэд айдас төрүүлдэг. Их хэмжээний торгууль төлөх айдас нь нийтийн ашиг сонирхолтой холбоотой асуудлыг хэвлэх, мэдээлэхээс хэвлэлийнхэн татгалзахад хүргэнэ.[348] гэж үздэг байна.

Мэдээллийг худалдаж авах ажлыг дэмжин үүрэгжүүлэх, мэдээлэл өгсөн иргэн аж ахуйн нэгжид эрсдэл бий болохоос урьдчилан сэргийлэх, тухайн иргэнд ноцтой хохирол учирч болохуйц нөхцөл байдал үүссэн, үүсч болох нь тогтоогдсон тохиолдолд хамгаалах ажил нь Авлигатай тэмцэх газар, Цагдаагийн байгууллага, Тагнуулын байгууллагын үндсэн ажил байхаар зохицуулах шаардлагатай юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн[349] 13.1 дүгээр зүйлд зааснаар

[347] Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пактын 19 дүгээр зүйлтэй үндэсний хүчин төгөлдөр хууль тогтоомж нийцэж байгаа эсэх болон тэдгээр хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ. ХЗДХЯ-ХЗҮХ., 2019 он.

[348] О.Мөнхсайхан, Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд нийцүүлэн гүтгэлгийг зохицуулах нь, Эрх зүй сэтгүүл, 2017 он, №2, 25 дахь тал.

[349] Төрийн мэдээлэл эмхэтгэл. 2017 он, №23

хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд мөрдөгчийн санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн прокурор, шүүхийн шатанд прокурорын санал, гэрч, хохирогч, өмгөөлөгчийн хүсэлтийг үндэслэн шүүгч аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх, хэрэгжүүлэх шийдвэр гаргахаас гадна гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах талаар тодорхой шийдвэрүүдийг гаргадаг байна.

Гэмт хэргийн нөхцөл байдлаас үүдэн гэрч, хохирогчийн эрүүл мэнд, амь насанд заналхийлэл учирсан тохиолдолд, учирч болох эрсдэл бий болсон бол хамгаалалтад авахуулах хүсэлтээ эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд гаргах эрхтэй тул тухайн иргэн хэрэг шалгаж буй хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч болон өмгөөлөгчөөрөө дамжуулан хүсэлт гаргах боломжтой. Хүсэлтийг хүлээн авсан хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч гэмт халдлага үйлдэх бодит нөхцөл байдал, аюулын эрсдэлийн түвшинг тогтоож, эрсдэлтэй түвшинд байна гэж үзвэл хамгаалалтад авах саналаа прокурор, шүүгчид гаргадаг.[350]

Прокурор, шүүгчийн шийдвэрийн дагуу ЦЕГ-ын дэргэдэх Гэрч, хохирогчийг хамгаалах хэлтэс аюулгүй байдал хамгаалалтын арга хэмжээгээ хэрэгжүүлж, гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, туслалцаа дэмжлэг үзүүлэх ажлыг хийдэг.[351] Гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндэд заналхийлсэн, халдахаар завдсан, бэлтгэсэн, халдлага бодитой эхэлсэн тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага албан тушаалтан хуульд заасан хамгаалалтын арга хэмжээг шийдвэр гаргахыг хүлээхгүйгээр хэрэгжүүлж, шийдвэр гаргуулахаар шүүхэд даруй хандах үүрэгтэй байна. Үүнд, шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн эрхийг хамгаалах асуудлыг нэмж тусгах, байгууллагыг нэмэгдүүлэн Авлигатай тэмцэх газар, Тагнуулын байгууллагад гэрч, шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах ажиллагаа хийгддэг байх шаардлагатай байна.

Хувилбар 2. Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчихөөр завдсан тохиолдолд хуулиар хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах.

Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчихөөр завдсан тохиолдолд хуулиар хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэх эсхүл Эрүүгийн хуулиар зохих хариуцлагыг хүлээлгэх талаар зохицуулсан нь албан тушаалтан, иргэдийн үйлдэлд гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуулиар хариуцлага хүлээлгэх талаар заасан, мөн томилох эрх бүхий этгээд үүрэгт ажлаас нь чөлөөлөх мэдэгдлийг хүргүүлдэг. Ийнхүү тухайн эрх бүхий этгээдийг үүрэгт ажлаас нь чөлөөлөхдөө төрийн улс төрийн, төрийн тусгай албан тушаалтанг огцруулах, түдгэлзүүлэх, цол бууруулах, гэх мэт хариуцлага нь холбогдох хуулиар зохицуулагддаг байна.

Зөрчлийн тухай хуулиар хүлээлгэх хариуцлагыг хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйд оногдуулахад чиглэсэн. Харин Эрүүгийн хуулиар хүлээлгэх хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх тухай зохицуулагдсан хэдий ч албан тушаалтны үйлдэлтэй холбоотой нуугдмал, дарагдмал хэргийг илрүүлэх гол салбар болох Авлигатай тэмцэх газраас хууль зөрчиж өөрийн болон бусдын өмч хөрөнгийг арвижуулах, албан тушаалын давуу байдлаа ашиглан хөрөнгөжихөд чиглэсэн, үйлдлээс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт явуулах, хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Ийнхүү нийтийн албан тушаалтантай холбоотой асуудлыг холбогдох хуулиар шалган албан тушаалтны хөрөнгө, орлогын өсөлт, бууралтад дүн шинжилгээ хийж,

[350] "Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх үнэлгээний тайлан. ХЗДХЯ-ХЗҮХ.,2018 он. /11 дэх тал/

[351] Цагдаагийн ерөнхий газрын хэвлэл, мэдээллийн төвийн мэдээ. http://www.police.gov.mn/a/2435 (сүүлд үзсэн: 2018.08.23)

нуугдмал эд хөрөнгийг илрүүлэх, төрийн албаны ил тод байдал, төрийн албан хаагчийн хариуцлагатай, шударга байдлыг хангах, олон нийтийг мэдээлэл авах боломжоор хангаж буй ч өндөр түвшний авлигыг илрүүлэх, ногдуулах хариуцлагын хэмжээ төдийлөн хангалттай бус байгааг "Шүгэл үлээгч" /мэдээлэгч/-тэй холбоотой хуулийг батлан гаргаж, нийгмийн хандлагыг авлигын эсрэг чиглүүлэх, Эрүүгийн хуулиар оногдуулах ялын хэмжээг торгуулиар шийдвэрлэх бус харин заавал биеэр эдлүүлэх тухай, хууль бусаар олсон хөрөнгийг хураан төрийн өмч болгох зэргээр эрх зүйн орчинг сайжруулах өнөөгийн тулгамдсан асуудал юм.

Зардал, үр өгөөжийн харьцаа:

Нийтийн ашиг сонирхлын төлөө илчлэгч, шүгэл үлээгч /мэдээлэгч/, гэрчийг төрөөс урамшуулах, хамгаалах тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах нөхцөл, боломж бүрдүүлэх, тогтолцоог сайжруулан уялдуулах, хүлээлгэх хариуцлагыг оновчтой зохицуулан нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, хүлээлгэх хариуцлагыг оновчтой ногдуулах хувилбаруудад зардал гарах боловч асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг шийдвэрлэхэд хамгийн үр дүнтэй арга зам юм. Иймд цаашид Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу хуулийн төслийн зардал тооцох аргачлалын дагуу зардлыг тооцон гаргах нь үр дүнтэй юм.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгон авсан зохицуулалтын хувилбарын үр нөлөөг дараах шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлсэн болно.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Дэвшүүлсэн зохицуулалтын хувилбаруудыг ерөнхийд нь авч үзвэл, нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчихөөр завдсан этгээдийг зохих байгууллагад шүгэл үлээх /мэдээлэх/ нь төрийн урамшуулал, хамгаалалтад хамрагдан хүний эрхийг хангах, хамгаалах, хариуцлага тооцох механизмыг сайжруулахад чиглэснээрээ тодорхой үр дүн гарч болно гэж үзэж байна.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Зохицуулалтын хувилбарууд нь дотоод болон дэлхийн зах зээлийн өрсөлдөх чадварт нөлөөлнө. Авлига, төрийн өндөр түвшний хээл хахууль болон нийтийн эрх ашгийг зөрчсөн явдлыг илрүүлэн эрүүл нийгмийг бий болгох нь хүний тэгш эрхийг хангахын зэрэгцээ улсын эдийн засагт сайнаар нөлөөлөх давуу талтай.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Нийгэмд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэхгүй. Харин хүний эрх тэгш байх эрхийг хангах, хүний эрхийг хангах, хамгаалах нь хууль дээдлэх зарчимд нийцсэнээр эерэг нөлөө үзүүлэх боломжтой.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчныг хамгаалан хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах нь эерэг нөлөө үзүүлнэ.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид 2005 онд нэгдэн орж, Улсын Их Хурал соёрхон баталсан. Тус конвенцын 33 дугаар зүйлд "Оролцогч улс бүр энэхүү конвенцын дагуу тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалахаар заах талаарх зохих арга хэмжээг өөрийн дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэн оруулах асуудлыг авч

Хуулийн үндэсний хүрээлэн www.jl.gov.mn

үзнэ.” гэж тунхагласан.[352] Монгол Улс гишүүн орны хувьд мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх үүргийг хүлээж байгаа юм. Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгон хуулийн төслийг 2019 онд УИХ-д өргөн барьсан байх тухай Засгийн газраас авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаж өгсөн байгаа явдал нь НҮБ-ын конвенцын зарчимд нийцэж байна.

Энэхүү үндэслэл нь бусад хууль тогтоомж, бодлогын баримт бичгийг боловсруулах суурь болж, хүний эрхийг хангах, хамгаалах үүргийг төр хүлээдэгтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлага тулгараад байна.

Аргачлалын 6-д заасны дагуу сонгон авсан хуулийн төсөл боловсруулах хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг Хавсралт 1-ийн 1, 2, 3, 4 дүгээр хүснэгтээс үзнэ үү.

ТАВ.ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Дэлхийн 30 гаруй орон шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог нэвтрүүлээд байна. Тэдгээрийн зарим нь шүгэл үлээгчийг хамгаалах заалтуудыг Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Эрүүгийн хууль, Авлигын эсрэг хуульд тусгаж өгсөн байдаг бол цөөн орон шүгэл үлээлтийн тухай бие даасан хууль баталсан байна.[353] Шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан хуулийн зохицуулалтын хамрах хүрээ нь зарим оронд төрийн албан хаагчдаас гадна хувийн секторын ажилтнуудыг багтаасан байна. Тухайлбал, Англи, Франц, Норвеги гэх мэт улсуудад төрийн албаны болон хувийн секторын шүгэл үлээгчийг нэг хуулиар хамгаалсан байдаг бол заримд нь (АНУ, Австрали гэх мэт) тусдаа хуулиар хамгаалдаг байна. Мөн түүнчлэн холбооны улсууд нь төрийн болон хувийн сектор дахь шүгэл үлээлтийн тусдаа эрх зүйн зохицуулалттай байхаас гадна төрийн албаны өөр өөр түвшинд ялгаатай зохицуулалттай байх хандлагатай байна.[354]

Ерөнхийдөө шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоотой орнуудын эрх зүйн зохицуулалт нь дараах 2 үндсэн санааг агуулдаг. Нэгдүгээрт, идэвх санаачилга гарган байгууллага доторх зүй бус үйлдлийн талаарх мэдээллийг илчлэхийг дэмжих болон боломжийг нэмэгдүүлэх зэргээр байгууллагын соёлыг өөрчлөх, хоёрдугаарт, ажилтнууд эрсдэлээс айхгүйгээр зүй бус үйлдлийг илчлэхэд зориулсан үе шаттай хамгаалалт болон урамшууллыг бий болгох зэрэг юм.[355]

Их гүрнүүд авлигатай тэмцэх үйл ажиллагаанд шүгэл үлээгчийн оролцоо чухал нөлөө үзүүлж байгааг ухамсарлан хамтарсан уулзалтаар ториалга дэвшүүлж, шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах тогтолцоог эрчимтэй нэвтрүүлж байна. Тухайлбал, 2010 онд Сөүл хотноо болсон Их 20-ын төрийн тэргүүн нарын уулзалтаар шүгэл үлээгчийг хамгаалах нь дэлхий дахины авлигын эсрэг хөтөлбөрийн хамгийн чухал хэсгүүдийн нэг болохыг хүлээн зөвшөөрч, “Их 20-

[352] Авлигын эсрэг НҮБ-ын конвенцийг соёрхон батлах тухай. https://www.legalinfo.mn/annex/details/6492?lawid=10269 (сүүлд үзсэн 2019.10.15)

[353] Banisar, David, “Whistleblowing: International standards and developments.” Corruption and transparency: Debating the frontiers between state, market and society, I. Sandoval, ed., World Bank-Institute for Social Research, UNAM, Washington, DC (2011), p.2.

[354] Loyens, Kim, and Wim Vandekerckhove. “Whistleblowing from an international perspective: A comparative analysis of institutional arrangements.” Administrative Sciences 8, no.3. (2018), p.5.

[355] Banisar, David, “Whistleblowing: International standards and developments.” Corruption and transparency: Debating the frontiers between state, market and society, I. Sandoval, ed., World Bank-Institute for Social Research, UNAM, Washington, DC (2011), p.2.

ын Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний 7 дугаар хэсэгт дараах байдлаар тодорхойлсон байна:

Авлигын сэжигтэй үйлдлийг сайн санааны үндсэн дээр мэдээлсэн шүгэл үлээгчийг ялгаварлан гадуурхах болон залхаан цээрлүүлэх үйлдлээс хамгаалахад “Их 20”-ын улсууд 2012 оны эцэс гэхэд шүгэл үлээгчийг хамгаалах хууль дүрэм баталж хэрэгжүүлнэ.[356]

Мөн түүнчлэн 2019 онд Японы Осака хотод зохион байгуулагдсан Их 20-ын уулзалтад “Их 20 Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө 2019-2021”-г хэрэгжүүлэхэд зориулж шүгэл үлээгчийг үр дүнтэй хамгаалах дээд түвшний зарчмуудыг баталсан.[357] Эдгээр зарчмууд нь шүгэл үлээгчийг хамгаалах хууль тогтоомжийг баталж нэвтрүүлэхэд жишиг болохуйц сайн туршлага дээр тулгуурласнаас гадна “Transparency International” байгууллагаас гаргадаг олон улсын зарчимд нийцсэн байна.[358] Улс орнууд өөрсдийн улс төр, нийгэм, соёлын онцлогийг харгалзан эдгээр зарчмуудаас тохируулан авч, шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоогоо бий болгох боломжтой.

“Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)”-ын гишүүн орнууд дунд шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан хуультай улс 2010 оноос хойш олширсон. Тус байгууллагын 2014 оны санал асуулгаар нийт гишүүн орнуудын 84 хувь нь төрийн алба дахь шүгэл үлээгчийн эсрэг цээрлүүлэлтээс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдээллийг дэмжихтэй холбоотой бусад салбарын хуулийн заалт болон бие даасан хууль баталсан байна. Хэд хэдэн салбар хуулиар шүгэл үлээгчийг хамгаалах нь түгээмэл байгаа ба энэ нь шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан хуультай харьцуулахад хамгаалах тогтолцоо тодорхой бус, мөн хамрах хүрээ хязгаарлагдмал байна.[359]

Энэхүү харьцуулсан судалгаанд шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн тогтолцооны хувьд бусад улсад жишиг болсон, олон жилийн туршлагатай, бие даасан хуультай Америкийн Нэгдсэн Улс (АНУ), Их Британи, Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (ӨАБНУ), Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) зэрэг улсуудыг авч үзлээ.

АНУ-ын хувьд нийтийн эрх ашгийн төлөө мэдээлэл ил болгогчийг ялгаварлан гадуурхах болон залхаан цээрлүүлэхээс хамгаалсан цогц эрх зүйн тогтолцоотой, мөн олон жилийн туршлагатай орон юм. Тухайлбал, холбооны засгийн газрын ажилтны шүгэл үлээх эрхийг хамгаалсан бие даасан акт 1989 онд батлагдаж байсан бол санхүүгийн салбар дахь шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоо 2002 онд “Олон нийтийн компанийн тайлан тооцооны шинэтгэл ба хөрөнгө оруулагчийг хамгаалах акт (Sarbanes-Oxley)” батлагдсанаар эхэлсэн. Мөн шүгэл үлээгчийг хамгаалах заалтууд АНУ-ын гол гол хууль тогтоомжуудад багтсан. Жишээлбэл, “Волл стрийтийн шинэтгэл ба үйлчлүүлэгчийг хамгаалах акт 2010 (Dodd-Frank)”, “Өвчтөнийг хамгаалах ба эрүүл мэндийн үйлчилгээний хөнгөлөлтийн акт (Obamacare)” гэх мэт.[360]

2010 онд Европын Парламентын хурлаас баталсан шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах 1729 дугаар тогтоолоор гишүүн орнуудыг өөрсдийн хууль тогтоомжийг шүгэл үлээгчийг хамгаалах талаас нь дахин авч үзэж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулахыг уриалсан.[361] Эдгээр орнуудаас Их Британи Улс нь анх 1998

[356] G20 Seoul Summit 2010, G20 Anti-Corruption Action Plan, 2010, p.2.

[357] Full text of the G20 Osaka leaders’ declaration, Сүүлд үзсэн огноо: 2019-10-24, https://www.japantimes.co.jp/news/2019/06/29/national/full-text-g20-osaka-leaders-declaration/#.XarYzugzbIU.

[358] Four ways the G20 can take the lead on anti-corruption, Сүүлд үзсэн огноо: 2019-10-25, https://www.transparency.org/news/feature/four_ways_the_g20_can_take_the_lead_on_anti_corruption.

[359] OECD, Committing to Effective Whistleblower Protection, 2015, p.2.

[360] Piper, D. L. A. “Whistleblowing: An employer’s guide to global compliance.” (2013), p.9.

[361] Protection of “whistle-blowers”, Parliamentary Assembly, 2010, Сүүлд үзсэн огноо: 2019-10-25, http://assembly.coe.int/nw/xml/XRef/Xref-XML2HTML-en.asp?fileid=17851.

онд шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоог нэвтрүүлсэн ба 2013 онд хамгаалах бодлогыг илүү тодорхой болгосноор өдгөө бусад гишүүн орнууддаа шүгэл үлээгчийг хамгаалах тогтолцоогоороо үлгэр жишээ болж байна.[362]

Харин ӨАБНУ-ын хувьд Африк тивд шүгэл үлээгчийг хамгаалах өргөн хүрээний болоод дэвшилттэй тогтолцоог нэвтрүүлснээрээ манлайлж байна. Тус улс нь 2000 онд шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан хууль болох "Мэдээлэл илчлэлтийг хамгаалах акт"-ыг баталсан ба уг хуулиар мэдээлэл илчлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлсэн.

Ази тивд шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан хуультай орнууд цөөнгүй байгаагаас БНСУ-ын "Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай акт"-ыг уг судалгаанд авч үзэв. Тус улс нь 2001 онд "Авлигын эсрэг акт"-ыг баталж төрийн албан дахь шүгэл үлээгчийг хамгаалж эхэлсэн. Харин 2011 онд "Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай акт"-ыг баталж 2014, 2015, 2017 онуудад өөрчлөлт оруулсан байна.

"Transparency International" байгууллагын "Шүгэл үлээлтийн хууль тогтоомжид зориулсан сайн туршлага" гарын авлагад дурдсанаар улс орнууд шүгэл үлээлтийн тухай хууль тогтоомжид дараах гол асуудлуудыг тусгадаг байна. Үүнд: шүгэл үлээлтийн тодорхойлолт, хуулиар хамгаалагдах этгээдүүд, ил болгох мэдээллийн хамрах хүрээ, мэдээлэл дамжуулах суваг буюу мэдээлэл хүлээн авагч, дэмжлэг болон урамшуулал, хамгаалах механизм гэх мэт.[363] Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хуулийн зарим харьцуулсан судалгаанд "хамгаалагдах этгээд, хамгаалалтын хүрээ, мэдээлэх суваг, хууль сахиулах механизм, урамшуулал ба мөнгөн шагнал" гэсэн хүрээнд харьцуулалт хийсэн байна. Иймээс энэ судалгаанд сонгон авсан улсуудын шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг дараах хүрээнд харьцуулсан:

- Шүгэл үлээгчийн тодорхойлолт;
- Зохицуулалтаар хамгаалагдах этгээд;
- Мэдээллийн хүрээ;
- Мэдээлэл хүлээн авагч;
- Урамшуулал ба нөхөн олговор;
- Хамгаалах механизм.

5.1. Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

АНУ нь шүгэл үлээлтийн болон шүгэл үлээгчийг хамгаалах тухай холбооны болон мужийн түвшинд хэдэн арван хууль ба агентлагтай орон юм. Тус улсын 50 мужийн ихэнх нь ямар нэг байдлаар төрийн алба болон хувийн секторт шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн орчныг бий болгосон байна. Холбооны түвшинд нийтийн эрх ашгийн төлөө мэдээлэгчийг хамгаалсан дараах актуудыг баталсан байна:

- Шүгэл үлээгчийг хамгаалах акт (1989; 2012 онд шинэчлэн найруулсан);
- Олон нийтийн компанийн тайлан тооцооны шинэтгэл ба хөрөнгө оруулагчийг хамгаалах акт (2002) /Sarbanes–Oxley Act/;
- Волл Стрийтийн шинэтгэл ба үйлчлүүлэгчийг хамгаалах акт (2010) /Dodd-Frank Act/.[364]

Үүнээс гадна тус улсад шүгэл үлээгчийг хамгаалсан салбарын тодорхой хууль тогтоомжууд байдаг. Жишээлбэл, 1970 онд батлагдсан "Үйлдвэрлэлийн аюулгүй байдал ба эрүүл мэндийн акт"-аар ажлын байрны аюулгүй байдал ба эрүүл

[362] Piper, D. L. A. "Whistleblowing: An employer's guide to global compliance." (2013), p.7.

[363] A Best Practice Guide for Whistleblowing Legislation, Transparency International, 2018.

[364] Wolfe, Simon, Mark Worth, Suelette Dreyfus, and Arthur J. Brown. *Whistleblower protection laws in G20 countries: Priorities for action*. Blueprint for Free Speech, 2014, p.63.

мэндийн асуудлыг мэдээлсэн, гомдол гаргасан этгээдийг хамгаалдаг бол 2010 онд батлагдсан "Өвчтөнийг хамгаалах ба эрүүл мэндийн үйлчилгээний хөнгөлөлтийн акт"-аар эрүүл мэндийн үйлчилгээний шинэтгэлтэй холбоотой асуудлаар шүгэл үлээсэн этгээдийг хамгаалдаг. Эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг "АНУ-ын Хөдөлмөрийн департамент" болон "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн агентлаг" зэрэг байгууллагууд хангадаг.[365]

Шүгэл үлээгчийн тодорхойлолт: Хууль зөрчих, ноцтой луйвар эсхүл шамшигдуулалт, удирдлагын алдаа, эрх мэдлийг урвуулан ашиглах, нийтлэг зүй бус үйлдэл, нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд томоохон аюул учруулах зэрэг үйлдлийг тэдгээрийн баримт нотолгоонд итгэсний үндсэн дээр ил болгож буй ажилтныг шүгэл үлээгч гэж тодорхойлсон.[366]

Зохицуулалтаар хамгаалагдах этгээд: "Шүгэл үлээгчийг хамгаалах акт (1989)"-аар тус улсын холбооны засгийн газрын ажилтан, өмнө ажиллаж байсан хүн, ажлын байранд горилогч зэрэг этгээдүүдийн шүгэл үлээх эрхийг хамгаалдаг. Харин Sarbanes–Oxley актаар хөрөнгийн бирж дээр хувьцаагаа нээлттэй арилждаг хувийн компаниуд болон тэдгээрийн охин компаниудын ажилтнууд, гэрээгээр ажиллагч нарын мэдээлэх эрхийг, Dodd-Frank актаар санхүүгийн салбар дахь шүгэл үлээгчийн эрхийг тус тус хамгаалдаг.

Мэдээллийн хүрээ: Хэрэв ил болгож буй мэдээлэл нь хуулиар хориглосон ба үндэсний батлан хамгаалах эсхүл гадаад хэргийн үйл ажиллагааны нууцтай холбоотой бол эрхийг хамгаалахгүй.[367] "Шүгэл үлээгчийг хамгаалах акт (1989)"-ын 2 дугаар хэсгийн (a)(1)-д "АНУ-ын хуулийн эмхтгэлийн 5 дугаар гарчгийн 2302 (b)(8)"-д заасан дараах мэдээллийг ил болгосон холбооны засгийн газрын ажилтныг хамгаалахаар тусгажээ:

"(B) ...ажилтан эсхүл ажил горилогч мэдээллийн баримт нотолгоонд үндэслэлтэйгээр итгэсэн (i) хууль, дүрэм, журмын зөрчил, (ii) удирдлагын ноцтой алдаа, сангийн хөрөнгийг ноцтойгоор үрэгдүүлсэн, эрх мэдлийг буруугаар ашигласан, эсхүл нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдалд бодитойгоор онцгой аюул учруулсан..."[368]

Харин Sarbanes–Oxley актаар холбооны захидал харилцаа, утас, банктай холбоотой зөрчил, мөн үнэт цаасны луйврын эсрэг хууль тогтоомжийн зөрчил, эсхүл "Үнэт цаас ба арилжааны комисс" (ҮЦАК)-ын аль нэг дүрэм, журам болон хувьцаа эзэмшигчдийн эсрэг залилантай холбоотой холбооны хууль тогтоомжийн заалтуудыг зөрчсөн тухай мэдээллийг ил болгосон этгээдийг хамгаалдаг.[369] Dodd-Frank актын хүрээнд үнэт цаасны тухай хуулийг зөрчсөн аливаа үйлдэл хийгдсэн, хийгдэж буй, хийгдэх талаар ҮЦАК руу мэдээлсэн мэдээлэгчийг хамгаалдаг.[370]

Мэдээлэл хүлээн авагч: Практикт зөвхөн ҮЦАК руу мэдээллийг ил болгох нь сүүлийн хоёр хуулиар хамгаалагдах боломжийг хувийн секторын шүгэл үлээгчдэд олгож байна.[371] Гэхдээ Sarbanes-Oxley акт нь нээлттэй компаниудыг аудитын

365 Piper, D. L. A. "Whistleblowing: An employer's guide to global compliance." (2013), p.33.

366 What is a Whistleblower?, Government Accountability Project, https://www.whistleblower.org/what-is-a-whistleblower/.

367 Peffer, Shelley L., Aleksandr Bocheko, Rita E. Del Valle, Allmir Osmani, Shawn Peyton, and Edna Roman. "Whistle where you work? The ineffectiveness of the Federal Whistleblower Protection Act of 1989 and the promise of the Whistleblower Protection Enhancement Act of 2012." *Review of Public Personnel Administration* 35, no. 1 (2015), p.73.

368 U.S. Code § 2302. Prohibited personnel practices, https://www.law.cornell.edu/uscode/text/5/2302.

369 Piper, D. L. A. "Whistleblowing: An employer's guide to global compliance." (2013), p.34.

370 Plan, Anti-Corruption Action. "Protection of Whistleblowers. Study on whistleblower protection frameworks, compendium of best practices and guiding principles for legislation." (2012), p.6.

371 Chalouat, Iheb, Carlos Carrión-Crespo, and Margherita Licata. *Law and practice on protecting whistle-blowers in the public and financial services sectors*. No. 995041591802676. International Labour Organization, 2019, p.37.

хороотой байхыг шаарддаг ба хороо нь алдаатай тайлан тооцоо болон аудитын талаарх мэдээллийг аливаа этгээд мэдээлснийг хүлээн авах ёстой.[372] Тухайн мэдээлэгч нь шаардлагатай бол нэрээ нууцлах эрхтэй бөгөөд уг эрхийг компаниуд мэдээлэл хүлээн авах утасны шугам нээснээр хангах боломжтой болсон.[373] Холбооны засгийн газрын ажилтнуудын хувьд аливаа зүй бус үйлдлийг хэнд ч илчилж болохоос[374] гадна шууд АНУ-ын "Тусгай зөвлөлийн алба" руу мэдээлж болно. Ингэхдээ тухайн ажилтан өөрийн хувийн мэдээллийг заавал бүртгүүлэх бөгөөд хэрэв шаардлагатай бол тус албанаас нэрийг нь нууцлахыг хүсэж болно.[375]

Урамшуулал ба нөхөн олговор: АНУ-д хувь хүн засгийн газрын нэрийн өмнөөс улсын сангаас луйвраар хулгайлагдсан хөрөнгийг буцаан төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг.[376] Энэ тохиолдолд тухайн хүн улсад буцаан төлүүлсэн хөрөнгөний 15-25 хувийг хүртэх эрхтэй болдог. Тэгэхээр шүгэл үлээгчдэд мөн улсад буцаан төвлөрүүлсэн тухайн хөрөнгөний мөн адил хувийг түүний эрсдэл болон хичээл зүтгэлийг үнэлэн олгодог. Энэхүү тогтолцооны ачаар 1986-2014 оны хооронд АНУ-ын Засгийн газар 35 тэрбум долларын хөрөнгийг улсын санд буцаан төвлөрүүлсэн. Харин хувийн секторт Dodd-Frank актын дагуу ҮЦАК нь мэдээлэгчийг үнэн бодит мэдээллээр хангасны төлөө буцааж олж авсан хөрөнгийн 10-30 хувиар шагнадаг.[377]

Хамгаалах механизм: Шүгэл үлээгчид ажлын байртай холбоотой шийтгэл оногдуулахыг хориглосон. Тухайлбал, "Шүгэл үлээгчийг хамгаалах акт (1989)"-д зааснаар тодорхой албан тушаалтан нь шүгэл үлээгчийн эсрэг боловсон хүчний өөрчлөлт хийх (ажлаас халах, түдгэлзэх, шилжүүлэх, өөр албан тушаалд томилох гэх мэт) болон хийхээр сүрдүүлэх зэргийг хориглодог.[378] Хэрэв шүгэл үлээгч шийтгүүлсэн бол "АНУ-ын Мерит системийг хамгаалах зөвлөл"-д "Тусгай зөвлөлийн алба"-аар дамжуулан гомдол гаргах эсхүл өөрөө бие даан өргөдөл гаргах боломжтой. "АНУ-ын Мерит системийг хамгаалах зөвлөл"-өөс гаргасан шийдвэрийг АНУ-ын Холбооны тойргийн давж заалдах шатны шүүх хянадаг.[379]

5.2. Их Британи

Их Британи Улс нь Европын холбооны улсууд дундаа дэлхий дахинаа хамгийн боловсронгуй шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоотой улсуудын нэг юм. Тус улс нь шүгэл үлээгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоо дараах актуудаас бүрддэг:

- Нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийг ил болгох акт (1998, 23-р бүлэг);
- Хөдөлмөрийн эрхийн акт (1996, 18-р бүлэг);
- Их Британийн Санхүүгийн удирдах газар болон бусад байгууллагаас тогтоосон дүрэм.[380]

[372] Banisar, David. "Whistleblowing: International standards and developments." *Corruption and transparency: Debating the frontiers between state, market and society, I. Sandoval, ed., World Bank-Institute for Social Research, UNAM, Washington, DC* (2011), p.29.

[373] Ibid, p.29.

[374] Peffer, Shelley L., Aleksandr Bocheko, Rita E. Del Valle, Allmir Osmani, Shawn Peyton, and Edna Roman. "Whistle where you work? The ineffectiveness of the Federal Whistleblower Protection Act of 1989 and the promise of the Whistleblower Protection Enhancement Act of 2012." *Review of Public Personnel Administration* 35, no. 1 (2015): p.73.

[375] Whistleblower Protection Act: An Overview, FindLaw, Сүүлд үзсэн огноо: 2019-10-28, https://employment.findlaw.com/whistleblowers/whistleblower-protection-act-an-overview.html

[376] Wolfe, Simon, Mark Worth, Suelette Dreyfus, and Arthur J. Brown. *Whistleblower protection laws in G20 countries: Priorities for action*. Blueprint for Free Speech, 2014, p.64.

[377] Anticorruption Working Group. "Protection of whistleblowers: study on whistleblower protection frameworks, compendium of best practices and guiding principles for legislation." (2012), p.27.

[378] 5 United States Code § 2302(b)(8).

[379] Devine, Thomas M. "The whistleblower protection act of 1989: Foundation for the modern law of employment dissent." *Admin. L. Rev.* 51 (1999), p.531.

[380] Chalouat, Iheb, Carlos Carrión-Crespo, and Margherita Licata. *Law and practice on protecting whistle-*

Шүгэл үлээгчийн тодорхойлолт: “Нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийг ил болгох акт”-д нийтийн эрх ашгийн төлөө тодорхой мэдээллийг ил болгож буй этгээдийг хамгаалах ба тухайн этгээд үүнээс үүдсэн аливаа цээрлүүлэлт, хавчлагын эсрэг нэхэмжлэл гаргах эрхийг олгосон байна.[381] Энэ актаар ажил олгогч нь ажилтныг уг актаар хамгаалсан мэдээллийг ил болгосны төлөө хор хөнөөл учруулах нь хууль бус үйлдэл болдог.

Зохицуулалтаар хамгаалагдах этгээд: Их Британи Улсын дээрх хуульд хамгаалагдах этгээдийг илүү өргөн хүрээнд тодорхой заасан байдаг бөгөөд төрийн жинхэнэ албан хаагчаас гадна гэрээний ажилтан, түр ажилтан, зөвлөх, Үндэсний эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагын ажилтан, орон тооны бус ажилтан, гэрээсээ ажилладаг хүн зэргийг хамруулсан байна.[382] Үүнээс гадна хувийн секторын ажилтанг мөн эдгээр актаар хамгаалдаг.[383] Харин уг хуулийн үйлчлэлд хувиараа хөдөлмөр эрхлэгч (Үндэсний эрүүл мэндийн үйлчилгээний байгууллагаас бусад), сайн дурын ажилтан, тагнуулын албаны ажилтан, зэвсэгт хүчний байгууллагын ажилтан зэрэг нь хамаардаггүй.[384]

Мэдээллийн хүрээ: “Нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийг ил болгох акт”-аар зөвхөн тодорхой төрлийн мэдээллийг ил болгосон шүгэл үлээгчийг хамгаалдаг. Тухайн мэдээлэл нь нийтийн ашиг сонирхлын төлөө ба ажилтан үндэслэлтэй гэж итгэсэн үед илчлэгдсэн байх ёстой бөгөөд дараах төрлийн зүй бус үйлдэл хийгдсэн, хийгдэж буй, эсхүл хийгдэх боломжтой байх тухай мэдээллийг авч үздэг:

- Эрүүгийн гэмт хэрэг;
- Хуулиар хүлээсэн үүргийн зөрчил (гэрээний үүргийн зөрчил бас хамаарна);
- Хуулийг буруу ашиглах;
- Аливаа этгээдийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулсан;
- Хүрээлэн буй орчинд хор хөнөөл учруулсан;
- Дээрхтэй холбоотой ямарваа мэдээллийг хаацайлах оролдлого.

Эдгээр мэдээлэл нь зөвхөн сайн санааны үндсэн дээр ил болгосон мэдээлэл байх бөгөөд хэрэв ил болгож буй шалтгаан нь зүй бус, хувийн шинжтэй бол сайн санааны үүднээс байх зарчмыг зөрчсөн гэж үзнэ. Хуульд заасан хүрээнд хамаарах ил болгосон мэдээллийг тухайн ажилтан үнэн болохыг батлах шаардлагагүй.[385]

Мэдээлэл хүлээн авагч: Тус улсын эрх зүйн зохицуулалтаар байгууллага дотроо ажил олгогч руу эсвэл хариуцсан этгээд рүү мэдээлэхийг шүгэл үлээх анхан шатны арга зам гэдгийг тодорхойлсон. Мөн түүнчлэн “Нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийг ил болгох акт”-аар шүгэл үлээгч нь хуулийн зөвлөх (43D хэсэг), харьяалагдах сайд (43E хэсэг), төрийн нарийн бичгийн даргын томилсон зохицуулагч (43F хэсэг) зэрэг этгээд рүү мэдээлэх боломжтой. Харин шүгэл үлээгч дараах нөхцөлд мэдээллийг олон нийтэд ил болгох боломжтой. Тухайлбал, шүгэл үлээгч нь тус актын 43F хэсгийн дагуу ажил олгогчид мэдээлэх тохиолдолд шийтгүүлнэ гэдэгт үндэслэлтэйгээр итгэсэн, эсхүл актын 43F хэсэгт заасан томилогдсон зохицуулагч байхгүй ба нотлох баримтыг ажил олгогч нуун дарагдуулах, устгах боломжтой гэдэгт итгэсэн, эсхүл ажил олгогчид өмнө нь мэдээлж байсан бол түүний эрхийг

blowers in the public and financial services sectors. No. 995041591802676. International Labour Organization, 2019, p.34.

381 Public Interest Disclosure Act 1998 of the United Kingdom.

382 Piper, D. L. A. “Whistleblowing: An employer’s guide to global compliance.” (2013), p.31.

383 Chalouat, Iheb, Carlos Carrión-Crespo, and Margherita Licata. Law and practice on protecting whistle-blowers in the public and financial services sectors. No. 995041591802676. International Labour Organization, 2019, p.14.

384 Wolfe, Simon, Mark Worth, Suelette Dreyfus, and A. J. Brown. “Whistleblower protection laws in G20 countries.” *Priorities for Action, The University of Melbourne, Griffith Univeristy, Transparenty International Australia* (2014), p.61.

385 Piper, D. L. A. “Whistleblowing: An employer’s guide to global compliance.” (2013), p.32.

хамгаалахаар тусгажээ.

Урамшуулал ба нөхөн олговор: Их Британи Улсын хувьд шүгэл үлээгч хуулийн хүрээн дэх мэдээлэл ил болгосны төлөө олгох урамшуулал байхгүй ба харин хохирсон тохиолдолд нөхөн олговор олгодог байна.[386] Тус нөхөн олговроор тухайн ажилтанд учирсан хохирлыг бүрэн барагдуулах ёстой. "Нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийг ил болгох акт"-ын 4 дүгээрт зааснаар нөхөн олговрын хэмжээ нь "Хөдөлмөрийн эрхийн акт"-ын X хэсгийн 2 дугаар бүлэгт заасан нөхцөлөөр тооцсон хэмжээнээс хэтрэхгүй.

Хамгаалах механизм: Ажилтан "Нийтийн эрх ашигт хамаарах мэдээллийг ил болгох акт"-ын 47B хэсгийн 1 дүгээрт заасанчлан уг актаар хамгаалагдсан мэдээлэл ил болгосны төлөө ямар нэг акт болон ажил олгогчийн зүгээс ямар нэг шийтгэл хүртэх ёсгүй. Уг актын 3 дугаарт зааснаар хэрэв ажилтан шүгэл үлээснийхээ төлөө шийтгэгдсэн бол "Хөдөлмөрийн маргааны шүүх"-д гомдол гаргах эрхтэй. Мөн 5 ба 6 дугаарт зааснаар хэрэв ажилтан шүгэл үлээснийхээ төлөө ажлаас чөлөөлөгдөх эсвэл цомхтголд орох тохиолдолд үүнийг шударга бус гэж үзнэ. Өөрөөр хэлбэл, ажил олгогч нь ажилтанг тус актын хүрээнд нийтийн эрх ашгийн төлөө ажил олгогчийн зүй бус үйлдлийн талаарх мэдээллийг өөрт нь болон бусад хуульд заасан этгээдэд илчилснийх нь төлөө ажлаас халах болон цомхтгох эрхгүй байна.

5.3. Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс (ӨАБНУ)

ӨАБНУ нь 2000 онд шүгэл үлээгчийг хамгаалах бие даасан хууль болох "Мэдээлэл илчлэлтийг хамгаалах акт"-ыг баталсан.[387] Энэ акт нь төрийн алба болон хувийн хэвшилд ажиллаж буй ажилтанд үйлчлэх ба мөн ӨАБНУ-ын нутаг дэвсгэрт болон гадна талд үйлдэгдсэн зүй бус үйлдлийг хамруулдаг. Үүнээс гадна шүгэл үлээгчийг хамгаалах заалтууд тус улсын "Компанийн акт (2008)"-ын 159 дүгээр хэсэг, "Хөдөлмөрийн харилцааны акт (1995)"-ын 186 дугаар хэсгийн (2)(d), 187 дугаар хэсгийн (1)(h), 191 дүгээр хэсгийн (3)-т тусгагдсан байна.

Шүгэл үлээгчийн тодорхойлолт: "Мэдээлэл илчлэлтийг хамгаалах акт"-ын эхэнд хуулийн үйлчлэлийг тодорхойлохдоо: "төрийн албан хаагч болон хувийн секторын ажилтан ажил олгогчийн болон бусад харьяалагдах ажилтны зүй бус эсхүл хууль бус үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг ил болгох, энэ актын дагуу хамгаалагдсан мэдээллийг ил болгосон ажилтныг хамгаалах, үүнтэй холбоотой бусад асуудлыг зохицуулах эрх зүйн орчныг бий болгох гэсэн байна."[388]

Зохицуулалтаар хамгаалагдах этгээд: Уг актаар зөвхөн ажилтны шүгэл үлээх эрхийг хамгаалах бөгөөд гэрээгээр ажиллагч болон сайн дурын ажилтнуудад энэ акт үйлчлэхгүй. Харин "Компанийн акт"-аар компани руу бараа, үйлчилгээ нийлүүлэгч, хувьцаа эзэмшигч, захирлуудын шүгэл үлээх эрхийг хамгаалсан нь гэрээгээр ажиллагчийг хамааруулсан байх боломжтой.[389]

Мэдээллийн хүрээ: Мэдээлэл ил болгосон нь хамгаалагдах эсэх нь тухайн мэдээллийн агуулга, мөн чанар, ил болгохдоо мөрдсөн процедур зэргээс хамаардаг. Дээрх эрх зүйн зохицуулалтаар зөвхөн тодорхой төрлийн мэдээллийг ил болгосныг авч үздэг. Тухайлбал, "Мэдээлэл илчлэлтийг хамгаалах акт"-д тодорхойлсноор мэдээлэл ил болгох нь ажил олгогч эсхүл тухайн ажил олгогчийн ажилтны дараах төрлийн зүй бус үйлдэл хийгдсэн, хийгдэж буй, хийгдэх боломжтой гэдэгт итгэсэн үед илчилж буй үйлдэл юм:[390]

- Эрүүгийн гэмт хэрэг;
- Хуулиар хүлээсэн үүргийг зөрчих;

[386] Whistleblowing Payments in the UK and USA, 2015, Сүүлд үзсэн огноо: 2019-10-27, https://www.co-oplegalservices.co.uk/media-centre/articles-jan-aug-2015/whistleblowing-payments-in-the-uk-and-usa/.

[387] Protected disclosure act 26 of 2000, http://www.justice.gov.za/legislation/acts/2000-026.pdf.

[388] Ibid.

[389] Piper, D. L. A. "Whistleblowing: An employer's guide to global compliance." (2013), p.29.

[390] Ibid, p.30.

- Хуулийг буруугаар ашиглах;
- Аливаа этгээдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд аюул учруулсан;
- Хүрээлэн буй орчинд хохирол учруулах;
- "Шударга бус ялгаварлан гадуурхалтаас урьдчилан сэргийлэх ба тэгш эрхийг дэмжих тухай акт (2000)"-д тусгасан шударга бус ялгаварлан гадуурхалт;
- Дээрх төрлийн аль нэг мэдээллийг зориудаар нуун дарагдуулах.[391]

Ажилтны хөдөлмөрийн гэрээнд эсхүл ажлаас чөлөөлөх гэрээнд мэдээлэл нууцлах заалт тусгагдсан нь "Мэдээлэл илчлэлтийг хамгаалах акт"-тай зөрчилдвөл тухайн гэрээний заалтыг хүчингүйд тооцно.[392] Харин "Төрийн мэдээлэл хамгаалах билл"-д зааснаар хэрэв шүгэл үлээгч нь "нууцалсан", "нууц", "маш нууц" ангиллын төрийн мэдээллийг ил болгосон бол эрүүгийн хариуцлага хүлээх ба 3-5 жил, 10-15 жил, 15-25 жилийн хорих ял тус тус шийтгүүлдэг.[393]

Мэдээлэл хүлээн авагч: "Мэдээлэл илчлэлтийг хамгаалах акт"-д зааснаар шүгэл үлээгч дээрх төрлүүдэд хамаарах мэдээллийг дараах этгээдүүдэд ил болгоно:

- Хууль зүйн зөвлөгөө авах үед хуулийн зөвлөх;
- Журамласан процедурын дагуу ажил олгогч;
- Эрхлэх асуудлын хүрээний Засгийн газрын гишүүн;
- Оршин буй орон нутгийн гүйцэтгэх зөвлөлийн гишүүн;
- Өмнөд Африкийн хүний эрхийн комисс;
- Хүйсийн тэгш эрхийн комисс;
- Соёл, шашин, хэлний бүлгүүдийн эрхийг хамгаалах, дэмжих комисс;
- Төрийн албаны комисс;
- Нийтийн хамгаалагч;
- Ерөнхий аудитор, эсхүл
- Журмаар эрх олгосон этгээдэд.

Урамшуулал ба нөхөн олговор: Шүгэл үлээгч нь хохирол амссан тохиолдолд нөхөн олговор нэхэмжлэх, олж авах эрхтэй.[394] Ажлын байртай холбоотой хохирол учирсан тохиолдолд "Хөдөлмөрийн харилцааны акт"-ын дагуу нөхөн олговор тооцогдож болно. Тухайлбал, шүгэл үлээгч шударга бусаар ажлаас чөлөөлөгдсөн бол албан тушаалд нь эргүүлэн томилох эсхүл хамгийн ихдээ 24 сарын цалинтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг эдийн болон эдийн бус хохиролд зориулан төлнө. Харин шударга бус хөдөлмөрийн үйл ажиллагаа явагдсан бол үйл ажиллагааг залруулахад, мөн эдийн ба эдийн бус хохиролд зориулж хамгийн ихдээ 12 сарын цалинтай тэнцэх нөхөн олговор олгодог.[395]

Хамгаалах механизм: Тус улсад ажилтныг ажил олгогч, эсвэл хамтран ажиллагч нь шүгэл үлээснийх нь төлөө ажлын байртай холбоотой тодорхой шийтгэл, хохирол учруулахаас хамгаалдаг.[396] Ажлын байртай холбоотой дараах шийтгэлүүдийг авч үздэг:

---

391 Protected disclosure act 26 of 2000, Section 1.

392 Whistleblower's handbook, Corruption Watch, 2015, https://www.corruptionwatch.org.za/wp-content/uploads/2015/05/Corruption-Watch-Whistleblower-handbook.pdf, p.6.

393 Empowering our whistleblowers, Open Democracy Advice Centre, https://www.corruptionwatch.org.za/wp-content/uploads/migrated/WhistleblowingBook.pdf, p.26.

394 Whistleblower's handbook, Corruption Watch, 2015, https://www.corruptionwatch.org.za/wp-content/uploads/2015/05/Corruption-Watch-Whistleblower-handbook.pdf, p.6.

395 Empowering our Whistleblowers, Open Democracy Advice Centre, https://www.corruptionwatch.org.za/wp-content/uploads/migrated/WhistleblowingBook.pdf, p.24.

396 Piper, D. L. A. "Whistleblowing: An employer's guide to global compliance." (2013), p.30.

- Сахилгын арга хэмжээ авах;
- Ажлаас халах;
- Түдгэлзэх;
- Айлган сүрдүүлэх;
- Заналхийлэх;
- Албан тушаал дэвшүүлэхээс татгалзах;
- Ажилтныг хүссэн албан тушаалаас шилжүүлэх.[397]

Хэрэв ажилтан ажлын байртай холбоотой дээрх шийтгэлийн аль нэгийг хүртсэн бол ажилтан хөдөлмөрийн маргааныг хариуцсан шүүхэд (Жишээ нь, хөдөлмөрийн шүүх) гомдол гаргах эрхтэй. Мөн үүнээс гадна ажилтан "Эвлэрүүлэн зуучлах комисс"-т хандаж тулгарсан асуудлаа шийдвэрлүүлэх боломжтой.[398] "Мэдээлэл илчлэлтийг хамгаалах акт"-ын 6 дугаар хэсэгт тусгаснаар ажил олгогч нь ажилтанд байгууллага доторх зүй бус үйлдлийг мэдээлэх эрх олгох ёстой. Гэхдээ энэ нь компани болон байгууллага нь шүгэл үлээгчийн талаарх дотоод бодлоготой байх үүргийг хүлээлгэдэггүй ба мөн энэ хуулийг сахиулах үүрэгтэй засгийн газрын агентлаг ӨАБНУ-д байхгүй.[399]

5.4. Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ)

БНСУ-ын хувьд 2001 онд "Авлигын эсрэг акт"-ыг баталснаар төрийн албан дах шүгэл үлээгчийг хамгаалж эхэлсэн. Хамгаалалтын болон урамшууллын механизмыг илүү боловсронгуй болгож 2011 онд "Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай акт"-ыг баталсан.[400] Ийнхүү БНСУ-ын Засгийн газар шүгэл үлээгчид зориулж эрх зүйн орчныг сайжруулсан ч гэлээ авлигыг илчлэх, шүгэл үлээгчийг хамгаалахад зарим талаар дутагдалтай байна.[401] Тухайлбал, тус улсын төрийн албаны шүгэл үлээгчийг хамгаалах хууль тогтоомжид гадагшаа мэдээллэх сувгийг нарийн тодорхойлоогүй, мөн дотооддоо илчлэх процедур болон нэрээ нууцалсан этгээдийн хамгаалалт тодорхой бус байсан.[402]

Гэхдээ БНСУ-ын энэхүү хууль нь дэлхий дээрх хамгийн сайн зохицуулалттай хуулиудын нэг юм. Тус хуулиар төрийн албаны болон хувийн секторын ажилтнууд аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчин, шударга өрсөлдөөнтэй холбоотой зөрчлийн талаар шүгэл үлээх эрхийг хамгаалахаас гадна мөнгөн урамшуулал олгох зохицуулалтыг бий болгосон.[403]

<u>Шүгэл үлээгчийн тодорхойлолт:</u> БНСУ-ын "Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай акт"-д шүгэл үлээгч болон шүгэл үлээлтийг нарийн тодорхойлсон. Нийтийн ашиг сонирхолын төлөө шүгэл үлээх гэдгийг нийтийн ашиг сонирхолын эсрэг зөрчил гаргасан, гаргах магадлалтай талаар гомдол гаргах, буруушаах, мэдээлэх, өргөдөл гаргах, тайлагнах гэж ойлгоно. Хэрэв ил болгосон мэдээлэл нь худал гэдгийг шүгэл үлээгч мэдэж байсан эсвэл мэдэх боломжтой байсан, мөн түүнчлэн шүгэл үлээгч нь мөнгө, бараа нэхсэн эсвэл мэдээллээр барьцаалсан тохиолдолд үүнийг нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээсэн гэж

[397] Whistleblower's handbook, Corruption Watch, 2015, https://www.corruptionwatch.org.za/wp-content/uploads/2015/05/Corruption-Watch-Whistleblower-handbook.pdf, p.6.

[398] Ibid, p.6.

[399] Section 159 of the Companies Act 71 of 2008

[400] Chang, Yongjin, Mark Wilding, and Min Chul Shin. "Determinants of whistleblowing intention: evidence from the South Korean government." *Public Performance & Management Review* 40, no. 4 (2017): 676.

[401] Ibid.

[402] Wolfe, Simon, Mark Worth, Suelette Dreyfus, and A. J. Brown. "Whistleblower protection laws in G20 countries." *Priorities for Action, The University of Melbourne, Griffith Univeristy, Transparenty International Australia* (2014).

[403] Wolfe, Simon, Mark Worth, Suelette Dreyfus, and A. J. Brown. "Whistleblower protection laws in G20 countries." *Priorities for Action, The University of Melbourne, Griffith Univeristy, Transparenty International Australia* (2014):p.47.

үзэхгүй.[404]

Зохицуулалтаар хамгаалагдах этгээд: Шүгэл үлээгч гэж нийтийн ашиг сонирхолын төлөө шүгэл үлээж буй хүнийг хэлнэ. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг энэ хуулийн зүйл 2.7-д дэлгэрэнгүй тодорхойлсон. Тухайлбал, төрийн институц, төсөл, арга хэмжээ, компани, байгууллагад ажилладаг, ажиллаж байсан этгээд, дээр дурдсан төрийн байгууллагатай гэрээний үндсэн дээр хамтарч барилга байгууламж, үйлчилгээ эрхэлдэг, эрхэлж байсан этгээд, мөн Ерөнхийлөгчийн зарлигаар томилогдсон бусад этгээд зэргийг хамруулсан.[405]

Мэдээллийн хүрээ: Уг хуулийн хүрээнд мэдээлж болох нийтийн эрх ашгийн эсрэг зөрчлийг ерөнхийд нь тодорхойлсноос гадна хамаарах хууль тогтоомжуудын нэрийг хавсаргасан байна. Нийтийн ашиг сонирхолын эсрэг зөрчил гэж олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, хэрэглэгчийн ашиг сонирхол, шударга өрсөлдөөний эсрэг зөрчлийг ойлгохоос гадна үүнд хуульд хавсаргасан актуудад шийтгүүлэх заалттай аливаа үйлдэл, Ерөнхийлөгчийн зарлигаар захиргааны арга хэмжээ авахуулах аливаа үйлдэл зэргийг хамруулна.[406] Үүнээс харахад БНСУ-д шүгэл үлээгчийн мэдээлж болох мэдээллийн хүрээ маш өргөн байна.

Мэдээлэл хүлээн авагч: БНСУ-д шүгэл үлээгчийн ил болгож буй мэдээллийг хүлээн авч үүнтэй холбоотой үйл ажиллагаа явуулах эрхийг "Авлигын эсрэг иргэний эрхийн комисс" (Цаашид "Комисс" гэх) гэх байгууллага хэрэгжүүлдэг.[407] Аливаа этгээд авлигын хэргийн талаарх мэдээллээ уг комисс руу мэдээлж, хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг хүсэх эрхтэй. Мөн төрийн албан хаагч өөрийн ажил олгогч, байгууллага, компани зэрэг нь авлигын гэмт хэрэг үйлдсэнийг эсвэл үйлдэгдэх гэж буйг захиргааны байгууллага, дээд газар, Үндэсний ассамблейн гишүүн, хуулийн байгууллага, Хяналт, шалгалтын хороо, эсвэл Комисст мэдээлнэ.[408] Авлигын талаарх мэдээллийг бичгээр гаргах бөгөөд уг бичигт шүгээл үлээгч нь өөрийн хувийн мэдээлэл, мэдээлж буй зорилго, шалтгаанаа дурдана. Мөн түүнчлэн шүгэл үлээгч нь хуулийн хамгаалалтад байх ёстойгоо баталж мэдээллийн нотлох баримт, субъектыг тодорхой илэрхийлнэ.[409]

Урамшуулал, мөнгөн шагнал, дэмжлэг: "Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай акт"-ын 4 дүгээр бүлэгт шүгэл үлээгчид олгох урамшуулал, шагнал, тусламжийн мөнгөний талаарх зохицуулалтууд агуулагддаг. Ерөнхийдөө шүгэл үлээгчид зориулсан урамшууллын систем нь шүгэл үлээгч шүгэл үлээсний үр дүнд улсын сангаас алдагдсан хөрөнгийг эргүүлэн авсан, төрийн байгууллагын орлого өссөн, нийтийн эрх ашгийг хамгаалахад хувь нэмэр болсон зэргийг үндэслэн шагнаж, урамшуулдаг тогтолцоо юм. Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгч нь хуулийн дагуу урамшуулал олгохыг Комиссоос шаардах эрхтэй. Хуульд зааснаар шүгэл үлээгч урамшуулал авах хүсэлтээ түүний шүгэл үлээлтийн үр дүнд Засгийн газрын төв болон орон нутгийн байгууллагын орлого өссөн эсвэл хөрөнгө буцаан төвлөрүүлснийг мэдсэнээс хойш 2 жилийн дотор эсвэл мэдээлэл ил болгосноос хойш 5 жилийн дотор мэдүүлнэ.[410] Комисс нь хүсэлтийг хүлээн авсны дараа шүгэл үлээгчид шагнал урамшуулал олгох эсэх болон урамшууллын мөнгөн дүнг тодорхойлж, хэрэв татгалзах зүйлгүй бол урамшууллын мөнгийг 90 хоногийн дотор шүгэл үлээгчид шилжүүлнэ.[411] Урамшууллын мөнгөн дүн нь шүгэл үлээсний

[404] Article 2, South Korean Act on the Protection of Public Interest Whistleblowers.

[405] Article 2, South Korean Act on the Protection of Public Interest Whistleblowers.

[406] Article 2.1, South Korean Act on the Protection of Public Interest Whistleblowers.

[407] Article 4.1, South Korean Act on the Protection of Public Interest Whistleblowers.

[408] The Whistleblower Protection and Reward System of Korea, Сүүлд үзсэн: 2020.1.25, https://www.ohchr.org/Documents/Issues/Opinion/Protection/RepublicOfKorea.docx.

[409] The Whistleblower Protection and Reward System of Korea, Сүүлд үзсэн: 2020.1.25, https://www.ohchr.org/Documents/Issues/Opinion/Protection/RepublicOfKorea.docx.

[410] Article 26.3, South Korean Act on the Protection of Public Interest Whistleblowers.

[411] Article 26.4, South Korean Act on the Protection of Public Interest Whistleblowers.

үр дүнд буцаагдсан хөрөнгө, өссөн орлогын 4-өөс 20 хувийн хооронд байх бөгөөд урамшууллын мөнгөн дүн хамгийн ихдээ 2 тэрбум вон байна.412

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн нь улсын хөрөнгөд үр ашиг авчирсан, хөрөнгө алдагдахаас сэргийлсэн бөгөөд дараах 4 тохиолдолд бий болсон үед мөнгөн шагнал олгодог. Үүнд,

1. Нийтийн сонирхлын эсрэг зөрчил үйлдсэн этгээд прокурорын шатанд мөрдөгдөж буй, тэнсэн харгалзсан, ялын тогтоол уншигдсан үед;
2. Засан хүмүүжүүлэх эсвэл хориглох тухай захиргааны арга хэмжээ авагдсан үед;
3. Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн нь системийг сайжруулахад хувь нэмэр оруулсан, тухайлбал, нийтийн сонирхлын эсрэг зөрчлөөс сэргийлэх үүднээс холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт орсон, эсвэл шинээр баталсан үед;
4. Ерөнхийлөгчийн зарлигаар тогтоосон бусад үндэслэл бүрдсэн зэрэг болно.

Шүгэл үлээгч нь 100 сая воноос хэтрэхгүй мөнгөн шагнал хүлээн авч болно.

Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээсэн этгээд болон түүний хамаарал бүхий этгээд шүгэл үлээснээс үүдэн гарсан дараах хохирлыг нөхөн төлүүлэхээр Комисст хүсэлт гаргах эрхтэй. Үүнд,

1. Биеийн болон сэтгэл зүйн эмчилгээнд зарцуулсан зардал;
2. Албан тушаал, ажлын байр өөрчлснөөс үүдсэн хөдөлгөөний зардал;
3. Анхны байдалдаа буцан орохоор хуулийн байгууллагад гаргасан зардал;
4. Шүгэл үлээснээс үүдэн ажлаас халагдсан хугацааны цалин;
5. Бусад эдийн засгийн алдагдал зэрэг болно.

<u>Хамгаалах механизм:</u> Комисс нь авлигын талаарх мэдээллийг илчилсэн этгээдийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Хамгаалах арга хэмжээнд шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг ил гаргахыг хориглох, хамгаалалтад авах, шүгэл үлээгчийн эсрэг аливаа арга хэмжээг хориглох зэргийг хамруулдаг. Эдгээр хамгаалах арга хэмжээг зөрчсөн этгээдийг 3 жилээс илүүгүй хугацаагаар хорих ял эсвэл 30 сая воноос илүүгүй торгууль ногдуулах шийтгэл оногдуулдаг.[413]

"Нийтийн эрх ашгийн төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай акт"-аар шүгэл үлээгчийг ажлаас чөлөөлөх, түдгэлзүүлэх, цалингийн хэмжээ бууруулах, хамтрагчийн бараа, үйлчилгээний гэрээг цуцлах, зөвшөөрөл, лиценз цуцлах, шүгэл үлээгчид сэтгэл зүйн дарамт учруулах зэргийг хориглодог.[414] Мөн уг хууль дахь нэг онцлог зохицуулалт нь шүгэл үлээгчийн хамаарал бүхий этгээд, хамтрагчид ноцтой аюул учирсан, учрах боломжтой гэж үзсэн тохиолдолд Комисс цагдаагийн байгууллагад эсвэл шаардлагатай хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх байгууллагад хүсэлт гаргадаг.[415] Комисс хүсэлт гаргасан даруйд үүнийг хүлээн авсан цагдаагийн газар болон байгууллага нь хамгаалах арга хэмжээг хойшлуулшгүйгээр авч хэрэгжүүлдэг.[416] Шүгэл үлээхийн тулд шүгэл үлээгч нь гэмт хэрэг үйлдсэн бол оногдуулах шийтгэлийг хөнгөвчилж болно.

412 The Whistleblower Protection and Reward System of Korea, Сүүлд үзсэн: 2020.1.25, https://www.ohchr.org/Documents/Issues/Opinion/Protection/RepublicOfKorea.docx.

413 The Whistleblower Protection and Reward System of Korea, Сүүлд үзсэн: 2020.1.25, https://www.ohchr.org/Documents/Issues/Opinion/Protection/RepublicOfKorea.docx.

414 Chapter III, South Korean Act on the Protection of Public Interest Whistleblowers.

415 Article 13.1, South Korean Act on the Protection of Public Interest Whistleblowers.

416 Article 13.2, South Korean Act on the Protection of Public Interest Whistleblowers.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, САНАЛ

Монгол Улс НҮБ-ын Авлигын эсрэг конвенцид 2005 онд нэгдэн орсон нь тус конвенцын 33 дугаар зүйлд заасан "...тогтоосон гэмт хэргийн талаарх аливаа баримт нотолгоог сайн санааны үүднээс, үндэслэлтэйгээр эрх бүхий байгууллагад мэдээлж буй аливаа этгээдийг аливаа шударга бус хандлагаас хамгаалах"-аар тунхагласан нь мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх үүргийг хүлээж байгаа юм.

Мэдээлэгчийг хамгаалах эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх ажлын хүрээнд тусгайлсан зохицуулалт бүхий хууль боловсруулах шаардлагатай эсэхийг судлан үзвэл, манай улсад мэдээ, мэдээллийн харилцааг зохицуулсан, гэрчийг хамгаалах, шударга ёсны талаар хууль, тогтоомжид зарим харилцааг тусгасан хэдий ч шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах, урамшуулах талаар зохицуулалтгүй, харин гэрчийг хамгаалах талаар сайжруулах шаардлагатай асуудал нэлээд байна. Иймд тус харилцааны эрх зүйн орчин хангалттай бүрдсэн гэж үзэх үндэсгүй, УИХ болон ЗГ-ын тогтворгүй байдал, ажлын уялдаа, залгамж холбоо алдагдсан байгаа нь аюулгүй байдал, хүний эрхийг хангах ажлыг төрөөс зохион байгуулахтай холбоотой байна. УИХ, ЗГ-аас хууль тогтоомж, дүрэм, журмаар зохицуулагдаж байсан зарим харилцаа өөрчлөгдсөн бөгөөд хүлээлгэх хариуцлагыг Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар торгууль ногдуулах хэлбэрээр хүлээлгэх болсон. Ийнхүү гомдол, мэдээлэл гаргахтай холбоотой төрөөс авч буй арга хэмжээ суларсан нь Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах асуудал улам бүр хурцаар тавигдаж, мэдээлэгч түүн дотроо шүгэл үлээгч, матаач, гэрчийн ялгааг сайн гаргаж өгсөн хууль шаардлагатай болоод байна.

Иймд Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийн талаар тусгайлан зохицуулсан, шинэлэг харилцааг зохицуулсан хууль шаардлагатай юм.

Судалгааны 3-р хэсэгт зардал, үр өгөөжийн харьцааг зорилгод хүрэх боломжтой харьцуулан судалсны үндсэн дээр дээрх хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Гарч болох эерэг үр дагавар

Хувилбар 1-ийн хувьд иргэдэд тусгай чиг үүрэг бүхий төрийн байгууллагаас түргэн, шуурхай үйлчилгээ авах боломж бүрдэж, төрийн үйлчилгээний чанар, үр нөлөөг хянах хүний эрхийг хангах, эрх тэгш нөхцөл байдлыг хангах, урамшуулах, хамгаалах нэгдсэн тогтолцоотой болно. Ингэснээр төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирч иргэдийн эрх зөрчигдөхөөс сэргийлэх, төрийн үйл ажиллагаанд итгэх нийгмийн итгэл дээшилнэ.

Хувилбар 2-ын хувьд Нийтийн ашиг сонирхлыг зөрчсөн, зөрчихөөр завдсан тохиолдолд хуулиар хүлээлгэх хариуцлагыг нийтийн албан тушаалтантай холбоотой асуудлыг холбогдох хуулиар шалган, өндөр түвшний авлигыг илрүүлэх, ногдуулах хариуцлагын хэмжээ төдийлөн хангалттай бус байгаад Эрүүгийн хуулиар оногдуулах ялын хэмжээг торгуулиар шийдвэрлэх бус харин заавал биеэр эдлүүлэх тухай, хууль бусаар олсон хөрөнгийг хураан төрийн өмч болгох зэргээр эрх зүйн орчинг сайжруулах нь төрийн өндөр түвшний хээл хахууль болон нийтийн эрх ашгийг зөрчсөн явдлыг илрүүлэн эрүүл нийгмийг бий болгох нь хүний тэгш эрхийг хангахын зэрэгцээ улсын эдийг засагт сайнаар нөлөөлөх давуу талтай.

Гарч болох сөрөг үр дагавар

Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ конвенцын үзэл баримтлалд хүний эрх, эрх чөлөөг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, шударга шүүхээр шүүлгэх, аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрхээр хангагдах нь хүн бүрийн эдлэх эрх тул үүнийг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэхдээ хууль хоорондын уялдаа холбоог хангаагүйгээс сөрөг үр дагавар үүсэх магадлалтай гэж дүгнэсэн билээ.

Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр эрх тэгш байх үндсэн зарчим хэрэгжих шалтгаан нөхцөл нь эрх, үүрэг, хариуцлагаа ухамсарладаг, нөгөө талаас хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх засаглалын үйл ажиллагааны хүрээнд заавал удирдлага болох хууль зүйн эрх, үүрэг, хариуцлага гурав хүн бүрт адил тэгш үйлчилж байдаг.

Төрөөс хүний эрхийг хангах, хамгаалахад тохирох үүрэг, хариуцлагыг ногдуулдаг эрх тэгш байх үндсэн зарчим бүрэн утгаараа хэрэгжих баталгаа бүрдэх учиртай.

Хүний эрхийг хангах, хамгаалах, урамшуулах тогтолцоог сайжруулан уялдуулахад бүрдэл хэсэг тус бүрээр дараах байдлаар авч үзэх саналтай байна:

- Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Хууль тогтоох болон бүх шатны гүйцэтгэх байгууллага;
- Хүний эрхийн Үндэсний Комисс, шүүх, прокурор, өмгөөлөх гэх мэт хүний эрхийг хангах шууд үүрэг зорилго бүхий төрөлжсөн байгууллагууд;
- Нутгийн өөрөө удирдах байгууллагуудыг оролцуулан иргэний нийгмийн бүх байгууллага, хөдөлгөөн, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл;
- Бүх төрлийн бизнес эрхлэгч хувийн хэвшлийн байгууллагуудын үйл ажиллагаа;
- Хүний эрхийг хангах, хамгаалах ажлын алба, тэдгээртэй адилтгах хэлтэс, нэгж.

Тус байгууллагууд нь хүний эрхийг хангах, хамгаалах, урамшуулахад чиглэсэн нарийвчилсан зохицуулалтыг тусгаж өгөх, бүрдэл хэсгийн чадавх, хүний эрхийг сахин биелүүлэх, үүрэг хариуцлагыг тухайлсан хуулийн зохицуулалттай нийцүүлэн тодорхойлох шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ

Олон Улсын гэрээ, Хууль, тогтоомж

- НҮБ-ын Авлигын эсрэг конвенц, (2003)
- Европын зөвлөлийн Авлигын талаарх иргэний эрх зүйн тухай конвенц, (1999)
- Европын Зөвлөлийн Авлигатай тэмцэх Эрүүгийн хуулийн конвенц, (1999)
- Монгол Улсын Үндсэн хууль, (1992)
- Авлигын эсрэг хууль, (2006)
- Агаарын тухай хууль, (2012)
- Амьтны тухай хууль, (2012)
- Авто тээврийн тухай хууль, (1999)
- Гүйцэтгэх ажлын тухай хууль, (1997)
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль, (1997)
- Зөрчлийн тухай хууль, (2017)
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, (2012)
- Эрүүгийн хууль, (2015)
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, (2017)
- Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, (2016)
- БНСУ, Нийтийн ашиг сонирхлын төлөө шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль, (2011)
- Republic of India, The whistle blowers protection act, (2011)

Хуулийн үндэсний хүрээлэн www.nlt.gov.mn

- South Africa, Protected disclosure act 26 of 2000.
- South Africa, Companies Act 71 of 2008.
- U.K, Public Interest Disclosure Act (1998)
- U.K, Enterprise and Regulatory Reform Act (2013)
- U.K, Employment Rights Act (1996)
- U.S. Code § 2302(b)(8). Prohibited personnel practices.
- U.S, Whistleblower Protection Act (1989)
- U.S, Whistleblower Protection Enhancement Act (2012)
- U.S, Sarbanes-Oxley Act (2002)
- U.S, Dodd-Frank Act (2010)

Монгол хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл, тайлан, гарын авлага

- Ж.Амарсанаа, Хүний эрх /Олон улсын ба үндэсний эрх зүйн асуудал/ (Уб,2000)
- Ж.Амарсанаа, “Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөө”, Ханнс Зайделийн сан, Төр, эрх зүйн хуудас, эргэцүүлэл, (Уб, 2000), №7, 103 дахь тал.
- П.Амаржаргал, Э.Уянга, Монгол Улс дахь мэдээллийн аюулгүй байдлын эрх зүйн зохицуулалтын төлөвшил, чиг хандлага. Хууль дээдлэх ёс сэтгүүл. №72, (Уб, 2019)
- Авлигатай тэмцэх хууль тогтоомжийн хэрэгжилт, авлигын ерөнхий нөхцөл байдал-2018, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт (2016-2018) (Уб, 2019),
- А.Бямбажаргал, “Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргаж шийдвэрлүүлэх эрхийн хэрэгжилт, шинжилгээ” Ардчиллын хөгжил-Иргэний оролцоо, (Уб, 2014),
- Б.Батзориг, Ц.Цэлмэг нар. Авлига, албан тушаалын гэмт хэрэг. (Уб, 2014),
- Л.Галбаатар, Авлигатай тэмцэх үйл ажиллагаа ба шүгэлдэгчийн хамгаалалт /олон улсын туршлага/, АТГ-аас судалгаатай холбоотой явуулсан материалаас, (Уб, 2019),
- Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага, Авлигатай тэмцэх гарын авлага, (Уб, 2018)
- Д.Жигваансүрэн, Д.Халиун, “Гадаадын зарим орны шүүмжлэгч (шүгэлдэгч)-ийн эрхийг хамгаалах эрх зүйн зохицуулалтын талаарх лавлагаа”, УИХ-ын Тамгын газар Судалгааны эмхэтгэл XXV боть (Уб, 2017),
- Д.Жаргалсайхан, “Шүгэл үлээх соёл”, Шүүх эрх мэдэл №4, (Уб, 2016),
- Нүүдэл Шийдэл: Шүгэл үлээгч гэж хэн бэ?
- Санхүүгийн зохицуулах хороо, Банкнаас бусад санхүүгийн байгууллагын комплейнсын ажилтнуудад зориулсан гарын авлага (суурь ойлголт), (Уб, 2019),
- Г.Совд, Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрх /харьцуулсан эрх зүй/ (Уб, 1999),
- Ханнс-Зайделийн сан, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2009),
- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ /судалгааны тайлан/, (Уб, 2018)
- Б.Чимид, Үндсэн хуулийн үзэл баримтлал. (Уб, 2017) 56 дахь тал.
- Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг. (Уб, 2008),

Хуулийн үндэсний хүрээлэн www.mn.gov.mn

- Л.Отгондорж, Р.Пүрэвбаатар, “Дотоод мэдээлэгчийг хамгаалах зарим санал”, Орчин үеийн эрх зүйн тулгамдсан асуудлууд, (Уб, 2015),

Гадаад хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл

- Anticorruption Working Group. “Protection of whistleblowers: study on whistleblower protection frameworks, compendium of best practices and guiding principles for legislation.” (2012).
- Banisar, David. “Whistleblowing: International standards and developments.” Corruption and transparency: Debating the frontiers between state, market and society, I. Sandoval, ed., World Bank-Institute for Social Research, UNAM, Washington, DC (2011),
- Chalouat, Iheb, Carlos Carriyn-Crespo, and Margherita Licata. Law and practice on protecting whistle-blowers in the public and financial services sectors. No. 995041591802676. International Labour Organization, 2019.
- Chang, Yongjin, Mark Wilding, and Min Chul Shin. “Determinants of whistleblowing intention: evidence from the South Korean government.” Public Performance & Management Review 40, no. 4 (2017): 676.
- Committing to Effective Whistleblower Protection, OECD, 2015.
- Devine, Thomas M. “The whistleblower protection act of 1989: Foundation for the modern law of employment dissent.” Admin. L. Rev. 51 (1999):
- Dodd-Frank Wall street Reform and Consumer Protection Act
- Empowering our whistleblowers, Open Democracy Advice Centre,
- Four ways the G20 can take the lead on anti-corruption,
- Full text of the G20 Osaka leaders’ declaration,
- G20 Seoul Summit 2010, G20 Anti-Corruption Action Plan,
- Loyens, Kim, and Wim Vandekerckhove. “Whistleblowing from an international perspective: A comparative analysis of institutional arrangements.” Administrative Sciences 8, no. 3 (2018): 30.
- OECD, Committing to Effective Whistleblower Protection, 2015.
- OECD, Study on whistleblower protection frameworks, compendium of best practices and guiding principles for legislation.
- Peffer, Shelley L., Aleksandr Bocheko, Rita E. Del Valle, Allmir Osmani, Shawn Peyton, and Edna Roman. “Whistle where you work? The ineffectiveness of the Federal Whistleblower Protection Act of 1989 and the promise of the Whistleblower Protection Enhancement Act of 2012.” Review of Public Personnel Administration 35, no. 1 (2015):
- Piper, D. L. A. “Whistleblowing: An employer’s guide to global compliance.” (2013).
- Protection of “whistle-blowers”, Parliamentary Assembly, 2010,
- Transparency International, “A Best Practice Guide for Whistleblowing Legislation”, (2018).
- Transparency international, People and corruption: Asia Pacific-Global corruption barometer, (2017).
- Whistleblower’s handbook, Corruption Watch, 2015,
- Whistleblowing Payments in the UK and USA, 2015,
- Wolfe, Simon, Mark Worth, Suelette Dreyfus, and A. J. Brown. “Whistleblower protection laws in G20 countries.” Priorities for Action, The University of Melbourne, Griffith Univeristy, Transparenty International Australia (2014).
- Wolfe, Simon, Mark Worth, Suelette Dreyfus, and Arthur J. Brown. Whistleblower

Хуулбарыг Үндэсний хуульчдын www.mlaw.gov.mn

protection laws in G20 countries: Priorities for action. Blueprint for Free Speech,

- Wolfe, Simon, Mark Worth, Suelette Dreyfus, and A. J. Brown. “Whistleblower protection laws in G20 countries.” Priorities for Action, The University of Melbourne, Griffith Univeristy, Transparenty International Australia (2014).

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

Хавсралт

ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨНИЙ УРЬДЧИЛСАН ҮНЭЛГЭЭ

Хувилбар 1-ийн хүрээнд зохицуулалтын үр нөлөөг тандан судалсан байдал.

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	**1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх**			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	**Үгүй**	Ялгаварлан гадуурхалтыг хориглож буй зохицуулалт агуулаагүй.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	Зөвхөн Шүгэл үлээгчийн эрх зүйн байдлыг тодорхойлж эрх, үүргийг зааж өгсөн, ялгаварлан гадуурхсан зохицуулалт агуулаагүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэхийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгчийг хамгаалах, эрх зүйн байдлыг тодорхойлж өгсөн мөн олон улсын эрх зүйн баримт бичигт тусгагдсан.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	**Үгүй**	Зохицуулалтын хувилбар боловсруулагдаагүй
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	**Үгүй**	Хүний эрхийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг Төрийн бус байгууллага, холбогдох албан тушаалтан, сэтгүүлч, өөрийн болон бусдын эрхийн төлөө тэмцэж буй иргэн, хувь хүн.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	**Тийм**	Үгүй	Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжоор баталгаажуулсан хүний эрхийг хангах, дэмжлэг үзүүлэх, хамгаалах тогтолцоо сайжирч, зорилтод бүлэгт хүрэх хүртээмж нэмэгдэнэ.
	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, НҮБ-ын Авлигын эсрэг конвенцод нийцсэн.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах харилцааны явцад хууль зөрчсөн тохиолдолд холбогдох хуульд заасны дагуу хариуцлага тооцно.

Хуульзүйн үндэсний хүрээлэн www.mn.gov.mn

2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	**Тийм**	Үгүй	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	**Үгүй**	Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулаагүй.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	**нийтийн ашиг сонирхол, аюулгүй байдлын эсрэг үйлдлийн тухай мэдээллийг илчэлсэн этгээд**
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Хуулийн төсөл нь Шүгэл үлээгчийг хамгаалахад чиглэгдсэн.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	**Тийм**	Үгүй	Хуулийн төсөл нь Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалахад эрх зүйн байдлыг тодорхойлоход чиглэгдсэн.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/	Тийм	**Үгүй**	Шүгэл үлээгчийг хамгаалах ерөнхий зохицуулалт агуулсан.
4. Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	**Тийм**	Үгүй	Төрийн байгууллага, албан тушаалтан, Төрийн бус байгууллага, Аж ахуйн нэгжийн эрх бүхий этгээд.
5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгчийг хамгаалахтай холбогдсон бүх харилцаанд жендерийн тэгш байдлыг бүрдүүлсэн байна.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгчийг хамгаалахтай холбогдсон бүх харилцаанд жендерийн тэгш байдлыг бүрдүүлсэн байна.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг Монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	**Үгүй**	Энэ чиглэлээр зохицуулалт агуулаагүй.

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	**Үгүй**	Аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэхгүй.
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсэж байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Нэмэлт зардал үүсэхгүй.
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Инновацы болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

Хууль зүйн яаманд хүргэгдэн www.mojs.gov.mn

7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Холбогдох байгууллагуудад нэмэлт чиг үүрэг бий болгосноор шинээр ажлын байр бий болохгүй.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Зөвхөн Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалахтай холбоотой асуудлыг зохицуулах тул нөлөө үзүүлэхгүй.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгчийг хамгаалах чиг үүрэг бүхий холбогдох байгууллагын үйл ажиллагаатай холбогдох зардлыг санхүүжүүлэх шаардлагатай.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагуудад нэмэлт чиг үүрэг бий болсноор бүтцийн өөрчлөлт явагдах боломжтой.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгчийн эрхийг хамгаалах харилцааг бий болгохтой холбогдуулан шинээр чиг үүрэг бий болох боломжтой.
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Ажил эрхлэлтийн байдалд эерэг нөлөө үзүүлэх боловч, улсын төсөвт тодорхой хэмжээний зардал нэмэгдэнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	**Тийм**	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mli.gov.mn

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах байгууллага нэмэгдсэнээр тодорхой ажлын байр нэмэгдэнэ.
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	**Үгүй**	Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах талаар нэмэлт стандарт шаардлагагүй.
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	**Үгүй**	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Хууль зүй, үндэсний хууль эрх
www.mjs.gov.mn

4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Шүгэл үлээгч /мэдээлэгч/-д шүүхэд хандаж эрхээ хамгаалуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх боломж бүрдэнэ.
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (холлолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Хуульзүйн яамны хуулийн
www.mojus.mn

8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	**Холбогдох асуултууд**	**Хариулт**		**Тайлбар**
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nji.gov.mn

7.Нөхөн сэргээгдэх/ нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	7.2.Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	**Үгүй**	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.

Хувилбар 2-ын хүрээнд зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдал. *Хувилбар 1-тэй адил хариулттай асуултууд үлдээв.*

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах чиг үүргийг гүйцэтгэх үүднээс салбар бүрт цөөн тоогоор ажлын байр шинээр бий болох боломжтой.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах чиг үүргийг холбогдох төрийн байгууллагад нэмж хүлээлгэснээр үйл ажиллагаатай холбогдох зардлыг санхүүжүүлэх хувилбар 1-д дурдсаны дагуу шаардлагатай хэвээр байна.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах чиглэлээр тусгай байгууллага байгуулах шаардлагагүй. Шаардлагатай тохиолдолд дээрх чиг үүргийг нэгдсэн удирдлагаар хангах, тогтолцоог хянах үүднээс зарим төрийн байгууллагад шинээр нэгж, эсхүл салбар хороо байгуулах боломжтой.
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах харилцааг өргөжүүлэхтэй холбогдуулан шинээр чиг үүрэг бий болох боломжтой.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

(Хүснэгт 6)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1.Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	**Тийм**	Үгүй	Шүгэл үлээгч /мэдээлэгч/-ийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлж эхэлснээр хязгаарлагдмал хүрээнд ажлын байр нэмэгдэх боломжтой.

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

илүү гарсан буюу дээр ороогүй зүүлтүүд шалгаж оруулах

(Footnotes)

1 Улсын Дээд Шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.06.22.) “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178 (Сүүлд үзсэн: 2018.12.26.)

2 Улсын Дээд Шүүхийн 2003 оны 02 дугаар тогтоол (2003.02.20.) “Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, https://www.legalinfo.mn/law/details/603 (Сүүлд үзсэн: 2018.12.26.)

3 Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 11 дэх талд “Сонгогчийн нэрийн жагсаалтыг сумын засаг захиргааны байранд хадгалах тохиолдлууд гарсан бөгөөд энэ нь сумын төвөөс алслагдмал суудаг орон нутгийн сонгогчдод мэдээллээ шалгахад нь хүндрэлтэй байлаа.” гэж дурджээ.

https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн: 2019.01.02).

4 СЕХ-оос ирүүлсэн урьд онуудад явуулж байсан Ерөнхийлөгчийн сонгуулийн ирцийн мэдээллээс үзэхэд 2013 оны тухайд ирцийн мэдээг 11.00, 15.00, 19.00, 22.00 цагаас дөрвөн удаа гаргаж байсан бөгөөд 19.00 цагийн байдлаар ирц улсын хэмжээнд 1,073,118 иргэн санал өгсөн буюу 57.73 хувьтай байсан бол үүнээс 4 цагийн дараа буюу 22.00 цагийн байдлаар 1.234.999 иргэн санал өгсөн буюу 66.46 хувьтай болсон байна. Үүнээс харахад 19.00-22.00 цаг хүртэл 161.881 иргэн буюу 8.73 хувиар санал өгсөн иргэний тоо нэмэгдсэн байна. Харин 2017 оны тухайд ирцийн мэдээг 12.00, 17.00, 22.00 цагаас гурван удаа гаргаж байсан бөгөөд 17.00 цагийн байдлаар ирц улсын хэмжээнд 762.703 иргэн санал өгсөн буюу 38.44 хувьтай байсан бол үүнээс 6 цагийн дараа буюу 22.00 цагийн байдлаар 1.199.084 иргэн санал өгсөн буюу 60.41 хувьтай болсон байна. Үүнээс харахад 17.00-22.00 цаг хүртэл 436.381 иргэн буюу 21.97 хувиар санал өгсөн иргэний тоо нэмэгдсэн байна. Сонгуулийн ирцийн талаар цаг тутмын мэдээлэл байхгүй учраас 20.00 цаг хүртэл ирц ямар байдаг, 20.00-22.00 цагийн хооронд ирц ямар байдаг талаар бодитой тооцон гаргахад хүндрэлтэй байна. Гэсэн хэдий ч дээрх хоёр сонгуулийн 17.00-22.00 цаг, 19.00-22.00 цагийн хоорондох 4-6 цагийн ирцийн мэдээг дундажлан хуваах үзвэл 2013 онд 19.00-22.00 цагийн хооронд цагт дунджаар 40.470 иргэн буюу 2.1 хувиар, 2017 онд 17.00-22.00 цагийн хооронд цагт дунджаар 72.730 иргэн буюу 3.66 хувиар ирц өссөн дүнтэй байжээ. Энэ нь мэдээж хэлбэлзэлтэй дүн юм. Хуулийн төсөлд санал авах цагийг 2 цагийн өмнө дуусгахаар зохицуулсан нь сонгуулийн ирц хүрэхгүй байх эрсдэлийг үүсгэж болзошгүй юм.

5 Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 14 дэх талд “СТХ-иар зөвхөн сонгуулийн анхан шатны санал хураалтын үед сонгуулийн сурталчилгааг зохион байгуулж явуулахтай холбогдсон харилцааг зохицуулж өгсөн байна. Харин сонгуулийн хоёр дахь санал хураалтын үеэрх сонгуулийн сурталчилгааны тухайд хуулийн хийдэл байгаа нь ажиглагдав.” гэж дурджээ. https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн: 2019.01.02).

6 Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43

7 Төрийн мэдээлэл эмхэтгэл (2018), №01

8 Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24

9 “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хөдөлмөр,

нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2018 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320.000 /гурван зуун хорин мянга/-н төгрөгөөр тооцов.

10 Манай улсад хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь 2000 оноос хойш нийт 12 удаа өөрчлөгдсөн бөгөөд анх тогтоосноос хойш 10.8 дахин нэмэгджээ.

11 СЕХ-оос хийсэн хуулийн төслүүдийн харьцуулалтаас дэлгэрүүлэн үзнэ үү.

12 Авлигын эсрэг конвенцийн 7 (3) зүйлд «оролцогч улс орон бүр сонгуульт төрийн байгууллагад нэр дэвшүүлэх, улс төрийн намуудын санхүүжилтийг ил тод болгохын тулд хууль тогтоох болон захиргааны зохих арга хэмжээ авах талаар анхаарч үзэх»-ыг санал болгодог. Улс төрийн намын зохицуулалтын тухай 194 дүгээр зүйлд «сонгогчид нь улс төрийн намуудыг хариуцлагатай байлгахын улс төрийн намуудад өгсөн санхүүгийн дэмжлэгийн талаар холбогдох мэдээлэлтэй байх ёстой» гэжээ.

13 Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 19 дэх талд "... сонгуулиас өмнө намуудын орлого, зардлын тайланг ил болгох тухай ямар нэг заалт байсангүйгээс гадна намуудаас аль нь ч сурталчилгааны зарцуулалтын дэлгэрэнгүй мэдээллийг сайн дураар тайлагнасангүй. Тиймээс сонгуулийн сурталчилгааны үеэрх сурталчилгааны зардлыг шалгаж, сонгуулийн сурталчилгааны санхүүжилтийн журмыг зөрчсөн эсэхийг илрүүлж, зохих арга хэмжээг шуурхай авах боломжгүй байлаа. Түүнчлэн, сонгогчид санал өгөхөөсөө өмнө нэр дэвшигчдийн болон улс төрийн намуудын санхүүгийн байдлын талаар баталгаатай мэдээлэл авах боломжгүй байсан нь хариуцлагатай сонголт хийх болон нэр дэвшигчдэд хариуцлага тооцох боломжийг сонгогчдод олгосонгүй." гэж дурджээ.

https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн: 2019.01.02).

Мөн энэ талаар 2018 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хороо, Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурал, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, тогтоомжийн төслийг боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгээс хамтран зохион байгуулсан "Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг"-т оролцсон оролцогчдоос сурталчилгааны зардлын тайланг ил болгох, тухай бүрд нь мэдээлж байх талаар санал гаргаж байсан байна.

14 "Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2018 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320.000 /гурван зуун хорин мянга/-н төгрөгөөр тооцов.

15 Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 20 дахь талд "Ерөнхийдөө сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоотой зөрчлүүдэд оногдуулдаг арга хэмжээнүүд нь үр дүн муутай, тохиромжгүй байгаагийн зэрэгцээ сонгууль явуулах олон улсын сайн туршлагад зөвлөсний дагуу нэр дэвшигчдэд ижил тэгш өрсөлдөх боломж, нөхцөлийг хангаж өгөхгүй байна." гэж дурджээ.

https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн: 2019.01.02).

16 Улсын дээд шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.6.22.) “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178 (Сүүлд үзсэн: 2018.12.26).

17 Улсын дээд шүүхийн 2003 оны 02 дугаар тогтоол (2003.2.20.) “Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, https://www.legalinfo.mn/law/details/603 (Сүүлд үзсэн: 2018.12.26).

18 Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайланд “Сонгогчийн нэрийн жагсаалтыг сумын засаг захиргааны байранд хадгалах тохиолдлууд гарсан бөгөөд энэ нь сумын төвөөс алслагдмал суудаг орон нутгийн сонгогчдод мэдээллээ шалгахад нь хүндрэлтэй байлаа” гэж дурдаж байжээ.

Дэлгэрэнгүйг https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true үзнэ үү. (Сүүлд үзсэн огноо: 2019.1.2).

19 Дэлгэрэнгүйг хүснэгт 5-аас үзнэ үү.

20 Харилцаа холбооны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43

21 Монгол Улсын сонгуулийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох нь, Олон улсын бага хурал, УБ., 2002 он, 56 дахь тал.

22 ЕАБХАБ-ын Ардчилсан Институт, Хүний Эрхийн Газар, Сонгууль ажиглах хороо, Монгол Улс. УИХ-ын сонгууль 2016.6.26, Урьдчилсан тайлан /2016 оны 5 сарын 20-оос 6 сарын 14-ний өдөр/.

23 “Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Хөдөлмөр, нийгмийн зөвшлийн гурван талт Үндэсний хорооны 2018 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 05 дугаар тогтоолын дагуу хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 320.000 /гурван зуун хорин мянга/-н төгрөгөөр тооцов.

24 Энэ талаар 2017 оны 6 дугаар сарын 26-ны өдөр болон 7 дугаар сарын 7-ны өдөр зохион байгуулагдсан Монгол Улсын Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийн талаар ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлангийн 20 дахь талд “Ерөнхийдөө сонгуулийн сурталчилгааны зардалтай холбоотой зөрчлүүдэд оногдуулдаг арга хэмжээнүүд нь үр дүн муутай, тохиромжгүй байгаагийн зэрэгцээ сонгууль явуулах олон улсын сайн туршлагад зөвлөсний дагуу нэр дэвшигчдэд ижил тэгш өрсөлдөх боломж, нөхцөлийг хангаж өгөхгүй байна” гэж дурдаж байжээ.

https://www.osce.org/odihr/elections/mongolia/352876?download=true (Сүүлд үзсэн огноо: 2019.01.02).

25 Улсын Дээд Шүүхийн 2010 оны 17 дугаар тогтоол (2010.06.22.) “Иргэний хуулийн 5, 6, 7 дугаар бүлгийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, https://www.legalinfo.mn/law/details/178?lawid=178 (сүүлд үзсэн: 2018.12.26.)

26 Улсын дээд шүүхийн 2003 оны 02 дугаар тогтоол (2003.02.20.) “Прокурорын байгууллагын тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай”, https://www.legalinfo.mn/law/details/603 (сүүлд үзсэн: 2018.12.26.)

27 Төрийн мэдээлэл эмхэтгэл (2001), №43

Хуулийн мэдээлэл, судалгаа, сургалтын нэгдсэн сан www.legal.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХОЁР. ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

КОДИФИКАЦИЙГ АМЖИЛТТАЙ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ГАДААД ОРНУУДЫН ТУРШЛАГА

(Харьцуулсан судалгаа)[1]

НЭГ. УДИРТГАЛ

Хууль зүйн шинжлэх ухаан дахь эрх зүйн системчлэл гэсэн өргөн хүрээний ойлголтын нэг хэсэг нь хууль тогтоомжийн системчлэл юм. Хууль тогтоомжийн системчлэл гэж албан ёсоор хүчингүйд тооцоогүй бөгөөд хүчин төгөлдөр дагаж мөрдөж байгаа хууль, эрх зүйн хэм хэмжээ бүхий актуудыг нийгмийн амьдралын хүрээгээр буюу эрх зүйн салбараар төрөлжүүлэн нэгтгэх, эмхлэн цэгцлэх үйл ажиллагааг хэлнэ.[2]

Энэхүү хууль тогтоомжийн системчлэл нь эрх зүйн үйл ажиллагааны бие даасан дөрвөн хэлбэрээс бүтдэг ба тэдгээр үндсэн аргын[3] нэг нь хууль тогтоомжийн кодификаци болно. Тус судалгаанд хууль тогтоомжийн кодификацийн талаарх ерөнхий ойлголт, өнөөгийн нөхцөл байдал болон кодификацийг амжилттай хэрэгжүүлж буй гадаад улсын сайн туршлагын талаар судалж, үндэсний эрх зүйд нутагшуулах арга зам, хандлагыг эрэлхийлэхийг зорилоо.

Ингэхдээ кодификаци буюу хууль тогтоомжийг системчлэн нэгтгэж буй техник ажиллагааны талаар түлхүү судалсан бөгөөд кодификацийн нэг хэсэг болох төрөлжсөн хууль (кодекс)-ийн агуулгын талаарх ойлголтыг хамааруулаагүй болно.

ХОЁР. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

2.1. Ерөнхий ойлголт, түүхэн хөгжил

Хууль тогтоомжийг системчлэх ажиллагаа нэг удаагийн үйл ажиллагаа бус байнгын шинжтэй, тогтмол ажиллагаа юм. Нийгмийн харилцаагаа дагаад хууль бүтээх ажиллагаа байнга явагдана.[4] Хууль тогтоомж нь өөр өөр хугацаанд батлагдсан, нарийвчилсан хэд хэдэн хэм хэмжээ тогтоосон байдаг. Ийм байдал нь тэдгээрийг олж мэдэх, зөв хэрэглэхэд бэрхшээл учруулдаг. Тиймээс ч хууль тогтоомжийг системчлэх шаардлага бий болдог[5] байна.

Дэлхийн эрх зүйн түүхийн хөгжлийн явцад “Кодификаци” *(англ. Codification)*-ийг “Кодекс” буюу төрөлжсөн хуулийн талаас нь түлхүү судалж, ойлгож ирсэн байх бөгөөд энэ нь шууд утгаараа “хууль тогтоомжийг агуулга болон тодорхой салбар эрх зүйгээр нэгтгэж, төрөлжүүлэн хуульчлах арга[6] буюу хууль тогтоох байгууллагаас баталж буй үйл ажиллагаа” юм. Гэвч кодекс буюу төрөлжсөн хууль нь кодификацийн гагцхүү нэг хэсэг бөгөөд эрх зүйн актыг системчлэх ажиллагааг мөн кодификацид хамруулан ойлгох учиртай.

Иймд дурдсан агуулгын хүрээнд авч үзвэл, хэдий кодификацид кодекс хамаардаг боловч кодификаци нь илүү өргөн хүрээтэй ойлголт бөгөөд үүнийг уламжлалт утгаар нь авч үзэхээс гадна эрх зүйн актын системчлэл талаас нь судлах шаардлагатай. Өнөөдрийн байдлаар кодификацийг өргөн утгаар нь буюу эрх зүйн актын системчлэл болон төрөлжсөн хуулийн аль аль талаас нь гагцхүү ОХУ-ын

[1] Тус судалгааг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа удирдаж, Эрдэм шинжилгээний ажилтан Ц.Оюунчимэг, С.Цэрэндолгор нар хамтран гүйцэтгэв.

[2] О.Амархүү, Эрх зүйн онолын арван таван сэдэв (УБ: Адмон хэвлэл, 2008), 59 дэх тал.

[3] Системчилсэн эмхэтгэлийг бэлтгэхэд а/ инкорпораци, б/ кодификаци гэсэн үндсэн хоёр аргыг түлхүү хэрэглэдэг.

[4] Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник (УБ: BCI хэвлэл, 2016), 119 дэх тал.

[5] О.Амархүү, Эрх зүйн онолын арван таван сэдэв (УБ: Адмон хэвлэл, 2008), 59 дэх тал.

[6] Мөн тэнд.

эрдэмтэн Т.В.Кашанина “Хууль зүйн техник” (Юридическая техника)[7] бүтээлдээ дурдсан байна.

Монгол Улсад хэрэглэгдэж буй хууль зүйн техникийн сурах бичиг, бүтээлийг үзвэл, эрх зүйн актын системчлэлийг кодификацаас тусад нь буюу “хууль тогтоомжийн системчлэл”-ийн үндсэн дөрвөн аргын нэг хэмээж, агуулгаар нь “Эрх зүйн актын бүртгэл буюу лавлагаа мэдээллийн сан бүрдүүлэх”[8] ажиллагаанд хамааруулжээ. Гэвч “... Эрх зүйн актын бүртгэл нь кодификаци, инкорпорацийн зайлшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тэдгээрийн анхан шат хэмээн үзэж болно”[9] гэснээр кодификаци хэмээх өргөн ойлголтын нэг бүрдэл хэсэг нь эрх зүйн актын системчлэл мөн болохыг дүгнэж болно.

Түүнчлэн нэр томьёоны хувьд “кодификаци” гэвэл ихэвчлэн төрөлжсөн хууль буюу кодексийг ойлгох хандлага давамгайлах төдийгүй “эрх зүйн актын системчлэл”, “эрх зүйн актын ангилал”, “эрх зүйн актын бүртгэл” зэрэг олон янзаар бичигдэж байгаа тул хоёрдмол утга гаргахгүй байх үүднээс энэхүү судалгаанд “эрх зүйн актын системчлэл” гэсэн нэршлээр бичлээ.

Эрх зүйн актын системчлэлийг “... лавлагаа мэдээллийн ажил” хэмээн үзэж болно. Лавлагаа, мэдээллийн сан бүрдүүлэх арга ажиллагаа нь хууль тогтоомжийн системчлэлийн эхний шатны бааз суурь, тасралтгүй үргэлжилдэг ажил мөн.[10] Системчлэл нь хууль, эрх зүйн хэм хэмжээ бүхий актыг цуглуулах, тэдгээрийг тусгайлан батлагдсан ангиллын дагуу ангилан индексжүүлэн төрөлжүүлэх, төрөлжүүлсэн каталог, карт хөтлөх, механик буюу цахим тооцоолуурын автоматжуулсан сан бүрдүүлэх ажиллагаанаас бүрдэнэ. Лавлагаа, мэдээллийн санг:

- Үндэсний хууль тогтоомжийн;
- Шүүхийн шийдвэрийн;
- Захиргааны хэм хэмжээний актын;
- Олон Улсын гэрээ хэлэлцээрийн гэж ангилж болно.

Монгол Улсын хувьд хууль тогтоомжийг системчлэх ажил 1950-иад оны сүүлчээр эхэлж, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Хэрэг эрхлэх газарт Хууль цаазын хороо байгуулан ажиллуулсан түүхтэй. Системчлэлийн ажил 1921 оноос батлагдан гарсан бүх хууль тогтоомжийг хүчинтэй эсэхийг харгалзахгүйгээр худам монгол бичгээс кирилл үсэгт хуулбарлан буулгахаас гараагаа эхэлж, тэдгээрийг тусгайлан баталсан ангиллын дагуу улс ардын аж ахуйн болон эрх зүйн салбараар төрөлжүүлэн лавлагаа, мэдээллийн санг картаар бүрдүүлсэн нөр их хөдөлмөрөөр бүртгэгдэж байжээ.[11]

Дараа нь 1960-аад оны дунд үеэс инкорпорацийн аргаар он дараалын системчилсэн эмхэтгэлүүдийг бэлтгэн хэвлүүлж, хууль тогтоомжийг боловсронгуй болгох шаардлагын үүднээс системчлэлийн ажлыг улам нарийвчлан үргэлжлүүлэх Улсын комисс 1982 онд байгуулагдан ажиллажээ. Тэрхүү комисс хууль тогтоомжийн системчлэлийг инкорпорацийн болон кодификацийн аргаар хослуулан хийж, 1990 он хүртэлх хугацаанд төрийн байгуулалт, эдийн засаг, нийгэм, соёл, боловсрол зэрэг салбаруудаар төрөлжүүлсэн “БНМАУ-ын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн системчилсэн бүрэн эмхэтгэл долоон боть”-ийг хэвлүүлсэн[12] байна.

Тус долоон ботиос гадна Үндсэн хууль, засаг захиргаа, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, их барилга, тээвэр, холбоо, шинжлэх ухаан, ардын боловсрол, соёл гэгээрэл,

[7] Т.В.Кашанина, Юридическая техника (Москва: Норма-Инфра-М, 2011), с. 341-343.

[8] Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник (УБ: BCI хэвлэл, 2016), 126 дахь тал.

[9] Мөн тэнд, 129 дэх тал.

[10] О.Амархүү, Эрх зүйн онолын арван таван сэдэв (УБ: Адмон хэвлэл, 2008), 61 дэх тал.

[11] Мөн тэнд, 62-63 дахь тал.

[12] Мөн тэнд.

эрүүлийг хамгаалах, батлан хамгаалах, хэв журмын, биеийн тамир спортын зэрэг нийгмийн харилцааны болон эрх зүйн зохих салбар, дэд салбараар ангилж эрэмбэлсэн олон зүйл эмхэтгэл гарган хэрэглэж ирсэн түүхтэй. Хууль зүйн үндэсний төв (тухайн үеийн нэршлээр) 2008 онд хүчин төгөлдөр хууль тогтоомжийн сугалбар хуудастай 4 боть эмхэтгэлийг "Монгол Улсын хууль" нэрээр хэвлэн гаргасан нь хэрэглээний талаасаа ихээхэн чухал дорвитой бүтээл болсон.[13]

2.2. Системчлэх арга, онцлог шинж, давуу тал

Нийтийн болон хувийн эрх зүйн хуулийн этгээдийн аль нь байхаас үл хамааран хууль дээдлэх ёсыг сахиж, хуульд нийцсэн үйл ажиллагаа явуулах үүрэгтэй бөгөөд "... эрх зүйг хэрэглэх үед хүчин төгөлдөр хууль тогтоомжийг л баримтлах учиртай. Иймээс үүнийг хэрэгжүүлэгч эрх бүхий албан тушаалтнууд хэрэглэх гэж байгаа хуулиа хүчин төгөлдөр эсэхийг сайн магадлан шалгаж хэрэглэх ёстой.[14]

Эрх зүй бүтээх ажиллагааг хууль тогтоомжийн нарийвчилсан, бүрэн дүүрэн бүртгэлгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй юм. Хэрэв ийм бүртгэлгүй бол мэргэшлийн талаас чанартай сайн хууль боловсруулах, түүнд экспертиз хийх боломж хомс болно. Эрх зүйн актын бүртгэл хийхгүйгээр эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх боломжгүй. Өөрөөр хэлбэл, эрх зүйн актын бүртгэл нь эрх зүйн субъектуудын мэдээллийн хэрэгцээг хангах чиглэлээр үйлчилнэ.[15]

Эрх зүйн актын системчлэлийн төрөл, хэлбэр олон янз бөгөөд иж бүрэн /институтчилсэн, сэдэвчилсэн/, дагнасан, холимог, албан ёсны ба албан бус, мэргэжил-техникийн, шинжлэн боловсруулалтын, түүхчилсэн, хэсэгчилсэн, хэрэглээний, судалгааны гэхчлэн хамрах хүрээ, сэдэв, зорилго, зориулалт, хүчин чадал, ач холбогдлын хувьд олон хэлбэр дүрстэй.[16] Ерөнхийдөө эрх зүйн актын системчлэлийн дараах үндсэн хоёр төрөл байна:

- Албан ёсны: Албан ёсны бүртгэлийг төрийн байгууллагуудын хууль зүйн албад гүйцэтгэнэ.
- Албан бус: Улсын хэмжээний бүх актыг хамарсан бүртгэлийг тухайн байгууллага болон хувь хүн гүйцэтгэх боломжгүй тул өөрсдийн хэрэгцээнд нийцүүлэн бүртгэлийн ажлыг хэрэгжүүлнэ.

Түүнчлэн эрх зүйн актын системчлэлийн янз бүрийн арга байдгаас гол төлөв дараах аргуудыг хэрэглэдэг:

- Картжуулалт: Энэ нь эрх зүйн актын системчлэлийн хамгийн түгээмэл арга бөгөөд картуудыг тодорхой дэс дараалалд байрлуулан актыг баталсан байгууллага, нэр, баталсан огноо зэрэг мэдээллийг тусгадаг. Картжуулан оруулсан мэдээлэл актын талаар мэдлэг олж авахад тус дөхөм болох, шууд сонголт хийж авах боломжоор хангах, актыг буцааж хэвэнд нь оруулах, тэдгээрээс дахин шинэ эшлэл хийх зэргээр ашигладаг. Үүнтэй холбогдуулан дурдахад, төрийн захиргааны байгууллагуудад "кодификатор" гэх хууль, зарлиг гэхчлэнг зохих ангиллын дагуу шошголж /"карталж"/, "шивж" лавлагаа өгдөг орон тоо байдаг.[17]
- Эмхэтгэсэн хавтас: Энэ аргыг эрх зүйн актын тоо хэмжээ цөөхөн бол ашиглахад тохиромжтой. Энэ тохиолдолд актыг тодорхой дэс дараалалд оруулж тусгай хавтаст хийж ашиглана.
- Мэдээлэл хайлтын систем: Техник технологи хөгжиж, өдөр тутмын хэрэглээнд нэвтэрсэн өнөө үед дээрх аргууд хоцрогдож, эрх зүйн

[13] Б.Чимид "Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэлийн онол, практикийн ач холбогдол" (УБ: 2010), https://www.legalinfo.mn/details/535 хаягаас үзнэ үү.

[14] Д.Лүндээжанцан, Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник (УБ: BCI хэвлэл, 2016), 128 дахь тал.

[15] Мөн тэнд, 129 дэх тал.

[16] Б.Чимид "Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэлийн онол, практикийн ач холбогдол" (УБ: 2010), https://www.legalinfo.mn/details/535 хаягаас үзнэ үү.

[17] Мөн тэнд.

мэдээллийн нэгдсэн систем буюу эрх зүйн актын бүртгэлийг нэг дор цахим хэлбэрт оруулсан хувилбар түгээмэл ашиглагдаж байна.

Эрх зүйн актын системчлэлийн давуу талыг дараах байдлаар тодорхойлж болох юм. Кодификаци байнга, тасралтгүй хийснээр:

- Хууль тогтоомж маш тодорхой, уялдаа холбоотой болдог;
- Хууль илүү энгийн, бүгдэд хүртээлтэй, ойлгогдох боломжтой болж, улмаар иргэд эрх, үүргээ сайтар ухамсарлан мэддэг;
- Хууль хооронд давхардал, хийдэл, зөрчилдөөн бага гардаг;
- Хуулийг тогтвортой[18] байлгадаг. Хуулийн тогтвортой байдал гэдэг тун чухал тул хуулийг хэрэглэх явцад эргэлзээ тээнэгэлзэл төрөх явдал багассанаар хууль хэрэглээ илүү хялбар болдог;
- Кодификаци нь нэгдмэл, өргөн хүрээний хэрэглээг нийгэмд авчирдаг тул улс орны хөгжил төлөвлөгөөний дагуу урагшилдаг.

ГУРАВ. ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Нийгмийн хөгжлийн явцад хүмүүсийн хэлзүйн чадвар өсөн нэмэгдэж, хууль зүйн салбар дахь төрөл бүрийн ялгаатай нэр томьёог ойлгож, ялган зааглахад өөр өөр нэр томьёо ашиглах боломжтой болжээ. Энэ үүднээс хууль тогтоомжийн системчлэлийн бусад төрлүүдийг мөн "кодификаци" гэсэн нэг нэр томьёогоор илэрхийлэх шаардлагагүй болов уу. Иймд ямартай ч Оросын хууль зүйн шинжлэх ухаанд "кодификаци" гэсэн нэр томьёог онцгой утгаар хэрэглэх нь зүйтэй гэж зарим эрдэмтэд[19] нь үзэж байна. Энэ тухай тус судалгааны Хоёр дахь хэсгийн 2.1-д дурдсан тул үл нуршин Монгол Улсад өнөөдрийн байдлаар кодификацийн аргаар эрх зүйн актыг системчлэх үйл ажиллагаа ямар түвшинд байгааг авч үзье.

Эрх зүйн актын албан ёсны бүртгэлийг төрийн байгууллагуудын хууль зүйн албад гүйцэтгэх бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн[20] 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэгт "Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага мэдээлэл, лавлагаа өгөх зорилгоор Монгол Улсын хүчин төгөлдөр хууль тогтоомжийн нэгдсэн санг цаасан болон цахим хэлбэрээр бүрдүүлэх, хууль тогтоомжийг системчлэх ажлыг хариуцан зохион байгуулна" гэж заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн яам эрх зүйн актын бүртгэлийг гардан хэрэгжүүлж байна.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэгт "... хууль тогтоомжийн сан бүрдүүлэх, системчлэн ангилж, хууль тогтоомжийн хувийн хэрэг хөтлөх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална" гэсний дагуу эрх зүйн актын системчлэл буюу кодификаци хийхэд баримталж буй дараах журам байгааг хүснэгт хэлбэрээр жагсаавал:

Хүснэгт 1. *Баримталж буй журмын жагсаалт*

Нэр	Дугаар	Батлагдсан огноо
"Эрх зүйн актын ангилагчийг батлах тухай"[1]	Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаал №147	2003-08-15
Нэмэлт тайлбар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2017 оны Үр дүнгийн гэрээнд заасны дагуу Хууль тогтоомжийн ангилагчийг шинэчлэн боловсруулах ажлын хэсгээс хийж гүйцэтгэсэн ажлын тайлан болон Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2003 оны 147 дугаар тушаалаар батлагдсан "Эрх зүйн актын ангилагч"-ийг шинэчлэн боловсронгуй болгох саналыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд 2017 оны 6 дугаар сарын 29-ний өдөр 01/353 тоот албан бичгээр хүргүүлсэн.		
"Хууль тогтоомжийн сан бүрдүүлж, системчлэн ангилах журам"	Хууль зүйн сайдын тушаалын нэгдүгээр хавсралт А/221	2016-07-01

[18] Gunther A.Weiss "The Enchantment of Codification in the Common Law World" *Yale Journal of International Law* (2000) 8 (25): s.469.

[19] Т.В.Кашанина, Юридическая техника (Москва: Норма-Инфра-М, 2011), с. 343.

[20] Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №25

Хуулийн хүрээлэн www.mglaw.mn

“Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санг эрхлэн хөтлөх журам”	Хууль зүйн сайдын тушаалын нэгдүгээр хавсралт А/226	2016-07-01
“Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журам”	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга нарын хамтарсан тушаал, захирамжийн нэгдүгээр хавсралт 17/А/10/А/04/36/02/03/А/01	2017-01-16
“Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах мэдээллийн төрөл, хугацаа, хариуцах байгууллага”	Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга, Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга нарын хамтарсан тушаал, захирамжийн хоёрдугаар хавсралт 17/А/10/А/04/36/02/03/А/01	2017-01-16
“Эрх зүйн актыг бүртгэх, эрх зүйн актын ангилагчийг ашиглаж системчилсэн картын сан, хяналтын хувийг хөтлөх аргачилсан зөвлөмж”	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын тушаал	2009-03-11

Эрх зүйн актыг системчлэхэд дээрх хүснэгтэд дурдсан баримт бичгүүдийг мөрдөж байгаа бөгөөд эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем болох www.legalinfo.mn цахим хуудаст Монгол Улсын хэмжээнд батлагдсан бүхий л хууль тогтоомжийг, Хууль зүй, дотоод хэргийн яамны www.mojha.gov.mn цахим хуудаст захиргааны хэм хэмжээний актын жагсаалтыг тус тус нийтэлж байна. Харин УИХ-д өргөн мэдүүлсэн болон олон нийтээр хэлэлцүүлж буй хуулийн төслүүдийг www.mojha.gov.mn, http://forum.parliament.mn/ цахим хуудсуудад тус тус нээлттэй байршуулж байгаа бол Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан болох www.shuukh.mn цахим хуудаст Эрүү, Иргэн, Захиргааны хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүхийн шийдвэрүүдийг нийтэлж байна.

Үүнээс үзэхэд манай улсын хувьд өмнөх хэсэгт дурдсанчлан, эрх зүйн актыг системчлэх бусад аргууд төдийлөн хэрэглэгдэхээ больж, улмаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн цахим системийг ашиглах болжээ гэж үзэж болохоор байна. Иймд цаашид цахим хуудас ашиглан эрх зүйн актыг системчлэх ажлыг цаашид улам боловсронгуй болгох талаар анхаарах шаардлагатай.

ДӨРӨВ. ГАДААД ОРНЫ ТУРШЛАГА

Гадаад улсын эрх зүйн шийдлийг хүлээн авахын тулд, нэгдүгээрт, эрх зүйн хэм хэмжээ нь “экспортолж” буй улсдаа хэрэгжих боломжтой, шударга ёсыг хангасан гэдэг нь нотлогдсон эсэх, хоёрдугаарт, хүлээн авах гэж байгаа улсын нөхцөл, эрх зүйн тогтолцоонд үйлчлэх боломжтой эсэхийг судлах ёстой байдаг.[21] Түүнчлэн харьцуулсан судалгааны объектыг “харьцуулж болохуйц” эсэхийг[22] судалсны үндсэн дээр сонгох учиртай.

[21] Б.Амарсанаа, *Харьцуулсан эрх зүй судлал*, 2 дахь хэвлэл (УБ: МУИС Пресс, 2014), 29 дэх тал.

[22] UvA, Amsterdam Law School, *Thesis Manual* (Amsterdam: University of Amsterdam, 2005), p.17.

Эрх зүйн актын системчлэл буюу кодификаци, тэр дундаа эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем бий болгох, хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем бүтээх ажиллагаа нь эрх зүйн бүлээс үл хамааран улс бүрт байх тогтолцоо тул энэ хэсэгт эрх зүйн бүлийг харгалзахгүйгээр эрх зүйн актын системчлэлийн цогц, бүрэн цахим систем бүхий улсуудын туршлагыг судаллаа.

4.1. Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

4.1.1. Эрх зүйн актын нэгдсэн сан:

АНУ дахь эрх зүйн актын нэгдсэн санг албан ёсны болон албан ёсны бус гэж хоёр ангилж болох юм. Учир нь хууль тогтоомжийг албан ёсоор нийтэлдэг цахим хуудсаас гадна хувь хүн, хуулийн этгээдэд тухайн хуулийг хэрэглэхэд дөхөм болох зорилгоор хялбар шийдэлтэй бүтээгдсэн албан бус цахим хуудсууд байдаг.

АНУ-ын Холбооны бүх хууль тогтоомжийн нэгдсэн албан ёсны цахим хуудас нь www.congress.gov болон www.govinfo.gov юм. Эдгээр хуудсуудад нийтлэгдсэн хууль тогтоомжийг гуравдагч хэрэглэгчдэд илүү ойлгомжтой байдлаар http://www.loc.gov/law/help/guide.php хуудаснаас үзэж болно. Түүнчлэн мужууд нь дотоодын хууль тогтоомжийг нийтэлдэг тус тусын цахим хуудастай бөгөөд тэдгээрийг https://www.congress.gov/state-legislature-websites хуудсанд байршуулдаг.

Тус улсын хууль тогтоомжийг дотор нь “Хувийн”, “Нийтийн” гэж ангилах бөгөөд хэддүгээр Конгрессийн үед батлагдсанаар нь эрэмбэлэн нэрлэсэн байна. Тухайлбал, Public Law 107-101 гэвэл 107 дугаар Конгрессийн үед батлагдсан, 101 дүгээр Нийтийн эрх зүйн хууль гэж ойлгоно. Хувийн эрх зүйн хуулийн хувьд дугаарлалт адил, гагцхүү Private Law гэсэн нэршил урд нь бичигддэг.

Мөн тус улсын ихэнх хуулиудад кодификаци хийж, нэгтгэдэг бөгөөд тэдгээр нь тогтмол 54 бүлгээс бүрддэг болоч 6 жил тутамд шинээр батлагдсан хуулиудыг АНУ-ын Засгийн газрын Хэвлэлийн газар /Government Publishing Office (GPO)/ хэмээх АНУ-ын хууль тогтоох байгууллагын харьяа агентлагаас тохирох бүлэг, ангилал тус бүрд шинээр нэмж, эмхэтгэсэн хувилбарыг хэвлэн нийтэлдэг. Эдгээрийг http://uscode.house.gov/browse.xhtml цахим хуудаст тухай бүрд нь байршуулдаг.

Дээр дурдсан хуудсуудад хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийг нэн даруй оруулах, хууль тогтоомж хоорондын уялдаа холбоог хангах тал дээр онцгой анхаардаг. Түүнчлэн бүх хууль тогтоомжийг бус шүүхийн практикт бодит гардаг хэрэг маргаантай холбогдолтой, өдөр тутмын эрх зүйн харилцаанд түгээмэл хэрэглэгддэг хуулиудын талаар хувь хүн, хуулийн этгээдэд мэдээлэл өгөх зорилго бүхий https://www.alllaw.com/, https://statelaws.findlaw.com/ зэрэг цахим хуудсууд ажилладаг.

АНУ-ын эрх зүйн актын нэгдсэн сангийн хайлтын системийн давуу тал нь:

- үсгийн дараалаар (англи хэлний A-Z үсэг хүртэлх дараалаар);
- ангилал/категориор (хуулийн төсөл, хувийн буюу нийтийн эрх зүйн хууль, эрх зүйн бусад акт, төрөлжсөн хууль);
- огноогоор;
- хороогоор (Нийтийн танхим болон Сенатад харьяалагддаг олон салбар хороодын чухам аль хороонд хамааралтай хууль тогтоомж болох);
- зохиогчоор (Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн аль байгууллагад хамаарах буюу төсөл боловсруулсан агентлагаар) зэрэг олон сонголттой хайлт хийдэгт оршино.

4.1.2. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем:

АНУ-ын хэмжээнд батлагдаж буй 1973 оноос хойших бүх хуулийн төсөл, тэдгээрийн хэлэлцэж байгаа байдал, хууль бүтээх үйл явц зэргийг www.congress.gov цахим хуудаст байршуулдаг.

Тус улсад “танилцуулах-Сенат батлах-Нийтийн танхим батлах-Өөрчлөлт, засварыг шийдвэрлэх-Ерөнхийлөгчид хүргүүлэх” гэсэн дараалаар хууль бий

болдог. Сенат болон Нийтийн танхим тухайн хуулийн төслийг дэмжсэний дараа Ерөнхийлөгч гарын үсгээ зурж, баталгаажуулснаар хууль батлагдах бөгөөд түүнийг “Конгрессийн хууль” гэж нэрлэнэ. Ерөнхийлөгч хуульд гарын үсэг зурмагц хуулийг гарын үсэг зурсан дараалаар дугаарлана. Дээр дурдсанчлан, P.L.107-101 зэрэг.

Ингэхдээ хууль батлагдах үйл явц, нэмэлт, өөрчлөлт, хурлын тэмдэглэл, тайлан зэрэг бүх баримт бичгийг тухай бүрд нь огноотой нь дэлгэрэнгүй байдлаар цахим хуудаст байршуулдаг. Жишээлбэл, нэг хуулийн төслийг санамсаргүй түүврийн аргаар сонгож, зургаар үзүүлье.

Зураг 1. *АНУ дахь хууль боловсруулах үйл явц цахим хуудаст харагдах байдал*



Зургаас үзвэл 115 дахь Конгресс буюу 2017-2018 оны хооронд батлагдсан “Америкийн Усны Дэд бүтцийн тухай хууль” байх бөгөөд 2018 оны 6 дугаар сарын 7-ны өдөр анх танилцуулж, хамгийн сүүлд 2018 оны 10 дугаар сарын 23-ны өдөр “Нийтийн эрх зүйн хууль” болжээ. “Tracker” буюу үйл явцыг харвал хууль боловсруулах 6 үе шатны хамгийн сүүлчийн алхам болох “Хууль батлагдсан” төлөвт байна. Тодруулбал, хуулийн төсөл хэлэлцэж батлах үйл явц (шууд танилцуулах үе шатаас эхэлж байх тул боловсруулах үе шат хамаарахгүй байна) дунджаар 4 сарын турш үргэлжилжээ.

Түүнчлэн хуудасны доод хэсэгт *“Хураангуй”*, *“Хуулийн бичвэр”*, *“Үйлдэл”* (төсөл батлах явцыг огноотой нь дэлгэрэнгүй оруулсан байх бөгөөд тус хуульд нийт 48 удаагийн үйлдэл хийгдсэн байна), *“Нэр”* (төсөл байх хугацаанд хуулийг хэрхэн нэрлэх талаарх саналуудыг оруулсан бөгөөд тус хуулийн хувьд анх “Усны нөөцийг боловсронгуй болгох тухай” гэсэн нэртэй байсан байна), *“Нэмэлт, өөрчлөлт”*, *“Хамтран санаачлагч”* (тус хэсэгт дарвал хуулийн төслийн санаачлагч болон хамтран санаачилсан сенаторын нэр байх бөгөөд энэхүү хуулийн хувьд санаачлагч 1, хамтран санаачлагч 1, нийт 2 сенатор санаачилжээ), *“Хороод”* (хуулийн төсөлд хамаарах хороод), *“Холбоотой төсөл”* (санаачлагч, журам, бичвэр зэргээрээ адил төстэй байж болох бусад хуулийн төслүүд) гэсэн булангууд тус тус байна.

Нэмж дурдвал, АНУ-д боловсруулсан бэлэн хуулийн төслийг засварлах, кодчилох, техник талаас нь хянах чиг үүрэг бүхий Open Law Library[23] нэртэй цахим хуудас ажилладаг байна. Өөрөөр хэлбэл, боловсруулсан төслөө хянах гэж олон сарын хугацаа алдалгүйгээр тус байгууллагад хандан техник ажиллагаатай холбоотой бусад зүйлсийг хийлгэх боломжтой. Гэсэн хэдий ч, Конгрессийн түвшинд

[23] http://www.openlawlib.org/platform/open-law-codify/ хаягаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

Хуулийн үндэсний хүрээлэн www.mongolii.gov.mn

баталдаг холбооны хуулиудыг ийнхүү хянуулах боломжгүй бөгөөд гол төлөв мужийн түвшинд баталдаг хууль тогтоомжид кодификаци хийсэн байна. Гэвч ингэхдээ холбооны хуулиас мужид хамааралтай зохицуулалтыг мужийн хуульд нэгтгэж, системчилж болохоор ажээ.

Мөн түүнчлэн дээрхтэй адил чиг үүрэгтэй Municode[24] хэмээх цахим хуудас ажилладаг ба мэргэжлийн өмгөөлөгчдийн тусламжтайгаар муж, тэр дундаа хотуудын хууль тогтоомжийг нэгтгэх, системчлэх ажиллагаа хийдэг. Хэдийгээр эдгээр цахим хуудсууд нь Конгрессийн цахим хуудас, хууль батлах ажиллагаатай харьцуулбал харьцангуй хялбар, хурдан боловч ажиллагааг автомат цахим хэрэглүүрээр бус хувь хүн, баг хамт олон хийдэг гэдгийг анхаарах шаардлагатай. Түүнээс гадна, эдгээр нь албан ёсны төрийн захиргааны байгууллага биш тул ийм төрлийн систем Монгол Улсад төдийлөн тохиромжтой биш юм. Харин одоо байгаа цахим хуудсуудаа Конгрессийн хууль тогтоомжийн төслийн албан ёсны цахим хуудас шиг илүү боловсронгуй болгож сайжруулах нь оновчтой арга байж болох юм.

4.2. ХБНГУ (Холбооны Бүгд Найрамдах Герман Улс)

4.2.1. Эрх зүйн актын нэгдсэн сан:

ХБНГУ-ын хууль тогтоомжийн нэгдсэн сангийн албан ёсны цахим хуудас нь ХБНГУ-ын Эрх зүйн мэдээллийн систем - https://www.gesetze-im-internet.de/index.html болно. Энд Холбооны хуулийн эмхэтгэлд нийтлэгдсэн хуулиудын цахим хувилбар байх бөгөөд хуулийн тайлбар, хуулийн албан ёсны орчуулсан хувилбар байршдаг. Түүнчлэн мужийн хууль тогтоомжийг https://justiz.de/bundlaender/index.php цахим хуудаснаас муж тус бүрийн нэр бүхий холбоос дээр даран үзэх боломжтой.

Холбооны Үндсэн хуулийн шүүх, Эрүүгийн хэргийн шүүх, Захиргааны хэргийн шүүх, Татварын шүүх, Хөдөлмөрийн шүүх, Дээд шүүх зэрэг Холбооны шүүхийн шийдвэрүүдийг https://www.rechtsprechung-im-internet.de цахим хуудаст; Холбооны Засгийн газрын яамдын захиргааны хэм хэмжээний актыг http://www.verwaltungsvorschriften-im-internet.de цахим хуудаст тус тус байршуулдаг байна. Мөн Холбооны хуулийн эмхэтгэл (Bundesgesetzblatt)-ийг хэвлэгдсэн даруйд нь эмхэтгэл хэлбэрээр нь https://www.bgbl.de/ цахим хуудаст байршуулдаг.

Ингэхдээ дээр дурдсан хуудас бүрт байрших хууль тогтоомжийг татаж авах хувилбар нь сонголттой байдагт эдгээрийн давуу тал оршино. Хууль тогтоомжийг үсгийн дараалал болон дугаараар эрэмбэлсэн байгаа нь Монгол Улсад хэрэглэгдэж буй www.legalinfo.mn цахим хуудастай ижил төстэй боловч бүх хууль тогтоомж, шүүхийн шийдвэр, захиргааны хэм хэмжээний акт, хуулийн эмхэтгэлийг HTML, PDF, XML, EPUB гэсэн өргөтгөлөөс сонгон үзэх, татаж авах боломжтой байршсанаар илүү дэвшилттэй байна.

Хэдийгээр хууль тогтоомж, шүүхийн шийдвэр зэргийг өөр өөр цахим хуудаст байршуулж буй боловч эдгээрийн загвар, бүтэц, татаж авах хувилбар, хайлтын горим зэрэг нь яг адил учраас нэгдмэл, бүрэн цогц систем гэж үзэж болохоор байна.

4.2.2. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем:

ХБНГУ-ын хууль боловсруулах, батлах үйл явцын талаар мэдээлэл Бундесрат[25] болон Бундестагийн[26] албан ёсны цахим хуудаст ил тод, хангалттай байх боловч хууль тогтоомжийн төслийг байршуулаагүй байна.

Өмнөх хэсэгт дурдсан хууль тогтоомжийн албан ёсны цахим хуудас болох https://www.gesetze-im-internet.de/index.html хуудаст гагцхүү батлагдан гарсан хууль тогтоомжууд байх бөгөөд эрх зүйн актын нэгдсэн санг маш сайн хөгжүүлсэн хэдий ч хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим системийг

[24] https://www.municode.com/codification-and-recodification/#footer хаягаас дэлгэрэнгүйг үзнэ үү.

[25] https://www.bundesrat.de хаягаас үзнэ үү.

[26] https://www.bundestag.de хаягаас үзнэ үү.

хөгжүүлээгүй байна. Өөрөөр хэлбэл, хууль тогтоох үйл явцаас илүү батлагдсан хуулийг сурталчлах ажиллагаанд чухал ач холбогдол өгдөгтэй холбон ойлгож болох юм.

4.3. ОХУ (Оросын Холбооны Улс**)**

4.3.1. Эрх зүйн актын нэгдсэн сан:

Төрийн эрх мэдлийн холбооны улсын хэмжээний байгууллага бүрт эрх зүйн мэдээллийн мэдээлэл хайлтын автоматжуулсан систем байна.[27] Үүнээс гадна хувийн мэдээлэл хайлтын системүүд өргөн дэлгэр хөгжиж байгаа билээ. Жишээлбэл, “КонсультантПлюс”[28], “Гарант”[29], “Кодекс”[30] зэрэг нь зүгээр нэг эрх зүйн актын цахим карт биш юм.

Мэдээлэл хайлтын системийн онцлог давуу талыг[31] товч дурдвал:

- Мэдээлэл хайлтын систем нь сонирхож буй эрх зүйн тулгамдсан асуудлаар бүрэн хэмжээний мэдээлэл олж авах бололцоогоор хангана. Тухайлбал, мэдээлэл хайлтын систем болох “КонсультантПлюс”-ын мэдээллийн сан 1,5 сая баримт бичгээс бүрдэх бөгөөд эрх зүйн актын бүх төрөл, бүх түвшинг (Холбоо, Мужийн хэмжээний) хамаарна.
- Мэдээлэл хайлтын системийн мэдээллийн сан нь байнга нэмэгдэн баяжиж өөрчлөгддөг бөгөөд эрх зүйн актуудын нэмэлт, өөрчлөлт орсон болон шинэчлэн найруулсан хувилбарыг байршуулдаг.
- Мэдээлэл хайлтын систем нь мэдээллийн сан дахь баримт бичиг хоорондын уялдаа холбоог харахад тусалдаг.
- Сэдэвчилсэн сонголт буюу нарийвчилсан хайлт хийх боломжтой тул хэрэгтэй эрх зүйн актаа богино хугацаанд олдог.

4.3.2. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем:

Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим системийн хувьд ОХУ-ын загвар нэлээд боловсронгуй, дэвшилттэй юм. ОХУ-ын Төрийн Думын хууль тогтоомжийн мэдээллийн албан ёсны цахим хуудас болох http://sozd.duma.gov.ru/ хуудаст бүх хуулийн төслийг хэлэлцэх үйл явцын хамт дэлгэрэнгүй байдлаар байршуулсан байдаг. Тус цахим хуудас нь АНУ-ын Конгрессийн хуулийн төслийн цахим хуудастай нэлээд төстэй төдийгүй түүнээс дэвшилтэт, ойлгомжтой гэж хэлж болно.

Тус цахим хуудас руу зочлоход нүүр хуудас хэсэгт “Хуулийн төсөл”, “Хуулийн төсөл хэлэлцэх үе шат”, “Хуулийн төсөлтэй холбогдох уулзалт, төлөвлөх баримт бичгүүд” гэсэн булангууд байна. Жишээлбэл, нэг хуулийн төслийг санамсаргүй түүврийн аргаар сонгон авч зураг хэлбэрээр үзүүлбэл:

[27] Т.В.Кашанина, Юридическая техника (Москва: Норма-Инфра-М, 2011), с. 365.

[28] http://www.consultant.ru/ хаягаас үзнэ үү.

[29] http://www.garant.ru/ хаягаас үзнэ үү.

[30] https://kodeks.ru/ хаягаас үзнэ үү.

[31] Т.В.Кашанина, Юридическая техника (Москва: Норма-Инфра-М, 2011), с. 365-366.

Зураг 2. *ОХУ дахь хууль боловсруулах үйл явц цахим хуудаст харагдах байдал*



Юун түрүүнд хайлт хэсгээс сонирхож буй хуулийн төслөө хайна. Бүртгэлийн дугаар, нэр, явц, хэлэлцүүлэгт танилцуулсан байдал, бүртгэсэн огноо зэрэг шалгуураас өөрийн сонирхож буй мэдээлэлд тулгуурлан хүссэн мэдээллээ хайж болно. Тухайлбал, зураг үзүүлснээр 6 дахь удаагийн хэлэлцүүлгийн үе шатыг дамжсан хуулийн төслийг хайхад нийт 6382 хайлтын илэрц гарч иржээ.

Жишээ болгон сонгосон хуулийн төсөл нь “Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төсөл байна.

Зураг 3. *“Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн харагдах байдал*



Хуулийн үндэсний хүрээлэн www.nlegov.mn

Дээрх зургаас үзвэл, “Хууль санаачлагч”, “Хуулийн төслийн хэлбэр”, “Хариуцах хороо” (манай тохиолдолд “Мэдээллийн бодлого, мэдээллийн технологи, харилцаа холбооны Төрийн Думын байнгын хороо” байна), “Хууль тогтоомжийн ангилал” (120.050.000 Мэдээллийн хэрэгсэл), “Хуулийн төслийн сэдэвчилсэн ангилал” (эдийн засгийн бодлого), “Гол агуулга” (“Радио давтамжийн системийг хөгжүүлэх”), “Хууль боловсруулах үеийн бичвэр” зэрэг мэдээлэл байна.

Зураг 4. *“Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийн үйл явц*



Дээрх зурагт хуулийн төсөл хэлэлцэх, батлах үйл явцыг дэлгэрэнгүй өгүүлсэн байх бөгөөд тухай бүрийн эрх зүйн баримт бичиг, тэмдэглэл, дүрс бичлэгийг хавсаргасан байна.

Зураг 5. *“Олон нийтийн мэдээллийн хэрэгслийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийн төслийг дэмжсэн эсэх үзүүлэлт*



ОХУ-ын Төрийн Думын гишүүдээс тухайн хэлэлцүүлж буй хуулийн төслийг дэмжсэн буюу дэмжээгүй тоог нарийвчлан гаргажээ.

Хуулийн хүрээний хөгжлийн www.rdi.gov.mn

Энэ маягаар ОХУ-д хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах ажиллагаа ил тод, ойлгомжтой, хүртээмжтэй, дэлгэрэнгүй байдлаар хийгдэж байна.

ТАВ. ДҮГНЭЛТ, САНАЛ

Кодификаци гэсэн ойлголт нь нэлээд өргөн хүрээний ойлголт бөгөөд өнөөдрийг хүртэл тус ойлголтыг явцуу, уламжлалт утгаар нь буюу төрөлжсөн хууль (кодекс)-ийн талаас нь тайлбарлаж, ойлгож иржээ. Гэтэл орчин үеийн эрх зүйн хувьд кодификацийг өргөн утгаар нь тайлбарлах шаардлага бий болж байгаа буюу эрх зүйн актын системчлэлийн талаас нь дэлгэрэнгүй тайлбарлах шаардлагатай байна. Иймд энэхүү судалгаанд тэрхүү өргөн утга, агуулга бүхий ойлголтын нэг хэсэг болох эрх зүйн актын системчлэл талаас нь судаллаа.

Эрх зүйн актын системчлэлийн гол зорилго нь хууль хоорондын уялдаа холбоог хангах, зөрчил, давхардал, хийдлийг арилгах юм. Эрх зүйн актын системчлэлийн олон төрлийн арга хэлбэр байдгаас техник технологи эрчимтэй хөгжиж буй өнөө үед улсууд “Эрх зүйн актын мэдээллийн сан”-г цахим хэлбэрээр боловсруулан ашиглах болжээ. Мөн түүнчлэн хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах ажиллагааг цахим хэлбэрээр олон нийтэд хүргэх болсон байна. Ингэснээр хууль тогтоомжтой холбогдсон мэдээллийн ашиглалтыг хялбаршуулах, үр ашгийг нь дээшлүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой.

Монгол Улсын хувьд эрх зүйн актын нэгдсэн санг www.legalinfo.mn албан ёсны цахим хуудсаар нэгтгэж, системчилсэн төдийгүй хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх ажиллагааг Улсын Их Хурлын цахим хэлэлцүүлэг болох www.forum.parliament.mn, Хууль зүй, дотоод хэргийн яамны www.mojha.gov.mn цахим хуудсуудаар тус тус нийтлэн хүргэж байна.

Энэхүү судалгааны “Гадаад орны туршлага” хэмээх дөрөв дэх хэсэгт эрх зүйн актын нэгдсэн сан болон хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх цахим системийг боловсронгуй байдлаар ашиглаж буй 3 улс болох АНУ, ХБНГУ, ОХУ-ыг сонгон авч судлав. Хэдийгээр эдгээр гурван улс нь гурвуулаа холбооны улс боловч дурдсан агуулгын хүрээнд эрх зүйн бүл, төрийн дэглэм харгалзахгүйгээр зөвхөн сайн туршлагыг судлах нь илүү хэрэгцээ, шаардлагатай байх тул ийн сонгон авсан билээ.

Дээрх 3 улсын туршлагаас харахад эрх зүйн актын системчлэлийг эрх зүйн актын нэгдсэн цахим сан боловсруулах замаар хөгжүүлж, хууль хоорондын уялдаа холбоог нарийн хангаж байна. Түүнчлэн хуулийн төсөл боловсруулахаас батлагдан гарах хүртэлх явцыг албан ёсны цахим хуудаст ил тод, дэлгэрэнгүй байршуулж байгаа нь сайн хууль батлагдах нэг үндэс гэж үзэж болно.

АНУ-ын хувьд батлагдсан хууль тогтоомж болон хэлэлцүүлгийн шатанд буй хуулийн төслүүдийг Конгрессийн цахим хуудаст нэгтгэн байршуулж, тус бүрт нь ойлгомжтой хайлтын систем, дэлгэрэнгүй зохицуулалтыг бий болгосноор хэрэглэгчдэд нэг дороос тухайн хууль тогтоомжийн цогц мэдээллийг авах боломжийг олгож байна.

ХБНГУ-ын хууль тогтоомж, тэдгээрийн тайлбар, орчуулга, шүүхийн шийдвэр, Холбооны хуулийн эмхэтгэл зэрэг нь тусдаа цахим хуудсуудад байршдаг боловч хэлбэрийн хувьд цахим хуудас бүрийн загвар, бүтэц, өнгө төрх адил тул нэгдсэн цогц систем гэж ойлгож болохоор ба тус бүрийн нүүр хуудасны зүүн талд бусад холбоосууд эмх цэгцтэй байрладаг тул хэрэглэгчид мөн л өөрийн сонирхсон мэдээллийг нэг дороос төвөггүй авах боломжтой. Харин хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх талаарх цахим хуудсыг хөгжүүлээгүй нь олон нийтэд батлагдсан хуулийг сурталчлах, тэдгээрийн уялдаа холбоог хангахад илүү ач холбогдол өгдөг гэж үзэж болохоор байна.

ОХУ-д эрх зүйн актын нэгдсэн сан болон хуулийн төсөл боловсруулах,

хэлэлцүүлэх цахим хуудсууд тусдаа буюу хуулийн төслийг хууль тогтоох байгууллага болох Төрийн Думын хуудаст байршуулсан байдаг хэдий ч цахим хуудас хоорондын уялдаа холбоог сайн хангасан тул хэрэглэгчдэд чирэгдэл төвөг учрахааргүй байна. Хууль тогтоомж болон хуулийн төслийг өөр өөр цахим хуудаст байршуулдгаараа манай улстай адил боловч цахим хуудсуудын загвар, бүтэц, агуулгын хувьд илүү ойлгомжтой, дэлгэрэнгүй, мэдээллүүдийг цаг алдалгүй оруулдаг, үе шат тус бүрийг нарийвчлан тайлагнадгаараа давуу талтай байна.

Иймд судалгааны хүрээнд хийсэн дүгнэлтийг үндэслэн дараах саналыг гаргаж байна. Үүнд:

1. *Эрх зүйн актын нэгдсэн санг боловсронгуй болгох үүднээс:*

- Өнөөдрийн байдлаар эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем дэх хууль тогтоомжийг гагцхүү үсгийн дараалал, огноо зэрэг хэлбэрийн шалгуураар ангилж буй бөгөөд цаашид зохицуулж буй харилцаагаар нарийвчлан ангилан системчлэх нь оновчтой.
- Салбар хуулиудын захиргааны хэм хэмжээний акттай холбогдох уялдаа холбоог хангах шаардлагатай. Тухайлбал, Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.3 дахь хэсэгт “Хууль зүйн хэлний салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг хууль зүйн болон соёлын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална” гэсний дагуу баталсан журмыг хуулийн зүйл, заалттай холбож өгөх. Ингэснээр салбарын хууль болон захиргааны хэм хэмжээний актын уялдаа холбоо нэлээд хангагдах юм.
- Хуульд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлттэй зохицуулалт байвал тухайн заалт дээр дарахад Үндсэн хуулийн цэцийн холбогдох дүгнэлт рүү шууд ордог /холбоосоор/ байдлаар холбох шаардлагатай бөгөөд ингэснээр хууль хэрэглээ илүү дөхөм болно.
- Хуулийн нэмэлт, өөрчлөлт орсон зохицуулалт нь тухайн хуулийн талаарх чухал мэдээллийг агуулдаг тул “нэмэлт, өөрчлөлт оруулсан” гэх өгүүлбэр дээр дарахад нэмэлт, өөрчлөлт орохоос өмнөх хувилбар болон дараах хувилбарын аль алиныг нь харж болохоор хөгжүүлэх шаардлагатай.

2. *Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, сурталчлах цахим систем боловсруулах үүднээс:*

- Энэхүү ажиллагааны хувьд АНУ болон ОХУ-ын цахим хуудсуудын загвар, бүтцийг судлах, тэдний туршлагыг нутагшуулах арга замыг эрэлхийлэх нь зүйтэй. Хуулийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх үе шатыг ил тод, дэлгэрэнгүй байдлаар байршуулснаар нэлээд чамбай, сайн хууль батлагдах үндэс болно.
- АНУ болон дэлхийн бусад оронд сүүлийн жилүүдэд эрчимтэй нэвтэрч буй хуулийн төслийг хянаж, засварлаж, кодолдог хувь хүн, хуулийн этгээдийн цахим хуудсыг нэвтрүүлэхээс илүүтэйгээр одоо байгаа цахим хуудсуудаа боловсронгуй болгох, үйл ажиллагааг нь сайжруулах шаардлагатай. Тодруулбал, хуулийн төсөл хэлэлцэхтэй холбоотой баримт бичиг, хэлэлцүүлгийн тэмдэглэл, хэлэлцүүлэгт оролцсон гишүүдийн санал, тоо баримт зэргийг нарийвчлан оруулах гэх мэт.

Хуулийн зүйн үйлчилгээний хэлтэс www.mjs.gov.mn

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Нэг. Хууль тогтоомж

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1
- Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2015), №25

Хоёр. Ном зохиол, гарын авлага, судалгааны тайлан

Монгол хэлээр

- Амарсанаа.Б. Харьцуулсан эрх зүй судлал, 2 дахь хэвлэл. УБ: МУИС Пресс, 2014.
- Амархүү.О. Эрх зүйн онолын арван таван сэдэв. УБ: Адмон хэвлэл, 2008.
- Лүндээжанцан.Д. Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник. УБ: BCI хэвлэл, 2010.
- Нарангэрэл.С. Эрх зүйн эх толь бичиг. УБ: Адмон хэвлэл, 2007.
- Түвшинтулга.А. нар. Хууль зүйн арга ажиллагаа /эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл/ (УБ: ХЗҮХ-гийн хэвлэх үйлдвэр, 2018).

Гадаад хэлээр (Орос)

- Кашанина.Т.В. Юридическая техника. Москва: Норма-Инфра-М, 2011.

Гурав. Судалгааны тайлан, илтгэл өгүүлэл

Монгол хэлээр

- Чимид.Б. “Хууль тогтоомжийг системчлэхэд Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэлийн онол, практикийн ач холбогдол” (УБ: 2010).

Гадаад хэлээр (Англи)

- Gunther A.Weiss “The Enchantment of Codification in the Common Law World” *Yale Journal of International Law* (2000) 8 (25).

Дөрөв. Цахим эх сурвалж

- “Detailed guide to the united states code content and features”, http://uscode.house.gov/detailed_guide.xhtml
- Municode - https://www.municode.com/codification-and-recodification/#footer
- Open Law Library - http://www.openlawlib.org/platform/open-law-codify/
- Rohit Kumar “Advantages and Disadvantages of Codification of Law”, https://lawjugaad.com/codification-of-law-meaning-advantages-and-disadvantages-of-codification-condition-for-codification-classidication-of-code-and-codification/
- АНУ-ын Мужуудын хууль тогтоомжийн цахим сан - https://statelaws.findlaw.com/
- АНУ-ын Хууль тогтоомжийн нэгдсэн сан - www.congress.gov
- АНУ-ын Хууль тогтоомжийн нэгдсэн сан - www.govinfo.gov
- АНУ-ын Хууль тогтоомжийн хялбаршуулсан сан - http://www.loc.gov/law/help/guide.php
- АНУ-ын Эрх зүйн мэдээллийн хялбаршуулсан хуудас -https://www.alllaw.com/,
- Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн нэгдсэн сан - www.shuukh.mn
- Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан – www.legalinfo.mn

Хууль зүйн яамны хуулийн www.rli.gov.mn

- ОХУ-ын Төрийн Думын хууль тогтоомжийн төсөл боловсруулах, хэлэлцүүлэх нэгдсэн сан - http://sozd.duma.gov.ru/
- ОХУ-ын эрх зүйн актын нэгдсэн сан - http://www.consultant.ru/
- ОХУ-ын эрх зүйн актын нэгдсэн сан - http://www.garant.ru/
- ОХУ-ын эрх зүйн актын нэгдсэн сан - https://kodeks.ru/
- Улсын Их Хурлын цахим хэлэлцүүлгийн хуудас - http://forum.parliament.mn/
- ХБНГУ-ын Бундесратын албан ёсны цахим хуудас - https://www.bundesrat.de
- ХБНГУ-ын Бундестагийн албан ёсны цахим хуудас - https://www.bundestag.de
- ХБНГУ-ын Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн сан - http://www.verwaltungsvorschriften-im-internet.de
- ХБНГУ-ын Мужийн хууль тогтоомжийн нэгдсэн сан - https://justiz.de/bundlaender/index.php
- ХБНГУ-ын Холбооны хуулийн эмхэтгэлийн цахим хувилбар - https://www.bgbl.de/
- ХБНГУ-ын Шүүхийн шийдвэрийн цахим сан - https://www.rechtsprechung-im-internet.de
- ХБНГУ-ын Эрх зүйн актын нэгдсэн сан - https://www.gesetze-im-internet.de/index.html
- Хууль зүй, дотоод хэргийн яамны албан ёсны цахим хуудас -www.mojha.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХҮНИЙ СЭТГЭЛ САНААНЫ ХОХИРЛЫГ ХЭРХЭН ТООЦОХ АРГАЧЛАЛ БОЛОН ГАДААД УЛСЫН ТУРШЛАГА

/Харьцуулсан судалгаа/[32]

ХУРААНГУЙ

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн захиалгын дагуу хүний сэтгэл санааны хохирлыг тооцох зарим улс орны эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судалсны үндсэн дээр Монгол Улсад хүний сэтгэл санааны хохирлыг тооцох эрх зүйн орчныг боловсронгуй болгоход дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэв.

Судалгааны тайлангийн Нэгдүгээр бүлэгт сэтгэл санааны гэм хорын ерөнхий ойлголт ба Монгол Улсын эрх зүйн орчин, Хоёрдугаар бүлэгт бусад орны зохицуулалтыг харьцуулж авч үзлээ.

Тухайлбал, сэтгэл санааны хохирлын талаарх ойлголтын хүрээнд олон улсын чиг хандлага, үзэл баримтлалыг судлахаас гадна Монгол Улсын тухайд сэтгэл санааны хохирлыг хууль зүйн хүрээнд тайлбарлаагүй байх тул дээрх ойлголтыг тодруулах үүднээс бусад улсын хуульд хэрхэн тусгасныг судлав.

Мөн Монгол Улсын эрх зүйн орчны хүрээнд сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөр болон энэ талаарх эрх зүйн зохицуулалт бий эсэхийг уг судалгаагаар тодруулсан болно.

Бусад улсын зохицуулалтыг харьцуулан судлах хүрээнд Оросын Холбооны Улс /*цаашид* “ОХУ” *гэх*/, Америкийн Нэгдсэн Улс /*цаашид* “АНУ” *гэх*/, Финланд Улс, Швед Улс, Япон Улс болон Бельги Улсын сэтгэл санааны хохирлын ерөнхий зохицуулалт, нөхөн төлбөрийг тооцох аргачлалыг харьцуулж дүгнэсэн. Үүний хүрээнд Монгол Улсын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр санал дэвшүүллээ.

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар дугаар зүйлийн 14 дэх хэсэгт: “Монгол Улсын хууль, Олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...” хэмээн заажээ. Үндсэн хуулийн дээрх суурь зохицуулалт нь Монгол Улсын Иргэний хуулийн 8, 9 дүгээр зүйл болон 18, 52 дугаар бүлгүүдэд хуульчлагдсан. Бие махбодын болон эдийн хохирлыг Иргэний болон Эрүүгийн хуулийн хүрээнд хангалттай зохицуулсан байна. Харин эдийн бус хохирлын тухайд түүний арилгах арга замыг зааж өгснөөс бус хохирлын хэмжээг тодорхойлох талаар нарийвчлан тусгаагүй.

Сэтгэл санааны хохирлыг тооцож арилгах заалт байхгүй гэсэн үндэслэлээр хэргийг шийдвэрлэхгүй орхиж болохгүй юм. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Шүүх тухайн маргаантай харилцааг зохицуулсан эрх зүйн хэм хэмжээ байхгүй буюу байгаа нь тодорхой бус гэсэн үндэслэлээр хэргийг хянан шийдвэрлэхээс татгалзаж болохгүй” хэмээн заасан байдаг. Иргэний хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээг дагаж мөрдөнө” гэжээ. Энэ ч үүднээс Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 8 дугаар зүйлд “Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон үндсэн эрх нь зөрчигдвөл

[32] Энэхүү судалгааг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ажилтан О.Төрболд, Ч.Батзориг, Ц.Оюунчимэг нар хамтран гүйцэтгэв.

хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй", Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлийн 5-д "Хууль бусаар баривчлагдаж эсхүл цагдан хоригдож хохирсон этгээд хохирлоо албадан нөхөн төлүүлэх эрхтэй." Мөн Пактын 14 дүгээр зүйлийн 6-д "Эрүүгийн хэрэг үйлдэж, шүүхийн эцсийн шийдвэрээр ял заагдсан бөгөөд шинэ буюу шинээр илэрсэн үйл баримт шүүн таслах ажиллагааны алдааг хөдөлбөргүй нотолсны учир оногдуулсан ялыг хожим хүчингүй болгосон буюу хэргийг цагаатгасан бол тэрхүү мэдэгдээгүй байсан үйл баримт тухайн үедээ илрээгүй нь бүхэлдээ буюу зарим талаар уг хүний буруугаас болсон гэдэг нь батлагдаагүй бол тийнхүү шийтгүүлсэн этгээд хуулийн дагуу хохирлоо нөхөн төлүүлнэ." хэмээн тус тус заасныг үндэслэл болгон шүүх хэргийг шийдвэрлэж болох хэдий ч нарийвчлан зохицуулаагүйгээс үүдэн зөрчигдсөн эрх бүрэн сэргэх боломжгүй нөхцөл байдал үүснэ. Иймд иргэнийхээ зөрчигдсөн эрхийг сэргээх, нөхөн төлөх эрх зүйн орчин, тогтолцоо механизмыг бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай.

Монгол Улсын тухайд Иргэний хууль, Эрүүгийн хууль, Хөрөнгийн үнэлгээний тухай хуулиар эд хөрөнгийн хохирлыг бүрэн тооцож байгаа ч эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг хэрхэн тооцож арилгахыг бүрэн шийдвэрлэж чадахгүй байна.

Судалгааны ажлын зорилго

Судалгааны ажлын хүрээнд эрх зүйн тогтолцоо, эдийн засаг, нийгмийн хөгжлийн түвшин, хүний эрхийн хэрэгжилтийг харгалзан Финланд Улс, Швед Улс, ОХУ, АНУ, Бельги Улс болон Япон Улсыг сонгон судалж, жишиг болохуйц туршлага илрүүлэх, мөн дотоодын эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замыг тодорхойлоход дэмжлэг үзүүлэх санал, зөвлөмж боловсруулах

Судалгааны арга зүй

Дээрх судалгааны ажлаар хууль зүйн шинжлэх ухааны үндсэн аргууд болох норматив аргаар хэм хэмжээнүүдийг логик зарчмын үүднээс авч үзэж, тухайн асуудлыг илүү оновчтой авч үзэх үүднээс харьцуулалтын арга, нийгмийн асуудлыг тодорхой болгох үүднээс анализ, синтезийн арга, мөн тухайн харилцааг зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалт тэдгээрийн ойлголтыг системтэйгээр судлах үүднээс системчилэх аргуудыг тус тус хэрэглэсэн болно.

Судалгааны хүрээ

"Хүний сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлал болон гадаад улсын туршлага" сэдэвт харьцуулсан судалгааны ажлын хүрээнд сонгон авсан гадаад орнуудын эдийн бус гэм хорын эрх зүйн зохицуулалтыг өөрийн орны эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалж, эдийн бус гэм хорыг тооцох аргачлал, шалгуур зэрэг зарим онцлог зохицуулалтыг түүвэрлэн судаллаа.

НЭГ. СУДАЛГААНЫ ҮНДСЭН АСУУДАЛ

1.1 Сэтгэл санааны хохирлын ойлголт

Иргэний эрх зүй дэх гэм хор түүнийг хэрхэн төлж арилгах арга хэлбэрийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь сэтгэл санааны гэм хор байдаг.[33] Сэтгэл санааны гэм хор гэдгийг тодорхойлохын тулд юуны өмнө гэм хорын тухай ойлголтыг авч үзэх шаардлагатай. Иргэний хуулийн 497-514 дүгээр зүйлд гэм хор учруулснаас үүсэх үүргийн харилцааг зохицуулсан байдаг. Хуульд "гэм хор" гэсэн ойлголтыг тодорхойлж өгөөгүй. Гэм хор нь субъектын амин хувийн эрх болон эд хөрөнгийн эрхийг ямар нэгэн байдлаар зөрчсөн явдлаар илэрдэг.[34] Хууль зүйн ном зохиол, шүүхийн практикт "хохирол" гэсэн нэр томьёог хэрэглэдэг. Гэм хор ба хохирол гэсэн нэр томьёо нь хоорондоо яг нийцдэггүй. Гэм хор нь нэлээд өргөн хүрээтэй

[33] Б. Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги (Уб, 2011),

[34] Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал I дэвтэр (Уб, 1999), 89 дэх тал.

ухагдахуун бөгөөд эд хөрөнгийн эрхийн ба эд хөрөнгийн бус гэж хуваагдана. Эд хөрөнгийн гэм хорын мөнгөн үнэлгээг хохирол гэж нэрлэнэ[35] гэж үздэг.

Эдийн бус гэм хор гэдэгт эдийн бус баялаг, хувийн эрх нь зөрчигдсөн байдлыг ойлгож болно. Эдийн бус баялагт амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, хувийн амьдралын халдашгүй байдал, хувийн болон гэр бүлийн нууц зэрэг орно. Эдийн бус хувийн эрх гэдэгт оршин суугаа газраа чөлөөтэй сонгох, зохиогчийн эрх, өөрийн нэрийг хэрэглэх эрх зэрэг орно. Эдгээр баялаг, эрхийг эдийн бус гэж тодорхойлох гол шалгуур бол түүнийг бусад этгээдэд дамжуулж болдоггүй, зөвхөн тухайн этгээдэд хамааралтай байдаг онцлогтой юм.[36]

Эд хөрөнгийн бус амины эрхийг хувь хүний оршин буйтай холбоотой иргэний эрхүүд, нийгэмд оршин байхтай холбоотой иргэний эрхүүд гэж ангилж авч үздэг байна. Хувь хүний оршин буйтай холбоотой иргэний эрхүүдэд амьд явах, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл аюулгүй орчинд амьдрах, хувийн халдашгүй байдал, эрх чөлөө зэрэг эрхүүд, харин нийгэмд оршин байхтай холбоотой иргэний эрхүүдэд иргэний нэр, хувийн амьдрал, чөлөөтэй зорчих, нэр хүнд, алдар хүнд ажил хэргийн нэр хүндтэй байх эрхүүдийг хамруулдаг байна.[37]

Монгол Улсын Иргэний хуулийн тайлбарт[38] Эд хөрөнгийн бус хохирол гэдэг нь материаллаг бус бүх хохирлыг хэлнэ. Тухайлбал, бие эрхтэний болон сэтгэцийн хохирол, цаашлаад амьдралын баяр баясгалан байхгүй болох, хийлгэх ёстой хүнд мэс заслын улмаас үүссэн нервийн ачаалал гэх мэт хамаарна хэмээн тодорхойлсон байна. Харин бусад улсын тухайд Иргэний хуульдаа эдийн бус хохирол буюу сэтгэл санааны хохирлыг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд: ОХУ-ын Иргэний хуульд "сэтгэл санааны хохирол гэдэгт иргэний хувийн эдийн бус эрх эсхүл түүнд хамааралтай эдийн бус баялгийг зөрчсөн үйлдлийн улмаас учирсан болон бусад хуульд заасан тохиолдолд биеийн болон сэтгэл санааны зовлон шаналал байна. Сэтгэл санааны хохирол нь гэм буруутай этгээдийн гэм буруугаас үл харгалзан аюул ихтэй зүйлсийн улмаас иргэний амьдрал, эрүүл мэндэд учирсан хохирол, иргэнийг хууль бусаар шүүсэн, таслан сэргийлэх арга хэмжээг хууль бусаар хэрэглэсэн, баривчлах болон засан хүмүүжүүлэх хэлбэрээр захиргааны шийтгэлийг хууль бусаар ногдуулснаас учирсан хохирол, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээлэл тарааснаас учирсан хохирол хуульд заасан бусад тохиолдол"[39], Филиппин Улсын Иргэний хуульд "сэтгэл санааны хохирол гэдэг нь бие махбодын зовлон, шаналал, айдас, ноцтой түгшүүр, сэтгэл санааны цочрол, нийгмийн доромжлол эдгээртэй төстэй гэмтэл орно"[40] гэж тус тус заажээ. Эдгээрээс үзвэл сэтгэл санааны хохирол гэдэг нь эд хөрөнгийн хохирол болон эд хөрөнгийн бус хохирлоос үүссэн сэтгэл зүйд бий болсон зовлон шаналал гэж ойлгож болохоор байна.

Эд хөрөнгийн бус амины эрхийн үндсэн шинж чанарууд нь:[41]

1. Эд хөрөнгийн бус амины эрх нь туйлын эрх юм. Өөрөөр хэлбэл тодорхой эрх бүхий этгээдийн эсрэг түүний эд хөрөнгийн бус амины эрхийг зөрчихгүй байх үүрэг бүхий тодорхой бус этгээдүүд байна.
2. Эд хөрөнгийн бус амины эрх нь салшгүй эрх юм. Өөрөөр хэлбэл нэг

[35] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Уб, 2007), Адмон хэвлэл, 138 дахь тал.

[36] Ш.Үнэнтөгс, "Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт" Хууль дээдлэх ёс №4, (2007): 51 дэх тал.

[37] Э. Золзаяа, "Эд хөрөнгийн бус амины эрхийн иргэний эрх зүйн зарим зохицуулалт", Монголын төр, эрх зүй №4 (2013): 28 дахь тал.

[38] Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /шинжлэх ухааны тайлбар/, (2010): 458 дахь тал.

[39] Л.Дарьсүрэн, "Эдийн бус гэм хорын маргаантай хэргийг шүүхээр шийдвэрлэж буй практик асуудал", Монголын төр, эрх зүй №1 (2014): 59 дэх тал.

[40] The Civil code of the Philippines, (1949), article 2217.

[41] Э. Золзаяа, "Эд хөрөнгийн бус амины эрхийн иргэний эрх зүйн зарим зохицуулалт", Монголын төр, эрх зүй №4 (2013): 31 дэх тал.

этгээдээс нөгөөд шилжиж болохгүй.

3. Эд хөрөнгийн агуулгагүй байна, өөрөөр хэлбэл эд хөрөнгийн биш хувийн шинж чанартай байна.
4. Тухайн иргэн эсхүл хуулийн этгээдтэй салшгүй холбоотой байна. Эдгээр зарим эрх нь хүнийг төрснөөр бий болж нас барахад дуусгавар болдог.
5. Тодорхой иргэн, хуулийн этгээдэд байх эд хөрөнгийн бус амины эрхтэй этгээдээс уг баялгийг салгаж үл болох /нэртэй байх, нэр төр, алдар хүнд/.
6. Эдгээр баялаг нь иргэний эрх зүйн хэлцлийн аливаа нэгэн зүйл болохгүй байх. Өөрөөр хэлбэл, амьдрал, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд нь нийгмийн харилцаа хөгжлийн нөхцөлд бараа болж гүйлгээнд орохгүй.

Ингэснээр эд хөрөнгийн бус амины эрх нь эд хөрөнгийн бус шинж чанартай баялгийн эрх бөгөөд эдийн засгийн агуулгагүй, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжоор хүлээн зөвшөөрөгдөж, зохицуулагдаж, хамгаалагдаж буй баялаг бөгөөд тэдгээрийг хувь хүн, хуулийн этгээдээс салгаж үл болох эрх юм.[42]

Хууль тогтоогч, эрх зүй бүтээгчдийн шийдвэрлэвэл зохих гол асуудал нь гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх ерөнхий болон тусгай дүрэм, хуулиар хамгаалах ашиг сонирхлын хүрээ буюу ямар төрлийн хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг байдаг. Тухайлбал, эд хөрөнгийн хохирлоос гадна эдийн бус хохирол буюу амь нас, эрүүл мэнд, сэтгэл санаанд үүссэн сөрөг үр дагавар /өвдөлт, гутрал, ганцаардал гэх мэт мөнгөөр үнэлж болохгүй алдагдал/, эсхүл цаашдын эдийн засгийн боломжоо алдсан зэрэгтэй холбоотой хохирлыг арилгуулах нь гэм хорын эрх зүйн хүрээнд зохицуулагддаг байна.[43] Эдийн бус гэм хорыг дараах байдлаар арилгана. Үүнд:

1. Учирсан материаллаг гэм хорыг арилгах;
2. Сэтгэл санааны гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлбөр гаргуулах;
3. Нэр төр, алдар хүндийг сэргээх.[44]

Нөхөн төлбөр олгох зорилгын хүрээнд хариуцлага ногдуулах нь буруутай этгээдийн үйл ажиллагааны улмаас хохирогчид үүссэн нэмэлт ачаалал, дарамтыг арилгахад чиглэсэн байдаг.[45]

1.2 Монгол Улсын эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын хувьд Эрүүгийн хууль болон Иргэний хуульд эдийн бус хохирлын төрлүүдийг бүрэн бус ч тодорхой хэмжээгээр тусгасан байдаг. Үүнийг дараах байдлаар авч үзэж болно.

- Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутааснаас учирсан сэтгэл санааны хохирол;
- Гэмт хэргийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол;
- Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурорын хууль бус үйлдлийн улмаас учирсан сэтгэл санааны хохирол (эрүүдэн шүүгдсэн, хилсээр ял эдэлсэн, үндэслэлгүйгээр хоригдсон).[46]

Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндтэй холбоотой эдийн бус хохирлыг Иргэний хуулийн 21, 230, 510 дугаар зүйлээр тус тус зохицуулж өгсөн байдаг. Ийнхүү зохицуулахдаа эдийн бус хохирол нь Иргэний эрх зүйн хамгаалалт болох өөрөөр хэлбэл иргэний эрх зүйн харилцаа үүсэх үндэслэл болохоос эхлэн

[42] Мөн тэнд, 31 дэх тал.

[43] Ж.Оюунтунгалаг, "Гэм хорын эрх зүйн зорилго: эрх зүй, эдийн засгийн хандлага" Шүүх эрх мэдэл №1, (2019): 96 дахь тал

[44] Ц.Батчимэг, Б.Энхбаяр нар, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй, (Уб, 2005), 72 дахь тал.

[45] Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, (Уб, 2013), 109 дэх тал.

[46] Д.Тамир, "Эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудал", Хууль дээдлэх ёс №2 (2010): 50 дахь тал.

Хуулийн зөвлөлийн хуралдаан www.nl.gov.mn

түүнийг мөнгөн хэлбэрээр болон бусад аргаар хэрхэн арилгах талаар тусгаж өгсөн. Тухайлбал, Иргэний хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт "Иргэний эрхийг эдийн бус гэм хорыг арилгуулах аргаар хамгаална", 497 дугаар зүйлд "Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэл/-ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй" гэж заасан байна. Эндээс харахад сэтгэл санаанд учруулсан гэм хорын талаар дурдаагүй байна.

Харин Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийгээ бодит байдалд нийцэж байгааг нотолж чадахгүй бол материаллаг хохирлыг арилгасныг үл харгалзан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах үүрэг хүлээнэ" гэсэн нь материаллаг хохирлын хажуугаар материаллаг бус хохирлыг нөхөн төлүүлөх бололцоог бүрдүүлсэн гэж үзэж болохоор байна.

Мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Эдийн бус гэм хорын хэмжээг мэдээ тараасан хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан нэхэмжлэгчийн шаардлагын хүрээнд мөнгөөр тооцож тогтоох"-оор зааснаас үзэхэд сэтгэл санаанд учирсан үр дагавар буюу сэтгэл санааны гэм хор нь эдийн бус гэм хорыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх нэг үзүүлэлт болж байгаа нь харагдаж байна. Иймд манай хууль тогтоомжид заасны дагуу сэтгэл санааны гэм хорыг эдийн бус гэм хорыг нөхөн төлүүлэх аргаар арилгаж болох үндэслэл байна.

Эрүүгийн хуулийн 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, бусад эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, аюулгүй байдалд шууд учирсан үр дагаврыг гэмт хэргийн хохиролд тооцно.", тус зүйлийн 2 дахь хэсэгт "Энэ хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэг үйлдэж хохирол учруулсны улмаас үүссэн үр дагаврыг гэмт хэргийн хор уршигт тооцно." хэмээн заасан байна.

Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирол нэхэмжлэх, түүнийг шийдвэрлэх эрх зүйн зохицуулалтын асуудал нэлээд төвөгтэй байна. Энэхүү зохицуулалт нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх эрх зүйн шинжлэх ухаанд судлагдах төдий байна. Энэхүү асуудлаар зарим судлаачид дараах дүгнэлтийг өгсөн байна. Үүнд:

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад эдийн бус хохирлын шинж чанар, хэр хэмжээг тогтоох ажиллагаа хийгддэггүй;
- Эдийн бус хохирлын нэхэмжлэлийг шийдвэрлэх, уг хохирлыг мөнгөөр тооцон үнэлэх эрх зүйн зохицуулалт боловсронгуй болоогүй байна.[47]

Улсын Дээд шүүхийн "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх Эрүүгийн байцаан шийтгэх болон Иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай" 2009 оны 15 дугаар тогтоолын 6.1.2-т "Бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан гэм буруутай этгээд эд хөрөнгийн хохирол арилгасан эсэхээс үл хамааран мөнгөн болон бусад хэлбэрээр арилгах эдийн бус гэм хорын хэмжээг Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн 511.2.-т зааснаар мэдээ тараасан арга хэрэгсэл, тарсан хүрээ, хохирогчийн сэтгэл санаанд учирсан үр дагавар зэргийг харгалзан тодорхойлно." хэмээн заасан байна. Дээрхээс үзвэл сэтгэл санааны хохирлыг тооцоход дараах шалгуурыг харгалзан үзэхээр байна. Үүнд:

- Мэдээ тараасан арга;
- Тараасан хэрэгсэл;
- Тархсан хүрээ;
- Сэтгэл санаанд учирсан үр дагавар.

[47] Н.Амарзаяа, "Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилт", Монголын төр, эрх зүй №2 (2014): 9 дэх тал.

Энэхүү тогтоол нь шүүхээс иргэдийн эдийн бус гэм хорын хохирлыг нөхөн төлүүлэх, арилгах, сэргээхтэй холбогдсон харилцааг арга зүйн хувьд шийдвэрлэх боломжийг бүрдүүлж байна гэж болох хэдий ч тус тогтоолын 6.2.4-т "Иргэний хуулийн 230 дугаар зүйлийн 230.2-т эдийн бус гэм хорыг зөвхөн хуульд тусгайлан заасан тохиолдолд мөнгөөр нөхөн төлөхөөр заасан ба хүний амь нас, бие эрхтэн, өвчин, зовиур шаналал, сэтгэл санааны байдал зэрэг эдийн бус хохирлыг үнэлэх хуулийн зохицуулалт байхгүй нөхцөлд мөнгөөр нөхөн төлүүлж болохгүй.", "Иргэний хуулийн 21, 511 дүгээр зүйлд заасан эдийн бус гэм хорыг мөнгөн болон бусад хэлбэрээр арилгана"[48] гэж тайлбарласан зэргээс харвал Иргэний хуулийн 511 дүгээр зүйлийн зохицуулалт нь "бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ мэдээлэл тараасантай" холбоотой учирсан хохирлыг арилгахтай хамааралтай гэж ойлгогдож байна.

Дээрхээс үзвэл Монгол Улсын эрх зүйн орчинд сэтгэл санааны хохирлыг тодорхойлсон тодорхойлолт байхгүй зөвхөн нэр төр, алдар хүнд хэмээн ойлгогдохоор хуульчилсан байгаа нь эрх зүйн зохицуулалт дутмаг байгааг илтгэж байна.

ХОЁР. БУСАД УЛСЫН ТУРШЛАГА

2.1 Оросын Холбооны Улс

ОХУ-ын Иргэний хуулийн 128 дугаар зүйлд зааснаар иргэний эрх зүйн объектэд эд зүйл, бусад хөрөнгө, ажил үйлчилгээ, мэдээлэл, оюуны үйл ажиллагааны үр дүн, эд хөрөнгийн бус баялгийг нэрлэсэн байна. Иймд ОХУ-ын эрдэмтэн судлаачид нь иргэний эрх зүйн объектыг эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус баялаг гэж авч үзэж, эд хөрөнгийн бус амины баялагт эдийн засгийн агуулгагүй, хувь этгээдээс салгаж болохгүй, хуулиар зөвшөөрөгдөж, хамгаалдаг эрх, эрх чөлөөг авч үздэг байна.[49] ОХУ-ын Дээд шүүхээс сэтгэл санааны хохирлыг:

- Ойр дотны хүмүүсээ алдсанаас болж учирсан шаналал;
- Идэвхтэй нийгмийн амьдралыг цааш үргэлжлүүлэх боломжгүй болсон байдал;
- Ажлаа алдах;
- Гэр бүлийн болоод эрүүл мэндийн байгууллагын нууцыг задлах;
- Нэр төр, алдар хүндийг гутаасан мэдээ тараасантай холбоотой шаналал;
- Ямар нэгэн эрхийг түр хязгаарласан, зөрчсөнтэй холбоотой шаналал;
- Биеийн өвчин зовлон тахир дутуу болсонтой холбоотойгоор гарсан сэтгэлийн шаналал гэх мэтчилэн үргэлжилж болохоор тайлбарлажээ.[50]

Тус улсад эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхэд Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай, Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн тухай хууль болон Эрделевскийн хүснэгтийг ашигладаг. ОХУ-ын Иргэний хуулийн 150, 151, 152, 1099, 1100, 1101 дүгээр зүйлүүдэд эдийн бус гэм хор болон нөхөн төлбөрийн талаар зохицуулж өгсөн байна. Тухайлбал, 151 дүгээр зүйлд "Хэрэв тухайн иргэнд эд хөрөнгийн бус хохирол учруулсан тохиолдолд шүүхээс гэм буруутай этгээдээр учруулсан эд хөрөнгийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх шийдвэр гаргаж болно.", 152 дугаар зүйлд "иргэний эсрэг худал хуурмаг мэдээлэл тараах, нэр төр, алдар хүндэд халдсан тохиолдолд тухайн мэдээллийг худал болохыг

[48] Улсын Дээд шүүхийн тогтоол, "Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай", дугаар 15, 2009 оны 5 дугаар сарын 22.

[49] Э.Золзаяа, "Эд хөрөнгийн бус амины эрхийн иргэний эрх зүйн зарим зохицуулалт", Монголын төр, эрх зүй №4 (2013): 28 дахь тал.

[50] Ш.Оюунханд, "Сэтгэл санааны хохирол ба олон улсын хэм хэмжээ" Монголын төр, эрх зүй №3 (2013): 36 дахь тал.

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.nli.gov.mn

тогтоолгох болон сэтгэл санааны хохирлыг шаардах эрхтэй”[51] хэмээн зааж өгсөн бол 1099 дүгээр зүйлд ерөнхий сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхэд баримтлах журмыг тусгасан байдаг. Үүнд: Сэтгэл санааны хохирлыг зөвхөн энэхүү хуульд заасны дагуу тодорхойлно. Хуульд заасан тохиолдолд тухайн этгээд нь өөрийн хөрөнгөнд бусдын буруутай үйлдэл, эс үйлдлээс болж учирсан хохирлоос үүссэн сэтгэл санааны хохирлоо нэхэмжлэх эрхтэй. Сэтгэл санааны хохирол нь эд хөрөнгийн хохирлоос хамаарахгүйгээр шийдэгдэнэ.

Харин хуулийн 1100 дугаар зүйлд гэм буруутай эсэхийг харгалзахгүйгээр сэтгэл санааны хохирол шаардаж болох тусгайлсан тохиолдлуудыг дурдсан байна. Жишээ нь, амь нас, эрүүл мэндэд хэн нэгнээс болон онцгой аюулын улмаас хохирол учирсан хууль бус аливаа ажиллагаа болох, хууль бусаар аливаа ажиллагаа явуулах, оршин суугаа газраа орхихгүй байхыг хууль бусаар тулгах, захиргааны шийтгэл, албадан хөдөлмөрлүүлэлт, хууль бусаар хорих зэрэг үйл ажиллагаа болсон тохиолдлууд гэх мэт. Мөн бизнесийн нэр хүнд, хүний эрхэм чанар, нэр төр зэргийг гутаасан дордуулсан тохиолдолд цаашлаад хуульд заасан тохиолдлуудад сэтгэл санааны хохирлыг нэхэмжлэх боломжтой байна. Харин 1101 дүгээр зүйлд сэтгэл санааны хохирлыг тооцох, хэмжээ, арга замыг зааж өгсөн байна. Сэтгэл санааны хохирлыг мөнгөөр нөхөн төлөхөөр зохицуулсан бөгөөд хэргийн нөхцөл байдал, хохирогчид учруулсан бие махбодын хохирол, гэм буруугийн хэлбэр, хохирлын нийт хэмжээ зэргээс хамааран шударга, үндэслэлтэй хэмжээгээр шүүхээс тогтоохоор[52] тус тус заасан байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн ийм төрлийн хэргийн жишээг дор дурдвал, ОХУ-ын иргэн 1 хиймэл шүд хийлгэхээр очоод эмчийн буруутай үйл ажиллагаанаас болж 5 эрүүл шүдээ авахуулахад хүрсэн байна. Дээрх хэргийн хохирогчид ОХУ-н шүүхээс сэтгэл санааны хохирол болгон 5000 рублийн нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн байна.[53]

Дээрхээс үзвэл ОХУ-ын зохицуулалт нь илүү ерөнхий байгаа ч гэсэн хамгаалах ёстой эрх ашгаа хамгаалахад сайн зохицуулалт болсон байгаа бөгөөд ихэвчлэн бие махбод болон зарим амины эрхэд учирсан хохирлоос үүдсэн сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэхээр зохицуулсан нь харагдаж байна.

Эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн төлүүлэхтэй холбоотой харилцааг дээрх хууль тогтоомжоор зохицуулахаас гадна шүүхийн практикт зарим тохиолдолд А.М.Эрделевскийн хүснэгтийг хэрэглэж байна. Тодруулбал:

D=d*f(v)*i*c*(1-f(s)) [54]

D- сэтгэл санааны хохирлын дүн

d- сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн хэмжээ

f(v)- гэмт этгээдийн үйлдсэн гэм хорын хэмжээ. Гэм хор нь 0 < f(v) <1 байна

i- хохирогчийн хувийн онцлог, o<i<2

c- анхаарвал зохих нөхцөл байдал, o<c<2

f(s)- хохирогчийн гэм буруутай байдал, 0 < f(s) <1

Энэ томьёоллоос харахад бодит сэтгэл санааны гэм хорын нөхөн төлбөрийн дээд хэмжээ учирч болохуйц сэтгэл санааны гэм хорын хэмжээнээс дөрөв дахинаас хэтрэхгүй байхаар харагдаж байна. Энэ томьёоллыг хэрэглэхэд гэм хор учруулагчийн гэм буруугийн хэмжээнд дараах үнэлгээг хэрэглэж болно гэж үздэг. Үүнд:

[51] The Civil code of the Russian federation, (1994): article 151-152.

[52] Н.Баярсүрэн, “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх ба гадаад орнуудын хуулийн зохицуулалт”, Монголын төр, эрх зүй №2 (2018) 3 дахь тал.

[53] Ш.Оюунханд, “Сэтгэл санааны хохирол ба олон улсын хэм хэмжээ” Монголын төр, эрх зүй №3 (2013): 37 дахь тал.

[54] А.М Эрделевский, *Компенсация морального вреда,* (Москва: 2007), с.241-242.

f(v)= 0.25 энгийн болгоомжгүй

f(v)= 0.5 бүдүүлэг болгоомжгүй

f(v)= 0.75 шууд бус санаатай

f(v)= 1 шууд санаатай

Мөн гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдал нөхөн төлбөрийн хэмжээг бууруулж болох ба хэрэв санаатай гэм хор учруулсан бол үүнийг харгалзан үздэггүй гэзд ийм үед дараах томьёоллыг хэрэглэж болно гэжээ:

D=d*f(v)*i*c*(1-f(s))*p

p- гэм хор учруулагчийн эд хөрөнгийн байдал

0.5<p<1

гэж томьёолсон байдгийг анхаарах шаардлагатай.[55]

Хохирлын нөхөн төлбөрийг тухайн буруутай этгээдэд нөхөн төлбөр олгох хангалттай хөрөнгө байхгүй бол улсын төсвөөс энэхүү нөхөн төлбөрийг олгодог. Нөхөн төлбөр олгох улсын сангийн хөрөнгийг улсын төсвөөс санхүүжүүлдэг. Жил бүр энэхүү сангийн санхүүжилтийг ОХУ-ын Засгийн газраас баталж өгдөг бөгөөд Улсын төсвийн тухай хуулиар зохицуулдаг.[56]

2.2 Финланд Улс

Тус улсын 1974 оны "Гэм хорын хариуцлагын акт"-д хувь хүний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирлыг нөхөн барагдуулах мөн гэмт хэргийн эсвэл хүчирхийллийн улмаас үүссэн зовлон шаналалыг нөхөн барагдуулах тухай заасан байна. Энэ хуулийн 5 дугаар бүлгийн 2 дугаар зүйлд хувь хүний хохирол гэдэгт шаардлагатай эрүүл мэндийн болон бусад зардлууд, орлогын алдагдал, бие махбодын болон сэтгэл санааны шаналал ба зовлон, эрхтэний ба гоо зүйн түр зуурын болон байнгын гэмтэл зэргийг хамруулах бөгөөд эдгээр нь эрүүл мэндийн эрх зүйн шалгуурын үндсэн дээр тодорхойлогдоно гэж заажээ.[57]

Зовлон, шаналал буюу сэтгэл санааны хохирол нь хүний үндсэн эрхийн зөрчилд хамаарах ба уг хуулиар хувь хүний эрх чөлөө, амгалан тайван байдал, алдар хүнд ба хувийн амьдрал, ялгаварлан гадуурхагдахгүй байх эрх зэргийг зөрчсөн эрүүгийн гэмт хэрэг мөн хувь хүний халдашгүй байдлыг зориудаар эсвэл хүндрүүлсэн хайхрамжгүй байдлаар зөрчсөн зэргийг авч үздэг байна. Эдгээр нь бодитой сэтгэл санааны хохирол бөгөөд эмпирик тодорхойлолт шаардлагагүй аж. Хохирлыг бүрэн барагдуулах үндсэн зарчмын хүрээнд хохирсон хүний хөндөгдсөн эрх болон эд хөрөнгийг өмнөх байдалд нь сэргээсэн байх ёстой. Энэ зарчим нь зарим стандартчлагдсан нөхөн олговор*, гэмт үйлдэлтэй холбоотой төрөөс олгох нөхөн олговор, тодорхой гэмт хэрэгт нийт олгогдох нөхөн төлбөр зэрэг төрөлтэй бөгөөд шүүгч нөхцөл байдлыг харгалзан үзэж* үнэнч шударгаар тодорхойлно.[58]

2004 онд Финланд Улсын Хууль зүйн яам (Oikeusministeriц) шүүхийн практикт хяналт, шинжилгээ хийж "Гэм хорын хариуцлагын акт"-д заасан зовлон, шаналал ба материаллаг бус хохирлын хэмжээг тодорхойлох, боловсронгуй болгох "Хувь хүний хохирлын Зөвлөх комисс"-ыг байгуулсан байна. Комиссын зөвлөмжийн 3 дугаар бүлэгт зовлон, шаналал гэдгийг хүний үндсэн эрхийг зөрчсөнөөс үүдсэн бодитой сэтгэл санааны нөхцөл байдлын үр дагавар гэж тодорхойлсон байна.

Тус комиссын зөвлөмжид зарим эд хөрөнгийн бус хохирлыг барагдуулахад олгох нөхөн олговрын доод болон дээд хэмжээг тодорхойлсон байна. Тухайлбал, хүний халдашгүй байдалд халдсан бол 200-500 еврог, урт хугацааны бэлгийн

[55] Ш.Үнэнтөгс, "Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт" Хууль дээдлэх ёс №4 (2007): 53 дахь тал.

[56] Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013): 7 дахь тал.

[57] Vahingonkorvauslaki, (1974): article 2.

[58] Carlo I. Cremonesi, Ville Pönkä, Compensation for personal injuries in Finland, (2015), p.3.

мөлжлөгт өртсөн хүүхэд эсвэл нэг удаагийн бэлгийн мөлжлөгт өртсөн бага насны хүүхдэд 10,000-30,000 хүртэл еврог сэтгэл санааны хохирлын нөхөн төлбөрт олгох тухай дурдсан байна. Мөн тус зөвлөмжийн 4 дүгээр бүлэгт дотны хүн нь нас барсанаас үүдсэн сэтгэл санааны хохиролд зориулсан нөхөн олговрыг дараах байдлаар тусгажээ. Үүнд: хүүхдээ алдсан бол 2,000-11,000 евро, эцэг эхээ алдсан бол 2,000-15,000 евро, төрсөн ах дүүгээ алдсан бол 2,000-8,000 евро, нөхөр эсвэл эхнэрээ алдсан бол 3,000-11,000 евро тус тус олгоно гэжээ.[59]

Финланд Улсын хувьд мөн хувь хүний хохирлын хариуцлагыг зохицуулсан салбарын хуулиуд байдаг бөгөөд нийгэм хамгаллын хүчтэй тогтолцоотой улсын хувьд зарим эмзэг салбарт тухайлбал, тээврийн хэрэгслийн хэрэглээ, эмнэлэг, эрүүл мэндийн зөрчлийн хариуцлагаас үүдсэн нөхөн олговрыг даатгалаас олгодог байна.

Харин “Эрүүгийн гэмт хэргийн хохирлыг барагдуулах акт” -ын 1 дүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд “гэмт хэргийн улмаас үүссэн хохирлын нөхөн олговрыг улсын сангаас олгоно” хэмээн заажээ. Мөн энэ хуулиар улсын сангаас олгох нөхөн олговрын дээд хэмжээг тодорхойлсон байх бөгөөд гэмт хэргийн улмаас үүссэн шаналгаа, зовлон болон бусад түр зуурын хохиролд 12,000 евро, бэлгийн чиг хандлага, хувь хүний эрх чөлөөний эсрэг гэмт хэргийн улмаас үүссэн зовлонд 9,400 евро энэ тохиолдолд хохирогч хүүхэд бол 16,000 евро зэргийг олгодог. Ямар ч тохиолдолд хувь хүний хохирол болон сэтгэл санааны зовлонд зориулсан нөхөн олговор 61,000 еврогоос хэтрэхгүй байхаар зохицуулсан байна.[60]

2.3 Швед Улс

Тус улсад гэмт хэргийн хохирогч гэмт хэргийн улмаас учирсан хохирлоо гурван үндсэн аргаар нөхөн төлүүлэх боломжтой. Нэгдүгээрт, хохирогч шүүхийн тодорхойлсноор Шведийн “Гэм хорын хариуцлагын акт”-ын дагуу гэмт этгээдээс хохирлыг нөхөн төлүүлж болно.[61] Хоёрдугаарт, хохирогч нь даатгалд хамрагдсан тохиолдолд даатгалын компаниас хохирлоо гаргуулж болно. Гуравдугаарт, Шведийн гэмт хэргийн хохирогчийн “Хохирол барагдуулах, дэмжих газар” (Brottsoffermyndigheten)-аар дамжуулан хохирогч хохирлоо Засгийн газрын сангаас төлүүлж болдог байна.[62]

Швед Улсад үүрэг хариуцлага болон нөхөн төлбөрийг ерөнхийд нь 1972 оны “Гэм хорын хариуцлагын акт”-аар зохицуулдаг ба хохирлыг барагдуулах асуудлыг энэ хуулийн 5 дугаар бүлэгт дэлгэрэнгүй тусгасан. Эдгээр зохицуулалтууд нь хохирогчийн нөхөн төлбөрийг бүрэн барагдуулах баталгааг уг хуулийн зарчмын дагуу хангахыг зорьсон.[63] Үүнээс гадна зарим салбарын тодорхой төрлийн хохирлыг тусгай хууль журмаар зохицуулдаг. Жишээлбэл: Байгаль орчны тухай хуулийн 32 дугаар бүлэг, “Зам тээврийн хохирлын акт”, “Өвчтний хохирлын акт”, “Үйлдвэрлэлийн хариуцлагын акт” гэх мэт. Гэхдээ хохирлын нөхөн олговрыг үнэлэхдээ “Гэм хорын хариуцлагын акт”-ын зүйл заалтыг эдгээр салбарт ашигладаг.

Гэм хорын хариуцлагын акт нь хувь хүний хохирол нөхөн төлөгдсөн байх ёстой гэсэн зарчмыг удирдлага болгодог. Өөрөөр хэлбэл, хэн нэгэн зориудаар эсвэл хайхрамжгүй байдлаар хувь хүнд эсвэл эд хөрөнгөд хохирол учруулсан бол хохирлыг барагдуулах ёстой гэж уг хуулийн 2.1 дүгээр зүйлд тодорхойлсон байна. Уг хуулиар хайхрамжгүй байдлаар эд хөрөнгөд хохирол учруулсан үйлдлийн хариуцлага болон зориудаар хохирол учруулсан үйлдэлд оноох хариуцлагыг ялган зохицуулсан бөгөөд хайхрамжгүй байдлаас үүдсэн тухайн хохирлыг хариуцагч

[59] Recommendations of the Personal Injury Advisory Committee. https://oikeusministerio.fi/hanke?tunnus=OM035:00/2006

[60] Rikosvahinkolaki, (1973): article 1.

[61] Skadeståndslagen, (1972).

[62] Mannelqvist, R., Compensation for victims in public legislation and as a civil right. *Scandinavian Studies in Law*, *50*, 423-434, (2007), p.425.

[63] Skadeståndslagen, (1972): chapter 5.

барагдуулах бол зориудаар буюу шууд санаатай үйлдсэнээс үүссэн бүх хохирлыг хариуцагч барагдуулахаар тус тус заасан байна.

Хайхрамжгүй байдлыг шалгахдаа хэрэв зохицуулсан журам байхгүй бол шүүгч асуулгаар шалгах ёстой. Швед Улсын хувьд үүнийг шалгахдаа “Hand Test”-ийг ашигладаг ба доорх шинжүүдийг тодруулдаг. Үүнд:

1. Хохирол учрах эрсдэл;
2. Боломжит хохирлын хэмжээ эсвэл ноцтой байдал;
3. Хариуцагчийн энэхүү эрсдэлээс сэргийлж болох байсан зардал;
4. Хариуцагчийн хохирлыг урьдчилж харах боломж.

Эдгээр хүчин зүйлсийг үйлдэл хайхрамжгүй байсан эсэхийг үнэлэхийн тулд өөр хооронд нь харьцуулдаг байна.

Энэ хуулийн 5 дугаар бүлэгт хохирлын төрлийг тодорхойлсон бөгөөд хувь хүний хохиролд эд хөрөнгийн бус буюу зовлон, шаналал зэргийг тооцно гэж заасан байна. Тухайлбал, энэ бүлгийн 6 дугаар зүйлд доорх шинж байдал ажиглагдсаныг хохирол гэж үзэхээр заажээ. Үүнд:

- тухайн үйлдэл нь доромжилсон эсвэл гутаасан агуулгатай;
- амь нас, эрүүл мэндэд нөлөөлөхүйц ноцтой айдас төрүүлсэн;
- хөгжлийн бэрхшээлтэй хүнийг доромжилсон;
- хамаарал эсхүл итгэлийг ашиглан хүчирхийлсэн;
- олон нийтийн тав тух алдуулсан.

Швед Улсын хувьд хувь хүний хохирлын нөхөн төлбөрийг барагдуулахад энгийн хуулийн процессоор шийдвэрлэснээс илүү уян хатан, оновчтой нөхөн төлбөрийн системтэй бөгөөд энэ нь хуулийн салбарт тулгамдсан маш олон асуудлыг шийдэж чаддаг. Энэ нь тухайн тохиолдолд зориулсан даатгал бөгөөд ерөнхийдөө дараах 3 төрлийн даатал байна.[64] Үүнд:

- Хөдөлмөрийн ослын аюулгүй байдлын даатгал;
- Өвчтний даатгал;
- Эм бэлдмэлийн даатгал.

Тодруулбал: Аюулгүй байдлын даатгалаас хөдөлмөрийн ослын хохирогч нь гэм хорын актын хэм хэмжээний дагуу орлогын алдагдалд зориулсан нөхөн төлбөр авах бөгөөд мөн нэмэлтээр сэтгэл санааны хохиролд зориулсан нөхөн төлбөр авдаг байна. Өвчтний даатгалаас тухайн өвчтөн эмчилгээнээс үүдэлтэй зовлон, шаналалын хохирлын нөхөн төлбөр авдаг. Харин эм бэлдмэлийн даатгалаас хохирогч эм бэлдмэлийн нөлөөгөөр ноцтой хохирсон бол нөхөн төлбөр авах ба хохирлын нөхөн төлбөрийн хэмжээг гэм хорын актын зүйл заалтын дагуу тооцдог.[65]

Мөн эд хөрөнгийн бус хохиролын нөхөн төлбөрийн асуудлыг Швед Улсын Хууль зүйн сайдын томилсон комисс судлан зарим зарчмыг тодорхойлсон байна. Комиссын зүгээс энэ төрлийн хохирлыг үнэлэхдээ дур зоргоор бус тохирсон шалгуурт үндэслэсэн байх нь чухал гэж үзсэн. Шалгуурт хохирлын нөлөөлсөн хугацаа, шаналалын хурцадмал байдал, болон бие махбодын гэмтлийн зэрэг зэргийг хамруулсан байна. Гэм хорын хариуцлагын актын 5.1 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэгт заасны дагуу энэ төрлийн хохирлын нөхөн төлбөрийн систем доорх зүйлсээс бүрдэж байна. Үүнд:

Зовлон, шаналал: Энэ төрлийн хохирлын нөхөн төлбөр нь сэтгэл санааны шаналал болон өвчнөөс үүдсэн бие махбодын өвдөлтийн цочмог үеийн хугацаанд зориулагддаг. Нөхөн төлбөрийн хэмжээг бодитой тоон шалгуурт

[64] Erland Strömbäck, Personal Injury Compensation in Sweden, 2000, p.434.

[65] Erland Strömbäck, Personal Injury Compensation in Sweden, 2000, p.435.

Хүний эрхийн үндэсний комисс www.nhrc.gov.mn

суурилсан стандарчлагдсан схемийн[66] дагуу тооцдог. Тухайлбал, нөхөн төлбөрийн хэмжээг тооцохдоо эмнэлэгт эмчлүүлсэн хугацаа, эмчилгээний үеийн шаналал, тусгаарлагдсан байдал зэргийг харгалзан үздэг. Нөхөн төлбөр хамгийн ихдээ 1998 онд 100,000 крон байсан байна.

Байнгын хохирол: Бие махбодын болон сэтгэл зүйн хувьд учирсан байнгын хохиролд нөхөн төлбөр төлөх ба хохирлыг тооцоход нас болон эрүүл мэндийн хохирлын зэргийг авч үзнэ. Энэ төрлийн хохирлын хэмжээ хамгийн ихдээ 800,000 крон байсан байна.

Бусад: Эдийн бус хохирлын бусад онцгой тохиолдолд хохирлыг бүрэн барагдуулах зорилгоор нэмэлт нөхөн төлбөр олгодог.

Швед Улсад нэр хүнд нь хохирсон хүмүүс "Хэвлэл мэдээллийн гомдлыг шийдвэрлэх байгууллага" эсхүл "Шведийн өргөн нэвтрүүлгийн газар"-т хандахаас гадна шүүхэд хандаж шийдвэрлүүлж болдог байна. Жишээлбэл, 2016 оны 12 дугаар сард Стокольм хотын шүүгч Шведийн Экспрессэн сонины ахлах редактор Отто Сёоберг гэгчийг Шведийн жүжигчин Майкл Персбрандтыг гүтгэсэн гэмт хэрэг үйлдсэнийх нь төлөө шийтгэсэн байна. Жилийн өмнө Экспрессэн сонин жүжигчнийг архины хордлогын улмаас Уппсалагийн эмнэлэгт хүргэгдсэн талаарх мэдээллийг нийтэлжээ. Жүжигчин мэдээллийг үндэслэлгүй хэмээн үгүйсгэсэн бөгөөд үүний дараа Экспрессэн сониноос нийтлэл эх сурвалжаас ташаа мэдээлэгдсэн мэдээ хэмээгээд алдаа гаргасанаа хүлээн зөвшөөрч, уучлалт гуйсан байна.

Жүжигчин сонины редакцийг өөрийг нь гүтгэсэн хэмээн шүүхэд өгч сэтгэл санааны хохирлын төлбөрт 500,000 крон нэхэмжилсэн байна. Прокурор Сёоберг болон сонины эсрэг төлбөрийг гаргуулахаар шүүхэд шилжүүлсэн байна. Шүүх хурал дээр Сёоберг сонины байр суурьт халтай ноцтой алдаа хийснээ хүлээн зөвшөөрсөн ба Экспрессэн сонины өмгөөлөгчид хэлэхдээ жүжигчнийг архины хамаарлаас салахыг хүсч байсныг олон нийт мэддэг байсан тул түүний нэр хүнд хэдийгээр эмнэлэгт хүргэгдсэн гэх мэдээлэл худал байлаа ч энэ нийтлэлээс болж хохироогүй гэв. Есөн гишүүнтэй шүүх бүрэлдэхүүн Сёобергийг хүндрүүлсэн гүтгэлэг үйлдээгүй гэж үзсэн ч түүнийг гүтгэлэгийн хэм хэмжээг зөрчсөн гэж үзжээ. Ингээд Стокольмын дүүргийн шүүх түүнд 80 өдрийн турш өдөр бүр жүжигчинд 1000 крон (нийтдээ 80,000 крон) мөн жүжигчний сэтгэл санааны хохиролд зориулж 75,000 крон төлөх шийтгэл оногдуулсан байна.[67]

2.4 Америкийн Нэгдсэн Улс

АНУ-ын хувьд 1982 онд баталсан Гэмт хэргийн үйлдлийн Нэгдмэл хохирогчийн тухай хуулиар сэтгэл санааны хохирол, нөлөөллийн талаар мэдээлэл өгөх эрхийг нь баталгаажуулсан.[68] Тухайлбал: 2017 оны 4 дүгээр сард Аова мужийн каунтигийн тангарагтны шүүхээс (Huitt v. Iowa Clinic) хорт хавдарын оноштой гэсэн өвчтөнд мэс засал хийсэн хэрэгт тухайн хохирогч хорт хавдаргүй байсан нь тогтоогдож тэрээр сэтгэл санааны хүнд хохирол хүлээсэн гэх нэхэмжлэлийг Аова мужийн каунтигийн тангарагтны шүүхээс хангахаар шийдвэрлэн хохирогчид 12.5 сая ам.долларын нөхөн төлбөрийг эмнэлэг төлөх болсон байна.[69]

Холбооны болон мужийн хэмжээнд Холбооны гэмт хэрэг үйлдсэн этгээдээс төлсөн торгуулийг хохирогчдод нөхөн төлбөр олгох сангийн хуримтлал[70] үүсгэх ажлыг 1960 оноос эхлүүлсэн бөгөөд тус улсын 50 мужид "Мужийн Гэмт хэргийн

[66] Схем нь Замийн хөдөлгөөний ослын зөвлөлөөс батлагдсан бөгөөд Швед Улсын дээд шүүх хэрэглэхийг зөвшөөрсөн (NJA 1972 p.81).

[67] Claus Granath, "Juryn fäller Sjöberg för förtal", 2006, https://www.sydsvenskan.se/2006-11-24/juryn-faller-sjoberg-for-fortal.

[68] Judith Platania Garrett L. Berman, The Moderating Effect of Judge's Instructions on Victim Impact Testimony in Capital Cases,

[69] https://www.injuryclaimcoach.com/pain-and-suffering-reimbursement.html

[70] The Handbook on Justice for Victims *UNODCCP*

хохирогчдод нөхөн төлбөр олгох тухай” Холбооны Засгийн хөтөлбөр (CVC) / дунджаар 25000 ам.долларын нөхөн төлбөр/ хэрэгжүүлдэг.[71]

Хүч хэрэглэсэн гэмт хэргийн улмаас санхүүгийн алдагдал хүлээсэн, мөн бие махбод болон сэтгэл санааны цочролд орсон хохирогч нь эрүүл мэндийн болон зөвлөгөө авах үйчилгээнээс үүдэн гарах аливаа санхүүгийн зардлаа хэрхэн төлөх, гэнэтийн үхэл болон хөгжлийн бэрхшээлээс болж алдагдсан боломж болох орлогоо хэрхэн нөхөх талаар санаа зовохгүй байж хүчирхийлэл, доромжлолоос буцаж хэвийн байдалдаа эргэн орох явдал нь маш хэцүү асуудал юм. Тус хөтөлбөр нь дээрх нөхцөл байдлаас гарахад тус хөтөлбөр туслах зорилготой бөгөөд муж бүрт хэрэгжүүлдэг. Мөн засгийн газрын хөтөлбөрийг хууль бус аргаар ашиглах, завшихаас сэргийлсэн Зөвлөмжийг[72] баримталж ажиллахыг мөрдлөг болгодог.

Мөн 11 муж нөхөн төлбөрийн дээд хэмжээний тухай хууль гаргасан (энгийн хохирлын хэмжээг 1-5 дахин ихэсгэх), зарим муж 300 мянгаас 5 сая хүртэл ам.доллар гэж тогтоосон, 13 муж Улсын сан (Treasury), эсхүл Адил тэгш шударга ёсны эвслээс тогтоосон хувь хэмжээг удирдлага болгодог ажээ.

Мөн АНУ-ын Дээд шүүхээс нөхөн төлбөрийн хэмжээ нь хохирлыг 9 дахин ихэсгэснээс хэтэрч болохгүй гэж тусгайлан шийдвэр гаргасан нь орон даяар хэрэгжих жишээтэй.[73]

Тус улсад гэмт хэргийн улмаас сэтгэл санааны хохирол хүлээсэн хохирогчдод сэтгэл зүйн нөхөн сэргээлт эмчилгээг үзүүлдэг бөгөөд АНУ-ын Сэтгэл Судлалын Холбооноос /APA/ Сэтгэл санааны хямралд орсон үеийн эмчилгээний үед баримтлах Зөвлөмж[74], мөн Гэмтлийн дараах стрессийн эмгэг[75] (PTDS)-ийн[76] гурван үндсэн (APA DSM-IV-TR) зэрэглэлийг хэрхэн тодорхойлох тухай албан ёсны Зөвлөмжийг сэтгэл зүйн хохирлыг тогтоох холбогдох эрх бүхий мэргэжлийн лиценз бүхий эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд үйл ажиллагаандаа баримтлахад зориулан баталсан. Мөн тус байгууллагаас 2002 оны 8 дугаар сарын 21-ний өдөр “Сэтгэл зүйчийн ёс зүйн зарчим, үйл ажиллагааны дүрэм”-ийг[77] баталсан.

2.5 Япон Улс

Япон Улсын Иргэний хуулийн 709-724 дүгээр зүйл гэм хорын талаар зохицуулж өгсөн. Тухайлбал, 709 дүгээр зүйлд “Санаатай буюу болгоомжгүй үйлдлээр бусдын эрх ашиг, хуулиар хамгаалагдсан ашиг сонирхлыг зөрчсөн этгээд үүний улмаас үүссэн хохирлыг нөхөн төлөх хариуцлагыг хүлээнэ.”, 711 дүгээр зүйлд “Бусдын амь насанд хохирол учруулсан этгээд хохирогчийн эцэг эх, эхнэр нөхөр, болон үр хүүхдэд эд хөрөнгийн хохирол учруулаагүй байсан ч хохирлыг нөхөн төлнө.”, 722 дугаар зүйлд “Гэм хор учруулснаас үүссэн хохирлыг нөхөн төлөхөд тус хуулийн 417 дугаар зүйлийг[78] нийцүүлэн хэрэглэнэ.”,723 дугаар зүйлд “Бусдын нэр төр, алдар хүнд гэм хор учруулсан этгээдэд хохирогчийн нэхэмжлэлийн дагуу шүүх хохирлыг нөхөн төлүүлэхийн хамт, нэр төр, алдар хүндийг сэргээхэд шаардлагатай арга

[71] АНУ-ын Холбооны Засгийн Газрын албан цахим хуудас, Сүүлд үзсэн огноо: 2019-09-13, https://www.benefits.gov/benefit/4416; http://nacvcb.org/index.asp?sid=5

[72] United States Department of Justice, Сүүлд үзсэн огноо: 2019-09-13, https://www.justice.gov/usao/page/file/915836/download.

[73] Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013): 12-13 дахь тал.

[74] The American Psychological Association, Сүүлд үзсэн огноо: 2019-09-13, https://www.apa.org/depression-guideline/appendices.pdf

[75] PTDS буюу Гэмтлийн дараах стресийн эмгэг (монг. орч) https://www.slideshare.net/azora14/11-12687528

[76] John P. Wilson, PTSD and Complex PTSD Symptoms, Syndromes, and Diagnoses. Сүүлд үзсэн огноо: 2019-09-16 https://www.guilford.com/excerpts/wilson5.pdf?t.

[77] The American Psychological Association, Сүүлд үзсэн огноо 2019-09-16 https://www.apa.org/ethics/code/ethics-code-2017.pdf

[78] Япон Улсын Иргэний хууль, 417 дугаар зүйл “Талууд өөрөөр тохиролцоогүй бол хохирлыг мөнгөөр үнэлж тогтооно”

хэмжээг авахыг тушааж болно."[79] гэж тус тус заажээ.

Шүүхээс хохирлыг тооцохдоо хохирогчийн гэм буруутай эсэх, түүний сэтгэцийн эмзэг байдал, хууч өвчин зэргийг харгалзан үзэх нөхцөл байдалд авч үздэг.[80] Жишээ нь: 2019 оны 06 дугаар сард Кумамотогийн анхан шатны шүүхэд 561-н нэхэмжлэгчид leprosy буюу Хансений өвчтэй гэх үндэслэлээр Засгийн газраас тусгаарлах бодлого хэрэгжүүлсний улмаас өвчтөнүүдийн гэр бүлийн гишүүд нь нийгмээс тусгаарлагдан ялгаварлан гадуурхагдан эдийн бус хохирол болон бусад хохирол учирсан тул Засгийн газар тэднээс уучлал гуйх, гэр бүлийн гишүүн бүрт 5 сая иений нөхөн төлбөр төлөхийг нэхэмжилсэн. Шүүхээс анх удаа өвчтөний гэр бүлийн гишүүнд Засгийн газраас нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн.[81] Мөн Нагояо дүүргийн шүүхээс 72 настай хэвлэн нийтлэл бичигч иргэний NHK түүний нийтлэлийг хүлээн авахаас татгалзсан шийдвэр нь түүнд сэтгэл санааны дарамт учруулсан гэх үндэслэлээр нэхэмжилсэн 1.41 сая иений хэргийг хэрэгсэхгүй болгосон[82] зэрэг тохиолдлууд гарч байжээ.

Тус Улсын хуулиар хохирогч хохирол хүлээсэн гэж үзснээс хойш гурван жилийн дотор шүүхэд хандах эрхтэй бөгөөд нөхөн төлбөрийн хөөн хэлэлцэх хугацаа 20 жил байдаг.[83]

Япон Улс нь цөмийн эрчим хүч үйлдвэрлэлтээр АНУ, Франц улсын дараа жагсдаг. Энэ ч үүднээс боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэд цөмийн хор хохирлын нөхөн төлбөрт зориулсан хураамжийг цөмийн талбар буюу онгоц бүрт 120 тэрбум иен байхаар тооцдог ба гадаад улсын зүгээс цөмийн хөлөг онгоц ирэх бол нэг бүрт нь 36 тэрбум иен нөхөн төлбөрт байршуулахыг шаарддаг байна. Нөхөн төлбөрт зориулсан хураамжаа Хууль зүйн асуудал хариуцсан товчоо буюу Тойргийн хууль зүйн асуудал хариуцсан товчоонд шилжүүлж, Яамны зөвшөөрөлтэйгээр хохирол учирсан талаар гомдол гаргасан этгээдэд олгоно. Нөхөн төлбөр олгох журмыг[84] Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яам болон Хууль зүйн яам хамтарч гаргадаг онцлогтой.

Боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, технологийн яамны дэргэд Цөмийн хохиролтой холбоотой нөхөн төлбөрийн асуудал эрхэлсэн Маргаан таслах хороо ажиллахаар тус тус хуульчилжээ. Энэ хуультай холбогдуулан Ажлын байран дээр ослын даатгалын тухай хуульд (the Insurance Act for the Compensation of Work Accidents (Act No. 50 of 1947)) нийцүүлэн асуудлыг нарийвчлан зохицуулжээ.[85]

2.6 Бельги Улс

Бельги Улсад гэмт хэргийн хохиролд сэтгэл санааны хохирол болон гэмт хэргээс үүдсэн сэтгэл санааны үр дагаврыг тооцдог бөгөөд сэтгэл санааны үр дагавар нь дотны хүнээ алдах, айдас, жихүүдэс мэдрэх зэргээс үүснэ. Хохирогч гэмт хэргийн улмаас үүссэн хохирлыг батлах нотлох баримтыг гаргах ёстой бөгөөд

[79] Япон Улсын Иргэний хууль, (1896), орч. Б.Урангоо, 180-181 дэх тал.

[80] The Global Class Actions Exchange, Stanford Law School, Сүүлд үзсэн огноо: 2019-09-17, http://globalclassactions.stanford.edu/sites/default/files/documents/Japan_Reevaluating_Role_of_Tort_Liabilty_System_in_Japan.pdf

[81] Japan govt ordered to Pay Damages to Relatives of Ex- Leprosy Patients, Сүүлд үзсэн огноо: 2019-09-07, https://www.nippon.com/en/news/yjj2019062800920/japan-govt-ordered-to-pay-damages-to-relatives-of-ex-leprosy-patients.html.

[82] Japan today "Court rules against man who sued NHK for using too many loan words" article, Сүүлд үзсэн огноо: 2019-09-18, https://japantoday.com/category/national/court-rules-against-man-who-sued-nhk-for-using-too-many-loan-words.

[83] The Global Class Actions Exchange, Stanford Law School, Сүүлд үзсэн огноо: 2019-09-17, http://globalclassactions.stanford.edu/sites/default/files/documents/Japan_Reevaluating_Role_of_Tort_Liabilty_System_in_Japan.pdf

[84] 原子力損害の賠償に関する法律 /Цөмийн хохирлын нөхөн төлбөр олгох журам/, https://elaws.e-gov.go.jp/search/elawsSearch/elaws_search/lsg0500/detail?lawId=336AC0000000147

[85] Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013): 14 дэх тал.

ингэснээр хууль сахиулагчид хохирлыг тодорхойлоход дөхөм болдог. Тухайлбал, эрүүл мэндийн шинжилгээний бичиг, шинжилгээний болон эмчилгээний төлбөр, нэхэмжлэл гэх мэтийг үрэгдүүлэлгүй хадгалах ёстой.[86]

Тус улсад эдийн бус хохирлыг эрүү, иргэний журмаар буюу бие даасан оролцогчийн стастустайгаар нэхэмжлэх боломжтой байдаг. Энэ нь эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны явцад хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжилж болно гэсэн үг. Гэхдээ энэ нь зөвхөн хохирогчийн хүсэлтээр хэрэгжих ба шүүгч өөрийн санаачилгаар ажиллагаа явуулах эрхгүй. Харин иргэний журмаар хохирлоо нөхөн төлүүлэхээр нэхэмжилсэн тохиолдолд хэрэв эрүүгийн процесс дуусаагүй байгаа тохиолдолд иргэний шүүх хэргийг шийдвэрлэхийг түр хүлээдэг. Хэрэв эрүүгийн хэргийг шүүхээс хэрэгсэхгүй болгосон тохиолдолд иргэний журмаар хохирлоо нөхөн төлүүлэх боломж тэр хэмжээгээр хумигддаг. Хохирогч нийтийн сангаас эдийн бус хохирлыг нөхөн төлүүлэхээр нэхэмжилж болно. Гэхдээ тухайн нөхөн төлбөрийг эрүүгийн хэргийн улмаас бие махбодод нь ямар нэгэн гэмтэл учирсан байгаа тохиолдолд л өгөх боломжтой байдаг.

Жишээ нь, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны эдийн бус хохирлыг дараах хэлбэрээр нөхөн төлүүлж байна. Үүнд:

- Эмнэлэгт хэвтэхэд нэг өдрийн 31 евро;
- Хөдөлмөрийн чадвараа 100 хувь алдсаны нэг өдрийн 25 евро;
- Хөдөлмөрийн чадвараа 75 хувь алдсаны нэг өдрийн 19 евро;
- Хөдөлмөрийн чадвараа 50 хувь алдсаны нэг өдрийн 13 евро ;
- Нэмэлт өвдөлт, шаналал зовиурт мөн нөхөн төлбөр өгнө.

Харин хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдсан тохиолдолд хохирогчийг насны байдлаар нь ангилан үзэж нөхөн төлбөр дараах хэмжээгээр олгож байна:

- 10 ба түүнээс доош настай хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт нь 3300 евро;
- 35 ба түүнээс доош настай хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт нь 2425 евро;
- 64 ба түүнээс доош настай хүнд хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тус бүрт нь 1410 евро;.

Дээр дурдсан тоо хэмжээ хөдөлшгүй зүйл биш бөгөөд шүүгчийн үнэлэмжээр өөрөөр тогтоогдож болдог байна. Бусад эдийн бус хохирлын тухайд дараахь хохирлыг нөхөн төлүүлэх боломжтой байдаг. Тухайлбал,

Гоо сайхны хохиролд 1-7 хүртэлх доорх түвшингээр үнэлж байна:

- 1-р түвшин 250-750 евро;
- 4-р түвшин 2250-8700 евро;
- 5-р түвшин 8700 евро ба түүнээс дээш;
- 7-р түвшин 24800 евро ба түүнээс дээш.

Жишээ нь, тус улсад гэмт хэргийн улмаас нүүрэндээ эдгэшгүй сорви авсан 16 настай хүүхдэд 18600 еврогийн нөхөн төлбөрийг шүүхээс олгосон байна. Түүнчлэн амьдралаас таашаал авах боломжоо алдсаны хохирол, бэлгийн харилцааны хэм алдагдсаны хохирол, сэтгэл санааны тайван бус байдалд оруулсны хохирол зэргийг эдийн бус гэм хорын хэлбэрээр тооцож барагдуулсан байна. Бельги Улсад хохирогчийн ар гэрийнхний сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулах тогтолцоо бүрджээ. Жишээ нь:

- Эхнэр/нөхрөө алдсан бол 10000 евро;
- Эцэг эхээ алдсан бол хүн тус бүрт 17500 евро;

[86] Холбооны хууль зүйн төрийн үйлчилгээ, Хохирогчийн гарын авлага, (2016) 18 дахь тал. https://justice.belgium.be/sites/default/files/vous-etes-victime-2016-en-web.pdf_.pdf

- Хүүхдээ алдсан бол 10000 евро.

Бельги Улсад хүнд гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох тусгай бүтцийг 1985 оны Хохирогчид нөхөн төлбөр олгох тухай хууль /Victims Compensation Act 1985/-аар бий болгосон. Энэ хуулийн зорилго нь тухайн хохирогчид бүрэн хэмжээгээр нөхөн төлбөр олгохоосоо илүүтэй эрүүгийн болон иргэний байцаан шийтгэх ажиллагаанаас хохирлоо нөхөн төлүүлж чадаагүй, эсвэл бусад хэлбэрийн нөхөн төлбөр, жишээ нь тэтгэвэр тэтгэмж, даатгалын төлбөр гэх мэтийг олж авах боломжгүй хүмүүст санхүүгийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн.[87]

ДҮГНЭЛТ, САНАЛ

Бусад улсын практикаас харвал гэмт хэргийн улмаас хохирсон хүний санаа сэтгэл, бие эрхтний эдийн бус хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлж арилгах эрх зүйн зохицуулалтыг Иргэний хууль, Гэм хорын хариуцлагын тухай акт, Хөдөлмөрийн тухай хууль зэрэг хуулиудаар зохицуулж байна. Эдгээр зохицуулалтад нийтлэг байдлаар тодорхой төрлийн үйлдлийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн дүнгээр илэрхийлэн дээд болон доод хэмжээг тусгаж өгч тэр хүрээнд шүүх нотлох баримт, нөхцөл байдлыг үнэлэн нөхөн төлбөрийг ногдуулж байгаа нь харагдаж байна. Мөн хохирогчийн хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүднээс Засгийн газар нь нөхөн төлбөр олгох сан байгуулж түүндээ хуримтлал бий болгож байгаа сайн жишиг байна.

Монгол Улсын тухайд Иргэний хууль болон Улсын дээд шүүхийн тогтоолоор эдийн бус гэм хор, болон сэтгэл санааны хохирлыг тооцох талаар зохицуулсан хэдий ч сэтгэл санааны хохирлыг зөвхөн нэр төр, алдар хүндтэй холбон тайлбарласан, хохирлыг тооцох шалгуур нь тодорхой бус зэрэг дутагдлууд байна. Иймд эдийн бус гэм хор буюу сэтгэл санааны хохирлыг арилгах дэлгэрэнгүй зохицуулалтыг Иргэний хууль, Эрүүгийн хууль, процессын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах замаар бий болгох, шүүх хэргийг шийдвэрлэхдээ баримтлах эдийн бус хохирлын хэмжээг тооцох аргачлалыг батлан мөрдүүлэх шаардлагатай байна.

Санал

Судалгаагаар авч үзсэн асуудлын хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

- Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, шалгуур, хэмжээг тогтоох аргачлал, журам заавар боловсруулж мөрдүүлэх;
- Сэтгэл санааны хохирлын талаарх ойлголтыг хуулийн хүрээнд тодорхойлох;
- Сэтгэл санааны хохирлыг нотлох нотолгооны хэрэгслийг процессын хуулиудад тусгаж өгөх. Тухайлбал, ойр дотны хүмүүсээс хохирогчийн сэтгэл санааны байдлын талаарх мэдүүлэг авах гэх мэт;
- Нөхөн төлбөрийн хэмжээг тодорхойлохдоо дараах шалгуурыг харгалзан үзэх талаар эрх зүйн хэм хэмжээний актад тусгаж өгөх. Үүнд: гэм хор учруулагчийн гэм буруугийн хэмжээ, хохирол учирсан этгээдийн хувийн онцлогтой холбоотой бие махбодын болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ хэмжээ, бодит нөхцөл байдал болон хохирогчийн хувийн онцлогийг тусгасан бие махбодын болоод ёс суртахууны зовлонгийн /гэм хорын/ шинж чанар, шударга ёсны шаардлага зэрэг;
- Төрийн буруутай үйл ажиллагааны улмаас эдийн болон эдийн бус хохирол учирсан иргэдэд Засгийн газрын сангаас нөхөн төлбөр олгох эрх зүйн боломжийг нээж өгч Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах.

[87] Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013): 8-9 дэх тал.

Хуулийн мэдээлэл, судалгаа www.nli.gov.mn

НОМ ЗҮЙ

Олон улсын гэрээ, Хууль, тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, /1992/.
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал, /1946/.
- Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, /1966/.
- Иргэний хууль, /2002/.
- Эрүүгийн хууль, /2015/.
- Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, /2002/.
- Улсын Дээд шүүхийн тогтоол, дугаар 15, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг арилгах талаарх эрүүгийн байцаан шийтгэх болон иргэний хуулийн зарим зүйл, заалтыг эрүү, иргэний шүүн таслах ажиллагаанд хэрэглэх тухай”, 2009 оны 5 дугаар сарын 22-н
- Япон Улсын Иргэний хууль
- The Civil code of the Russian federation, /1994/.
- Rikosvahinkolaki, /1973/.
- Skadestendslagen, /1972/.
- The Civil code of the Philippines, /1949/.
- Vahingonkorvauslaki, /1974/.
- Victims Compensation Act, /1985/.

Ном, өгүүлэл, нийтэл:

- Н.Амарзаяа, “Гэмт хэргийн улмаас учирсан хохирол нөхөн төлүүлэх эрхийн хэрэгжилт”, Монголын төр, эрх зүй №2 (2014):
- Ц.Батчимэг, Б.Энхбаяр нар, Гэм хороос үүсэх үүргийн эрх зүй, (Уб, 2005),
- Б.Буянхишиг, Иргэний эрх зүйн тусгай анги (Уб, 2011),
- Н.Баярсүрэн, “Сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх ба гадаад орнуудын хуулийн зохицуулалт”, Монголын төр, эрх зүй №2 (2018)
- Л.Дарьсүрэн, “Эдийн бус гэм хорын маргаантай хэргийг шүүхээр шийдвэрлэж буй практик асуудал”, Монголын төр, эрх зүй №1 (2014):
- Э.Золзаяа, “Эд хөрөнгийн бус амины эрхийн иргэний эрх зүйн зарим зохицуулалт”, Монголын төр, эрх зүй №4 (2013):
- Д.Наранчимэг, Иргэний эрх зүйн үндсэн асуудал I дэвтэр (Уб, 1999),
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг (Уб, 2007), Адмон хэвлэл,
- Монгол Улсын Иргэний хуулийн тайлбар /шинжлэх ухааны тайлбар/, (2010):
- Д.Тамир, “Эдийн бус хохирлыг мөнгөөр нөхөн төлөх асуудал”, Хууль дээдлэх ёс №2 (2010):
- Ш.Оюунханд, “Сэтгэл санааны хохирол ба олон улсын хэм хэмжээ” Монголын төр, эрх зүй №3 (2013):
- Ж.Оюунтунгалаг, “Гэм хорын эрх зүйн зорилго: эрх зүй, эдийн засгийн хандлага” Шүүх эрх мэдэл №1, (2019):
- Ж.Оюунтунгалаг, Харьцуулсан иргэний эрх зүй, (Уб, 2013),
- Ш.Үнэнтөгс, “Сэтгэл санааны гэм хорын тухай ойлголт буюу гүтгэлэг, нэр төр гутаах асуудлын талаарх эрх зүйн зохицуулалт”
- Хүний эрхийн үндэсний комисс, Гэмт хэргийн улмаас учирсан эдийн бус

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.mlsjov.mn

хохирлыг нөхөн төлөх эрх зүйн зохицуулалт /суурин дүн шинжилгээ/, (2013):

Гадаад хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл

- А.М Эрделевский, *Компенсация морального вреда,* (Москва: 2007),
- Carlo I. Cremonesi, Ville Pцnkд, Compensation for personal injuries in Finland, (2015),
- Mannelqvist, R., Compensation for victims in public legislation and as a civil right. *Scandinavian Studies in Law*, *50*, 423-434, (2007),
- Erland Strцmbдck, Personal Injury Compensation in Sweden, 2000,
- Claus Granath, “Juryn fдller Sjцberg fцr fцrtal”, 2006,
- Judith Platania Garrett L. Berman, The Moderating Effect of Judge’s Instructions on Victim Impact Testimony in Capital Cases,
- John P. Wilson, PTSD and Complex PTSD Symptoms, Syndromes, and Diagnoses.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГУРАВ. БУСАД СУДАЛГААА
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИНСТИТУТИЙН ЗАРИМ НЭР ТОМЬЁО

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ГУРАВ. БУСАД СУДАЛГАА
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬ ДАХЬ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИНСТИТУТИЙН ЗАРИМ НЭР ТОМЬЁО[88]

УДИРТГАЛ

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд[89] хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад Монгол Улсын Үндсэн хууль (*цаашид "Үндсэн хууль" гэх*), бусад хуульд хэрэглэсэн нэр томьёог хэрэглэх, нэг нэр томьёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх, үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих, хүч оруулсан нэр томьёо хэрэглэхгүй байх, жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх зэрэг асуудлыг хуульчилсан байдаг. Энэ нь хуулийг батлан гаргахдаа хуулийн нэр томьёог жигдлэх, хуулийг нэг мөр хэрэглэх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, төслийг хэлэлцэн батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томьёог зөв ойлгох нь чухал гэдгийг харуулж буйн илрэл юм.[90]

Хууль зүйн нэр томьёоны замналыг өөрийн орны хууль тогтоомжийн түүхэн үеүүдэд тулгуурлан он цагийн дараалаар хураангуйлан үзвэл:[91]

- Эхний үед (1206-1921 он) Монголын эзэнт улсын төр хууль цааз тогтнож, чиг үүргээ хэрэгжүүлэх явцад цааз ёс, цааз хууль, цааз эрхэмж, хууль зүйл зэрэг уламжлалт нэр томьёоны үндэс суурь бүрэлдэн бий болсон;
- Хоёр дахь үед (1921-1991 он) Ардын эрхт ёсыг тогтоон явуулах болсноор Үндсэн хууль, шүүх цааз, журам дүрэм зэрэг хэлбэрээр хууль зүйн нэр томьёонд шинэлэг хандлага илэрхийн зэрэгцээ хөгжингүй орнууд, юуны өмнө зөвлөлт маягийн хуулиудыг үлгэр загвар болгосноор нэгдмэл хийгээд төрөлжсөн хуулиудыг боловсруулж, хууль зүйн нэр томьёо мэргэжлийн шинжтэй болж салбарлан хөгжсөн бөгөөд нэр томьёог жигдлэн сайжруулах үүднээс зарим алхмыг хийсэн;
- Гурав дахь үед (1992 оноос өнөөг хүртэл) Нийгмийн нэг тогтолцооноос нөгөөд шилжиж, бүхий л хүрээг хамарсан өөрчлөлт шинэчлэл хийгдэх болсноор өмнөх хуулиуд шинэ хуулиудад байр суурьа тавьж, дэлхийн жишгээр хууль зүйн нэр томьёонд шинэ үг хэллэг нэвтрэн, эх хэл болон харь хэлний агуулгыг утга зүйн үүднээс танин мэдэж харьцуулан жигдлэх шаарлага улам бүр өсөн нэмэгдсэн хэмээн томьёолж болно.

Хуулийн нэр томьёо хэт өргөн агуулгатай хийгээд олон салаа утгатай бол ердийн хуульд нэр томьёоны тайлбар хийдэг. Харин Үндсэн хуулийн бичвэрт нэр томьёоны тайлбар гэсэн хэсэг байхгүй, Үндсэн хуулийн цэцээс маргааныг хянан шийдвэрлэх замаар тайлбарлаад явдаг. Монгол Улсын Үндсэн хууль нь хатуу[92] Үндсэн хуулийн ангилалд хамрагддаг тул нэгэнт Үндсэн хуульд тусгагдсан хууль зүйн нэр томьёо цаг хугацааны хувьд хоцрогдсон, оновчгүй байсан ч өөрчлөх боломж хязгаарлагдмал байдаг. Үндсэн хуульд хэрэглэсэн нэр томьёог бусад хууль

[88] Энэхүү үнэлгээг ХЗҮХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, хууль зүйн доктор П.Амаржаргал удирдан, Эрдэм шинжилгээний ахлах ажилтан Г.Халиунаа, Эрдэм шинжилгээний ажилтан Б.Ариунжаргал, Ж.Булгансүрэн, Ц.Оюунчимэг, О.Төрболд, Э.Уянга, С.Цэрэндолгор, У.Эрдэнэзаяа нар хамтран гүйцэтгэв.

[89] Хууль тогтоомжийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл №25, (Уб, 2015).

[90] Монгол Улсын Үндсэн хууль нийтдээ 7559 тэмдгэлгээнээс бүрдсэн байдаг бөгөөд үүнээс үг 5977, тоо 323, цэг 471, таслал 625, тэмдэгт 163 байдаг талаар, мөн манай улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомж дахь түгээмэл хэрэглэж буй нэр томьёог судлан үзэхэд "этгээд, бүхий, бус" гэх үгс хамгийн их хэрэглэгдсэн байна гэсэн судалгааны дүн гарсан байдаг.

[91] Т.Сэнгэдорж, "Монгол Улсын хууль зүйн нэр томьёо судлал: сургамж ба шийдэл", Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, (Уб, 2016), 19 дэх тал.

[92] Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахын тулд ихээхэн хүндрэлтэй нэмэлт болзол тогтоосон Үндсэн хуулийг энэ ангилалд хамааруулдаг.

тогтоомж, эрх зүйн актад тусгаж, Үндсэн хуульд нийцүүлэн хэрэглэх шаардлагатай байдаг зэрэг нь үндсэн хуулийн эрх зүйн нэр томьёоны онцлог юм. 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд тусгасан хууль зүйн нэр томьёо нь гуч шахам жил тогтвортой хэрэглэгдэж, хууль зүйн нэр томьёоны үндсэн эх сурвалж болж байгаа билээ.

Иймд бид энэхүү судалгааны хүрээнд Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн институт дахь тодорхой нэр томьёог эрдэмтэн, судлаачид болон үг зүйн толь бичигт хэрхэн тодорхойлж, тайлбарласан, тухайн нэр томьёог агуулгын хувьд хэрхэн ойлгож, хэрэглэх ёстой болон уг нэр томьёоны талаар гадаад улсын зарим жишээг авч үзлээ.

Судалгааны объект

Ерөнхийлөгч гэх нэр томьёо нь 1990-ээд оноос албан ёсоор хуульчлагдан, хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд 1992 оны Үндсэн хуулийн Гучдугаар зүйлээс Гучиндолдугаар зүйлд тус субъекттэй холбоотой зохицуулалтыг тусгасан байдаг. Уг судалгааны хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн дээрх хэсгээс дараах нэр томьёог сонгон судлав. Үүнд:

1. Ерөнхийлөгч;
2. Төрийн тэргүүн;
3. Ерөнхийлөгчийн сонгууль;
4. Сонгуулийн хоёр шат;
5. Анхан болон дахин санал хураалт;
6. Тангараг өргөх;
7. Зарлиг;
8. Огцруулах;
9. Бүрэн эрх;
10. Хориг;
11. Зөвшилцөх;
12. Итгэмжлэх жуух бичиг;
13. Онц байдал;
14. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл;
15. Дайчилгаа;
16. Дайны байдал.

Судалгааны арга зүй

Дээрх судалгааны ажлаар үгийн үндсийг тодорхой үндэслэлтэй гаргахын тулд шинжлэх ухааны гременивтик арга, түүхэн талаас нь түүхчлэх арга, тухайн үгийн агуулгыг илүү тодорхой болгохоор харьцуулалтын арга, мөн Үндсэн хуулийн холбогдох зүйл заалт, үгийн утга агуулгыг ойлгох үүднээс Үндсэн хууль тайлбарлах үгчлэх, системчлэх, утга зүйн аргуудыг тус тус хэрэглэсэн болно.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ҮГИЙН УГ ГАРВАЛ, ТҮҮНИЙ УТГА АГУУЛГА

ЕРӨНХИЙЛӨГЧ

Энэ үг латин хэлний “praesidēns” (тэргүүлэгч, ерөнхийлөгч, удирдагч) гэсэн үгнээс гаралтай. Латин хувилбар нь praesideō (тэргүүлэх) гэсэн үйл үгнээс үүсжээ. Үйл үгийг задалбал prae (урд, өмнө), sedeō (суух) гэсэн утгатай. “Урд, тэргүүнд суух” гэсэн үгийн эх утга нь “хурал даргалах” гэсэн утгаар ойлгогдоно. Тус үйл үгийн хоёрдугаар утга нь “удирдах, эрх барих” гэсэн утга агуулна. Иймд praesidēns гэдэг нь “хурал даргалж буй хүн” буюу “удирдагч, эрх баригч” гэсэн утгатай юм.[93]

Бусад улсад засаглалын хэлбэрээс хамааран Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээ өөр өөр байна. Парламентын бүгд найрамдах засаглалтай улсад Ерөнхийлөгч ихэвчлэн бэлгэдлийн шинжтэй, тухайн улсынхаа хязгаарлагдмал эрх мэдэл бүхий төрийн тэргүүн байдаг бол Ерөнхийлөгчийн засаглалтай болон хагас Ерөнхийлөгчийн засаглалтай улсад үүрэг нь илүү ач холбогдолтой, Засгийн газрын тэргүүний үүргийг гүйцэтгэж, удирдан чиглүүлсэн шинжтэй байна.[94] Мөн авторитари дэглэмтэй, нам төвтэй улсын удирдагч буюу дарангуйлагчийг Ерөнхийлөгч гэх нь бий.[95]

Английн Бүгд Найрамдах Улс (англ. the Commonwealth of England)-ын үед Английн Засгийн газрын хамгийн өндөр албан тушаалтныг илархийлэх зорилгоор “Ерөнхийлөгч” хэмээх үгийг анх хэрэглэжээ. Төрийн зөвлөлийн хэмжээгүй эрхийг халсны дараагаар Нийтийн танхимаас сонгогдсон гишүүд Бүгд Найрамдах Улсын гүйцэтгэх эрх мэдэл бүхий Засгийн газрын гишүүд болж, Төрийн зөвлөлийг Лордын Ерөнхийлөгч (англ. Lord President) удирдах бөгөөд Лордын Ерөнхийлөгч нь дангаараа бус зөвлөлтэй хамтран төрийн тэргүүний үүргийг гүйцэтгэдэг байв.[96]

Бүгд Найрамдах Улсын төрийн тэргүүн буюу “ганц тоон дээр” илархийлэгдэх нэр томьёо бүхий Ерөнхийлөгч гэсэн үгийг орчин үед сонгодог утгаар нь АНУ-ын 1787 оны Үндсэн хуульд “АНУ-ын Ерөнхийлөгч” гэсэн албан тушаалын нэршлээр анх оруулсан.[97] Хэдийгээр АНУ-ын өмнөх Засгийн газруудад Конгрессын Ерөнхийлөгч гэх албан тушаал байсан боловч тэдгээр нь гүйцэтгэх эрх мэдлийг агуулахгүй, хурал даргалах хэлбэрийн шинжтэй байсан байна. Энэхүү нэр томьёог Америкийн коллеж, их сургуулийн захирлыг “Ерөнхийлөгч” гэдэг байснаас үүдэлтэйгээр гаргаж иржээ. Учир нь Британийн их сургуулиудын захирлыг “Канцлер” (англ. Chancellor), гүйцэтгэх захирлыг “Дэд канцлер” (англ. Vice Chancellor) зэргээр нэрлэдэг байсан ба “Ерөнхийлөгч” гэсэн нэр томьёо ихэвчлэн АНУ-ын Их, дээд сургуулийн боловсролын тогтолцоонд хэрэглэгддэг байв.

АНУ ийнхүү бүгд найрамдах засаглалтай улсынхаа төрийн тэргүүнийг “Ерөнхийлөгч” хэмээн нэрийдэх болсноос хойш эдүгээ Бүгд Найрамдах хэлбэртэй бараг бүх улс оронд түгэн дэлгэрсэн гэж үздэг.[98]

Франц Улсад парламентын Ерөнхийлөгчийг “фр. Monsieur/Madame le Prйsident” гэдэг байсан бөгөөд өдгөө тус улсад Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий шүүгчийн хувьд энэ нэр томьёог хэрэглэж байна. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгч гэдэг нь тодорхой эрх зүйн байдал бүхий, тусгай үг тул дур зоргоор хэрэглэхгүй бөгөөд албан ёсоор улсын Ерөнхийлөгч болон Ерөнхий шүүгч хоёрыг ийн нэрлэдэг ажээ.

---

93 Henry Campbell Black, *Black’s law dictionary*, 4th edition (St.Paul, Minn: 1968, West publishing Co), p.1424.

94 MS Shugart “Comparative Executive–Legislative Relations” *The Oxford handbook of political institutions (PDF)*. https://doi.org/10.1093%2Foxfordhb%2F9780199548460.003.0018 (Сүүлд үзсэн: 2019.05.08)

95 Мөн тэнд.

96 E.B.Fryde, *Handbook of British Chronology* (Cambridge: Cambridge University Press, 1941, 1961, 1986).

97 АНУ-ын Үндсэн хуулийн Хоёрдугаар зүйл, (1787).

98 П.Очирбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр, (Уб, 2001), 17 дахь тал.

Латин Америкийн Хаити Улсад 1807 онд Хенри Кристоф “Ерөнхийлөгч” гэгдэх болсноор тивийнхээ анхны Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглалтай улс болжээ.[99] Мөн Европ тивд 1802 онд анхлан Итали Улс “Ерөнхийлөгч”-тэй болсон бол Африкийн анхны Ерөнхийлөгч нь 1848 онд Либерээс төржээ. Түүнчлэн, Ази тивд анхны Ерөнхийлөгчийн албан тушаал 1912 онд Бүгд Найрамдах Хятад Улсад бий болсон гэж үздэг байна.[100]

Өнөөдрийн байдлаар дэлхий дахинд бүгд найрамдах засаглалтай улсыг “Ерөнхийлөгчийн тогтолцоотой”, “Хагас Ерөнхийлөгчийн тогтолцоотой”, “Парламентын тогтолцоо”-той хэмээн ангилж, ийм тогтолцоотой улсад төрийн тэргүүнээ “Ерөнхийлөгч” гэсэн нэр томьёогоор илэрхийлж байна. Тодруулбал, дэлхий дахинд “Ерөнхийлөгч” гэсэн томьёоллоор төрийн тэргүүнээ илэрхийлж буй 82 улс байна.[101]

Монгол хэлний хувьд “Ерөнхийлөгч” гэсэн үгийн үүсэл, чухам хэзээнээс хэрэглээнд орсон талаарх мэдээлэл хомс байна. Харин эрх зүйн зохицуулалтын хүрээнд 1990 оны 5 дугаар сарын 12-нд “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль”-ийг баталснаар “Ерөнхийлөгч” гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн шинэ байгуулалт /институт/[102] бий болсон талаар тэмдэглэсэн байдаг.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Ерөнхийлөгч” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучдугаар зүйлдийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1-д дэх хэсэгт “Ерөнхийлөгч бол Үндсэн хуулийн гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн.” гэсэн бол Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” номонд:

1. Улсын дээд эрхийг барих газрыг ерөнхийлөгч удирдагчийн албан тушаал; 2. Эрдэм шинжилгээний томоохон байгууллагыг ерөнхийлөн удирдагчийн албан тушаал;[103] академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” номондоо: “англ. president; ор. президент – Бүгд Найрамдах улсын хэлбэрт ерөнхийлөгч төрийн төдийгүй гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн;[104] Ш.Чоймаа нарын “Монгол хэлний хэлзүйн толь бичиг I боть” номонд: “ерөнхийлөн удирдагч, улсын ерөнхийлөгч[105] гэж тус тус тайлбарлажээ.”

Харин Г.Совд нарын “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар”-т ерөнхийлөгч гэх нэр томьёог авч үзэхдээ тухайн улс орны засаглалын хэлбэрээс хамаарч төрийн тэргүүн нь ерөнхийлөгч эсхүл хаан байна гэж тэмдэглэсэн бол доктор, профессор Ц.Сарантуяа хууль зүйн нэр томьёог 1/латин, 2/ үндэсний гэж ангилсан бөгөөд үндэсний нэр томьёог 1/гадаад, 2/ орчуулгын, 3/орчуулгын бус (уугуул) гэж ангилж үзсэн. Бидний судалж буй Монгол Улсын Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн институттай холбоотой нэр томьёоны суурь нь болж буй “Ерөнхийлөгч” гэсэн үгийг дээрх ангиллын орчуулгын бус (уугуул) гэх ангилалд багтаасан байна.[106]

---

[99] Gaspard Théodore Comte de Mollien, *Haïti ou Saint-Domingue, Vol 2*. (Paris: L’Harmattan, 2006), p. 63.

[100] Сун Ятсэн (хят. 孫文; 孫中山; 孫逸仙; латин галиг Sūn Yìxiān)

[101] Үүнийг тогтолцооноос нь үл хамааруулан албан ёсны нэр томьёогоор нь хавсралт 2-т хүснэгтээр үзүүлэв.

[102] Б.Чимид, “Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал” Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь онол практикийн бага хурал (2003), 23 дахь тал.

[103] Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (Уб, 1966), 233 дахь тал.

[104] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (*дөрөв дэх хэвлэлт*), (Уб, 2015), 189 дэх тал.

[105] Ш.Чоймаа нар, Монгол хэлний хэлзүйн толь бичиг I боть, (Хөх хот, 2006), 324 дэх тал.

[106] Ц.Сарантуяа, “Монгол Улсын хууль зүйн нэр томьёо судлал: сургамж ба шийдэл”, “Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, (Уб, 2016), 36 дахь тал.

Дүгнэвэл, “Ерөнхийлөгч” хэмээх нэр томьёог удирдагч, тэргүүлэгч гэсэн утгаар тайлбарласан бөгөөд бүгд найрамдах засаглалтай улсууд төрийн тэргүүнээ “Ерөнхийлөгч” гэх нийтлэг нэр томьёоор илэрхийлдэг байна.

ТӨРИЙН ТЭРГҮҮН

Төрийн тэргүүн гэдэг нь улс орныг тэргүүлэгч хүн юм. Өдгөө дэлхий дээрх ихэнх улсад Ерөнхийлөгч хэмээх албан тушаалтан энэ үүргийг гүйцэтгэдэг бол Хаант засаглалтай улсад хаан, социалист улсад Ардын хурлын тэргүүлэгч, дарга нар энэ үүргийг гүйцэтгэдэг байна. Тусгаар тогтносон улс орон төрийн тэргүүнтэй байх бөгөөд төрийн тэргүүнийхээ эрх, үүрэг, эрх хэмжээг Үндсэн хуулиараа тогтоодог байна.[107] Төрийн тэргүүнээ “Ерөнхийлөгч” хэмээн албан ёсоор нэрийддэг 82 улс байдаг талаар өмнөх хэсэгт дурдсан билээ.

Төрийн тэргүүн нь үндэсний эв нэгдэл, бүрэн эрхт улсын хуульт ёсыг албан ёсоор төлөөлдөг нийтийн албан тушаалтан юм.[108] Гагцхүү тухайн улсын төрийн дэглэм, эрх мэдэл хуваарилалтаас хамаарч төрийн тэргүүн нь бэлгэдлийн шинжтэй байх эсхүл Засгийн газрын тэргүүн байх эсэх нь тодорхойлогддог байна. Тухайлбал, парламентын засаглалд төрийн тэргүүн нь тухайн улсын “де-юре” (de jure)[109] удирдагч байдаг бол Ерөнхий сайд нь “де-факто” (de facto)[110] удирдагч байдаг. Эсрэгээрээ, хагас-ерөнхийлөгчийн засаглалтай улсад төрийн тэргүүн болон Засгийн газрын тэргүүний аль аль нь улсынхаа “де-факто” удирдагчид байдаг.

Парламентын засаглалтай орнуудад төрийн тэргүүн нь ерөнхийдөө бэлгэдлийн шинжтэй, Засгийн газрын өдөр тутмын үйл ажиллагаанд чиглэл өгдөггүй, улс төрийн албан тушаалыг ямар нэг байдлаар хэрэгжүүлдэггүй этгээд байна.[111] Төрийн тэргүүн нь мөн Засгийн газрын тэргүүний үүргийг хавсран гүйцэтгэдэг орнуудад улсын бэлгэдлийн шинжтэй төлөөлөгч байхаас гадна гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг хамгийн дээд эрэмбэ бүхий улс төрийн удирдагч байдаг.

Үндсэн хуулиараа тодорхойлсон төрийн дэглэм, засаглалын хэлбэрээс хамааруулан “төрийн тэргүүн”-ийг үндсэн дөрвөн төрөлд хуваах болох юм:

1. Парламентын тогтолцоот (стандарт загвар) – Онолын хувьд стандарт загвар бүхий парламентын тогтолцоонд төрийн тэргүүн нь гүйцэтгэх эрх мэдлийг Засгийн газрын тэргүүнтэй зөвшилцөн хэрэгжүүлдэг (Тухайлбал, ИБУИНВУ, Энэтхэг, ХБНГУ);
2. Парламентын тогтолцоот (гүйцэтгэх бус загвар) – Төрийн тэргүүн нь маш хязгаарлагдмал гүйцэтгэх эрх мэдэл бүхий, голдуу улсынхаа бэлгэдэл, ёс төдий үүрэг гүйцэтгэдэг загвар (Тухайлбал, Швед, Израиль);
3. Хагас-Ерөнхийлөгчийн тогтолцоот - төрийн тэргүүн нь Засгийн газар, танхимын тэргүүнтэй хамтран гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг (Тухайлбал, ОХУ, Франц, Шри-Ланка);
4. Ерөнхийлөгчийн тогтолцоот - төрийн тэргүүн нь Засгийн газрын тэргүүний

[107] Sir Arthur Watts “Heads of State” In Wolfrum, Rüdiger (ed.). *Max Planck Encyclopedia of Public International Law* (Oxford International Public Law: Oxford University Press, 2010), https://opil.ouplaw.com/view/10.1093/law:epil/9780199231690/law-9780199231690-e1418 (сүүлд үзсэн: 2019.05.01)

[108] Joanne Foakes, *The Position of Heads of State and Senior Officials in International Law* (Oxford, UK: 2014, Oxford University Press), p.110-111.

[109] Мөн тэнд, “Хууль ёсны” гэсэн утгатай латин үг. Олон Улсын эрх зүй дэх улс орны тусгаар тогтнолыг “бүрэн” хүлээн зөвшөөрөх хэлбэр бөгөөд төрийн тэргүүний хувьд “бүрэн эрх” бүхий удирдагч гэсэн утгаар хэрэглэгдэнэ.

[110] Мөн тэнд, “Харьцангуй бараг баримт” гэсэн утгатай латин үг. Олон Улсын эрх зүй дэх улс орны тусгаар тогтнолыг “бүрэн бус” хүлээн зөвшөөрөх хэлбэр. Улс төрийн онолд “де факто удирдагч” гэж төрийн удирдлагыг Үндсэн хуулийн бус буюу бусад хууль бус аргаар авсан этгээдийг хэлдэг. Энд зарим эрхийг эдлэх гэсэн утгаар номын зохиогч Жоанн Фоакес оруулсан.

[111] Мөн тэнд, 62 дахь тал.

үүргийг давхар гүйцэтгэх бөгөөд гүйцэтгэх бүх эрх мэдлийг хэрэгжүүлдэг (Тухайлбал, АНУ, Индонези).

Монгол Улсын тухайд 1206-1924 он хүртэл Чингис хаанаас эхлэн үе залгамжилсан 37 хаан, Манжийн хаадыг дамжин Богд хаан хүртэл төрийн тэргүүн маань хаад байжээ.[112]1924 онд батлагдсан БНМАУ-ын анхдугаар Үндсэн хуулийн хоёрт "харьяат улсад Бүгд Найрамлах Ардын засгийг явуулж, дажутан гэдэг ерөнхий даргыг сонгохгүй улсын бүх дээд эрхийг УИХ-д ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраа хадгалах" гэж зааснаас хойш Монгол Улсын төрийн тэргүүний хууль ёсны статус алга болж, Улсын Бага Хурлын тэргүүлэгчид, Тэргүүлэгчдийн дарга, Ерөнхий сайд, Ардын Их Хурлын тэргүүлэгчид, Тэргүүлэгчдийн дарга, намын дарга хавсран "хамтын тэргүүний" хэлбэртэй байж хожим энэ албан тушаалтнаас "Нам, төрийн тэргүүн" гэж өргөмжилдөг болсоор 1990 он хүрчээ.[113]

Төрийн тэргүүн гэх нэр томьёо тухайн нийгмийн цаг үеийн байдал, тогтолцоо, засаглалын хэлбэрээс хамаараад тодорхой хэмжээний ялгаатай тодорхойлогдож ирсэн байх тул Монгол Улсын хувьд тус нэр томьёо хэрхэн ойлгогдож ирснийг дараах цаг хугацаагаар ангилан авч үзье:

Их Засаг хууль (Их Монгол Улсын үед)	1921-1924 оныг хүртэлх үе	1924-1990 оныг хүртэлх үе	1990-ээс одоог хүртэлх үе
Тус хуулийн 1 дүгээр зүйлд "Мөнх тэнгэрийн хүчин дор Их монгол улсын Далай хааны зарлиг ил болгон иргэн дор хүрвээс биширтүгэй, аюутугай", 2 дугаар зүйлд "Тэнгэрээс соёрхсон Чингис хааны зарлиг эргэлзээгүй" хэмээн тус тус заажээ. Их Монгол Улсаас өмнөх үе, Их Монгол Улсын үе, Бага хаадын үе, Манжийн ноёрхлын үе зэргээс 720 шахам жил манай улс хаант засагтай, төрийн тэргүүн нь "хаан" байж иржээ. XIII зууны эрх зүйн гол эх сурвалж болох Их Засаг хуулийн дээр дурдсан заалтаас үзвэл, Чингис хааны зарлигийг эргэлзээгүй бөгөөд дагаж мөрдөхөөр хуульчилсан байна.	1921 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр "Богд хаан ба Засгийн газар хоорондын холбогдлыг илэрхийлсэн тангараг дүрэм"-ийг баталж, хэмжээт засагтай ард улсад "төрийн тэргүүн" болох "хаан" нь ямаршуу байр суурь, эрх мэдэлтэй байхыг тодорхойлсон. Тангарагийн гэрээ байгуулагдсанаар Монгол Улсад засаглалын хэмжээ, хуваарилалтын эхлэл тавигдаж, уг чанартаа Үндсэн хуульт хаант засгийн нийтлэг төрх тодорсон байна.[2]	1924 оны 5 сард Богд Жавзандамба хаан нэгэнт таалал төгссөн тухайд ардын Засагт улсын ёсонд нийцүүлэн Бүгд Найрамдах засгийг явуулахаар тогтсон. 1924 оны Үндсэн хуулийн боловсруулах ажлыг гардан хийсэн Б.Цэрэндорж төрийн тэргүүнгүй байхын сайхныг хойт хөршөөс үлгэр авч, төрийн тэргүүнтэй байхын муу уршгийг урд хөршийн жишээгээр тайлбарлаж байсан.[3] Тийнхүү Богдыг дахин тодруулахгүй, "Да жунтан" хэмээх улсын ерөнхий дарга / төрийн тэргүүн/-ийг сонгохгүй гэж шийдэж, анхны Үндсэн хуульдаа тунхаглажээ. Тэр цагаас хойш ЗХУ-ын жишгээр төрийн "хамтын тэргүүн"-тэй байх ёсыг 66 жил даган баримталсан түүхтэй.[4] Өнгөрсөн зууны энэ хэлбэр нь улс орны хэмжээний эрхэм дээд шийдвэрийг хэн нэгэн тушаалтан ганцаараа гаргахгүй, харин хууль, зарлигийг Тэргүүлэгчид хэмээх хамтын бүрэлдэхүүний олонхийн саналаар батлан дагуулдаг зарчимд үндэслэн байсан бөгөөд гол төлөв түүгээр нь "хамтын тэргүүн" гэж байжээ.	1990 онд АИХ-ын чуулган "БНМАУ-ын Төрийн дээд байгууллагын бүтцийн тухай" тогтоол гаргаж, "БНМАУ-ын төрийн тэргүүн нь Ерөнхийлөгч байна" гэсэн томьёолол хуульчлагдан тусгагдсан. 1990 оны 5 дугаар сарын 12-нд "БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль"-ийг баталж, 13 дугаар зүйлд "БНМАУ-ын Ерөнхийлөгч бол Ардын төрийн тэргүүн, БНМАУ-ын тусгаар тогтнол, монголын ард түмний эв нэгдлийн баталгаа мөн" гэж тодорхойлсноор Монгол Улсад Ерөнхийлөгч гэсэн Үндсэн хуулийн эрх зүйн шинэ байгуулалт / институт/[5] бий болжээ. Ийнхүү парламентын бүгд найрамдах улсын Ерөнхийлөгчийн статустайгаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн албан тушаал анхлан бий болсон юм.

1990 оноос өмнө нам нь төрийг орлон ажиллах болсны хэрээр социалист орнуудын намын удирдагчийг төрийн тэргүүн гэж Олон Улсын хүрээнд хүртэл

[112] П.Очирбат, *Монгол Улсын Үндсэн хууль /хэрэгжилт, хяналт, судалгаа/,* (Уб, 2017), 181 дэх тал.

[113] 1924 оноос өнөөг хүртэлх Төрийн тэргүүний үүрэг гүйцэтгэгч болон Төрийн тэргүүний мэдээллийг хавсралт 3-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

тооцож харилцдаг, сонин хэвлэлд бичдэг байв. Доктор, профессор Б.Чимид "Төрийн тэргүүн гэж төрийн албан тушаал талаасаа ямар ялгаатай нь гол биш, төрийг орлосон намын дарга байсан нь тодорхойлох үүрэгтэй байжээ. Өөрөөр хэлбэл, "намын нэрээр улсын тэргүүний үүргийг гүйцэтгэх болсон нь цагтаа бодит зүйл, угтаа гажуудал байж дээ" гэж сэтгэлд арга буюу бууна"[114] хэмээн илтгэлдээ бичжээ. Харин 1990 оны 5 дугаар сарын 12-нд баталсан "БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн хууль", 1992 оны 1 дүгээр сарын 13-нд баталсан "Монгол Улсын Үндсэн хууль"[115]-д "Ерөнхийлөгч"-ийн институтийг бий болгосноор Монгол Улсад "төрийн тэргүүн" гэх нэр томьёо дахин хэрэглэгдэх болж, тэрхүү "төрийн тэргүүн" нь "Ерөнхийлөгч" байхаар тогтжээ.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Төрийн тэргүүн" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Б.Чимид "Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь" номондоо "төр тэргүүлдэг гэх дээрх санааг засаг төрийн гурван салааг тус тусад нь даргалдаг мэтээр гуйвуулан хэтрүүлж болохгүй. Харин Үндсэн хуулиар бэхжүүлсэн засаг төрийн байгууллын оршин тогтнохуйн үүднээс тэдгээр салаа мөчрийн аль алинд нь хууль зүйн хувьд эцсийн бодитой нөлөө үзүүлэхүйц бүрэн эрх, түүнийг хангах, юуны өмнө, эрх-зохион байгуулалтын механизмтай байх гэсэн ойлголт болно"[116] гэсэн бол Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь" номонд: "Тэргүүн – 1. Толгой; толгой тэргүүн хорш; 2. толгойлогч, удирдагч, ерөнхийлөгч; засгийн газрын тэргүүн; төлөөлөгчдийн тэргүүн; тэргүүн захас (тэргүүлж даргалсан хүн); тэргүүн сайд (жинхэнэ сайд); 3. Хуучирсан нэгдүгээр зэрэг шагнагдсан тайж; тэргүүн зэрэг; 4. Юмны дээд тал, урд тал; тэргүүний залуур (онгоцны хэрэгсэл); 5. Нэгдүгээр, анхдугаар, анхны, эхний; тэргүүн дэвтэр; тэргүүн боть."[117]; гэсэн бол академич Ж.Амарсанаагийн редакторласан "Эрх зүйн мэдлэгийн товч толь" номонд: "Төрийн удирдлагын болон гадаад харилцааны асуудал эрхэлсэн Үндсэн хуулийн дээд байгууллага. Тэрээр хамтын болон нэг хүний гэсэн хоёр төрөлтэй. Хөрөнгөтөн улсуудын төрийн тэргүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх хэлбэрээсээ шалтгаалан олон улсын харилцааны салбарт онцлогтой байдаг. Хөрөнгөтөн орны төрийн тэргүүн нь гадаад бодлогын асуудлаар бүрэн эрхгүй эсхүл бага хэмжээний бүрэн эрхийг эдэлдэг онцлог шинжтэй. Төрийн тэргүүн нь хаан, ван, ерөнхийлөгч буюу эсхүл төрийн зөвлөл, дээд зөвлөл, тэргүүлэгчид зэрэг хамтын удирдлагын байгууллага байдаг."[118]; академич С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" номондоо: "англ. head of state; ор. глава государства - Төрийн дээд төлөөлөгч, гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг дээд албан тушаалтан. Хаант засаглалтай улсад (Их Британи, Швец, Испани, Япон) Т.т нь хаан байх бөгөөд хуулиар тогтоосон журмын дагуу эрх мэдлийг угсаа залгамжилна. БНУ-ын засаглалтай улсад Т.т нь ерөнхийлөгч бөгөөд хүн амаас шууд (ОХУ, Мексик) буюу шууд бус журмаар (АНУ, Аргентин), эсхүл олон шаттай сонгуулиар (Итали, ХБНГУ, Энэтхэг) сонгогдоно. Дэлхийн бараг бүх улсад Т.т нь ганцаарчилсан хувь хүн байхаар тогтоосон бөгөөд ерөнхийлөгчийн БНУ-д (АНУ, Мексик) нэгэн зэрэг гүйцэтгэх эрх мэдлийн тэргүүн байдаг. Бараг бүх улсын Үндсэн хуулиар Т.т-нд өргөн бүрэн эрх олгосон: засгийн газрын тэргүүн ба сайд нарыг томилох, зэвсэгт хүчний дээд ерөнхий командлагч байх, уучлал үзүүлэх, хуульд хориг тавих, одон медиалаар шагнах, парламентын чуулганыг зарлан хуралдуулах, парламентыг тараах, хууль санаачлах зэрэг. Парламентын бүгд найрамдах улсад Т.т-ий бүрэн эрхийг түүний нэрийн өмнөөс засгийн газар хэрэгжүүлнэ." [119]; хэмээн тодорхойлсон бол Ш.Чоймаа нарын "Монгол хэлний хэлзүйн толь бичиг II боть"

[114] Мөн тэнд, 20 дахь тал.

[115] Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, (1992),

[116] Б.Чимид, Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь (төслийн багийн судалгааны ажлын тайлан), (Уб, 2005), 16 дахь тал.

[117] Я.Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь,* (Уб, 1966), 578 дахь тал.

[118] Ж.Амарсанаа, *Эрх зүйн мэдлэгийн товч толь*, (Уб, 1986), 134 дэх тал.

[119] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (анхны хэвлэл), (Уб, 2007), 434 дэх тал.

номонд: “Тэргүүн – толгой, манлай, эхний, дээд”[120] гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, “Төрийн тэргүүн” хэмээх нэр томьёо нь тухайн улс орны засаглалын хэлбэр, эрх мэдлийн хуваарилалтаас шалтгаалан янз бүр байгаа ч улс орныг тэргүүлэн удирдагч гэсэн нэгдмэл утгаар тайлбарласан байна. Мөн “төрийн тэргүүн” гэсэн нэршил нь “Ерөнхийлөгч” хэмээх нэр томьёоноос ялгаатай нь бүгд найрамдах болон хаант засаглалтай байхаас үл хамааран хэрэглэгддэг нийтлэг нэр томьёо буюу илүү өргөн хүрээний ойлголт болох нь харагдаж байна.

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ

Англи хэлний “Presidential election” буюу Ерөнхийлөгчийн сонгууль нь Улсын төрийн тэргүүн болох Ерөнхийлөгчийг сонгох сонгууль юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн хувьд ард түмнээс сонгодгийг харгалзан “холимог” буюу “Парламент-Ерөнхийлөгч” хосолсон улс гэж дотоод, гадаадын зарим судлаач ангилсан нь бий. Гэхдээ “сонгох ёсон” бол төрийн удирдлагын хэлбэр хийгээд Ерөнхийлөгчийн статусыг тодорхойлох цорын ганц шалгуур биш[121] юм.

Энэ хэсэгт Ерөнхийлөгчийн сонгуулийн агуулгыг өргөжүүлэн авч үзэлгүйгээр тус сонгуулийн талаар Үндсэн хуульдаа тусгасан улсуудыг тогтолцоо бүрээр төлөөлөл болгон үзье.

Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал: Ерөнхийлөгчийн засаглалтай ихэнх улсад Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн болон Засгийн газрын тэргүүний үүргийг хамтад нь хэрэгжүүлдэг. Өөрөөр хэлбэл, Ерөнхийлөгч нь гүйцэтгэх эрх мэдлийг шууд удирддаг. Энэхүү тогтолцоонд Ерөнхийлөгч нь ард нийтийн саналаар шууд эсхүл сонгуулийн коллеж (англ. Electoral college[122]) болон өөр бусад ардчиллын замаар сонгогдсон байгууллагаас шууд бусаар сонгогддог байна.

Жишээ 1 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Америкийн Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн II зүйлийн 1 дэх хэсэг[123]: “Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчид гүйцэтгэх эрх мэдэл хадгалагдана. Тэрээр дөрвөн жилийн хугацаанд чиг үүргээ Дэд Ерөнхийлөгчийн хамтаар хэрэгжүүлэх ба дараах байдлаар сонгогдоно:

Сонгогчид нь холбогдох Муждаа хоёр нэр дэвшигчтэй саналын хуудас бөглөх ба тэдгээрийн нэг нь өөртэй нь ижил Мужийн оршин суугч биш байна. Ийнхүү санал өгсөн хүмүүсийн жагсаалт, тоог тус бүрээр гаргаж жагсаалтыг баталгаажуулан битүүмжилж Сенатын Ерөнхийлөгчид хүргүүлнэ. Сенатын Ерөнхийлөгч нь Сенатын болон Төлөөлөгчдийн танхимын хамтаар бүх баталгаажуулалт, саналыг тоолно. Томилогдсон Сонгогчдын олонхийн саналыг авсан хүн Ерөнхийлөгч болно: хэрэв олонхийн санал авсан нэгээс илүү хүн байвал, саналын тоо тэнцвэл Төлөөлөгчдийн танхим саналын хуудсаар аль нэгийг нь Ерөнхийлөгчөөр сонгоно; тэгээд олонхийн санал авсан хүнгүй бол жагсаалтын хамгийн тэргүүнд бичигдсэн таваас Танхимын хэлсэн журмаар Ерөнхийлөгчийг сонгоно. Гэвч Ерөнхийлөгчийг сонгоход Мужуудаас санал хураасан байх ба Муж бүрийн Төлөөлөгчид тус бүр нэг саналын эрхтэй; энэ нь Мужийнн гуравны хоёрын ирцийг шаардах бөгөөд Мужийнн олонхийн сонголт шаардлагатай. Ерөнхийлөгчийг сонгосны дараа сонгогчдын хамгийн олон санал авсан хүн Дэд Ерөнхийлөгчөөр сонгогдоно. Гэвч хоёр буюу түүнээс дээш хэмжээний тэнцүү санал байвал Сенат саналын хуудсаар Дэд Ерөнхийлөгчийг сонгоно” гэжээ.

---

[120] Ш.Чоймаа нар, Монгол хэлний хэлзүйн толь бичиг II боть, (Хөх хот, 2006), 900 дахь тал.

[121] Б.Чимид “Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал” Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь ОПБХ (УБ: 2003): 27 дахь тал.

[122] The Electoral College – Сонгуулийн коллеж гэж АНУ-ын Үндсэн хуулиар байгуулагдсан, 4 жил тутамд солигддог, Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийг сонгох зорилго бүхий сонгогчдын байгууллага юм. Сонгуулийн коллеж нь 538 сонгогчтой, сонгуульд ялахад олонх буюу 270 сонгогчийн санал авсан байх шаардлагатай.

[123] АНУ-ын Үндсэн хууль, (1787).
https://www.constituteproject.org/constitution/United_States_of_America_1992?lang=en

Дээрх жишээнээс харвал, АНУ-ын хувьд Ерөнхийлөгчийг “Сонгуулийн коллеж” (англ. Electoral college) гэх эрх бүхий байгууллагаас сонгодог өвөрмөц тогтолцоотой байна.

Жишээ 2 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Үндсэн хуулийн 77 дугаар зүйл[124]: “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч болон Дэд Ерөнхийлөгчийн сонгуулийн эхний санал хураалтын дүн аравдугаар сарын эхний ням гарагт гарах бөгөөд хэрэв хоёр дахь санал хураалт болохоор байвал тухайн үеийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусах жилийн аравдугаар сарын сүүлийн ням гарагт дүн гаргаж, нэгэн зэрэг сонгоно.

Мөн нэр дэвшигчдийн аль нь ч эхний санал хураалтаар олонхийн санал аваагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийн үр дүнг танилцуулснаас хойш хорь хоногийн дотор дахин санал хураалт явуулах ба олонхийн санал авсан нэр дэвшигч сонгогдоно.

Тус улсын Үндсэн хуулийн 82 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байх бөгөөд сонгогдсон жилийн нэгдүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн тоолно” гэсэн байна.

Бразил Улсын Ерөнхийлөгч нь дөрвөн жилийн хугацаатайгаар ард түмнээс шууд сонгогдох ба Монгол Улсын Үндсэн хуульд тусгагдсантай адилаар “анхан болон дахин санал хураалт”-ыг хуульчилснаараа онцлог байна.

<u>Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал:</u> Энэхүү тогтолцоо нь парламентын засаглалтай адил Ерөнхийлөгч, Ерөнхий сайд гэсэн хоёр албан тушаалтан байх боловч ялгаатай нь Ерөнхийлөгч нь илүү “өдөр тутмын” шинжтэй чиг үүрэг хэрэгжүүлнэ.[125] Энэхүү тогтолцооны гол төлөөлөл нь Франц бөгөөд тус улсаас улбаалан Румын, Шри-Ланка, Португал болон Францын колони байсан зарим улсууд “Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал”-ыг хэрэгжүүлдэг.

Жишээ 3 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Франц Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлд[126] “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь бүх нийтийн сонгон шалгаруулалтаар таван жилийн хугацаатай сонгогдоно.”, 7 дугаар зүйлд “Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь дийлэнх олонхийн саналаар сонгогдоно. Эхний санал хураалтаар олонхийн санал аваагүй бол түүнээс хойш арван дөрөв хоногийн дотор хоёр дахь санал хураалт явуулна. Эхний санал хураалтаар хамгийн олон санал авсан зөвхөн хоёр нэр дэвшигч хоёр дахь санал хураалтад оролцоно. Ерөнхийлөгч сонгох үйл явцыг Засгийн газраас зарласнаар хэлэлцэж эхэлнэ. Шинэ Ерөнхийлөгчийн сонгууль одоогийн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас хориос доошгүй, гучин таваас дээшгүй хоногийн хугацаанд явагдана ...” гэж хуульчилжээ.

Франц Улс мөн Үндсэн хуульдаа дээрхээс гадна Ерөнхийлөгчийн сонгуулийн журмыг ерөнхийд нь боловч нэлээд дэлгэрэнгүй байдлаар хуульчилсан байна.

Монгол Улсыг тус тогтолцоонд буюу “Холимог парламентын засаглал”-тай улсад хамааруулах нь бий. Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлд Ерөнхийлөгчийн сонгуулийн ерөнхий журмыг зохицуулсан.

<u>Парламентын бүгд найрамдах засаглал:</u> Парламентын бүгд найрамдах засаглалын хувьд Ерөнхийлөгч нь де-факто, тодорхой гүйцэтгэх эрх мэдэлгүй (Австрийн Ерөнхийлөгчийн адил) эсхүл де-юре, тодорхой гүйцэтгэх эрх мэдэлгүй (Ирландын Ерөнхийлөгчийн адил) байх ба ихэвчлэн бэлгэ тэмдгийн шинжтэй албан тушаалтан байна. Энэхүү тогтолцоонд гүйцэтгэх эрх мэдэл олонхийн суудал авсан эрх баригч намын дарга болох Ерөнхий сайдад хадгалагдана. Гэсэн хэдий ч Ерөнхийлөгч нь төрийн албаны тэргүүн, зэвсэгт хүчний Ерөнхий командлагч

[124] Бразил Улсын Үндсэн хууль, (1988), https://www.constituteproject.org/constitution/Brazil_2017?lang=en

[125] MS Shugart “Comparative Executive–Legislative Relations” *The Oxford handbook of political institutions (PDF)*. https://doi.org/10.1093%2Foxfordhb%2F9780199548460.003.0018 (Сүүлд үзсэн: 2019.05.30)

[126] Франц Улсын Үндсэн хууль, (1958), https://www.constituteproject.org/constitution/France_2008?lang=en

байдаг.[127] Ийм засаглалтай улсад Австри, Армени, Албани, Бангладеш, Бүгд Найрамдах Чех, ХБНГУ, Унгар, Исланд, Энэтхэг, Ирланд, Израиль, Итали, Мальта, Пакистан, Сингапур зэрэг хамаарна.

Жишээ 4 (Парламентын бүгд найрамдах засаглал): Унгар Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд[128] 1. "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийг 5 жилийн хугацаагаар Парламентаас сонгоно.", 2. "35-аас дээш насанд хүрсэн Унгар Улсын аливаа иргэн Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдоно.", 3. "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийг зөвхөн нэг удаа дахин сонгож болно." гэж заасан бол тус хуулийн 11 дүгээр зүйлд 1. "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийг өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дуусахаас гуч хоногоос доош, жар хоногоос дээшгүй хугацаанд эсхүл хугацаанаас өмнө дуусгавар болсон тохиолдолд гуч хоногийн дотор тус тус сонгоно. Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хугацааг Танхимын Дарга тогтооно. Үндэсний Ассамблей Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийг нууц санал хураалтаар сонгоно.", 2. "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг нэр дэвшүүлж явуулна. Үндэсний Ассамблейн гишүүдийн дор хаяж тавны нэг нь бичгээр санал болгосноор нэр дэвшүүлэлт хүчинтэй. Санал хураалт явуулахаас өмнө Үндэсний Ассамблейн дарга нэр дэвшигчдийг батална. Үндэсний Ассамблейн гишүүн тус бүр нэг нэр дэвшигчийг санал болгож болно. Хэрэв Үндэсний Ассамблейн гишүүн нэгээс илүү хүнийг нэр дэвшүүлбэл тухайн гишүүний санал болгосон бүх нэр дэвшигч хүчингүй.", 3. "Эхний санал хураалтаар Үндэсний Ассамблейн гишүүдийн гуравны хоёрын саналыг авсан нэр дэвшигч Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдоно.", 4. "Эхний санал хураалт үр дүнд хүрээгүй бол хоёр дахь санал хураалтыг явуулна. Хоёр дахь санал хураалтад эхний санал хураалтад хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг оруулна. Эхний санал хураалтаар эхний байранд тэнцүү санал авсан бол хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг оруулна. Эхний санал хураалтаар хоёрдугаар байранд тэнцүү санал авсан бол хамгийн олон санал авсан болон хоёрдугаарт орсон нэр дэвшигчийг аль алиныг нь оруулна. Хоёр дахь санал хураалтаар санал өгөгчийн тооноос хамааралгүйгээр олонхийн хүчинтэй санал авсан нэр дэвшигч Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдоно.", 5. "Санал өгөх үйл явц дараалсан хоёроос дээшгүй өдрийн дотор явагдаж дуусна ..." гэж хуульчилжээ.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Ерөнхийлөгчийн сонгууль" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь" номонд: "Тус тольд энэхүү холбоо үгээр тайлбарлаагүй бөгөөд "Сонгууль" хэмээх үгийг – депутат, хариуцлагатай албан тушаалтан, байгууллагын гишүүдийг олноороо хэлэлцэж шилэн томилох; сонгууль хийх; сонгуулийн тойрог; нийт, тэгш, шууд, нууц саналаа өгөх сонгууль; сонгуулийн өмнөх хурал."[129] гэсэн бол академич С.Нарангэрэлийн "Эрх зүйн эх толь бичиг" номонд: "англ. presidential election; ор. президентские выборы – МУ-д хоёр шаттай сонгууль. Анхан шатны сонгуульд УИХ-д суудалтай нам дангаараа буюу хамтран нэр дэвшүүлнэ."[130]; Э.Уранчимэг "Монгол хэлний шинэ үг, хэллэгийн толь" номондоо: "Улс төр, улсын ерөнхийлөгчийг ард түмний саналаар сонгох үйл ажиллагаа[131] гэж тайлбарласан байна."

Дүгнэвэл, парламентын засаглалтай улсад Ерөнхийлөгч нь парламентаас сонгогдох бөгөөд жишээ болгон авсан Унгар Улсын хувьд Ерөнхийлөгчийн сонгууль, ялангуяа анхан болон хоёр дахь санал хураалтын талаар Үндсэн хуульдаа нэлээд дэлгэрэнгүй зохицуулсан байна.

---

127 MS Shugart "Comparative Executive–Legislative Relations" *The Oxford handbook of political institutions (PDF)*. https://doi.org/10.1093%2Foxfordhb%2F9780199548460.003.0018 (Сүүлд үзсэн: 2019.05.30)

128 Унгар Улсын Үндсэн хууль, (2011), https://constituteproject.org/constitution/Hungary_2016?lang=en

129 Я.Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь,* (Уб, 1966), 479 дэх тал.

130 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (дөрөв дэх хэвлэлт) (Уб, 2015), 190 дэх тал.

131 Э.Уранчимэг, *Монгол хэлний шинэ үг, хэллэгийн толь, Монгол хэл соёл 13*, (Уб, 2014), 115 дахь тал

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ХОЁР ШАТ

Ерөнхийлөгчийн сонгууль явагдах хэлбэр буюу нэг сонгуулийн хоёр үйлдэл. Өөрөөр хэлбэл, бие даасан хоёр шат биш бөгөөд нэг нь нөгөөгүйгээрээ орших боломжгүй, нийлээд нэг сонгуулийг бүрэлдүүлж буй үйл явц юм. Монгол Улсын хувьд сонгуулийн анхан шатанд Ерөнхийлөгчөө ард түмнээс шууд сонгож, хоёр дахь шатанд УИХ олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргадаг.

Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байх тухайд Монгол Улсын Үндсэн хуулийн төсөл хэлэлцэх үед зарчмын зөрөөтэй санал гарч байсныг эрдэмтэд тэмдэглэсэн нь бий.[132]

Монгол Улсын Үндсэн хууль батлагдахаас өмнөх хувилбар	Монгол Улсын Үндсэн хуулийн батлагдсан хувилбар	Монгол Улсын Сонгуулийн тухай хууль[6]
УБХ-аас Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байх бөгөөд анхан шатанд сонгогчдын санал хурааж хамгийн олон санал авсан хоёр хүнийг 2 дахь шатанд УИХ дээр өрсөлдүүлэн санал хурааж сонгох хувилбарыг ард түмнээр хэлэлцүүлэн АИХ-д өргөн мэдүүлсэн байв. Гэтэл "Бие даасан депутатуудын бүлэг" голлог "Ерөнхийлөгчийг ард түмнээс шууд сонгоно" гэсэн санал оруулж, "Ерөнхийлөгчөө сонгож чаддаггүй ард түмнийг ямар ард түмэн гэх вэ?"[7] гэсэн маргаан өрнөжээ. Уул маргаан АИХ-ын хуралдаанаас хальж намуудын хоорондын болж өрнөөд "мухардалд орох" тийш хандсан тул УИХ-ын болон намуудын удирдагчдыг Ерөнхийлөгч зохицуулан зөвшилцөж, "ард түмнээс сонгох", тэгэхдээ 2 дахь шат байна гэсэн дундын хувилбарт хүрч батлагдсан түүхтэй.[8]	Батлагдсан хувилбар нь Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай гэснээр төслийнхтэй адил мэт боловч 2 дахь шатанд 2 хүнийг өрсөлдүүлэх бус, харин "анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрнө" гэснээр ялгаатай болсон байна.[9]	Монгол Улсын Сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт "Хоёр дахь шатны сонгууль гэж анхан шатны сонгуульд оролцож саналаа гаргасан сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж УИХ түүний бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахыг хэлнэ" гэж заасан ба эрдэмтэд энэ заалтыг зүй ёсоор шүүмжилж, энд дурдсан хоёр дахь шатны сонгуулийг сонгуулийн бие даасан шат гэж үзэхгүй, учир нь энэ нь ард түмний сонголтыг дээд байгууллагаас хүлээн зөвшөөрч байгаа ердийн үйл явц бөгөөд нэр дэвшигчийг сонгох "сонгууль" явагддаггүй гэжээ.[10] Өөрөөр хэлбэл, "УИХ энд үзэмжээрээ шийдвэр гаргахгүй, нэг дэх шатанд олонхийн санал авсан нэр дэвшигчийн авч хэлэлцэн Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж албан ёсоор хүлээн зөвшөөрч хууль батлах үүрэгтэй. Үүнийг бүх нийтийн санал асуулгын дүнг парламент хууль батлах замаар баталгаажуулдаг бусад улсын практиктай харьцуулж болно. Энэ нь шийдвэрийг хоёрдмол байдлаар хүчин төгөлдөр болгож байгаа хэрэг биш, харин ард түмний илэрхийлсэн шийдвэрийг хууль зүйн хэлбэрт оруулж байгаа явдал юм"[11] хэмээн тайлбарласан байна.

Монгол Улсын Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна гэж заасан. Уг нь нэр дэвшигчийн талаар нийт сонгогчдын санал хурааж, хамгийн олон санал авсан хоёр хүнийг УИХ-д оруулан өрсөлдүүлж, гишүүдийн саналыг нуцаар хураан олонхийн саналаар эцэслэн сонгох төслийг АИХ-д оруулсан байдаг. Түүнийг хэлэлцээд хоёр дахь шатны сонгуулийг дараах байдлаар өөрчилжээ.

Энэ заалтын ёсоор анхан шатны сонгуулийн дараа УИХ Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нь шалгаж хүлээн зөвшөөрөх нь 2 дахь шат болох бөгөөд үүгээрээ ард түмнээс сонгогдмогц бүрэн эрх олдог бусад зарим орны практикаас ялгаатай юм. Нэгэнт УИХ "зөвшөөрөх" хууль гаргах эрхтэй учир сонгууль зохих журмаар явагдаагүй, сонгогдогч Үндсэн хуулиар тавих шаардлагад нийцэхгүй гэж тогтоогдвол анхан шатны сонгуулийг хүчингүй болгох хууль зүйн үндэстэй нь учир шалтгааны үүднээс ойлгомжтой юм. Үүгээр нь Үндсэн хуульд "хоёр шаттай" хэмээн тооцож

[132] Б.Чимид "Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал" Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь ОПБХ (Уб, 2003): 25 дахь тал.

үлдээсэн байна.[133]

Анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг УИХ Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж түүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсөн хууль гаргана.[134]

Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)-ийн Гучин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт Ерөнхийлөгчийн сонгууль нь шууд сонгууль атлаа түүний хоёр дахь шатыг тодорхой илэрхийлээгүй мэт боловч Сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д "Анхан шатны сонгууль гэж сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн төлөө саналаа нууцаар гаргаж, Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийг хэлнэ." гэж, мөн зүйлийн 9.2-т "Хоёр дахь шатны сонгууль гэж анхан шатны сонгуульд оролцож саналаа гаргасан сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж УИХ түүний бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахыг хэлнэ."[135] гэж тус тус тодорхойлон бичжээ. Энэ нь сонгуулийн хоёр дахь шатанд сонгуулийн дүнг хүлээн зөвшөөрч хууль гаргах боломжгүй, шинэ нөхцөл байдал илэрвэл сонгуулийн хоёр дахь шатанд эцсийн шийдвэр гаргах эрх бүхий төлөөлөгчдийн байгууллага болох УИХ-ын саналыг сонгуулийн хоёр дахь шат гэж үзэж буй болно.[136]

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Ерөнхийлөгчийн сонгуулийн хоёр шат" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна;", Сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхийлөгчийн сонгууль нь дараах шаттай байна", 9.1.2-т "анхан шат;",9.1.3- т "хоёр дахь шат.", мөн тус зүйлийн 2 дахь хэсэгт "Анхан шатны сонгууль гэж сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхтэй оролцож, Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийн төлөө саналаа нууцаар гаргаж, Ерөнхийлөгчийг сонгох сонгуулийг хэлнэ.", 3 дахь хэсэгт "Хоёр дахь шатны сонгууль гэж анхан шатны сонгуульд оролцож саналаа гаргасан сонгогчдын олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж УИХ түүний бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргахыг хэлнэ." хэмээн тусгаж өгсөн бол Г.Совд нарын "Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар" номонд: "Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай байна гэдэг бол сонгууль бүрд заавал дамжих ёстой биш, шаардлагатай үед хоёрдахь шатаар дамжиж болох заалт юм. Хэрэв Ерөнхийлөгчийн сонгуулийн анхан шатны санал хураалтад гурав буюу түүнээс дээш тооны нэр дэвшигч оролцоод тэдгээрийн хэн нь санал хураалтад оролцсон сонгогчдын олонхийн санал авч чадаагүй бол тайлбарлан буй зүйлийн 5 дахь хэсэгт заасныг хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг дахин санал хураалтад оруулж сонгох боломжийг нээлттэй орхисныг хоёр дахь шат гэж ойлгох нь зүйтэй."[137] гэж тайлбарлажээ.

Дүгнэвэл, Монгол Улсын хувьд сонгуулийн анхан шатанд Ерөнхийлөгчөө ард түмнээс шууд сонгож, хоёр дахь шатанд УИХ олонхийн санал авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрдөг хоёр шат бүхий тогтолцоотой болохыг Үндсэн хуулиар баталгаажуулсан байна.

АНХАН БОЛОН ДАХИН САНАЛ ХУРААЛТ

Дахин санал хураалтыг улсуудын сонгуулийн эрх зүйд "Two-round system" буюу "Хоёр тойргийн тогтолцоо" гэсэн нийтлэг нэр томьёогоор илэрхийлдэг. Түүнчлэн,

---

133 Б.Чимид, *Үндсэн хуулийн мэдлэг,* (Уб, 2008), 260 дахь тал.

134 Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Төрийн мэдээлэл эмхэтгэл №1, (1992).

135 Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №4, (2016),

136 П.Очирбат, *Монгол Улсын Үндсэн хууль /хэрэгжилт, хяналт, судалгаа/,* (Уб, 2017), 186 дахь тал.

137 Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2000), 162 дахь тал.

хоёрдугаар санал хураалт (англ. second ballot), сүүлийн шатны санал хураалт (англ. runoff voting), хоёр дахь санал хураалт (англ. ballotage) зэрэг нэр томьёогоор зарим улсад хэрэглэх нь бий.

Дахин санал хураалт буюу "Хоёр тойргийн тогтолцоо"-г Ерөнхийлөгч, Парламент, орон нутгийн сонгуулийн аль алинд нь хэрэглэдгээрээ Франц Улс энэхүү ойлголтын гол төлөөлөл болдог ба дэлхий даяар 40 гаруй улс Ерөнхийлөгчөө сонгохдоо тус аргыг хэрэглэж байна.[138]

Сонгуулийн эрх зүйд санал хураалт явуулах хэд хэдэн арга байдгаас "дахин санал хураалт" нь нэр дэвшигчдээс гагцхүү нэг нь сонгогдох зорилго бүхий санал хураах арга хэлбэр юм. Үүний дагуу эхний санал хураалтад нэр дэвшигчдийн аль нь ч олонхийн санал авч чадаагүй бол хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг тодруулж, хоёр дахь санал хураалтыг явуулдаг.[139]

Хэдийгээр хоёр дахь санал хураалтаас цааш гурав дахь санал хураалт гэж байхгүй, дээр дурдсан хоёр хувилбар үлдэх боловч дэлхийн улсууд "хоёр-тойргийн тогтолцоо"-г өөр өөрсдийн арга хэлбэр, журмаар зохицуулж байгаа буюу хоёр дахь санал хураалтад хоёроос илүү нэр дэвшигч оролцохыг зөвшөөрдөг улс ч байна. Энэ хувилбарын дагуу хоёр дахь санал хураалтаар сонгогдоход бусдаасаа саналын тоогоор илүүрхэж байхад хангалттай ажээ. Тухайлбал, Чех болон Кени Улсад энэ аргаар хоёр дахь санал хураалтыг явуулдаг.[140] Мөн зарим цөөн тохиолдолд, тухайлбал, Гана Улсад хоёр дахь санал хураалтад хэн нь ч олонхийн санал авч чадаагүй бол гурав дахь санал хураалтыг явуулдаг байна. Гэвч ихэнх улсад эхний санал хураалтаар хамгийн олон санал авсан хоёр нэр дэвшигчийг дахин санал хураалтад оруулах хувилбар зонхилж байна.

Түүх сөхвөл, анх Германы Эзэнт гүрний үед буюу 1871-1918 оны хоорондо Райхстаг (тухайн үеийн Германы хууль тогтоох байгууллага)-ийн сонгууль болон 1908-1911 оны Шинэ Зеландын сонгууль хоёр удаагийн санал хураалттай болж байжээ. Түүнчлэн, 1925, 1932 онуудад Ваймарын Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч "хоёр-тойргийн тогтолцоо"-гоор сонгогдсон бөгөөд сонирхолтой нь, эхний санал хураалтад оролцоогүй нэр дэвшигч хоёр дахь санал хураалтад оролцож болох ба сонгогдохын тулд заавал олонхийн санал авсан байхыг шаардаагүй байна.[141]

"Хоёр-тойргийн тогтолцоо" буюу дахин санал хураалтыг ойлгомжтой, хөгжилтэй байдлаар (тухайлбал, нэр дэвшигчдийг жимс, ногоогоор төлөөлүүлэн тайлбарласан жишээ байна) тайлбарласан жишээ цахим орчинд байршсан сонгуулийн эрх зүйн гарын авлагуудад олон байгаагаас энд дурдвал:

Жишээ 1: АНУ-ын Теннесси мужийн нийслэл хотыг сонгох санал хураалт[142]

АНУ-ын Теннесси муж нийслэл хотоо сонгох гэж байна гэж үзье. Тус мужийн хүн ам 4 томоохон хотдоо төвлөрөн суурьшдаг. Бүх сонгогчид эдгээр хотод амьдардаг гэж үзвэл нийслэлээ аль болох өөрийн амьдардаг хотод ойрыг сонгохыг эрмэлзэнэ.

Нийслэл хотод нэр дэвшигчид нь:

Мемфис, мужийн хамгийн том хот боловч бусад хотуудаасаа хол зайтай

Нэшвилл

Ноксвилл

138 Electoral Reform Society "Two-Round System", https://www.electoral-reform.org.uk/voting-systems/types-of-voting-system/two-round-system/ (сүүлд үзсэн: 2019.05.01)

139 Eric Pacuit, "Voting Methods", *The Stanford Encyclopedia of Philosophy* (Fall 2017 Edition), Edward N. Zalta (ed.), https://plato.stanford.edu/archives/fall2017/entries/voting-methods/

140 Electoral Reform Society "Two-Round System", https://www.electoral-reform.org.uk/voting-systems/types-of-voting-system/two-round-system/ (сүүлд үзсэн: 2019.05.01)

141 Dieter Nohlen, Philip Stöver, *Elections in Europe: A Data Handbook,* (Baden-Baden: Nomos, 2010), p.762.

142 *Tenn Voting Example* /Тус жишээ нь бодит бус, зохиомол жишээ болно./

Чаттануга

Эхний санал хураалт /Round 1/:

Мемфис: 42%

Нэшвилл: 26%

Ноксвилл: 17%

Чаттануга: 15%

Хоёр дахь санал хураалт /Round 2/:

Эхний санал хураалтаар аль нь ч олонхийн буюу 50%-иас дээш санал аваагүй тул хамгийн олон санал авсан Мемфис, Нэшвилл хотуудыг хоёр дахь санал хураалтад оруулахаар боллоо. Энэхүү санал хураалтад эхний санал хураалтаар Мемфис болон Нэшвилл хотод саналаа өгсөн сонгогчдын санал хэвээр бөгөөд хасагдсан хоёр хотын сонгогчид саналаа хуваах шаардлагатай. Ийнхүү санал хураалтын үр дүн дараах байдлаар гарав:

Нэшвилл: 58%

Мемфис: 42%

Үр дүнгээс үзвэл, хоёр дахь санал хураалтаар Нэшвилл хот олонхийн санал авч ялагч болсон байна. Гэтэл эхний санал хураалтад Нэшвилл ердөө 26%-ийн санал авсан билээ. Учир нь Мемфис хот хэдийгээр эхний тойрогтоо давуу санал авсан ч бусад хотуудаасаа хамгийн хол зайтай нь юм. Үүнээс дүгнэвэл, эхний санал хураалтад давуу байсан нь дараагийн санал хураалтад мөн ялна гэсэн үг биш бөгөөд саналын тоо хоёр дахь санал хураалтаар яаж ч өөрчлөгдөх боломжтой.

Жишээ 2: Франц Улсын Ерөнхийлөгчийн сонгууль – 2002[143]

Эхний санал хураалт /Round 1/:

Эхний жишээнээс ялгаатай нь энэ бол бодит тохиолдол юм. 2002 оны Франц Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр хэвлэл, мэдээллийн хэрэгслүүд Францын гол хоёр намаас нэр дэвшигчид болох Жак Ширак, Лионель Жоспен нарыг ялах өндөр магадлалтай гэж байв. Гэсэн хэдий ч саналын хуудас дээр нийт 16 нэр дэвшигчийн нэр байсан бөгөөд эхний санал хураалтад хамгийн олон санал авсан гурван нэр дэвшигч нь:

Жак Ширак: (Баруун төвийн нам) 19.88%

Жан-Мари Ле Пен: (Хэт барууны нам) 16.86%

Лионель Жоспен: (Зүүн төвийн нам) 16.18% нар байлаа.

Хоёр дахь санал хураалт /Round 2/:

Ийнхүү хэн нь ч эхний санал хураалтад олонхийн саналыг авч чадаагүй тул хоёр дахь санал хураалтыг явуулсан бөгөөд хоёр дахь санал хураалтад оролцоогүй намын дэмжигчид Ле Пенээс илүү Ширакад саналаа өгснөөр Ширак маш давуу ялалт байгуулсан байна.

Жак Ширак: 82.21%

Жан-Мари Ле Пен: 17.79%

Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль хоёр шаттай явагддагийн хувьд “дахин санал хураалт” нь гагцхүү эхний шатанд хамаарах ойлголт билээ. Тодруулбал, Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд нэр дэвшигчдийн хэн нь ч сонгогчдын олонхийн санал аваагүй бол анхны санал хураалтад оролцсон нийт сонгогчийн хамгийн олон санал авсан хоёр хүнийг дахин санал хураалтад оруулах тухай болно. Хуулийн зохицуулалтаас үзвэл, хоёр дахь санал хураалт нь анхан шатны сонгуулийн сүүлийн үе шат бөгөөд гурав дахь санал хураалт гэж байхгүй, энэ үе шатын дараа (1) нийт сонгогчийн олонхийн санал авсан хүнийг Ерөнхийлөгчөөр

[143] Raymond Kuhn “The French presidential and parliamentary elections”, *Representation* Vol. 39, (2002), p.46, https://www.tandfonline.com/doi/abs/10.1080/00344890208523213?journalCode=rrep20

сонгогдсон гэж үзэж УИХ-аас бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, (2) хэн нь ч олонхийн санал аваагүй бол дахин сонгууль явуулах гэсэн хоёр хувилбар байна. Энэ утгаар Монгол Улсын зохицуулалт нь "дахин санал хураалт"-ын талаарх сонгуулийн эрх зүйн нийтлэг зарчим, утгад нийцэж байна гэж үзэх үндэслэлтэй.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Анхан болон дахин санал хураалт" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь" номонд: "Санал хураалт – (санал хураах явц, санал хураах үйлийн нэр)"[144], академич Ж.Амарсанаа нарын "Эрх зүйн мэдлэгийн товч толь" номонд: "Санал хураалт – Улс орны дотоод амьдралын, тухайлбал хуулийн төслийн зэрэг асуудлаар ард нийтээс санал авах ажиллагааг санал хураалт гэнэ. Олон улсын харилцааны хүрээнд санал асуултаар аливаа нэг нутаг дэвсгэрийн улсын харьяаллын талаар ард түмний хүсэл зоригийг тодорхойлдог. Иймд санал хураалт нь ард түмэн үндэстний хүсэл зоригийг илэрхийлэх нэг хэлбэр юм[145], академич С.Нарангэрэлийн "Эрх зүйн эх толь бичиг" номонд: "Санал хураалт – (англ. voting; poll; ор. голосование) – сонгууль ард нийтийн санал асуулгаар хамтын шийдвэр гаргах ба парламентад шийдвэр гаргах арга."[146] хэмээн тус тус тайлбарласан байна.

Дүгнэвэл, санал хураалт явуулах олон арга хэлбэр байдгийн нэг нь "хоёр-тойргийн тогтолцоо" буюу хоёр дахь санал хураалт явуулах бөгөөд энэхүү хоёр дахь санал хураалт явуулахыг Гиббард-Саттертвэйтийн теором (англ. Gibbard–Satterthwaite theorem)-ийн дагуу санал хураах тактик хийгээд нэр дэвших стратеги гэж үздэг.[147] Учир нь олон нэр дэвшигчийг оролцуулж, "санал хуваах" замаар сонгуулийн үр дүнд нөлөөлдөг байна.[148] Дээр дурдсанчлан Франц Улсын Ерөнхийлөгчийн сонгууль нь энэхүү санал хураах аргын хамгийн түгээмэл жишээ юм. Харин Монгол Улсын тухайд Үндсэн хуулийн Гучин нэгдүгээр зүйлийн 5 болон 6 дахь хэсэгт зааснаас үзвэл тус ойлголтыг "дахин санал хураалт", "хоёр дахь санал хураалт" гэсэн хоёр төрлийн нэр томьёогоор илэрхийлжээ. Харин СтХ-ийн 105 дугаар зүйлд "Ерөнхийлөгчийн сонгуульд хоёр дахь санал хураалт явуулах" хэмээн "хоёр дахь санал хураалт" гэсэн томьёоллоор хуульчилсан байна. Хэдийгээр эдгээр нь хоёрдмол утга агуулахгүй, нэг утгыг илэрхийлж буй боловч нэр томьёоны ялимгүй ялгааг нэг мөр болгох шаардлагатай байж мэдэх юм.

ТАНГАРАГ ӨРГӨХ

Тангараг хэмээх үг нь латин хэлний "juro" хэмээх үгнээс үүдэлтэй[149] бөгөөд англи хэлний "*oath*" орос хэлний "присяга" хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд ямар нэгэн үүргийг сахин биелүүлэхээ албан ёсоор ба ёслол төгөлдөр амлах (тангараглах)[150] гэсэн утгатай.

Тангараг өргөх өдөр нь улс төрийн албан тушаалтнуудаас ихэвчлэн Ерөнхийлөгчид хамаарах ойлголт ба хэдий ёслол, бэлгэдлийн шинжтэй боловч ач холбогдолтой үйл ажиллагаа юм. Энэ хэсэгт Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслол, өргөх тангарагтай холбоотой улсуудын Үндсэн хуулийн зохицуулалтыг судалж, тогтолцоо бүрээр төлөөлөл болгон авч үзье.

Жишээ 1 (Парламентын бүгд найрамдах засаглал): Бүгд Найрамдах Исланд

[144] Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (Уб, 1966 он), 468 дахь тал.

[145] Ж.Амарсанаа, Эрх зүйн мэдлэгийн товч толь, (Уб, 1986), 118 дахь тал.

[146] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (дөрөв дэх хэвлэлт), (Уб, 2015), 363 дахь тал.

[147] Allan Gibbard "Manipulation of voting schemes: A general result", *Econometrica* 41 (4): p.587–601 https://www.jstor.org/stable/1914083

[148] Мөн тэнд.

[149] Латин-Англи толь бичиг, https://latin-dictionary.net/search/english/oath

[150] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб,2007) 407 дахь тал.

Улсын Үндсэн хуулийн 80 дугаар зүйлд[151] "Исландын Ерөнхийлөгч нь албан тушаалаа хүлээн авахдаа Үндсэн хуулийн өмнө гарын үсэг зурж, тангараг өргөнө";

Жишээ 2 (Парламентын бүгд найрамдах засаглал): Унгар Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан эсхүл бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бол сонгуулийн дүнг зарласнаас хойш найм дахь өдөр ажлаа хүлээн авна; Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон хүн ажлаа хүлээн авахдаа Үндэсний Ассамблейн өмнө тангараг өргөнө";

Жишээ 3 (Парламентын бүгд найрамдах засаглал): Пакистан Улсын Үндсэн хуулийн 42 дугаар зүйлд[152] "Бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө Ерөнхийлөгч нь гурав дахь хуваариар тогтоосон журмын дагуу Пакистан Улсын Хууль зүйн Сайдын өмнө тангараг өргөнө";

Жишээ 4 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Португал Улсын Үндсэн хуулийн 127 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхийлөгч нь Бүгд Найрамдах Улсын Ассамблейн өмнө ажлаа хүлээж авна, 2 дахь хэсэгт "Тангараг өргөх өдөр нь өмнөх Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хугацаа дууссан эсхүл бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бөгөөд сонгуулийн дүн нийтлэгдсэнээс хойш найм дахь өдөр байна.", 3 дахь хэсэгт "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч ажлаа хүлээн авахдаа дараах тангараг өргөнө: "Надад олгогдсон үүргийг шударгаар биелүүлж, Бүгд Найрамдах Португал Улсын Үндсэн хуулийг хамгаалж, чанд сахин мөрдөхөө хүндэтгэлтэйгээр тангараглая";

Жишээ 5 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Румын Улсын Үндсэн хуулийн 82 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт[153] "Хүчин төгөлдөр сонгуулиар сонгогдсон нэр дэвшигч нь Сенат болон Төлөөлөгчдийн Танхимын өмнө хамтад нь дараах тангараг өргөнө: Бүх хүчин чадал, чармайлтаа Румын Улсын ард түмний биеийн болон оюуны сайн сайхны төлөө зориулж, улсын Үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэн ардчилал, иргэдийн үндсэн эрх, эрх чөлөө, Румын Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, эв нэгдэл, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг батлан хамгаалахаа чин сэтгэлээсээ тангараглая. Үүний тулд Бурхан надад туслаг!";

Жишээ 6 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): АНУ-ын Үндсэн хуулийн II зүйлийн 1 дэх хэсэгт "Ерөнхийлөгч нь бүрэн эрхээ хэрэгжүүлж эхлэхээс өмнө дараах тангараг буюу баталгааг үйлдэнэ: "Нэгдсэн Улсын Ерөнхийлөгчийн чиг үүргийг шударгаар биелүүлж, бүх чадлаараа Нэгдсэн Улсын Үндсэн хуулийг чандлан сахиж, батлан хамгаалахаа чин сэтгэлээсээ тангараглая";

Жишээ 7 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Мексикийн Нэгдсэн Улсын Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд[154] "Ерөнхийлөгч албан үүргээ хүлээж авахдаа Конгрессын өмнө эсхүл Конгрессын чөлөө цагт Түр хорооны өмнө дараах тангарагийг өргөнө: "Миний бие Мексикийн Нэгдсэн Улсын Үндсэн хууль болон түүнээс үүдэн гарсан бусад хуулийг чанд сахиж, ард түмнээс надад өгсөн Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгчийн үүргийг үнэнч, эх орончоор биелүүлж, тэдний сайн сайхан, улсынхаа хөгжил цэцэглэлтийн төлөө ажиллахаа тангараглая; хэрэв энэхүү үүргээ биелүүлж чадахгүй аваас Үндэстэн намайг хүчлэн шаардах болтугай.", Ерөнхийлөгч тангарагийг дээр заасан журмаар өргөх боломжгүй аливаа тохиолдолд нэн даруй Нэгдсэн Конгрессын Танхимын зөвлөлийн гишүүдийн өмнө тангараг өргөнө" гэжээ.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Тангараг өргөх" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин хоёрдугаар зүйлийн 1 дэх

[151] Исланд Улсын Үндсэн хууль, (2011), https://constituteproject.org/constitution/Iceland_2011D?lang=en

[152] Пакистан Улсын Үндсэн хууль, (1973), https://constituteproject.org/constitution/Pakistan_2017?lang=en

[153] Румын Улсын Үндсэн хууль, (1991), https://constituteproject.org/constitution/Romania_2003?lang=en

[154] Мексик Улсын Үндсэн хууль, (1917), https://constituteproject.org/constitution/Mexico_2015?lang=en

хэсэгт: “Ерөнхийлөгчийн бүрэн эрх тангараг өргөснөөр эхэлж, шинэ сонгогдсон Ерөнхийлөгч тангараг өргөснөөр дуусгавар болно” хэмээн заасан бол Я.Цэвэлийн “Монгол хэлний товч тайлбар толь” номонд: “Тангараг - ам алдах, тангараг тавих”, академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номонд: “Тангараг –(англ. *oath*; ор. присяга) ямар нэгэн үүргийг сахин биелүүлэхээ албан ёсоор ба ёслол төгөлдөр амлах (тангараглах). Т.-ыг улс орны ерөнхийлөгч албан тушаалд орохдоо өргөдөг. МУ-д үзэгч, цагдаагийн албан хаагч зэрэг төрийн нэлээд хэд хэдэн албан тушаалтан тангараг өргөх тухай заажээ.”[155], Г.Совд нарын “Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар” номонд: “Санал хураалтад оролцсон сонгогчдын олонхийн санал авч сонгогдсон Ерөнхийлөгчийн сонгуулийн дүнг албан ёсоор нийтэд зарласан өдрөөс хойш гуч хоногийн дотор УИХ-ын чуулганаар хэлэлцэж, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргадаг. Ийнхүү Ерөнхийлөгч энэ чуулган дээр тангараг өргөж сэнтийдээ залран бүрэн эрхээ хэрэгжүүлж эхэлдэг. Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын журмыг УИХ тогтоодог. Ерөнхийлөгчийн тангараг нь хуульд бичигдсэн хэлбэрийн хувьд товч боловч агуулгын хувьд Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх, үүрэг, хариуцлагыг бүгдийг багтаасан гүнзгий агуулгатай, ямар ч тайлбар, шалтгаангүй хэрэгжүүлэх ёстой Үндсэн хуулийн хэм хэмжээ юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрхэмлэн хамгаалах эрдэнэ нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхэт байдал, ард түмний эрх чөлөө, дээдлэн сахих шүтээн нь Монгол Улсын Үндсэн хууль, шударгаар сахин биелүүлж байх хууль зүйн болон ёс зүйн дээд зарчим нь Ерөнхийлөгчийн үүрэг байх юм. Хэрвээ Ерөнхийлөгч энэ тангарагийнхаа аль нэг зүйлийг санаатай болон болгоомжгүйн аль нэг хэлбэрээр өчүүхэн төдий зөрчвөл хүлээх хууль зүйн хариуцлага нь Ерөнхийлөгчийг албан тушаалаас огцруулах үүргийн санкцтай. Тангараг гэгчийн хатуу сахилга, хууль цаазын хүчин чадал энэ болой.[156]

Харин Б.Чимид агсан бичихдээ тангараг өргөнө гэдэг бол “эцсийн өндөр хариуцлагыг нийт ард түмнийхээ өмнө хүлээж буйн дээд илрэл юм. Тангарагаасаа няцвал Ерөнхийлөгчийг огцруулах Үндсэн хуулийн анхдагч үндэслэл болдогийн учир энд буй.” хэмээжээ.

Дүгнэвэл, Ерөнхийлөгчид гүйцэтгэх эрх мэдэл хадгалагддаггүй буюу парламентын бүгд найрамдах засаглалтай улсын Үндсэн хуульд Ерөнхийлөгчийн тангарагийн талаар товч дурдсан байхад эсрэгээрээ Ерөнхийлөгчийн болон Хагас-Ерөнхийлөгчийн засаглалтай улсад тангарагийн талаар нэлээд дэлгэрэнгүй хуульчилсан байна. Өөрөөр хэлбэл, засаглалын хэлбэр, тогтолцоо буюу Ерөнхийлөгчийн гүйцэтгэх үүрэг, эрх хэмжээнээс хамааран тангараг өргөх өдөр мөн Ерөнхийлөгчийн тангараг өргөхдөө хэлэх үгийн талаарх зохицуулалт ялгаатай байна. Ингэхдээ тухайн улсын үнэт зүйлээс хамааруулан үг хэллэг (шашны холбогдолтой зэрэг үгс) мөн өөр байна.

ЗАРЛИГ

Зарлиг гэдэг нь Түрэг хэлний “Jrlg ~ yarlig”[157] хэмээх үгнээс үүдэн Монгол Улсад хэрэглэгдэж ирсэн бөгөөд англи хэлний “decree” орос хэлний “указ”[158] гэсэн үгтэй дүйцүүлэн хэрэглэдэг. Уг нэр томьёог түүхийн үүднээс янз бүрээр тайлбарлаж ирсэн.

Монгол Улсын Үндсэн хуульд уг нэр томьёо нь 13-н удаа давтагдсан байх бөгөөд Ерөнхийлөгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд гаргадаг эрх зүйн актыг зарлиг[159] гэдэг агуулгаар тусгасан байна. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Ерөнхийлөгч

[155] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб, 2007), 407 дахь тал.

[156] Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2000), 162-164 дахь тал

[157] Ж.Амарсанаа, Монгол улсын Үндсэн хуульд орсон харь үг, (Уб,2013), 8 дахь тал.

[158] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб, 2007), 202 дахь тал.

[159] Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб,2000), 180 дахь тал.

нь бүрэн эрхэд хамаарах асуудлаар гаргадаг шийдвэрийг албажуулан баталсан эрх зүйн акт нь зарлиг ба захирамжийн хэлбэртэй байна. Захирамж нь тодорхой асуудлын талаар гаргасан шийдвэр байдаг бол Зарлиг нь хэм хэмжээ тогтоосон байдгаараа зориулалт, үйлчилэх цар хүрээ, эрх зүйн үр дагавраараа ялгаатай.[160]

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг (англ. decrees of the president of Mongolia; ор. Указ президента Монголия)- Ерөнхийлөгчөөс бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль, бусад хуулиудад нийцүүлэн гаргасан эрх зүйн акт. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг нь дараах нэн чухал шинжтэй[161] гэж зарим эрдэмтэн үзсэн байна. Үүнд:

- Эрх зүйн актын тогтолцоонд Үндсэн хууль, хууль, УИХ-н бусад шийдвэр, Засгийн газрын тогтоолын дараах байр суурийг эзэлнэ:
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх ба чиг үүргийн эрх хэмжээнд багтах нийгмийн харилцааг зохицуулна
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийг Монгол Улсын нутаг дэвсгэрт бүх нийтээр дагаж мөрдөнө:
- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцсэн байна.

Ерөнхийлөгч өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгсөн зарлиг гаргах бүрэн эрхтэй боловч энэ нь Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог. Харин Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлд зааснаар, Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээний бусад асуудлаар гаргасан зарлиг нь давхар баталгаажуулалт шаардахгүй.

Зарлиг нь хууль зүйн хүчин чадлаараа ялгагдана. Хэм хэмжээний тогтоосон зарлиг нь эрх зүйн хэм хэмжээг агуулсан бөгөөд дахин давтан хэрэглэгдэх үйлчилгээтэй байдаг. Жишээ нь, онц байдал зарласан, бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарласан зэрэг зарлигууд нь тодорхой нөхцөл байдалтай холбоотой асуудлуудыг зохицуулдаг бөгөөд тэр нөхцөл байдал арилаагүй цагт дахин давтагдан хэрэглэгдэж үйлчилдэг юм.[162] Хэм хэмжээний бус зарлиг нь эрх зүйн хэм хэмжээг хэрэглэх акт юм.[163] Жишээ нь Улсын Ерөнхий шүүгчийг буюу Ерөнхий прокурорыг томилох, иргэнийг одон медалиар шагнах, цол хүртээх ялтан этгээдэд уучлал үзүүлэх гэх мэт зарлигууд багтдаг.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Зарлиг" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: "Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд хуульд нийцүүлэн зарлиг гаргана." хэмээн заасан бол Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь" номонд: "Улсын дээд бүрэн эрхийг барих газраас гаргасан хуулийн чанартай шийдвэр, их хурлын тэргүүлэгчдийн зарлиг, хааны хэлсэн зарласан үг ба бичиг хааны зарлиг эзний зарлиг, хүндэтгэвэл зохих хүний хэлсэн үг багшийн зарлиг ноёны зарлиг ламын зарлиг;"[164], академич Ж.Амарсанаагийн "Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг" номонд: "хааны тунхаг; улсын эрх барих газар, албан тушаалтнаас гаргасан шийдвэр; хааны хэлсэн, зарласан үг болон бичиг;"[165] гэсэн бол академич С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" номондоо "Монгол улс болон хэд хэдэн улсад төрийн тэргүүний (ерөнхийлөгчийн) гаргадаг нэлээд чухал эрх зүйн актын нэр. Зарлигаар дээд албан тушаалтныг томилох ба албан тушаалаас чөлөөлөх, одон, медалиар шагнах,

[160] ХБНГУ-н Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2009), 171 дахь тал.

[161] Ш.Цогтоо, Ерөнхийлөгчийн институт ба Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, *Эрх зүй сэтгүүл*, №2, (2014), 67 дахь тал.

[162] Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2000), 180 дахь тал.

[163] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб, 2007), 281 дахь тал.

[164] Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (Уб, 1966), 268 дахь тал.

[165] Ж.Амарсанаа, Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг, (Уб, 2013), 8 дахь тал.

цэргийн дээд цол ба хүндэт цол олгох зэрэг асуудлыг шийдвэрлэнэ. Нийтлэг журмын дагуу зарлиг нь тухайн улсын Үндсэн хууль ба бусад хуульд нийцсэн байх ёстой[166], О.Сүхбаатарын "Монгол хэлний харь үгийн толь" номонд: "1. Улсын эрх барих газраас хуулийн чанартай шийдвэр, 2. Хаан хүний хэлсэн үг, зарласан үг болон бичиг, 3. Хүндтэй хүний хэлсэн үг[167] хэмээн тус тус тодорхойлсон байна.

Дүгнэвэл, "Зарлиг" хэмээх үг нь эртнээс Монгол хэлний үгийн санд хэрэглэгдэж эхэлсэн бөгөөд одоо хүртэл зарлиг гаргах этгээд нь өөрчлөгдсөнөөс утгын хувьд гажаагүй байна.

ОГЦРУУЛАХ

Огцруулах хэмээх нэр томьёог англи хэлний "resignation"; "retirement" орос хэлний "отставка"[168] гэсэн нэр томьёотой утга дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд латин хэлний "renuntiatio"[169] үгнээс гаралтай. Нийтлэг утгаараа огцруулах хэмээх нэр томьёог албан тушаалтныг тодорхой эрхэлж буй албан тушаалаас нь хасах буюу халах гэж ойлгож болохоор байгаа бол төрийн өндөр албан тушаалтныг огцруулж хариуцлага хүлээлгэх асуудлыг импечментийн журмаар шийдвэрлэж улмаар сонгууль болон ард нийтийн санал асуулгыг хүчингүйд тооцох зэрэг үр дагаврыг бий болгодог байна.[170]

Иймд гадаадын зарим оронд Ерөнхийлөгчийг огцруулах буюу импечмент[171] хийх асуудлыг хэрхэн журмалсан талаар авч үзье.

Жишээ 1: АНУ-ын 1787 оны Үндсэн хуульд заасан импечментийн сонгодог загвар нь парламентын доод танхим ялгааг томьёолон дэвшүүлж, харин дээд танхим нь шүүхийн журмаар ялгааг хянан үзэж, шийдвэрээ гаргана.[172] Үндсэн хуулийн 2 дугаар зүйлийн 4 дүгээр хэсэгт зааснаар: "Ерөнхийлөгч эх орноосоо урвасан, хахууль болон ийм төрлийн гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчил гаргасны төлөө импечментээр албан тушаалаас нь огцруулж болно"[173] хэмээн заасан байдаг. Импечмент хийхийн тулд дараах үе шатыг дамжсан байх шаардлагатай. Үүнд:

Нэгдэх шат: АНУ-ын Конгрессийн төлөөлөгчдийн танхим Ерөнхийлөгчийн эсрэг мөрдөн шалгах тусгай (бие даасан) прокурор томилохыг хүснэ.

Хоёр дахь шат: АНУ-ын хууль зүйн сайдын хүсэлтээр гурван холбооны шүүгчдийн зөвлөл тусгай прокурорыг томилж, мөрдөн шалгах ажлын хүрээг тогтоож өгнө.

Гурав дахь шат: Тусгай прокурор нь өөрийн ажилтнуудыг бүрдүүлж, буруутгаж буй асуудлаар нарийн мөрдөн шалгалт хийж, хэргийн талаар цуглуулсан бүх нотлох баримтыг Төлөөлөгчдийн танхимд шилжүүлж өгнө.

Дөрөв дэх шат: Төлөөлөгчдийн танхим хэргийн талаар авсан нотлох баримтуудыг хэлэлцэж ердийн олонхоор Ерөнхийлөгчийг огцруулах тухай шийдвэр гаргана: хэрэв энэхүү хэргийн талаарх буруутгасан дүгнэлтийг танхим дэмжиж байгаа бол импечментийн тухай зүйл гэгчийг бэлдэнэ, түүнд Ерөнхийлөгчийг огцруулах үндэслэл бүрийг нарийн заадаг. Үүний дараа Синетад хэлэлцүүлэхээр импечментийг хүргүүлнэ.

Тав дахь шат: Сенатад буруутгалыг дэмжүүлэх үүднээс төлөөлөгчдийн танхим яллагчийг томилно.

---

166 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб, 2007), 202 дахь тал.

167 О.Сүхбаатар, Монгол хэлний харь үгийн толь, (Уб, 2018), 135 дахь тал.

168 Мөн тэнд, 332 дахь тал.

169 Латин хэлний толь бичиг, https://www.latin-dictionary.net/search/english/retirement

170 Ж.Амарсанаа нар, Хууль зүйн тайлбар толь, (Уб, 2003), 275 дахь тал.

171 Өндөр албан тушаалтныг огцруулах.

172 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб, 2007), 229 дахь тал.

173 АНУ-ын Үндсэн хууль, Хоёрдугаар зүйл, (1787).

Зургаа дахь шат: Сенатын Ерөнхийлөгч (өөрөөр хэлбэл, АНУ-ын ерөнхийлөгч буюу АНУ-ын түр ерөнхийлөгч) Дээд шүүхийн даргыг Импечментийн шүүхийн даргын хувьд нь тангараг өргүүлж, хурал даргалуулахаар урина. Импечментийн шүүхийн дарга юуны өмнө импечментийн тангарагтны шүүхийн хувьд нь АНУ-ын бүх Сенатын гишүүдээр тангараг өргүүлнэ: төлөөлөгчдийн танхимын нэрийн өмнөөс яллагчид Импечментийн шүүхийн өмнө импечменттэй холбогдсон зүйл ангиудыг ёс төдий тунхаглана.

Долоо дахь шат: Импечментээр ерөнхийлөгчийн эсрэг буруутгаж буй үндэслэл, түүнчлэн эдгээр асуудалд түүнээс хариу авах хугацааг тодорхойлон заасан шүүхийн мэдэгдлийг баталж Ерөнхийлөгчид илгээнэ. Шүүхийн мэдэгдлийг Сенатын түшмэл (гүйцэтгэгч) Цагаан ордонд ёс төдий гардуулна.

Найм дахь шат: Импечментийн шүүхээс ирүүлсэн Ерөнхийлөгчийн эсрэг дэвшүүлсэн бичгийг үндэслэн Ерөнхийлөгчөөс, түүний өмгөөлөгчид (өөрөөр хэлбэл, түүний өмгөөлөгчдийн команд) “Ерөнхийлөгч гэм буруугаа хүлээж байна”, эсхүл “Ерөнхийлөгч гэм буруугүй” гэсэн агуулгатай хариуг илгээнэ түүнчлэн яллагчид төлөөлөгчдийн танхимын нэрийн өмнөөс өөрсдийн буруутгаж буй үндэслэлийг Импечментийн шүүхэд явуулна.

Ес дэх шат: Хэргийг шүүхээр хэлэлцэхэд эхлээд яллагчид өөрсдийн үндэслэгээг дэвшүүлнэ: дараа нь өмгөөлөгчид буруугүй болох талаар өөрсдийн үндэслэлээ гаргаж тавина.

Арав дахь шат: Шүүхээр хэлэлцэх үед талуудаас гаргасан материалуудыг үнэлэх зорилгоор тангарагтны шүүгчид зөвлөлдөх тасалгаа руу явна (зөвлөлдөх танхимд түүний дараа өөрсдийн саналыг илэрхийлэхэд нь зориулж Сенатын гишүүн бүрт 15 минут өгнө), эцэст нь “гэм буруутай”, эсхүл “гэм буруугүйн” аль нэг хэлбэрээр шийдвэр гаргана. Ерөнхийлөгчийг гэм буруутайд тооцоход 67 санал шаардлагатай буюу оролцсон Сенатуудын 2/3-ийн санал хэрэгтэй

Арван нэг дэх шат: Тангарагтны шүүх бүрэн бүрэлдэхүүнээрээ гаргасан шийдвэрээ нээлттэй хуралдаан дээр зарлана.[174]

АНУ-ын түүхэнд 1868 онд Ерөнхийлөгч Andrew Johnson (АНУ-ын 17 дахь Ерөнхийлөгч) ба 1999 онд Ерөнхийлөгч William Seffevson Clinton (АНУ-ын 42 дахь ерөнхийлөгч) нарт тус тус импечмент хийж огцруулах асуудал хөндөгдөж байсан.[175]

Жишээ 2: 1993 оны ОХУ-ын Үндсэн хуулийн 92 дугаар зүйлийн 2-т эрүүл мэндийн шалтгааны улмаас болон импечментээр оргцруулж болох талаар тусгасан[176] бөгөөд ерөнхийлөгч огцорвол засаг захиргааны даргууд бүрэн эрхээ өөрийн санаачилгаар хүлээлгэн өгөх эсхүл ард түмний итгэлийг алдсанаас болж албан тушаалаасаа огцрох ба дахин энэ албан тушаалд сонгогдох эрхгүй болно.[177] ОХУ-ын импечмент нь дараах үе шаттай явагддаг. Үүнд:

Нэг дэх шат: Төрийн думын нийт гишүүдийн гурваны нэгийн санаачлагаар Ерөнхийлөгчийн эсрэг үүссэн үндэслэлүүдийг мөрдөн шалгах тусгай комисс байгуулдаг.

Хоёр дахь шат: Тусгай комисс Ерөнхийлөгчийн эсрэг дэвшүүлсэн үндэслэлүүдийг мөрдөн шалгаж, улмаар өөрийн дүгнэлтийг Төрийн думд өргөн барина.

Гурав дахь шат: Төрийн думын нийт депутатын гуравны хоёрын саналаар

[174] Кристофер Осаке, Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги бүдүүвч, (Уб, 2005), 107 дахь тал.

[175] Keith E.Whittington, Bill Clinton was no Andrew Johnson, Comparing two impeachments, *Journal of constitutional law*, Vol.2:2, p.424.

[176] ОХУ-ын Үндсэн хууль, 92 дугаар зүйл, (1993). https://www.constituteproject.org/constitution/Russia_2014?lang=en

[177] Т.Азжаргал, Үндсэн хуулийн дэг журам зөрчсөн үйлдэлд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах үндэслэл журам, *Хүний эрх онол арга зүйн сэтгүүл*, №2, (2015), 40 дахь тал.

эх орноосоо урвасан буюу бусад хүнд гэмт хэрэг үйлдсэний хувьд ОХУ-ын Ерөнхийлөгчийг буруутгасан үндэслэгээг дэвшүүлэн тавьж байгаа тухай шийдвэр гаргана.

Дөрөв дэх шат: Хэрэв Ерөнхийлөгчийн үйлдэлд гэмт хэргийн шинж байгаа бол ОХУ-ын Дээд шүүх баталгаажуулсан дүгнэлт гаргана.

Тав дахь шат: Ерөнхийлөгчийг буруутгасан үндэслэгээ нь тогтоосон журмыг зөрчөөгүй бол ОХУ-ын Үндсэн хуулийн Шүүх дүгнэлт гаргаж өгнө.

Зургаа дахь шат: Холбооны зөвлөл Импечментийн шүүхийн журмаар хэргийн талаар сонсож, нийт гишүүдийн гуравны хоёрын саналаар ОХУ-ын Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах эсэх тухай шийдвэр гаргана.[178]

Жишээ 3: Франц Улсын тухайд,

Нэг дэх шат: Францын Ерөнхийлөгчийг эх орноосоо урвасан гэж үзвэл, түүний эсрэг үндэслэлээ Үндэсний хурлын нийт гишүүдийн дунд илээр хураасан саналын олонхоор батална.

Хоёр дах шат: Сенат өөрийн гишүүдийн дийлэнх олонхийн ил санал хураалтаар Францын Ерөнхийлөгчийн эсрэг эх орноосоо урвасан хэмээн буруутгасан тухай шийдвэр гаргана. Францын Ерөнхийлөгчийг буруутгасан тухай Сенатын шийдвэр нь Үндэсний хурлын шийдвэртэй адил байна.

Гурав дахь шат: Үндэсний хурал болон Сенатын ижил тооны гишүүдээс бүрэлдсэн шүүн таслах Дээд танхим байгуулагддаг. Тэр нь өөрийн гишүүдээс даргыг сонгоно.

Дөрөв дэх шат: Шүүн таслах Дээд танхим нь Ерөнхийлөгчийн хэргийг дэвшүүлсэн үндэслэлээр хэлэлцэнэ.

Жишээ 4: Холбооны ерөнхийлөгч ХБНГУ-ын төлөөллийн байгууллагуудын өмнө улс төрийн хариуцлага хүлээхгүй бөгөөд өөрийн үйл ажиллагааныхаа талаар Бундестаг болон Холбооны хурлын өмнө тайлан тавихгүй.[179] Гэхдээ ХБНГУ-ын Үндсэн хуулийн 61 дүгээр зүйлийн 1 болон 2 дахь заалтад Бундестаг, эсхүл Бундесратаас Холбооны Ерөнхийлөгчийг энэхүү Үндсэн хууль, бусад Холбооны хууль тогтоомжийг санаатай зөрчсөн хэмээн Бундесратын гишүүдийн дөрөвний нэг санал өгсөн, эсхүл Бундестагийн гишүүдийн доод тал нь дөрөвний нэгийн саналаар эгүүлэн татахыг дэмжсэн тохиолдолд Холбооны Үндсэн хуулийн шүүхэд хандаж болох бөгөөд Холбооны Үндсэн хуулийн шүүхээс Холбооны Ерөнхийлөгчийг энэхүү Үндсэн хууль, бусад хууль тогтоомжоор санаатайгаар зөрчсөн гэм буруутайг нь тогтоосон бол түүнийг албан тушаалаас нь чөлөөлж болохоор тусгасан байна.[180] Хариуцлагад татсанаас хойш Холбооны Ерөнхийлөгч бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсныг түр захирамжаар тогтоож болно.

ХБНГУ-ын өнөөгийн улс төрийн механизмд Холбооны Ерөнхийлөгч үндсэндээ билэгдлийн чанартай үүрэг гүйцэтгэх бөгөөд гагцхүү хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн хооронд зөрчил үүссэн тохиолдолд засаглах бодит бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.[181]

Харин Монгол Улсын тухайд Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж

---

178 Кристофер Осаке, *Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги бүдүүвч*, (Уб, 2005), 111 дэх тал.

179 Ч.Энхбаатар, *Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын төрийн эрх зүй,* (Уб, 2009), 109 дэх тал.

180 Орч: Christian Tomuschat and David P.Currie, Donald P.Kommers in cooperation with the language service of the German Bundestag, Basic Law for the Federal Republic of Germany, art 61, https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf

181 Ч.Энхбаатар, *Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын төрийн эрх зүй,* (Уб, 2009), 111 дэх тал.

чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна."[182] хэмээн заасан байна. Төрийн тэргүүний хариуцлагын тухай энэхүү заалт нь өмнөх заалттай холбоотой бөгөөд Ерөнхийлөгчид бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох нэгэн үндэслэл буюу Ерөнхийлөгчийг албан тушаалаас нь огцруулах журмыг заасан юм.[183] Дээрх заалтаас үзвэл ерөнхийлөгчийг тангаргаасаа няцсан буюу Үндсэн хууль ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг хянаж дүгнэлт гаргуулахаар Үндсэн хуулийн цэцэд хандаж өргөдөл, мэдээллийг иргэд, хүсэлтийг УИХ, Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Улсын ерөнхий прокурор гаргах эрхтэй бөгөөд хүсэлтийг УИХ гаргахын тулд УИХ-ын нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй нь санал гаргасан нөхцөлд чуулганаараа хэлэлцээд чуулганд оролцсон нийт гишүүдийн ердийн олонхи нь Цэцээр хэлэлцүүлэхээр санал өгсөн бол цэцэд хандана. Улсын Дээд шүүх энэ асуудлыг тавихын тулд нийт гишүүдийн хурлаар хэлэлцэж олонхийн саналаар цэцэд хандана.[184] Улмаар иргэдээс ирүүлсэн өргөдөл, мэдээллийг Цэцийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Цэц өөрийн санаачилгаар шийдвэрлэх ёстой бол УИХ, Ерөнхий сайд, Улсын Дээд шүүх, Улсын Ерөнхий прокуророос ирүүлсэн хүсэлтийг хүлээн аваад шууд цэцийн хуралдаанд оруулан дүгнэлт гаргаж УИХ-д хуульд заасан журмын дагуу өгөх ёстой бөгөөд Цэцээс ерөнхийлөгчийг Үндсэн хууль зөрчсөн хэмээн үзсэн тохиолдолд УИХ-ын чуулганд оролцсон нийт гишүүн буюу доод тал нь 39-н гишүүний дийлэнх олонх дэмжсэн тохиолдолд огцорхоор зохицуулсан байна.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Огцруулах" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, бусад хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн тухай асуудлыг УИХ-ын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь албан ёсоор тавибал Үндсэн хуулийн гучин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу УИХ хэлэлцэж Ерөнхийлөгчийг огцруулах эсэхийг шийдвэрлэнэ." хэмээн заасан бол Я.Цэвэлийн "Монгол хэлний товч тайлбар толь" номонд "Эрхэлсэн албан тушаалаас хасагдан гарах: албан тушаалаас огцруулах, албанаас огцруулах"[185] гэсэн бол академич С.Нарангэрэлийн "Эрх зүйн эх толь бичиг" номонд "Монгол улсад өргөн утгаараа төрийн албанаас халагдах буюу төрийн албан тушаал эрхэлж байсан этгээд уг албан тушаалаа орхих. 2. Үндсэн хуулийн эрх зүйд засгийн газар түүний тэргүүн буюу сайдыг огцруулах. Өөрөөр хэлбэл, засгийн газарт итгэл хүлээлгэхгүй байгаагаа илэрхийлсэн буюу засгийн газар дахь дотоодын үл ойлголцох байдал, эрүүл мэндийн байдал, хуулиар тогтоосон насанд хүрсэн зэрэгтэй холбогдуулан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болох. Үндсэн хуулиар түүнчлэн төрийн тэргүүн болон бусад зарим албан тушаалтныг огцруулах асуудлыг зохицуулсан байдаг."[186] гэж тус тус тайлбарласан байна.

Дүгнэвэл, "Огцруулах" хэмээх нэр томьёо нь салаа утгагүй, нэг мөр ойлгогдох агуулгатай бөгөөд төрийн өндөр албан тушаалтанг огцруулах асуудал нь олон улсын жишигт өөр нэр томьёогоор хэрэглэгддэг болох нь харагдаж байна.

БҮРЭН ЭРХ

Бүрэн эрх буюу authority гэх нэр томьёо нь Латин хэлний "auctoritas" гэсэн үгнээс гаралтай бөгөөд дээрх нэр томьёог зарим судлаачид англи хэлний "sovereign" гэх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэх нь зөв гэдэг талаар байр сууриа илэрхийлсэн

[182] Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, (1992).

[183] ХБНГУ-н Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (*Уб, 2009*),* 172 дахь тал.

[184] Г.Совд нар, *Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар*, *(*Уб, 2000*),* 182 дахь тал.

[185] Я.Цэвэл, *Монгол хэлний товч тайлбар толь, (*Уб, 1966), 408 дахь тал.

[186] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб, 2007), 332 дахь тал.

байдаг[187].

Ерөнхийлөгчийн институтийн хувьд ямар бүрэн эрх эдэлж байгаагаасаа хамааран тухайн засаглалын хэлбэр нь хамаардаг бөгөөд улс орон болгон өөрийн онцлогоос хамааран ерөнхийлөгчийг ялгаатайгаар зохицуулан бүрэн эрхийг нь тодорхойлсон байна. Үндсэн хуульдаа төрийн тэргүүнээ тодорхойлсон ерөнхий зохицуулалтаас холбогдох хэсгийг түүвэрлэн авч үзвэл:

Жишээ 1 (Парламентын хаант засаглал): Испани Улсын Үндсэн хуулийн 56 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт[188] "Хаан нь төрийн тэргүүн, бат бөх байдал, эв нэгдлийн бэлгэ тэмдэг байна ...";

Жишээ 2 (Парламентын эзгүй хаант засаглал[189]): "Шинэ Зеландын Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд "Шинэ Зеландын эрх баригч нь төрийн тэргүүн бөгөөд хааны хэв маягтай байна";

Жишээ 3 (Парламентын гүйцэтгэх-бус хаант засаглал): Японы Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлд[190] "Эзэн хаан бол төрийн болон ард түмний эв нэгдлийн бэлгэ тэмдэг бөгөөд түүний байр суурь нь халдашгүй дархан байдлыг өөртөө хадгалах ард түмний хүслээс үүснэ.";

Жишээ 4 (Парламентын бүгд найрамдах засаглал): Итали Улсын Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд[191] "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд үндэсний эв нэгдлийг илэрхийлнэ";

Жишээ 5 (Парламентын бүгд найрамдах засаглал): Иракийн Үндсэн хуулийн 67 дугаар зүйлд[192] "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд улсын эв нэгдлийн бэлгэ тэмдэг байж улсын бүрэн эрхт байдлыг илэрхийлнэ ...";

Жишээ 6 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Португал Улсын Үндсэн хуулийн 120 дугаар зүйлд[193] "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь Португалийн Бүгд Найрамдах Улсыг төлөөлж, улсын эв нэгдэл, үндэсний тусгаар тогтнол, ардчилсан институцийн зүй ёсны үйл ажиллагааны баталгаа бөгөөд Зэвсэгт хүчний ерөнхий командлагч байна";

Жишээ 7 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Бүгд Найрамдах Солонгос Улсын Үндсэн хуулийн 66 дугаар зүйлийн (1) дэх хэсэгт [194] "Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн бөгөөд гадаад харилцаанд улсаа төлөөлнө", (2) дахь хэсэгт "Ерөнхийлөгч нь Улс болон Үндсэн хуулийн тасралтгүй, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн, халдашгүй байдлыг сахин хамгаалах үүрэгтэй";

Жишээ 8 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Литва Улсын Үндсэн хуулийн 77 дугаар зүйлд[195] "Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна. Тэрээр Литва Улсаа төлөөлж, Үндсэн хууль болон бусад хуулиар олгосон бүх үүргийг биелүүлнэ";

[187] Энэ талаар Д.Гангабаатар "Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал" номондоо Манайд "sovereignty"-г бүрэн эрхт байдал гэх тул "sovereign" гэдгийг бүрэн эрх гэж ойлгох ёстой боловч "бүрэн эрх" гэдэг хууль зүйн нэр томьёог манайд "authority" хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэж байна." хэмээжээ.

[188] Испани Улсын Үндсэн хууль, (1978), https://www.constituteproject.org/constitution/Spain_2011?lang=en

[189] Англ. Parliamentary absentee monarchy – Парламентын хаант засаглалтай, бүрэн эрхийг нь Үндсэн хуулиараа зохицуулсан боловч өөр улсын харьяанд байдаг тул дотооддоо хаан, хатан залдаггүй улсыг ийнхүү нэрлэдэг байна. Тухайлбал, Шинэ Зеланд Улс нь хаант засаглалтай боловч шууд удирддаг хаангүй, Их Британи Умард Ирландын Вант Улсын хатан хааны удирдлагад байдаг.

[190] Япон Улсын Үндсэн хууль, Орч. П.Амаржаргал (Уб, 2011), 10 дахь тал.

[191] Итали Улсын Үндсэн хууль, (1947), https://www.constituteproject.org/constitution/Italy_2012?lang=en

[192] Ирак Улсын Үндсэн хууль, (2005), https://www.constituteproject.org/constitution/Iraq_2005?lang=en

[193] Португал Улсын Үндсэн хууль, (1976), https://www.constituteproject.org/constitution/Portugal_2005?lang=en

[194] БНСУ-ын Үндсэн хууль, (1948), https://www.constituteproject.org/constitution/Republic_of_Korea_1987?lang=en

[195] Литва Улсын Үндсэн хууль, (1992), https://www.constituteproject.org/constitution/Lithuania_2006?lang=en

Жишээ 9 (Хагас-Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Оросын Холбооны Улсын Үндсэн хуулийн 80 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт[196] "Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нь төрийн тэргүүн байна", 2 дахь хэсэгт "Оросын Холбооны Улсын Ерөнхийлөгч нь Оросын Холбооны Улсын Үндсэн хууль, хүний болон иргэний эрх, эрх чөлөөний баталгааг хариуцагч байна ...";

Жишээ 10 (Ерөнхийлөгчийн бүгд найрамдах засаглал): Аргентин Улсын Үндсэн хуулийн 87 дугаар зүйлд[197] "Үндэсний гүйцэтгэх эрх мэдэл нь "Аргентин үндэстний Ерөнхийлөгч" хэмээх албан тушаалтай иргэнд хадгалагдана";

Жишээ 12 ХБНГУ-ын тухайд тус улсын Үндсэн хуульд Холбооны ерөнхийлөгчийн эрх хэмжээ нь үндсэндээ төлөөллийн болон зарим тохиолдолд гүйцэтгэх шинжтэй байдаг. Холбооны Ерөнхийлөгч дотоод бодлогын хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Холбооны хуулиудад гарын үсэг зурж, тэдгээрийг хэвлэн нийтлэх асуудлыг шийдвэрлэнэ.
- Парламентын баталсан хуулийг Тулгуур хууь зөрчсөн үндэслэлээр маргаан үүсгүүлэхээр холбооны Үндсэн хуулийн шүүхэд шилжүүлнэ.
- Бундестаг дахь улс төрийн хүчний харьцааг харгалзсаны үндсэн дээр холбооны Канцлерын албан тушаалд нэр дэвшигчийг санал болгоно
- Холбооны Канцлерын санал болгосны дагуу холбооны сайдуудыг томилно
- Хуульд өөрөөр заагаагүй бол холбооны Ерөнхийлөгч холбооны шүүгч, иргэний албан хаагч, офицер болон Зэвсэгт хүчний албан тушаалтныг томилох буюу чөлөөлөх эрхүүд эдэлдэг байна.

Монгол Улсын хувьд Ерөнхийлөгчийн бүрэн эрх гэдгийг төрийн тэргүүний хувьд ч, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд ч юу хийх үүрэгтэй, түүнийгээ биелүүлэхдээ ямар эрх боломж эдлэх ёстой вэ гэдэг утгаар авч үзэв.[198] Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг "үндсэн", "тодорхой" хэмээн ялган үзэх бөгөөд Үндсэн хуульд заасныг нь үндсэн, түүнийг ердийн хуулиар тодруулсан хийгээд нэмж олгосон эрх, үүргийг нь "тодорхой" гэнэ.[199]

Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрх нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 1-д заасан 12 заалт[200] бөгөөд эдгээрээс дийлэнх олонх буюу нийт 9 бүрэн эрх нь гүйцэтгэх засаглалын хүрээнд хэрэгжиж байна. Үлдсэн бүрэн эрх нь УИХ болон Шүүх эрх мэдэлтэй харилцахтай холбоотой эрх хэмжээ болж байна.[201] Харин тодорхой бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4-т зааснаар "Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгоно" гэсэн заалтаас үүдэн нийт 40 орчим[202] салбар хуульд ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрхийг хуульчилж өгсөн байна.

Ерөнхийлөгчийн эдлэх үндсэн бүрэн эрхийг:

- Бэлгэ тэмдгийн шинжтэй чиг үүрэг;
- Хууль тогтоомжтой холбогдох бүрэн эрх;
- Гадаад харилцаанд хамаарах бүрэн эрх;

[196] ОХУ-ын Үндсэн хууль, (1993), https://www.constituteproject.org/constitution/Russia_2014?lang=en

[197] Аргентин Улсын Үндсэн хууль, (1853), https://www.constituteproject.org/constitution/Argentina_1994?lang=en

[198] Б.Чимид, *Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал*, (Уб, 2008), 148 дахь тал.

[199] Мөн тэнд.

[200] Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, (1992)

[201] Я.Төгөлдөр, "Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн институтийн байр суурь эрх мэдлийн хэрэгжилтийн шинжилгээ", Монгол Улсын Төрийн байгуулал дахь засаглалын инстутын талаарх судалгаа *(судалгааны эмхэтгэл)*, (Уб, 2018), 39 дэх тал.

[202] Эдгээр тодорхой бүрэн эрхийн талаар тусгасан холбогдох хуулийн зохицуулалтыг хавсралт 4-өөс дэлгэрүүлэн үзнэ үү.

- Батлан хамгаалахтай холбоотой бүрэн эрх;
- Хууль тогтоогчийг тараах бүрэн эрх;
- Бусад бүрэн эрх[203] хэмээн тодорхойлж болно. Эдгээр бүрэн эрхийг тус бүрд нь авч үзвэл:

Бэлгэ тэмдгийн шинжтэй чиг үүрэг

Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Монгол Улсын Ерөнхийлөгч бол төрийн тэргүүн, Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгч мөн." гэсэн нь засаг төр, нийгмийн тогтолцоонд түүний эрх зүйн байдлыг илэрхийлсэн гол тодорхойлолт юм.[204] Ерөнхийлөгч Монголын ард түмний эв нэгдлийг илэрхийлэгчийн хувьд үндэсний эв нэгдлийн ашиг сонирхлыг бүхнээс дээгүүр тавьж, шаардлагатай үед нийгмийн бүлэг, хэсэг улс төрийн хүчнүүдийн хооронд зөвшилцөлд хүрэхэд нь дэмжлэг үзүүлнэ. Энэ ч үүднээс бэлгэ тэмдгийн төдий ухагдахуун биш засаглах эрх мэдлийн бүх салбаруудын тэнцвэрт харилцааг гагнан бэхжүүлж засаглах эрх мэдлийг бодитой биечлэн хэрэгжүүлэгч юм.[205] Ийнхүү ерөнхийлөгч нь төрийн тэргүүний хувьд төрийн бусад бэлгэ тэмдгээс ч илүү тухайн улсыг төлөөлж, улсын эв нэгдлийн бэлгэ тэмдэг болж байдаг.[206]

Хууль тогтоомжтой холбогдох бүрэн эрх

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1.1 дэх хэсэгт ерөнхийлөгч Улсын Их хурлаас баталсан хуульд бүхэлд нь буюу аль нэг бүлэг зүйл, хэсэгт нэг удаа хориг тавих эрхтэй бөгөөд хууль буюу шийдвэрт тавьсан хоригийг УИХ хүлээн авмагц хэлэлцэх асуудлын ээлж дугаар хүлээхгүй нэн даруй хэлэлцэж, хүлээн авах эсэхийг шийдвэрлэнэ.[207] УИХ-ын гишүүдийн олонх хоригийг хүлээн аваагүй тохиолдолд хууль батлагдан гардаг.

Гадаад харилцаанд хамаарах бүрэн эрх

Ерөнхийлөгч нь гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, УИХ-тай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах, Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газын тэргүүнийг УИХ-тай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах зэрэг, Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүний итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах бүрэн эрхтэй байдаг.[208]

Батлан хамгаалахтай холбоотой бүрэн эрх

Ерөнхийлөгч Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг тэргүүлдэг эрхтэйн хувьд нийгмийн болон улсын аюулгүй байдлыг хангах, хууль ёс, дэг журмыг бэхжүүлэх талаар хууль тогтоомжийн заалтын хүрээнд олон зүйл бүрэн эрхтэй.

Хууль тогтоогчийг тараах бүрэн эрх

Ерөнхийлөгч парламентыг бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж үзвэл УИХ-ын даргатай зөвшилцсөний үндсэн дээр тараах санал УИХ-д тавьж болно. Үндсэн хуульд "УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно". Ийнхүү тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл УИХ бүрэн эрхээ эдэлнэ" гэж заажээ. Мөн Монгол Улсын Ерөнхий сайдыг томилох саналыг УИХ-д өргөн мэдүүлснээс хойш дөчин тав хоногийн дотор УИХ хэлэлцэн шийдвэрлэж чадаагүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч УИХ-ыг тараах шийдвэр гаргах эрхтэй байгаа нь хууль тогтоогчид гүйцэтгэх засаглалаас тавих

[203] Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, (Уб, 2012), 174 дэх тал.

[204] Б.Чимид, Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, (Уб, 2008), 137 дахь тал.

[205] Г.Совд нар, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2000), 182 дахь тал.

[206] Д.Гангабаатар, Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал, (Уб, 2012), 175 дахь тал.

[207] Г.Совд нар, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2000), 168 дахь тал.

[208] Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №1, (1992).

томоохон хяналтын хэлбэр мөн.

Бусад бүрэн эрх

Мөн тодорхой салбарт гавьяа байгуулсан, амжилт бүтээлтэй ажилласан хүмүүсийг урамшуулан шагнах, цол, медалиар шагнах, улс, цэргийн дээд цол хүртээх эрхийг Ерөнхийлөгчид олгосон. Мөн уучлал үзүүлэх, Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох гэх мэт бүрэн эрхийг Үндсэн хуульд тусгасан байна.

Бүрэн эрх хэмээх ойлголтыг Б.Чимид "Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь" номондоо "Бүрэн эрх /полномочне-authority/ гэдгийг энгийн ухамсрын түвшинд "эрх" гэж /нэг л их эрхтэй юм шиг/ ойлгох нь байнга ажиглагдана. Гэтэл энэ бол уг эзнийхээ гүйцэтгэх үүрэг, түүнийг биелүүлэхдээ эдлэх эрх боломжийг агуулсан тусгай утга бүхий хууль зүйн нэр томъёо билээ."[209] хэмээн тодорхойлсон бол академич С.Нарангэрэл Эрх зүйн эх толь бичиг номондоо "Бүрэн эрх хэмээх үг нь нийтлэг байдлаар нэг этгээдийн (төлөөлүүлэгчийн) нэрийн өмнөөс төлөөлүүлэгчийн эрх ба үүргийг буй болгох, өөрчлөх буюу дуусгавар болгох хэлцэл хийх нөгөө этгээдийн (төлөөлөгчийн) эрх[210] хэмээн тус тус тайлбарласан байна.

Дээрхээс үзвэл бүрэн эрх хэмээх нэр томьёо нь үгийн хувьд нэгдсэн нэг ойлголттой байх бөгөөд харин улс орны засаглалын хэлбэр, эрх зүйн тогтолцооноос хамааараад агуулгын хүрээнд бүрэн эрх гэдэгт юуг хамааруулж үзэх нь өөр өөр байна.

ХОРИГ

Англи хэлний "veto" гэх үгийг монгол хэлний хориг хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг байна. Төрийн тэргүүнээс парламентын баталсан хуультай санал нэгдэхгүй байх эрх. Ардчилсан улс орнуудад ветог эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх тогтолцооны тэнцвэржүүлэгч нэн чухал элемент гэж үздэг болой.[211] гэсэн байх бөгөөд АНУ-ын "*Black's law dictionary*"[212] толь бичигт "би хориглож байна" гэсэн үгнээс гаралтай, засаглалын нэг салаа мөчир нь нөгөөгийнхөө үйл ажиллагааг хориглох эрх мэдэл юм. Үндсэн хуулийн эрх зүйд гүйцэтгэх засаглалын тэргүүн нь хууль тогтоогчийн баталсан хуульд гарын үсэг зурахаас татгалзах гэж хоригийг тодорхойлсон байна. Мөн "*Oxford dictionary of law*"[213] толь бичигт "1/Хориг тавих нь олон улсын эрх зүйд тодорхой саналыг аюулгүйн зөвлөлийн аль нэг гишүүн зөвшөөрөхөөс татгалзах эрх мэдлийг хэлнэ. 2/ Европын холбооноос ямар нэг шийдвэрийг санал нэгтэйгээр гаргах шаардлагатай хууль тогтоомжийг аль нэг гишүүн улс татгалзах эрх юм. Европын хорооноос санал болгосон хуулийг Европын парламент татгалзах эрх мэдлийг ойлгоно" гэжээ. Хоригийн институц нь эртний Ромд манай эриний өмнө VI зуунд Сенатад давамгайлах патрикануудаас блебуудын ашиг сонирхлыг хамгаалах боломжийг трибунд олгох зорилгоор хэрэглэгддэг байсан "intercessio" хэмээх тогтолцооноос үүсэлтэй юм. Трибуны хориг нь Сенатаас хууль батлахыг болиулахгүй боловч хуулийн хүчин чадлыг сулруулдаг байжээ.[214]

Дэлхийн улс орнуудад Ерөнхийлөгчийн институт нь төрийн тэргүүний эсхүл гүйцэтгэх эрх мэдлийн аль нэгийг хэрэгжүүлдгээс шалтгаалан төрийн засаглалын хэлбэр тодорхойлогддог. Хориг нь Ерөнхийлөгчийн институцээр дамжин хэрэгждэг.

- *АНУ-ын* Ерөнхийлөгчийн эрх мэдэл нь хуулийн төсөл эсхүл тогтоолд хориг

[209] Б.Чимид, Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь (төслийн багийн судалгааны ажлын тайлан), (Уб, 2005), 22 дахь тал.

[210] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW Dictionary, (Уб, 2007), 94 дэх тал.

[211] С.Нарангэрэл. Хууль зүй судлалын Англи-Монгол тайлбар толь, (Уб, 2005), 516 дахь тал.

[212] Henry Campbell Black, *Black's law dictionary*, 4th edition (St.Paul, Minn: 1968, West publishing Co), p.1595.

[213] Oxford dictionary of law, 6th.ed.(2006) p.564

[214] П.Амаржаргал, Парламентын хууль тогтоох бүрэн эрх ба Ерөнхийлөгчийн хориг, *Хууль дээдлэх ёс,* №2, (2014), 63 дахь тал.

тавих болон хуулийг батламжлахаас татгалзах явдал юм. Ерөнхийлөгч арван өдөрт (ням гаригийг оруулахгүйгээр) Конгрессоос гаргасан хуулийн төсөлд гарын үсэг зурж батламжилна. Ерөнхийлөгч хориг тавьсан үед хууль санаачилсан танхимд хориг тавих үндэслэлийг тайлбарлан хууль тогтоомжоо буцаана. Энэ хоригийг зөвхөн танхим дахь Сенатын гуравны хоёрын саналаар өөрчилж болох юм. Хэрэв энэ тохиолдолд хуулийн төсөл нь Ерөнхийлөгчийн эсэргүүцлийг давж хууль болж гардаг байна. Конгресс арван өдрийн турш түр хугацаагаар хойшлуулснаар халаасны хориг тавьдаг. Ерөнхийлөгч Конгрессод хуулийн төслийг буцаахгүй. Ерөнхийлөгчийн гарын үсэг зурахгүй байх шийдвэр нь халаасны хориг байх тул үүнийг Конгресс давж заалдах боломжгүй байна.

Үндсэн хуульд Ерөнхийлөгч 10 хоногийн дотор Конгрессоор батламжлах арга хэмжээг авна. Ерөнхийлөгч 10 хоногийн дараа хуулийн төсөлд гарын үсэг зураагүй бол түүний гарын үсэггүй болж байх тул Конгресс 10 өдрийн туршид хойшлуулсан ч хуулийн төсөл хууль болдоггүй байна.[215] АНУ-ын Ерөнхийлөгчид 1789 оноос эхлэн хуулийн төсөлд хориг тавьсан байх бөгөөд Жорж Вашинктон 4 хуульд хориг тавьснаар эхэлж байсан бол хамгийн сүүлд Доналд Трамп 116 хуулийн төсөлд хориг тавьжээ.[216]

- *Их Британи* Улсад 1265 онд парламент бий болж түүний баталсан хууль тогтоомжийг хаан батламжилж гарын үсэг зурснаар сая хүчин төгөлдөр үйлчлэх болсон. Английн хатан хаан Анна 1708 онд хориг тавих эрхээ хэрэгжүүлснээс хойш 1999 оныг хүртэлх хугацаанд парламентийн үйл ажиллагаанд хориг тавих эрх хэрэгжээгүй байна.[217] Хатан хаан II Элизабета Их Британийн парламентийн баталсан "Их Британийн зэвсэгт хүчнийг Ираны эсрэг явуулах цэргийн ажиллагаанд АНУ-ын талд оролцуулах тухай" хуульд Засгийн газрын санал болгосноор хориг тавьсан байна.

- *Франц Улсын* Үндсэн хуульд ерөнхийлөгчийн зөвшөөрлөөр хууль тогтоомжийг нийтлэх бөгөөд Үндсэн хуульд зааснаар парламентаас батлан ирүүлсэн хууль тогтоомжийн төслийг төрийн тэргүүн хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор бүхэлд нь эсхүл тодорхой зүйл, заалтыг дахин хэлэлцүүлэхээр буцаах эрхтэй. Энэ хугацааг хэтрүүлсэн болон дахин хэлэлцээд ирүүлсэн төслийг ерөнхийлөгч татгалзах эрхгүй батламжлах ёстой ажээ.

- *Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын* Үндсэн хуульд[218] заасан журмын дагуу батлагдсан хууль тогтоомжийг баталгаажуулах, гарын үсэг зурагдсаны дараа Холбооны ерөнхийлөгч батламжилж, Холбооны хууль тогтоомжийн эмхэтгэлд нийтлэх тухай заасан. Харин хориг тавих тухай тусгайлсан заалт тусгаагүй байна.

- *Япон Улс* Үндсэн хуульдаа хааны эрхийг бүрэн хязгаарласан байх бөгөөд хориг тавих эрх мөн давхар хязгаарлагддаг байна.[219] Тус хуульд хориг тавих тухай тусгайлсан заалт тусгаагүй. Харин Төлөөлөгчийн танхим болон Зөвлөхүүдийн танхим хуулийн төслийг хэлэлцэн батлах бөгөөд төслийг нэг танхим 5 өдрийн дотор багтаан хэлэлцэж, нөгөө танхимдаа өгдөг. Ингэхдээ хоёр танхим голлох үүргийг гүйцэтгэдэг. Төлөөлөгчийн танхимын баталсан хууль тогтоомжийн төслийг зөвлөхүүдийн танхим батлахаас татгалзсан тохиолдолд төлөөлөгчийн танхим төслийг хоёр дахь удаагаа авч хэлэлцэн гишүүдийн гуравны хоёр нь хоригийг хүлээн авахаас татгалзаж төслийг урьдын хэвээр баталсан тохиолдолд төсөл хүчин төгөлдөр хууль болох эрхийн зохицуулалтыг тусгасан.

---

[215] Pocket veto https://www.senate.gov/reference/glossary_term/pocket_veto.htm (сүүлд үзсэн: 2019.05.13)

[216] Summary of Bills Vetoed, 1789-present https://www.senate.gov/reference/Legislation/Vetoes/vetoCounts.html (сүүлд үзсэн 2019.05.13)

[217] Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (Уб, 2018), 35 дахь тал

[218] Grundgesetz für die Bundesrepublik Deutschland https://www.gesetze-im- internet.de/gg/BJNR 000010949/.html (сүүлд үзсэн 2019.05.13)

[219] The Constitution of Japan https://japan.kantei.go.jp/constitution_and_government_of_japan/constitution_e.html (сүүлд үзсэн 2019.05.13)

Ерөнхийлөгч хэмээх нэр томьёо үүссэн цагаас “Ерөнхийлөгчийн хориг” хэмээх ойлголт бий болсон. Тухайлбал, Монгол Улсад төрийн эрх мэдлийг хуваарилах талаар 1921 оны дүрэмд дурдаж байсан бөгөөд 1988 оны МАХН-ын Төв хорооны V бүгд хуралд дэвшүүлж байсан нь 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр “БНМАУ-ын Төрийн дээд байгууллагын бүтцийн тухай тогтоол”-ыг батлан гаргасантай нийцүүлэн Үндсэн хууль дахь нэг намын дангаар ноёрхлыг бэхжүүлсэн заалтыг халж, улс төрийн олон ургалч ёс, иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийг АИХ-ын 11 дэх удаагийн сонгуулийн 9 дүгээр чуулганаар хэлэлцүүлснийг 1990 оны 5 дугаар сарын 12-ны өдөр “БНМАУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуулийг баталсан”[220]-аар Ерөнхийлөгчийн бүрэн эрх баталгаажин хэрэгжиж эхэлсэн байна. Энэ хуульд Ерөнхийлөгчийн хориг тавих, гарын үсэг зурж батламжлах тухай зааж өгсөн. Улмаар 1991 онд Ерөнхийлөгчийн тухай хуулийг батлан гаргаснаар Ерөнхийлөгчийн бүрэн баталгаажин АИХ, Бага хурлын шийдвэрт хориг тавих эрх хэмээн хуульчилсан. 1990-1992 онд Ерөнхийлөгч, УИХ, Засгийн газар нь 30 гаруй хуулийг батлан гаргаж, үндсэн хуулийн эрх зүйн урьдач нөхцөлийг бүрдүүлсэн. Ерөнхийлөгч энэ хугацаанд 7 удаа хориг тавьсан байна.

Ийнхүү 1991 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхэлсэн АИХ-ын 12 дахь удаагийн сонгуулийн 2 дугаар хуралдаан нийт 76 хоног хуралдаж, 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр МУ-ын шинэ Үндсэн хуулиа баталсан. Ийнхүү Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1-д “УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ” хэмээн хуульчилсан. УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь нь буюу хэсэгчлэн хориг тавих эрхтэй байхаар зохицуулсан хэдий ч Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд заасан “баталсан хуулийг гарын үсэг зурж батламжлах” эрхийг шинэ хуулиар Ерөнхийлөгчид олгоогүй байна.

1992 оны Үндсэн хуулийн Хавсралт хуульд Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг ...1993 онд багтаан батлан гаргах ажлын хүрээнд 1992 оны 4 дүгээр сарын 4-нд Монгол Улсын Их Хурлын тухай, 1993 оны 6 дугаар сарын 5-нд Ерөнхийлөгчийн тухай хуулийг батлан гаргасан. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 7-д “Хууль санаачлагчаас УИХ-д өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаар саналаа илэрхийлж болно. Энэ нь уул хуульд хориг тавих бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд саад болохгүй.”, 8-д “УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавина.” гэснийг өнөөг хүртэл хэвээр хадгалсан байна.

Харин Монгол Улсын Их Хурлын тухай хууль 1997 онд шинэчилсэн найруулгыг хийж, мөн онд Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийг батлан гаргасан.

Монгол Улсын Их Хурлынхуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн хоригийг хянан хэлэлцэх талаар заасан байх бөгөөд 6 хэсэг агуулгатайгаар оруулсан байна. Үүнд:

1. Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу УИХ-ын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь Ерөнхийлөгчийн тавьсан хоригийн үндэслэлийг Ерөнхийлөгч, эсхүл Ерөнхийлөгчийн итгэмжилсэн төлөөлөгч УИХ-д танилцуулна.

2. Ерөнхийлөгчийн хоригийн талаар тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хариуцаж байсан зохих Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны дүгнэлтийг сонсоно. Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонссоны дараа асуулт, хариулт явуулж, гишүүд санал гаргаж болно. Ийнхүү санал, дүгнэлт гаргаж дуусаны дараа Ерөнхийлөгч тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим

[220] Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (Уб, 2018), 65 дахь тал.

хэсэгт нь хориг тавьсныг үндэслэн уг хоригийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар санал хураалт явуулна. Хэрэв Ерөнхийлөгч хууль, УИХ-ын бусад шийдвэрийн зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явуулна.

3. УИХ Ерөнхийлөгчийн хоригийн талаар тогтоол гаргана.

4. УИХ хоригийг хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсгийг хүчингүй болгож, эсхүл тэдгээрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэж батална.

5. Тухайн хууль, бусад шийдвэрийг хүчин төгөлдөр дагаж мөрдөж эхлэх тусгайлан заасан хугацаа Ерөнхийлөгчийн хориг тавьсан хугацаатай давхацвал хоригийг хэрхэх тухай асуудлыг УИХ хянан хэлэлцэж дуусах хүртэл уг хууль, бусад шийдвэр бүхэлдээ буюу түүний зарим хэсгийн үйлчлэл түр зогсоно.

6. Хориг тавьсан асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн тухай хариуг уг шийдвэрийг баталснаас хойш 72 цагийн дотор Ерөнхийлөгчид илгээх талаар заажээ.

Харин 40 дүгээр зүйлд Ерөнхийлөгчийн хориг болон бусад Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлахаас бусад асуудлаар чуулганы хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөөнд ороогүй төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэхээр тухайн чуулганы явцад өргөн мэдүүлбэл Төрийн байгуулалтын байнгын хороо, зохих Байнгын хорооны санал, дүгнэлтийг харгалзан түүнийг чуулганаар хэлэлцэх эсэхийг чуулганы хуралдаанд оролцсон нийт гишүүний олонхийн саналаар шийдвэрлэх тухай заасан.

Хуулийн 44 дүгээр зүйлд “Улсын Их Хурал өөр хугацаа тогтоогоогүй бол шийдвэрийг ёсчилж илгээснээс хойш Ерөнхийлөгч ажлын 5 өдөрт багтаан тухайн хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавьсан бол түүнийг хэлэлцэх асуудлын дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжинд хэлэлцэж чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр нь хоригийг хүлээн зөвшөөрөөгүй бол УИХ-ын тухайн шийдвэр хэвээр үлдэнэ, Ерөнхийлөгч УИХ-ын чуулган ажлаа дуусаны дараа УИХ-ын шийдвэрт хориг тавьсан бол УИХ ээлжит бус чуулганаар хэлэлцэн шийдвэрлэж болно. Ерөнхийлөгчийн хоригийг УИХ-ын ээлжит бус чуулганаар хэлэлцэн шийдвэрлээгүй бол дараагийн ээлжит чуулганаар эхний ээлжинд, улс оронд онцгой нөхцөл байдал бий болсон, эсхүл УИХ-ын чуулганы ажиллагаа өндөрлөх гэж байгааг харгалзан Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг УИХ тогтоон өгч болох тухай, УИХ-ын тухайн шийдвэрт өөрөөр заагаагүй бол уг шийдвэр албан ёсоор нийтлэгдсэнээс хойш 10 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.” гэж заасан байна.

Анх удаа 1997 онд батлагдаж байсан Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хууль нь 2001 болон 2007 онд шинэчлэн найруулагдсан ба холбогдох заалтад 2018 онд нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

2007 онд шинэчлэн найруулагдсан хуулийн 31, 53 дугаар зүйлд Ерөнхийлөгчийн хоригийн талаар заасан. Үүнд, Хууль, УИХ-ын бусад шийдвэрт Ерөнхийлөгч хориг тавьсан бол УИХ түүнийг чуулганы үеэр 14 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хориг тавьсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 10 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж тогтоол батлах тухай заасан. Мөн гишүүд энэ хуульд заасны дагуу үг хэлсний дараа Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэх асуудлаар ил санал хураалт явуулах бөгөөд хэрэв хууль, УИХ-ын бусад шийдвэрийн зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, заалт нэг бүрээр санал хураалт явуулж дүнг танилцуулах талаар заасан. Энэхүү заалтад 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан байна.

Тус хуульд байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр буюу 66.6 хувь нь хоригийг хүлээж аваагүй бол хууль, УИХ-ын бусад шийдвэр хүчин төгөлдөр үлдэх талаар, Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан бол хууль, УИХ-ын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй

болгох, шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, УИХ-ын бусад шийдвэрийн төслийг хэлэлцэн баталж болох тухай, Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан хууль, УИХ-ын бусад шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах бол холбогдох шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй байх талаарх зохицуулалтыг тусгасан. Мөн хуулийн 53 дугаар зүйлд хууль, УИХ-ын бусад шийдвэрийг Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Ерөнхийлөгч тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэрийг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэх тухай, ийнхүү хориг тавьсан бол УИХ түүнийг хүлээж авснаас хойш дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжинд, тэгэхдээ ажлын 14 өдрийн дотор нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд түүнд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хоригийг хүлээн аваагүй бол тухайн хууль, УИХ-ын бусад шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөх тухай заажээ.

Улсын Их Хурлаас 2010 оны 12 дугаар сард Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийг батлан гаргасан. Тус хуулийн 16.2-т "Ерөнхийлөгч Улсын Их Хурлаас Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт оруулах уг эхийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын долоо өдрийн дотор хянан үзэж хэрэв уг хууль бүхэлдээ буюу түүний аль нэг зүйл хэсэг, заалт, нэр томьёоны агуулга нь Үндсэн хуульд харшилсан гэж үзвэл Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д зааснаар хориг тавьж болно." гэж хуульчлан тодорхойлж өгсөн байна.

Ийнхүү 1990 оноос хойш 29 жилийн хугацаанд Үндсэн хуулийн "Ерөнхийлөгчийн хориг" тавих заалтад өөрчлөлт оруулаагүй хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлынтухай хууль, мөн Монгол Улсын Их Хурлынхуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтууд шинэчлэгдэж байсан төдийгүй сүүлд 2018 онд нэмэлт, өөрчлөлт орж байжээ.

Дээрх хуулийн заалтаас үзвэл Ерөнхийлөгчийн хориг нь түүний бүрэн эрх төдийгүй парламентийн үйл ажиллагааны харилцан хяналтын шинжтэй чиг үүргийг хэрэгжүүлдэг байна. Энэ нь Ерөнхийлөгчийн бүрэн эрх /хориг тавих/ байх бөгөөд УИХ-ын хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох, парламенттай харилцах харилцааны хэлбэр төдийгүй ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн хуулийг батлан гаргах боломж юм.

Энэ талаар манай нэрт эрдэмтэн судлаачид[221] хэрхэн үзсэнийг тоймлон үзвэл, профессор Б.Чимид "Монгол Улсын Ерөнхийлөгчийн хуульд хориг тавих бүрэн эрх нь үзэмжийн хэрэг бус (1) Ард түмний язгуур ашиг сонирхолд харш, (2) Үндсэн хуулийн үзэл баримтлалд үл нийцсэн хуулийн заалтуудыг урдуураа зүгээр өнгөрүүлэх эрх төрийн тэргүүнд байх ёсгүй." гэж тодорхойлсон бол профессор Г.Совд "хориг тавих эрх нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн хууль тогтоох үйл ажиллагааны хүрээнд эдлэх нэгэн зүйл үндсэн бүрэн эрх, УИХ-аас батлан гаргаж байгаа хууль болон бусад шийдвэрийг хүчин төгөлдөр болохын өмнө Улсын Ерөнхийлөгч үзээд хэрэв тэр хууль буюу бусад шийдвэрийг (1) Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд харшилсан, (2) Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, (3) бусад эрх ашигт нийцэхгүй гэж үзвэл түүнийг бүхэлд нь буюу зарим заалтыг хүчингүй болгуулахаар хориг тавьж УИХ-д буцаах эрхтэй" гэж 3 үндэслэлийг тодорхойлсон бол Монгол Улсын анхны Ерөнхийлөгч асан П.Очирбат "Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр" номондоо "Ерөнхийлөгчийн хориг нь УИХ-ын шийдвэрт ямар нэг хэмжээгээр үл итгэсэн байдлын илэрхийлэл биш, хуулийг аль болох алдаа мадаггүй гаргах эцсийн анхааруулга, дахин бодох, дутуугаа гүйцээх, буруугаа зөвтгөх, цаг үеэ олох боломж олгох төрийн бодлогын нэгдмэл чанарыг илэрхийлэхэд ач тустай арга зам мөн."[222], Д.Солонго хоригийг төрийн тэргүүнээс

[221] Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (Уб, 2018), 88 дахь тал.

[222] П.Очирбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр, (Уб, 2001),

парламентийн баталсан хуулийг хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлэх эрх, Ардчилсан улс орнуудад вето нь эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх, тэнцвэржүүлэх ач холбогдол бүхий чухал хэрэглүүрт тооцогддог хэмээгээд (1) хууль, Үндсэн хуульд зөрчилдөх, (2) төгс боловсруулалт хийгдээгүй, (3) бусад хуультай үл авцалдах, (4) холбогдох харилцааг зохицуулах үндэслэл муу, (5) хууль хэрэгжүүлэх материаллаг болон зохион байгуулалтын нөхцөл хангагдаагүй, (6) парламент хууль хэлэлцэх, батлах тогтсон журам үл баримталсан зэрэг тохиолдол гэж тодорхойлсон байна.

"Ерөнхийлөгч" хэмээх төрийн тэргүүний тухай ойлголт бий болсон цагаас эхлэн Монгол Улсад Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан хүний хугацаа, тавьсан хоригийн тоог[223] дараах байдлаар хүснэгтээр харуулбал:

Д/д	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэр	Бүрэн эрхийн хугацаа	Бүхэлд нь хориг тавьсан	Хэсэгчлэн хориг тавьсан	Хүлээн авсан эсэх		Нийт
					Тийм	Үгүй	
1.	Пунсалмаагийн Очирбат	1990-1992	2	5	3	4	7
2.	Пунсалмаагийн Очирбат	1993-1997	21	2	11	10	23
3.	Нацагийн Багабанди	1997-2001	6	11	12	5	17
4.	Нацагийн Багабанди	2001-2005	4	11	7	5	15
5.	Намбарын Энхбаяр	2005-2009	3	6	7	2	9
6.	Цахиагийн Элбэгдорж	2009-2013	2	3	4	1	5
7.	Цахиагийн Элбэгдорж	2013-2017	4	-	3	1	4
8.	Халтмаагийн Баттулга	2017-одоог	4	-	1	3	4

Нийт хоригийн 2/3-г хүлээн зөвшөөрч, үлдэх хэсэг буюу 1/3-г хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн тогтоол гаргасан байна.[224]

Дээрх хугацаа болон хориг тавьсан үндэслэл шалтгааныг 3 болон түүнээс дээш удаа давтагдсан гэх шалгуураар бүлэглэн авч үзсэн[225]-ийг дурдвал,

- Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, зүйл заалтад нийцэгүй;
- Үндэсний аюулгүй байдал, төрийн бодлого, хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой зөрчилдсөн;
- Ёс суртахуун нийтийн эрх ашигт нийцэхгүй;
- Төсвийн зарлагыг үндэслэлгүй нэмэгдүүлсэн, хэт үрэлгэн;
- Бодит амьдралд хэрэгжих үндэслэл муутай, судлаачдын саналыг аваагүй, хүн амын амьжиргаанд сөргөөр нөлөөлөхүйц;
- Түүхэн уламжлал, олон улсын жишигт нийцэхгүй;
- Ерөнхийлөгчийн үндсэн бүрэн эрхийг хязгаарласан;
- Үг найруулга, хууль зүйн техник, хууль тогтоох процесс ажиллагаа зөрчигдсөн гэх үндэслэлээр голлон дурдагджээ.

Энэхүү хориг тавих үндэслэл, шалгуур нь хэт ерөнхий, судалгаанд суурилсан байж чадахгүй байгааг Хууль тогтоомжийн тухай хуулиар зохицуулан судалгаа үндэслэлтэй, хариуцлагатай ил тод байлгах нь эрх мэдлийн хяналт тэнцлийг хангах,

27 дахь тал.

[223] П.Амаржаргал. "УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаан дахь Ерөнхийлөгчийн оролцоо, хууль тогтоомжид тавих хориг" Үндсэн хуульт ёс ба Ерөнхийлөгчийн бүрэн эрх сэдэвт олон улсын онол-практикийн бага хурал. (Уб, 2015), 113 дахь тал.

[224] П.Амаржаргал, Парламентын хууль тогтоох бүрэн эрх ба Ерөнхийлөгчийн хориг, *Хууль дээдлэх ёс,* №2, (2014), 68 дахь тал

[225] Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (Уб, 2018), 93 дахь тал

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН www.ulsyn.gov.mn

ард иргэдийн эрх ашгийг хамгаалах чухал ач холбогдолтой.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Хориг" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол хэлний их тайлбар тольд "1/ хориул, хорио; саад хориг; хориг тавих; 2/ хүний муу буруу, өө сэв буюу бусдад муу санасан атаг; муугий нь гаргаж, хоригий нь уудлах; 3/ хүн амьтны эрх эмзэг газар; толгойдоо хориг морь гэж тайлбарласан байна." [226] гэсэн бол академич Ж.Амарсанаа нар "Хууль зүйн тайлбар толь бичиг" номондоо "Орчин үед төрийн ямар нэгэн байгууллагын гаргаж байгаа актын үйлчилгээг түр буюу бүрмөсөн зогсоохыг ойлгодог. Үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухаанд парламентаас гаргаж байгаа актын үйлчилгээг зогсоохоор төрийн тэргүүнээс бүрэн эрхийн дагуу тавьдаг актыг хориг гэдэг." [227] хэмээн тайлбарласан байна. Мөн академич С.Нарангэрэлийн "Эрх зүйн тайлбар толь бичиг" номонд "Ямар нэгэн байгууллагын шийдвэрийн үйлчлэлийг түдгэлзүүлэх буюу зогсоох акт. Ялангуяа парламентаас баталсан хуульд төрийн тэргүүнд хориг тавих эрх олгосон нь онцгой чухал ач холбогдолтой. Хоригийг туйлын ба харьцангуй гэж ангилна. Туйлын хоригийн нөхцөлд парламентаас баталсан хууль тогтоомжийн үйлчлэлийг бүрэн зогсоох эрх хадгалагдана. Харьцангуй хоригийн үед төрийн тэргүүн зөвхөн хуулийн үйлчлэлийг түдгэлзүүлэх бүрэн эрхтэй байх бөгөөд парламентад түүнийг хоёр дахь санал хураалтаар батлах эсэх эрх байна. Ийнхүү хуулийн төслийг хэд хэдэн парламентад хоёр дахь удаа (эцэслэн) батлахад дийлэнх олонхийн санал (жишээ нь ОХУ, АНУ-д танхим бүрийн гишүүдийн 2/3-ын санал) шаарддаг. Тэрчлэн ерөнхий буюу хэсэгчилсэн хориг хэмээн ангилна. Эхнийхэд нь хуульд бүхэлд нь, харин хоёр дахь тохиолдолд зарим зүйл буюу хэсэгт хориг тавигдана." [228,] Г.Совд нарын "Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар" номонд "хууль цаазын практикт хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль болон бусад шийдвэрийн үйлчилгээг саатуулах буюу зогсоох талаар төрийн тэргүүний эдлэх үндсэн бүрэн эрхийг илэрхийлэн дэлхий нийтээр хэрэглэж хэвшсэн Үндсэн хуульт ёсны ойлголтыг Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Ерөнхийлөгчөөс хууль тогтоомжид хориг тавих эрх гэж томьёолсон. Хуульд хориг тавих эрхийг хуулиар олгосон хүчин чадлын байдлаар нь туйлын /хязгааргүй/, харьцангуй /саатуулах/ гэж хоёр ангилдаг. Хориг тавих туйлын эрх эдэлсэн тохиолдолд төрийн тэргүүнээс хориг тавьсан хууль хүчин төгөлдөр болдоггүй, бүрмөсөн зогсдог бол хориг тавих харьцангуй эрх эдэлдэг төрийн тэргүүний хориг тавьсан хуулийг хууль тогтоогч дахин хэлэлцэж, хүчин төгөлдөр болж үйлчлэх эсэхийг шийдвэрлэдэг онцлогтой"[229] зэргээр агуулга талаас нь дэлгэрэнгүй тайлбарласан байна.

Дүгнэвэл, олон улсын эрх зүйд VETO буюу хориг тавих эрх нь тодорхой саналыг аюулгүйн зөвлөлийн аль нэг гишүүн зөвшөөрөхөөс татгалзах эрх мэдлийг ойлгох тухай илэрхийлсэн бол Ардчилсан улс орнуудад ветог эрх мэдэл хуваарилах зарчмыг хэрэгжүүлэх тогтолцооны тэнцвэржүүлэгч нэн чухал элемент гэж үзжээ.

Харин Монгол Улсад хууль тогтоох байгууллагаас гаргасан хууль болон бусад шийдвэрийн үйлчилгээг саатуулах буюу зогсоох талаар төрийн тэргүүний эдлэх үндсэн бүрэн эрхийг илэрхийлэн дэлхий нийтээр хэрэглэж хэвшсэн Үндсэн хуульт ёсны ойлголтыг Монгол Улсын Үндсэн хуульд Улсын Ерөнхийлөгчөөс хууль тогтоомжид хориг тавих эрх хэмээн тайлбарласан бол Ерөнхийлөгч хэмээх нэр томьёо үүссэн цагаас "Ерөнхийлөгчийн хориг" хэмээх ойлголт бий болсон байна.

Үндсэн хууль дахь нэг намын дангаар ноёрхлыг бэхжүүлсэн заалтыг халж, улс төрийн олон ургалч ёс, иргэдийн улс төрийн эрх, эрх чөлөөг хүлээн зөвшөөрсөн өөрчлөлтийг 1990 оны 3 дугаар сарын 23-ны өдөр "БНМАУ-ын Төрийн дээд

[226] Монгол хэлний их тайлбар толь, https://mongoltoli.mn/dictionary/detail/110788 (сүүлд үзсэн 2019.05.09)

[227] Ж.Амарсанаа нар. Хууль зүйн тайлбар толь бичиг. Монголын нээлттэй нийгэм хүрээлэн, Хүний эрхийн боловсрол төв, (Уб., 2003). 296 дахь тал

[228] С.Нарангэрэл. Эрх зүйн тайлбар толь бичиг, (Уб, 2007), 516 дахь тал.

[229] Г.Совд нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. (Уб, 2000), 166 дахь тал.

байгууллагын бүтцийн тухай тогтоол”-ыг батлан гаргасанаар Ерөнхийлөгчийн бүрэн эрх баталгаажих эхлэл тавигдсан төдийгүй Ерөнхийлөгчийн тухай хуулийг батлан АИХ, Бага хурлын шийдвэрт хориг тавих эрх баталгаажиж, 1990-1992 оны хугацаанд УИХ нь 30 гаруй хуулийг батлан гаргасанд 7 удаа хориг тавьсан байдаг.

Ийнхүү 1990 оноос хойш 29 жилийн хугацаанд Үндсэн хуулийн “Ерөнхийлөгчийн хориг” тавих заалтад өөрчлөлт оруулаагүй хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлынтухай хууль, мөн Монгол Улсын Их Хурлынхуралдааны дэгийн тухай хуулийн холбогдох заалтуудаар зохицуулж тэдгээрт тухайн цаг үеийн шаардлагаар өөрчлөлт, шинэчлэлт хийж байсан төдийгүй сүүлд 2018 онд шинэчлэгдэж, нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Ерөнхийлөгчийн хориг нь түүний бүрэн эрх төдийгүй парламентийн үйл ажиллагааны харилцан хяналтын шинжтэй чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд Ерөнхийлөгчийн бүрэн эрх /хориг тавих/ байх бөгөөд УИХ-ын хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох, парламенттай харилцах харилцааны хэлбэр, ард түмний нийтлэг эрх ашигт нийцсэн хуулийг батлан гаргах боломж, хариуцлагатай ил тод, эрх мэдлийн хяналт тэнцлийг хангах, ард иргэдийн эрх ашгийг хамгаалах чухал ач холбогдолтой байна.

зөвшилцөх

Зөвшилцөх гэх нэр томьёог англи хэлний “consensus”,[230] орос хэлний “согласование консенсус”, герман хэлний “konses;”[231] хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд латин хэлний “consensus” гэх үгнээс гаралтай.[232] БНСУ-ын Хууль тогтооомжийн судалгааны хүрээлэн, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хамтран гаргасан Англи-Солонгос-Монгол-Орос-Герман хууль зүйн толь бичигт “accord” гэсэн үгийг зөвшилцөл, хэлэлцээр гэж орчуулан буулгасан бол Виктор Кондэ “consensus” гэсэн үгийг нь зохион байгуулалттай санал хураах хэмээн орчуулан буулгасан бөгөөд “...Санал хураалтад хэлэлцэгч талууд буюу гишүүд татгалзсан санал гаргахгүйгээр шийдвэрт хүрэх процессыг хэлнэ. Энэ нь дийлэнх буюу гуравны хоёроор шийдвэр гаргахаас ялгаатай. Санал нэгтэйгээр буюу эсрэг саналгүйгээр шийдэлд хүрнэ гэсэнтэй ойролцоо утгатай.”[233] гэжээ.

Эрх зүйн бүлийн хувьд ижил ХБНГУ-ын Үндсэн хуульд 9-н заалтад[234] зөвшилцөх асуудлыг тусгаж өгсөн байна. Тодруулбал: ХБНГУ-ын Үндсэн хуулийн 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хэрэв Муж нь энэхүү Үндсэн хууль, Холбооны бусад хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол Бундесраттай зөвшилцсөний үндсэн дээр Холбооны Засгийн газраас тухайн Мужийг албадан үүргээ биелүүлэхийг шаардаж болно.”, 85 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Холбооны Засгийн газраас Бундесраттай зөвшилцөн захиргааны ерөнхий хэм хэмжээ баталж болно. Төрийн албан хаагч болон бусад нийтийн цалинтай ажилтны сургалтыг нэгдсэн журмаар зохицуулна. Түүний зөвшөөрснөөр дунд шатны байгууллагыг удирдах эрх бүхий этгээдийг томилно.”, 91б дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Холбоо болон Муж нь хамтын зөвшилцлийн үндсэн дээр боловсролын тогтолцооны үр дүнтэй байдлыг олон улсын жишигтэй харьцуулан үнэлэх, мөн холбогдох тайлан болон зөвлөмж боловсруулахад хамтран ажиллаж болно.”, 108 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Холбооны санхүүгийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллага нь 2009 оны

[230] Англи- Солонгос- Монгол- Орос- Герман – Хууль зүйн толь, №1642, (Уб, 2011), 184 дэх тал.

[231] Ж. Амарсанаа, Англи-орос-герман-монгол Олон улсын эрх зүйн толь, (Уб, 2004), 194 дэх тал.

[232] П.Цагаан, Хууль зүйн Латин, англи, орос монгол толь, (Уб, 2013), 61 дэх тал.

[233] Х.Виктор Кондэ, *Хүний эрхийн олон улсын нэр томьёоны гарын авлага,* НҮБХХ, (Уб, 2002), 29 дэх тал.

[234] ХБНГУ-ын 37 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 85 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 91б дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 108 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 115и дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 115й дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 129 дүгээр зүйлийн 1 дэх хэсгүүдэд тус тус зохицуулсан байна.

долдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Холбооны хуулиар зохицуулагддаг гаалийн албан татвар, санхүүгийн монополь, онцгой албан татвар, мөн импортын гүйлгээний албан татвар, авто тээврийн хэрэгсэл, түүнтэй холбогдох бусад албан татварыг, түүнчлэн Европын хамтын нийгэмлэгийн хүрээнд төлөх хураамжийг хариуцна. Эдгээр байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг Холбооны хуулиар зохицуулна. Ийнхүү дунд шатны эрх бүхий байгууллагыг байгуулан, удирдлагыг Мужийн Засгийн газартай зөвшилцөн томилно.” мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Холбооны санхүүгийн асуудал эрхэлсэн захиргааны байгууллага нь 2009 оны долдугаар сарын 1-ний өдрөөс эхлэн Холбооны хуулиар зохицуулагддаг гаалийн албан татвар, санхүүгийн монополь, онцгой албан татвар, мөн импортын гүйлгээний албан татвар, авто тээврийн хэрэгсэл, түүнтэй холбогдох бусад албан татварыг, түүнчлэн Европын хамтын нийгэмлэгийн хүрээнд төлөх хураамжийг хариуцна. Эдгээр байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг Холбооны хуулиар зохицуулна. Ийнхүү дунд шатны эрх бүхий байгууллагыг байгуулан, удирдлагыг Мужийн Засгийн газартай зөвшилцөн томилно.”,[235] гэх зэргээр зохицуулж өгсөн байна.

Монгол Улсын түүхэнд зөвшилцөх асуудлыг хэрэглэж ирсэн тухай баримт нь Монголын нууц товчоо юм. Энэхүү түүхийн эх сурвалжаас үзэхэд Монголын төр нь хэлбэрийн хувьд хэмжээгүй эрхт хаант засгийн төрхтэй боловч мөн чанараараа ардчиллын олон бүрдлийг өөртөө агуулсан, тун өвөрмөц шинж бүхий төр байв. Төр улсын тулгамдсан асуудалд ончтой хариу эрэлхийлж, нягтлан магадласаны үндсэн дээр их хаанд зөвлөх эрх бүхий байгууллага бол Их Хуралдай байжээ. Их Хуралдай нь төрийн дээд байгууллагын шинжийг агуулж байсан. Монголын нэгдсэн тулгар төр, улсын эрх ашгийн үүднээс хэн нэгэнтэй дайн зарлах, байлдаан явуулах, өөрийн залгамжлагчийг сонгох, төр улсын тулгамдсан асуудлын гарц, шийдлийг зөвшилцлийн аргаар шийдвэрлэдэг байжээ.[236]

Ийнхүү Монголын төрд зөвшилцөх улс төрийн соёл хэвшин тогтсон уламжлалыг Дөчин дөрвөн хоёрын их цааз бичгээс харж болно. Тухайлбал, Манжийн эзлэн түрэмгийллийн эсрэг бүх нийтээрээ тэмцэх, буддын шашны шарын урсгалыг улсын шашин болгож түүний дэмжлэгээр Монгол овогтныг нэгтгэх, том ноёдын зөрчил сөргөлдөөнийг зогсоож хүчээ төвлөрүүлэх зэрэг асуудлуудыг зөвшилцөн хэлэлцэж шийдвэрлэжээ.

1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийг батлах явц нэлээд онцлог бөгөөд нийтийн зөвшилцлийн үзэл санааны дагуу явагдсан гэж үздэг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийг батлах үйл явц нь бүхэлдээ нийгмийг хамарсан зөвшилцлийн үр дүн болсон. Түүний төслийг ард нийтээр хэлэлцсэн, түүний баталсан АИХ-ын депутатууд Монгол Улсын засаг захиргааны анхан шатны нэгж болсон сумуудыг нийтэд нь төлөөлсөн, Их Хурлын хуралдааны үеэр улс төрийн намууд ажиллаж байсан зэрэг нь бүтцийн талаасаа зөвшилцөл хангагдсан гэсэн үг юм.[237]

Монгол Улсын Үндсэн хуулийн зургаан зүйлд[238] зөвшилцөх асуудлыг тусгаж өгсөн байна. Тухайлбал, Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “УИХ бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь үзсэнээр буюу эсхүл мөнхүү шалтгаанаар Ерөнхийлөгч УИХ-ын даргатай зөвшилцөн санал болгосноор өөрөө тарах шийдвэр гаргаж болно. Ийнхүү

[235] Орч: Christian Tomuschat and David P.Currie, Donald P.Kommers in cooperation with the language service of the German Bundestag, Basic Law for the Federal Republic of Germany, https://www.btg-bestellservice.de/pdf/80201000.pdf

[236] Т.Ганхуяг, Зөвшилцөл, (Уб, 2003).

[237] Мөн тэнд.

[238] Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэг, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2, 4, 5 дахь заалт, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 9 дэх заалт, 39 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгүүдэд тус тус зөвшилцөж шийдвэр гаргах талаар зохицуулж өгсөн.

тарах шийдвэр гаргасан бол шинэ сонгогдсон гишүүдээ тангараг өргөтөл УИХ бүрэн эрхээ эдэлнэ.”, Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “УИХ-д олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвсэлтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол УИХ-д суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор УИХ-д оруулах;” гэх зэргээр хуульчлан оруулсан.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид “Зөвшилцөх” хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Монгол хэлний их тайлбар тольд “Аливаа маргаантай асуудлыг шийдэхдээ тодорхой нэг саналд хүрэхгүй боловч талуудын сонирхолд тохирсон шийдэлд хүрэх арга зам.”[239], *Монгол хэлний хадмал тольд “зөвшилц* - зөвшихийн үйлдэлцэх хэв, харилцан зөвших;”[240], Монгол хэлний товч тайлбар тольд “зөвшилдөх - олноороо зөвших, зөвлөлдөх; зөвших - аливаа хэрэг явдлыг санал солилцон, шүүмжлэн хэлэлцэх”[241] гэсэн бол Улсын Дээд шүүхээс Ерөнхийлөгчийн тухай хуулийн зарим зүй заалтыг тайлбарлах тухай 1996 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 216 дугаар тогтоолд: 1.“Ерөнхийлөгчийн тухай хуульд заасан “зөвшилцөх” гэдгийг хууль тогтоомжид өөрөөр тодорхойлоогүй бол Ерөнхийлөгч, УИХ буюу Ерөнхий сайд тодорхой бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ хууль бүрэн эрхэд хамаарах асуудлаар өөрийн гаргаж буй шийдвэр авах гэж буй арга хэмжээнийхээ талаар хуульд заасан байгууллага, албан тушаалтантай санал солилцохыг ойлгоно. 2.Хуулийн 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн «…нам буюу намуудын сонгуулийн эвсэлтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг УИХ-д оруулна» гэдгийг Ерөнхийлөгч Ерөнхий сайдад нэр дэвшүүлэх хүнийхээ тухай өөрийн саналыг тухайн нам буюу намуудад бичгээр оруулж нам бүрээс бичгээр саналыг нь авахыг ойлгоно гэж[242], академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номонд “Санал нэгтэйгээр буюу эсрэг саналгүйгээр шийдэлд хүрнэ гэсэнтэй ойролцоо утгатай;”[243], гэсэн бол Монгол Улсын Үндсэн Хуулийн тайлбарт “зөвшилцөх гэдэг нэр томьёо бол төр, засгийн дээд байгууллага, албан тушаалтнуудын хооронд болон олон улсын харилцаанд ямар нэг асуудлыг шийдвэрлэхийн тулд урьдчилан хэлэлцээр хийж харилцан санал нэгдэх аргыг илэрхийлдэг...” гэсэн бол Д.Солонго “Төрийн эрх зүйн тайлбар толь” номонд “Эрх бүхий байгууллага батлан гаргах актын төсөл, эсхүл аль нэг албан тушаалд томилохоор нэр дэвшүүлсэн хүний талаар нөгөө байгууллагаас урьдчилан санал дүгнэлт авах ажиллагаа юм”[244] гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, “Зөвшилцөл” хэмээх үгийн утга, агуулга нь Монгол хэлний толь бичигт болон хууль зүйн эрдэмтдийн гадаад хэлнээс хөрвүүлсэн судалгаанаас харахад “хамтын шийдвэр; тодорхой асуудлыг санал нэгтэй; нэгдмэл санаа бодлоор шийдвэрлэх” гэсэн утгатай дүйж байгаа юм.

---

239 МУ-ын Шинжлэх ухааны академи, Монгол хэлний их тайлбар толь

240 Ш.Чоймаа нар, *Монгол хэлний хадмал толь,* (*кирил- монгол- тайлбар*), (2011), 341 дэх тал.

241 Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (Уб, 1966), 278 дахь тал.

242 Энэхүү Дээд шүүхийн тайлбарыг академич С.Нарангэрэл “Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын “Судалгаа хууль зүйн нэр томьёоны амин сүнс” илтгэлдээ “...нэгдмэл буюу хамтын санаа бодол гэсэн зөвшилцлийн үндсэн утгыг нь илэрхий гуйвуулан “санал солилцох” , “бичгээр саналыг нь авах” болгон хувиргажээ хэмээн шүүмжилсэн билээ.

243 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW Dictionary, Анхны хэвлэл, (Уб, 2007), 219 дэх тал.

244 Д.Солонго, Төрийн эрх зүйн тайлбар толь, (Уб, 2003), 39 дэх тал.

ИТГЭМЖЛЭХ ЖУУХ БИЧИГ

Төлөөлөгчийн газрын тэргүүнийг хүлээн авагч улсын төрийн тэргүүнд итгэмжлэх жуух бичгээр нотолдог. Итгэмжлэх жуух бичиг гэсэн нэр томьёо нь итгэл найдлага /*credencetum*/[245] гэсэн утга бүхий Латин үгнээс гаралтай бөгөөд Олон улсын эрх зүйн гол үндсэн эх сурвалж болох" Дипломат харилцааны тухай Венийн Конвенцод /1961/[246] "credentials" англи үгээр илэрхийлсэн байдаг. Монгол хэлэнд итгэмжлэх жуух бичгийг "letters of credence" үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг байна.[247] Оксфордын хуулийн толь бичигт: letter of credence[248] /lettre de creance/- тухайн улсаас шинээр томилогдсон дипломат төлөөлөгчөө хүлээн авагч орны төрийн тэргүүнд итгэмжилэн баталгаажуулсан албан бичиг баримт гэж бичсэн байна. НҮБ-ын ЮНЕСКО-гийн албан цахим хуудаснаа байршуулсан Монгол Улсын Үндсэн хуулийн[249](1992) англи хэлний орчуулгын хувилбарт "*to receive the Letters of Credence*" буюу *"итгэмжлэх жуух бичгийг хүлээн авах"* хэмээн орчуулжээ.

Өнөөгийн байдлаар Бүгд Найрамдах Литва Улс, Исламын Бүгд Найрамдах Иран Улс, Бүгд Найрамдах Хорват Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Сальвадор улс Үндсэн хуульдаа итгэмжлэх жуух бичиг /the letter of Credence/ гэсэн томьёоллыг[250] оруулсан байдаг.

Итгэмжлэх жуух бичиг гэсэн Үндсэн хуулийн нэр томьёог түүхэн талаас нь авч үзвэл, Их Монгол Улс 1206 онд байгуулагдсан цагаас хааны зарлигийг зарлан тунхаглах хүнд хааны дур зоригийн үнэн мөнийг, тухайн зарлигийн жинхэнэ болохыг батлан гэрчилсэн тусгай тэмдэг-пайзыг[251] уг зарлигийг дагалдуулан олгодог байжээ.

1924 оны Монгол Улсын Анхны Үндсэн хуульд "итгэмжлэх жуух" гэсэн нэр томьёо, хуулийн үг заалт ороогүй байна. Харин БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуульд *итгэмжлэх бичиг*, БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуульд *итгэмжлэх жуух бичиг* гэсэн нэр томьёо орж, 1992 оны Үндсэн хуульд энэхүү хуулийн томьёог тэр чигт нь хадгалжээ.

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Итгэмжлэх жуух" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Я. Цэвэлийн "*Монгол хэлний товч тайлбар толь*"-д "Итгэх, найдах, түшиг тулгуур болох, (итгэмжлэх бичиг) нэг этгээд нөгөөдөө өөрийн төлөө ямар нэг зүйлийг гүйцэтгэхийг итгэмжлэн олгох бичиг"[252] гэсэн бол Монгол хэлний товч тайлбар тольд «жуух: жуух бичиг – ямар нэгэн төлөөний хүмүүст

[245] https://www.etymonline.com/

[246] https://www.legalinfo.mn/law/details/1164; гадаад цахим эх сурвалж: (Сүүлд үзсэн 2019.06.07), http://legal.un.org/ilc/texts/instruments/english/conventions/9_2_1963.pdf, Vienna Convention on Consular Relations. (Сүүлд үзсэн 2019.06.07)
1963, Article 13: "1.The head of the mission is considered as having taken up his functions in the receiving State either when he has presented his credentials or when he has notified his arrival and a true copy of his credentials has been presented to the Ministry for Foreign Affairs of the receiving State, or such other ministry as may be agreed, in accordance with the practice prevailing in the receiving State which shall be applied in a uniform manner.
2.The order of presentation of credentials or of a true copy thereof will be determined by the date and time of the arrival of the head of the mission."

[247] Д.Ганхуяг, Ш.Юмжав, Дипломат эрх зүй, (Уб, 2014), 63 дахь тал.

[248] Jonathan Law, *A Dictionary of Law, 7th edition*, Oxford University Press, 2009, 323 дахь тал. "a formal document by which the head of an accredited state presents its newly appointed diplomatic agent to the head of state of the host country".

[249] http://www.unesco.org/education/edurights/media/docs/6a6a23469e136afaa4860bf5869f6f8f659c6688.pdf (Сүүлд үзсэн: 2019.06.10)

[250] https://constitution.com/?s=letter+of+credence+&post_type=post, (Сүүлд үзсэн: 2019.06.10)

[251] В.А.Рязановский, *Монголчуудын хууль цаазын дурсгал бичгүүдийн түүхэн тойм, Их засаг хууль*, УБ.,2000, 15 тал. "пайзыг нэгдүгээрт, хааны зарлигийн баталгаа болгож; хоёрдугаарт, тухайн хүний, элч, түшмэл, алба гүйцэтгэгч гэх мэт эрхэлж буй хэргэм зэргийн тэмдэг болгож; гуравдугаарт, дагаар орон бууж өгөгсөдийг хамгаалах жуух болгож ашигладаг байсан байна."

[252] Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (Уб,1966).

олгох итгэмжлэл үнэмших бичиг буюу итгэмжлэх жуух бичиг харь улсад улсаа төлөөлөн суулгах диплоамт төлөөлөгчид олгох бүрэн эрхийн бичиг", Хууль зүйн тайлбар тольд "итгэмжлэл нэгэн этгээд (итгэмжлэгч) өөрийн нэрийн өмнөөс хууль зүйн үр дагавар бүхий тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэх, бүрэн эрхийг нөгөө этгээд (итгэмжлэгдэгч)-д олгосноо бичгээр тодорхойлсныг итгэмжлэл гэнэ"[253] гэж тодорхойлсон. Харин эрх зүйн мэдлэгийн товч тольд "нэг этгээдээс (итгэмжлэгчээс) нөгөө этгээдэд (итгэмжлэгдэгчид)-д өөрийн нэрийн өмнөөс хууль ёсны тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлэхийн тулд бичгээр олгосон бүрэн эрх[254] гэж дэлгэрэнгүй бөгөөд анхлан тайлбарлажээ. Мөн энэ талаар академич С.Нарангэрэл "Эрх зүйн эх толь бичиг" номондоо "итгэмжлэл (латин mandatum; англ. Letter of authorney procuracy; power of attorney; орч. доверенность) нэг этгээд нь өөрийн нэрийн өмнөөс хууль зүйн үр дагавар бүхий тодорхой үйлдэл хийлгэхийн тулд нөгөө этгээдэд бүрэн эрх олгосноо бичгээр тодорхойлох;" [255], "*итгэмжлэх жуух* – (англ. *credential*; ор. Верительные грамоты) – элчин сайд буюу элчингийн зэрэг дэв бүхий дипломат төлөөлөгч түүний төлөөллийн шинж ба гадаад улсад тохоон томилогдсныг гэрчлэх баримт бичиг"*[256]*, академич Ж.Амарсанаа "*Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг" номондоо* "Дипломат[257] Герег хэлний үг- Дипломат захиа, итгэмжлэх жуух бичиг эзэмшигч дипломат төлөөлөгчийн газрын тэргүүн ба ажилтныг дипломатч гэнэ. Гадаад улс, олон улсын байгууллагатай гадаад харилцааны асуудлаар харилцах төрийн байгууллагын эрх бүхий албан ёсны этгээд гэсэн letter of delegation[258] - *итгэмжлэл*," Хуулийн нэр томьёоны дагалга" номонд[259] "итгэмжлэл- аливаа байгууллага, эсхүл хувь хүн нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх чадавхтайг нь эрх бүхий байгууллагаас тогтоож албан ёсоор хүлээн зөвшөөрөх ажиллагаа;" гэж тус тус тайлбарлажээ.

Харин Проф. Чой. Лувсанжав нарын "English- Mongolian Dictionary"-д "Credentials"[260] – *итгэмжлэх жуух бичиг* гэж монгол хэлнээ буулгасан байдаг. Мөн доктор Д.Ундралсайхан letter of credence[261] – итгэмжлэх жуух бичиг хэмээн орчуулсан нь бий.

Дүгнэвэл, гадаад оронд улсаа төлөөлөн суухаар шинээр томилогдсон дипломат төлөөлөгчийн төлөөлөх чадварыг нотолсон албан ёсны баримт бичгийг итгэмжлэх жуух бичиг хэмээн ойлгох бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль дахь "итгэмжлэх жуух бичиг" хэмээх хуулийн нэр томьёог манай улс 1960 оны БНМАУ-ын Үндсэн хуульдаа анхлан томьёолжээ. Өнөөгийн Үндсэн хууль хүртэл дээрх нэр томьёо эдүгээ нийтдээ 59 жилийн турш хэрэглэж ирсэн хэвшин тогтсон томьёолол юм.

www.hilgov.mn

[253] Хууль зүйн тайлбар толь, (Уб, 2003), 140 дэх тал.

[254] *Эрх зүйн мэдлэгийн товч толь*, (Уб,1986), 76 дахь тал.

[255] С.Нарангэрэл, *Эрх зүйн мэдлэгийн товч толь*, (2007, Анхны хэвлэл), 242-243 дахь тал. "итгэмжлэх жуух бичигт дипломат төлөөлөгчийг тохоон томилсон улсын тэргүүн үзэглэж, гадаад хэргийн сайдын гарын үсгээр баталгаажуулсан байдаг. Суух улсын төрийн тэргүүнд хаяглаж, түүнд ёслолын байдалтай гардуулна. Итгэмжлэх жуух бичигт дипломат төлөөлөгчийн овог, нэр, хоёр улсын хоорондын хэлэлцээрээр тодорхойлогдсон түүний зэрэг дэвийг заасан байна. Итгэмжлэх жуух бичиг нь ерөнхий бүрэн эрхийн шинжтэй байна. Хэрэв дипломат төлөөлөгчид олон улсын хэлэлцээрт гарын үсэг зурах даалгавар өгвөл, түүнд энэ талаар тусгай бүрэн эрх олгоно.

[256] С.Нарангэрэл, *Хууль зүйн судлалын англи-монгол тайлбар толь*, (Уб, 2005).

[257] Ж.Амарсанаа, Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг, (Уб, 2014), 15 дахь тал.

[258] Англи- Солонгос- Монгол- Орос- Герман – Хууль зүйн толь, (Уб, 2013), 288 дахь тал.

[259] Хууль зүйн үндэсний төв, Хуулийн нэр томьёоны дагалга, (Уб,2004), 46 дахь тал.

[260] Проф. Чой. Лувсанжав, Ц.Сумъяа, English- Mongolian Dictionary, (Уб, 1990), 45 дахь тал.

[261] Д.Ундралсайхан, Орчин үеийн олон улсын эрх зүй, (Уб, 2016), 293 дахь тал.

ОНЦ БАЙДАЛ

Онц байдлыг англи хэлний “state emergency”, орос хэлний “чрезвычайное положение”[262] гэх үгтэй дүйцүүлэн хэрэглэдэг бөгөөд онц байдал хэмээх ойлголт нь эртний Ромын эрх зүйн Юститиум (лат. Justitium)[263] гэх ойлголттой ижилхэн бөгөөд МЭӨ 465 онд Эквы омгийнхон дайрахаар айсуй гэсэн цуурхлаас болж хотод үймээн дэгдсэн тул анхны Юститиумыг зарлаж байжээ.

Онц байдал гэдэг нь хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагад ердийн үед зөвшөөрөгдөхөөргүй үйлдэл хийх бүрэн эрхийг олгож буй үйл ажиллагаа буюу байгалийн гамшиг, иргэний дайн, зэвсэгт мөргөлдөөн зэргийн үед зарлаж болох ажиллагаа юм. Онц байдлыг зарлах нь ард иргэдэд өдөр тутмын хэвийн байдлаа өөрчлөх болон Засгийн газрын агентлагуудад онц байдлын шийдвэрийг хэрэгжүүлэх нөхцөл байдлыг үүсгэдэг.[264]

Олон Улсын эрх зүйн дагуу онц байдлын үед тухайлбал, шүүх хуралдаанаар хэлэлцүүлэлгүйгээр хүнийг цагдан хорих буюу эрх, эрх чөлөөг хязгаарлаж болно. Өөрөөр хэлбэл, ИБУТЭТОУП-д заасан аливаа эрхийг хязгаарлаж болох ба гагцхүү тус пактын 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан эрхүүдээс ухарч үл болно. Тодруулбал, “ухарч үл болох эрх” (англ. Non-derogable rights) гэдэгт амьд явах эрх, эрүү шүүлт тулгах, хэрцгий, хүнлэг бусаар, нэр төрийг нь доромжлон харьцах буюу шийтгэхээс ангид байх эрх чөлөө хамаарна.

Зарим улсууд онц байдлын үеэр Үндсэн хууль болон ОБтХ-даа нэмэлт, өөрчлөлт оруулах, нөгөө зарим нь Үндсэн хуулийн хүрээнд баталгаажуулсан эрх, зохицуулалтыг ямар ч үед, хүссэн хэлбэрээр өөрчлөх зэргээр Олон Улсын Пактыг зөрчдөг.[265] Үндсэн хууль нь Засгийн газар болон хувь этгээд хоорондын гэрээ байдаг тул ИБУТЭТОУП-д нэгдэн орсон улсууд заавал дагаж мөрдөх учиртай. Өөрөөр хэлбэл, онц байдалд хамаарах асуудлын хүрээг дурааараа томьёолох боломжгүй юм. Пактад нэгдэн орсон гэдэг утгаар тус пактыг хувь этгээдээс илүү Засгийн газар биелүүлэх үүрэг хүлээх бөгөөд онц байдал зарласан тохиолдолд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад нэн даруй мэдээлнэ.

Онц байдал нь аливаа улсын Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл болдог бөгөөд зарлах журам, эрх зүйн үндэслэлийг улсууд пактад нийцүүлэн янз бүрээр зохицуулж байна.

Дэлхий даяар, ялангуяа Англи-Америкийн эрх зүйд өргөн хэрэглэгддэг АНУ-ын хууль зүйн нэр томьёоны “Блэкийн хууль зүйн толь”-д “Үндэсний онц байдал” (англ. National emergency) гэж “Үндэсний хэмжээний хямралт байдал; Холбоо болон үндэсний хэмжээнд хойшлуулшгүй бөгөөд онц арга хэмжээ авахыг шаардсан нөхцөл байдал” -ыг ойлгохоор тайлбарласан[266] байна.

Блэкийн хууль зүйн толь төдийгүй 1943 оны шүүхийн шийдвэрт тусгагдсан байдлаас үзвэл, “Онц байдал” хэмээх ойлголт нь Англи-Америкийн эрх зүйд нэлээд эртнээс хэрэглэгдэж ирсэн гэж үзэж болохоор байна. Түүнчлэн эртний Ромын эрх зүйд МЭӨ 465 оноос хэрэглэсэн ойлголт гэж үзвэл эх газрын эрх зүйн бүлийн орнуудын хувьд мөн олон жилийн түүхтэй үйл ажиллагаа гэхээр байна.

Онц байдлын төрөлд юу хамаарах талаар нэгдсэн тодорхойлолт, жагсаалт байхгүй бөгөөд улсууд үндэсний хууль тогтоомжоороо хүрээг нь томьёолж байна.

---

262 С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW (Уб, 2007), Адмон, 352 дахь тал.

263 William Smith, William Wayte and G.E.Marindin, John Murray, *A Dictionary of Greek and Roman Antiquities*, Volume 1, (London:1890), p.1052.

264 Anna Khakee, *Securing Democracy?, A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30, (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.6.

265 *Nuovi studi politici* “Declaratoria dello stato di emergenza e Consiglio supremo di difesa” (2005, n. 1/2): p. 107.

266 Henry Campbell Black, *Black’s law dictionary*, 9th edition, (Minn, St.Paul: West publishing Co, 2009), p.1122.

Байгалийн гамшиг болон тахал нь эмх замбараагүй байдал буюу төрийн эрхэд халдсан үйлдлээс ялгаатай хариу үйлдлийг шаардаж, ялгаатай үр дүнг бий болгодог. Мөн террорист халдлага нь эдийн засгийн хямрал буюу гадаадын зэвсэгт довтолгооноос ялгаатай. Энэ мэтчилэн нийгэмд гарч болох онц байдал хоорондын ялгаа нь Үндсэн хууль боловсруулагч болон энэ чиглэлээр судалгаа хийдэг эрдэмтдийн хувьд ихээхэн бэрхшээлтэй асуудал болдог байна.[267] Онц байдалд хамаарах асуудлын хүрээг тодорхойлж чадахгүй байх нь мөн онц байдлыг хуулиар зохицуулахтай холбогдсон харилцаанд эргэлзээ үүсэх үндэс болно. Дэлхий дахинд улсууд Үндсэн хуульдаа онц байдлын төрлийг зохицуулж буй хэлбэрээр нь дараах байдлаар 3 ангилж болно:[268]

- Өргөн утгаар нь зохицуулж буй (Герман, Грек, Унгар, Польш, Португаль, Испани);
- Явцуу утгаар нь зохицуулж буй (Австри, Бельги, Кипр, Чех, Дани, Финланд, Люксембург, Норвеги, Швейцарь);
- Дундаж хүрээнд зохицуулж буй (Болгарь, Эстони, Франц, Ирланд, Итали, Латви, Литва, Мальт, Нидерланд, Румын, Словак, Словени, Швед).

Дээрхээс үзвэл онц байдал гэдэгт бүхий л төрлийн ноцтой аюул, байгалийн гамшиг, дайны байдал зэргийг хамааруулах эсэхийг улс орон Үндсэн хуульдаа ялгамжтай байдлаар зохицуулж байна.[269] Гэвч энэхүү ялгамжтай байдал гэдгийн зааг ялгаа нь нэг талаас дайны байдлыг онц байдалд хамааруулах эсэх, нөгөө талаас бусад онц байдлын төрлүүдийг хамааруулах эсэх гэсэн асуудалд оршино.

Саяхныг хүртэл захиргаадалтын дэглэмд байсан буюу Эстони, Польш, Испани зэрэг улсууд Үндсэн хуульдаа онц байдлыг илүү нарийвчилсан байдлаар зохицуулсан байна. Тодруулбал, үүнийг "гурван шатлалт тогтолцоо" (англ. Three-level system) гэх бөгөөд дайны байдал, онц байдал, байгалийн гамшиг зэргийг нийлүүлэн "онцгой арга хэмжээ" буюу "онц байдал" хэмээн томьёолжээ. Гэтэл Унгарын Үндсэн хуульд зааг ялгааг нь нарийн тодорхойлоогүй ч онц байдлын таван өөр түвшинг хуульчилжээ. Тэдгээр нь дайны байдал, үндэсний хямралт байдал, онц байдал, урьдчилан сэргийлэх батлан хамгаалах байдлыг зарлах эсхүл үргэлжлүүлэх зэрэг болно.

Ирээдүйд үүсэж болзошгүй онц байдлын хэлбэр, төрлийг урьдчилан нарийн тодорхойлох боломжгүй тул улсууд ихэвчлэн Үндсэн хуульдаа "Үндсэн хуулийн дэг журамд заналхийлсэн", "нийтийн дэг журамд ноцтой заналхийлсэн", "тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд заналхийлсэн" зэрэг томьёоллоор онц байдлыг тусгажээ.[270]

Харин Монгол Улсын хувьд энэхүү ойлголт хэзээнээс нэвтэрсэн талаар түүх сөхвөл, 1940 оны БНМАУ-ын Үндсэн хуульд "онц байдал" гэсэн агуулга бүхий заалт байхгүй боловч хуулийн Хорин гуравдугаар зүйлийн 11 дэх хэсэгт "Бага хурлын чөлөө цагт хэрэв Бүгд Найрамдах Монгол Ард Улсад дайнаар довтлох буюу эсхүл харилцан туслалцаж дайран довтлогчдоос хамгаалалцахаар Олон Улсын хоорондтогтоосон гэрээний үүргийг гүйцэтгэх учир тохиолдвол Бага Хурал нь дайн бүхий байдлыг зарлах"[271] хэмээн Бага Хурлын Тэргүүлэгчдийн эрхлэх асуудлыг тогтоожээ. Өөрөөр хэлбэл, 1940 оны Үндсэн хуульд дайны байдал зарлах эрх зүйн зохицуулалт байсан боловч онц байдлын талаар тусгаагүй.

1960 оны БНМАУ-ын Үндсэн хуульд мөн "онц байдал" гэсэн ойлголт байхгүй бөгөөд гагцхүү хуулийн Гучин дөрөвдүгээр зүйлийн "р" дэх хэсэгт "БНМАУ-д халдан

[267] Anna Khakee, *Securing Democracy?, A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30, (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009), p.10.

[268] Мөн тэнд, 11 дэх тал.

[269] Мөн тэнд.

[270] Мөн тэнд, 12 дахь тал.

[271] 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, Ханнс-Зайделийн сан, (Уб, 2007), 32 дахь тал.

довтлоход буюу түүнчлэн харийн довтолгооноос харилцан бие биеэ хамгаалах талаар Олон Улсын гэрээгээр авсан үүргээ биелүүлэх хэрэгцээ тохиолдвол Ардын Их Хурлын чуулганы чөлөө цагт дайны байдал зарлана”[272] хэмээн Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн бүрэн эрхийг заасан байна.

1992 оны Үндсэн хуульд анх удаа “онц байдал” гэсэн ойлголтыг тусгаж, хуулийн Арван есдүгээр зүйлийн 2, Хорин тавдугаар зүйлийн 1-ийн 18, мөн зүйлийн 2, Хорин долдугаар зүйлийн 5, Гучин гуравдугаар зүйлийн 1-ийн 12 дахь хэсэгт тус тус уг ойлголтыг хуульчилжээ.

Ингэхдээ Улсын Их Хурлаас 1995 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ОБтХ-ийг баталж, хуулийн 3 дугаар зүйлд “Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор энэ хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэмийг онц байдал гэнэ” хэмээн тодорхойлжээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “... Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно:

1/улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;

2/Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохинуулах боломжгүй болсон” хэмээн заажээ.

Академич С.Нарангэрэлийн “Эрх зүйн эх толь бичиг” номондоо “онц байдал”-ыг “тухайн улс орны амьдралд нөлөөлөхүйц онцгой нөхцөл байдал бий болсныг эрх зүйн үүднээс тодорхойлсон нэр томьёог онц байдал гэнэ. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйд тус улсын нийт нутаг дэвсгэрт буюу түүний зарим хэсэгт Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл байдал бий болсон үед онцгой нөхцөл, түүний үр дагаврыг арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгох зорилгоор хуульд заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлаж, тэдэнд нэмэгдэл үүрэг хариуцуулан төрийн болон аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хугацаагаар тогтоосон эрх зүйн онцгой дэглэм.”[273] хэмээн тайлбарлажээ.

Дүгнэвэл, улс орнууд өөрийн орны зан заншил, иргэншил, онцлогоос шалтгаалж онц байдалд өөр өөр асуудлыг өргөн болон явцуу хүрээнд авч үзэж байна. Гэсэн хэдий ч түгээмэл байдлаар байгалийн гамшиг, гоц халдварт өвчин зэрэг шалтгааны улмаас нийгэмд аюултай нөхцөл байдал үүссэн үед онц байдал зарлахаар тогтоосон байна.

Мөн онц байдлыг тусгай журам болон салбар хуулиудаар зохицуулдаг улс орнууд байхад манай улстай адил бие даасан хуулиар зохицуулдаг улс орнууд ч цөөнгүй байна.

[272] Мөн тэнд, 106 дахь тал.

[273] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб, 2007), 353 дахь тал.

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛ

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл гэх нэр томьёог монгол хэлэнд “national security council”[274] гэх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг байна.

АНУ-ын тухайд Үндэсний аюулгүй байдал гэх ойлголтыг анх АНУ-ын ерөнхийлөгч Т.Рузвельт Панамын сувгийг нэгтгэхтэй холбогдуулан 1904 онд конгресс дээрээ хэлсэн байдаг.[275] АНУ-ын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл[276] нь үндэсний аюулгүй байдлын талаарх бүх асуудлаар Ерөнхийлөгчид зөвлөгөө өгдөг Засгийн газрын агентлаг юм. (1947 оны Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 402 дугаар зүйлд зааснаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг үүсгэн байгуулсан). Үндэсний аюулгүй байдлын зөвлөл (NSC) бол үндэсний аюулгүй байдалд хамаарах бүх асуудлаар Ерөнхийлөгчид зөвлөгөө өгөх хороо. Үүнд: дотоодын, зэвсэгт хүчний болон гадаад асуудлууд хамаарна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь Ерөнхийлөгчийн удирдаж буй Засгийн газрын удирдлагад хамаарна. Энэ нь Ерөнхийлөгчийн ахлах үндэсний аюулгүй байдлын зөвлөх болон кабинетын гишүүдээс бүрддэг.[277]

Францын Үндсэн хуульд үндэсний батлан хамгаалах асуудлыг ерөнхий сайд хариуцаж, хариуцлага хүлээнэ гэж заасан байдаг. Францын батлан хамгаалах зөвлөлийн бүрэлдэхүүнд Ерөнхийлөгч Ерөнхий сайдаас гадна гадаад хэргийн сайд , Санхүү эдийн засгийн сайд , Зэвсэгт хүчний жанжин штабын дарга нар ордог байна. Францын Ерөнхийлөгч нь АНУ-ын Ерөнхийлөгч шиг зэвсэгт хүчинд ямар нэгэн тушаал шууд өгдөггүй. Хэрэв тийм зайлшгүй шаардлага гарвал Ерөнхий сайд, Батлан хамгаалах сайд, Үндэсний батлан хамгаалах Зөвлөлтэй зөвшилцөж байж шийдвэрээ гаргадаг байна.[278]

Харин Филипин Улсын хувьд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь хоёр үндсэн хэсгээс бүрддэг бөгөөд үүнд, төрийн асуудал эрхэлсэн зөвлөл, үндэсний аюулгүй байдлын зөвлөл хамаарна. Зохих асуудлыг эрхэлсэн зөвлөл нь ерөнхийлөгчийн удирдлага дор үйл ажиллагаа явуулдаг. Уг зөвлөлд Конгрессийн ба танхимын гишүүд, бусад Засгийн газрын гишүүд болон ерөнхийлөгчийн урилгаар иргэд оролцож болдог.[279]

Филипиний Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь 1950 оны 7 сарын 1-ний өдөр Ерөнхийлөгч Quirino-ийн 330 дугаар захирамжаар анх байгуулагдсан. Үүний дараа 1986 онд бүтэц зохион байгуулалтаа шинэчилсэн байна. Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь төрийн асуудал эрхэлсэн зөвлөлийг тасралтгүй дэмжлэг үзүүлдэг байгууллага бөгөөд уг байгууллагыг үндэсний аюулгүй байдлын зөвлөх удирддаг байна.[280]

Монгол Улс 1992 оны нэгдүгээр сарын 13-нд баталсан шинэ Үндсэн хуулиараа Ерөнхийлөгчийн институцийг бий болгож, уг хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт 10 дахь заалтад Ерөнхийлөгчийн хэрэгжүүлэх бүрэн эрхийн дотор “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх” гэж заасан. 1990 оны анхны ардчилсан чөлөөт сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Бага Хурал 1992 оны 5 дугаар сарын 29-нд Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын

---

274 Мөн тэнд, 483 дахь тал.

275 Ж.Амгалан, “Үндэсний аюулгүй байдал гэсэн ойлголтыг хамаагүй ярих нь сөргөөр нөлөөлнө” (сурв. Г.Цолмон), 2015.10.27, http://unuudur.mn, (Сүүлд үзсэн 2019.05.14).

276 Henry Campbell Black, *Black’s law dictionary*, 9th edition, (Minn, St.Paul: West publishing Co, 2009), p.1125.

277 https://study.com/academy/lesson/national-security-council-definition-history-members-role.html (Сүүлд үзсэн: 2019.06.20).

278 П.Очирбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр, (Уб, 2001), 62 дахь тал.

279 http://www.nsc.gov.ph/ (Сүүлд үзсэн: 2019.06.20).

280 Мөн тэнд.

зөвлөлийн тухай хуулийг баталж уг зөвлөлийг байгуулсан юм.[281] Энэ хуулиар Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн зарчим, чиг үүрэг, бүтэц бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тодорхойлон заасан байна. Тодруулбал: "Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл нь үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн хангагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага мөн бөгөөд Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоо нь Монгол УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгч, түүний тэргүүлсэн Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Засгийн газар, үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэгтэй төрийн байгууллага, орон нутгийн өөрөө удирдах байгууллага болон холбогдох албан тушаалтнаас бүрдэнэ хэмээн заажээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь Ерөнхийлөгч бөгөөд УИХ-ын дарга, Ерөнхий сайд зөвлөлийн гишүүн байдаг. УИХ-ын дэд дарга, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга, УИХ дахь нам, эвслийн бүлгийн ахлагч нар зөвлөлийн хуралдаанд зөвлөх эрхтэй оролцдог[282] байна.

"Үндэсний аюулгүй байдал" хэмээх үгийг Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд /2001 он/ "Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байдлыг хэлнэ;" гэсэн бол Британика нэвтэрхий тольд "Аюулгүй байдлыг хүн ба эд хөрөнгийг янз бүрийн аюулаас хамгаалах арга, хэрэгслийн систем", Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал (2010 он)-д "Үндэсний аюулгүй байдал гэж Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг хангах гадаад, дотоод таатай нөхцөл бүрдсэн байхыг хэлнэ;"[283], В.И.Далийн тайлбар тольд "Аюулгүй байдал гэдэг нь аюулаас ангид байх, хадгалах чанар, найдвартай байдал", С.И.Ожеговын орос хэлний тольд "Хүн буюу ямар нэгэн юманд аюул учрахгүй байх төлөв", П.Шагнягийн Олон улсын харилцааны франц тольд "хамгаалагдсан төлөв"[284], ОХУ-ын Аюулгүй байдлын тухай хууль (1992 он)-ийн нэр томьёоны тайлбарт "Төр, нийгэм, хувь хүний амин чухал ашиг сонирхол гадаад, дотоодын аюул заналаас хамгаалагдсан байдлыг хэлнэ;" гэсэн бол академич С.Нарангэрэлийн "Эрх зүйн эх толь бичиг" номондоо "Үндэсний аюулгүй байдлын зөвлөл үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн нэгдмэл бодлого боловсруулах үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэх явдлыг уялдуулан зохицуулах, энэхүү зохицуулалт нь хэрхэн явагдаж байгаад хяналт тавих төрийн зөвлөлдөх байгууллага. Ажлаа УИХ-ын өмнө хариуцна[285] гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, дэлхийн улс орнуудын онцлог, эрх зүйн бүл, соёл, иргэншлээс хамаарч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг өөр өөр байдлаар нэрлэж байх боловч чиг үүргийн хувьд үндэсний аюулгүй байдлыг хангах, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг тэрхүү байгууллагууд нь хэрэгжүүлж байна. Тэдгээр байгууллага үндэсний аюулгүй байдлын хамтарсан хороо[286], үндэсний батлан хамгаалах зөвлөл[287], үндэсний аюулгүй байдлын зөвлөл[288] гэх мэтээр нэрлэдэг байна.

---

[281] 1992 оноос хойш Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн болон нарийн бичгийн даргаар ажиллаж байсан хүмүүсийн мэдээллийг хавсралт 5-аас дэлгэрүүлэн үзнэ үү.

[282] Л.Лүндээжанцан, Ч.Энхбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, (Уб, 2000),170 дахь тал.

[283] Мөн тэнд.

[284] Б.Өлзийхуяг, "Аюулгүй байдлын ухааны хөгжлийн асуудал", Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл, №2 (36) (2018): 18 дахь тал.

[285] С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб, 2007), Адмон, 485 дахь тал.

[286] Австрали, Ирланд гэх мэт (англ. National security committee).

[287] Армен, Бразил гэх мэт (англ. national defence council).

[288] Монгол, Эстони, Энэтхэг, Тайланд, Турк гэх мэт (англ. National security council).

ДАЙЧИЛГАА

Дайчилгаа хэмээх үгийг англи хэлний “mobilisation” хэмээх үгтэй утга дүйцүүлэн хэрэглэдэг байна. АНУ-ын Үндсэн хуулиар конгресст олгосон 2 эрх мэдлийн нэг нь АНУ гадны халдлага болон босогчдыг дарах хуулийг хэрэгжүүлэх зорилгоор зэвсэгт хүчнийг дайчлах эрх[289] бөгөөд Дайнд иргэдийн хүч шаардлагатай байгаа боловч сайн дурынхан хангалтгүй байгаа тохиолдолд хуульд заасны дагуу дайчилгаа зарлаж дайнд оролцох чадвартай хүмүүсийг дайчилгаанд хамруулдаг.[290]

Дайчилгаа (Зэвсэгт хүчинд алба хаах) анх дэлхийн 1 дүгээр дайн, 1939 онд дэлхийн 2 дугаар дайны үед анх Их Британи Улсад хэрэглэж байсан бөгөөд дэлхийн 2 дугаар дайн дуусаны дараа үндэсний албаны нэрээр нэрлэгдсэн. Дайны үед 18-аас 41 насны бүх эрэгтэйчүүдийг дайчлан дуудах боломжтой. Зэвсэгт хүчин нь анх олон нийтийн аюулгүй байдлыг хангах, үймээнийг таслан зогсоох зорилготой байсан боловч хожим нь шархадсан хүмүүсийг асрах үүргийг мөн гүйцэтгэж байсан. 1948 оны дараа 19-өөс 25 насны эрэгтэйчүүдийг 21 сараар цэргийн алба хаалгаж байсан (дараа нь 2 жил болгон нэмсэн) байна.[291]

Монгол Улсын тухайд Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд дайчилгаа зарлах тухай зарлиг гаргана. Уг зарлиг дайчилгааны ямар хэлбэрийг зарлаж байгааг, мөн дайчилгаа зарлахад хүргэсэн цэрэг, улс төрийн нөхцөл байдал, дайчилгаа явуулах нутаг дэвсгэр, дайчлах хүний тоо, насны хязгаар, цэргийн мэргэжлийн ангилал, дайчлах эд хөрөнгийн төрөл, тоо хэмжээ, дайчилгаа эхлэх хугацаа, явуулах дараалал, дайчилгааг зохион байгуулах журам зэрэг дайчилгааны арга хэмжээг явуулахад нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой бусад асуудлыг тусгана.[292]

1998 онд Дайчилгааны тухай хууль батлагдсанаар дайчилгааны эрх зүйн үндэс бүрдсэн бөгөөд 2002 онд “Улсын дайчилгааны төлөвлөгөө”-г Монгол Улсын Засгийн газрын 29 дүгээр тогтоолоор баталсан. Дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөөг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхийг “бүх нийтийн дайчилгаа”, нутаг дэвсгэрийн зарим хэсэгт дайчилгаа явуулах буюу хязгаарлагдмал зорилтыг хэрэгжүүлэхийн тулд дайчилгааны улсын нэгдсэн төлөвлөгөөний зөвхөн зарим арга хэмжээг хэрэгжүүлэхийг “хэсэгчилсэн дайчилгаа” гэнэ.[293]

Манай улсад дайчилгааны зарлан мэдээллийн систем нь:

1. Дайчилгааг нууцаар зарлах:

- Үндсэн арга – Электрон дайчилгааны систем буюу телефон холбооны хэрэгсэл /гэр, ажлын болон үүрэн телефон/ эсхүл факсаар зарлан мэдээллийг явуулна. Иймээс цэргийн үүрэгтний хувийн мэдээлэл ялангуяа холбоо барих утасны дугаар чухал ач холбогдолтой. Цэргийн бэлтгэн үүрэгтэн нь цэргийн үүрэгтний нэгдсэн портал сайтаар дамжуулан хувийн мэдээллээ байнга тодотгох шаардлагатай.
- Нөөц арга – Цэргийн бэлтгэх үүрэгтэнд зарлан мэдээллийг үндсэн аргаар хүргэж чадаагүй тохиолдолд дайчлах тушаал эсхүл дайчлан дуудах мэдэгдлийг гэрийн хаягаар нь хүргэдэг.
- Дайчлах тушаалыг зөвхөн дайны аюул бодитойгоор нүүрлэсэн тохиолдолд өгөх ба дайчлан дуудах мэдэгдлийг сургуулийг журмаар дайчилгаа зарлахад хэрэглэдэг.

---

[289] Henry Campbell Black, *Black’s law dictionary*, 9th edition, (Minn, St.Paul,: West publishing Co, 2009), p.1083.

[290] https://www.vocabulary.com/dictionary/conscription (Сүүлд үзсэн: 2019.06.20).

[291] Мөн тэнд.

[292] Б.Эрдэнэчимэг, Улсын дайчилгааны төлөвлөлт, түүний нийгэм эдийн засгийн ач холбогдол, Батлан хамгаалах судлал сэтгүүл, №7 (17), (2007), 50 дахь тал.

[293] Мөн тэнд.

2. Дайчилгааг илтээр зарлах:

- Олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэл тухайлбал, телевиз радиогоор дайчилгааны зарлан мэдээллийг бүх нийтэд зориулан илтээр явуулна. Зарлан мэдээллийг хүлээн авмагц цэргийн бэлтгэл үүрэгтэн нь цэргийн дүрэмт хувцас, хэрэглэлтэйгээр нэн даруй өөрийн томилгоот дайчилгааны төвд очих үүрэгтэй байдаг байна.[294]

Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид "Дайчилгаа" хэмээх үгийг дараах байдлаар тодорхойлж ирсэн байна. Тухайлбал, Дайчилгааны тухай хуульд "Дайчилгааг улс орны эдийн засаг, нийгмийг шаардлагатай үед дайны байдалд шилжүүлэх, зэвсэгт хүчнийг өргөтгөн зохион байгуулахын тулд дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа цогц арга хэмжээ"[295] гэсэн бол Цэргийн нэр томьёоны тайлбар тольд "...зэвсэгт хүчнийг байлдааны бэлэн байдалд оруулах, улс орны төрийн болон төрийн бус байгууллагууд, эдийн засгийг дайны байдалд шилжүүлж, дайнд шаардагдах өөрийн цэргийн хяналтын цогц арга хэмжээ".[296] гэжээ. Мөн Ч.Энхбаатар нарын "Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар" номонд "Цэргийн дайчилгаа зарлана гэдэг нь онц байдал болон дайны байдалтай болсон буюу бусад онцгой нөхцөл байдалтай холбогдсон гарцаагүй шаардлагатай үед хийгддэг. Цэргийн дайчилгаа гэдэгт зөвхөн цэргийн насны эрчүүд хамаардаг төдий ухагдахуун биш хүмүүсийн, хөдөлмөрийн, эд материалын зэрэг бүхнийг хамарсан дайчилгаа байдаг.[297] "Улс орны эдийн засаг, нийгмийг дайны байдалд шилжүүлэх, зэвсэгт хүчнийг байлдааны цагийн орон тоогоор нөхөн хангахын тулд дайчилгааны бэлтгэх нөөцийн бүрэлдэхүүн, дайчилгааны болон санхүүгийн нөөцийг дахин хуваарилах зорилгоор төр, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас хуулийн дагуу авч хэрэгжүүлж байгаа цогцолбор арга хэмжээг "дайчилгаа" гэнэ"[298] гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, тус нэр томьёог ихэнх улс орон хэрэглэдэг бөгөөд цэргийн дайчилгаа зарлах үндэслэл улс орон бүрт ялгамжтай хэдий ч түгээмэл байдлаар нийтийг хамарсан үймээн самуун даамжирч, зэвсэгт мөргөлдөөн үүсэх нөхцөл бий болсон, зэвсэгт мөргөлдөөн үүссэн тохиолдолд дайны байдал зарлан цэргийн дайчилгаа зарладаг байна. Мөн тухайн улс орны хүн ам, насны байдлаас шалтгаалан дайчилгаа зарлахдаа бүх эрэгтэйчүүд /тухайн улсын хуулиар тогтоосон насны бүх эрэгтэйчүүд/-ийг хамруулж болдог байна.

ДАЙНЫ БАЙДАЛ

Дайны байдал гэх нэр томьёог англи хэлний "State of war" болон "belligerence" гэх хоёр өөр янзаар утга дүйцүүлэн хэрэглэдэг байна. Дайны байдал гэдэг үг нь утгын хувьд хоёр улсын хооронд зэвсэгт мөргөлдөөн үүсч бий болсон эсхүл албан ёсоор дайн зарлаагүй боловч дайсагнасан шинжтэй байгаа үе эсхүл хууль ёсны дагуу зарласан болон зайлшгүй байдлаар зэвсэгт мөргөлдөөнд оролцсон, Дайн үргэлжлэх нөхцөл байдал бий болсон зэрэг үеийг ойлгодог байна. Анх 1928 онд 15 улс Парисын гэрээгээр хоорондьн харилцаа, үл ойлголцох явдлаа дайны аргаар зохицуулахаас татгалзсан нь дайныг хориглосон анхны олон талт гэрээ[299] болсон

[294] Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан, (Уб, 2018), Хууль зүйн үндэсний хүрээлэн, 14-15 дахь тал.

[295] Дайчилгааны тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, №6,(1998).

[296] Цэргийн нэр томьёоны тайлбар толь, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн, (Уб:, 2014), 138 дахь тал.

[297] ХБНГУ-н Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2009).177-178 дахь тал.

[298] Мөн тэнд, 168 дахь тал.

[299] Олон Улсын нийтийн эрх зүй /гарын авлага/, 51 дэх тал.

юм.

ХБНГУ-ын Үндсэн хуулийн “10 А” Үндэсний аюулгүй байдал гэх бүлэгт онцгой нөхцөл буюу үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн нөхцөл бий болсон хууль тогтоох эрх мэдэл хамтарсан хороо буюу парламентын дээд, доод танхимаас бүрдсэн институцэд шилжихээр зохицуулсан.

Дайны байдал үүссэн үед, Үндсэн хуулийн холбогдох зохицуулалтаас хамааран парламент нь шийдвэр гаргах явцад дараах гурван аргаар оролцож болно (ач холбогдол нь буурах дараалаар):

1. Үндсэн хуулиар дайн зарлах, энх тайван тогтоох эрхийг парламентад олгосон байх. Гэхдээ өнөөдөр бодит амьдрал дээр аливаа дайн мөргөлдөөн ямар нэг анхааруулгагүйгээр эхлэх нь олонтаа бөгөөд парламент шийдвэр гаргахаас өмнө үйл явдал өрнөх магадлалтай тул энэ нөхцөл харьцангуй хийсвэр юм.
2. Үндсэн хуулийн дагуу гүйцэтгэх засаг нь дайн зарлах, энх тайван тогтоохын өмнө парламентаас шуурхай зөвшөөрөл авах. Ийм заалт нь байлдааны ажиллагаа эхлүүлэх, хилийн чанадад цэргийн ажиллагаа явуулахаас өмнө асуудлыг хэлэлцэх боломжийг парламентад олгоно.
3. Үндсэн хуульд дайн зарлах шийдвэрийг парламентаас урьдчилан зөвшөөрөл авалгүй, зөвхөн мэдэгдэхээр заасан байх. Ихэнх орны Үндсэн хуульд чухам ингэж заасан байдаг.[300]

Дайн зарласнаар эрх зүйн үүднээс дайны байдал үүснэ. Дайн эхэлснээр дайтагч талуудын хооронд энхийн харилцаа зогсож дипломат болон консулын харилцаа тасардаг бөгөөд дайтагч улсад шууд хамаарах хөрөнгө (дипломат болон консулын газрын төлөөлөгчийнхөөс бусад)-ийг хураадаг. Байлдаан болж байгаа газрыг дайны талбар гэж нэрлэдэг. Дайн эхэлснээр дайтаж байгаа улсуудын хоорондын гэрээ хэлэлцээрийн үйлчлэлд нөлөө үзүүлдэг боловч олон талт гэрээний хувьд тэдгээр улсын хувьд бүр мөсөн зогсоно гэж үздэггүй. Дайтаж байгаа улс, түүний иргэдийн эрх ашгийг нөгөө дайтаж байгаа улсад төлөөлөх ажлыг уг талуудтай дипломат харилцаатай гурав дахь улс гүйцэтгэж болдог бөгөөд үүнийг голдуу төвийг сахисан улс гүйцэтгэдэг. Орчин үед дайн өдөөх нь олон улсын эрх зүйн хэм хэмжээг зөрчиж гэмт хэрэг үйлдсэнд тооцдог.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно” гэжээ.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс дайн бүхий байдал зарлах нөхцөл бүрэлдсэн тухай оруулсан санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч өргөн мэдүүлснээр УИХ хэлэлцэж, дайн бүхий байдал зарлах эсэх талаар шийдвэр гаргадаг.

“Дайны байдал” хэмээх үгийг Монгол Улсын хууль тогтоомж болон бусад эх сурвалжид эрдэмтэн, судлаачид дараах байдлаар тайлбарлажээ.

Манай улсын хувьд дайны байдал, дайн бүхий байдал хэмээх нэр томьёог өөр өөр утгаар тайлбарлан хэрэглэж байна. Тодруулбал: Дайны байдлын тухай хуульд /1995 он/ “Дайны байдал гэж Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхцөл бий болох үед төрийн эрх барих дээд байгууллагаас Монгол Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт тогтоох улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүйн,

[300] Аюулгүй байдлын салбар дахь парламентын хяналт, Зарчим, механизм, үйл ажиллагаа, 119-120 дахь тал.

цэргийн онцгой дэглэмийг хэлнэ” гэсэн бол Дайн бүхий байдлын тухай хуульд /1998 он/ “...дайн бүхий байдал” гэж Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд аюул занал учруулж, зэвсэглэн халдсан улс,түүний холбоотонтой дайн бүхий байдал зарласан мөчөөс түүнийг цуцлах хүртэл харилцах харилцааны онцгой хэлбэрийг хэлнэ” гэж ялгамжтай байдлаар тайлбарлажээ. Мөн академич С.Нарангэрэл “Эрх зүйн эх толь бичиг” номондоо “англ. Military situation; ор. Военное положение – 1. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүйд улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал аюул заналхийлэл учруулж, зэвсэглэн халдсан улс, түүний холбоотонтой зарласан харилцааны онцгой хэлбэр, 2. Олон улсын эрх зүйд олон улсын буюу дотоодын шинж чанартай зэвсэгт мөргөлдөөн. Дотоодын мөргөлдөөний үед эл нэр томьёог бага хэмжээний бослого, үймээн төдий биш харин цар хүрээ нь өргөжиж, дайны байдал бий болсныг тухайн улс хүлээн зөвшөөрсөн үед хэрэглэнэ. Олон улсын шинж чанартай зэвсэгт мөргөлдөөнд оролцогч улсууд энэхүү мөргөлдөөний цар хүрээ өргөжин дайны байдал буй болсныг хүлээн зөвшөөрсөн үед хэрэглэнэ. Ингэснээр олон улсын эрх зүйн хэм хэмжээ үйлчилж эхэлнэ;”[301] хэмээсэн бол “Цэргийн шинэчлэл” сэтгүүлд “Дайн гэдэг нь нийгмийн (геополитикийн) субъектүүдийн шинэ зорилго болон байр суурийн (хуучнаа бэхжүүлэх) төлөөх тэмцэлд хүрсэн ялалтаа бэхжүүлэх тэдний шинэ бүтэц, зураглал бий болгож, түүнийгээ удирдах зорилгыг тодорхойлсон нийгмийн үйл явц юм;”[302], “Дайн гэдэг нь өөрийн ашиг сонирхлын тулд нөөцийн хуваарилалт болон эсрэг талын боломжийг өөрчлөх зорилгоор нийгмийн нэг хэсэг субъект нөгөө хэсэг субъектын эсрэг зорилго чиглэл, зохион байгуулалттай хүч хэрэглэх үйл явц юм”[303] гэж тус тус тайлбарлажээ.

Дүгнэвэл, үгийн утга агуулгын хувьд нийтлэг ойлголттой ч тайлбар талаасаа харилцан адилгүй байгаа нь харагдаж байна. Дайны байдал гэдэгт улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал аюул заналхийлэл учруулж, зэвсэглэн халдсан улс, түүний холбоотонтой зарласан харилцааны онцгой хэлбэрийг ойлгож болохоор байгаа бөгөөд гагцхүү энэ бослого үймээнээс өргөн цар хүрээг хамарсан байх шаардлагатай.

ДҮГНЭЛТ

Улс орон бүрийн эрх зүйн тогтолцоо, эрх зүйн хөгжил өөр байдагтай холбоотойгоор хууль зүйн нэр томьёо харилцан адилгүй зарим тохиолдолд үгийн тодорхойлолт ойлголт хүртэл өөр байдлаар хэрэглэгддэг тул нэр томьёоны асуудал нь байнгын судалгаа шинжилгээ шаардлагатай, судлаачдаас олон талын мэдлэг шаардсан нарийн ажил билээ.

Хууль зүйн нэр томьёо нь хууль зүйн техникийн нэг элемент бөгөөд хэм хэмжээг боловсруулахад хэрэглэдэг мэргэжлийн онцлог бүхий үгийн сан юм. Энэ ч үүднээс тус нэр томьёо нь хууль зүйн шинжлэх ухааны ойлголт ухагдахууныг үгээр томьёолсон хэлний элемент бөгөөд мэдлэг мэдээллийг дамжуулах хэрэгсэл болдог. Тиймээс хууль зүйн тодорхой нэг ухагдахууныг тухайн нэр томьёо нь ямар нэг салаа утгагүйгээр илэрхийлдэг байх шаардлагатай. Өөрөөр хэлбэл, нэр томьёоны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь тодорхойлолт юм.

Сүүлийн жилүүдэд хууль зүйн нэр томьёог судлах, цэгцлэх, жигдрүүлэх талаар эрдэмтэн, судлаачид нэлээд ажлыг хийж, судалгааны цөөнгүй бүтээл хэвлэгдэн гарчээ. Хууль зүйн үндэсний хүрээлэн ч мөн энэхүү ажилд хувь нэмрээ оруулах үүднээс 2016-2026 оны Хөгжлийн стратеги хөтөлбөртөө “Хууль зүйн эрдэм шинжилгээ, судалгааны ажлын удирдлага, зохион байгуулалт, арга зүй, дэд бүтцийг боловсронгуй болгох замаар судалгааны чанар, үр нөлөөг дээшлүүлж, хууль зүйн

[301] С.Нарангэрэл, Монголын эрх зүйн эх толь бичиг, (Уб: 2015), Адмон, 164 дэх тал.

[302] Р.Сүхбат, Дайны тухай онол ба орчин үеийн дайны агуулга хувьсал өөрчлөлт, онцлогийг шинжих нь, Цэргийн шинэчлэл сэтгүүл, №3 (51) (2013), 11 дэх тал.

[303] Мөн тэнд.

шинжлэх ухааныг хөгжүүлэх” зорилт дэвшүүлсэн. Уг зорилтын хүрээнд хууль зүйн нэр томьёог жигдрүүлэх, нэгдмэл сантай болох арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан бөгөөд энэхүү арга хэмжээний хүрээнд хийгдэх нэг ажил нь хууль тогтоомжийн нэр томьёоны судалгаа хийх юм. Тус ажил нь цаашид тасралтгүй үргэлжлэн хийгдэх нэлээд томоохон ажил бөгөөд бидний зүгээс энэ удаа Монгол Улсын Үндсэн хуулийн Ерөнхийлөгчийн институттэй холбогдох нэр томьёоны талаар судалгаа хийхээр зорьсон билээ.

Судалгааг шинжлэх ухааны хэд хэдэн арга зүйд тулгуурлан хийхийг оролдсон бөгөөд хууль зүйн болон хэл шинжлэлийн эрдэмтэн, судлаачдын бүтээлээс аль болох иш татахыг хичээлээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн 30-37 дугаар зүйлээс нийт 16 нэр томьёог сонгон авч судалгаа хийхээр хамтрах хүрээгээ тогтоож, эдгээр нэр томьёог Монгол Улсын эрдэмтэн судлаачид, болон бусад улсын эрх зүйн толь бичиг хууль тогтоомжид ямар агуулгаар хэрхэн хэрэгжиж байгаа талаар судаллаа. Зарим нэр томьёонд англи хэлний хэд хэдэн үгтэй утга дүйцүүлэн хэрэглэх, үгийн утгыг хэт явцуурруулах, өргөжүүлэх гэсэн асуудлууд байсаар байна. Тухайлбал: “бүрэн эрх” хэмээх нэр томьёог англи хэлний “authority” болон “sovereign” гэх үгтэй, “онц байдал” хэмээх нэр томьёог англи хэлний “state emergency”, “national emergency”, “state of defence” гэх байдлаар утга дүйцүүлэн хэрэглэж байгаа бол “зөвшилцөх” хэмээх нэр томьёог “санал нэгтэйгээр буюу эсрэг саналгүйгээр шийдэлд хүрнэ гэсэнтэй ойролцоо утгатай” мөн “эрх бүхий байгууллага батлан гаргах актын төсөл, эсхүл аль нэг албан тушаалд томилохоор нэр дэвшүүлсэн хүний талаар нөгөө байгууллагаас урьдчилан санал дүгнэлт авах ажиллагаа юм” гэх зэргээр өөр өөр байдлаар тайлбарлаж хэрэглэх ч тохиолдол байсаар байгаа нь ажиглагдлаа.

Аливаа нэр томьёо нь нийгмийн хөгжлөө дагаад хувьсан өөрчлөгдөх, шинээр бий болохыг үгүйсгэхгүй ч цаашид хууль зүйн нэр томьёог жигдлэх үүднээс нэр томьёоны хэрэглээ, орчуулгад баримтлах журам боловсруулах, хууль зүйн нэр томьёоны судалгаан дахь эрдэмтэн, судлаачдын оролцоог сайжруулах, эрдэмтэн, судлаачид тус тусдаа биш, нэгдэн нийлж хууль зүйн тайлбар толь бичиг гаргах, үүнийгээ тогтмол баяжуулж, сайжруулан ажиллах шаардлагатай гэж үзэж байна.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЛЫН ТӨВ
www.parliament.mn

НОМ ЗҮЙ

Монгол Улсын хууль тогтоомж:

- Монгол Улсын Үндсэн хууль, /1992/.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хууль, /1993/.
- Монгол Улсын Их Хурлын тухай хууль /2006/.
- Сонгуулийн тухай хууль, /2015/.
- Дайчилгааны тухай хууль, /1998/.
- Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, /2016/.
- Онц байдлын тухай хууль, /1995/.

Гадаад улсын хууль, тогтоомж

- АНУ-ын Үндсэн хууль, /1787/.
- Аргентин Улсын Үндсэн хууль, /1853/.
- БНСУ-ын Үндсэн хууль, /1948/.
- Бразил Улсын Үндсэн хууль, /1988/.
- Исланд Улсын Үндсэн хууль, /2011/.
- Испани Улсын Үндсэн хууль, /1978/.
- Итали Улсын Үндсэн хууль, /1947/.
- Ирак Улсын Үндсэн хууль, /2005/.
- Литва Улсын Үндсэн хууль, /1992/.
- Мексик Улсын Үндсэн хууль, /1917/.
- ОХУ-ын Үндсэн хууль, /1993/.
- Пакистан Улсын Үндсэн хууль, /1973/.
- Португал Улсын Үндсэн хууль, /1976/.
- Румын Улсын Үндсэн хууль, /1991/.
- Унгар Улсын Үндсэн хууль, /2011/.
- Франц Улсын Үндсэн хууль, /1958/.
- Япон Улсын Үндсэн хууль, Орч. П.Амаржаргал (Уб, 2011)

Ном, өгүүлэл, нийтлэл:

- Ж.Амарсанаа, Эрх зүйн мэдлэгийн товч толь, (Уб, 1986).
- Ж.Амарсанаа, Монгол улсын Үндсэн хуульд орсон харь үг, (Уб, 2013).
- Ж.Амарсанаа нар Хууль зүйн тайлбар толь, (Уб, 2003).
- Ж.Амарсанаа нар Англи- Солонгос- Монгол- Орос- Герман – Хууль зүйн толь, (Уб, 2011).
- Ж.Амарсанаа, *Англи-орос-герман-монгол Олон улсын эрх зүйн толь*, (Уб, 2004).
- Ж.Амарсанаа, Монгол Улсын Үндсэн хуульд орсон харь үг, (Уб, 2014).
- П.Амаржаргал, Парламентын хууль тогтоох бүрэн эрх ба Ерөнхийлөгчийн хориг, *Хууль дээдлэх ёс,* №2, (2014),
- П.Амаржаргал. “УИХ-ын хууль тогтоох үйл ажиллагаан дахь Ерөнхийлөгчийн

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.mn.gov.mn

оролцоо, хууль тогтоомжид тавих хориг" Үндсэн хуульт ёс ба Ерөнхийлөгчийн бүрэн эрх сэдэвт олон улсын онол-практикийн бага хурал. (Уб, 2015).

- Т.Азжаргал, "Үндсэн хуулийн дэг журам зөрчсөн үйлдэлд Үндсэн хуулийн эрх зүйн хариуцлага оногдуулах үндэслэл журам", Хүний эрх онол арга зүйн сэтгүүл, №2, (2015).
- *Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн,* Цэргийн нэр томьёоны тайлбар толь, (Уб, 2014).
- Д.Гангабаатар, "Үндсэн хуулийн эрх зүйн нэр томьёог цэгцлэх асуудал", Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ, эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, (Уб, 2016).
- Т.Ганхуяг, Зөвшилцөл, (Уб, 2003).
- Т.Гантулга, Улс төрийн зөвшилцлийн онол-практикийн асуудал, (Уб, 2000).
- Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүйн удиртгал,* (Уб, 2012).
- Я.Долгоржав "Онол, практикийн бага хурлыг нээж хэлсэн үг" Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь онол практикийн бага хурал (Уб, 2003).
- Л.Дамбадорж, *Орчин үеийн англи-орос-монгол толь,* (Уб, 2004).
- Ч.Лувсанжав, Ц. Сумъяа, English- Mongolian Dictionary, (Уб,1990).
- Л.Лүндээжанцан, Ч.Энхбаатар, Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй, (2000).
- О.Машбат, Үндсэн хууль, улс төр-хянал-тэнцэл, (Уб, 2015).
- Г.Мөнхболд, Г.Мөнхтулга. Ерөнхийлөгчийн хориг, (Уб, 2018).
- М.Мөнхбат, Олон улсын гэрээний эрх зүй, (Уб, 2017).
- Монгол Улсын төрийн байгуулал дахь засаглалын институтийн талаарх судалгаа, (Уб, 2018),
- С.Нарангэрэл, Эрх зүйн эх толь бичиг Dictionary of LAW, (Уб, 2015).
- *С.Нарангэрэл, Хууль зүйн судлалын англи-монгол тайлбар толь,* (Уб, 2005).
- П.Очирбат, Монгол Улсын Үндсэн хууль /хэрэгжилт, хяналт, судалгаа/, (Уб, 2017).
- Олон Улсын нийтийн эрх зүй, /гарын авлага/
- П.Очирбат, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Үндсэн хуулийн бүрэн эрх анхны зам мөр, (Уб, 2001),
- Б.Өлзийхуяг, аюулгүй байдлын ухааны хөгжлийн асуудал, Аюулгүй байдал, батлан хамгаалах судлал сэтгүүл, №26, (36) (2018).
- Ц.Сарантуяа, Үндсэн хуулийн процессын эрх зүй: суурь ойлголт, тулгамдсан асуудал, (Уб, 2005).
- Г.Совд нар, Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб,2000).
- Д.Солонго, Төрийн эрх зүйн тайлбар толь, (Уб, 2003).
- Ц.Сарантуяа, "Монгол Улсын хууль зүйн нэр томьёо судлал: сургамж ба шийдэл",
- Т.Сэнгэдорж "Монгол Улсын хууль зүйн нэр томьёо судлал: сургамж ба шийдэл", Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ, эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, (Уб,2016).
- О.Сүхбаатар, Монгол хэлний харь үгийн толь, (Уб,2018).
- Я.Төгөлдөр, "Монгол Улсын төрийн тогтолцоон дахь Ерөнхийлөгчийн

Хуулийн мэдээлэл www.nli.gov.mn

институтийн байр суурь эрх мэдлийн хэрэгжилтийн шинжилгээ", Монгол Улсын Төрийн байгуулал дахь засаглалын инстутын талаарх судалгаа (судалгааны эмхэтгэл), (Уб, 2018).

- Д.Ундралсайхан, Орчин үеийн олон улсын эрх зүй, (Уб, 2016).
- Э.Уранчимэг, Монгол хэлний шинэ үг, хэллэгийн толь, Монгол хэл соёл 13, (Уб, 2014).
- Үндсэн хуульт ёсны төлөвшил, цаашдын хандлага:Олон улсын эрдэм шинжилгээний бага хурал. (Уб, 2012).
- Ханнс-Зайделийн сан, 1924, 1940, 1960, 1992 оны Үндсэн хуулиуд, (Уб, 2007).
- ХБНГУ-н Ханнс Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, Эрх зүйн боловсрол академи, Монгол улсын Үндсэн хуулийн тайлбар, (Уб, 2009).
- Хууль зүйн үндэсний хүрээлэн, Дайчилгааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах үнэлгээний тайлан, (2018).
- Хууль зүйн үндэсний төв, "Хуулийн нэр томьёоны дагалга", (Уб,2004).
- Ш.Цогтоо, Ерөнхийлөгчийн институт ба Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал, Эрх зүй сэтгүүл, №2, (2014).
- П.Цагаан, Хууль зүйн латин, англи, орос монгол толь, (Уб, 2013).
- Я.Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, (Уб, 1966).
- Ш.Цогтоо, Үндсэн хуулийн 7 нэмэлт, өөрчлөлт ба Үндсэн хуулийн нэмэлтэд хориглох, хязгаарлах хэм хэмжээ /онол, практик/, Хууль дээдлэх ёс сэтгүүл, (Уб, 2018),
- Б.Чимид, Төр, нам, эрх зүйн шинэтгэлийн эгзэгтэй асуудал, (Уб, 2008).
- Б.Чимид, Үндсэн хуулийн мэдлэг, (Уб, 2008).
- Б.Чимид, Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлох нь (төслийн багийн судалгааны ажлын тайлан), (Уб, 2005),
- Ш.Чоймаа нар, Монгол хэлний хадмал толь, (кирил- монгол- тайлбар), (2011).
- Б.Чимид, "Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал" Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь онол практикийн бага хурал (Уб, 2003).
- Ш.Чоймаа нар, Монгол хэлний хэлзүйн толь бичиг I боть, Монгол Улсын Их Сургуулийн Монгол Судлалын Төв, (Хөх хот, 2006).
- Ч.Энхбаатар нар, Монгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг, (Уб, 2015).
- Ч.Энхбаатар, *Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын төрийн эрх зүй,* (Уб, 2009).
- Ч.Энхбаатар, Монгол Улсын төрийн тогтолцоо: Эрх зүйн зохицуулалт, улс төрийн практик, Үндсэн хуулийн эрх зүйн тулгамдсан асуудал онол, арга зүй,хэрэгжилт, (Уб, 2017).
- Ч.Энхбаатар нар, Монгол Улсын төрийн байгуулалтын өнөөгийн тогтолцоо, түүнийг цаашид төгөлдөржүүлэх боломж, арга зам судалгааны тайлан, Удирдлагын академи, (Уб, 2011).
- Б.Эрдэнэчимэг, Улсын дайчилгааны төлөвлөлт, түүний нийгэм эдийн

Хууль зүйн үндэсний хүрээлэн www.jus.gov.mn

засгийн ач холбогдол, Батлан хамгаалах судлал сэтгүүл, №7, (17) (2007).

Гадаад хэл дээрх ном, өгүүлэл, нийтлэл.

- Anna Khakee, *Securing Democracy? A Comparative Analysis of Emergency Powers in Europe*, Policy Paper No.30 (Geneva: Geneva Centre for the Democratic Control of Armed Forces, 2009).
- Allan Gibbard "Manipulation of voting schemes: A general result", *Econometrica* 41 (4) JSTOR,
- Bryan A. Garner, Black law dictionary, 8th.ed,(2004).
- Bryan A. Garner, *9th edition Black's law dictionary*, (West publishing Co.),
- Christian Tomuschat and David P.Currie, Donald P.Kommers in cooperation with the language service of the German Bundestag, Basic Law for the Federal Republic of Germany,
- Dieter Nohlen, Philip Stцver, *Elections in Europe: A Data Handbook,* (Baden-Baden: Nomos, 2010).
- David Marrani, The Importance of the Symbolic Role of the Head of State, European Journal of Law Reform, (13) (2011).
- "Declaratoria dello stato di emergenza e Consiglio supremo di difesa" *Nuovi studi politici* (gennaio-giugno 2005, n. 1/2).
- Eric Pacuit, "Voting Methods", *The Stanford Encyclopedia of Philosophy* (Fall 2017 Edition), Edward N. Zalta (ed.),
- E.B.Fryde, Handbook of British Chronology, Cambridge University Press (Cambridge,1941, 1961, 1986).
- Gaspard Thйodore Comte de Mollien, Hanti ou Saint-Domingue, Vol 2. (Paris: L'Harmattan, 2006).
- Henry Campbell Black, Black's law dictionary, 4th edition, West publishing Co, (St.Paul, Minn, 1968)
- Henry Campbell Black, *Black's law dictionary*, 9th edition (St.Paul, Minn: West publishing Co, 2009).
- Jonathan Law, *A Dictionary of Law, 7th edition*, Oxford University Press, (2009)
- Joanne Foakes, The Position of Heads of State and Senior Officials in International Law, Oxford University Press, (UK Oxford, 2014).
- Keith E.Whittington, Bill Clinton was no Andrew Johnson, Comparing two impeachments, *Journal of constitutional law*, Vol.2:2
- Lewis Wood, "Mr.President Is correct", New York Times, (May 13, 1945)
- MS Shugart, "Comparative Executive–Legislative Relations"
- The Oxford handbook of political institutions (PDF), (Сүүлд үзсэн: 2019.05.08)
- Oxford dictionary of law, 6th.ed,(2006).
- Sir Arthur Watts, "Heads of State" In Wolfrum, Rьdiger (ed.), Max Planck Encyclopedia of Public International Law, Oxford University Press (Oxford,2010),
- Raymond Kuhn "The French presidential and parliamentary elections", *Representation* Vol. 39, (2002),
- William Smith, William Wayte and G.E.Marindin, *A Dictionary of Greek and Roman Antiquities*, Volume 1. (London: John Murray, 1890).

Хуулийн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

Орчуулгын ном

- *Англи-Монгол толь,* (Oxford University Press and Monsudar Publishing 2006).
- Х. Виктор Кондэ, Хүний эрхийн олон улсын нэр томьёоны гарын авлага, НҮБХХ, (Уб, 2002).
- Кристофер Осаке, Харьцуулсан эрх зүй судлал: Ерөнхий ба тусгай анги бүдүүвч, (Уб, 2005).
- Роналд Дворкин, Хуулийн эзэнт гүрэн, (Уб, 2015).

Цахим хаяг

- Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем www.legalinfo.mn
- The Queen's role in Canada, Royal Household, http://www.royal.gov.uk/MonarchAndCommonwealth/Canada/TheQueensroleinCanada.aspx
- Electoral Reform Society "Two-Round System", https://www.electoral-reform.org.uk/voting-systems/types-of-voting-system/two-round-system/
- Монгол хэлний их тайлбар толь. https://mongoltoli.mn/dictionary/detail/110788
- Pocket veto https://www.senate.gov/reference/glossary_term/pocket_veto.htm / last visited 2019.05.13/
- Summary of Bills Vetoed, 1789-present https://www.senate.gov/reference/Legislation/Vetoes/vetoCounts.html
- Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь, http://toli.gov.mn/l/
- https://president.mn/mongol-khelnii-zuv-bichih-durmiin-juram/
- http://legal.un.org/ilc/texts/instruments/english/conventions/9_2_1963.pdf,

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЛЭН
www.nli.gov.mn

ХАВСРАЛТ 1

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системээс “Нэр томьёо” гэсэн холбоо үгээр хайлт хийж үзэхэд үр дүнд нь бүх үг орсон 185 эрх зүйн акт, “Нэр томъёо” гэсэн холбоо үгээр хайлт хийж үзэхэд үр дүнд нь бүх үг орсон 197 эрх зүйн акт олдож байна.[304]

Энэ мэтчилэн Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар бүлгийн хоёр дахь хэсгийн 30, 31 дүгээр зүйлд тусгасан дараах үгсийг эрх зүйн нэгдсэн системээс хайж үзэхэд доорх үр дүн гарч байна. Үүнд:

Д/д	Хайлт хийх үг	Эрх зүйн акт												
		МУ-ын хуулль	УИХ-ын тогтоол	МУ-ын ОУГ	Ерөнхийлөгчийн зарлиг	ҮХЦ-ийн шийдвэр	УДШ-ийн тогтоол	УИХ-аас томилогдог байгууллагын дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны шийдвэр	ЗГ-ын тогтоол	Сайдын тушаал	ЗГ-ын агентлагийн даргын тушаал	Аймаг нийслэлийн ИТХ-ын шийдвэр	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж	Нийт илэрцийн тоо
1.	Ерөнхийлөгч	145	192	99	185	79	13	11	142	13	1			790
2.	Төрийн тэргүүн	8	2	55		4			1					20
3.	Ерөнхийлөгчийн сонгууль	8	2			4	1							15
4.	Хоёр шаттай	3												3
5.	Анхан шатны сонгууль	4												4
6.	Анхны санал хураалт	3				1								4
7.	Дахин санал хураалт	5	1			3								9
8.	Тангараг өргөх	22	11	11	5									39
9.	Зарлиг	30	35	11	172	43	5		51	2				339
10.	Огцруулах	28	15	22		27	2							74
11.	Бүрэн эрх	238	96	998	7	176	47	1	30			1	1	695
12.	Хориг	281	69	1113	33	132	50		101	20		5	6	780
13.	Зөвшилцөх	14	6	115	11	7	2		2	1				48
14.	Итгэмжлэх жуух бичиг	1		11										2
15.	Онц байдал	13	2	55	11	3	1		1					26
16.	Үндэсний аюулгүй байдал	36		77	3	17	2		1					66
17	Дайчилгаа	40	3	33	11	1	2		12				2	64
18.	Дайны байдал	27	1	22		10								40

[304] https://www.legalinfo.mn/advenced-search

www.nli.gov.mn

ХАВСРАЛТ 2

“Ерөнхийлөгч” гэсэн томьёоллоор төрийн тэргүүнээ илэрхийлж буй улс орны жагсаалт

Африк тив	
1.	Алжир: Бүгд Найрамдах Ардчилсан Алжир Ард Улсын Ерөнхийлөгч
2.	Бенин: Бүгд Найрамдах Бенин Улсын Ерөнхийлөгч
3.	Ботсвана: Бүгд Найрамдах Ботсвана Улсын Ерөнхийлөгч
4.	Камерун: Бүгд Найрамдах Камерун Улсын Ерөнхийлөгч
5.	Египт: Арабын Бүгд Найрамдах Египет Улсын Ерөнхийлөгч
6.	Этиоп: Холбооны Бүгд Найрамдах Ардчилсан Этиоп Улсын Ерөнхийлөгч
7.	Гана: Бүгд Найрамдах Гана Улсын Ерөнхийлөгч
8.	Зааны ясан эрэг улс: Бүгд Найрамдах Кот-Дивуар Улсын Ерөнхийлөгч
9.	Либери: Бүгд Найрамдах Либери Улсын Ерөнхийлөгч
10.	Сенегал: Бүгд Найрамдах Сенегал Улсын Ерөнхийлөгч
11.	Сейшель: Сейшелийн Ерөнхийлөгч
12.	Сьерра-Леон: Сьерра-Леоны Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч
13.	Сомали: Сомалийн Ерөнхийлөгч, Madaxaweynaha Jamhuuriyadda Federaalka Soomaaliyeed
14.	Өмнөд Африк: Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч
15.	Судан: Бүгд Найрамдах Судан Улсын Ерөнхийлөгч
16.	Тунис: Бүгд Найрамдах Тунис Улсын Ерөнхийлөгч
17.	Уганда: Бүгд Найрамдах Уганда Улсын Ерөнхийлөгч
Америк тив	
18.	Аргентин: Бүгд Найрамдах Аргентин Улсын Ерөнхийлөгч, Presidente de la Naciyn Argentina
19.	Бразил: Холбооны Бүгд Найрамдах Бразил Улсын Ерөнхийлөгч, Presidente da Repъblica Federativa do Brasil
20.	Колумб: Колумбын Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Presidente de la Repъblica de Colombia
21.	Чили: Чилийн Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Presidente de la Repъblica de Chile
22.	Коста Рика: Бүгд Найрамдах Коста Рика Улсын Ерөнхийлөгч, Presidente de la Repъblica de Costa Rica
23.	Куба: Бүгд Найрамдах Куба Улсын Ерөнхийлөгч, Presidente del Consejo de Estado de Cuba
24.	Эквадор: Эквадорын Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Presidente de la Repъblica del Ecuador
25.	Гватемал: Гватемалын Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Presidente de Guatemala
26.	Гайана: Бүгд Найрамдах Гайана Улсын Ерөнхийлөгч
27.	Хаити: Бүгд Найрамдах Хаити Улсын Ерөнхийлөгч, Prezidan peyi Repiblik Ayiti (Creole)
28.	Гондурас: Бүгд Найрамдах Гондурас Улсын Ерөнхийлөгч, Presidente de la Repъblica de Honduras
29.	Суринам: Бүгд Найрамдах Суринам Улсын Ерөнхийлөгч, President van de Republiek Suriname
30.	АНУ: Америкийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч
31.	Уругвай: Зүүний Бүгд Найрамдах Уругвай Улсын Ерөнхийлөгч, Presidente de la Repъblica Oriental del Uruguay
32.	Мексик: Мексикийн Нэгдсэн Улсын Ерөнхийлөгч, Presidente de los Estados Unidos Mexicanos
Ази тив	
33.	Афганистан: Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсын Ерөнхийлөгч, د افغانستان د اسلامي جمهوريت رئيس
34.	Азербайжан: Бүгд Найрамдах Азербайжан Улсыг Ерөнхийлөгч
35.	Бүгд Найрамдах Хятад Улс: Бүгд Найрамдах Хятад Улсын Ерөнхийлөгч, 中華民國總統
36.	Бүгд Найрамдах Хятад Ард Улс: Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Ерөнхийлөгч, 中华人民共和国主席

хуулийн мэдээлэл хүрээлэн www.ulsiin.gov.mn

37.	Гранд Комор: Гранд Комор Арлын Ерөнхийлөгч
38.	Энэтхэг: Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Ерөнхийлөгч, □□□□ □□□□□□□□ □□ □□□□□□□□□□□□ (Хинди хэлээр)
39.	Индонез: Бүгд Найрамдах Индонез Улсын Ерөнхийлөгч
40.	Иран: Исламын Бүгд Найрамдах Иран Улсын Ерөнхийлөгч, رئیس جمهور ایران Rayis Jomhur-e Irān (Перс хэлээр)
41.	Ирак: Бүгд Найрамдах Ирак Улсын Ерөнхийлөгч, رئيس العراق Rayis aleiraq
42.	Израиль: Израиль Улсын Ерөнхийлөгч, נשיא מדינת ישראל
43.	Казахстан: Бүгд Найрамдах Хасаг Улсын Ерөнхийлөгч, Қазақстан Республикасының Президенті, Qazaqstan Respwblnkasınıc Prezndenti
44.	Монгол: Монгол Улсын Ерөнхийлөгч, Mongol Ulsyn Yerцnkhiilцgch
45.	Филиппин: Бүгд Найрамдах Филиппин Улсын Ерөнхийлөгч, “Pangulo ng Republika ng Pilipinas” (Филипино хэлээр)
46.	Өмнөд Солонгос: Бүгд Найрамдах Солонгос Улсын Ерөнхийлөгч, □□□□ □□□
47.	Шри-Ланка: Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри-Ланка Улсын Ерөнхийлөгч, □□□□ □□□□ □□□□□□□□□ (Sinhalese), □□□□□□ □□□□□□□□□ (Tamil)
48.	Лаос: Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсын Ерөнхийлөгч
49.	Сири: Арабын Бүгд Найрамдах Сири Улсын Ерөнхийлөгч, رئيس سوريا Rayis suria
50.	Узбек: Бүгд Найрамдах Узбек Улсын Ерөнхийлөгч, O□zbekiston Respublikasining Prezidenti
51.	Вьетнам: Бүгд Найрамдах Нийгэм Журамт Вьетнам Улсын Ерөнхийлөгч
52.	Сингапур: Бүгд Найрамдах Сингапур Улсын Ерөнхийлөгч
Европ тив	
53.	Албани: Бүгд Найрамдах Албани Улсын Ерөнхийлөгч, Presidenti i Shqiprrisл
54.	Австри: Бүгд Найрамдах Австри Улсын Ерөнхийлөгч, Bundesprдsident der Republik Цsterreich
55.	Беларусь: Бүгд Найрамдах Беларусь Улсын Ерөнхийлөгч, Прэзідэнт Рэспублікі Беларусь, Президент Республики Беларусь
56.	Болгар: Бүгд Найрамдах Болгар Улсын Ерөнхийлөгч, Президент на Република България
57.	Хорват: Хорватын Бүгд Найрамдах Улсын Ерөнхийлөгч, Predsjednik Republike Hrvatske
58.	Кипр: Бүгд Найрамдах Кипр Улсын Ерөнхийлөгч, Πρόεδρος της Κυπριακής Δημοκρατίας буюу Kıbrıs Cumhuriyeti Cumhurbaşkanı
59.	Умард Кипр: Умард Киприйн Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч Kuzey Kıbrıs Tьrk Cumhuriyeti cumhurbaşkanı
60.	Эстон: Бүгд Найрамдах Эстон Улсын Ерөнхийлөгч, Eesti Vabariigi President
61.	Финланд: Бүгд Найрамдах Финланд Улсын Ерөнхийлөгч, Tasavallan presidentti or Republikens president
62.	Франц: Бүгд Найрамдах Франц Улсын Ерөнхийлөгч, Prйsident de la Rйpublique Franзaise
63.	Гүрж: Гүрж Улсын Ерөнхийлөгч, □□□□□□□□□□□□ □□□□□□□□□□□
64.	Герман: Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Холбооны Ерөнхийлөгч, Bundesprдsident der Bundesrepublik Deutschland
65.	Бүгд Найрамдах Чех Улс: Бүгд Найрамдах Чех Улсын Ерөнхийлөгч, Prezident Českй republiky
66.	Грек: Бүгд Найрамдах Грек Улсын Ерөнхийлөгч, Πρόεδρος της Ελληνικής Δημοκρατίας
67.	Унгар: Бүгд Найрамдах Унгар Улсын Ерөнхийлөгч, Kцztбrsasбgi elnцk
68.	Исланд: Бүгд Найрамдах Исланд Улсын Ерөнхийлөгч, Forseti Hslands
69.	Ирланд: Бүгд Найрамдах Ирланд Улсын Ерөнхийлөгч, Uachtarбn na hЙireann
70.	Итали: Бүгд Найрамдах Итали Улсын Ерөнхийлөгч, Presidente della Repubblica Italiana
71.	Польш: Бүгд Найрамдах Польш Улсын Ерөнхийлөгч, Prezydent Rzeczypospolitej Polskiej
72.	Португали: Бүгд Найрамдах Португали Улсын Ерөнхийлөгч, Presidente da Reръblica Portuguesa
73.	Румын: Румын Улсын Ерөнхийлөгч, Pre□edintele Romвniei
74.	ОХУ: ОХУ-ын Ерөнхийлөгч, Президент Российской Федерации

www.mfa.gov.mn

75.	Татарстан: Бүгд Найрамдах Татарстан Улсын Ерөнхийлөгч, Татарстан Республикасы Президенты
76.	Серби: Бүгд Найрамдах Серби Улсын Ерөнхийлөгч, Председник Републике Сербия
77.	Словак: Бүгд Найрамдах Словак Улсын Ерөнхийлөгч, Prezident Slovenskej republiky
78.	Словени: Бүгд Найрамдах Словен Улсын Ерөнхийлөгч, Predsednik Republike Slovenije
79.	Турк: Бүгд Найрамдах Турк Улсын Ерөнхийлөгч, Tırkiye Cumhuriyeti Cumhurbaşkanı
80.	Украйн: Украйн Улсын Ерөнхийлөгч, Президент Украүни
Номхон далайн улсууд	
81.	Фижи: Бүгд Найрамдах Фижи Улсын Ерөнхийлөгч
82.	Францын Полинез: Францын Полинез Улсын Ерөнхийлөгч

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
www.nli.gov.mn

ХАВСРАЛТ 3

Төрийн тэргүүний үүрэг гүйцэтгэгч:

1. Балингийн Цэрэндорж (1924 оны 5 сарын 20 - 1924 оны 11 сарын 28)
2. УИХ-ын дарга Наваандоржийн Жадамбаа (1924 оны 11 сарын 28 - 1924 оны 11 сарын 29)

Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга

3. Пэлжидийн Гэндэн (1924 оны 11 сарын 29 - 1927 оны 11 сарын 15)
4. Жанцангийн Дамдинсүрэн (1927 оны 11 сарын 16 - 1929 оны 1 сарын 23)
5. Хорлоогийн Чойбалсан (1929 оны 1 сарын 24 - 1930 оны 4 сарын 27)
6. Лосолын Лааган (1930 оны 4 сарын 27 - 1932 оны 7 сарын 2)
7. Анандын Амар (1932 оны 7 сарын 2 - 1936 оны 3 сарын 22)
8. Дансранбилэгийн Догсом (1936 оны 3 сарын 22 - 1939 оны 7 сарын 9)
9. Хоосон (1936 оны 3 сарын 22 - 1940 оны 7 сарын 6)
10. Гончигийн Бумцэнд (1940 оны 7 сарын 6 - 1951 оны 7 сарын 6)

БНМАУ-ын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга (1960 оны 7 сарын 7-оос БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга)

11. Гончигийн Бумцэнд (1951 оны 7 сарын 6 - 1953 оны 9 сарын 23)
12. Сүхбаатарын Янжмаа (1953 оны 9 сарын 23 - 1954 оны 7 сарын 7) (үүрэг гүйцэтгэгч)
13. Жамсрангийн Самбуу (1954 оны 7 сарын 7 - 1972 оны 5 сарын 20)
14. Цагаанламын Дүгэрсүрэн (1972 оны 5 сарын 20 - 1972 оны 6 сарын 29) (үүрэг гүйцэтгэгч)
15. Сономын Лувсан (1972 оны 6 сарын 29 - 1974 оны 6 сарын 11) (үүрэг гүйцэтгэгч)
16. Юмжаагийн Цэдэнбал (1974 оны 6 сарын 11 - 1984 оны 8 сарын 23)
17. Нямын Жагварал (1984 оны 8 сарын 23 - 1984 оны 12 сарын 12) (үүрэг гүйцэтгэгч)
18. Жамбын Батмөнх (1984 оны 12 сарын 12 - 1990 оны 3 сарын 21)
19. Пунсалмаагийн Очирбат (1990 оны 3 сарын 21 - 1990 оны 9 сарын 3, 1990 оны 9 сарын 3 - 1992 оны 2 сарын 12)

Монгол Улс (1992 оноос хойшхи) Ерөнхийлөгч:

Пунсалмаагийн Очирбат (1992 оны 2 сарын 12 - 1997 оны 6 сарын 20)

20. Нацагийн Багабанди (1997 оны 6 сарын 20 - 2005 оны 6 сарын 24)
21. Намбарын Энхбаяр (2005 оны 6 сарын 24 - 2009 оны 6 сарын 18)
22. Цахиагийн Элбэгдорж (2009 оны 6 сарын 18 - 2017 оны 7 сарын 10)
23. Халтмаагийн Баттулга (2017 оны 7 сарын 10 -)

Хуулийн үндэсний сан www.pli.gov.mn

ХАВСРАЛТ 4

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тодорхой бүрэн эрх

Д/Д	ХУУЛЬ	БАТЛАГДСАН ОН	ХОЛБОГДОХ ЗҮЙЛ, ХЭСЭГ
1	СОЁЛЫГ ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/	2014-05-15	11.1.Монгол Улсын Ерөнхийлөгч соёлын өвийг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.1.Их эзэн Чингис хаан, монголын хаад, хатдын булш, бунхан, дурсгалын орчин болон олдворыг судлах, хамгаалах, мэдээлэх ажлыг хэрэгжүүлэх талаар холбогдох этгээдэд чиглэл өгөх; 11.1.2.хууль бусаар алдагдсан соёлын өвийг Монгол Улсыг төлөөлөн гадаад улс, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас нэхэмжлэх эрхийг итгэмжлэлээр олгох, итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилох; 11.1.3.Ерөнхийлөгчийн ивээл доор хамгаалж болох соёлын өвийг зарлах, уул, усыг төрийн тахилгатай болгох шийдвэр гаргах; 11.1.4.хууль заасан бусад бүрэн эрх.
2	СОНГУУЛИЙН ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ	2006-01-12	4.2.Хорооны гишүүний тавыг УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо, хоёрыг Монгол Улсын Ерөнхийлөгч, хоёрыг Улсын дээд шүүх төрийн жинхэнэ албан хаагчдаас санал болгосноор УИХ зургаан жилийн хугацаагаар томилно.
3	Т А Г Н У У Л Ы Н БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ	1999-07-08	14.1.Тагнуулын ерөнхий газрын даргаар төрийн албанд 15-аас доошгүй жил ажилласан, сүүлийн 5 жил төрийн албанд тасралтгүй ажиллаж байгаа Монгол Улсын иргэнийг Ерөнхий сайд Монгол Улсын Ерөнхийлөгчтэй зөвшилцөн санал болгосноор Засгийн газар 6 жилийн хугацаагаар томилж, чөлөөлнө. 16.2.Монгол Улсын Ерөнхийлөгч-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь шаардлагатай гэж үзвэл тагнуулын байгууллагын даргын илтгэл, мэдээллийг сонсож, тэдгээртэй холбоотой үйл ажиллагаатай танилцаж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн тогтсоны үндсэн дээр үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдсон асуудлаар даалгавар өгнө. 18.2.Тагнуулын ажилтны тангараг өргөх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.
4	Т Е Р Р О Р И З М Т О Й ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬ	2004-04-23	12.2.Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах дүрмийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхийлөгч батална.
5	ТӨР СҮМ ХИЙДИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬ	1993-11-11	2.Ард түмний эв нэгдэл, үндэсний аюулгүй байдлын эрх ашигт нийцүүлэн төр, сүм хийдийн болон шашин хоорондын харилцааг Монгол Улсын Ерөнхийлөгч зохицуулна.
6	ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/	2017-12-07	36.2.Тангараг өргөх ёслолын журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. 63.2.Албан хаагчийн дүрэмт хувцасны загварыг эдэлгээний хугацаа, хэрэглэх журмын хамт Ерөнхийлөгч, Засгийн газар тус тус тогтооно.
7	ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬ	2003-01-03	12.5.Монгол Улсын Ерөнхий аудиторын албан тушаалын зэрэг дэвийг Монгол Улсын Ерөнхийлөгч олгоно
8	ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ	2016-12-01	9.1.Монгол Улсын Ерөнхийлөгч-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт тавьж, энэ талаар холбогдох төрийн байгууллагын тайлан, мэдээллийг сонсох, Засгийн газарт чиглэл өгөх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 21.1.Хуулиар хориглоогүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч, УИХ-ын дарга, Ерөнхий сайд төрийн болон албаны нууцтай зэрэглэл харгалзахгүй танилцана.

9	ТӨРИЙН БЭЛГЭ ТЭМДГИЙН ТУХАЙ ХУУЛЬ	1994-05-20	**10 дугаар зүйл. Төрийн тугийг хүндэтгэн залах** 2. Төрийн тугийг цэнгүүлэх, хүндэтгэн залах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална. **19 дүгээр зүйл. Төрийн тамгыг залах, хадгалах** Төрийн тамгыг залах журмыг Улсын Их Хурал, хадгалах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.
10	ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬ	1995-04-27	**14 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг** 2.Төрийн тусгай хамгаалалтын алба хаагчийн тангараг өргөх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.
11	УЛС ТӨРИЙН ХИЛС ХЭРЭГТ ХЭЛМЭГДЭГЧДИЙГ ЦАГААТГАХ, ТЭДЭНД НӨХӨХ ОЛГОВОР ОЛГОХ ТУХАЙ	1998-01-02	24.3.Улсын комисс нь дарга, 8 гишүүний бүрэлдэхүүнтэй байна. Улсын комиссын дарга нь УИХ-ын дэд дарга байна. Улсын комиссын гишүүдийг Улсын комиссын даргын өргөн мэдүүлснээр Монгол Улсын Ерөнхийлөгч томилно. Улсын комиссын нарийн бичгийн дарга орон тооны байна. 24.4.Улсын комиссын дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.
12	ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ	2001-12-27	8.2.Монгол Улсын Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд Үндсэн хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг ерөнхий удирдлагаар хангаж, үндэсний аюулгүй байдлыг хангах асуудлаар холбогдох байгууллагуудын ажилтай танилцаж, чиглэл өгнө. 18.2.Ажлын хэсгүүдийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга удирдлагаар хангаж, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулна. Ажлын хэсгүүдийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч батална.
13	ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫН ТУХАЙ ХУУЛЬ	2003-06-19	6.1.Баяр наадмыг зохион байгуулах хорооны саналыг үндэслэн бөх, уяач, харваачид үндэсний спортын төрлөөр улсын цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч, аймаг, сумын цолыг аймаг, сумын Засаг дарга тус тус олгоно.
14	ХАРЬЯАТЫН ТУХАЙ ХУУЛЬ	1995-06-05	**19 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн эрх хэмжээ** Монгол Улсын Ерөнхийлөгч бүрэн эрхийнхээ хүрээнд дор дурьдсан асуудлаар шийдвэр гаргана: 1/гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсын харьяат болгох; 2/Монгол Улсын харьяатаас гаргах; 3/Монгол Улсын иргэний харьяаллыг сэргээн тогтоох.
15	ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/	2017-02-09	75.1.Цагдаагийн дээд цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч олгоно. 75.2.Цагдаагийн дээд цол олгох, бууруулах, хураан авах, сэргээх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

Хуулийн мэдээлэл www.legal.mn Нэгдсэн

16	ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ	2012-03-07	8.1.Энэ хуулийн 4-7 дугаар зүйлд заасан шүүгчид тавих болзол, шаардлагыг хангасан эсэхийг үнэлж дүгнэх, шалгаруулах журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн мэргэшлийн хороотой хамтран боловсруулж, Монгол Улсын Ерөнхийлөгч /цаашид “Ерөнхийлөгч” гэх/ батална. 15.1.Анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл санал болгож Улсын Их Хуралд танилцуулснаар тус тус Ерөнхийлөгч томилно. 15.3.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно. 16.2.Шүүгчийн тангараг өргөх журам, шүүгчийн өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална. 26.9.Ерөнхийлөгч энэ хуулийн 26.8-д заасан саналыг хүлээн авсан бол ажлын хоёр өдрийн дотор шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг шийдвэрлэнэ.
17	ШҮҮХИЙН ЗАХИРГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ	2012-05-22	13.1.Ерөнхий зөвлөл нь дарга, дөрвөн гишүүнээс бүрдэх бөгөөд Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнийг анхан шатны шүүхийн шүүгчдийн болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус бүр нэг, Хуульчдын холбооноос нэг, хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг хүний нэрийг тус тус санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч томилно. 13.2.Ерөнхий зөвлөлийн даргыг Ерөнхий зөвлөлийн гишүүд дотроосоо нэр дэвшүүлэн хуралдаанаараа хэлэлцэж, гишүүдийн олонхын санал авсан хүнийг санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч томилно.
18	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ	1992-05-29	3. Зөвлөлийн тэргүүн нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч байна. Зөвлөлийн тэргүүн нь Зөвлөлийн ажлыг бүхэлд нь удирдаж, дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 1/ Зөвлөлийн хуралдаанд хэлэлцэх асуудлыг тодорхойлж, хуралдааныг товлох, даргалах; 2/ Зөвлөлийн бүрэлдэхүүнийг нэмэгдүүлэх саналыг Улсын Их Хуралд оруулах; 3/ төрийн гадаад, дотоод бодлогыг хэрэгжүүлэхэд Зөвлөлийг төлөөлөх; 4/ Зөвлөлийн ажлын хэсэг байгуулж ажиллуулах; 5/хуульд заасан бусад бүрэн эрх. **10 дугаар зүйл. Зөвлөлийг мэдээллээр хангах тогтолцоо** 1. Төрийн холбогдох байгууллагууд Зөвлөлийг шаардагдах мэдээллээр тогтоосон журмын дагуу хангана. Энэхүү журмыг Зөвлөлийн шийдвэрийн үндсэн дээр Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. 3. Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц, зохион байгуулалт, бүрдүүлэлт, ашиглалтын журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. Зөвлөлийн дэргэдэх мэдээллийн нэгдсэн сан нь төрийн нууцад хамаарах бөгөөд тусгай хамгаалалтад байна.
19	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ	2010-12-23	**7 дугаар зүйл.Ерөнхийлөгч Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачлах** 7.1.Ерөнхийлөгч нь төрийн тэргүүний хувьд энэ хуулийн 5.2.2-т зааснаас болон дор дурдсанаас бусад асуудлаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хууль санаачилж болно: 7.1.1.Үндсэн хуулиар Ерөнхийлөгчид олгосон бүрэн эрхийг өргөтгөх, хязгаарлах, эрх хэмжээг нэмэгдүүлэх; 7.1.2.Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийн болон үлдсэн бүрэн эрхийн хугацааг сунгах, бусад байдлаар өөрчлөх; 7.1.3.Ерөнхийлөгчид нэр дэвшигчид тавих шаардлагыг сулруулах, өөрчлөх.
20	МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/	2016-12-28	50.4.Улсын хил хамгаалалтад иргэнийг оролцуулах журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

21	МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬ	2012-03-07	12.3.Үндсэн хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасны дагуу Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно. 12.4.Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн, Улсын дээд шүүхийн танхимын тэргүүнийг тухайн шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн тус тус өргөн мэдүүлснээр Ерөнхийлөгч гурван жилийн хугацаагаар томилж, тухайн шүүхэд нэг удаа улируулан томилж болно.
22	МОНГОЛ УЛСЫН ЯАМНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ	2004-04-15	16.1.Яам нь сайдаас Ерөнхийлөгчтэй харилцахад нь дэмжлэг үзүүлэх чиглэлээр дараахь үйл ажиллагаа явуулна: 16.1.1.Ерөнхийлөгчийг сайдын эрхлэх асуудлын хүрээний талаархи шаардлагатай мэдээллээр хангах; 16.1.2.Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн холбогдох шийдвэрийн биелэлтийг хангах; 16.1.3.сайдын эрхлэх асуудлын хүрээний чиглэлээр Ерөнхийлөгчийн өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх; 16.1.4.хууль тогтоомжид заасны дагуу Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх зарлиг, бусад бичиг баримтын төсөл боловсруулах.
23	МОНГОЛ ХЭЛНИЙ ТУХАЙ ХУУЛЬ	2015-02-12	9.1.Монгол Улсын Ерөнхийлөгч монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх талаар дараах үүрэг хүлээнэ: 9.1.1.монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэхтэй холбоотой төрийн бодлогын талаарх саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 9.1.2.монгол хэл, бичиг үсгээ эзэмших, хэрэглэх, хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа ажил, анхаарах асуудлын талаар хоёр жил тутам Улсын Их Хуралд мэдээлэл хийх; 9.1.3.монгол хэл, бичиг үсгээ хэрэглэх, эзэмших, хамгаалах, хөгжүүлэх чиглэлээр зарлиг гаргах, төрийн холбогдох байгууллагад чиглэл өгөх; 9.1.4.энэ хуулийн 21.1-д заасан эрх бүхий байгууллагын бүрэлдэхүүнийг томилж, чөлөөлөх; 9.1.5.монгол хэл, бичиг үсгээ хамгаалах, хөгжүүлэх талаар идэвх санаачилга гаргасан иргэн, хуулийн этгээдэд дөрвөн жил тутамд Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит шагнал олгох; 9.1.6.хуульд заасан бусад үүрэг. 21.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд монгол хэлийг хамгаалах, хөгжүүлэх үндсэн үүрэг бүхий Хэлний бодлогын үндэсний зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана. 21.2.Зөвлөл есөн гишүүнтэй байна. Гишүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгч монгол хэл, утга зохиолын эрдэмтэн, хэвлэл мэдээлэл, боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын мэргэжлийн төлөөлөөс сонгож, зургаан жилийн хугацаагаар томилно. Зөвлөлийн дарга, гишүүн хүндэтгэх шалтгаанаар ажлаа үргэлжлүүлэх боломжгүй болсон нөхцөлд Монгол Улсын Ерөнхийлөгч нөхөн томилно. 21.3.Зөвлөлийн даргыг Монгол Улсын Ерөнхийлөгч Зөвлөлийн гишүүдийн дотроос сонгож, гурван жилийн хугацаатай томилно. Зөвлөлийн даргыг хоёроос дээшгүй удаа улируулан томилж болно.
24	НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯРЫН БОЛОН ТЭМДЭГЛЭЛТ ӨДРҮҮДИЙН ТУХАЙ ХУУЛЬ	2003-12-18	6.1.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийг тэмдэглэн өнгөрүүлэхэд төрийн ёслолын арга хэмжээг зохион байгуулж болно. Төрийн ёслолын журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

25	ОЙН ТУХАЙ ХУУЛЬ / Ш И Н Э Ч И Л С Э Н НАЙРУУЛГА/	2012-05-17	44.3.Улсын хил, аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэр дамжсан орон нутгийн хүчээр унтраах боломжгүй ой, хээрийн түймэртэй тэмцэхэд шүүхээс албадан хөдөлмөр хийлгэхээр шийтгэгдсэн хүмүүсийг оролцуулах асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, цэргийн ангийн асуудлыг Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ.
26	ОЛОН НИЙТИЙН РАДИО ТЕЛЕВИЗИЙН ТУХАЙ ХУУЛЬ	2005-01-27	21.5.Энэ хуулийн 21.3, 21.4-т заасан шалгуурыг удирдлага болгон дор дурдсан байгууллага, албан тушаалтан Үндэсний зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлнэ: 21.5.1.Монгол Улсын Ерөнхийлөгч 4 хүн;
27	ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/	2016-12-01	6.2.Монгол Улсын Ерөнхийлөгч болон Засгийн газар өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Монгол Улсын нэрийн өмнөөс улс хоорондын олон улсын гэрээ байгуулах эрхтэй.
28	ОНЦ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ	1995-11-14	**5 дугаар зүйл.Онц байдал зарлах** 3.Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл УИХ-ын чуулганы чөлөө цагт бий болсон бөгөөд үйл явцын өрнөлт нь онц байдал нэн даруй зарлахыг шаардаж байгаа хойшлуулшгүй тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгч Онц байдал зарлах тухай зарлиг гаргана. 7.Онц байдал зарлах тухай санаачлагчийн төсөл, УИХ-ын шийдвэр, эсхүл Ерөнхийлөгчийн зарлигт дор дурдсан зүйлийг заавал тусгана: 1/онц байдал зарлах үндэслэл болсон онцгой нөхцөл; 2/онц байдлын зорилго; 3/онц байдал хамрах нутаг дэвсгэр; 4/онц байдал үргэлжлэх хугацаа /эхлэх, дуусах он, сар, өдөр, цаг/; 5/онц байдлын үед энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан онцгой арга хэмжээний алийг нь хэрэгжүүлэх болон хэрэгжүүлэх арга хэмжээ тус бүрийн, түүний дотор иргэдийн эрх, эрх чөлөө, хуулийн этгээдийн эрхийг хязгаарлах хүрээ заагийг бий болсон нөхцөлд нийцүүлэн тогтоох; 6/энэ зүйлийн энэ хэсэгт заасан болон энэ хуулийн холбогдох бусад заалт, түүнчлэн онц байдал зарласантай холбогдуулан авах арга хэмжээг шууд хариуцаж хэрэгжүүлэх төрийн байгууллага, албан тушаалтан, тэдгээрийн энэ талаар эдлэх онцгой бүрэн эрхийг энэ хуульд нийцүүлэн нэг бүрчлэн тогтоох; 7/онц байдал зарлах тухай УИХ-ын шийдвэр, эсхүл Ерөнхийлөгчийн зарлиг хүчин төгөлдөр болох он, сар, өдөр, цаг.
29	ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ	2018-06-27	14.1.Монгол Улсын Ерөнхийлөгч орон нутгийн хамгаалалтын талаар Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль болон бусад хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
30	ПРОКУРОРЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/	2017-06-09	46.1.Прокурорын байгууллагыг Улсын ерөнхий прокурор тэргүүлнэ. Улсын ерөнхий прокурорыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилно. 46.2.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурорын саналыг үндэслэн түүний орлогчийг Улсын Их Хуралтай зөвшилцөн зургаан жилийн хугацаагаар томилно. 6.5.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ. 50.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хүсэлтийн дагуу Улсын ерөнхий прокурор өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар дүгнэлт гаргаж болно

31	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫНТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/	2006-01-26	14.1. Анхдугаар чуулганыг ээлжит сонгуулийн санал хураалт явуулсан өдрөөс хойш 30 хоногийн дотор Ерөнхийлөгч зарлигаар товлон зарлаж хуралдуулна. 16.2. Ээлжит бус чуулганыг нийт гишүүний гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, УИХ-ын даргын санаачилгаар хуралдуулна.
32	МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ	2016-09-01	12.1.Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Монгол Улсын Үндсэн хуульд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.1.батлан хамгаалах бодлогын үндсийг Засгийн газартай зөвшилцөн тодорхойлж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 12.1.2.батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах нөөцийг бүрдүүлэх, зэвсэг, техникийг шинэчлэх төсвийг шийдвэрлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх; 12.1.3.батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийн талаар батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний мэдээллийг сонсож, түүний дагуу авч хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Засгийн газарт чиглэл өгөх; 12.1.4.цэргийн нийтлэг дүрмүүдийг батлах; 12.1.6.бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгааг хууль тогтоомжид заасны дагуу зарлах.
33	ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬ	2016-09-01	11.1.Монгол Улсын Ерөнхийлөгч нь зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.1.төрийн цэргийн номлолыг батлах; 11.1.2.зэвсэгт хүчнийг хэрэглэх ерөнхий болон стратегийн дэлгэн байгуулалтын төлөвлөгөөг батлах; 11.1.3.зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвчийг батлах; 11.1.4.Бүх Цэргийн Их Хар Сүлд, зэвсэгт хүчний Жанжин тугийн тодорхойлолт, дүрмийг батлах; 11.1.5.Зэвсэгт хүчний Жанжин штабын дүрмийг батлах; 11.1.6.дээд офицерын албан тушаалын ангилал, цолны зэрэглэлийг тогтоох; 11.1.7.цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загварыг батлах; 11.1.8.цэргийн анги, байгууллагыг цэргийн ёслолын жагсаалын арга хэмжээнд оролцуулах журмыг тогтоох; 11.1.9.улсад онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд хугацаат цэргийн алба хаах хугацааг гурван сараас дээш хугацаагаар сунгах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 11.1.10.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргыг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох; 11.1.11.зэвсэгт хүчний дайны үеийн бүтэц, зохион байгуулалт, зэвсэгт хүчнийг дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөөг батлах, цэргийг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх, байлдааны ажиллагаа эхлэх шийдвэрийг холбогдох хууль тогтоомжийн дагуу гаргах; 11.1.12.улсын хил, онц чухал объектын хамгаалалтад зэвсэгт хүчнээр дэмжлэг үзүүлэх шийдвэр гаргах; 11.1.13.цэргийн алба хаагчид цэргийн цол олгох журмыг тогтоох; 11.1.14.Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын санал, батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх төрийн албаны салбар зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Зэвсэгт хүчний Жанжин штабын орлогч дарга, төрлийн цэргийн командлагчийг томилох, чөлөөлөх.
34	ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬ	2000-10-05	14.4.Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин цолны ялгах тэмдгийн тодорхойлолт, загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч батална.

35	ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬ	1998-05-15	6.1.Дайчилгааг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч зарлана. 6.2.Дайчилгаа зарлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигт дараахь асуудлыг тусгана: 6.2.1.дайчилгаа зарлахад хүргэсэн цэрэг-улс төрийн нөхцөл, байдал; 6.2.2.дайчилгаа явуулах нутаг дэвсгэр; 6.2.5.дайчилгаа эхлэх хугацаа /он, сар, өдөр, цаг/, явуулах дараалал; 6.2.6.дайчилгаа зохион байгуулж явуулах журам; 6.2.7.хуульд нийцсэн шаардлагатай бусад заалт. 12.1.Монгол Улсын Ерөнхийлөгч тайван цагт дайчилгааны талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.1.Зэвсэгт хүчний Жанжин штабын дайчилгааны төлөвлөгөөг батлах; 12.1.2.зэвсэгт хүчний дайчилгааны нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавих, энэ талаар Засгийн газарт чиглэл өгөх; 12.1.3.төрийн байгуулллагын удирдах албан тушаалтны цэргийн бэлтгэл, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний бүртгэл, давтан бэлтгэл, сургалтын байдалд хяналт тавих. 12.2.Монгол Улсын Ерөнхийлөгч дайчилгаа зарласан үед дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.2.1.бүх нийтийн буюу хэсэгчилсэн дайчилгаа зарлах тухай шийдвэр гаргах; Монгол Улсын Ерөнхийлөгч дайчилгаа зарласан тухай зарлигаа УИХ-ын даргад нэн даруй өргөн мэдүүлнэ. 12.2.2.Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, холбогдох бусад албан тушаалтны илтгэлийг сонсож, чиглэл, үүрэг даалгавар өгөх; 12.2.3.цэргийн албанд татах бэлтгэл офицер, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүний насны дээд, доод хязгаарыг шинэчлэн тогтоох, байлдагч түрүүчийн цэргийн алба хаах хугацааг сунгах тухай шийдвэр гаргах.
36	ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ	1998-05-15	13.1.Дайны байдалтай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагч дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: Тайван цагт: 13.1.1.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дээд командлалын газрын бүтэц, зохион байгуулалт, чиг үүргийн тухай саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх; 13.1.2.улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөөний талаар Улсын Их Хуралд санал, дүгнэлт оруулах; 13.1.3.зэвсэгт хүчийг бэхжүүлэх талаар Засгийн газарт чиглэл өгөх; 13.1.4.улсын болон цэргийн дайчилгааны материаллаг нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтад хяналт тавих. Дайны байдлын үед: 13.1.5.Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын хороо, Цэргийн дээд командлалын газрыг тэргүүлэх; 13.1.6.дайны байдал зарлахад хүргэсэн нөхцөл байдал өргөжин гүнзгийрүүлэхгүй байхад чиглэсэн арга хэмжээ авах; 13.1.7.Цэргийн дээд командлалын газрын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх саналыг Үндэсний аюулгүй байдлын хороонд оруулах; 13.1.8.дайны байдлын үед зэвсэгт хүчний гүйцэтгэх үүргийг тодорхойлон түүнийг хэрэглэх төлөвлөгөөг баталж, зэвсэгт тэмцлийг ерөнхий удирдлагаар хангах.

37	ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ / Ш И Н Э Ч И Л С Э Н НАЙРУУЛГА/	2017-02-02	46.3.Онцгой байдлын байгууллагын алба хаагчид цэргийн цол олгох журам болон дүрэмт хувцасны загварыг Монгол Улсын Ерөнхийлөгч, дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг Засгийн газар тогтооно.
38	ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ / Ш И Н Э Ч И Л С Э Н НАЙРУУЛГА/	2010-07-08	9.1.Монгол Улсад эрхэмлэн дээдэлдэг үзэл санааны төлөө хавчигдан мөшгөгдсөн гадаадын иргэнд Монгол Улсын Ерөнхийлөгч тус улсад орогнох эрх олгоно.
39	АРД НИЙТИЙН САНАЛ АСУУЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/	2016-02-05	5.1.Ард нийтийн санал асуулга явуулахыг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар, УИХ-ын нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь санаачлах эрхтэй.
40	МОНГОЛ УЛСЫН Е Р Ө Н Х И Й Л Ө Г Ч И Й Н ТУХАЙ ХУУЛЬ	1993-06-05	12-15 дугаар зүйл

Хуульзүйн үндэсний хүрээлэн www.nli.gov.mn

ХАВСРАЛТ 5

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн

Д/д	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн	Бүрэн эрхээ хэрэгжүүлсэн хугацаа
1	П. Очирбат	1992 оны 6 дугаар сарын 11-нээс 1997 оны 6 дугаар сарын 20-ний өдөр
2	Н.Багабанди	1997 оны 6 дугаар сарын 20-ноос 2005 оны 6 дугаар сарын 24-ний өдөр
3	Н.Энхбаяр	2005 оны 6 дугаар сарын 24-нөөс 2009 оны 6 дугаар сарын 18-ны өдөр
4	Ц.Элбэгдорж	2009 оны 6 дугаар сарын 18-наас 2017 оны 7 сарын 10-ны өдөр
5	Х.Баттулга	2017 оны 7 дугаар сарын 10-ны өдрөөс хойш

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн анхдугаар хуралдаан 1992 оны 8 дугаар сарын 8-нд болж, түүгээр Зөвлөлийн нарийн бичгийн даргыг томилох тухай, Зөвлөлийн ажлын дотоод журам болон Зөвлөлийг мэдээллээр хангах журмын төсөл зэрэг асуудлуудыг хэлэлцэн баталжээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга

№	ҮАБЗ-ын нарийн бичгийн дарга	Бүрэн эрхээ хэрэгжүүлсэн хугацаа
1	Р.Батаа	1992-1993 он
2	Ж.Энхсайхан	1993-1996 он
3	Ч.Баатар	1996-1997 он
4	Р.Болд	1997-2003 он
5	Д.Готов	2003-2006 он
6	П.Сүндэв	2006-2008 он
7	М.Ганболд	2008-2009 он
8	Ц.Энхтүвшин	2009-2017 он
9	А.Гансүх	2017 оноос хойш

--- oOo ---

ХУУЛЬЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРАЛДААН
www.nlis.gov.mn

(Footnotes)

1 А.Түвшинтулга нар, Хууль зүйн арга ажиллагаа /эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл/ (УБ: ХЗҮХ-гийн хэвлэх үйлдвэр, 2018), 247 дахь тал.

2 Я.Долгоржав "Онол, практикийн бага хурлыг нээж хэлсэн үг" Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь онол практикийн бага хурал (Уб, 2003), 7 дахь тал.

3 Мөн тэнд, 11 дэх тал.

4 Б.Чимид, "Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал" Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь онол практикийн бага хурал (Уб, 2003), 18 дахь тал.

5 Мөн тэнд, 23 дахь тал.

6 Монгол Улсын Сонгуулийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл, *№4, (2016).*

7 Б.Чимид "Ерөнхийлөгчийн байгуулалтын талаарх Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлал" Ерөнхийлөгчийн институтийг боловсронгуй болгох нь ОПБХ (Уб, 2003): 27 дахь тал.

8 Мөн тэнд.

9 Мөн тэнд, 26 дахь тал.

10 Ч.Энхбаатар нар, М*онгол Улсад ардчиллыг бэхжүүлэхэд Үндсэн хуулийн гүйцэтгэсэн үүрэг (Уб, 2015), 39 дэх тал.*

11 Мөн тэнд.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХУРЭЭЛЭН
www.nli.gov.mn